



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
СУДАЛГААНЫ ТӨВ

БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

(СУДАЛГААНЫ ЭМХТГЭЛ)



- ◇ **Хууль, эрх зүй**
- ◇ **Төрийн байгуулалт**
- ◇ **Сонгуулийн тогтолцоо**

DDC
328015
Б-53

«Бодлогын судалгаа, шинжилгээ» -ний эмхэтгэл (Х боть, 2011)
-ийг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргав.

Редактор: Ц. Норовдондог (Ph.D)

Техник редактор: Ц. Товуусүрэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г. Чулуун, О. Нарантуяа

ISBN 978-99929-895-6-4

ГАРЧИГ

Судалгааны эмхтгэл - Х боть

УИХ -ЫН 2011 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

| | |
|---|----|
| ӨМНӨХ ҮГ | 5 |
| 1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР | |
| 1.1. “Гадаадын зарим орны эрүүгийн хуулийн “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэрэг, “гэмт хэрэгт хамтран оролцох”, талаархи ойлголт, эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа <i>Р. Хатанбаатар, Б. Ариунжаргал, П. Амаржаргал, Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа, А. Пагма</i> | 8 |
| 1.2. Ард нийтийн санал асуулга (Лавлагаа, мэдээлэл) <i>Ц. Товуусүрэн, П. Амаржаргал</i> | 27 |
| 1.3. Үндэсний хороо, зөвлөлүүдийн бүрэлдэхүүн, эрх зүйн статус, үйл ажиллагааны санхүүжилтийн талаархи мэдээлэл ((Лавлагаа мэдээлэл) <i>Б. Мөнхцэцэг, Ө. Мөнхтунгалаг</i> | 30 |
| 1.4. Улстөрийн намуудын бүтэц, гишүүнчлэл, санхүүжилтийн талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт (Харьцуулсан судалгаа) <i>П. Амаржаргал, Б. Буяндэлгэр, Ц. Товуусүрэн, Б. Хатантуул</i> | 42 |
| 1.5. Хууль тогтоох байгууллага ба парламентын сэтгүүл зүйн харилцааны онцлог, олон улсын туршлага, жишиг хандлага (Харьцуулсан судалгаа) <i>Ц. Норовдондог (Ph.D), Ц. Болормаа, Д. Мягмарцэрэн, О. Нарантуяа</i> | 54 |
| 1.6. Мэдээллийн аюулгүй байдлын тухай зарим улс орны эрх зүйн зохицуулалт (Харьцуулсан судалгаа) <i>Ч. Базар (Ph.D)</i> | 73 |
| 1.7. Монгол Улсын далайн эрх зүйн байдлын тухай мэдээлэл <i>Б. Мөнхцэцэг</i> | 92 |
| 1.8. Нийслэл хот дундуур урсан өнгөрдөг гол мөрний ашиглалт, менежмент, нөхөн сэргээлтийн талаархи бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт (Харьцуулсан судалгаа) <i>Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Г. Гэрэл, О. Нарантуяа, Г. Чулуун</i> | 96 |

| | | |
|---|---|-----|
| 1.9 | Хотын тухай гадаадын зарим улс орны үндсэн хуульд зохицуулсан байдал (Харьцуулсан судалгаа) <i>Ц. Товуусүрэн, Б. Буяндэлгэр, П. Амаржаргал, Б. Хатантуул</i> | 118 |
| 1.10 | Оросын Холбооны Улсын төрийн өмчийн талаахи эрх зүйн зохицуулалт (Лавлагаа мэдээлэл) <i>Д. Мягмарцэрэн</i> | 127 |
| 2. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР | | |
| 2.1 | Гадаадын зарим орны парламентын өргөдөл гомдлын болон сонгуулийн асуудал хариуцсан хорооны талаархи харьцуулсан судалгаа <i>Р. Хатанбаатар, Г. Алтан - Оч (Ph.D), П. Амаржаргал, Ч. Базар (Ph.D), А. Пагма</i> | 136 |
| 2.2 | Сонгогчдын ирц, саналын босгын талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт <i>Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, Ц. Болормаа, Б. Хатантуул, Ө. Мөнхтунгалаа</i> | 150 |
| 2.3 | Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар өдөр тутмын хэвлэлүүдийн нийтлэлд хийсэн контент анализ (Лавлагаа мэдээлэл, 1999 - 2011. 03) <i>Ж. Алтанцэцэг, Б. Ариунжаргал, Ө. Мөнхтунгалаа, Б. Мөнхцэцэг, Т. Мягмаржав, Р. Нургуль, М. Оюунтулга, Ц. Янжинцэрэн</i> | 171 |
| 2.4 | Орон нутгийн сонгуульд улстөрийн намууд оролцох нь (Харьцуулсан судалгаа) <i>Ц.Товуусүрэн, Р. Хатанбаатар, Б. Ариунжаргал, Г. Билгээ, Ц. Болормаа, Г. Гэрэл, О. Нарантуяа, Б. Хатантуул</i> | 256 |
| 2.5 | Дэлхийн зарим улс орнуудын парламентын сонгуулийн шууд зарчим (Мэдээлэл лавлагаа) <i>Ц. Товуусүрэн, П. Амаржаргал, Ч. Базар (Ph.D), А. Пагма</i> | 287 |
| 2.6 | Гадаадын зарим орны хоёр танхимтай парламентын талаархи харьцуулсан судалгаа <i>Ц. Товуусүрэн, Р. Хатанбаатар, Б. Буяндэлгэр, П. Амаржаргал, Б. Ариунжаргал, Ц. Болормаа, Г. Билгээ, Г. Гэрэл, О. Нарантуяа, А. Пагма</i> | 297 |
| • ХАВСРАЛТ | | |
| - | УИХ -ын 2011 оны хаврын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа <i>(IX ботид орсон бусад судалгааны жагсаалт)</i> | 388 |

ӨМНӨХ ҮГ

УИХ -ын эрхэм гишүүд та бүхний гар дээр УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн 2011 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн судалгааны ажлуудын эмхэтгэл 9, 10 -р цуврал ботийг хүргүүлж байна.

УИХ-ын хаврын ээлжит чуулганаар хэлэлцсэн асуудлууд болон эрхэм гишүүд та бүхний хууль санаачлах, хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл-лавлагаа, судалгааны ажлуудыг тус төв нь шуурхай байдлаар гарган хүргүүлсээр ирлээ. Тайлант хугацаанд нийт 42 судалгааны ажил, мэдээлэл лавлагааг тус төв эрхэм гишүүд та бүхний захиалгын дагуу гүйцэтгэн хүргүүлсэнээс эдгээр эмхэтгэлд 30 судалгааны ажлыг эмхэтгэн хэвлүүлжээ.

Судалгааны төвд хаврын чуулганы хугацаанд ирүүлсэн нийт захиалгын 80% орчим нь УИХ -ын гишүүдийн захиалгаар, 20% орчим нь Судалгааны төвийн санаачлага болон Байнгын хороод, УИХ-ын Тамгын газрын хэлтэс албадын захиалгаар хийгдсэн байна.

2011 оны УИХ -ын хаврын чуулганаар улс орны нийгэм, эдийн засагт чухал ач холбогдол бүхий олон чухал асуудлуудыг хэлэлцэхээр төлөвлөж, хэлэлцсэн асуудлууд 81,2% -ийн биелэлттэй гарсаныг УИХ-ын дарга Д. Дэмбэрэл хаврын чуулганы хаалтан дээр цохон тэмдэглэсэн. Эдгээр хэлэлцсэн асуудал бүрээр тус Судалгааны төв судалгаа, мэдээлэл гаргаж өгч байсныг та бүхэнд уламжлахад таатай байна. Тухайлбал, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль, Эрүүгийн хууль, Монгол улсын 2011 оны төсвийн тухай хууль зэрэг гол гол хуулиуд, бодлогын чанартай томоохон арга хэмжээнүүдийн талаархи тогтоолын төслийг хэлэлцэхэд мэдээллийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллалаа.

Түүнчлэн УИХ -ын эрхэм гишүүд УИХ -ын ээлжит чуулганаар хэлэлцсэн асуудлуудаас гадна нийгэмд тулгамдсан зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлуудаар хэд хэдэн томоохон судалгаа хийлгэсэн байна. Тухайлбал, Гадаадын зарим орнуудын 2 танхимтай парламентын талаархи судалгаа, Нийслэл хот дундуур урсан өнгөрдөг гол мөрний ашиглалт, хамгаалалт, менежментийн асуудал, Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах бодлого, Монгол улсын жижиг дунд үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, Хараа хяналтгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тулгамдсан асуудлууд, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар олон нийтээс гарч байгаа санал шүүмжүүд гэх мэт.

УИХ -ын эрхэм гишүүдээс ирүүлж буй захиалга өргөжихийн хэрээр тус Судалгааны төвийн үүрэг роль, ажлын ачаалал нэмэгдэж байна. Тус төв нь зөвхөн чуулганаар хэлэлцэх асуудлууд төдийгүй гишүүдийн хүсэлтээр цаг үеийн асуудлууд, хууль болон тогтоолын төсөл санаачлахтай холбоотой судалгаануудыг гүйцэтгэж байна. Мөн Хуулийн ажлын хэсгүүдийг мэдээлэлээр хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэргээр шаардлагатай үед УИХ болон УИХ -ын Тамгын газрын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.

УИХ -ын Тамгын газрын зүгээс гишүүдэд үзүүлж буй үйлчилгээг боловсронгуй болгох, мэдээлэл түгээлт, хүртээмжийг сайжруулах зорилгоор бүх гишүүдийг iPad бичил компьютерээр хангасан. Цаашид УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн гүйцэтгэсэн судалгааны ажлуудыг эрхэм гишүүд та бүхэн MyParliament дотоод сүлжээнээс цаг тухай бүрт нь бүрэн эхээр нь уншиж ашиглах боломжтой болсоныг дуулгахад таатай байна.

Тус төв нь УИХ -ын дараа дараагийн чуулганаар хэлэлцэхээр төлөвлөж байгаа асуудлуудын ач холбогдол, онцлогийг харгалзан төсөв, санхүү, уул уурхай зэрэг салбарын асуудлууд, мөн нийгэм - эдийн засгийн тулгамдсан асуудлуудад анхаарлаа хандуулан ажиллаж байна.

УИХ -ын эрхэм гишүүд та бүхэнд мэдээлэл, судалгааны шуурхай үйлчилгээ үзүүлэн төрийн бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх нь тус төвийн үүрэг бөгөөд эдгээр судалгааны цуврал эмхэтгэл нь та бүхэнд гарын авлага, мэдээллийн эх сурвалж болон ашиглагдана гэдэгт найдаж байна.

Номын арвин цагаан буян дэлгэрэх болтугай.

Ц. Норовдондог (УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, Ph.D)



1

БҮЛЭГ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН “ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙГ ХУУЛЬ
БУСААР АВАХ” ГЭМТ ХЭРЭГ, “ГЭМТ ХЭРЭГТ ХАМТРАН ОРОЛЦОХ” ТАЛААРХИ
ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Р. Хатанбаатар, Б. Ариунжаргал, П. Амаржаргал, Ө. Мөнхтунгалаг,
О. Нарантуяа, А. Пагма*

СЭДВИЙН АГУУЛГА

1. “Гэмт хэрэгт хамтран оролцох” талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт

- 1.1. ХБНГУ
- 1.2. ОХУ
- 1.3. Япон Улс
- 1.4. АНУ
- 1.5. БНСУ

2. “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэргийн талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт

- 2.1. ХБНГУ -ын Эрүүгийн хуулийн “Төрөөс урвах” гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт
- 2.2. ОХУ -ын Эрүүгийн хуулийн “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт
- 2.3. Япон Улсын Эрүүгийн хуулийн “Хуйвалдаантай холбогдох” гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт
- 2.4. АНУ -ын Эрүүгийн хуулийн “Бослого, үймээн гаргах”, “Эсэргүүцлийн хуйвалдаан, явуулга” хийх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт
- 2.5. БНСУ-ын Эрүүгийн хуулийн “Дотоодын үймээн самууны гэмт хэрэг”, “Нийгмийн аюулгүй байдлын эсрэг” гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт

3. Судалгааны дүгнэлт

Ашигласан материал

* * *

УДИРТГАЛ

УИХ-ын гишүүн Э.Бат-Үүлийн захиалгаар “Гадаадын зарим орны эрүүгийн хуулийн “Гэмт хэрэгт хамтран оролцох” ба “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэргийн ойлголт, эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Гадаадын зарим орны, тухайлбал, захиалгын дагуу ХБНГУ, ОХУ, АНУ, БНСУ, Япон Улсын эрүүгийн хуулийн “Гэмт хэрэгт хамтран оролцох” ба “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэргийн ойлголт, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, Монгол Улсын Эрүүгийн хуулийн зохих зүйл, ангиудтай харьцуулан дүгнэлт гаргахад оршино.

Судалгааны эмхтгэл, Х боть

Судалгааны зорилтууд:

- Гадаадын зарим орны эрүүгийн хуулийн “Гэмт хэрэгт хамтран оролцох” ойлголт, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Гадаадын зарим орны эрүүгийн хуулийн “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэргийн ойлголт, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Дээрх орнуудын эрүүгийн хуулийн зохих заалтуудыг Монгол Улсын эрүүгийн хуулийн “Гэмт хэрэгт хамтран оролцох” ба “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах” гэмт хэргийн ойлголт, эрх зүйн зохицуулалттай харьцуулан дүгнэлт гаргах зэрэг болно.

Судалгааны аргачлал:

- Гадаадын зарим орнуудын эрүүгийн хуулийн холбогдох бүлэг заалт,
- Гадаадын зарим орны эрүүгийн эрх зүйн тухайн ойлголт, эрх зүйн зохицуулалтыг харьцуулах
- Судалгааны материалыг харьцуулан нэгтгэн дүгнэх

Хамрах хүрээ:

1. ХБНГУ, ОХУ, АНУ, БНСУ, Япон Улсын эрүүгийн хуулийн “Гэмт хэрэгт хамтран оролцох” ойлголт, эрх зүйн зохицуулалт,
2. ХБНГУ, ОХУ, АНУ, БНСУ, Япон Улсын эрүүгийн хуулийн “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэргийн ойлголт, эрх зүйн зохицуулалт,
3. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зохих зүйл, заалт

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын Газрын Судалгааны төвийн ахлах референт Р. Хатанбаатар ахалж, ХБНГУ, АНУ, Япон улсын эрүүгийн хуулийн “Гэмт хэрэгт хамтран оролцох” ойлголт, эрх зүйн зохицуулалт, судлаач Б. Ариунжаргал, Ө. Мөнхтунгалаг АНУ-ын Эрүүгийн хууль, П. Амаржаргал Япон улсын Эрүүгийн хууль, О. Нарантуяа БНСУ -ын Эрүүгийн хууль, А. Пагма ОХУ -ын Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтуудын судалгааг тус тус хийж гүйцэтгэв.

* * *

Нэг. “Гэмт хэрэгт хамтран оролцох” талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт

1.1. ХБНГУ

Германы Эрүүгийн хуулинд гэмт хэрэгт хамтран оролцох гэсэн ойлголт байхгүй. Германы эрүүгийн эрх зүйн номлолоор гэмт хэрэгт хамтран оролцох гэдгийг санаатай гэмт хэрэг үйлдэхэд хэд хэдэн этгээд янз бүрийн хэлбэрээр оролцохыг ойлгодог. Хууль болон хуулийг хэрэгжүүлэх практикт гэмт хэрэгт хамтран оролцох үндсэн 2 хэлбэрийг хэрэглэдэг.

1. Гүйцэтгэх
2. Хатгах ба хамжих. Иймд гэмт хэргийн захиалагч ба зохион байгуулагч гэсэн

ойлголт Эрүүгийн хуульд байхгүй.

Гүйцэтгэх. Үүнийг Германы Эрүүгийн хуулийн 25 дугаар зүйлд 3 үндсэн хэлбэрээр тусгасан байна.

1. Ганцаар гүйцэтгэх
2. Хэн нэгнийг ашиглан гүйцэтгэх
3. Хамтран гүйцэтгэх гэсэн 3 хэлбэр байна. Хуулийн 25 дугаар зүйлээс үзэхэд гэмт хэргийг өөрийн биеэр үйлдэх юмуу хэн нэгнийг ашиглан үйлдүүлж буй этгээдийг гүйцэтгэгч гэж үзнэ. Хэрэв хэд хэдэн этгээд хамтран үйлдвэл хамтран гүйцэтгэх хэлбэр болно.

Хатгах ба хамжих. Эрүүгийн хуулийн 26, 27 дугаар зүйлд гэмт хэрэгт хамтран оролцох хоёрдахь хэлбэр болох хатгагч ба хамжигчийн талаар заасан байна. Гүйцэтгэгчээс ялгагдах гол онцлог нь гэмт хэрэг үйлдэхэд голлох үүрэгтэй оролцоогүй байна. Хатгагч нь бусдыг гэмт хэрэг үйлдэхэд санаатайгаар өдөөн түлхсэн этгээд бол хамжигч нь бусдыг санаатайгаар гэмт хэрэг үйлдэхэд нь тусласан этгээд байна. Эрүүгийн хуулиар хатгагч нь гүйцэтгэгчтэй адилаар шийтгэгдэж байхаар заагдсан байдаг бол хамжигчийн шийтгэл нь гүйцэтгэгчийн шийтгэлтэй хамааралтайгаар тогтоогдох бөгөөд хатгагчаас илүү зөөлөн шийтгэл хүлээнэ.

Гэмт хэрэгт хамтран оролцох нь зөвхөн гэмт үйлдэл дуустлах хугацаанд хамаатай ба үүнээс хойш нуун дарагдуулах янз бүрийн хэлбэрийн талаар ярих бөгөөд энэ нь хуулийн өөр заалтаар шийтгэгдэнэ. Гэмт хэрэгт хамтран оролцогчдыг шийтгэхдээ дараах үндсэн зарчмыг барина.

1. Хамтран оролцогч бүр өөрийн бурууд тохирсон шийтгэл хүлээнэ.
2. Гүйцэтгэгчид шийтгэл хүлээлгэхэд онцгой хувийн шинж чанар шаардлагатай байсан бөгөөд энэ шинж чанар нь гэмт хэргийн хамтран оролцогчид болох хатгагч, хамжигч нарт байхгүй бол тэдэнд оногдуулах ялыг шүүхийн зүгээс хөнгөлөх ёстой
3. Хатгагч ба хамжигч гэмт хэрэгт хамтран оролцохоор завдсан бол хуулийн өөр нормоор, тухайлбал, гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж шийтгэл оногдуулах ба шийтгэл нь илүү хөнгөн байна. Мөн гэмт хэрэг үйлдэхэд бэлэн гэдгээ илэрхийлсэн, гэмт хэрэг үйлдэхээр бусдаас саналыг нь хүлээн авсан юмуу харилцан тохиролцсон, эсвэл гэмт хэрэгт хатгасан этгээд үүний адилаар шийтгэл хүлээнэ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий анги, 1-р хэсэг, 3-р бүлэг:

§ 25 Гүйцэтгэх

1. Гэмт хэргийг гардан хийсэн буюу бусдыг ашиглан хийсэн этгээд гэмт хэргийн гүйцэтгэгч гэж шийтгэгдэнэ.
2. Хэрэв гэмт хэргийг хэд хэдэн этгээд хамтран үйлдсэн бол этгээд бүр гүйцэтгэгч гэж шийтгэгдэнэ

§ 26 Хатгах

Бусад этгээдийг санаатайгаар хийх хуулийн эсрэг үйлдэлд санаатайгаар өдөөн түлхсэн хатгагчийг гүйцэтгэгчтэй адилаар шийтгэнэ.

§ 27 Хамжих

1. Бусад этгээдийн санаатайгаар хийх хуулийн эсрэг үйлдэлд санаатайгаар дэмжлэг үзүүлсэн этгээд хамжигч гэж шийтгэгдэнэ

2. Хамжигчийн шийтгэл гүйцэтгэгчийн шийтгэлтэй холбоотойгоор тодорхойлогдох ба энэ хуулийн § 49, абзац1-ийн дагуу хөнгөлөгдөнө

§ 28 Хувийн онцгой шинжүүд

1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн шийтгэл нь түүний хувийн онцгой шинжид үндэслэн оноогдсон бөгөөд тийм онцгой шинж хамтран үйлдсэн этгээдэд (хатгагч, хамжигч) байхгүй бол шийтгэл уг этгээдийн шийтгэл энэ хуулийн § 49, абзац1-ийн дагуу хөнгөлөгдөнө

2. Хэрэв хуулиар онцгой шинж нь ноогдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөлөх эсвэл хүчингүй болгохоор байвал энэ нь зөвхөн уг шинж бүхий гэмт хэргийн оролцогчид хамаатай.

§ 29 Хамтран оролцогчийн бие даан шийтгэгдэх

Гэмт хэргийн хамтран оролцогч бүр бусдынхаа гэм буруугийн хэмжээнээс хамаарахгүй бие даан шийтгэгдэнэ.

1.2.ОХУ

Гэмт хэрэгт хамтран оролцох

ОХУ -ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн “Гэмт хэрэгт хамтран оролцох” гэсэн 7 дугаар бүлгийн 32, 33, 34 дүгээр зүйлүүдэд гэмт хэрэгт хамтран оролцох ойлголт, хамтран оролцогч, түүний төрөл, гэмт хэрэгт хамтран оролцсон тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хуульчилжээ.

Гэмт хэрэгт хамтран оролцох ойлголт (32-р зүйл)

Гэмт хэргийг нэг хүн бус харин хэд хэдэн хүн хамтран үйлдэхийг гэмт хэрэгт хамтран оролцох гэнэ. Хамтран үйлдсэн гэмт хэргийн төлөө хариуцлага хүлээх, гэмт хэрэгт хамтран оролцсоны объектив, субъектив шинж чанар нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн зүйлээр тодорхойлогдсон.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 32-р зүйлд “Гэмт хэрэг санаатай үйлдэхэд хоёр буюу түүнээс дээш этгээд нэгдсэнийг хамтран оролцох гэнэ”¹ хэмээн хуульчилжээ.

ОХУ-ын эрүүгийн эрх зүйн үүднээс гэмт хэрэг үйлдэхэд хоёр буюу түүнээс дээш этгээд нэгдэн үйлдсэн байдал нь гэмт хэрэгт хамтран оролцох ойлголтын объектив шинжийг илэрхийлдэг байна.

Гэмт хэрэгт хамтран оролцогч бүр үйлдэх гэмт хэргээ туйлд нь хүргэхэд чиглэсэн нэгдсэн зорилготой, нийгэмд аюултай үйлдэл хийхийг хүсч байдаг онцлогоороо дангаараа гэмт хэрэг үйлдэгчээс ялгагдана. Гэмт хэрэгт хамтран оролцогч бүрийн үйлдэл, гэмт хэргийн үр дагавар нь хоорондоо нарийн учир шалтгааны холбоотой байдаг нь хамтран оролцсоныг илэрхийлдэг нэг гол шинж юм. Гэмт хэрэгт хамтран оролцогч бүрийн оролцоо янз бүр байснаас үл шалтгаалан тэдний зохицуулалттай үйл ажиллагаагаар гэмт үйлдэл үр дүнд хүрдэг.

Гэмт хэрэгт хамтран оролцогчид нь зүгээр нэг үйлдэл хийх бус, харин энэхүү үйлдэл нь гэмт хэргийг эцэст нь хүргэхэд зайлшгүй шаардлагатай нөхцөлийг бий болгоход чиглэгдсэн байдаг. Бие биентэйгээ харилцан холбоогүй хэд хэдэн этгээд бие даан нэг объектод хор хохирол учруулсаныг гэмт хэрэгт хамтран оролцсон гэж үздэггүй.

¹ Уголовный Кодекс РФ, гл.7, ст.32

Гэмт хэрэгт хамтран оролцохын субъектив шинж нь гэмт хэргийн хамтран оролцогч бүр гэмт хэргийг санаатай үйлдэхийг илэрхийлдэг. Гэмт хэрэгт хамтран оролцоход санамсаргүй үйлдэл гэж байдаггүй. Гэмт хэрэг хамтран санаатай үйлдэх нь оролцогч бүр өөрийн үйлдлийн нийгмийн аюултай байдал, тэдний хувьд нийтлэг нэг гэмт хэргийн объектод халдах гэж байгаагаа ухамсарласан, хамтран гэмт хэрэг хийх гэж байгаа талаар мэдсэний үндсэн дээр гэмт хэрэг үйлддэг байна.

ОХУ -ын Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 32-р зүйлийн шаардлага нь Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан бүлэглэн гүйцэтгэх, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн үйлдсэн гэмт хэрэгт хамаарахгүй.

Гэмт хэрэгт хамтран оролцогч, түүний төрөл (33-р зүйл)

Гэмт хэрэгт хамтран оролцогчдыг оролцогч бүрийн үйлдлийн шинжээр нь гүйцэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигч гэж ангилан авч үздэг. Гэмт хэрэгт хамтран оролцогч бүрийн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, үйлдлийн шинж чанар, хэр хэмжээ нь эрүү-эрх зүйн ач холбогдолтой ба гэмт хэрэгт нэг этгээд олон янзын үүрэг гүйцэтгэх боломжтой.

Эрүүгийн хуулиар гэмт хэрэг гардан гүйцэтгэсэн этгээдийг **гүйцэтгэгч** гэх бөгөөд гүйцэтгэгч нь нэг ба хэд хэдэн хүн байж болно. Ийм тохиолдолд тэдгээрийг хамтран гүйцэтгэгч гэнэ. Хамтран гүйцэтгэгчдын дотроос хамгийн аюултай нь **зохион байгуулагч** юм. Тэрээр гэмт хэргийг үйлдэхэд биечлэн оролцоогүй байж болно. Эрүүгийн хуулийн 33-р зүйлд зааснаар “Гэмт хэрэг үйлдэхийг гардан зохион байгуулсан буюу удирдсан этгээдийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийг үүсгэн, зохион байгуулсан этгээдийн нэгэн адилаар зохион байгуулагч гэнэ”².

Гэмт хэргийн зохион байгуулалт нь гэмт хэргийн төлөвлөлт, оролцогчдыг сонгон авч үүргийг хуваарилах, гэмт хэргийн объектын талаар мэдээлэл цуглуулах, гэмт хэрэг үйлдэхэд шаардлагатай хэрэгсэл, зэр зэвсэг бэлтгэх, гэмт хэрэг үйлдэх арга боловсруулах зэрэг олон үйлдлээс бүрдэнэ. Гэмт хэргийн зохион байгуулалт нь шийдвэр гаргах, хамтран оролцогч бүрийн үйлдлийг гэмт хэрэг үйлдэхэд чиглүүлж, зохицуулах, гэмт хэргийн үйлдлийг нуун далдлах зэрэгээс бүрдэнэ.

Гэмт хэрэгт хамтран оролцохыг ятгах, заналхийлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд бусдыг өдөөн түлхсэн, зоригжуулсан этгээдийг **хатгагч** гэнэ. Гагцхүү хатгагч нь бусдад гэмт хэрэг үйлдэх сэдэл төрүүлдэг байна. Тодорхой гэмт хэрэгт оролцоход бусдыг татах зорилго агуулаагүй ерөнхий уриалга, тодорхой этгээдэд хандаагүй ерөнхийдөө гэмт хэрэг үйлдэх хүслээ илэрхийлсэн нь хатгалагад тооцогдохгүй.

Гэмт хэрэг үйлдэхэд зааж зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлах, зарж борлуулах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амласан этгээдийг **хамжигч** гэнэ.

Хамжигч нь гэмт хэрэг үйлдэхэд тусалж, түүнийг гүйцэтгэх таатай нөхцөлийг бий болгож өгдөг байна. Хамжигчийг оюун санааны хувьд ба биечлэн хамжсан гэж ангилдаг ба оюун санааны хувьд хамжлага үзүүлэх нь үргэлж үйлдэл байдаг бол биечлэн хамжсан нь үйлдэл, эс үйлдлээс бүрдэнэ.

² Уголовный Кодекс РФ, гл.7, ст.33

Гэмт хэрэгт хамтран оролцсон тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлага (34 -р зүйл)

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 7.32-р зүйлээр “Гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг сонгон хэрэглэхдээ оролцогч бүрийн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, үйлдлийн шинж чанар, хэр хэмжээг харгалзан тогтооно”³ хэмээн хуульчилжээ.

Гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үйлдлийн шинж чанар, хэр хэмжээг тогтооно гэдэг нь оролцогч бүрийн гэмт хэргийн үйлдэлд түүнд ногдуулсан үүргийг гүйцэтгэхдээ гаргасан идэвхи, үүрэг, түүний зүгээс гэмт хэрэгт бэлтгэх, үйлдэх үйл явц болон бусад оролцогчдод үзүүлсэн нөлөөлөл, гэмт үйлдэлийн зорилгод хүрэхэд түүний оруулсан бодит үйлдлийн мөн чанар, хэр хэмжээ, гэмт хэргийг үйлдсэнээр хуулиар хамгаалсан эрх ашигт үзүүлсэн бодит хохирол ба үзүүлж болох байсан хохирлыг тодорхойлохыг хэлнэ. Эдгээрийг гэмт хэрэгт хамтран оролцогчид ял оногдуулахад харгалзан үздэг (**67-р зүйл**).

Эрүүгийн хуулийн 34-р зүйлд гэмт хэрэгт хамтран оролцсон тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар доорхи эрх зүйн зохицуулалтыг хуульчилан заасан байна. Үүнд:

- Хамтран гүйцэтгэгчид /соисполнители/ Эрүүгийн хуулийн 33-р зүйлийг удирдлага болгохгүйгээр Тусгай ангийн гэмт хэргийн заалтаар ял шийтгэл оногдуулна,
- Гэмт хэргийн хамтран оролцогчид болох зохион байгуулагч, хатгагч, хамжигчид нь нэгэн зэрэг гүйцэтгэгч бус тохиолдолд Эрүүгийн хуулийн 33-р зүйлийг удирдлага болгон Тусгай ангийн гэмт хэргийн заалтаар ял шийтгэл оногдуулна,
- Субъект нь Эрүүгийн хуулийн Тусгай ангид тусгайлан заагдсан гэмт хэрэгт хамтран оролцогчид нь гэмт хэргийн зохион байгуулагч, хатгагч, хамжигчийн хувьд эрүүгийн хариуцлага хүлээнэ, /Субъект нь Эрүүгийн хуулийн Тусгай ангид тусгайлан заагдсан гэдэг нь тусгай субъект, тухайлбал, албан тушаалтан, цэргийн албан хаагч г.м /
- Өөрөөс нь үл шалтгаалах шалтгаан нөхцөлийн улмаас гүйцэтгэгч хэргийг төгсгөж чадаагүй бол гэмт хэргийн бусад оролцогчид гэмт хэрэг үйлдлэхээр бэлтгэсэн буюу гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэсэн ангилалаар эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэрэгт хамтран оролцсон тохиолдолд зайлшгүй ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг заагаагүй боловч хуульд бас ял шийтгэлийг тэгшитгэн оногдуулахыг хориглосон байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 67 -р зүйлд “Гэмт хэрэгт хамтран оролцогчид ял оногдуулахдаа оролцогч бүрийн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үйлдлийн шинж чанар, хэр хэмжээ, түүний оролцоо гэмт хэргийн зорилгод хүрэхэд гүйцэтгэсэн үүрэг, гэмт хэргийн үзүүлсэн хор хохиролд нөлөөлсөн байдал зэргийг харгалзан тогтооно”⁴ хэмээн хуульчилжээ. Түүнчлэн мөн 67-р зүйлд “Хамтран оролцогчдын хэн нэгний ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тооцохдоо зөвхөн тухайн оролцогчын ял шийтгэлийг оногдуулахдаа харгазан үзнэ” гэж заасан байна.

ОХУ-ын эрүүгийн хууль тогтоомжоор гэмт хэрэгт хамтран оролцогчид тус бүр өөрийн хийсэн хэргийн шинж чанар, хэр хэмжээ, гүйцэтгэсэн үүрэг, гэм буруугийнхаа төлөө бие даасан, ялгамжтай оногдуулсан ял шийтгэл хүлээхээр эрх зүйн зохицуулалт хийсэн байна.

³ Уголовный Кодекс РФ, гл.7, ст.34

⁴ Уголовный Кодекс РФ, гл.7, ст.67

1.3. Япон

Японы эрүүгийн эрх зүйн номлолоор гэмт хэрэгт хамтран оролцох асуудлын гарцаагүй хамтран оролцох, сайн дураар хамтран оролцох гэсэн хоёр үндсэн хэлбэрийг авч үздэг. Гарцаагүй гэдэг нь гэмт хэрэг зөвхөн хамтран үйлдэж байж бололцоотой болох тохиолдлыг хэлнэ. Харин гэмт хэргийг ганцаар үйлдэх бололцоотой байсан бол сайн дурын хамтран оролцох гэсэн тохиолдол болно. Японы эрүүгийн хуулийн ерөнхий ангид зөвхөн сайн дурын хамтран оролцох тухай асуудлуудыг тусгасан байдаг бол гэмт хэрэгт гарцаагүй хамтран оролцох тухай асуудал нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн нормоос мөрдөн гарах категори юм.

Гэмт хэрэгт сайн дураар хамтран оролцох. Хамтран гүйцэтгэх, хатгах, хамжих гэсэн гурван үндсэн хэлбэр байх бөгөөд Японы Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 60, 61, 62 дугаар зүйлд тусгагдсан. Үүнийг дор үзүүлэв:

§60 дугаар зүйл. Хамтран үйлдэгсэд

Хоёр болон түүнээс дээш тооны этгээд хамтадаа эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн бол бүгд гэмт хэргийг үйлдэгч гэж тооцогдоно.

§61 дүгээр зүйл. Хатгах

61.1. Бусдыг гэмт хэрэг үйлдэхэд хатгасан этгээд үйлдэгчтэй адил хэмжээгээр шийтгэгдэнэ.

61.2. Өмнөх хэсэгт заасан заалт нь хатгагчийг хатгагчид мөн адил хамаарна.

§62 дугаар зүйл. Туслах

62.1. Гэмт хэрэг үйлдэгчидэд тусалсан этгээд нь туслагч байна.

62.2. Туслагчийг хатгасан этгээд туслагчтай адил шийтгүүлнэ.

§63 дугаар зүйл. Туслагчийн талаархи нэмэлт заалт

Туслагчид ногдуулах ял нь үйлдэгчид ногдуулах ялнаас хөнгөн байна.

§64 дүгээр зүйл. Хатгах болон туслахад ял ногдуулахтай холбогдох хязгаарлалтууд

Хуульд өөрөөр заагаагүй бол бага хэмжээгээр торгуулах болон баривчлах ялаар шийтгүүлэх гэмт хэргийн туслагч болон хатгагчид ял шийтгэл ногдуулахгүй.

§65 дугаар зүйл. Хамтран оролцогчид

65.1. Гэмт хэрэгт гүйцэтгэгчээр оролцсон этгээд болон үүрэг нь тодорхой тогтоодоггүй этгээдийг хамтрагч гэж тооцно.

65.2. Гэмт хэрэгт оролцсон оролцооноос хамаарч ял шийтгэлийн хүнд хөнгөний байдлыг тогтоох ба үүрэг оролцоо нь тодорхой бус этгээдэд энгийн ял шийтгэл ногдуулна.

Хоёр болон түүнээс олон этгээд хамтдаа гэмт хэрэг үйлдсэн бол хамтран гүйцэтгэх гэнэ. Гэхдээ хамтран гүйцэтгэхэд хоёр янзаар хандана.

1. Гэмт хэрэг хамтран гүйцэтгэх буюу оролцогчид хамтран тодорхой гэмт хэрэг үйлдэх,
2. Гэмт үйлдэлд хамтрах буюу оролцогчид нэгдэн тус тусдаа тодорхой гэмт үйлдэл хийх.

Судалгааны эмхтгэл, Х боть

Мөн гэмт хэрэг хамтран гүйцэтгэх нөхцлийг субъектив ба объектив гэж ангилна. Субъектив тал нь хоёр буюу хэд хэдэн этгээд ерөнхий нэг гэмт хэргийн санаа агуулах байдаг бол объектив тал нь хамтарсан үйлдэл байдаг. Хэрэв хэд хэдэн этгээд гэмт хэрэг үйлдэх хуйвалдаанд хамтран оролцсон боловч тэдний зарим хэсэг нь гэмт хэргийг үйлдсэн бол хуйвалдаанд оролцсон бүх хүнд хамтран оролцсон гэж ял тулгадаг байна. Гэхдээ хэргийн байдлаас шалтгаалж хамтран гүйцэтгэгчийн шийтгэлийг хөнгөлөн авч үзнэ.

Хүнийг гэмт хэрэг үйлдэхэд өдөөн түлхэж, зоригжуулсан этгээд буюу хатгагчийг хэрэв уг гэмт хэрэг үйлдэгдсэн бол гүйцэтгэгчтэй адилаар шийтгэнэ. Гэхдээ зарим тохиолдолд хатгагчийг тусд нь бие даасан хэрэг гэж үзэн яллах нь бий. Жишээлбэл, төрийн албан хаагч ажил хаялт, эсэргүүцэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаанд уриалсан, ухуулсан бол ийнхүү яллана.

Бусдыг гэмт хэрэг үйлдэхэд нь тусалсан буюу үйлдлийг нь хөнгөвчилсөн хамжигчийг гүйцэтгэгчээс хөнгөнөөр яллана. Хамжих үйл ажиллагаа нь хугацааны хувьд гэмт хэрэг үйлдэхээс өмнө юмуу үйлдэх үед хамаарна. Гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэгтэнг нуух, гэмт хэргийн баталгааг устгах, хулгайлагдсан зүйлийг ашиглах зэргийг тусд нь бие даасан гэмт хэрэг гэж үзнэ.

Гэмт хэрэгт гарцаагүй хамтран оролцох. Үүнийг дотор нь 2 ангилна.

1. Нэгдсэн хэлбэрийн гэмт хэрэг
2. Эсрэг байрлалын хэрэг гэнэ.

Хоёр буюу хэд хэдэн этгээд нэгэн зорилгоор хийсэн хэргийг нэгдсэн хэлбэрээр хийсэн хамтарсан гэмт хэрэг гэнэ. Жишээлбэл, дотоодын бослого, үймээн самуун зохион байгуулсан тохиолдолд оролцогчид харилцан ялгаатайгаар шийтгэгдэнэ. Үүнд: толгойлогчийг цаазаар авах буюу албадан хөдөлмөр хийлгэлгүй бүх насаар нь хорих, хуйвалдаанд оролцогчийг албадан хөдөлмөр хийлгэлгүй бүх насаар нь хорих юмуу гурваас доошгүй жил хорих ял, бусад үүрэгтэйгээр оролцсон хүмүүсийг албадан хөдөлмөр хийлгэлгүй нэгээс арван жил хорих, ердийн оролцогчдыг албадан хөдөлмөр хийлгэлгүй гурав хүртэл жил хорих шийтгэл хүлээдэг байна.

Гэмт хэрэгт гарцаагүй хамтран оролцох эсрэг байрлалын хэрэг гэж хоёр буюу хэд хэдэн этгээд өөд өөдөөсөө харилцан холбогдож гэмт үйлдэл хийхийг хэлнэ. Олон тохиолдолд ийм хэргийн оролцогчид аль аль тал нь шийтгэл хүлээнэ. Жишээлбэл: олон эхнэр юмуу нөхөртэй байх, хээл хахууль гэх мэт хэрэг ингэж шийдэгдэнэ. Зарим тохиолдолд зөвхөн нэг тал нь л шийтгэгдэнэ, жишээлбэл, порнографийн ном хэвлэл худалдах.

1.4.АНУ

АНУ-ын эрх зүйд гэмт хэрэгт хамтран оролцох тухай ойлголт нь Английнхтай үндсэндээ адил юм. Гэмт хэрэгт хамтран оролцогчдыг гэмт хэрэг үйлдэхийн өмнө ба дараах гэж хуваахаас гадна гүйцэтгэгчийг нэгдүгээр ба хоёрдугаар зэргийн гэж ангилна. **Нэгдүгээр зэргийн гүйцэтгэгч** гэж гэмт хэргийн гол буруутныг хэлэх бөгөөд ихэнх тохиолдолд гэмт хэргийг өөрөө биечлэн гүйцэтгэсэн этгээд байна. Гэхдээ гэмт хэргийг буруугүй этгээдийг ашиглан хийлгэсэн байх тохиолдолд уг этгээд шийтгэл хүлээхгүй. Учир нь уг этгээд хийсэн үйлдэлдээ ямар нэгэн гэмт санаа агуулаагүй гэж үзнэ. Жишээлбэл, компанийн захирал хуурамч тооцооны хуудсанд санаатайгаар гарын үсэг зурж, хуурамч гэдгийг нь мэдээгүй ажилтнаар банкнаас мөнгө авахуулсан тохиолдол бий. **Хоёрдугаар зэргийн гүйцэтгэгч** гэдэгт хатгагч ба хамжигчийг голлон ойлгоно.

Нэг ба хоёрдугаар зэргийн гүйцэтгэгчийг гэмт хэрэг үйлдэгдэх үед газар дээр нь байсан гэдгийг голлон харах боловч конструктив хэлбэрээр газар дээр нь байсан гэж үзэж шийтгэл

онооно. Жишээлбэл, хэн нэг этгээд санаатайгаар хордуулсан ундаа орхисныг нь хохирогч уусан байвал нэгдүгээр зэргийн гүйцэтгэгч конструктив хэлбэрээр газар дээр нь байсан гэж үзнэ. Харин нэгдүгээр зэргийн гүйцэтгэгч гэмт хэрэг үйлдэж байх үед нь хэн нэгэн этгээд өөр газар байгаад хохирогчийн ирж явааг мэдэгдэх юмуу анхаарлыг сарниулах байдлаар гэмт хэрэгт тусалсан бол хоёрдугаар зэргийн гүйцэтгэгч болно.

Хэрэв хэн нэг этгээд гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө зөвлөлгөө, тусламж болон ямарваа өөр хэлбэрээр гэмт хэрэгт тусласан боловч гэмт хэргийн газар дээр байгаагүй бол хамжигч гэж үзнэ. Иймд уг этгээд хэргийн газар дээр байсан юмуу конструктив хэлбэрээр байсан бол хоёрдугаар зэргийн гүйцэтгэгч, байгаагүй бол гэмт хэрэг хэрэг гарахаас өмнөх үеийн **хамжигч** болно.

Хэрэв гэмт хэргийн гүйцэтгэгч болон хамжигч нарыг барих, шийтгэх, ял эдлүүлэх үйл ажиллагаанд саад болох зорилгоор тэдэнд тусалсан бол гэмт хэрэг үйлдэгдсэний дараах хамжигч болно. Эх газрын эрх зүйтэй орнуудад гэмт хэрэгт хамтран оролцогчийг зөвхөн гэмт хэрэг үйлдэгдэж дуусах хүртэлх хугацаагаар тооцогоос Англи-Саксоны эрх зүйтэй орнуудынх үүгээрээ ялгаатай.

Нэг ба хоёрдугаар зэргийн гүйцэтгэгчдийг гэмт хэрэгт адилхан буруутай гэж үзэх боловч тус тусд нь бие даан хариуцлага хүлээлгэнэ. Гэмт хэрэг гарахаас өмнөх хамжигч бие даан тусдаа хариуцлага хүлээхгүй боловч гүйцэтгэгчдийн ядаж нэг нь л шийтгэгдсэн тохиолдолд мөн шийтгэл хүлээж болно.

Гэхдээ АНУ-ын муж улс бүрийн Эрүүгийн хуульд гэмт хэргийн хамтран оролцогчийн талаар ялгаатай тодорхойлсон байдгийг анхаарах хэрэгтэй. Ихэнхдээ гэмт хэрэгт хамтран оролцох гэсэн ерөнхий тодорхойлолт байхгүй бөгөөд хамтран оролцох янз бүрийн хэлбэрийг тодорхойлсон байна.

1.5.БНСУ

БНСУ -ын Эрүүгийн хууль нь 1953 оны 9 сарын 18-ны 293-р хуулиар батлагдаж 4 удаа нэмэлт өөрчлөлт орж, одоо хүртэл үйлчилж буй юм. Солонгост гэмт хэргийн субъект 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна.

Солонгосын эрүүгийн хуулийн 30-34 дүгээр зүйлд гэмт хэрэгт хамтран оролцохыг

- Гүйцэтгэгч /бүлэглэн гүйцэтгэгч/
- Хатгагч
- Хамжигч гэсэн 3 төрлийг хуульчилсан.

БНСУ -ын Эрүүгийн хуулийн 3-р хэсэг:

3 дугаар хэсэг. Хамтран оролцогч

§30 дугаар зүйл. Хамтран оролцогчийн нөхцөл байдал

Хоёр ба түүнээс дээш этгээд хамтран гэмт хэрэг үйлдэхийг бүлэглэн гүйцэтгэх гэнэ. Оролцогч бүр гүйцэтгэгчээр ял шийтгэнэ.

§31 дүгээр зүйл. Хатгах

1. Бусад хүнийг хатган гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэргийг гүйцэтгэсэн этгээдтэй адилаар ял шийтгэнэ.
2. Хатгагдагч гэмт хэргийг хэрэгжүүлэхээр гар бие оролцож эхэлсэн боловч зорилгодоо хүрч чадаагүй тохиолдолд хатгагч болон хатгагдагчийг хуйвалдсан



Судалгааны эмхтгэл, Х боть

мөн бэлтгэсэнээр ял шийтгэнэ.

3. Хатгагдсан этгээд гэмт хэрэг үйлдэхгүй, үйлдэхийг хүсээгүй тохиолдолд хатгагч өөрөө хариуцлага хүлээнэ.

§32 дугаар зүйл. Хамжигч

1. Бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхэд тусалж дэмжсэн этгээдийг хамжигчаар ял шийтгэнэ.
2. Хамжигч этгээдийн ял шийтгэлийг хатгагчаас хөнгөн ял ногдуулна.

§34 дүгээр зүйл.

1. Аль ч үйлдлээр ял шийтгүүлээгүй этгээд болон гэмт хэргийн шинжтэй хайхрамжгүйгээр ял шийтгүүлсэн этгээд нь хатгагч мөн хамжигчийн гэмт хэргийн үйлдлийн үр дүнг үүдэн гарсан бол хатгагч мөн хамжигчаар ял ногдуулна.

Хоёр. “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэргийн талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт

Үндсэн хуулийн бус аргаар буюу зэвсгийн хүчээр тухайлбал, нууц хуйвалдаан зохион байгуулах аргаар төрийн эрх мэдлийг авах нь гэмт хэрэгт тооцогдоно. Ийм гэмт хэргийн объект нь тухайн улсын улс төрийн системийн үндсэн хуулийн байгуулалт байна. Гэмт хэргийн объектив тал нь а) төрийн эрх мэдлийг булаан авах, б) төрийн эрх мэдлийг үндсэн хуулийг зөрчин хадгалах, в) үндсэн хуулийн байгууллыг өөрчлөх зэргийг хүчээр гүйцэтгэх буюу завдах үйлдэл байна.

Хүч хэрэглэх юмуу хүч хэрэглэхээр сүрдүүлэхдээ хууль ёсны хүчний байгууллага, хууль бус зэвсэгт бүлэглэл юмуу иргэдийн зохион байгууллалттай хүчийг ашигласан байдгаараа дээрх төрлийн гэмт хэрэг хүчирхийллийн шинжтэй байдаг. Төрийн эрх мэдлийг булаан авах - эрх бүхий этгээдүүдийг төрийн эрх мэдлээс хууль бусаар зайлуулж, төрийн эрх мэдэлгүй этгээдүүд, бүлэглэл болон байгууллага дур мэдэн эрх мэдлийг авахыг хэлнэ. Төрийн эрх мэдлийг хууль бусаар хадгалан барих - Үндсэн хуулиар өмнө засгийн эрх барьж байсан этгээдүүд бүрэн эрх нь дуусгавар болсон ч хууль бусаар үргэлжлүүлэн төрийн эрхийг барихыг хэлнэ.

Үндсэн хуулийн байгууллыг өөрчлөх – Үндсэн хуулийг зөрчин үндсэн хуулийн байгууллыг бүрэн буюу хэсэгчлэн солихийг хэлнэ. Жишээлбэл, төрийн байгуулалт, засгийн эрхийн системд аль нэг институцийг үндсэн хуулийг зөрчин татан буулгах юмуу бий болгох Төрийн эрхийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах – Үндсэн хуулийн бус аргаар, төрийн эрх мэдлийг олж авах зорилгоор хэсэг бүлэг этгээд Үндсэн хуульд заасан төрийн эрх мэдэл нэгээс нөгөөд шилжих журмыг санаатайгаар, хүчээр зөрчихөөр нууцаар үгсэн тохиролцохыг хэлнэ.

Дээрх гэмт хэргүүд нь агуулгаараа төрийн эрх мэдлийг хүчээр булаан авах, төрийн эрх мэдлийг хууль бусаар хадгалан барих юмуу үндсэн хуулийн байгууллыг хүчээр өөрчлөх үйл ажиллагаанд бэлтгэсэн зохион байгуулалтын үйл ажиллагаа байдаг бол хэлбэрийн хувьд үндсэндээ төрийн эргэлт хийх зорилготой хуйвалдаан байна.

Төрийн эрх мэдлийг хүчээр булаан авах, төрийн эрх мэдлийг хууль бусаар хадгалан барих юмуу үндсэн хуулийн байгууллыг хүчээр өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа явагдаж эхэлсэн мөчөөс энэ төрлийн гэмт хэргийг үйлдэгдсэнд тооцно. Энэ нь санаачлагчдын хувьд хуйвалдаан зохион байгуулагдсныг нотлох хэлцэл явагдсан тэр мөчөөс эхлэн гэмт хэрэг үйлдэгдсэн гэж тооцогдох бол гэмт хэрэгт татагдан орсон этгээдүүдийн хувьд зохион байгуулалтын үйл ажиллагаа юмуу хүчирхийллийн үйл ажиллагаанд оролцохоо зөвшөөрсөн мөчөөс гэмт хэрэг үйлдсэнд тооцогдоно гэсэн үг юм.

АНУ Төрийн эсрэг гэмт хэргийг хамгийн ноцтой гэмт хэрэг гэж үзэж бүх насаар нь хорих юмуу цаазаар авах ял хүртэл оноодог. Үндэсний хэмжээний төрийн эсрэг гэмт хэрэг учир ийм хэрэг нь холбооны хууль тогтоомжийн хэмжээнд зохицуулагдана, тухайлбал, АНУ-ын Үндсэн хуулийн төрөөс урвах тухай заалт болон Холбооны Эрүүгийн хуулийн нормоор зохицуулна.

Холбооны хууль тогтоомжинд төрийн эсрэг гэмт хэргийн тухай ерөнхий тодорхойлолт байхгүй. Үлгэр жишээ Эрүүгийн хуулинд ч ийм ерөнхий тодорхойлолтууд байхгүй. Ийм ерөнхий тодорхойлолт байхгүй нь Холбооны Эрүүгийн хуулийн Тусгай ангийн бүтэцтэй холбоотой. Энд бүх материал нь үсгийн дарааллаар байрласан байдаг учир төрийн эсрэг гэмт хэргүүд өөр өөр бүлгүүдэд заагдсан байна.

Холбооны эрүүгийн хуулийн 115 дугаар бүлэгт “Урвах, үймээн самуунд уриалах, хорлон сүйтгэх ажиллагаа” гэсэн нэртэй ба энэ бүлэгт §2381 урвалт, §2382 урвалтыг нуун дарагдуулах, §2383 үймээн ба бослого, §2384 үймээн хийхээр хуйвалдах, §2385 засгийн газрыг түлхэн унагах зорилготой сурталчилгаа, §2386 зарим байгууллагыг бүртгэхээс татгалзах тухай, §2387 зэвсэгт хүчинд хохирол учруулах үйл ажиллагаа гэх мэт гэмт хэргийн талаар заасан байна. 37 дугаар бүлэг нь “Тагнуулын үйл ажиллагаа цэнзур”, 113В бүлэг нь “Терроризм”, 84 дүгээр бүлэг нь “Ерөнхийлөгч ба түүний аппаратын ажилтнуудад халдах, тэднийг хулгайлах, алах” гэсэн хэргүүдийг тус тус заасан байна.

Мөн олон штатын эрүүгийн хууль тогтоомжинд төрийн эсрэг гэмт хэрэгт оноох хариуцлагын талаар заагдсан байдаг байна. Гэхдээ янз бүрийн штатад эдгээр хэргийг өөр өөрөөр томъёолох бөгөөд штатуудын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн янз бүрийн хэсэгт тусгагдсан байна.

ХБНГУ Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 1-7 дугаар хэсэгт Төрөөс урвах ба ардчилсан, эрх зүйт төрд аюул учруулах, Эх орноос урвах ба гадаад аюулгүй байдалд заналхийлэх, Үндсэн хуулийн байгууллагуудын эсрэг болон сонгууль санал хураалтын эсрэг гэмт хэрэг, улс орны батлан хамгаалахын эсрэг гэмт хэрэг, Төрийн эрх мэдлийг эсэргүүцэх, Нийгмийн хэв журмын эсрэг гэмт хэрэг зэрэг заалтууд тусгагдсан байна.

Япон Эрүүгийн хуулинд Үндэсний засгийн газрыг түлхэн унагах зорилгоор үгсэн хуйвалдсан этгээдүүдэд ял оноохоор заасан байх бөгөөд удирдан зохион байгуулагчид, хуйвалдааныг төлөвлөх, зохион байгуулахад оролцсон этгээдүүд, хуйвалдах үйл ажиллагаанд дагалдан орсон этгээдүүдийг тус тус ангилан ялгаатай ял оногдуулдаг байна. Энэ гэмт хэргийг үйлдэхийг завдсан тохиолдолд мөн ял онооно. Мөн хуйвалдааныг бэлтгэсэн болон төлөвлөсөн этгээдүүд, хуйвалдсан болон хуйвалдаанд бэлтгэн төлөвлөсөн этгээдүүдэд ямарваа хэлбэрээр тусалсан этгээдүүд тус тусдаа ялгаатайгаар шийтгэл хүлээдэг байна.

БНСУ Эрүүгийн хуулинд “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах гэмт хэрэг” гэж тусгайлан заагаагүй. Харин дотоодын үймээн самууны гэмт хэрэг болон нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэсэн заалтуудаар үндсэн хуулийн байгууллыг задлан бутаргах зорилгоор үймээн самуун гаргасан этгээдүүдийг шийтгэхээр заажээ. Толгойлогч этгээд, оролцсон этгээдүүдэд оноох ял нь хэргийн байдлаас хамаарч янз бүр байгаагаас гадна бэлтгэх, хуйвалдах, үйеэн өдөөх, сурталчлах зэрэг үйлдлүүдэд тус тусд нь ял оноодог байна.

Эндээс үзэхэд төрийн эрх мэдлийг хууль бусаар авах гэмт хэргийн тухай орон орны эрүүгийн эрх зүйд өөр өөрөөр тусгахаас гадна гэмт хэрэг үйлдэгдсэн гэж үзэх нь ч өөр байна. Тухайлбал, ОХУ-д төрийн эрх мэдлийг хууль бусаар авахтай холбоотой хуйвалдаан зохион байгуулагдсаныг нотлох хэлцэл явагдсан мөчөөс эхлэн гэмт хэрэг үйлдэгдсэн гэж үздэг бол АНУ, Герман, Японд гэмт хэрэгт завдсан гэж үзэж байна. Ял шийтгэл нь ч үүнд үндэслэн ялгаатай байна. Одоо улс тус бүрээр авч үзье.



2.1.ХБНГУ

Германы Эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйлд Холбооны улсын төрөөс урвах, 82 дугаар зүйлд Муж улсын төрөөс урвах, 83 дугаар зүйлд Төрөөс урвахад бэлтгэх гэсэн 3 үндсэн хэлбэрээр тусгасан байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн Тусгай анги, 1-р хэсэг, 2-р бүлэг:**§ 81 Холбооны улсын төрөөс урвах**

1. Хүч хэрэглэж юмуу хүч хэрэглэхээр заналхийлэн
 1. ХБНГУ-ын бүрэн бүтэн байдлыг эвдэх буюу
 2. ХБНГУ-ын үндсэн хуулиар тогтоогдсон үндсэн хуулийн байгууллыг өөрчлөхөөр оролдсон этгээд бүх насаараа хоригдох, эсвэл арваас доошгүй жилээр хоригдох ял хүлээнэ.
2. Илүү хөнгөн тохиолдолд нэгээс арван жил хүртэл хорих шийтгэл онооно

§ 82 Муж улсын төрөөс урвах

1. Хүч хэрэглэж юмуу хүч хэрэглэхээр заналхийлэн
 1. Муж улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь юмуу хэсэгчлэн ХБНГУ-ын өөр муж улсад нэгтгэх буюу нутаг дэвсгэрийн хэсгийг салгах эсвэл
 2. Муж улсын үндсэн хуулиар тогтоогдсон үндсэн хуулийн байгууллыг өөрчлөхөөр оролдсон этгээдэд нэгээс арав хүртэл жил хорих ял онооно.
2. Илүү хөнгөн тохиолдолд зургаан сараас таван жил хүртэл хорих шийтгэл онооно

§ 83 Төрөөс урвахад бэлтгэх

1. Холбооны улсын эсрэг төрөөс урвах тодорхой үйлдэл бэлтгэсэн этгээд нэгээс арван жил хүртэл хугацаагаар хоригдохоор шийтгэгдэх бөгөөд илүү хөнгөн тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял онооно
2. Муж улсын эсрэг төрөөс урвах тодорхой үйлдэл бэлтгэсэн этгээдэд гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял онооно.

2.2. ОХУ**Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах буюу хууль бусаар барих (278-р зүйл).**

ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 278-р зүйлд заасан төрийн эрх мэдлийг хууль бусаар авах буюу хууль бусаар барих гэмт хэргийн объект нь Үндсэн хуулийн үндэс болсон төрийн эрх мэдлийн халдашгүй дархан байдал юм. ОХУ-д төрийн эрх мэдлийг ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны хурал /Холбооны Зөвлөл, төрийн Дум/, ОХУ-ын Засгийн газар, ОХУ-ын шүүх, Холбооны субъектуудад, тэдгээрийн төрийн байгууллагууд хэрэгжүүлдэг.

Эрүүгийн хуулийн 278-р зүйлээр зүйлчилсэн гэмт хэргийн объектив талд нь төрийн эрх мэдлийг хууль бусаар булаан авах, Үндсэн хуулийн бус аргаар барих, ОХУ-ын Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгуулалтыг өөрчлөх гэмт үйлдлүүд орно. Энэ нь төрийн эрх мэдлийг хууль бусаар булаан авч, барих, хууль бус аргаар төрийн байгуулалтыг өөрчлөх оролдлогыг хэлж байгаа болно.

Дээрхи үйлдлийн хууль бус буюу хүчээр үйлдэнэ гэдэг нь ихэвчлэн зэвсэглэн хууль ёсны хүчний байгууллагын зохион байгуулалттай хүч хэрэглэх, хууль бус зэвсэглэсэн бүлэглэл

аль эсхүл олон нийтийн хүч хэрэглэхээр сүрдүүлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхэд бэлэн байгаа байдлаа үзүүлэхийг ойлгоно.

Засгийн эрхийг булаан авах- Аливаа бүлэглэл, байгууллагын зүгээс хууль ёсны эрх баригчдыг хүчээр зайлуулан засгийн эрх мэдлийг дур мэдэн хууль бусаар, хүчээр булаан авахыг хэлнэ.

Засгийн эрхийг барих- ОХУ-ын Үндсэн хуулийг зөрчин, хууль ёсны эрх мэдлийг дуусгавар болгосны дараа өмнө нь засгийн эрх мэдлийг хууль ёсоор хэрэгжүүлж байгаагүй этгээдүүд хууль бусаар энэхүү эрх мэдлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг хэлнэ.

Төрийн байгуулалтын үндсэн хуулийн үндсийг өөрчилнэ гэдэг нь түүнийг бүрэн болон хэсэгчилэн /төрийн зарим институцийг татан буулгах эсхүл шинээр буй болгох/ өөрчлөхийг ойлгоно.

278-р зүйлд заасан гэмт хэргийн зорилго, чиглэл нь түүний олон янз, түвэгтэй шинж байдлыг илэрхийлнэ. Тус гэмт хэрэг нь агуулгаараа төрийн эрх мэдлийг хууль бусаар авах буюу хууль бусаар барих, төрийн байгуулалтын үндсэн хуулийн үндсийг өөрчлөх зохион байгуулалттай үйл ажиллагаанд бэлтгэх буюу ийм гэмт үйлдлийг гүйцэтгэхийг илэрхийлж байгаа бол түүний хэлбэр нь төрийн эргэлт хийх зорилготой хуйвалдаан болж байгаа юм.

278-р зүйл нь энэ гэмт хэргийг үйлдэхэд хүч хэрэглэсэн буюу бусад үйлдэл хийхэд оролцсон боловч зохион байгуулалтанд ороогүй гүйцэтгэгчдыг мөн оролцогч гэж хамаатуулан тооцохоор заасан.

Хуйвалдааныг эцсийн зорилгод нь хүргэхийн тулд хуйвалдагчид хэрэв гадаад улсын төлөөлөгчид ба гадаадын байгууллагатай холбоотой байсан бол тэдний гэмт үйлдэл нь эх орноосоо урвасан гэсэн зүйлчилэлтэй хамт хэрэглэгдэнэ-Эрүүгийн хуулийн 275-р зүйл, 278-р зүйл.

278-р зүйлд заасан гэмт хэргийн субъектив тал нь шууд санаатай үйлдсэн санаатай гэм буруугаар илэрдэг. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 278-р зүйлээр зүйлчилсэн төрийн эрх мэдлийг хууль бусаар авах буюу хууль бусаар барих гэмт хэргийн субъект нь хэрэг хариуцах чадвартай, 16 насанд хүрсэн ямар ч этгээд байж болно.

Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах буюу хууль бусаар барих гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 278-р зүйлээр эрх чөлөөг нь 2 жил хүртэл хугацаагаар хязгаарлан, 12-20 жил хүртэл хорих ял оногдуулахаар заасан.

2.3. Япон

Япон Улсын Эрүүгийн хууль нь 1907 оны 4 сарын 24-нд батлагдсанаар одоог хүртэл нэмэлт, өөрчлөлт хийгдээд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлгийн Хуйвалдах гэмт хэрэг нь онолын хувьд “хамгаалалтын зарчим” /protective principle/ -д үндэслэгдсэн бөгөөд 1947 онд Эрүүгийн хуульд оруулсан өөрчлөлтөөр энэхүү хамгаалалтын зарчимаас ухрах чигийг барьж байсан ч 1987 онд нийтлэг зарчим /universality principle/-д шилжих талаар дорвитой арга хэмжээ аваагүй байна. Хамгаалалтын зарчим гэдэг нь төрийн аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хамгаалахад чиглэгдсэн бөгөөд хязгаарлагдмал хүрээний гэмт хэргийн хувьд хэрэглэгддэг байна.

Япон Улсын Эрүүгийн хуулийн 2-бүлэг “Хуйвалдаантай холбогдох гэмт хэрэг”:

2 дугаар бүлэг. Хуйвалдаантай холбогдох гэмт хэрэг

§77 дугаар зүйл. Хуйвалдаан

77.1. Үндэсний засгийн газрыг түлхэн унагах зорилгоор төрийн бүрэн эрхт байдлыг



Судалгааны эмхтгэл, Х боть

үгүйсгэх болон хүчингүй болгох эрх мэдэл хэрэгжүүлэх замаар үгсэн хуйвалдсан этгээдийг хуйвалдсан гэмт хэрэгт буруутайд тооцож дор дурдсан ял шийтгэл ногдуулна.

1/ Удирдан зохион байгуулагчидад цаазаар авах эсхүл бүх насаар нь хорих ял ногдуулна.

2/ Хуйвалдааныг төлөвлөх, зохион байгуулахад оролцсон этгээдийг насаар нь болон 3 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэнэ, өөр бусад чиг үүрэгтэйгээр оролцсон этгээдийг 1 жилээс 10 жил хүртэл хорих ял шийтгэнэ.

3/ Үгсэн хуйвалдах үйл ажиллагаанд дагалдан орсон этгээдүүдийг 3 хүртэлх жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

77.2. Өмнөх хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхийг завдсан тохиолдолд ял шийтгэл ногдуулах ба 3 дахь заалтын этгээдэд үл хамаарна.

§78 дугаар зүйл. Бэлтгэх ба төлөвлөх

Хуйвалдааныг бэлтгэсэн, төлөвлөсөн этгээдийг 1 жилээс 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

§79 дүгээр зүйл. Хуйвалдаанд туслах

Өмнө дурдсан хоёр зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхэд зэвсэг, санхүүжилт, хоол хүнс нийлүүлэх болон бусад хэлбэрээр тусалсан бол 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

§80 дугаар зүйл. Хэргээ хүлээснээр ял, шийтгэлийг хэрэгсэхгүй болгох

Өмнөх 2 зүйлд дурьдсан гэмт хэргийг үйлдсэн этгээд үймээн эхлэхээс өмнө хэргээ хүлээж ирсэн тохиолдолд ял шийтгэлийг хэрэгсэхгүй болгоно.

2.4.АНУ

Америкийн Нэгдсэн Улсад эрүүгийн үндсэн гэмт хэргүүдийг **уламжлалт, эдийн засгийн, зохион байгуулалттай, улс төрийн болон тохиролцсон** гэмт хэрэг гэсэн таван том ангилалд хуваадаг. Улс төрийн гэмт хэрэг нь ихэвчлэн засгийн эсрэг гэмт хэрэг байдаг. Эх орноосоо урвах, зэвсэгт үймээн дэгдээх, төрийн албан тушаалтны амь насанд халдах, засгийн эсрэг өдөөн турхирах зэрэг болно. Гэхдээ энэ нэр томъёо нь засгийн газраас хувь хүмүүс, тэрслэгч бүлэг, гадаадын засгийн газар буюу иргэдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг мөн багтаана.

АНУ-д эрүүгийн эрх зүйн эх сурвалж нь Үндсэн хууль, Холбооны, Муж улсуудын болон Колумбын тойргийн гэх гурван төрлийн Эрүүгийн хуультай. Холбооны Эрүүгийн хууль, 50 муж улс өөр өөрийн Эрүүгийн хуультай.

Судалгааны сэдвийн хүрээнд төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, хуйвалдаан зохион байгуулах гэмт хэргийн тухай Холбооны эрүүгийн хууль тогтоомжийн зохицуулалтыг авч үзье.

АНУ-ын хуулиудын эмхэтгэлийн 18 дугаар хэсгийн /US code TITLE 18—CRIMES AND CRIMINAL PROCEDURE/ 1 бүлгийн /PART I—CRIMES (§§ 1—2725)/ 15 дугаар зүйлд Эх орноосоо урвах, үймээн самуунд турхирах ба хорлон сүйтгэх үйл ажиллагаа /CHAPTER 115—TREASON, SEDITION, AND SUBVERSIVE ACTIVITIES (§§ 2381,2382, 2383, 2384, 2385)/-г улс төрийн гэмт хэргээр зүйлчлэгддэг байна. **Үүнийг дор үзүүлбэл:**

Нэгдсэн Улсын иргэн хэн боловч Нэгдсэн Улсын эсрэг дайнд оролцсон, дайсагнаж буй талыг дагаж дэмжсэн, Нэгдсэн Улсын нутаг дэвсгэрт болон өөр газар тэдэнд тусламж дэмжлэг үзүүлсэн, орогнуулсан тохиолдолд эх орноосоо урвасан гэм буруутайд тооцож цаазаар авах ял эсвэл 5 жилээс доошгүй хугацаагаар хорих ял эдэлж, 10,000-аас доошгүй

доллараар торгуулах шийтгэл хүлээнэ. Энэ зүйлээр шийтгүүлж, ял эдэлсэн этгээд Нэгдсэн Улсад ямар нэгэн алба хаших эрхгүй болно.

§2382. Эх орноосоо урвасан гэмт хэргийг нуун дарагдуулах

Нэгдсэн улсын иргэн хэн боловч Нэгдсэн Улсын эсрэг хийгдэж буй болон хийгдэхээр завдаж буй аливаа урван тэрслэх үйл ажиллагааны мэдээллийг нуун дарагдуулж, боломжтой хамгийн богино хугацаанд Ерөнхийлөгч, Нэгдсэн Улсын шүүгч, мужийн захирагч, мужийн шүүгч болон шүүхийн аль нэгэнд мэдэгдээгүй тохиолдолд урван тэрслэх гэмт хэргийг нуун дарагдуулсан гэм буруутайд тооцогдож 7 жилээс илүүгүй хугацаатай хорих буюу торгох шийтгэл ногдуулна.

§2383. Бослого, үймээн гаргах

Нэгдсэн Улсын аль ч шатны засгийн болон хуулийн эсрэг ямар нэгэн үймээн самуун бослогод оролцсон, өдөөн турхирсан, тусалж дэмжсэн этгээдийг энэхүү зүйлийн дагуу 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих буюу торгууль ногдуулна. Энэ зүйлийн дагуу ял шийтгүүлсэн этгээд Нэгдсэн Улсад ямар нэгэн алба хаших эрхгүй болно.

§2384. Эсэргүүцлийн хуйвалдаан, явуулга

Хэрэв Нэгдсэн Улсын аль нэг муж, нутаг дэвсгэр ба Нэгдсэн Улсад харъяалагдах аль нэг газар нутагт нэг буюу түүнээс дээш этгээд Нэгдсэн Улсын Засгийн газрыг хүч хэрэглэн түлхэн унагах, огцруулах буюу нураахаар үгсэн хуйвалдсан, Засгийн газрын эсрэг дайн зарласан буюу хүчээр Засгийн эрхийг эсэргүүцсэн, эсвэл Нэгдсэн Улсын хуулийн биелэлтийг хүч хэрэглэн зогсоосон, саад болсон, хойшлуулсан, Засгийн удирдлагын эсрэг Нэгдсэн Улсын өмчийг олзолсон, булаан эзлэсэн бол уг этгээдүүд энэхүү зүйлийн дагуу торгуулах буюу 20 жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ.

§2385. Засгийн газрыг түлхэн унагаах явдлыг дэмжих, өмгөөлөх

- Зориудаар буюу санаатайгаар Нэгдсэн Улсын Засгийн газар, Нэгдсэн Улсын аль нэг мужийн Засгийн газар, нутаг дэвсгэрийн аль ч шатны засгийн удирдлагыг хүч хэрэглэн эсвэл Засгийн газрын аль нэг ажилтны амь насанд халдах замаар түлхэн унагаахыг дэмжсэн, хамссан, зааж зөвлөсөн, энэ талаар үүрэг даалгавар, хэрэгцээ шаардлагыг ухуулан зааварчилсан,
- Нэгдсэн Улсын аль ч шатны Засгийн удирдлагыг хүч хэрэглэн түлхэн унагах, түлхэн унагаахыг завдах зорилгоор ямар нэгэн хэвлэл хэвлэн тараасан, худалдсан, олон нийтийн газар дээрх үйлдлийг дэмжсэн, зөвлөсөн, үүрэг даалгавар, хэрэгцээ шаардлагыг ухуулан зааварчилсан материалуудыг дэлгэн сурталчилсан,
- Сайн дураараа, зориудаар буюу санаатайгаар Нэгдсэн Улсын аль ч шатны Засгийн удирдлагыг хүч хэрэглэн түлхэн унагаахыг дэмжсэн, зоригжуулсан, зааварчилсан ямар нэгэн нийгэмлэг, холбоо, бүлэг, цуглаан зэргийг байгуулсан, эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд оролцсон, оролцохоор завдсан, гишүүнээр элссэн, хэн боловч энэхүү зүйлийн дагуу торгуулах буюу 20 жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ. Мөн энэ зүйлийн дагуу ял шийтгэлээ эдэлж дууссан өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд Нэгдсэн Улсын Засгийн газрын аль нэг агентлаг, хэлтэст ажиллахыг хориглоно.

Хэрэв хоёр буюу түүнээс дээш этгээд энэхүү зүйлд заасан гэмт үйлдлүүдийг үйлдэхээр үгсэн хуйвалдсан бол энэхүү зүйлийн дагуу тус бүр торгуулах буюу 20 жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ. Мөн энэ зүйлийн дагуу ял шийтгэл эдэлж дууссан



Судалгааны эмхтгэл, Х боть

өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд Нэгдсэн Улсын Засгийн газрын аль нэг агентлаг, хэлтэст ажиллахыг хориглоно.

§2381. Эх орноосоо урван тэрслэх

Энэ зүйлд заасан “байгуулах” гэдэгт дээр дурдсан нийгэмлэг, холбоо, бүлэг, цуглаанд шинээр гишүүн элсүүлэх, шинэ нэгж салбар байгуулах, дахин бүлэглэн хуваах, одоо буй клуб, бүлгийг тэлэх зэрэг үйл ажиллагааг ойлгоно.

2.6.БНСУ

БНСУ-ын Эрүүгийн хуульд төрийн эрх мэдлийг хууль бусаар авах гэсэн тусгайлсан гэмт хэрэг заагаагүй, харин Эрүүгийн хуулийн 87-91-р зүйлд заасан “Дотоодын үймээн самууны хэрэг” болон 114-117 дугаар зүйлд заасан “Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн зохицуулалтыг хуульчилсан.

БНСУ-ын Эрүүгийн хуулийн 2-р хэсэг 1 ба 5 дугаар бүлэг, 2 дугаар хэсэг.

1 дүгээр бүлэг. Дотоодын үймээн самууны гэмт хэрэг

§87 дугаар зүйл. Дотоод үймээн самуун

Улсын нутаг дэвсгэр, үндсэн хуулийн байгуулалыг задлан бутаргах зорилгоор үймээн самуун гаргагч этгээдийг дараах байдлаар ял шийтгэнэ.

1. Толгойлогч этгээдийг цаазаар авах, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл бүх насаар нь биеийн хүчний хүнд хүчир ажил хийлгэх ял шийтгэнэ.
2. Хуйвалдаанд орлцсон эсвэл удирдсан болон бусад шаардлагатай үүрэг гүйцэтгэсэн этгээдийг цаазаар авах, хугацаагүй болон 5 жилээс доошгүй хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлэхээр хорих эсвэл ажил хийгэхгүйгээр хорих ял шийтгэнэ. Цус урсах, эвдэн сүйтгэх мөн дээрэм тонуул хийсэн этгээд мөн адил.
3. Хуйвалдаан удирдан зохион байгуулсан эсвэл энгийн үймээн самуун зохион байгуулсан этгээдийг 5 жилээс доош жилийн хорих мөн ажил хийгэхгүйгээр хорих ял ногдуулна.

§88 дугаар зүйл. Үймээн самууны зорилгоор хүн алах

Улсын нутаг дэвсгэрийг хагалган бутаргах болон үндсэн хуулийн байгууллыг задлан бутаргах зорилгоор хүний амь хохироосон этгээдийг цаазаар авах, насаар нь шоронд хорих мөн цагдан хорих ял шийтгэнэ.

§90 дүгээр зүйл. Бэлтгэх, хуйвалдах, үймээн өдөөх, сурталчлах

1. 87 болон 88 дугаар зүйлийн гэмт хэргийг хийх зорилгоор бэлтгэсэн болон хуйвалдсан этгээдийг 3 жилээс доошгүй хязгаарлагдмал хугацаагаар шоронд хорих эсвэл хязгаарлагдмал хугацаагаар ажил хийлгэлгүйгээр шоронд хорих ял шийтгэнэ. Зөвхөн тухайн зорилгодоо хүрэхийн өмнө татгалзсан этгээдийн ял шийтгэлийг бууруулах болон чөлөөлнө.
2. 87 болон 88 дугаар зүйлийн гэмт хэргийг хийхээр үймээн өдөөсөн, дайрсан этгээдэд мөн адил ял шийтгэнэ.

§91 дүгээр зүйл. Үндсэн хуулийн эмх замбараагүй байдлын тодорхойлолт



1. Үндсэн хууль болон хууль тогтоомжид заасан дүрэм журмыг зөрчин Үндсэн хууль болон хууль тогтоомжийн үйл ажиллагааг хүчингүй болгохоор хийсэн үйлдэл
2. Үндсэн хуульд зааснаар зохион байгуулдаг төрийн байгууллагуудыг хүчээр түлхэн унагаах, мөн түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болгохоор хийсэн үйлдэл

5 дугаар бүлэг. Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг

§114 дүгээр зүйл. Гэмт бүлэглэл зохион байгуулах

1. Гэмт хэрэг үйлдэх зорилгоор байгууллага байгуулах эсвэл түүнд элсэн орсон этгээд нь төлөвлөсөн гэмт хэрэгт тогтоосон ял шийтгэл ногдуулна. Мөн ял шийтгэлийг хөнгөрүүлж болно.
2. Цэргийн алба хаах болон татварын төлбөрийн үүргээсээ татгалзах зорилгоор байгууллага байгуулсан болон элсэн орсон этгээд нь 10 жилээс доошгүй хугацаагаар хорих болон ажил хийлгэлгүйгээр хорих, мөн 15 саяаас доошгүй вонийн торгууль ногдуулна.

§115 дугаар зүйл. Нийтийн эмх замбраагүй байдал

Олуулаа цуглан хүчирхийлэл, заналхийлэх мөн эвдэн сүйтгэх үйлдэл хийсэн этгээдүүдийг 1 жилээс 10 жил хүртэл хорих эсвэл биеийн хүнд хүчир ажил хийлгэх ял шийтгэх, эсвэл 15 саяаас дээшгүй вонийн торгууль оногдуулна.

§116 дугаар зүйл.

Хүчирхийлэх, заналхийлэх мөн эвдэн сүйтгэх үйлдлийг хийх зорилгоор олуулаа цуглан, түүнийг таслан зогсоохыг сануулсан албан хаагчийн сануулгыг 3 удаа авсан ч тараагаагүй этгээдүүдийг 2 жилээс доошгүй хугацаагаар хорих эсвэл биеийн хүнд хүчир ажил хийлгэх, эсвэл 3 саяаас доошгүй вонийн торгууль ногдуулна.

Гурав. Судалгааны дүгнэлт

- Гэмт хэрэгт хамтран оролцох тухай ойлголтыг улс бүрийн эрүүгийн эрх зүйд янз бүрээр ангилан томъёолдог байна. Тухайлбал, АНУ-ын эрх зүйд гэмт хэрэгт хамтран оролцогчдыг гэмт хэрэг үйлдэхийн өмнөх ба дараах гэж хуваагаад, гүйцэтгэгчийг нэгдүгээр ба хоёрдугаар зэргийн гүйцэтгэгч гэж ангилдаг бол, ХБНГУ-ын эрх зүйд тусгайлан хамтран оролцогч гэдгийг томъёолоогүй боловч хууль болон хууль хэрэгжүүлэх практикаараа хамтран оролцох үндсэн хоёр хэлбэр болох гүйцэтгэгч, хатгагч ба хамжигч гэсэн хоёр хэсэгт хуваан уг ойлголтыг хэрэглэдэг. Харин Японы эрх зүйд гэмт хэрэгт сайн дураар болон гарцаагүй хамтран оролцох гэсэн ойлголт байна.
- Аль ч улсын эрүүгийн эрх зүйгээр гэмт хэрэгт хамтран оролцогч бүр өөрийн бурууд тохирсон шийтгэл хүлээх ба гүйцэтгэгч шийтгэл хүлээсэн тохиолдолд бусад хамтран оролцогчид шийтгэл хүлээнэ. Германы эрүүгийн хуулиар хатгагч нь гүйцэтгэгчтэй адил шийтгэл хүлээхээр заасан байдаг бол хамжигч нь илүү хөнгөн шийтгэл хүлээнэ. Японы эрүүгийн хуулиар хатгагчийг мөн гүйцэтгэгчтэй адил шийтгэх боловч зарим тохиолдолд хатгагчийн хэргийг тусдаа бие даасан гэмт хэрэг гэж ангилдаг. Хамтарсан гэмт хэргийн хуйвалдаанд оролцсон бүх хүнд ял тулгах боловч гэмт хэргийн байдлаас шалтгаалан зарим хамтран оролцогчид арай хөнгөн шийтгэл онооно. Харин хамжигчийг гүйцэтгэгчээс хөнгөн яллана.

- Герман ба Японы эрүүгийн эрх зүйгээр гэмт хэрэгт хамтран оролцогч гэсэн ойлголтыг гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө болон үйлдэгдэх үе хүртэлх хугацаагаар ойлгох ба гэмт хэрэг үйлдэгдсэний дараа хэн нэг этгээд гэмт хэргийг нуух, гэмт хэргийн баталгааг устгах, нуун дарагдуулахыг бие даасан гэмт хэрэг гэж үздэг бол бол АНУ-ынхаар хамжигчийг гэмт хэрэг үйлдэгдэхийн өмнө болон дараах үеийн хамжигч гэж ангилна.
- Гэмт хэрэгт хамтран оролцогчийн төрлийн хувьд бидний судалсан улсууд өөр хоорондоо болон Монгол Улсын эрүүгийн эрх зүйд тодорхойлсоноос ялгаатай байна. Тухайлбал, ОХУ-ын эрүүгийн эрх зүйд гэмт хэрэгт хамтран оролцогчдыг зохион байгуулагч, гүйцэтгэгч, хатгагч, хамжигч гэж хуваан үздэг бол ХБНГУ-ын хувьд тэдгээрийг гүйцэтгэх, хатгах ба хамжигч, БНСУ-ын хувьд гүйцэтгэгч, хатгагч, хамжигч, Монгол Улсын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн хамтран оролцогчдыг захиалагч, гүйцэтгэгч, хатгагч, хамжигч гэсэн төрөлд хуваасан байна.
- Үндсэн хуулийн бус аргаар буюу зэвсгийн хүчээр тухайлбал, нууц хуйвалдаан зохион байгуулах аргаар төрийн эрх мэдлийг авах нь гэмт хэрэгт тооцогдоно.
- Ийм гэмт хэргийн объект нь тухайн улсын улс төрийн системийн үндсэн хуулийн байгуулал байна. Гэмт хэргийн объектив тал нь а) төрийн эрх мэдлийг булаан авах, б) төрийн эрх мэдлийг үндсэн хуулийг зөрчин хадгалах, в) үндсэн хуулийн байгууллыг өөрчлөх зэргийг хүчээр гүйцэтгэх буюу завдах үйлдэл байна.
- Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах гэмт хэргийн тухай орон орны эрүүгийн эрх зүйд өөр өөрөөр тусгахаас гадна гэмт хэрэг үйлдэгдсэн гэж үзэх нь ч өөр байна. Тухайлбал, ОХУ-д төрийн эрх мэдлийг хууль бусаар авахтай холбоотой хуйвалдаан зохион байгуулагдсаныг нотлох хэлцэл явагдсан мөчөөс эхлэн гэмт хэрэг үйлдэгдсэн гэж үздэг бол АНУ, Герман, Японд гэмт хэрэгт завдсан гэж үзэж байна. Ял шийтгэл нь ч үүнд үндэслэн ялгаатай байна.

* * *

Ашигласан материал

1. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он
2. Уголовный Кодекс ФРГ, www.law.edu.ru
3. Уголовный Кодекс РФ, 1996 г., www.consultant.ru
4. Penal Code of Japan, April 24, 1907
5. Crimes and criminal procedure. <http://www.law.cornell.edu/uscode/18/>
6. Б.Ганболд Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ., 2006 он
7. С.Жанцан Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009 он
8. Shigemitsu Dando The Criminal Law of Japan, 1997
9. Merry Dean Japanese Legal System, 2002
10. АНУ-ын эрх зүйн тогтолцооны гарын авлага. www.scribd.com/doc/47841266/erkh-zui
11. Уголовное право зарубежных стран. Общая и особенная части. Под ред. И.Д. Козочкина, М., 2010 г.

Веб сайт:

1. [Www.klaw.go.kr](http://www.klaw.go.kr) –БНСУ-ын хууль зүйн сайт
2. <http://www.law.go.kr>- БНСУ-ын дүрэм журмын сайт

3. <http://www.assembly.go.kr> –БНСУ-ын Үндэсний Ассамблейн сайт
4. <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?ft=1&re=02&dn=1&co=01&ky=criminal+code+of+japan&page=15>



АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА (Referendum) (Лавлагаа, мэдээлэл)

Ц. Товуусүрэн, П. Амаржаргал

Ард нийтийн санал асуулга /referendum/

Улсын Их Хурлын тамгын газрын нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнгийн захиалгаар “Ард нийтийн санал асуулга” нь бусад улс оронд ямар асуудлаар хэрхэн яаж шийдвэрлэхийг харьцуулан лавлагаа мэдээлэл гаргалаа. Үүнд: Итали улс, Сингапур улс, Австрали улсын ард нийтийн санал асуулгыг харьцуулан авч үзлээ.

Нэг. Итали улсын Ард нийтийн санал асуулга

Итали Улсын Үндсэн хуульд зааснаар зөвхөн дараахи хоёр тохиолдолд хууль ёсны хүчин төгөлдөр санал асуулга явуулна. Үүнд:

1. Ард нийтийн санал асуулга: одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэр гаргах.
2. Үндсэн хуулийн санал асуулга: зөвхөн Үндсэн хуулийг батлах болон нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэр гаргана.

Ард нийтийн санал асуулга нь 1947 онд анхны Үндсэн хууль батлагдсанаас хойш анх удаагаа 27 жилийн дараа буюу 1974 онд явагдсан. Үндсэн хуулийн анхны санал асуулга нь 54 жилийн дараа буюу 2001 онд явагдсан. Бүх Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт нь Парламентын дийлэнхи олонхиор батлагдана.

Төрийн хэлбэрийн санал асуулга:

1. 1946 оны санал асуулга нь Итали улс нь Эзэн хаант улс байх уу Бүгд Найрамдах улс байх уу? Бүгд найрамдах гэсэн хувилбарыг санал асуулгаар зөвшөөрсөн.

I. Хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар;

Ард нийтийн санал асуулга:

Ард нийтийн санал асуулгыг нарийвчлан он цагийн дараалалаар 16 асуулт тус бүрээр авч үзвэл:

1. 1974 оны ард нийтийн санал асуулга; Гэр бүл салалтыг хүчингүй болгох -татгалзсан
2. 1978 оны ард нийтийн санал асуулга; Хоёр асуулт - бүгд татгалзсан
3. 1981 оны ард нийтийн санал асуулга; Үр хөндөлтийн тухай хоёр асуулт- татгалзсан
4. 1985 оны ард нийтийн санал асуулга; Төлбөрийн зарим хэсгийг бууруулах тухай хуулийг хүчингүй болгох тухай санал асуулага-татгалзсан
5. 1987 оны ард нийтийн санал асуулга; Цөмийн эрчим хүчний тухай хуулийг хүчингүй болгох 3 асуулт- бүгд батлагдсан
6. 1990 оны ард нийтийн санал асуулга; Ан агнуур хортонтой тэмцэх хэрэгслийн тухай гурван асуулт-бүгд татгалзсан
7. 1991 оны ард нийтийн санал асуулга; Төлөөлөгчдийн танхимын орлогч нарыг сонгох-батлагдсан

8. 1993 оны ард нийтийн санал асуулга; Сенатын сонгуулийн тухай хуулийг өөрчлөх тухай найман асуулт- бүгд батлагдсан
9. 1995 оны ард нийтийн санал асуулга; 12 асуулт- таван асуулт батлагдаж, долоон асуулт хүчингүй болсон
10. 1997 оны ард нийтийн санал асуулга; Долоон асуулт-ирцийн тоо хүрээгүй
11. 1999 оны ард нийтийн санал асуулга; Пропорционал тогтолцоог бүхэлд нь өөрчлөх-ирцийн тоо хүрээгүй
12. 2000 оны ард нийтийн санал асуулга; Долоон асуулт-ирцийн тоо хүрээгүй
13. 2003 оны ард нийтийн санал асуулга; Хоёр асуулт- ирцийн тоо хүрээгүй
14. 2005 оны ард нийтийн санал асуулга; Дөрвөн асуулт ирцийн тоо хүрээгүй
15. 2009 оны ард нийтийн санал асуулга; Сонгуулийн тухай хуулийг өөрчлөх гурван асуулт-ирцийн тоо хүрээгүй
16. 2011 оны ард нийтийн санал асуулга нь Дөрвөн асуулт–Цөмийн эрчим хүчний төлөвлөгөө батлах гэх мэт.. бүгд батлагдсан

Нийт 16 удаагийн ард нийтийн санал асуулга явуулснаас 4 удаад нь батлагдаж, 5 удаад нь татгалзаж, 7 удаад нь санал асуулгын ирц бүрдээгүй байна.

II. Үндсэн хуулийн санал асуулга:

1. 2001 оны Үндсэн хуулийн санал асуулга; Орон нутгийн эрх мэдлийг өргөжүүлэх-батлагдсан
2. 2006 оны Үндсэн хуулийн санал асуулга; Үндсэн хуулийн шинэчлэл, Үндсэн хуулийн шүүхийн байгуулалт өөрчлөх-татгалзсан

Зөвлөлгөөний санал авалт:

1. 1989 оны Зөвлөлгөөний санал асуулга Европын холбооны Парламентын эрх мэдлийг өргөжүүлэх талаар хуулийн заавал биелэгдэх хүчин чадалгүй санал асуулага-батлагдсан.

Хоёр. Сингапур Улсын Ард нийтийн санал асуулга

Сингапур улс нь нэг танхимтай Парламентын бүгд найрамдах улс юм. Тус улсын Үндэсний санал асуулга нь /Сингапурын нэгдлийн санал асуулга/ анх удаа 1962 оны 9 дүгээр сарын 1 нд болсон. Малайз улстай нэгдэх тухай ард түмнээсээ асууж батлагдсан. Гэвч хоёр жилийн дараа уг нэгдэл задарсан.

Гурав. Австрали улсын Ард нийтийн санал асуулга

1999 оны 8 дугаар сарын 12-ны өдөр анх ард нийтийн санал асуулга явуулах санаачлагыг Хамтын нөхөрлөлийн орны Ерөнхий прокурор, Парламентын гишүүн Дари Уилламс болон Төрийн тусгай сайд, Сенатор Крисс Элисон нар гаргаж Ерөнхий захирагч 1999 оны 10 дугаар сарын 1-ны өдөр ард нийтийн санал асуулга явуулахаар үүрэг болгосон. Парламентаар асуулт бүхэн өөр өөр саналын хуудастай байхаар батлагдаж, тусгай хууль гарган явуулсан.

Энэхүү санал асуулга нь Австралийн сонгуулийн хорооны цахим хуудсанд тавигдаж бүртгүүлэх, санал авах болон хаах хугацааг тодорхой заасан байна. Энэхүү санал асуулга нь хоёр асуулттай бөгөөд 1. Үндсэн хуулийн оршил хэсгийг өөрчлөх үү? 2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах уу? гэсэн асуултанд хариулт нь тийм ба үгүй гэсэн хоёр хувилбартай байна. Хоёр асуулт батлагдаагүй.



Ийнхүү эдгээр гурван улсын санал асуулгыг харьцуулан дүгнэж үзвэл улс болгон өөрийн засаглалын хэлбэр, уламжлал, газар зүйн байрлалаасаа хамаарч өөр өөрийн онцлог тохирсон, ерөнхий зарчимд тулгуурлан явуулж байна. Европын улс орнуудын туршлага нь Азийн улс орныг бодвол илүү өргөн хүрээнд олон удаа явуулсан туршлагатай харагдаж байна.



**“ҮНДЭСНИЙ ХОРОО, ЗӨВЛӨЛҮҮДИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЭРХ ЗҮЙН СТАТУС, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ**
(Лавлагаа мэдээлэл)

Б. Мөнхцэцэг, Ө. Мөнтунгалаа

Судалгааны зорилго:

УИХ -ын гишүүн НББСШУ-ны байнгын хорооны дарга Д.Очирбатын захиалгын дагуу “Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Үндэсний хороо, зөвлөлүүдийн бүрэлдхүүн, эрх зүйн статус, тэдгээрийн ажлын албадын зохион байгуулалт, ажилтнуудын төрийн албаны ангилалд хамаарах байдал, үйл ажиллагааны санхүүжилт, Үндэсний хороо зөвлөлүүдийн хууль эрх зүйн орчны талаар холбогдох хуулиудад хэрхэн тусгагдсан талаархи” мэдээлэл лавлагааг гаргахад оршино.

Судалгаанд холбогдох хуулиудийн заалтыг үндэслэн Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор байгуулагдан ажиллаж байгаа байнгын болон орон тооны бус зөвлөл, хороодыг хамруулсан болно. Засгийн газрын агентлагийн болон УИХ-аас томилогддог ажлаа тайлагнадаг тухайлбал Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, Сонгуулийн ерөнхий хороо зэрэг нь тодорхой статустай, учир энэ судалгаанд аваагүй.

Энэ судалгаанд Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан үндэсний зөвлөл-3, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан “байнгын” ажиллагаатай үндэсний зөвлөл 14, үндэсний хороо 3, мөн тогтоолын 20 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн Газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах “орон тооны бус “үндэсний зөвлөл 22, үндэсний 13 хороо, нийт 55 хороо зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, зөвлөлийн бүрэлдэхүүн, холбогдох хуулийн заалт, эрх зүйн статус зэргийг тусгасан болно.

Нэг: УИХ-ын тогтоолоор байгуулагдсан Үндэсний зөвлөл, хороо

УИХ-ын тогтоолоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 3 үндэсний зөвлөл /Олон нийтийн радио телевизийн үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Үндэсний статистикийн хорооны зөвлөл/-ийн үндсэн чиг үүргийг холбогдох хуулийн заалтаас авч оруулснаас гадна зөвлөлийн бүрэлдхүүн, эрх зүйн статус, холбогдох хуулийн заалт, үйл ажиллагааны санхүүжилт, ажлын албадын бүтэц зохион байгуулалт, ажилтны төрийн албаны ангилалд хамрагдах байдал зэргийг Хүснэгт№ 1 ээр харуулсан болно.

Эдгээр зөвлөлүүд нь өөр өөрийн өвөрмөц чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг, санхүүжилтийн эх үүсвэртэй, зөвлөлийн гишүүд нь тодорхой урамшуулал, цалингийн нэмэгдэлтэй үүнийг нь тухайн зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм журамд тодорхой зааж өгсөн байдаг. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын албатай, ажлын албаны ажилтнууд нь төрийн захиргааны албан хаагч байдаг. Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлтэй ажлын албанд нь орон тооны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь орж ажилладаг. Нөгөө хоёр үндэсний зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай.

Зөвлөлүүдийн чиг үүрэг

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл нь 15 хүний бүрэлдэхүүнтэй. Олон нийтийн радио, телевизийн дүрэм болон тэнд ажиллагсдын ёс зүйн дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах; үйл ажиллагааны үндсэн зорилт, стратеги төлөвлөгөө, тухайн жилийн



Судалгааны эмхтгэл, X боть

төсвийн төслийг хэлэлцэх, Монгол Улсын төсөвт тусгуулах; техник, технологийн сүлжээг хөгжүүлэх, техникийн хангамжийн бодлогыг тодорхойлох; хяналтын зөвлөл, Өргөдлийг шалгах хороог байгуулах, тэдгээрийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах; зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох; Ерөнхий захиралд нэр дэвшүүлэх, томилох журмыг батлах чөлөөлөх, түүнтэй гэрээ байгуулах; үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах; нэгжийн даргыг сонгон шалгаруулах журмыг батлах үндсэн чиг үүрэгтэй.

Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнд Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн үндсэн ажлынх нь цалин, түүнтэй адилтгах бусад орлогын дунджийн 40 хувиас хэтрэхгүй хэмжээний урамшуулал олгох бөгөөд урамшууллын хэмжээ, олгох журмыг Үндэсний зөвлөл батална. Үндэсний зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн дарга нь орон тооны байна. Олон нийтийн байгууллага учраас нарийн бичгийн даргын цалинг үндэсний зөвлөлийн баталсан журмаар тогтооно.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, тэтгэвэр нэмэгдүүлэх талаар санал боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх; нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих; нийгмийн даатгалын үйл ажиллагаа, боловсон хүчний хангалт, санхүүгийн асуудлаар нийгмийн даатгалын байгууллагын тайлан мэдээллийг сонсон хэлэлцэж, санал дүгнэлт гаргаж, энэ талаар холбогдох арга хэмжээ авах; нийгмийн даатгалын байгууллагын цахим тооцоолуурын техник, технологи, программ хангамж, үйлчилгээний байдлыг хянаж үнэлэлт дүгнэлт өгөх; нийгмийн даатгалын төв байгууллагын бүтцийг батлах, нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих; нийгмийн даатгалын асуудлаар журам, зөвлөмж гаргах; эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс болон гомдлын шаардлагын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиг үүрэгтэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг НДҮЗ-ийн тогтоолоор батална. Иргэний эрүүл мэндийн даатгалын орон тооны бус салбар зөвлөл нь иргэний эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрийн бодлого чиглэлийг тодорхойлох, эрүүл мэндийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үүрэгтэй. Үйл ажиллагааны үндсэн зорилго нь эрүүл мэндийн даатгалын асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж, тогтоол гаргах, даатгалтай холбогдсон асуудлыг холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх, даатгалын сангийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, эрүүл мэндийн даатгалыг хэрэгжүүлэх ба улирал тутам НДҮЗ-д ажлаа тайлагнана.

Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл нь тодорхой хэмжээний үйл ажиллагааны зардалтай байх ба үүнийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн төсөвт тусгаж Улсын Их Хурлын НББСШУ-ны байнгын хороо батална. НДС-аас санхүүжина. Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан улирал тутам цалингийн нэмэгдэл олгож болно. Цалингийн нэмэгдлийн дээд хэмжээг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. Одоо тус зөвлөлийн ажлын алба нь 7 хүний бүрэлдэхүүнтэй, Дарга, хянан шалгагч-5, ЭМД-ийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга-1, одоогоор эрхэлсэн түшмэл-1, ахлах түшмэл-6 гэсэн албан тушаалын зэрэгтэй ТЗ-10, ТЗ-9, ТЗ-8-аар цалинжин ажилладаг.

“Нийгмийн даатгалын Үндэсний (орон тооны бус) зөвлөл (цаашид “зөвлөл” гэнэ)-ийн зорилго нь нийгмийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, нийгмийн даатгалын холбогдолтой хууль тогтоомжийн биелэлт болон даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хөндлөнгийн хяналт тавих, нийгмийн даатгалын асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж, тогтоол гаргах, шаардлагатай

асуудлыг холбогдох байгууллагад оруулж, шийдвэрлүүлэх, нийгмийн даатгалын багц хуулиудыг хэрэгжүүлэхэд оршино. Зөвлөл нь биеэ даасан төсөвтэй байна.

Төсвийг нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлын санхүүжилтын тодорхой хэсгээс гаргахаар УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо батална. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийг хуульд заасны дагуу томилно. Зөвлөл УИХ, холбогдох байнгын хороонд ажлаа жил бүр тайлагнана. Зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргыг Зөвлөлийн дарга томилно. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Нийгмийн даатгалын төв байгууллагын хэлтсийн даргын хэмжээний албан тушаалтан байна.

Нийгмийн даатгалын төв байгууллага нь Зөвлөлийн ажлын албаны үүргийг хариуцах бөгөөд ажиллах бололцоо, нөхцөл, шаардагдах мэдээллээр бүрэн хангана. Эрүүл мэндийн даатгалын асуудлаар салбар зөвлөлтэй байна. Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн даргыг Зөвлөлийн даргатай зөвшилцөж, салбар зөвлөлийн хурлаас сонгоно” гэж Нийгмийн даатгалын зөвлөлийн дүрмэнд заажээ.

Үндэсний статистикийн хорооны зөвлөл нь Үндэсний статистикийн хороонд албан ёсны статистикийн үйл ажиллагааг явуулахад туслах, арга зүйн нэгдмэл байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэгтэй. Улсын Их Хурал, Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллага болон хэрэглэгчийн төлөөлөл оролцсон 7 хүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөлийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг харгалзан зөвлөлийн гишүүдэд зохих хөлс олгож болно. Хөлс олгох тухай асуудлыг зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу зохицуулна. Нарийн бичгийн даргыг Үндэсний статистикийн хорооны ахлах шинжээч ажил хавсран гүйцэтгэдэг.АА-7, ахлах шинжээч.

УИХ -ын тогтоолоор байгуулагдсан Үндэсний зөвлөл

Хүснэгт №1

| № | Үндэсний зөвлөлийн нэр Зөвлөлийн бүрэлдхүүн | Эрх зүйн статус (Холбогдох хуулийн заалт) | Үйл ажиллагааны санхүүжилт | <ul style="list-style-type: none"> Ажлын албаны зохион байгуулалт Ажилтны ТАН-ны ангилалд хамрагдах байдал |
|----|--|--|--|--|
| 1. | <p>Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл</p> <p>Засгийн газрыг төлөөлж Сангийн дэд сайд ХЗДХ-ийн дэд сайд НХХ-ийн дэд сайд Даатгуулагчийг төлөөлж МҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч "Гэгээрэл" ҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч Төмөр замчдын ҮЭ-ийн хорооны дарга Ажил олгогчийг төлөөлж МАОЭНХ-ны ерөнхийлөгч Мобиком ХХК-ны ерөнхий захирал Тайж трейд группын захирал Зөвлөлийн дарга нь НХХ-ийн дэд сайд байна.</p> | <p>Улсын Их Хурал нь Засгийн газар, даатгуулагч, ажил олгогчийг тэнцүү тоогоор төлөөлсөн орон тооны бус гишүүдээс бүрдсэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байгуулж ажиллуулна. Үндэсний зөвлөл ажлаа Улсын Их Хуралд тайлагнана. Үндэсний зөвлөл нь 9 хүний бүрэлдхүүнтэй байна.(Нийгмийн даатгалын тухай хуулийн 27.2)</p> | <p>НДС-аас санхүүжина. Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан улирал тутам цалингийн нэмэгдэл олгож болно. Цалингийн нэмэгдлийн дээд хэмжээг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно</p> | <ul style="list-style-type: none"> Ажлын алба -7 Дарга, хянан шалгагч-5, ЭМД-ийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Төрийн захиргааны албан хаагч |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | | |
|----|--|---|---|--|
| 2. | <p>Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл</p> <p>- Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн; - Монгол Улсын Их Хурал 7 хүн; - Монгол Улсын Засгийн газар 4 хүн.</p> <p>Үндэсний зөвлөлийн даргад сонгох хүнийг Үндэсний зөвлөлийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн нууц санал хураалтаар Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.</p> | <p>Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх орон тооны бус байгууллага бөгөөд 15 гишүүнтэй байна. (Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 21.8)</p> | <p>Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнд Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн үндсэн ажлынх нь цалин, түүнтэй адилтгах бусад орлогын дунджийн 40 хувиас хэтрэхгүй хэмжээний урамшуулал олгох бөгөөд урамшууллын хэмжээ, олгох журмыг Үндэсний зөвлөл батална</p> | <p>Үндэсний зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн дарга нь орон тооны байна.</p> |
| 3. | <p>Үндэсний статистикийн хорооны зөвлөл</p> <p>Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо 3 гишүүнийг Засгийн газар санал болгож 3 гишүүнийг, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүд нь орон тооны бус байна. Зөвлөлийн дарга нь Үндэсний статистикийн хорооны дарга байна.</p> | <p>Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байна. Үндэсний статистикийн хороонд албан ёсны статистикийн үйл ажиллагааг явуулахад туслах, арга зүйн нэгдмэл байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэгтэй Улсын Их Хурал, Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллага болон хэрэглэгчийн төлөөлөлтэй зөвлөлийг Улсын Их Хурал томилно. (Статистикийн тухай хуулийн 14.1)</p> | <p>Зөвлөлийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг харгалзан зөвлөлийн гишүүдэд зохих хөлс олгож болно. Хөлс олгох тухай асуудлыг зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу зохицуулна.</p> | |

* * *

Хоёр: Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа “байнгын ажиллагаатай” үндэсний зөвлөл, хороо⁵

Байнгын ажиллагаатай 14 үндэсний зөвлөл, 3 хороог Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолоор батлан, зөвлөлийн бүрэлдхүүнийг 1-19 дүгээр хавсралтуудаар баталсныг тус зөвлөл хороо байгуулах үндэслэл болох холбогдох хуулийн заалттай нэгтгэн /Хүснэгт №2/ харуулав. Зөвлөл хороодын ажиллах дүрэм, журмыг Монгол Улсын Засгийн газар баталдаг бөгөөд хороо зөвлөлүүд нь 11-32 хүний бүрэлдхүүнтэй, зөвлөлийн гишүүдэд яамдын сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, харъяа яам болон агентлагийн газрын дарга нарыг албан тушаалаар нь зааж хамруулсан, цалин урамшуулал байхгүй.

Эдгээрээс 11 хороо зөвлөл нь орлогч даргатай, бүх хороо зөвлөл нь нарийн бичгийн даргатай, үүнээс 2 зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай бөгөөд төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагч юм. Зөвлөл хороодын үндсэн чиг үүргээс харахад ихэнх нь тухайн хуулийн хэрэгжилтийн үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулах, хуулийн биелэлтэнд хяналт тавих, санал боловсруулах, зөвлөгөө өгөх, санал дүгнэлт мэдүүлэг гаргах, шинжилгээ хийх үүрэгтэй ажилладаг юм байна. Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл, Гадаад сурталчилгаа соёлын харилцаа зохицуулах үндэсний зөвлөл, Цэрэг цагдаагийн багийг НҮБ болон Олон улсын үйл ажиллагаанд бэлтгэх асуудлыг зохицуулах үндэсний

⁵ Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 1-19,21 хавсралтаас

зөвлөл, Мянганы зам төслийг хэрэгжүүлэх хорооны чиг үүргээс бусад зөвлөл хороодын чиг үүргийг холбогдох хуулийн заалтаас дор дурдав.

Зөвлөлүүдийн чиг үүрэг

Гаалийн тарифийн зөвлөл Гаалийн татвар, тарифийн зохистой тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт гаргах, санал боловсруулах үүрэг бүхий гаалийн тарифын орон тооны бус зөвлөл ажиллах бөгөөд бүрэлдхүүн, дүрмийг Засгийн газар батална. Тус зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай. Нарийн бичгийн дарга нь төрийн тусгай албан хаагч. ТТ-13-аар цалинжиж, Гаалийн ерөнхий газрын хэлтсийн даргын статустай.

Эротикийн чиглэлийн суртачлагаанд хяналт тавих үндэсний зөвлөл нь эротикийн чиглэлийн хэвэл, ном зохиол, кино, дүрс бичлэгт тавих хяналтыг эрүүл мэнд, нийгийн хамгаалал, соёлын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын дэргэдэх зөвлөл хэрэгжүүлнэ. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдхүүнийг Засгийн газар батална.

Аялал жуучлалын зөвлөл нь аялал жуучлалын талаархи төрийн нэгдсэн бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх асуудлаар Ерөнхий сайдад зөвлөгөө өгөх, санал дүгнэлт гаргах үүрэгтэй. Зөвлөлийн дарга, гишүүдийг Ерөнхий сайд томилно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдэд хяналт тавих үндэсний зөвлөл нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бүртгэл, хуваарилалт, үйлдвэрлэл, зарцуулалт, хадгалалт, худалдаа, хэрэглээ, түүхий эдийн олборлолт, энэ төрлийн бодис болон тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг таслан зогсоох, хууль бус эргэлтийг таслан зогсоох, энэ төрлийн зөрчил гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүрэгтэй абнийгын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтооно.

Эмийн зөвлөл нь эмийн үндэсний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх орон тооны бус, мэргэжлийн зөвлөх байгууллага бөгөөд түүний бүрэлдэхүүн, дүрэм, гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргах журмыг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл нь Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохицуулах үүрэг бүхий орон тооны бус бөгөөд үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

Төрийн хэлний зөвлөл нь төрийн албан ёсны хэлэнд дагаж мөрхдөх орчин цагийн монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тогтоох, баталж мөрдүүлэх, жигдлэн хэвшүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, нэр томъёотой холбогдсон асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэгтэй.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага юм

Стандартчиллын үндэсний зөвлөл нь төрийн болон төрийн бус, шинжлэх ухааны холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллөөс бүрдэнэ. Үндэсний стандарт, стандартчиллын хөтөлбөрийг батлах, хүчингүй болгох, хууль тогтоомжил нийцүүлэн стандартчилал, тохирлын үнэлгээний ажлын хэтийн бодлого, чиглэлийг тодорхойлох, техникийн зохицуу-



Судалгааны эмхтгэл, Х боть

лалт тохирлын үнэлгээтэй холбогдсон дүрэм, журам, зааврыг батлах, стандартчиллын техникийн хороодыг байгуулах, тэдгээрийн дүрмийг батлах чиг үүрэгтэй. Орон тооны нарийн бичгийн даргатай.Нарийн бичгийн дарга нь төрийн захиргааны албан хаагч. ТЗ-7-гоор цалинжиж ахлах түшмэлийн зэрэгтэй.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, төр, олон нийтийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж,иргэдийг оролцуулах үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулах чиг үүрэгтэй

Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий /орон тооны бус/

Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөл Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулсан Архидан согтуурахтай тэмцэх сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргана.

Хороо

Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо нь баяр наадмыг уламжлалт ёс заншилд тулгуурлан улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.Зохион байгуулах хороо нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэж, салбар хороотой байна.

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, биелэлтэнд хяналт тавих, шинжилгээ хийх үүрэгтэй Ерөнхий сайдын дэргэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй байгуулж ажиллуулна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо хөдөлмөрийн асуудлаар төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх, нийгмийн зөвшлийн гурван талт тогтолцоог хөгжүүлэх;иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон эдийн засаг, нийгмийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд үүссэн хамтын маргааныг зохицуулах;хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт улсын хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, эдийн засаг, нийгмийн бодлогын нийтлэг асуудлаар зөвлөлдөх;

Үндэсний зөвлөл, хороодын бүрэлдхүүн, холбогдох хуулийн заалт

Хүснэгт №2

| № | А/ Үндэсний зөвлөл /14/ Холбогдох хуулийн заалт | Дарга | Орлогч | Гишүүд | НБД | Бүгд |
|---|--|---------------------------|--|--------|-----|------|
| 1 | Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл | Монгол Улсын ерөнхий сайд | Сангийн сайд, Байгаль орчин аялал жуучлалын сайд, Эрдэс баялаг эрчим хүчний сайд | 27 | 1 | 32 |

| | | | | | | |
|----|---|--|---|----|-------|----|
| 2 | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл/ Эрүүл мэндийн тухай хуулийн 11.2 | Монгол Улсын ерөнхий сайд | Эрүүл мэндийн сайд | 25 | 1 | 28 |
| 3 | МУЗГ, АНУ-ын Засгийн газар хоорондын худалдаа хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөл | Гадаад харилцааны сайд | 0 | 21 | 1 | 24 |
| 4 | Гадаад сурталчилгаа соёлын харилцаа зохицуулах үндэсний зөвлөл | Гадаад харилцааны сайд | 0 | 17 | 1 | 19 |
| 5 | Төрийн хэлний үндэсний зөвлөл / Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 6.3/ | Боловсрол соёл шинжлэх ухааны сайд | | 9 | 1 | 11 |
| 6 | Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл /Мэргэжлийн боловсролын тухай хуулийн 6,1 | Боловсрол соёл шинжлэх ухааны сайд | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны газрын дарга | 14 | 1 | 17 |
| 7 | Эмийн үндэсний зөвлөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5.1/ | Эрүүл мэндийн дэд сайд | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн т,н,б,д | 13 | 1 | 16 |
| 8 | Мансууруулах эм, түүхий эдэд хяналт тавих үндэсний зөвлөл / Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14,5 | Эрүүл мэндийн сайд | Хууль зүй дотоод хэргийн дэд сайд | 13 | 1 | 16 |
| 9 | Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөл /Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 132.3/ | Хууль зүй дотоод хэргийн сайд | 0 | 13 | 1 | 15 |
| 10 | Эротикийн сурталчилгаанд хяналт тавих үндэсний зөвлөл / Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 9.2/ | Хууль зүй дотоод хэргийн яамны т,н,б,д | 0 | 10 | 1 | 12 |
| 11 | Гаалийн тарифийн зөвлөл үндэсний зөвлөл /Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 6.1/ | Сангийн сайд | Гадаад харилцааны дэд сайд | 17 | 1 о/т | 20 |
| 12 | Стандартчиллын Үндэсний зөвлөл / Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 20.3/ | Стандартчилал хэмжил зүйн газрын дарга | 0 | 20 | 1 о/т | 22 |
| 13 | Аялал жуулчлалын бодлого зохицуулах зөвлөл /Аялал жуулчлалын тухай хуулийн 15.4/ | Байгаль орчин аялал жуулчлалын сайд | Зам тээвэр хот байгуулалтын сайд | 8 | 1 | 11 |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | | | | |
|----|--|--|--|---------------|------------|-------------|
| 14 | Цэрэг цагдаагийн багийг НҮБ болон Олон Улсын үйл ажиллагаанд бэлтгэх асуудлыг зохицуулах үндэсний зөвлөл /Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн 4.1.7/ | Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга | Гадаад харилцааны яамны газрын дарга | 8 | 1 | 11 |
| | Б/ Үндэсний хороо /3/ | Дарга | Орлогч | Гишүүд | НБД | Бүгд |
| 1 | Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хороо /УИХ –ын 2003 оны 41 дүгээр тогтоол/ | Монгол Улсын ерөнхий сайд | Хууль зүй дотоод хэргийн сайд | 31 | 1 | 34 |
| 2 | Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо /Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.3/ | Монгол Улсын шадар сайд | Нийслэлийн засаг дарга ,Улаанбаатар хотын захирагч | 17 | 1 | 20 |
| 3 | Мянганы зам төслийг хэрэгжүүлэх хороо | Зам тээвэр хот байгуулалтын сайд | Сангийн сайд | 12 | 1 | 15 |

* * *

Гурав: **Монгол Улсын Засгийн Газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах “орон тооны бус” үндэсний зөвлөл, хороо⁶**

Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах орон тооны бус үндэсний зөвлөл (22), хороодыг (16) Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтаар баталжээ.

Орон тооны бус зөвлөл, хороодын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь засгийн газраас батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, удирдан зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах явдал юм. Эдгээр зөвлөл хороодын ажиллах дүрэм журмыг салбарын сайд нь тушаал гаргаж батлана. Засгийн газрын байнгын ажиллагаатай ба орон тооны бус үндэсний зөвлөл хороодын ахалсан яамдын сайд дарга нарыг Хүснэгт №3–д нэгтгэж харуулав.

Үндэсний зөвлөл 22

Монгол Улсын Ерөнхий сайд даргалсан-1

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудлаархи салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах зөвлөл

Монгол Улсын Тэргүүн шадар сайд даргалсан -1

Үйлдвэржилттэй холбоотой хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний зөвлөл

Монгол Улсын Шадар сайд даргалсан -1

⁶ Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтаас

“Нэг суурин - нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд даргалсан -5

Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл

“Хүнсний баталгаат байдал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний зөвлөл

Эрхлэх ажлын хүрээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний зөвлөл

Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл

Ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд даргалсан -3

“Бүх нийтийн экологийн боловсрол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үндэсний зөвлөл

Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл

“Сонгодог урлаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зөвлөл

Хууль зүй, дотоод хэргийн сайд даргалсан -3

Хилийн боомтын асуудал эрхэлсэн зөвлөл

Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих зөвлөл

Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн зөвлөл

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд даргалсан -3

Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөл

Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл

Ховор ургамлын үндэсний зөвлөл

Сангийн сайд даргалсан -2

Засгийн газрын худалдан авах ажиллагааны дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн үндэсний зөвлөл

Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг удирдан зохион байгуулах зөвлөл

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд даргалсан -2

Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж хяналт тавих үндэсний зөвлөл



Эрдэс баялаг, эрчим хүчний сайд даргалсан -1

Эрхлэх ажлын хүрээний Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл

Үндэсний хороо /16/

1. Монгол Улсын Ерөнхий сайд даргалсан -5

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хороо

Монголын мэдээлэл, холбооны технологийн үндэсний хороо

Олимпид бэлтгэх үндэсний хороо

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудлаархи салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах зөвлөл

Жендерийн тэгш байдлын үндэсний хороо

2. Монгол Улсын Шадар сайд даргалсан -1

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн Үндэсний хороо

3. Сангийн сайд, МҮХАҮТ-ын дарга даргалсан -1

Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо

4. Гадаад харилцааны сайд даргалсан -3

Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг удирдан зохицуулах үндэсний хороо

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үйлдвэр хөгжлийн байгууллага /ЮНИДО/-ын Монголын үндэсний хороо

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсад 2007-2011 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд үндэсний хэмжээнд мониторинг хийх Удирдах хороо

5. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд даргалсан -3

Уур амьсгалын үндэсний хороо

Биоаяулгүй байдлын асуудлыг зохицуулах үндэсний хороо

Ойн тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах үндэсний хороо

6. Хууль зүй, дотоод хэргийн сайд даргалсан -1

Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хороо

7. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд даргалсан -1

Хүн ам, хөгжлийн асуудлаархи үндэсний хороо

8. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд даргалсан -1

Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үндэсний хороо

Хүснэгт №3

| № | Засгийн Газрын 82 дугаар тогтоолоор байгуулагдсан Байнгын ажиллагаатай болон орон тооны бус үндэсний зөвлөл, хороодын дарга | Байнгын ажиллагаатай | | Орон тооны бус | | Бүгд |
|-----|---|----------------------|----------------|-----------------|----------------|------|
| | | Үндэсний зөвлөл | Үндэсний хороо | Үндэсний зөвлөл | Үндэсний хороо | |
| 1. | Монгол Улсын Ерөнхий сайд | 2 | 2 | 1 | 5 | 10 |
| 2. | Монгол Улсын Тэргүүн шадар сайд | 0 | 0 | 1 | 0 | 1 |
| 3. | Монгол Улсын шадар сайд | 0 | 0 | 1 | 1 | 2 |
| 4. | Байгаль орчин аялал жуучлалын сайд | 1 | 0 | 3 | 3 | 7 |
| 5. | Хууль зүй дотоод хэргийн сайд | 2 | 0 | 3 | 1 | 6 |
| 6. | Гадаад харилцааны сайд | 2 | 0 | 0 | 3 | 5 |
| 7. | Боловсрол соёл шинжлэх ухааны сайд | 2 | 0 | 3 | 0 | 5 |
| 8. | Зам тээвэр барилга хот байгуулалтын сайд | 1 | 1 | 2 | 1 | 5 |
| 9. | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд | 0 | 0 | 5 | 0 | 5 |
| 10. | Сангийн сайд | 1 | 0 | 2 | 1 | 4 |
| 11. | Эрүүл мэндийн сайд | 2 | 0 | 0 | 0 | 2 |
| 12. | Эрдэс баялаг эрчим хүчний сайд | 0 | 0 | 1 | 0 | 1 |
| 13. | Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд | 0 | 0 | 0 | 1 | 1 |
| 14. | Батлан хамгаалах яамны ТНБД | 1 | 0 | 0 | 0 | 1 |
| 15. | БҮГД | 14 | 3 | 22 | 16 | 55 |

* * *

Дүгнэлт

Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан байнгын ажиллагаатай зөвлөл хороодын дүрэм журмыг Засгийн газар баталдаг. Зөвлөл хороодын үндсэн чиг үүрэг нь тухайн хуулийн хэрэгжилтийн үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулах, хуулийн биелэлтэнд хяналт тавих, санал боловсруулах, зөвлөгөө өгөх, санал дүгнэлт мэдүүлэг гаргах, шинжилгээ хийх үүрэгтэй ажилладаг. Зөвлөл хороодын дарга, гишүүдийг албан тушаалаар зааж томилсон, цалингийн нэмэгдэл, урамшуулал, хөлс байхгүй.

Орон тооны бус зөвлөл хороодын ажиллах журмыг салбарын сайд тушаал гаргаж батална. Үндсэн чиг үүрэг нь Засгийн газраас батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, удирдан зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах явдал юм. Зөвлөл хороодын даргыг Засгийн газрын тогтоолоор, гишүүдийг салбарын сайдын тушаалаар баталдаг, цалингийн нэмэгдэл, урамшуулал, хөлс байхгүй.



Судалгааны эмхтгэл, Х боть

Засгийн газрын 82 дугаар тогтоолын хавсралтаар байгуулагдсан зөвлөл хороодод Монгол Улсын Ерөнхий сайд болон зарим салбарын сайд 4-10 хороо зөвлөлийг тэргүүлэн ажиллаж байна. /Хүснэгт №3/

УИХ -аас байгуулагдсан 3 зөвлөл нь ажлаа УИХ -д тайлагнадаг. Зөвлөл хороодын бүрэлдэхүүн, статус, цалин урамшуулалыг /Хүснэгт№1 харуулсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь ажлын албатай, Гаалийг тарифийн зөвлөл, Стандартчилалын үндэсний зөвлөл 2 орон тооны нарийн бичгийн даргатай, төсвөөс цалинждаг.

* * *

Ашигласан материал

1. Монгол улсын холбогдох хуулиуд
2. Монгол Улсын Засгийн газрын тогтоол түүний хавсралт
3. Зөвлөл хороодын дүрэм, журам
4. www.pmis.gov.mn
5. www.legalinfo.mn
6. <http://www.ndaatgal.mn/>



**УЛС ТӨРИЙН НАМУУДЫН БҮТЭЦ, ГИШҮҮНЧЛЭЛ, САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХИ
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ***/Харьцуулсан судалгаа/*

*П. Амаржаргал, Б. Буяндэлгэр, Ц. Төвүүсүрэн,
Б. Хатантуул*

УИХ-ын Тамгын Газрын Судалгааны төвийн судлаачдын баг Улсын Их Хурлын гишүүн Ш.Сайхансамбуугийн захиалгаар ОХУ, Голланд, Швед, ХБНГУ, Япон зэрэг орны улс төрийн намын бүтэц, гишүүнчлэл, санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтын талаархи харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв.

Судалгааны зорилго нь судалгаанд хамрагдсан орнуудын Үндсэн хууль, улс төрийн намын тухай хууль, зарим намын дүрэм зэргийг нэг бүрчлэн судлаж, тухайн орнуудад улс төрийн намын бүтэц, гишүүнчлэл, санхүүжилтийн асуудлыг хэрхэн зохицуулсныг харьцуулж, нийтлэг чиг хандлагыг захиалагчид мэдээлэх явдал юм.

Судалгааны нэгдсэн дүгнэлт

Судалгаанд хамрагдсан орнууд болон бусад орнуудын улс төрийн намын тухай хууль тогтоомжоос харахад барууны ихэнх орнууд гишүүнчлэлгүй, эсвэл сул гишүүнчлэлтэй, зарим оронд зөвхөн дэмжигчид байдаг байна. Тиймээс тэнд гишүүнчлэлийг гол болгодоггүй, сонгуульд санал өгсөн дэмжигчдийнх нь тоогоор эрх барих хүчнийг тодорхойлдог. Энэ нь ард түмний эв нэгдэл бат бэх байх сайн талтай.

Судалгаанаас үзэхэд улс төрийн намын санхүүжилтийн дараах үндсэн 5 эх үүсвэр байна. Үүнд:

- Гишүүний элсэлтийн татвар болон гишүүний татвар
- Хуулиар зөвшөөрөгдсөн аж ахуйн үйл ажиллагаа
- Институционал хандив \ҮЭ-ээс гэх мэт\
- Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг
- Хувийн хандив, санхүүжилт

Үүний эхний хоёрыг нь намын өөрийн санхүүжилт гэж үзэх бөгөөд гишүүний татвар, хандив ба институционал хандивыг намын уламжлалт санхүүжилт гэж үздэг. Хөгжлийн явцад санхүүжилтийн дээрх эх үүсвэрүүдийн заримынх нь үүрэг багасч, зарим нь нэмэгдэж байна. Тухайлбал, уламжлалт санхүүжилтийн хэмжээ улам бүр багасах буюу алга болж байна. Нэг талаас улс төрийн намуудад шаардагдах санхүүжилтийн хэмжээ маш ихээр нэмэгдэж байхад гишүүдийн хандив, татвар намын санхүүжилтэнд бараг нөлөөгүй болж байна. Мөн хатуу гишүүнчлэлгүй намуудын тоо нэмэгдэж байгаа нь ч нөлөөлж байна. Засгийн газрын бодлогод намуудаар дамжуулан нөлөөлөх зорилготойгоор нөлөөлийн томоохон субъектуудын зүгээс хийгддэг байсан институционал хандивууд мөн багасч байна.

Үйлдвэрчний эвлэлүүдийн зүгээс зүүний чиглэлийн намуудыг, бизнес эрхлэгчдийн зүгээс барууны чиглэлийн намуудыг тус тус санхүүгийн талаар дэмжиж ирсэн уламжлал бий. Санхүүгийн энэ уламжлалт эх үүсвэр бараг үгүй болоод байна. Гэхдээ Швед зэрэг зарим оронд ямар нэг хэмжээгээр байсаар байна. Хэдийгээр намуудын үйл ажиллагааны зардал улам бүр өссөөр байгаа боловч уламжлалт санхүүжилтийн дээрх хоёр хэлбэр ийнхүү үндсэндээ байхгүй болж байгаа нь намуудын санхүүг сулруулаагүй. Масштабын хувьд уламжлалт санхүүжилтээс үлэмж давуу санхүүгийн эх үүсвэрүүд гарч ирсэн. Энэ нь төрийн ба хувийн санхүүжилт юм.



Судалгааны эмхтгэл, Х боть

Улс төрийн намуудыг улсын төсвөөс санхүүжүүлэх нь мөн нилээд сөрөг талуудыг авчирдаг байна. Жишээлбэл, Германд намуудын аппарат хэт олшрох, хүнд суртал газар авах, намууд хэт үнэтэй сонгуулийн кампани явуулах, төсвөөс аль болох их хөрөнгө олж авах эрмэлзэл бий болох зэрэг сөрөг талууд ихээр илрэх болсон тул намуудад нийтэд нь улсын төсвөөс өгөх мөнгөний дээд заагийг хуульчилан тогтоожээ.

Улс төрийн намуудын санхүүжилтийн улам бүр өсөн нэмэгдэж буй нэг томоохон эх үүсвэр нь хандивлагчид болж байна. Төрийн санхүүжилт намуудын үйл ажиллагааны зардлын өсөн нэмэгдэх хэмжээ, хурдыг хангахгүй тул хувь хүмүүс ба хуулийн этгээдүүдийн хандив намуудын үйл ажиллагаанд чухал үүрэгтэй болж байна. Иймээс авилга, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилгоор хуулиар хандивын дээд хэмжээг заан, гадаадын улсууд, иргэдээс болон эх үүсвэр нь тодорхойгүй хандив авахыг хориглож, томоохон хэмжээний хандив авсан тохиолдолд тайлагнах тусгай хэлбэрийг тогтоодог байна. Олон орнууд мөн төрийн байгууллагууд, төрийн өмчит аж ахуйн нэгжийн зүгээс намд хандив өгөхийг хориглосон байдаг.

Намуудын аж ахуйн үйл ажиллагаанаас олох орлого нь:

- Намын аж ахуйн үйл ажиллагааны орлого
- Өөрийн өмчинд байгаа хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, зарцуулах
- Сурталчилгааны үйл ажиллагаанаас олох орлого зэргээс бүрдэж байна.

Жишгээс үзэхэд олон улсуудад намын орлого олох дээрх үйл ажиллагааг татвараас чөлөөлөх буюу хөнгөлөдөг боловч намуудын дүрмийн зорилгод нь хамааралгүй аливаа төрлийн бизнесийн боломжуудыг нь хязгаарладаг. Нэлээд орны хуулиар нам аливаа хөндлөнгийн оролцоогүй үйлдвэр, аж ахуйн нэгж байгуулж болох боловч бусад аж ахуйн байгуулагад хувь эзэмшиж болохгүй. Ер нь улс бүрийн хувьд намууд өөрийн мэдлийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэн ашиг олж болох эсэх талаар янз бүрээр тусгасан байна. Зарим улсад үүнийг хориглосон байхад зарим нь зөвшөөрдөг байна.

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль” 2001 онд батлагдсан. 2002-2010 онд жил бүр нэмэлт өөрчлөлт орж байсан. ОХУ-д улс төрийн намуудыг тус улсын Хууль зүйн яам бүртгэдэг. Улсын бүртгэлд бүртгэлтэй 7 намтай. Үүнд:

1. “Единая Россия” \“Нэгдмэл Орос” нам\
2. “Коммунистическая партия Российской Федераций” \ОХУ-ын Коммунист нам\
3. “Либерально-демократическая партия России” \Оросын либерал-ардчилсан нам\
4. “Патриоты России” \“Оросын эх орончид” нам\
5. “Партия “Яблоко” \“Яблоко” нам\
6. “Справедливая Россия” \“Шудрага Орос орон” нам\
7. “Правое дело” \“Зөв үйлс” нам\

Үүнээс Төрийн Думд дараах 4 нам суудалтай:

1. “Нэгдмэл Орос” нам
2. ОХУ-ын Коммунист нам
3. Оросын либерал-ардчилсан нам
4. “Шудрага Орос орон” нам

Нэг. ГИШҮҮНЧЛЭЛ

Улс төрийн нам нь 45 мянгаас доошгүй гишүүнтэй, ОХУ-ын нийт субъектын талаас илүүд нь салбартай, салбар тус бүр нь 450-аас доошгүй гишүүнтэй байна. Нутаг дэвсгэрийн бусад нэгжүүд дэх салбар нь 200-аас доошгүй гишүүнтэй байна. Нам нэг ижил мэргэжлийн хүмүүсээс бүрдэж болохгүй. ОХУ-ын Ерөнхийлөгч нь бүрэн эрхийнхээ хугацаанд намын гишүүнээс түдгэлзэж болно. **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 2, 4 дүгээр заалт**

18 насанд хүрсэн ОХУ-ын иргэн улс төрийн намын гишүүн байж болно. Гадаадын харъяат болон харъяалалгүй этгээд, эрх зүйн чадваргүй болох нь шүүхээр тогтоогдсон ОХУ-ын иргэн улс төрийн намын гишүүн байж болохгүй. Иргэдийг намд элсүүлэхдээ тухайн намын дүрэмд заасан журмын дагуу бичгээр гаргасан өргөдлийг үндэслэнэ. **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 2,3 дугаар заалт**

Нам жил бүр гишүүдийнхээ тоог орон нутгийн салбар тус бүрээр гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 27 дугаар зүйл**

Хоёр. БҮТЭЦ

Намын удирдах дээд байгууллага нь намын Их хурал байна. Намын орон нутгийн байгууллагын удирдах дээд байгууллага нь Бага хурал, Бүх гишүүдийн хурал байна. Эдгээр байгууллагуудыг 4 жилд нэгээс доошгүй удаа шинээр сонгоно. **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 1-4 дүгээр заалт**

Гурав. НАМЫН ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ

Нам энэ хуульд болон өөрийн дүрэм, мөрийн хөтөлбөрт заасан үйл ажиллагааг хангах, зорилго, зорилтоо хэрэгжүүлэх үүднээс үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөтэй байна. **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 28 дугаар зүйл**

Намын мөнгөн хөрөнгө **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт** нь:

- а) элсэлтийн болон гишүүний татвар
- б) энэ хуульд заасан улсын төсвийн санхүүжилт
- в) хандив
- г) нам, түүний салбар байгууллагуудаас зохион явуулсан арга хэмжээнээс олсон орлого
- д) иргэний эрх зүйн хэлцлээс олсон орлого
- е) хуулиар хориглоогүй бусад орлого

Нам, түүний орон нутаг дахь салбар нь иргэд, хуулийн этгээдээс мөнгөн болон хөрөнгийн бусад хэлбэрээр хандив авч болох бөгөөд хандивын гарал үүслийг зааж, баримтаар баталгаажуулсан байна. **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 30 дугаар зүйлийн 1 дүгээр заалт**

Нам, түүний орон нутаг дахь байгууллагууд дүрэм, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх зорилгоор дараах аж ахуйн үйл ажиллагааг эрхлэж болно:

- а) өөрийн үзэл баримтлал, зорилго, зорилтыг нийтэд түгээх зорилгоор мэдээлэл сурталчилгаа хийх, хэвлэлийн үйл ажиллагаа эрхлэх

Судалгааны эмхтгэл, Х боть

б\ намынхаа нэр, бэлгэдэл бүхий бэлэг дурсгалын зүйлс, сонин, ном, товхимол зэргийг хийж бүтээх, худалдах

в\ өөрийн өмчлөлд байгаа хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдах, түрээслэх

Намын бүх шатны байгууллагуудын аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогыг намын гишүүдэд хуваарилаж болохгүй бөгөөд зөвхөн дүрэмд заасан зорилгыг хэрэгжүүлэхэд ашиглана. Намын аль ч шатны байгууллага буяны үйл ажиллагаа явуулж болно. **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 1, 5, 7 дугаар заалтууд**

Улс төрийн намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг тухайн намын сонгуульд гаргасан зардлыг нөхөх зорилгоор сонгуульд оролцсон дүнг харгалзан энэ хуульд заасан журмын дагуу улсын төсвөөс олгоно. Улс төрийн намд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын төсвөөс гаргах нийт мөнгөний хэмжээг хамгийн сүүлд явагдсан Төрийн Дум, Холбооны Хурлын, эсвэл ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч тутамд 20-иос доошгүй рубль байхаар тооцно.

Төрийн Дум, Холбооны Хурлын, эсвэл ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид нь санал хураалтад оролцсон сонгогчдын 3-аас доошгүй хувийн санал авсан намууд төсвөөс мөнгөн дэмжлэг авах эрхтэй. Төрийн Дум, Холбооны Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшигчид нь 3-аас доошгүй хувийн санал авсан намд тухайн намын нэр дэвшигчдийн төлөө өгсөн нэг саналыг 20 рублиер тооцож дараагийн сонгууль хүртэл жил тутам, ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож, нэр дэвшигч нь мөн тооны санал авсан намд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд нэг удаа дээрх хэмжээний мөнгийг төрөөс дэмжлэг болгон өгнө. **ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 33 дугаар зүйлийн 1, 3, 5, 6, 9 дүгээр заалтууд**

Дөрөв. АВИЛГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ТАЛААРХИ ЗҮЙЛ, ЗААЛТУУД

Нам, түүний орон нутаг дахь салбар нь иргэд, хуулийн этгээдээс мөнгөн болон хөрөнгийн бусад хэлбэрээр хандив авч болох бөгөөд хандивын гарал үүслийг зааж, баримтаар баталгаажуулсан байна. Намд болон түүний орон нутгийн салбаруудад өгөх мөнгөн хандивыг бэлэн бусаар шилжүүлнэ. Иргэдийн хандивыг бэлнээр авч болно. Нэг иргэнээс нэг жилд авах хандивын дээд хэмжээ нь 4330 рубль байна.

Нам, түүний орон нутгийн байгууллагуудыг дараахь этгээдээс хандив авахыг хориглоно:
а\ гадаад улс, гадаадын хуулийн этгээд

- б\ гадаадын иргэн
- в\ харьяалалгүй этгээд
- г\ 18 насанд хүрээгүй ОХУ-ын иргэн
- д\ хандив өргөж байгаа өдрийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нь дүрмийн сангийн 30-аас илүү хувийг эзлэж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд
- е\ олон улсын байгууллага, олон улсын олон нийтийн хөдөлгөөн
- ё\ төрийн болон нутгийн удирдлагын байгууллага
- и\ хандив өргөж байгаа өдрийн байдлаар дүрмийн санд нь төр, орон нутгийн өмчийн оролцоо 30-аас илүү хувийг эзлэж байгаа хуулийн этгээд
- к\ цэргийн байгууллага, анги салбар, хууль сахиулах байгууллага
- л\ буяны болон шашны байгууллага
- м\ тодорхой нэр хаяггүй этгээд

- н\ хандив өргөж байгаа өдрийн байдлаар байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд
- о\ ашгийн бус байгууллага

Нам, түүний орон нутгийн салбарын нэг хуулийн этгээдээс авах хандивын хэмжээ хуанлийн нэг жилийн хугацаанд 43 сая 300 мянган рублиэс, нэг иргэнээс авах хандив мөн хугацаанд 4 сая 330 мянган рублиэс их байж болохгүй. Нам, түүний орон нутгийн салбарын нийт хандивын хэмжээ нэг жилийн хугацаанд 4 тэрбум 330 сая рублиэс давж болохгүй. Харин орон нутгийн салбарын хувьд мөн хугацааны хандив 86 сая 600 мянган рублиэс хэтэрч болохгүй. \ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 30 дугаар зүйлийн 1, 2, 3, 8, 9 дүгээр заалтууд\


НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛС

Нидерланд Улсад анх 1780 -аад оноос “Улбар шаруудын нам”, “Эх орончдын нам байгуулагдаж эхэлснээр олон намын тогтолцооны эх суурь тавигджээ. Одоогийн байдлаар Нидерландад улс төрийн 20 гаруй нам үйл ажиллагаа явуулж байгаа юм байна. 2006 оны парламентын сонгуулийн үр дүнгээр парламентын доод танхимын 150 суудлаас Христийн ардчилсан уриа нам 41, Хөдөлмөрийн нам 33, Социалист нам 25, Эрх чөлөө, ардчиллын төлөө ардын нам 22, Эрх чөлөөний төлөө хэт барууны нам 9, Зүүний ногоон нам 7, Христийн холбоо 6, Ардчилал-66 нам 3, Шинэчлэлийн нам, Амьтан хамгаалахын төлөө нам тус бүр 2 суудал авсан байна.

Судлаачдын үзэж байгаагаар 1918 оноос хойш парламентад нэг ч удаа аль нэг нам дангаараа олонхийг бүрдүүлж байгаагүйг сонгуулийн хувь тэнцүүлсэн тогтолцоотой, саналын босгыг доогуур тогтоосонтой холбон тайлбарладаг байна. 2006 оны сонгуулиар Христийн ардчилсан уриа нам, Хөдөлмөрийн нам, Христийн холбоо нам эвсэж, Засгийн газраа байгуулж, 2010 оны II сард хугацаанаасаа өмнө Афганистанд явуулж байсан энхийг сахиулах үйл ажиллагааны талаар хоорондоо санал зөрснөөс болж огцорсон байна.

2010 оны YI сард болсон сонгуулийн үр дүнгээр Христийн ардчилсан уриа нам өмнөх суудлынхаа бараг тэн хагасыг нь алдаж, 21 суудалтай болсон байна. Энэ сонгуулиар Эрх чөлөө, ардчиллын төлөө ардын нам 31, Хөдөлмөрийн нам 30, Эрх чөлөөний нам 24, Социалист нам 15, Ардчилал-66, Зүүний ногоон нам, Христийн холбоо, Шинэчлэлийн нам, Амьтан хамгаалахын төлөө нам 2-10 суудал авчээ. Эрх чөлөө, ардчиллын төлөө ардын нам, Хөдөлмөрийн/социалист/ нам эвсэж Засгийн газраа байгуулсан бөгөөд Эрх чөлөөний нам энэ эвслийг дэмжиж ажиллахаар тогтсон байна.

Нидерландын 2010 оны парламентын доод танхимын сонгуулийн дүн



Нэг. Гишүүнчлэл

Нидерландийн улс төрийн намын тухай хууль олдоогүй ч Нидерландын <http://www.orangesmile.com> сайтад мэдээлснээр Нидерланд улсын улс төрийн намууд **гишүүнчлэлтэй** бөгөөд намуудын санхүүжилтийг тухайн нам өөрөө хангах үүрэгтэй байна. Улс төрийн намын санхүүжилт нь **гишүүдийн татвар, зарим үед орох бизнес эрхлэгчдийн бэлэглэлийн татвараар** бүрдэх бөгөөд эдгээр татварын орлогыг нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй байдаг байна.

Улс төрийн намууд дор дурдсан 3 чиглэлийн үйл ажиллагааны санхүүжилтэд зориулсан субсидыг улсын төрөөс авдаг байна. Үүнд:

- 1/ Шинжлэх ухааны сэтгүүл хэвлэн гаргадаг, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний товчооны үйл ажиллагааны санхүүжилт,
- 2/ Сургалт, соёл-боловсрол түүний дотор Төв болон зүүн Европын ах дүү намуудыг хамруулж сургалт, соёл боловсролын үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын санхүүжилт,
- 3/ Залуучуудын улс төрийн байгуулаагуудын санхүүжилт

Хоёр. Бүтэц

Улс төрийн намын тухай хууль, намын дүрмийн аль аль нь олдоогүй учир энэ талаар мэдээлэл өгөх боломжгүй байна.

Гурав. Хөрөнгө санхүүжилт

<http://Netherlander.org/administrativnoe-ustroistvo-niderlandov/politicheskaya-sistema->

niderlandov.html, <http://www.orangesmile.com>, <http://www.rekenmaker.nl> сайтуудад тавигдсан материалд Нидерланд Улс улс төрийн намын /баталгаа/ акт гэсэн эрх зүйн актаар намуудын үйл ажиллагааны баталгаа, санхүүжилтын асуудлыг зохицуулдаг тухай бичсэн байна. Тус улсын улс төрийн намуудын санхүүгийн баталгаа, намуудад бусад эх үүсвэрээс бэлэглэл, хандивийн журмаар орж байгаа санхүүжилтийг зохицуулах талаар хууль эрхийн актын дагуу хийсэн аудитын дүнгээр Европын зөвлөлийн зөвлөмжийн дагуу бусад орнуудын адил төсөөтэй зохицуулалттай харьцуулалт хийжээ.

Нидерландад 1999 онд Улс төрийн намуудын /баталгаа/ акт хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Нидерландын парламент энэхүү актаар парламентад төлөөлөлтэй улс төрийн намуудын баталгааны системийг тогтоожээ. Энэхүү баталгаанд жил бүр 15 сая еврог төсвөөс зориулдаг байна. Нидерландын улс төрийн намуудын баталгааны энэхүү систем нь Европын бусад орнуудынхаас дор дурдсан ялгагдах онцлогтой юм байна. Үүнд:

а/ Нидерландын энэхүү баталгаа нь нэг хүнд ногдох хэмжээгээрээ харьцангуй доогуур байна. Улс төрийн намууд татвар төлдөг гишүүдийн тоотой уялдсан санхүүжилтийг авдаг байна. Харин бусад орнуудад парламентад эзэлсэн суудал эсвэл сонгуульд авсан саналын тоотой уялдсан санхүүжилтийг авдаг байна.

б/ Нидерланд нь энэхүү санхүүжилтээс намын дэргэдэх шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний болон залуучуудын байгууллагын санхүүжилтэд зориулдаг бусад орнуудаас ялгагдана.

Дөрөв. Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар


в /Нидерландад улс төрийн намуудын санхүүжилтэд хийсэн аудитын дүгнэлтээр хувь этгээдээс оруулсан бэлэг, санхүүжилтийн талаархи эрх зүйн зохицуулалт нь сул байна гэж дүгнэсэн байна. Энэ талаар Европын зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу хүлээсэн үүргээ хангаж чадахгүй байгаа юм байна. Намуудад орсон бэлгийн тоо, эх үүсвэрийн хязгаарлалтын талаархи зохицуулалт хангалтгүй байна. Түүнээс гадна энэ талаархи санхүүгийн эх үүсвэр нь ил тод байх зөвлөмжийг ч хязгаарлагдмал хүрээнд биелүүлж, дүрэм журам зөрчсөн улс төрийн намуудад хариуцлага хүлээлгэх механизм бараг байхгүй байна.

г/ Нидерландын хуулийн дагуу улс төрийн намууд хувь хүмүүсийн хандив, бэлгийг оролцуулахгүйгээр бусад этгээдээс оруулсан 4537.8 мянган еврогоос дээш бэлэглэлийн санхүүжилтийн тайланг нийтэд дэлгэж тавих үүрэгтэй байна. Энэ нь бусад орнуудтай харьцуулбал өндөр босго юм.

Европын зөвлөлийн Авилгын эсрэг улс орнуудын бүлэг /GRECO/ -ээс 2008 онд Нидерландын улс төрийн намуудын санхүүжилтийн үнэлгээний талаар шүүмжлэл бүхий илтгэл нийтлүүлсэн байна. Нидерландын парламентаас энэ харилцааг зохицуулах шинэ хуулийн төслийг 2011 оны III сарын 1-ний дотор өргөн барихыг Хууль зүй, дотоод хэргийн сайддаа үүрэг болгосон байна.

ШВЕДЫН ВАНТ УЛС

Швед Улсын намын систем нь барууны ертөнц дэх хамгийн тогтвортой оршин тогтнож байгаа системүүдийн нэг юм. Тус улс нь улс төрийн намын төлөвшилөө хоёр зүйлээр тодорхойлдог. Нэгдүгээрт улс төрийн нам бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч байх ёстой. Аж ахуйн шинж чанартай амлалтын улс төрийн арга зүйгээс төрийн хөгжлийн бодлого боловсруулах, тодорхойлох үйл явц руу хандах чиглэлийг баримтлах. Хоёрдугаарт намын дотоод ардчилал, эрх чөлөөг өргөжүүлэн хөгжүүлэхэд гаргаж байгаа дэвшлээр нь тодорхойлох гэж үздэг.



Судалгааны эмхтгэл, Х боть

Улс төрийн намын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан бие даасан улс төрийн намын тухай хууль байдаггүй бөгөөд нам нь өөрийн дотоод дүрмээрээ үйл ажиллагаагаа зохицуулдаг байна (асерproject.org). Мөн түүнчлэн Швед нь нэгдмэл Үндсэн хуульгүй, Үндсэн хуулийн эрх бүхий актуудаар түүнийг орлуулдаг цөөн хэдэн улсын нэг юм.

Шведийн Үндсэн хууль нь 1974 оны Удирдлагын хэлбэрийн тухай акт (The Instrument of Government), 1810 оны Хаан ширээ залгамжлах тухай акт (Act of Succession), 1949 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай акт (The Freedom of the Press Act), 1991 оны Үг хэлэх эрх чөлөөний тухай тулгуур хууль (The Fundamental law of Freedom of Expression) зэргээс бүрдэнэ. Улс төрийн намууд нь эдгээр 4 актыг гол тулгуур зарчмаа болгодог.

Швед Улс нь олон намын тогтолцоотой. 2010 оны сонгуулиар парламентад 8 нам (Swedish Social Democratic Party, Moderate Party, Green Party, Liberal People's Party, Centre Party, Sweden Party, Sweden Democrats, Pirate Party, Christian Democrats, Left Party) суудал авчээ. Эдгээр парламентад суудал авсан намуудаас гадна орон нутгийн 47, жижиг 18 нам байна.

Улс төрийн намын бүтцийг дотоод дүрмээрээ зохицуулна: Намын аппарат, жирийн гишүүд, намыг дэмжигч гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Орчин үеийн Шведийн улс төрийн намын үндсэн зорилго бол ард түмний эрх ашиг, сонирхлыг илэрхийлэх, улс орны хөгжлийн бодлого тодорхойлох, улс орны мөн иргэний аюулгүй байдлыг хамгаалах, намын дотоод ардчилал, хариуцлага дээр тулгуурласан гишүүдийн эрх чөлөөг хангахад чиглэгдсэн байх, нийгэмд хүчтэй сөрөг хүчин байж нийгмийн гаж тогтолцоо, бодлогыг засаж залруулах, хяналт тогтоох, хариуцлага тогтоох, намын бүх шатны үйл ажиллагааг зөв менежментээр удирдан чиглүүлэхэд оршиж байна.

Сонгууль: Парламентын гишүүд сонгуулийн пропорцианаль тогтолцоогоор 4 жилийн хугацаагаар сонгогдоно. Олон мандат (2-34 мандат) бүхий 29 тойрогт намын нэрийн хаалттай жагсаалтаар санал хурааж, Сент-Лагийн боловсронгуй болгосон аргаар 310 суудлыг хуваарилна. Намуудын авсан байвал зохих саналын доод босго улсын хэмжээнд 4 хувь, тойргийн хэмжээнд 12 хувь байхаар тогтоожээ. Тодорхой нэр дэвшигчийн төлөө өгсөн санал нь намын авсан саналын 8 хувиас багагүй байна. Үлдсэн 39 суудлыг улсын хэмжээгээр 4 хувиас дээш суудал авсан намуудад авсан суудлын хувьд хувь тэнцүүлэн хуваарилна.

Намын нэрсийн жагсаалтаар депутат болж чадаагүй зарим нэр дэвшигч нь депутатын орлогч болдог. Тэд депутатуудын ажилд тусалдаг ба хэрэв парламентын суудал ямар нэг шалтгаанаар суларвал орлогч нь шинэ сонгуулийн дүн гартал депутат болдог.

Намын санхүүжилт: Жил бүр орлогоо мэдүүлж байхаар Парламентад суудал авсан бүх улс төрийн нам сайн дурын гэрээнд гарын үсэг зурдаг байна. Улс төрийн нам түүний ажлийн алба нь дараахь байдлаар санхүүждэг. Үүнд:

1. Гишүүний татвар (жилд ойролцоогоор 30 евро)
2. Улсын төсвийн санхүүжилт: Улсын төсвөөс улс төрийн намын санхүүжилтийг дэмжих 1972 оны 625 дугаар актаар зохицуулна. Үүнд: Парламентад суудал авсан нам санхүүгийн дэмжлэг авахаар тусгасан байна. (Act on State financial support to political parties 1972:625) Уг санхүүжилт нь намын орлогын гол эх үүсвэр нь болдог.
3. Хонжворт сугалаа: Нам нь их хэмжээний сугалаа эрхлэн гаргаж түүнийгээ зарж борлуулан орлого бүрдүүлж болно. Мөн сугалааг Улс болон ашгийн бус байгууллага гаргаж болно.
4. Хандив: Улс төрийн намд хувь хүн болон байгууллага хандив өргөж болно. Хувийн

бизнесийн байгууллагаас хандив авахийг хуулиар хориглодоггүй ч 1970 онд намуудын удирдагч нар эл төрлийн орлогыг авахгүй байхаар тохиролцсон .

Шведийн Социал-Демократ Намын Хууль буюу дүрэм /The Constitution of the Swedish Social Democratic Party/

БҮТЭЦ

- Намын удирдах дээд байгууллага нь намын Конгресс (Party Congress) байна. 350 гишүүнтэй.
- Намын орон нутгийн байгууллагын удирдах дээд байгууллага нь Үндэсний хурал (National Conference) 120 гишүүнтэй.

НАМЫН ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ

- гишүүний татвар
- улсын төсвийн санхүүжилт
- хонжворт сугалаа
- хандив

АВИЛГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ТАЛААР

Намын санхүүжилтийг хянах Аудитийг Намын орон нутгийн байгууллагын удирдах дээд байгууллагын дэргэд болон бусад бүх салбар нэгжийн дэргэд байгуулна.

Эх сурвалж:

- <http://www.legislationline.org>
- www.socialdemokraterna.se
- www.lexadin.nl
- <http://acerproject.gov>
- <http://www.riksdagen.se>

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

ХБНГУ-ын “Улс төрийн намын тухай хууль” Political Parties Act (Parteiengesetz, ParteienG) нь 1967 онд батлагдсан бөгөөд нэмэлт өөрчлөлт орон хэрэгжиж байна.

Нэг. Намын хөрөнгө, санхүүжилт

18 дугаар зүйл. Төрөөс үзүүлэх санхүүжилтийн зарчим, хүрээ

- 18.1. Төрөөс Үндсэн хуульд заасны дагуу намуудын ерөнхий үйл ажиллагааг хэсэгчлэн санхүүжүүлнэ. Төрийн сангаас санхүүжилт хуваарилах нь намуудын Европын холбоо, Парламент, Орон нутгийн сонгуульд оролцсон байдал түүний гишүүдээс өгсөн хандивийг хамаарч хуваарилна.
- 18.2. Бүх намд хуваарилах санхүүжилтийн жилийн дээд хэмжээ нь 230 сая дойч марк байна.
- 18.3. Намууд жил бүр намын нэрээр хүчинтэй санал бүрт 1 дойч марк байна. Нам тарсан эсхүл үйл ажиллагааг нь хориглосон бол Төрийн сангаас санхүүжилт авахгүй.

23 дугаар зүйл. Санхүүжилт

- 23.2. Жил бүрийн 9 дүгээр сарын 30-нд Германы Бундестаг нь Ерөнхийлөгчид

санхүүгийн тайланг гаргана. Үүнийг нь Бундестаг хэвлэнэ.

24 дүгээр зүйл. Орлого, зарлагын тайлан

24.2. Орлого нь:

1. Гишүүдийн хураамж хандив
2. Хувь хүмүүсээс өгсөн хандив
3. Хуулийн этгээдээс өгсөн хандив
4. Хөрөнгөөс олсон орлого
5. Зохион байгуулалтын үйл ажиллагаанаас олсон орлого, хэвлэсэн материал
6. Төрийн сан
7. Салбар байгууллагаас олсон орлого
8. Бусад орлого зэргээс бүрдэнэ.

24.3. Зарлага нь :

1. Албан хаагчдын зардал
2. Өдөр тутмын үйл ажилгааны зардал
3. Намын үндсэн ажил
4. Сонгууль
5. Салбарт хуваарилсан мөнгө
6. Бусад зардал зэрэг байна.

Хоёр. Намын бүтэц

7 дугаар зүйл. Намын зохион байгуулалт

Нам нь орон нутгийн байгууллагад хуваагдана

8 дугаар зүйл. Байгууллага

Гишүүдийн хурал, гүйцэтгэх зөвлөл нь үндсэн байгууллага байна. 2 жилийн хугацаатайгаар сонгогдоно. Гишүүдийн хурлыг төлөөлөгчдийн хурлаар солих асуудлыг намын дүрэмд зааж өгж болно.

9 дүгээр зүйл. Гишүүдийн болон төлөөлөгчдийн хурал

Гишүүдийн болон төлөөлөгчдийн хурал нь тухайн орон нутаг дахь намын дээд байгууллага байна.

11 дугаар зүйл. Гүйцэтгэх зөвлөл

Гүйцэтгэх зөвлөл нь 2 жил тутам сонгогдох бөгөөд доод тал нь 3 аас доошгүй гишүүнтэй байна.

12 дугаар зүйл. Удирдах зөвлөл

Удирдах зөвлөл нь намын бодлогын асуудлаар хэлэлцэх эрхтэй бөгөөд бүрэн эрх нь 2 жил байна.

14 дүгээр зүйл. Намын арбитр

Намын арбитр нь намын дүрмийг тайлбарлах, хэрэгжүүлэх асуудлаар гишүүд болон орон нутгийн байгууллагын дотоод арбитр байгуулна. 4 жилээс дээшгүй хугацаагаар сонгоно. Гүйцэтгэх зөвлөл болон орон нутгийн төлөөлөгчдийн байгууллага, намын аппаратыг

ажилтан байж болохгүй.

Гурав. Гишүүнчлэл

10 дугаар зүйл. Гишүүний эрх

10.1 Шинээр гишүүн элсүүлэх асуудал түр болон бүүр хориглох эрх байхгүй. Гишүүнээр элсэх өргөдөлд татгалзсан хариу өгөхдөө тайлбар гаргах албагүй. Шүүхийн шийдвэрээр сонгох, сонгогдох эрх нь хасагдсан иргэд намын гишүүн байж болохгүй.

10.2 Хуулиар намын гишүүд, төлөөлөгчид санал өгөх ижил эрхтэй боловч намын дүрмээр гишүүний хандиваас шалтгаалан саналын эрхтэй болохоор зааж болно.

Дөрөв.Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаархи зүйл заалт

25 дугаар зүйл. Хандив

Улс төрийн намууд дараахи тохиолдолоос бусад хандив авах эрхтэй.

1. Улс төрийн сан болон Парламентын бүлэг
2. Хуулийн этгээд болон хувь хүмүүс нь шашны болон хүмүүнлэг, ашгийн бус зорилгоор үйл ажилгаа эрхэлдэг
3. Мэргэжлийн холбоод
4. Хандивлагч нарын нэр нь тодорхой бус эсхүл хувь хүнээс 1000 дойч марк
5. Жилд 20000 дойч марк илүү хэмжээний хандивийн нэр, хаяг хандивийн хэмжээ <http://www.iuscomp.org/gla/statutes/ParteienG.htm>

ЯПОН УЛС

Япон Улсын “Улс төрийн намын санхүүжилтын тухай хууль” нь 1996 онд батлагдсан бөгөөд нэмэлт өөрчлөлтөөр хэрэгжиж байна.

Намын санхүүжилт, хандив

15.1. Намын орлого, зарлагын тайланг тухайн жилийн тухайн намын авсан санхүүжилт, зарлагыг ил тод байлгах, намын санхүү нээлттэй болгох үүднээс хэвлэх ёстой.

15.2. Иргэн жилд нэг удаа 50.000 иен хандив өгөх эрхтэй.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Улс төрийн гол намууд

АНУ-д үндсэндээ үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалсан Бүгд Найрамдах Нам /1854 онд байгуулагдсан/, Ардчилсан Нам /1828 онд байгуулагдсан/ хэмээх хоёр намын систем тогтож, засгийн эрхийг ээлж дараалан барьсаар ирэв. Эдгээр намын үзэл баримтлалд зарчмын ялгаа үгүй боловч БНН хувийн эдийн засагт төрийн оролцоог аль болохоор хязгаарлах чиг шугам баримтлаж байхад АН нь засгийн газар хувийн эдийн засгийг тодорхой хэмжээгээр удирдан зохицуулж, хүн амын нийгмийн асуудалд анхаарах ёстой гэж үздэг байна.

Энэ хоёр намаас гадна Шинэчлэлийн нам, Ногооны болон Социал демократ гэх зэрэг улс төрийн 21 нам байдаг. Тэдгээр намууд улс орны хэмжээнд улс төрийн нөлөө байхгүй ч зарим муж, хотуудад хүчтэй байр суурьтай байдаг.

БҮТЭЦ

АНУ-д улс төрийн намын институцийн тухай ямар нэг баримт бичиг байдаггүй ажээ. Ардчилсан намын одоогийн дүрэм 1974 онд батлагдсан. Удирдах дээд байгууллага нь Ерөнхийлөгчийн сонгуулийн жилд хуралддаг Намын Үндэсний Их хурал. Намын Үндэсний хороо нь хоёр Үндэсний Их хурлын хооронд намын үйл ажиллагааг удирдлагаар хангадаг бөгөөд бүх мужаас сонгогдсон төлөөлөгчдөөс бүрддэг. Муж бүрт намын байгууллагатай. Намын албан ёсны тэргүүн нь тус намаас нэр дэвшин сонгогдсон улсын Ерөнхийлөгч, эсвэл сүүлчийн Үндэсний Их хурлаас улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч байдаг.

ГИШҮҮНЧЛЭЛ

Гишүүнчлэл байхгүй, дэмжигчид дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг. Сонгогчдын 40 орчим хувь нь Ардчилсан намын, 23 хувь нь Бүгд найрамдахчуудын дэмжигчид байдаг.

САНХҮҮЖИЛТ

Холбооны Сонгуулийн компани тухай хууль:\1971\ 9033 дугаар заалт

9037 дугаар зүйлд заасан төлбөр авах болзол хангахын тулд Хороонд /Улс төрийн намуудын Хороо/ тусгай компани ажилтай холбоотой холбогдох нотлох баримтыг гаргаж өгөх, хорооноос шаардсан ямар ч тэмдэглэл, ном, бусад мэдээллийг гаргаж өгөх, Хорооны санхүүгийн хяналт шалгалтад хамрагдахаа бичгээр илэрхийлнэ. 9037 дугаар зүйлд заасан төлбөр авах болзлыг хангахын тулд 9035 аар тогтоосон хязгаарыг давсан тусгай компани ажил явуулахгүй байх, нэр дэвшигч нь АНУ-ыг Ерөнхийлөгчийн сонгуульд намаасаа нэр дэвших гэж байгаа, нэр дэвшигч 5000 доллараас илүү хандив авсан, дор хяаж 20 муж улсын оршин суугчдаас хандив өгсөн байх, нэг хүний өгсөн хандив нь 250 доллараас илүүгүй байх. Нэр дэвшигч дээр дурдсан мэдээллийг өгснөөс хойш 10 хоногийн дотор Хорооноос гэрчилгээ өгнө.

1-9038 дугаар заалтууд

Сонгуульд зориулсан тусгай сангийн зарцуулалтыг Нарийн бичгийн дарга хариуцах бөгөөд дээр дурдсан гэрчилгээ бүхий аль намын нэр дэвшигчдэд тэгш хуваарилах зарчим баримтална. Том намын /хувьд 4 сая доллар хүртэл, жижиг намуудын хувьд том намуудын авсан саналтай хувиас дээш санал авсан/ жижиг намын хувьд 5-25 хувийн санал авсан/ авсан саналд хувь тэнцүүлэн санхүүжилт олгоно.

527 дугаар зүйл

Улс төрийн нам нь хүү, хувьцааны ашиг, түрээс зэрэг орлого олж болох бөгөөд үүнийг цэвэр хөрөнгө оруулалтын орлого гэх ба татвараас чөлөөлөгдөхгүй.



**ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА БА ПАРЛАМЕНТЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ
ОНЦЛОГ /ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЖИШИГ ХАНДЛАГА (Харьцуулсан судалгаа)**

Ц. Норовдондог (Ph.D), Ц. Болормаа, Д. Мягмарцэрэн, О. Нарантуяа

Хууль тогтоох байгууллага ба парламентын сэтгүүл зүйн харилцааны онцлог**Парламентын сэтгүүл зүй, түүний онцлог**

Нээлттэй, ардчилсан нийгэмд ард түмэн өөрийнхөө төлөөлж сонгосон хууль тогтоох байгууллагын талаар мэдээлэл олж авах, хууль тогтоогчдын үйл ажиллагаанд итгэлтэй байх, өөрсдийнхөө санаа бодлыг бодлого, шийдвэрт тусгуулах, нөгөө талаас ард түмний төлөөлөл болж сонгогдсон парламентын гишүүд, парламентад суудалтай намууд парламентаар батлан гаргаж байгаа хууль тогтоомж, хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийнхээ талаар олон нийтэд үнэн бодитой, мэдээлэл хүргэх, үйл ажиллагаагаа тайлбарлан таниулах хүсэл сонирхолтой байдаг. Энэхүү 2 талын сонирхолыг холбогч гүүр нь – Хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл буюу парламентын сэтгүүлчид юм.

Гэвч парламентын сэтгүүл зүйд хэвлэл мэдээллийн нийтлэг үйл ажиллагаанаас ялгарах онцлог бий. Парламентын сэтгүүл зүйн гол асуудал нь парламент ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтэд хандсан мэдээллийн үйл ажиллагаа явуулахдаа хэрхэн зохистой түвшинд үр ашигтай харилцах вэ? гэдэг асуудал юм. Парламент ба хэвлэл мэдээллийн харилцааны эцсийн үр дүнд олон нийт парламентын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, итгэл үнэмшилтэй болсоноор аливаа хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хуулийг сахин биелүүлэх үүргээ ухамсарлах, нөгөө талаас гишүүд хууль тогтоох, төлөөлөх үйл ажиллагаандаа ард түмнээр дүн тавиулах явдал юм. Өөрөөр хэлбэл парламентын хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа нь ард түмэн парламентад хяналтаа хэрэгжүүлэх нэг чухал хэрэгсэл болдог байна.

Нэг талаас парламентын мэдээллийг олон нийтэд түгээх үйл ажиллагаа нь тодорхой хэм хэмжээнд зохицуулалттайгаар явагдах ёстой, нөгөө талаас хүний эрх, мэдээллийн эрх, эрх чөлөөг хангасан байх шаардлагатай. Сайн засаглал бүхий, мэдээлэлтэй ардчилсан нийгмийг байгуулахын тулд парламентын мэдээллийг хэрхэн зөв, үр ашигтай түгээх талаар олон улс, бүс нутгийн хэмжээний олон улсын байгууллагууд анхаарч парламентын сэтгүүлчдийн мөрдөх хэм хэмжээг тогтоох, нэгдсэн стандартыг бий болгох талаар санаачлагатай ажиллаж байна.

Хамтын нөхөрлөлийн орнуудын Парламентын нийгэмлэг, Олон улсын сэтгүүлчдийн болон Хэвлэл мэдээллийн холбоодууд энэ талаар тодорхой судалгаа хийж, санал зөвлөмж гаргасан байдаг. Энэхүү илтгэлийг бэлтгэх явцдаа дэлхийн 10 гаруй орны туршлагыг харьцуулан судалж, холбогдох олон улсын мэргэжлийн байгууллагуудын санал зөвлөмжүүдтэй танилцаж нийтлэг жишиг, чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон болно.

Эрх зүйн зохицуулалт

Парламентын мэдээллийг олон нийтэд хүргэх харилцаа нь улс орнуудын парламентаас батлан гаргасан хууль, Парламентын хуралдааны дэг болон Тамгын газрын үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журмуудаар зохицуулагддаг байна. Тухайлбал: **АНУ-д** “112 дугаар Конгрессийн дүрэм”-д нийцүүлэн гаргасан “Конгрессийн хуралдааныг цацах, нэвтрүүлэх дүрэм”, **Австралид** Хуралдааны дэг – /Standing and Sessional Orders 2010/, Парламентын хуралдааныг телевизээр нэвтрүүлэх тухай хууль /1946/ -Parliamentary Proceedings Broadcasting Act /1946/ , Парламентын үйлчилгээний тухай хууль /Parliamentary service act 1999он/ **БН Солонгос Улсад** Үндэсний Ассамблейн тухай хууль ,Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай хууль , Үндэсний Ассамблейн Тамгын газрын дүрэм,

Судалгааны эмхтгэл, Х боть

Үндэсний Ассамблейн мэдээ, мэдээлэл нэвтрүүлэх журам, Үндэсний Ассамблейгаас шууд нэвтрүүлэг дамжуулах журам, Үндэсний Ассамблейн хуралдаанд оролцох журам, **БН Франц Улсад** Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны журам гэх мэтийн эрх зүйн актуудаар зохицуулжээ.

Парламентын мэдээллийн орчин

Нууцад хамаарах болон хуулиар хязгаарласнаас бусад парламентын бүх төрлийн мэдээ, мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаг нь олон улсад нийтлэг жишиг юм. Парламентын мэдээллийг үндсэнд нь 2 хувааж болно. Үүнд:

Олон нийтэд нээлттэй мэдээлэл:

- Парламентын сурвалжлагчид нь хуулиар тогтоосон нууцад хамаарахгүй бүх төрлийн мэдээ мэдээллийг сурвалжлах эрхтэй.
- Чуулган болон хороодын хуралдааны хэлэлцэж буй асуудлуудтай танилцах
- Хэвлэлийн, видео болон бусад төрлийн хурлуудад оролцох
- Парламентаас гаргасан баримт бичгүүдтэй танилцах

Хязгаарлагдмал мэдээлэл:

Хязгаарлагдмал мэдээлэл гэдэг нь улс орны аюулгүй байдал, стратегийн бодлогод хамаарах асуудлууд болон нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий бодлого шийдвэрийг хэлэлцэх явцад бий болсон улсын нууцтай холбоотой мэдээллүүд юм. Мөн асуудлыг улс төржүүлэх болон бусад популист хандлагад автуулахгүйн тулд парламентын зарим мэдээллийг хязгаарлах явдал байдаг байна. Тухайлбал:

- Албан ёсны, баталгаатай мэдээлэл хүргэх үүднээс зарим улсад гадаад бодлого, хууль эрх зүй, төсөв санхүүгийн бодлого хариуцсан Байнгын хороодын мэдээллийг Тамгын газраас нь бэлтгэж сурвалжлагчдад тараадаг.
- Батлан хамгаалах болон Шинжлэх ухаан технологийн бодлого хариуцсан байнгын хороодын мэдээллийг Тамгын газар өөрийн хэлтэс албадаар дамжуулж олон нийтэд түгээнэ. /Франц улсын Парламентын Хуралдааны дэгээр зохицуулдаг /
- Тухайн асуудлаар зарчмын өөр байр суурьтай, маргаантай байгаа тохиолдолд чуулган, байнгын хороодын хуралдааныг хаалттай хэлэлцдэг. /Австрали улсад Хуралдааны дэгийн 8-р бүлгийн “Хаалттай хэлэлцэх асуудлууд”-ын 78-р зүйл/

Парламентын хуралдааны хэлбэр

Бусад орнуудын хувьд **Чуулганы** хуралдааныг **олон нийтэд нээлттэй хэлбэрээр явуулах** боловч зарим тохиолдолд **Байнгын хороодын** хуралдааныг **хаалттай** болон **нээлттэй бус** байдлаар явуулдаг жишиг байдаг. (Франц, Герман, Шинэ Зеланд, Турк, Австрали гэх мэт)

Хаалттай хуралдаан:

Үндэсний аюулгүй байдал, стратегийн бодлогод хамаарах асуудлууд, мөн нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий бодлого шийдвэрийг хэлэлцэх явцад улсын нууцтай холбоотойгоор Батлан хамгаалах, Гадаад бодлого болон Шинжлэх ухаан технологийн гэх мэтийн Байнгын хороодын хуралдааныг хаалттай явуулж болдог.

Нээлттэй бус хуралдаан:

Нээлттэй бус гэдэг нь нууц гэсэн үг биш юм. Харин уг хуралдаанаар хэлэлцэж буй асуудлыг ажил хэрэгчээр хэлэлцэхийн тулд хүссэн хүн бүрийг оролцуулах боломжгүй



гэсэн үг. Нээлттэй бус хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тухай уг хуралдаанд оролцсон гишүүд гуравдахь этгээдэд, тухайлбал, хэвлэл мэдээллийн байгууллага болон холбогдох хүрээний хүмүүст мэдээлэхийг хориглодоггүй. Өөрөөр хэлбэл хуралдааны тэмдэглэл, гарсан шийдвэр нь нээлттэй, гагцхүү хэлэлцүүлгийн явцыг мэдээлэх шаардлагагүй гэж үздэг байна.

Гэвч онолын хувьд энэ тал дээр өнөөг хүртэл маргаантай байдаг. Хуралдааныг нээлттэй бус явуулах нь мэтгэлцээнийг чөлөөтэй өрнүүлж, үүний үр дүнд нэгдсэн нэг ойлголтонд хүрэх арга гэж үздэг ч нөгөө талаас Байнгын хороод бүх асуудлыг нууц байдлаар ямар ч хяналтгүй хэлэлцэж шийдвэрлэх боломжтой байна гэсэн шүүмжлэл гардаг. Байнгын хороон дээр асуудлыг нээлттэй бусаар хэлэлцлээ ч гэсэн

Чуулганы хуралдаан нээлттэй байдаг тул парламентад суудалтай улс төрийн хүчнүүд намын бүлэг болон Байнгын хороодын хуралдаан дээр нээлттэй бус байдлаар шийдсэн зүйлүүдээ олон нийтийн өмнө тайлбарлах, үндэслэлээ хамгаалах, яагаад төслийг дэмжсэн эсвэл эсрэг санал өгсөнөө тайлбарлах боломжийг олгодог байна. Тухайлбал, зарим орнууд Байнгын хороодын хуралдааны нээлттэй байдлыг хязгаарлах талаар дараахь зохицуулалтыг хийжээ. Үүнд:

Япон Улсын Танхимын Дэгийн Тухай Дүрэм

140 дүгээр зүйл. Санал хураалт явагдаж байх хугацаанд бүх нэвтрэн орох танхимын хаалгыг хаана.

160 дугаар зүйл. Хуралдааны тэмдэглэлийг гишүүд болон олон нийтэд түгээнэ.

Оросын Холбооны Улсын Төрийн Думын Регламент

39 дүгээр зүйл. Төрийн Думын хаалттайгаас бусад хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг хэвлэн нийтлэнэ.

Францын Үндэсний Ассамблейн Хуралдааны Дэг

59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. Нээлттэй бус хэлэлцэх асуудлыг тодорхойлж, бүрэн тайлбарыг албан ёсны сэтгүүлд нийтлэнэ.

ХБНГУ-ын Бундестагийн Дэгийн тухай хууль

69 дүгээр зүйл. Хороо нь хуулиар хаалттай хуралдах ёстой.

Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын Дэгийн тухай хууль

235 дугаар зүйл. Сонсголоос бусад тохиолдолд хороо нь хаалттай хуралдах ба Төлөөлөгчдийн танхимд хурлын дүнг илтгэх хүртэл мэдээлэл нууц байна.


238 дугаар зүйл. Хуралдаан даргалагч олон нийтэд тухайн асуудлаар мэдэгдэл хийж болно.

Турк улсын Үндэсний Их Хуралд хэвлэл мэдээлэлийн төлөөлөгчдийн ажиллах журам

14 дугаар зүйл. Парламентын сурвалжлагч нь нэгдсэн хуралдааныг, зөвшөөрсөн тохиолдолд хороо болон намын бүлгүүдийн хуралдааныг өөрсдөд нь тусгайлан бэлдсэн хэсгээс ажиглаж болно.

Австралийн Хуралдааны Дэг

Австрали улсын хувьд Байнгын хорооны хуралдааныг нээлттэй явуулах боловч шаардла-



Судалгааны эмхтгэл, Х боть

гатай тохиолдолд хаалттай явуулах журамтай. Австралийн Парламентын дээд, доод танхим нь Байнгын, Дэд, Тусгай, Хамтарсан, Сонгогдсон болон Үндсэн хороо /Main committee/ бүхий өвөрмөц бүтэцтэй тул нарийвчилсан журмаар зохицуулсан байдаг. Тухайлбал: “**Standing and Sessional Orders**” хэмээх баримт бичигт зааснаар:

- Тодорхой сэдвээр яаралтай хэлэлцүүлэх асуудал (тус дэгийн 81-т)
- Гишүүний бүрэн эрхийг түдгэдзүүлэх, сунгах тохиолдолд (тус дэгийн 1-т)
- Үндсэн хорооноос хуулийн төсөлтэй холбогдуулан илтгэл-тайлан хэлэлцүүлэхээр санал гаргасан тохиолдолд (дэгийн 153-т)
- Гишүүн бусдад ямар нэгэн байдлаар нөлөө үзүүлэх тохиолдолд (тус дэгийн 65-т)

гэх мэт асуудлуудыг нээлттэй бус хэлэлцэхээр заасан байна.

Байнгын хорооны хаалттай хуралдаанаар хэлэлцсэн асуудлын 2-р хэлэлцүүлгийг **Main Committee** буюу **Үндсэн хороо** явуулах бөгөөд хуулийн төслийг зүйл заалт бүрээр нь нарийвчлан хэлэлцэж, ажил хэрэгч санал шүүмж энэ хорооны хуралдаан дээр өрнөдөг байна.

Парламентын мэдээллийг түгээх стратеги

Парламентаас мэдээллийг ил тод байлгах стратегийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална. Үүнд:

Стратеги 1:

Парламентэд хэлэлцэгдэж буй асуудлыг улс төржихгүй, гуравдагч этгээдийн санаа бодлыг оруулалгүйгээр иргэдэд шууд дамжуулах, танилцуулах.

Стратеги 2: Парламентийн үйл ажиллагаа олон нийтэд шууд бодитоор хүрэх.

Туршлагаас үзэхэд, хэвлэл мэдээллийн аливаа хэрэгсэлүүд ихэвчлэн хоёр намын хоорондын болон Засгийн газар болон цөөнхийн хоорондох маргаантай асуудлыг улс төрийн тэмцлийн үүднээс харуулах сонирхолтой байдаг. Иймээс бусад орнуудад Тамгын газар нь Байнгын хороод болон Чуулганы хуралдааныг шууд дамжуулах, улс орон, ард түмний эрх ашгийг хөндсөн асуудлаар гишүүд, бүлгийн байр суурийг илэрхийлэх зохион байгуулах гол үүргийг өөртөө авдаг байна.

Парламентын мэдээллийг олон нийтэл ил тод нээлттэй байлгахын ач холбогдол нь ард түмэн өөрсдийн сонгосон Парламент болон тэдний хууль батлах процесст итгэлтэй байх, Парламентаас батлан гаргасан аливаа хуулийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөхөд эерэг нөлөөтэй, нөгөө талаас Парламентаас алдаатай бодлого, шийдвэр гарах хандлагатай тохиолдолд олон нийтийн зүгээс санал, шүүмжлэл өрнүүлж урьдчилан сэргийлэх, хяналтаа хэрэгжүүлэхэд оршдог байна.

Парламентын сэтгүүлчдэд хориглох зүйл

- Парламентын мэдээллийг /чуулган, хуралдаан/ аль нэг намын улс төрийн кампанит ажлын материал болгон ашиглах,
- Төрийн сонгуульд албанд нэр дэвшсэн аливаа намын нэр дэвшигчийг дэмжих эсвэл эсэргүүцэх хэлбэрээр ашиглах,
- Хуралдааны дүрс болон дуу бичлэгийн утга агуулгыг алдагдуулах, мушгин гуйвуулах,
- Парламент, түүний хороод, гишүүн, төлөөлөгчдийн нэр хүндэд халдах,
- Ёжлол, шоглол, доог тохуу, худалдааны реклам зэрэг хэлбэрээр ашиглах

Парламентын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим

1954 онд Олон улсын сэтгүүлчдийн холбооны Дэлхийн Конгрессоос Сэтгүүлчдийн ёс зүйн кодексийг батлан гаргасан. 1986 онд шинэчлэн засварласан. Энэхүү дүрмээр сэтгүүлчдийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн стандарт гаргасан байдаг. Үүнд:

- Үнэнч, шударга байдлыг дээдлэх, олон нийтэд үнэнийг мэдүүлэх,
- Сэтгүүл зүйн эрх чөлөөт зарчмыг баримтлахдаа мэдээг ямагт үнэн зөвөөр цуглуулж, нийтэлж, үнэн зөв тайлбар, шүүмж өгөх,
- Мэдээллийн эх сурвалжийг нь мэдэх, баримтыг сурвалжлах ёстой бөгөөд гол мэдээллийг өөрчилж нэмэх, эсвэл зохиож бичихийг хориглоно,
- Аливаа мэдээллийг зөвхөн шударга, зөв замаар олох ёстой.

Парламентын сэтгүүлчдэд тавигдах шаардлага

Ерөнхий шаардлага:

Парламентын мэдээллийг олон нийтэд зөвхөн шударга, үнэн зөвөөр хүргэх.

Тусгай шаардлага:

- Тогтмол байнгын буюу өдөр тутмын мэдээллийн үйл ажиллагаатай,
- Магадлан итгэмжлэгдсэн,
- Нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий,
- Харьцангуй олон нийтэд мэдээллээ хүргэх боломжтой Телевиз, Радио, Хэвлэлийн байгууллагад Парламентын мэдээллийг олон нийтэд хүргэх эрх олгоно.

Парламентын Хэвлэл мэдээллийн албанаас сэтгүүлчидтэй харилцах

Парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрх олгох:

Хүссэн бүхэнд парламентыг сурвалжлах боломж олгодоггүй. Тодорхой шалгуурт нийцэх хэвлэл мэдээллийн **байгууллагад** Парламентын үйл ажиллагааг тодорхой хугацаатай буюу хугацаагүйгээр сурвалжлах эрх олгодог. Тухайлбал, хөрөнгө санхүүгийн хангалттай хэмжээний нөөц бололцоотой, мэдээллийн өргөн сүлжээ бүхий, нийгэмд тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй, талуудын байр суурийг тэнцвэртэйгээр илэрхийлж чадах хараат бус байх зэрэг гол шалгуурууд тавьдаг.

Магадлан итгэмжлэх:

Парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрх бүхий хэвлэл мэдээллийн байгууллагаас ирүүлсэн сурвалжлагчийг ажил үүргээ гүйцэтгэх явцад нь тодорхой хугацаанд үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх байдлаар магадлан итгэмжилж, сурвалжлах эрхийг нь сунгах эсэх асуудлыг шийддэг. Хэрэв хэлэлцэж буй асуудал болон гаргасан шийдвэрийн гол агуулгыг авч үзэлгүйгээр мэдээ мэдээллийн үнэн бодит байдлыг гуйвуулах, мушгих, талуудын санал бодлыг тэнцвэртэйгээр тусгахгүй байх, мэдээлэл түгээлтийн хамрах хүрээ багасах, гишүүдийг гүтгэх, доромжлох зэрэг бусад асуудлуудаар сөрөг үнэлэлт авсан тохиолдолд сурвалжлах эрхийг нь түдгэлзүүлэх буюу хязгаарлаж, тогтоосон шалгуурт нийцүүлэхийг шаардах ба шаардлагатай бол Хэвлэлийн албанаас сургалт зохион байгуулдаг. Хэрэв шаардлага хангахгүй тохиолдолд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын парламентыг сурвалжлах эрхийг нь хүчингүй болгоно.

Сэтгүүлчдэд мэдээлэл бэлтгэж өгөх:

Албан ёсны, баталгаатай мэдээлэл хүргэх, сурвалжлагчдын ажлыг хөнгөвчлөх үүднээс Хэвлэлийн алба нь хэвлэмэл болон дижитал хэлбэрээр мэдээ мэдээлэл, баримт бичгийг шууд болон шууд бус тойм хэлбэрээр бэлтгэн өгдөг. Хэрэв Хэвлэлийн албанаас өгсөн

Судалгааны эмхтгэл, Х боть

мэдээлэл нь хангалттай биш бол ямар мэдээлэл хүсч байгаагаа нарийвчлан тодорхойлж өгдөг. Хууль, журмаар нууцын зэрэглэлтэй гэж заагаагүй бол энэ хүсэлтийн дагуу байгаа холбогдох мэдээллийг нь бүрэн гаргаж өгнө. Хэрэв энэ хүсэлтээс нь тодорхой шалтгаангүйгээр татгалзах тохиолдолд сэтгүүлчид Тамгын газрын даргад гомдлоо гаргана.

Мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлэх:

- Итгэмжлэгдсэн бүх сурвалжлагч, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг хуралдаанд шууд нэвтрэх боломжоор хангах
- Гишүүдтэй уулзалтын цаг товлох зэргээр үйл ажиллагааны ерөнхий нөхцлийг бүрдүүлэх
- Ажиллах орчныг бүрдүүлсэн өрөө тасалгаа гаргаж өгөх зэрэг асуудлыг шийдвэрлэдэг.

Парламентын мэдээллийг олон нийтэд хүргэх аргууд

- Парламент, түүний хороодын хуралдааныг орон даяар радио телевизээр шууд нэвтрүүлэх,
- Парламентын албан ёсны вэб сайтаар дэлхий даяар дамжуулах,
- Парламентын мэдээллийг хэвлэлээр нийтлэх,
- Батлагдсан хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх,
- Парламентын Тамгын газраас улирал тутмын сэдэвчилсэн сэтгүүл гаргах,
- Хэлэлцэгдэж буй асуудлаар Тамгын газраас сэдэвчилсэн нэвтрүүлэг бэлдэх, цацах, DVD форматаар түгээх,
- Хэлэлцэгдэж буй асуудлаар хэвлэлийн бага хурал хийх,
- Зарчмын зөрүүтэй асуудлаар гишүүдийн байр суурийг илтгэсэн ярилцлага бэлдэх, нэвтрүүлэх

Вэб хуудсаар шууд дамжуулах:

- Улс төр, нийгэм, эдийн засгийн болон бусад тулгамдсан асуудлаар Парламентын гишүүдийн байр суурийг илэрхийлсэн баримтат болон уран сайхны нэвтрүүлэг бэлдэж вэб хуудас болон телевиз радиогоор нэвтрүүлэх,
- Улирал тутам хэлэлцэгдэж буй, анхаарал татсан, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий хуулийг олон нийтэд таниулах зорилгоор сэдэвчилсэн сэтгүүл гаргах бөгөөд тухайн сэтгүүлээр тусгайлан телевизийн нэвтрүүлэг бэлдэж DVD форматад оруулан архивлан хадгалах
- Улирал тутмын сэтгүүл , fact sheet гаргах

Орон даяар радио телевизээр шууд дамжуулах:

Сенат, Төлөөлөгчдийн танхим болон бүх байнгын хороодын хуралдаан, хэлэлцүүлэг, санал шүүмж, асуулгын цагийг орон даяар шууд дамжуулах үүргийг Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын Радио нэвтрүүлгийн хэлтэс гүйцэтгэх буюу эсвэл тухайн орны Үндэсний телевизэд дамжуулан эрх бүхий телевизийн сувгуудаар цацах

Парламентын мэдээллийг олон нийтэд хүргэх зохион байгуулалтын хэлбэр

АНУ -ын Конгрессын ажлын албанд:

Радио-телевизийн сурвалжлагчдийн галларей- Radio-Television Correspondents Gallery
Өдөр тутмын хэвлэлийн галларей- Daily Press Gallery
Тогтмол хэвлэлийн галларей - Periodical Press Gallery гэсэн нэгжүүд байдаг.

Радио-телевизийн сурвалжлагчдийн галларей: Конгрессийн Радио Телевизийн Сурвалжлагчдын Галерейгээс итгэмжлэгдсэн бүх телевиз, радио станц, хэвлэл мэдээллийн сүлжээ, каблийн телевизийн систем болон итгэмжлэгдсэн бүх сурвалжлагч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад хуралдаанд шууд нэвтрэх боломжийг тус галларей хангах үүрэг хүлээн ажиллана.

Өдөр тутмын болон тогтмол хэвлэлийн галерей: Тус галларейн ажилчид нь хэвлэл болон Конгрессийн гишүүдийг дараах үйлчилгээгээр хангах, Гишүүд болон сурвалжлагчдыг холбох ерөнхий нөхцлийг бүрдүүлэх, Конгрессийн болон Хороодын хуралдааны үйл ажиллагаа, Конгрессийн ажилтнуудын тавьсан асуулт лавлагаа зэрэгт хариулах үүрэгтэй. Тус галларейн ажилтнууд нь Конгрессийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой минут тутам шинэчлэгдэх бүртгэлийн болон мэдээллийн архивтай байна. Ажилтан нь хэвлэлийн мэдэгдэл/ fact sheet/гаргаж, хорооны мэдээлэл, зарлалыг галлерейд тавина. Мөн гишүүдийн хийсэн мэдэгдлийг томоохон хэвлэл мэдээллийн агентлагуудад хүргэнэ. Галлерей нь байнгын хороодын ажилтнуудтай хамтран сурвалжлагч, нэвтрүүлэгчдийг ажлаа саадгүй хийхэд нь туслах, шаардлагатай бүх нөхцлийг хангана. Хорооны хуралдааныг нэвтрүүлж буй сурвалжлагч, нэвтрүүлэгчдэд мэдээлэл түгээх өргөн боломж олгох, гишүүдийн мэдээллийн хуулбараар хангах, томоохон хэвлэл мэдээллийн агентлагуудад хуралдааны өдөр тутмын хөтөлбөрийг тараах зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

Австрали улсын Төлөөлөлөгчдийн танхимын Тамгын газарт:

Олон нийттэй харилцах хэлтэс

Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс

Радио нэвтрүүлгийн хэлтэс байна.

Олон нийттэй харилцах хэлтэс: Олон нийттэй харилцах хэлтэс Парламентын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах үндсэн чиг үүрэгтэй. Иргэдийг Парламентын хоёр танхимын хуралдаан болон Question time асуулт хариултын цаг, Парламентын ордонтой танилцуулах, өсвөр насныхны боловсролд зориулсан парламентын үйл ажиллагааны хөтөлбөр болон парламентын түүхийг таниулах ажиллагааг хариуцан зохион байгуулдаг.

Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс: Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс нь Парламентын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах үндсэн чиг үүрэгтэй. Улирал тутам хэлэлцэгдэж буй, анхаарал татсан, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий хуулийг олон нийтэд таниулах зорилгоор сэдэвчилсэн сэтгүүл гаргах бөгөөд тухайн сэтгүүлээр тусгайлан телевизийн нэвтрүүлэг бэлдэж DVD форматад оруулан архивлан хадгалдаг байна.

Түүнчлэн Парламентын вэбсайтад тухайн хуультай холбоотой гишүүдийн байр суурь, ярилцлага, бэлдсэн нэвтрүүлгийг цаг тухайд нь байршуулах үүрэг хүлээн ажиллаж байна. Тус хэлтэс нь бие даасан сэтгүүл, нэвтрүүлэг бэлдэх ажлаа 10 жилийн өмнөөс эхлүүлсэн туршлагатай.

Радио нэвтрүүлгийн хэлтэс: Радио нэвтрүүлгийн хэлтэс нь **Сенат, Төлөөлөгчдийн танхим, бүх байнгын хороодын** хуралдаан, хэлэлцүүлэг, санал шүүмж, асуулгын цагийг орон даяар шууд дамжуулах үүргийг хүлээдэг хэлтэс юм. Уг хэлтэс нь бусад газар, хэлтэс, албадын нэгэн адил Парламентын ордонд байрлах бөгөөд 2 танхим бүхий телевизийн студи, хуралдааныг шууд дамжуулах удирдлагын өрөөнүүдтэй мэргэжлийн инженер, техникийн ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна. Уг шууд нэвтрүүлгүүд нь орон даяар телевизийн сувгаар, дэлхий даяар Парламентын вэбсайтаар цацагддаг байна.



Судалгааны эмхтгэл, Х боть

Польш улсын Сеймын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах товчоо Товчоо нь мэдээллийн сангийн, хэвлэл мэдээлэлтэй харилцах, Сеймтэй харилцах, мэдээлэл судалгааны гэх мэт чиг үүрэгтэй. Сеймын үйл ажиллагаа болон холбогдох бусад баримт бичгүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээхдээ өөрийн албан ёсны вэбсайтад (www.sejm.gov.pl) байрлуулах буюу сэтгүүлчдэд хүргэх хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Хэрэв товчооноос өгсөн мэдээлэл нь хангалттай бус тохиолдолд сэтгүүлчид ямар мэдээлэл хүсч байгаагаа нарийвчлан тодорхойлж өгдөг. Хууль буюу журамд өөрөөр заагаагүй бол энэ хүсэлтийн дагуу байгаа мэдээллийг нь гаргаж өгнө. Хэрэв энэ хүсэлтээс нь тодорхой шалтгаангүйгээр татгалзах тохиолдолд сэтгүүлчид Тамгын газрын даргад гомдлоо гаргана.

Франц улсын Үндэсний Ассамблейн Тамгын газрын Хэвлэл, Телевиз, Радиогийн алба Франц улсад Парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрх хүссэн байгууллагуудын чадвар чадамжийг харгалзан эрх олгодог. Өөрөөр хэлбэл, тогтмол байнгын буюу өдөр тутмын мэдээллийн үйл ажиллагаатай, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий буюу харьцангуй олон нийтэд мэдээллээ хүргэх боломжтой Телевиз, Радио, Хэвлэлийн байгууллагад эрх олгоно. Бие даасан сурвалжлагчдад эрх олгодоггүй.

Мөн Хэвлэлийн албаны өөр нэг үүрэг бол гадаадын сурвалжлагчдад хязгаарлагдмал хүрээнд Парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрх олгодог. Энэхүү эрхийг олгохдоо Гадаадын Хэвлэл мэдээллийн Холбоо юмуу, эсвэл Англи-Америкийн Хэвлэл мэдээллийн Холбоонд (Foreign Press Association or the Anglo-American Press Association) хүлээн зөвшөөрөгдсөн сурвалжлагчдад эрх олгоно. Гадаадын сурвалжлагчид энэхүү эрхийг хүсэхээсээ өмнө заавал тус улсын Гадаад Харилцааны Яамнаас магадлан итгэмжлэгдсэн байх ёстой байдаг.

Хэдийгээр парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг хугацаагүй олгодог боловч Хэвлэлийн албанаас жил бүр бүх сурвалжлагчдыг тодорхой шалгуураар магадлан итгэмжлэдэг. Тухайлбал, мэдээ мэдээллийг үнэн бодит байдал, талуудын санал бодлыг тэнцвэртэйгээр тусгаж буй эсэх, мэдээлэл хүргэж буй хүрээ гэх мэтийг харгалздаг. Хэвлэлийн алба нь парламентын өдөр тутмын үйл ажиллагаа болон холбогдох бусад баримт бичгүүд, албан ёсны мэдээллийг өөрийн албан ёсны вэбсайтад (www.assemblee-nationale.fr) байрлуулахаас гадна парламентын сурвалжлагчид эдгээр мэдээллүүдийг хүлээн авах бололцоогоор хангах үүрэгтэй.

Хэвлэлийн албаны нэг гол үүрэг бол хэвлэл мэдээллийн байгууллагуудад парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг олгоно. Парламентын сурвалжлагчдын үйл ажиллагааг түргэн шуурхай чирэгдэлгүй байлгахын тулд Үндэсний Ассамблейн ордонд (Palais Bourbon) тусгай өрөөнүүд гаргаж өгсөн. Үүнд:

- Ярилцлага авах өрөө
- Харилцаа холбооны өрөө
- Интернэт сүлжээ бүхий компьютерүүдийн өрөө
- Радио нэвтрүүлгийн өрөө

Солонгос улсын Үндэсний Ассамблейн Тамгын газарт

- Төлөвлөлт хариуцсан хэсэг
- Зохион байгуулалт хариуцсан хэсэг
- Шууд нэвтрүүлэг хариуцсан хэсэг

Үндэсний Ассамблей нь өөрийн телевиз нь Үндэсний Ассамблейн чуулган, Үндэсний Ассамблейн хэлэлцэж буй асуудлуудаас гол хуралдааныг редакторлаж, нэмж хасахгүйгээр эхээр нь дамжуулдаг. Мөн түүнчлэн төрөл бүрийн тайлан мэдээлэл, цаг үеийн байдал, хуулийн мэдээлэл, улс төрийн түүх, соёл, орон нутгийн талаархи нэвтрүүлгүүдийг бэлтгэж өглөөний 6 цагаас шөнийн 02 цаг хүртэл нэтрүүлдэг.

Сурвалжлагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч бэлтгэгч зэрэг Үндэсний Ассамблейн сэтгүүлчид нь Үндэсний Ассамблейн хуралдаанд оролцох зөвшөөрлийг Үндэсний Ассамблейн Тамгын газраас авна. Шаардлагатай тохиолдолд зөвшөөрөлгүй сэтгүүлчийг түр хугацаагаар оруулж болох бөгөөд энэ тохиолдолд Үндэсний Ассамблейн тамгын газрын даргаас зөвшөөрөл авна.

Үндэсний Ассамблейн сэтгүүлчид, сурвалжлагчид нь телевиз болон радиогоор шууд нэвтрүүлэг хийх тохиолдолд урьдчилан нэвтрүүлэгийн объект, хугацаа болон хэлбэрийн талаар Үндэсний Ассамблейн дарга болон дэд даргад хүсэлт гаргаж зөвшөөрөл авна.

Үндэсний Ассамблейн номын сан нь Үндэсний Ассамблейн гишүүд болон тамгын газар, хэвлэл мэдээлэл, судалгааны албыг мэдээ, мэдээлэлээр хангахаас гадна олон нийтэд нээлттэй үйлчилдэг. Цахим мэдээллийн сангаараа дамжуулан өргөн хэмжээний мэдээлэл дамжуулах боломжтой бөгөөд нутаг дэвсгэрийн хаанаас ч хандалт хийж мэдээлэл авах боломжтой.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь өөрийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтийн санал асуулга болон хуулийн төсөлд холбогдох саналыг авдаг.

Парламентын Хэвлэл мэдээллийн алба ба парламентын сэтгүүлчдийн мэдээлэл

Тамгын газрын хэвлэл мэдээллийн алба:

- Сэтгүүл зүйд “Хуурай мэдээлэл” гэгддэг албан ёсны мэдээ, мэдээлэл, тоо, баримт бүхий Парламентаас гаргасан шийдвэрийг олон нийтэд хүргэх үйл ажиллагааг явуулдаг.
- Асуудлыг хэлэлцэх үйл явцыг шууд букуу эсвэл тоймлон харуулах замаар олон нийтэд хөндлөнгийн ажиглалт хийх боломж олгодог.

Парламентын сэтгүүлч:

- Албан ёсны мэдээ, мэдээлэл, тоо, баримт бүхий Парламентаас гаргасан шийдвэрийг олон нийтэд хүргэдэг. Мөн эдгээрээс гадна үүн дээр үндэслэн өөрсдийн дүгнэлт анализ гаргаж болно.
- Асуудлыг хэлэлцэх явцад гарч буй үйл, баримтуудад үнэлэлт, дүгнэлт өгөх боломжтой байдаг.

Монгол улсын парламентын мэдээллийн үйл ажиллагаа

Эрх зүйн орчин:

- Үндсэн хууль
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль
- Олон нийтийн радио телевизийн тухай хууль
- УИХ-ын Чуулганы дэгийн тухай хууль
- Төрийн ордны эрх зүйн байдлын тухай хууль
- УИХ-ын даргын 2008 оны 5 сарын 30-ны 62 тоот захирамжаар баталсан журам

Техник зохион байгуулалтын орчин

- ХМОНХХ-ийн ажилтнууд
- Парламентын сэтгүүлчдийн өрөө
- -Мэдээллийн төв/студи/, ХМХ-ийн өрөө, УИХ сурталчлах төвүүд

Мэдээллийн орчин

- Чуулган , Байнгын хороодын хуралдаанд оролцох
- Хэвлэлийн хурлуудад оролцох
- Гишүүдтэй уулзуулах
- Тусгайлан мэдээ, мэдээлэл бэлтгэж өгөх

УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны хэлтэс нь:

- УИХ-ын мэдээллийн бодлого, чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах;
- УИХ-ын үйл ажиллагааны тухай танилцуулга, сурталчилгааны материал бэлтгэх, эмхтгэж хэвлүүлэх;
- Цаг үеийн асуудлаар мэдээлэл, мэдэгдэл, тайлбар хийх , Улсын Их Хурлын албан ёсны байр суурийг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу илэрхийлэх;
- УИХ-ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэлийн бага хурал хийлгэх, төсөл санаачлагч болон ажлын хэсгийн гишүүд, холбогдох бусад хүмүүсийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгүүлэх ажлыг зохион байгуулах;
- УИХ-ын удирдлага, гишүүдийг олон улсын болон өөрийн оронд болж буй үйл явдлын тухай хэвлэлийн мэдээллээр хангах;
- Парламентын сэтгүүлчдэд сурвалжлах эрхийн үнэмлэх олгох, мэдээллээр хангах, бүртгэл судалгаа хөтлөх, гэрээ, журам зөрчсөн сэтгүүлчийн сурвалжлах эрхийн үнэмлэхийг хураах;
- Парламентын сэтгүүлчдийн бичсэн нийтлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарсан Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой алдаатай нийтлэл, нэвтрүүлэгт няцаалт өгөх, мэдэгдэл, тайлбар гаргах зэргээр мэдээллийн бодит байдлыг хангах ажлыг хариуцаж зохион байгуулах;
- УИХ-ын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажиллах гэрээ байгуулж ажиллах, гэрээний биелэлтэд хяналт тавих зэргээр парламентын сэтгүүлчид, парламентын сэтгүүлчидийн холбоо, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

* * *

Хавсралт**ПАРЛАМЕНТЫН МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ ТУРШЛАГА****Австрали улсын Төлөөлөгчдийн танхимын мэдээллийг олон нийтэд мэдээлэх журам**

Австралийн хамтын нөхөрлөлийн орон Парламентын 2 танхимтай бөгөөд парламентын дээд доод Танхим болон байнгын хороодын хуралдааны хэлэлцүүлэг, парламентаас батлан гаргаж буй хууль, бусад шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ “Парламентын үйлчилгээний тухай хууль” /Parliamentary service act/-д заасан журмаар бүрдүүлсэн

Танхимын тамгын газрын холбогдох газар, хэлтсүүд “Хуралдааны дэг” /Standing and Sessional Orders/-д заасан журмыг баримтлан өөр өөрийн чиг үүргийн дагуу мэдээллийг олон нийтэд хүргэнэ. Тухайлбал, “Хуралдааны дэг”-ийн 19 дүгээр бүлгийн:

- Хуралдааныг радиогоор нэвтрүүлэх, давтан нэвтрүүлэх
- Хуралдааныг телевизээр цацах
- Танхимын мониторинг үйлчилгээний өргөтгөл
- Парламентын хуралдааныг радиогоор нэвтрүүлэх- ерөнхий зарчим
- Хуралдааныг нэвтрүүлэх – нэвтрүүлэгчид тавих болзол. гэсэн хэсгүүдээр нарийвчлан зохицуулж байна.

Мэдээллийг ил тод байлгахад баримтлах эх сурвалжууд:

Хуралдааны дэг – Standing and Sessional Orders 2010

Парламентын хуралдааныг телевизээр нэвтрүүлэх тухай хууль /1946/-Parliamentary Proceedings Broadcasting Act /1946/

Парламентын үйлчилгээний тухай хууль - /Parliamentary service act 1999он/

Парламентаас мэдээллийг ил тод байлгах ач холбогдол: Мэдээллийг олон нийтэл ил тод нээлттэй байлгах нь ард түмэн өөрсдийн сонгосон Парламентад болон тэдний хууль батлах процесст итгэлтэй байх ба энэ нь Парламентаас батлан гаргасан аливаа хууль хэрэгжих, хуулийг сахин биелүүлэхэд маш өндөр нөлөөлөл үзүүлдэг ач холбогдолтой юм.

Парламентаас мэдээллийг ил тод байлгах стратеги:

Стратеги 1: Парламентэд хэлэлцэгдэж буй асуудлыг улс төржихгүй, гуравдагч этгээдийн санаа бодлийг оруулалгүйгээр иргэдэд шууд дамжуулах, танилцуулах.

Стратеги 2: Парламентийн үйл ажиллагаа олон нийтэд шууд бодитоор хүрэх.

Парламентийн олон жилийн туршлагаас харагдаж байгаа дутагдалтай тал нь хувийн болон улсын өмчийн хэвлэл мэдээллийн аливаа хэрэгсэл нь /хэвлэл мэдээллийн байгууллагууд/ хоёр намын хоорондын болон Засгийн газрын цөөнхийн хоорондох маргаантай асуудлыг улс төрийн тэмцлийн үүднээс харуулдаг.

Харин байнгын хороодоос ямар асуудлыг хэрхэн хэлэлцдэгийг гаргадаггүй. Иймээс иргэдэд дутагдаж буй энэ боломжийг хангах үүднээс Тамгын газар байнгын хороодын болон чуулганы хуралдааныг шууд дамжуулах, улс орон, ард түмний эрх ашигт шууд нөлөөлөх өндөр ач холбогдолтой асуудлаар гишүүд, бүлгийн байр суурийг илэрхийлэх гол үүргийг өөртөө авсан.

Арга замууд: Парламент болон байнгын хороодын хуралдаан, хэлэлцүүлэг, түүнээс батлан гаргасан хууль, бусад шийдвэрийг олон нийтэд түгээхдээ Төлөөлөгчдийн танхимын Тамгын газар нь:

Парламентын өөрийн вэб:

- Хуудсаар шууд дамжуулах,
- Улс төр, нийгэм, эдийн засгийн болон бусад тулгамдсан асуудлаар Парламентын гишүүдийн байр суурийг илэрхийлсэн баримтат болон уран сайхны нэвтрүүлэг бэлдэж вэб хуудас болон Австрали улсын телевиз радиогийн шугамаар нэвтрүүлэх,
- Улирал тутам хэлэлцэгдэж буй, анхаарал татсан, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий хуулийг олон нийтэд таниулах зорилгоор сэдэвчилсэн сэтгүүл гаргах бөгөөд

Судалгааны эмхтгэл, Х боть

тухайн сэтгүүлээр тусгайлан телевизийн нэвтрүүлэг бэлдэж DVD форматад оруулан архивлан хадгалах,

- Улирал тутмын сэтгүүл гаргах.

Эдгээр ажлыг Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс буюу Liaison and Media Project Office хариуцан ажиллана.

Орон даяар радио телевизээр шууд дамжуулах: Сенат, Төлөөлөгчдийн танхим болон бүх байнгын хороодын хуралдаан, хэлэлцүүлэг, санал шүүмж, асуулгын цагийг орон даяар шууд дамжуулах. Энэ үүргийг Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын Радио нэвтрүүлгийн хэлтэс буюу Broadcasting Office хүлээнэ.

Төлөөлөгчдийн танхимын “Хуралдааны дэг”-ийн 19 дүгээр бүлгийн Хуралдааныг нэвтрүүлэх нэвтрүүлэгчид тавих болзолд заасны дагуу нэвтрүүлэгчид хуралдааны үйл ажиллагааг олон нийтэд зөвхөн шударга, үнэн зөвөөр хүргэх зорилгоор ашиглана гэдэг гол шалгуур тавьсан байна. Түүнчлэн улс төрийн аль нэг нам болон сонгуулийн сурталчилгаа, ёжлол, шоглол, доог тохуу, худалдааны зар сурталчилгаа зэрэгт ашиглахыг хориглосон байна.

Дэгийн “Парламентын хуралдааныг радиогоор нэвтрүүлэх ерөнхий зарчим”-д заасны дагуу хуралдааныг нэвтрүүлэгчид нь ялгаатай үзэл бодлыг тэнцвэртэйгээр нэвтрүүлэх гэсэн гол зарчмыг бусад зарчмын хамтаар тусгасан байна.

Хэлтсүүдийн ерөнхий чиг үүрэг:

Олон нийттэй харилцах хэлтэс: Олон нийттэй харилцах хэлтэс Парламентын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах үндсэн чиг үүргийн дагуу ажилладаг. Иргэдийг Парламентын хоёр танхимын хуралдаан болон Question time асуулт хариултын цаг, Парламентын ордонтой танилцуулах, өсвөр насныхны боловсролд зориулсан парламентын үйл ажиллагааны талаархи хөтөлбөрийг хариуцах болон иргэдэд Парламентын үйл ажиллагаа болон парламентын түүхийг таниулах ажиллагааг хариуцан зохион байгуулдаг.

Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс: Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс нь Парламентын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны хэлтэс нь улирал тутам хэлэлцэгдэж буй, анхаарал татсан, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий хуулийг олон нийтэд таниулах зорилгоор сэдэвчилсэн сэтгүүл гаргах бөгөөд тухайн сэтгүүлээр тусгайлан телевизийн нэвтрүүлэг бэлдэж DVD форматад оруулан архивлан хадгалдаг байна. Түүнчлэн Парламентын вэбсайтад тухайн хуультай холбоотой гишүүдийн байр суурь, ярилцлага, бэлдсэн нэвтрүүлгийг цаг тухайд нь байршуулах үүрэг хүлээн ажиллаж байна. Тус хэлтэс нь бие даасан сэтгүүл, нэвтрүүлэг бэлдэх ажлаа 10 жилийн өмнөөс эхлүүлсэн туршлагатай.

Радио нэвтрүүлгийн хэлтэс: Радио нэвтрүүлгийн хэлтэс нь **Сенат, Төлөөлөгчдийн танхим, бүх байнгын хороодын** хуралдаан, хэлэлцүүлэг, санал шүүмж, асуулгын цагийг орон даяар шууд дамжуулах үүргийг хүлээдэг хэлтэс юм. Уг хэлтэс нь бусад газар, хэлтэс, албадын нэгэн адил Парламентын ордонд байрлах бөгөөд 2 танхим бүхий телевизийн студи, хуралдааныг шууд дамжуулах удирдлагын ерөөнүүдтэй мэргэжлийн инженер, техникийн ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна. Уг шууд нэвтрүүлгүүд нь орон даяар телевизийн сувгаар, дэлхий даяар Парламентын вэбсайтаар цацагддаг байна.

АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын мэдээллийг олон нийтэд мэдээлэх

АНУ -ын Парламентын доод танхим болох Төлөөлөгчдийн танхим (Конгресс) нь Танхимын болон бүх байнгын хороодын хуралдаан, хэлэлцүүлэг, сонсгол болон парламентаас батлан гаргасан хууль, бусад шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ Конгрессийн Тамгын газрын дэргэдэх:

- Радио-телевизийн сурвалжлагчдийн галларей- Radio-Television Correspondents Gallery
- Өдөр тутмын хэвлэлийн галларей- Daily Press Gallery
- Тогтмол хэвлэлийн галларей - Periodical Press Gallery –аар дамжуулан **“112 дугаар Конгрессийн дүрэм”**-д нийцүүлэн гаргасан “Конгрессийн хуралдааныг цацах, нэвтрүүлэх дүрэм”-д заасан процессийн дагуу олон нийтэд хүргэнэ

Радио-телевизийн сурвалжлагчдийн галларей: Конгрессийн Радио Телевизийн Сурвалжлагчдын Галерейгээс итгэмжлэгдсэн бүх телевиз, радио станц, хэвлэл мэдээллийн сүлжээ, каблийн телевизийн систем болон итгэмжлэгдсэн бүх сурвалжлагч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад хуралдаанд шууд нэвтрэх боломжыг тус галларей хангах үүрэг хүлээн ажиллана.

Дээрх хуралдаанд шууд нэвтрэх боломж олгох гол шалгуур:

- Шууд хуралдааны нэвтрүүлгийг улс төрийн аливаа зорилгоор ашиглахгүй байх
- Худалдааны мэдээллийг аливаа сурталчилгаанд ашиглахгүй байх
- Бодит, шударга мэдээллийн хөтөлбөр болон төрийн бодлоготой хамааралтай баримтат нэвтрүүлгээс бусад зар сурталчилгааны спонсор бүхий нэвтрүүлэгт ашиглахгүй байх.

гэсэн 3 үндсэн шаардлагыг хангасан тохиолдолд хэвлэл мэдээллийн аливаа байгууллагын сурвалжлагчид хуралдааныг шууд нэвтрүүлэх эрх олгоно.

Дуут болон дүрс нэвтрүүлэг

Зорилго: Конгрессийн олон нийтэд нээлттэй дүрс болон дуут нэвтрүүлгүүд нь хууль тогтоох болон ард түмнийг төлөөлөх байгууллага болох Конгрессийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны процедур, дэг журам, конгрессоос авч буй арга хэмжээ, шийдвэрлэж буй асуудал зэргийг иргэд, олон нийтэд таниулах, иргэдийг энэ тал дээр мэдлэгтэй болгох зорилгоор хийгддэг. Мөн АНУ-ын Үндсэн хуульд зааснаар Холбооны Засгийн газрын нэгэн институц болохын хувьд Конгрессийн үүрэг ролийн талаар олон нийтийн түгээмэл ойлголтыг хөгжүүлэх зорилготой.

Хориглох зүйлс: Радио телевизийн бичлэгүүд, нэвтрүүлэг зэргийг аль нэг намын улс төрийн кампанит ажлын материал болгон ашиглахыг, төрийн сонгуульт албанд нэр дэвшсэн аливаа намын нэр дэвшигчийг дэмжих эсвэл эсэргүүцэх хэлбэрээр ашиглахыг хориглоно. Хуралдааны дүрс болон дуу бичлэгийн утга агуулгыг алдагдуулах, мушгин гуйвуулах, конгресс, хороод, гишүүн, төлөөлөгчдийн нэр хүндэд халдах хэлбэрээр ашиглахыг хориглоно.

Мэдээллийн хамрах хүрээ: Олон нийтэд нээлттэй хуралдааны дүрс болон дуу бичлэг нь ямар ч хязгаарлалтгүй, чөлөөтэй байна. Хороод болон дэд хорооны хуралдааныг даргалагч нь хуульд өөрөөр заасан нөхцөл үүссэн болон аюулгүй байдлыг харгалзан хязгаарлалт хийх шаардлагатай болсноос бусад нөхцөлд хэвлэл мэдээллийн аливаа байгууллагын төлөөлөгчид, гэрэл зургийн аппаратын тоог 2-оос доош болгон хязгаарлалт хийж болохгүй. Хуралдааны танхимд байрлах телевизийн камерийн тоо, байрлал зэргийг хурал даргалагчийн зөвшөөрснөөр Радио Телевизийн Сурвалжлагчдын Галлерейн гүйцэтгэх хороо шударга, тэгш хуваарилна.

Дуут болон дүрс бичлэг хийх

Эрх бүхий этгээд нь дараах зүйлүүдийг хангах үүрэгтэй. Үүнд:

- Бүх хороодын хуралдааны бүрэн бүтэн, засч найруулаагүй дуут болон дүрс бичлэгийг үйлдэх
- Дээрх дуут болон дүрс бичлэгийг олон нийтэд нэвтрүүлэх. Тэдгээрийг хадгалах. Хуралдааныг интернет хуудсанд шууд нэвтрүүлэх ба, хуралдааны тэмдэглэлүүдийг хуанлийн нэг хоногийн дотор интернет хуудсанд байрлуулна.

Хорооны мэдээллийг интернетэд байрлуулах:

Хороо нь боломжтой хамгийн өргөн хүрээний мэдээллийг цахилгаан хэлбэрээр нийтэд хүргэнэ.

Хуанли

Галларей нь Хороодын хуанли хөтлөх ёстой ба уг хуанлид хороодод хамааралтай бүх хуулийн төсөл, тогтоол, хорооны тайлагнасан бүх хуулийн төсөл, тогтоол, бусад хорооны тайлагнасан бусад зүйлс зэргийг нэгтгэн хэвлэж тогтмол гаргана.

1. Өдөр тутмын болон тогтмол хэвлэлийн галерей: Тус галларейн ажилтнууд нь хэвлэл болон Конгрессийн гишүүдийг хэд хэдэн гол үйлчилгээгээр ханган ажилладаг. Галерей нь дараахь үндсэн үүргийг хүлээнэ:

- Гишүүд болон сурвалжлагчдыг холбох ерөнхий нөхцлийг бүрдүүлэх,
- Конгрессийн болон Хороодын хуралдааны үйл ажиллагаатай холбоотойгоор сурвалжлагчид болон Конгрессийн ажилчдын тавьсан асуулга лавлагаа зэрэгт хариулах үүрэгтэй.

Тус галларейн ажилтан нь Конгрессийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой минут тутам шинэчлэгдэх бүртгэлтэй байх ба Конгрессийн одоогийн болон хуучны хууль тогтоомж, үйл ажиллагаатай холбоотой архивтай байна. Ажилтан нь хэвлэлийн мэдэгдэл гаргаж, хорооны мэдээлэл, зарлалыг галерейд тавина. Түүнээс гадна мэдэгдэл хийсэн гишүүн тус бүрийн мэдэгдлийг томоохон хэвлэл мэдээллийн агентлагуудад хүргэнэ.

Галларей нь бүх хорооны ажилтантай хамтран, сурвалжлагч, нэвтрүүлэгчдийн хороо болон дэд хороодын хуралдааныг нэвтрүүлэх ажлаа саадгүй хийхэд нь тус дөхөм болж, шаардлагатай бүх нөхцлийг хангана. Хорооны хуралдааныг нэвтрүүлж буй сурвалжлагч, нэвтрүүлэгчдэд мэдээлэл түгээх өргөн хүрээний боломж олгох, гишүүдийн мэдүүлгийн хуулбараар хангах, томоохон хэвлэл мэдээллийн агентлагуудад хуралдааны өдөр тутмын хөтөлбөрийг тараах зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

Конгрессийн хуралдааныг нэвтрүүлэх дүрмийн гол зохицуулалт: Спикер нь хуралдааны бүрэн бүтэн, засч найруулаагүй дүрс болон дуу бичлэгийн нэвтрүүлгийг хянах үйл ажиллагааг удирдан явуулна. Спикер нь дээрх нэвтрүүлгийг хэвлэл мэдээллийн байгууллагуудад тараах, хадгалах, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулан эдгээр бичлэг нэвтрүүлгүүдийн хадмал текстийг бэлтгүүлэх зэргийг гүйцэтгэнэ.

БНСУ-ын Үндэсний Ассемблейн Мэдээллийг олон нийтэд мэдээлэх

Үндэсний Ассемблейн бүтэц нь чуулганы үйл ажиллагааг удирдан явуулдаг Үндэсний Ассемблейн дарга, дэд даргаас гадна гишүүдийн хариуцан ажилладаг 17 байнгын болон тусгай хороо, Үндэсний Ассемблей дэх нам эвслийн бүлэг, мөн Үндэсний Ассемблейг үр бүтээлтэй ажиллах нөхцөлөөр хангаж, шаардлагатай туслалцаа үзүүлэх эрхэм зорилго бүхий тамгын газар, хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх номын сан,

судалгааны алба зэргээс бүрдэнэ.

Солонгосын Үндэсний Ассамблей нь олон нийтэд мэдээлэл түгээхдээ Үндэсний Ассамблейн телевиз болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нээлттэй түгээдэг. Олон нийтэд мэдээлэл түгээх эрх зүйн үндсийг дараах хууль тогтоомжуудаар зохицуулдаг.

- Үндэсний Ассамблейн тухай хууль
- Үндэсний Ассамблейн тамгын газрын тухай хууль
- Үндэсний Ассамблейн Тамгын газрын дүрэм
- Үндэсний Ассамблейн мэдээ, мэдээлэл нэвтрүүлэх журам
- Үндэсний Ассамблейгаас шууд нэвтрүүлэг дамжуулах журам
- Үндэсний Ассамблейн хуралдаанд оролцох журам

Үндэсний Ассамблейн мэдээллээ дараах байдлаар олон нийтэд нээлттэй байлгадаг. Доорх мэдээллүүдийг Үндэсний Ассамблейн цахим хуудаснаас шууд хандан үзэх боломжтой.

- Хууль тогтоомжийн мэдлэг, мэдээллийн систем
Шинээр батлагдан гарч буй болон нэмэлт өөрчлөлт орсон хуулиудын талаархи мэдээллийг мэдээлдэг.
- Хуулийн төслийн мэдээллийн систем
Энд өргөн баригдсан бүх хуулийн төслүүд болон хуулийн төсөлтэй холбогдох бүх мэдээллийг агуулдаг.
- Санхүүгийн тайлангийн мэдээллийн систем
 - Үндэсний Ассамблейн гишүүд болон хэлтэс албадын төсвийн төлөвлөгөө болон тайлангийн мэдээллийг мэдээлдэг.
 - Төрийн хяналт, шалгалтын мэдээлэл
Төрийн хянан шалгах үйл ажиллагаатай холбогдох мэдээллүүд. Тухайлбал хэлтэс албадын ажлын төлөвлөгөө, төсөв болон төсвийн зарцуулалтын талаархи мэдээлэл.
 - Хурлын тэмдэглэлийн систем
Үндэсний Ассамблейн болон байнгын хороодын хуралдааны тэмдэглэлийг үзэх боломжтой.
 - Интернет нэвтрүүлгийн систем
Энэ нь интернет телевизийн зарчмаар ажилладаг. Мэдээллийг сэтгүүлчийн нэрээр нь хайж дахин үзэх боломжтой байдаг.
 - Video conference систем
Үндэсний Ассамблейн болон Үндэсний Ассамблейн гишүүдийн албан ёсны уулзалтуудын талаархи мэдээлэл нь тойм болон бүрэн эхээрээ байдаг.
 - Дижитал мэдээллийн систем
Үндэсний Ассамблейн болон Үндэсний Ассамблейн гишүүдийн талаархи түүхэн мэдээллийг агуулсан байдаг.

Үндэсний Ассамблейн тамгын газрын хуулийн хэлтсийн даргын харьяанд нэвтрүүлэг төлөвлөлтийн алба ажилладаг. Нэвтрүүлэг төлөвлөлтийн алба нь дараах 3 хэсэгт хуваагддаг.

- Төлөвлөлт хариуцсан хэсэг



Судалгааны эмхтгэл, Х боть

- Нэвтрүүлэг зохион байгуулалт хариуцсан хэсэг
- Шууд нэвтрүүлэг хариуцсан хэсэг гэсэн хэсгүүдэд хуваагддаг.
- Үндэсний Ассамблейн Тамгын газрын дүрмийн 5 дугаар зүйлд “Нэвтрүүлэг төлөвлөлтийн хэлтэс”-ийн талаар зохицуулсан байна. Дараах ажил үүргийг гүйцэтгэнэ.
- Үндэсний Ассамблейн нэвтрүүлгийг бүрдүүлэх болон удирдан зохион байгуулахтай холбоотой зүйл
- Үндэсний Ассамблейн нэвтрүүлгийг хийх болон нэвтрүүлэхтэй холбоотой зүйлүүдийг хийж гүйцэтгэнэ.

Үндэсний Ассамблейн телевиз

Үндэсний Ассамблейн телевиз нь Үндэсний Ассамблейн чуулган, Үндэсний Ассамблейн хэлэлцэж буй асуудлуудаас гол хуралдааныг редакторлаж, нэмж хасахгүйгээр эхээр нь дамжуулдаг. Мөн түүнчлэн төрөл бүрийн тайлан мэдээлэл, цаг үеийн байдал, хуулийн мэдээлэл, улс төрийн түүх, соёл, орон нутгийн талаархи нэвтрүүлгүүдийг бэлтгэж өглөөний 6 цагаас шөнийн 02 цаг хүртэл нэтрүүлдэг.

Сонины сурвалжлагч, сэтгүүлч, нэвтрүүлэг бэлтгэгч зэрэг Үндэсний Ассамблейн сэтгүүлчид нь Үндэсний Ассамблейн хуралдаанд оролцох зөвшөөрлийг Үндэсний Ассамблейн Тамгын газраас авна. Шаардлагатай тохиолдолд зөвшөөрөлгүй сэтгүүлчийг түр хугацаагаар оруулж болох бөгөөд энэ тохиолдолд Үндэсний Ассамблейн Тамгын газрын даргаас зөвшөөрөл авна.

Үндэсний Ассамблейн сэтгүүлчид, сурвалжлагчид нь телевиз болон радиогоор шууд нэвтрүүлэг хийх тохиолдолд урьдчилан нэвтрүүлэгийн объект, хугацаа болон хэлбэрийн талаар Үндэсний Ассамблейн дарга болон дэд даргад хүсэлт гаргаж зөвшөөрөл авна.

Үндэсний Ассамблейн музей

Олон нийтэд зориулан Үндэсний Ассамблейн музейтэй. Музей нь насанд хүрэгчдийн болон хүүхдийн гэсэн 2 хэсэгт хуваагддаг. Хүүхдийн Үндэсний Ассамблейн хөтөлбөр нь хүүхдэд ойлгомжтой байдлаар Үндэсний Ассамблейн үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг хүргэдэг.

Үндэсний Ассамблейн номын сан

Үндэсний Ассамблейн номын сан нь Үндэсний Ассамблейн гишүүд болон Тамгын газар, судалгааны албыг мэдээ, мэдээлэлээр хангахаас ганда олон нийтэд нээлттэй үйлчилдэг. Үндэсний Ассамблейн номын сан нь олон нийтэд нээлттэй үйл ажиллагаа явуулдаг. Цахим мэдээллийн сангаараа дамжуулан мэдээлэл дамжуулах боломжтой бөгөөд нутаг дэвсгэрийн хаанаас ч хандалт хийж мэдээлэл авах боломжтой.

Үндэсний Ассамблейн судалгааны алба

Үндэсний Ассамблейн судалгааны алба нь өөрийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтийн санал асуулга болон хуулийн төсөлд холбогдох саналыг авдаг.

Польшийн Сеймын мэдээллийг олон нийтэд мэдээлэх

Сеймын Тамгын газар (Cancellery) нь үйл ажиллагааны журмынхаа (Standing order) дагуу өөрийн мэдээллийн системээрээ дамжуулан мэдээллээ түгээдэг. Тамгын газрын орлогч даргын эрх мэдлийн хүрээнд хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах товчоо байдаг.



Энэ товчоо нь мэдээллийн сангийн, хэвлэл мэдээлэлтэй харилцах, Сеймтэй харилцах, мэдээлэл судалгааны гэх мэт чиг үүрэгтэй. Сеймын үйл ажиллагаа болон холбогдох бусад баримт бичгүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээхдээ өөрийн албан ёсны вэбсайтад (www.sejm.gov.pl) байрлуулах буюу сэтгүүлчдэд дамжуулах байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Хэрэв тус товчооноос өгсөн мэдээлэл нь хангалттай бус тохиолдолд сэтгүүлчид ямар мэдээлэл хүсч байгаагаа нарийвчлан тодорхойлж өгдөг. Хууль буюу журамд өөрөөр заагаагүй, хуульд харшлаагүй бол энэ хүсэлтийн дагуу байгаа мэдээллийг нь гаргаж өгнө. Хэрэв энэ хүсэлтээс нь тодорхой шалтгаангүйгээр татгалзах тохиолдолд сэтгүүлчид Тамгын газрын даргад гомдлоо гаргана.



Эх сурвалж: www.sejm.gov.pl

Францын Үндэсний Ассамблейн мэдээллийг олон нийтэд мэдээлэх

Тус улсын Үндэсний Ассамблейд хэвлэл мэдээлэлийн байгууллагуудтай харилцах чиг үүрэг бүхий Хэвлэл, Телевиз, Радиогийн алба (Press, Television and Radio Unit) байдаг. Товчоор, Хэвлэлийн алба (Press Office). Энэ алба нь Мэдээлэл Харилцаа холбооны газарт (Communication and Multimedia Department) харьяалагддаг.

Хэвлэлийн алба нь парламентын өдөр тутмын үйл ажиллагаа болон холбогдох бусад баримт бичгүүдийн талаарх мэдээллийг өөрийн албан ёсны вэбсайтад (www.assemblee-nationale.fr) байрлуулахаас гадна парламентын сурвалжлагчдыг эдгээр мэдээллүүдийг хүлээн авах бололцоог нь хангаж өгөх үүрэгтэй ажилладаг. Эдгээрийг тусгай журмаар зохицуулдаг. (Rules of Procedure of the National Assembly)

Хэвлэлийн албаны нэг гол үүрэг бол хэвлэл мэдээллийн байгууллагуудад парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг олгох явдал юм. Ингэхдээ парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрх хүссэн байгууллагуудын чадвар чадамжийг харгалзан үзсний үндсэн дээр эрх олгодог. Өөрөөр хэлбэл, тогтмол байнгын буюу өдөр тутмын мэдээллийн үйл ажиллагаатай, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий буюу харьцангуй олон нийтэд мэдээллээ хүргэх боломжтой Телевиз, Радио, Хэвлэлийн байгууллагад эрх олгоно. Бие даасан сурвалжлагчдад эрх олгодоггүй.

Парламентын сурвалжлагчид нь хуулиар тогтоосон нууцад хамаарахгүй бүх төрлийн



Судалгааны эмхтгэл, Х боть

мэдээ мэдээллийг сурвалжлах эрхтэй. Үүнд:

- Үндэсний Ассамблейн ойрын болон ирээдүйн зорилго, зорилтууд
- Чуулган болон хороодын хуралдааны хэлэлцэж буй асуудлууд
- Хэвлэлийн, видео болон бусад төрлийн хурлуудад оролцох
- Үндэсний Ассамблейгаас гаргасан баримт бичгүүдтэй танилцах (Засгийн газраас ирүүлсэн тайлан болон гишүүдийн илгээсэн бичиг баримт хүртэл хамаарна.) Мөн Хэвлэлийн албаны өөр нэг үүрэг бол гадаадын сурвалжлагчдад хязгаарлагдмал хүрээнд парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрх олгодог.
- Энэхүү эрхийг олгохдоо Гадаадын Хэвлэл мэдээллийн Холбоо юмуу, эсвэл Англи-Америкийн Хэвлэл мэдээллийн Холбоонд (Foreign Press Association or the Anglo-American Press Association) хүлээн зөвшөөрөгдсөн сурвалжлагчдад эрх олгоно. Гадаадын сурвалжлагчид энэхүү эрхийг хүсэхээсээ өмнө заавал тус улсын Гадаад Харилцааны Яамнаас магадлан итгэмжлэгдсэн байх ёстой байдаг.

Хэдийгээр парламентын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг хугацаагүй олгодог боловч Хэвлэлийн албанаас жил бүх сурвалжлагчдад үйл ажиллагаа болон бусад боломж чадавхи зэргийг харгалзан үзэж магадлан итгэмжлэдэг.

Үүнд шаардлага хангаагүй тохиолдолд сурвалжлах эрхийг нь түр буюу хагас хүчин төгөлдөр байдалтай гэж тодорхойлох бөгөөд хүчин төгөлдөр эрх бүхий болгохын тулд журмаар тогтоосон шалгуурт нийцсэн байхыг шаардах, зарим тохиолдолд Хэвлэлийн албанаас сургалт гэх мэтийг зохион байгуулдаг. Хэрэв энэхүү шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд парламентыг сурвалжлах эрхийг нь хүчингүй болгоно.

Парламентын сурвалжлагчдын үйл ажиллагааг түргэн шуурхай чирэгдэлгүй байлгахын тулд Үндэсний Ассамблейн ордонд (Palais Bourbon) тусгай өрөөнүүд гаргаж өгсөн. Үүнд:

- Ярилцлага авах өрөө
- Харилцаа холбооны өрөө
- Интернет сүлжээ бүхий компьютерүүдийн өрөө
- Радио нэвтрүүлгийн өрөө

Гэвч парламентын сурвалжлагчдад бүх зүйл нээлттэй байдаггүй. Албан ёсны, баталгаатай мэдээлэл хүргэх үүднээс 5 байнгын хороо, 3 тусгай хорооноос гарах мэдээллийг Хэвлэлийн албаны тусгай эрх бүхий 5 ажилтан мэдээлэлийн үйл ажиллагааг хариуцдаг.

5 Байнгын хороо:

- Cultural Affairs
- Economic Affairs
- Foreign Affairs
- Finance Affairs
- Law Affairs

3 Тусгай хороо:

- Regional Development
- Women rights
- European Union

Харин дараах нэгжүүд олон нийтэд мэдээлэл түгээх өөрийн тусгай системтэй бөгөөд



парламентын сурвалжлагчдаар мэдээллээ дамжуулдаггүй. Батлан хамгаалах байнгын хороо (Defence committee), Шинжлэх ухаан технологийн газар (Parliamentary Office for Scientific and Technological Assessment)



**МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ЗАРИМ УЛС ОРНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ** (Харьцуулсан судалгаа)*Ч. Базар (Ph.D)***Оршил**

Мэдээллийн аюулгүй байдлын талаархи улс орнуудын зохицуулалт нь маш их өргөн хүрээтэй асуудал аж. Гэхдээ өнөөгийн интернэжсэн болон глобальчлагдаж байгаа нийгэмд улс орнууд мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах нь мөн л өргөн хүрээний асуудал мөн. Мэдээллийн аюулгүй байдлын цаана улс орны Үндэсний аюулгүй байдлын асуудал оршиж байна.

Энэхүү судалгааны хүрээнд Үндэсний аюулгүй байдал ба мэдээллийн эрх чөлөө, Үндэсний аюулгүй байдал ба төрийн нууц, мэдээллийн аюулгүй байдлыг яагаад хангах нь чухал, энэ талаар юу хийвэл зохих талаар асуудал дэвшүүлэн тавьдаг мэргэжлийн хүмүүс, судлаачид, эрдэмтэн судлаачид, энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын мэдээлэл, судалгаан дээр үндэслэн товч мэдээллийг бэлтгэв.

Түүнчлэн дэлхийн улс орнууд мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд төрийн нууц, хувь хүний мэдээллийг хэрхэн хамгаалдаг, ямар тохиолдолд ил болгодог, Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс ямар үүрэг хариуцлагатай ажилладаг зэргийг пост коммунист байсан зарим орон, АНУ, Австрали, ИБУИВУ, ХБНГУ, БНСУ зэрэг орнуудын зарим эрх зүйн зохицуулалтаас товчлон бэлтгэв.

Дэлхийн улс орнууд мэдээллийн аюулгүй байдлыг хангахдаа олон улсын хүрээнд ямар ямар зарчим дээр үндэслэн эрх зүйн орчноо бүрдүүлдгийг мөн жишээлэв. Эдгээртэй зэрэгцэн Мэдээллийн аюулгүй байдлын салшгүй хэсэг болох Мэдээллийн эрх чөлөө, иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах, ХМХ-ийн эрх чөлөөний нэг тулгуур болсон нууц эх сурвалжийг хамгаалах асуудлыг бусад орнуудад хэрхэн зохицуулдаг талаар энэхүү судалгаанд түүвэрлэн өгүүлэв.

Дашрамд дурьдахад, мэдээллийн аюулгүй байдлын асуудал нь эрх зүйн хүрээнд цогцоор шийдэгдэх асуудал бөгөөд харин УИХ, Засгийн газар, хууль санаачлагчдаас тэдгээрийг хойшлуулалгүйгээр цогцоор нь боловсруулан, батлан хэрэгжүүлэх нь улс орны Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал юм гэсэн дүгнэлтэд уг судалгааг хийсэн судлаач хүрсэн болно.

1. Үндэсний аюулгүй байдал ба Мэдээллийн эрх чөлөө

Мэдээлэл нь хүн төрөлхтний өнөөгийн хөгжил (хувь хүн, хамт олон, улс гүрэн, төдийгүй дэлхийн хамтын нийгэмлэгийн амьдралд)-д шийдвэрлэх хүчин зүйл болж байна. Нөгөө талд, мэдээллийг хувь хүн, нийгэм, төрийн ашиг сонирхолд харшаар ашиглах тохиолдолд улс төр, нийгэм, эдийн засаг, олон улсын харилцааны хүрээнд маш их хор уршиг учруулах үр дагавартай. Үүнээс үүдэн иргэн, байгууллага, төр өөрөө мэдээлэл чөлөөтэй олж авах, түгээх, ашиглах эрхийг хамгаалахаас гадна учирч болох аюул занал, бусад хүчин зүйлийг зөв мэдэрсэн, мэдээллийн улсын нөөцийг хамгаалах, түүнийг ариг гамтай зарцуулах зэргийг тодорхойлон томъёолсон мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг цогцоор бий болгох нь цаг үеийн тулгамдсан, зүй ёсны асуудал юм.

Өнөөдөр Монгол улсад:

- Төр, байгууллага, хувь хүний нууцын тухай багц хуулиуд (1995)

- Улсын нууцын жагсаалт батлах тухай хууль (2004)
- Үндэсний аюулгүй байдлын тухай үзэл баримтлал зэргээс өөр мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн аргууд алга байна.

Тийм учраас юуны өмнө мэдээлэл бий болгох, цуглуулах, боловсруулах, хуримтлуулах, хадгалах, хайх, түгээх, түүнчлэн мэдээлэл болон мэдээлэлжүүлэлтийг хамгаалах асуудлыг зохицуулсан хууль (хэд хэдэн хууль байж болно) гаргах шаардлага байна. Өөрөөр хэлбэл, мэдээллийг зөвхөн нууцад хамаарах гэдэг үүднээс хуульчлан хамгаалах бус, харин нь мэдээллийн өнөөгийн ач холбогдлоор нь, иргэд Үндсэн хуульд заасан мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ бодитой эдлэх эрх зүйн механизмыг бүрдүүлэх том агуулгаар төр авч үзвэл зохино. Энэ хүрээнд Мэдээллийн эрх чөлөөний тухай Монгол улсын хуулийг баталж, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай Монгол улсын хуульд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг хийх нь чухал юм. Тодруулбал, Үндэсний аюулгүй байдал ба Мэдээллийн эрх чөлөөг зөв зохицуулсан эрх зүйн орчин чухал байна.

Гол томъёолол нь 1-д Үндэсний аюулгүй байдал алдагдах нь улс оршин тогтнох, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал алдагдах ноцтой үр дагавартай тул нууцыг чанд хамгаалах учиртай, 2-д Үндэсний аюулгүй байдал, түүнийг хамгаалах асуудал нь мэдээллийн эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн чөлөөт урсгалд хязгаарлалт болох ёсгүй юм. Анхаарах зүйл нь мэдээллийн эрх чөлөө нь Үндэсний аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалснаас бусад мэдээлэлд хамаардаг ойлголт юм.

2. Үндэсний аюулгүй байдал ба төрийн нууц

Мэдээллийн салбар дахь техник, технологийн асар хурдацтай хөгжил нь төрийн хүслээс үл хамааран иргэдийн мэдээлэл хүлээн авах чадавхид маш хүчтэй, хурдтай нөлөөлж байна. Энэ тохиолдолд төр мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын хүрээнд:

Нэгдүгээрт, Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах, ашиглах эрх, эрх чөлөө чөлөөтэй хэрэгжих орчинг бүрдүүлэх,

Хоёрдугаарт, Мэдээллийн технологийн хөгжлийг даган төрийн нууцад хамаарах мэдээлэл алдагдах магадлал өндөр байгааг харгалзан төрийн нууцын хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх механизмыг улам боловсронгуй болгох, төрийн нууцын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, чангатгахад чиглэсэн зохион байгуулалтын, техникийн шинжтэй цогц арга хэмжээг иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хохироохгүйгээр авч хэрэгжүүлэх,

Гуравдугаарт, Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үндсэн зарчмууд болох хууль ёсны болон ил тод байх зарчмыг төрийн бүх шатны байгууллагад жинхэнэ ажил хэрэг болгох,

Дөрөвдүгээрт, Төрийн нууцыг хамгаалах нь төрийн хүлээсэн шууд үүрэг хэдий ч энэ асуудал аливаа улс, үндэстний үндэсний аюулгүй байдлыг хангахтай шууд хамааралтай учраас төрийн нууцад хандах иргэдийн нийгмийн ухамсар, ёс зүйн хандлагыг эрс өөрчлөхөд илүүтэй анхаарал хандуулах болсон байна.

3. Яагаад мэдээллийн аюулгүй байдал чухал вэ?

Дэлхий нийтээр мэдээллийн нийгэмд шилжиж, тоон эдийн засаг, цахим ардчилал, цахим засаг, цахим бизнес, цахим банк, цахим эрүүл мэнд, цахим боловсрол, цахим хөдөө аж ахуй хөгжиж, мэдээлэл холбооны технологи нэвтрэхийн сацуу уламжлалт гэмт хэрэг, зөрчил цахим хэлбэрт хувирч, шинэ төрлийн гэмт хэргүүд бий болж, сүлжээ, систем, мэдээллийн нэгдмэл, бүрэн бүтэн байдал, нууцлал, хамгаалалтад заналхийлэх аюулууд олширч, эрсдэл эрс нэмэгдэж байна. Үүний улмаас мэдээллийн аюулгүй байдлын асуудал

Судалгааны эмхтгэл, X боть

зөвхөн програм-техникийн асуудал байхаа больж улам бүр нарийн төвөгтэй, захиргаа-удирдлагын асуудал болон хувирч байна.

Хэдхэн жилийн өмнө компьютерийн болон сүлжээний аюулгүй байдал онц чухал асуудал хэмээн тооцогдож байсан бол өнөөдөр нөхцөл байдал эрс өөрчлөгдсний улмаас мэдээллийн аюулгүй байдлын цогц удирдлага бий болгох, бодлого, хөтөлбөр, дэг батлан хэрэгжүүлэх, төрөл бүрийн будлиан, учрал, тохиолдол, гэмт хэргийн эсрэг хариу үйлдэл хийх, түүнийг мэдээлэх, удирдах, сөрөг арга хэмжээ боловсруулах шаардлага тулгарч байна. Үүний дагуу Монгол улсад мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бий болгох зайлшгүй шаардлага тулгарч байгаа ба энэ хүрээнд байгууллага бүр мэдээллийн аюулгүй байдлын үзэл баримтлал (стратег), бодлого, хөтөлбөр, дэгээ батлан гаргах, даган мөрдөх, хэвшүүлэх, зохих програм-техникийн арга хэмжээ, шаардлагатай сөрөг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Интернетээр дамжин гаднаас орж ирэх төрөл бүрийн халдлага, довтолгоон жил бүр нэмэгдэж, учруулах хохирол нь ихэссээр байхын зэрэгцээ дотроос эх үүсвэртэй халдлага, будлиан, зөрчил, гэмт хэргүүд ч маш их нэмэгдэж байна. Байгууллагын сүлжээг унагадаг, ажиллагаанаас гаргадаг, сервер, компьютеруудад хадгалагдаж буй өгөгдөл, мэдээллийг хулгайлах, устгах, өөрчлөх, хэрэглээний програмуудыг эвдэлдэг маш олон төрлийн (1000 орчим) халдлагаас гадна ажилтнуудыг хууран мэхэлж мэдээлэл авдаг, залилдаг олон төрлийн үйл ажиллагаа дэлгэрч байна. Гэтэл Монгол улсын байгууллагуудын мэдээллийн сүлжээ, систем нь заналхийлж буй эдгээр аюулыг сөрөн зогсох чадваргүй, маш олон эмзэг байдал, цоорхойтой, байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, хөтөлбөр, дэгүүд хэрэгждэггүй, ямар ч удирдлагагүй байгаа нь мэдээллийн нийгмийн хөгжлөөс эрс хоцрогдсоныг харуулж байна.

Өнөөгийн нөхцөлд байгууллага мэдээллийн аюулгүй байдлаа хангаж чадаагүй бол өрсөлдөх чадваргүй, ашиг орлого, хэмнэлтгүй, өргөжин хөгжих боломжгүй, орчин үеийн удирдлага хэрэгжихгүй явсаар улмаар дампуурах аюулд өртөх болно.

Мэдээллийн аюулгүй байдлыг баталгаажуулах тухайд

- Юун түрүүн бүх нийтийн ойлголтыг төлөвшүүлэх;
- Удирдлагын дэмжлэг, манлайллыг өндөрт өргөх (бий болгох);
- Хүний нөөцөөр хангах, хүний нөөцийн мэдлэгийг дээшлүүлэх;
- Байгууллага бүр мэдээллийн аюулгүй байдалдаа аудит, эрсдэлийн үнэлгээ хийлгэдэг болох;
- Үйл ажиллагааны дэгүүдийг тогтоох;
- Програм, техникийн үйл ажиллагаагаа сайжруулах зэргийг бүх шатанд бодлогоор зохицуулах шаардлагатай байна.

Түүнчлэн олон улсын хамтын ажиллагаагаа сайжруулах нь чухлаар тавигдаж байна. Ер нь дэлхийн аль ч өнцгөөс хаашаа ч халдаж болдог. Харин тийм хэргийг илрүүллээ гэхэд хариуцлага тооцож чадах эсэх нь тухайн улсуудын харилцаанаас шалтгаална. Тиймээс хамтын ажиллагаа сайтай байж л мэдээллээ хамгаалж чадна

Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухайд

АНУ-ын үндэсний МАБ-ын агентлагийн судалгаагаар АНУ-ын компаниудын 98% нь компьютерийн ямар нэг халдлагад өртсөн байна: Үүнээс хамгийн олон тохиолддог халдлага нь:

- Нянтай програмаар халдварлуулах

- Өгөгдөл хулгайлах
- Гадна, дотно эх сурвалжаас өгөгдлийг өөрчлөх, устгах, нэмж хасах.
- Компьютерийн тоног төхөөрөмжийг хууль бусаар ашиглах
- Сүлжээнд хууль бусаар хандах
- Веб сайтыг эвдлэх
- Denial of service (DoS)

Монгол улсын хувьд “Кибер довтолгооны эсрэг хариу үйлдэл хийх үндэсний төв”-ийн хийсэн тандалт судалгаагаар сүүлийн хоёр жил буюу 2007-2008 онд хакеруудын довтолгоо улам ихэссэн гэсэн дүгнэлт гарчээ. Довтолгоонд өртөж байгаа компьютер, вэб сайтыг төрлөөр нь авч үзвэл Засгийн газар түүний харъяа газруудын 66, олон нийтийн байгууллагын 40, боловсролын чиглэлийн 64, банкны зургаа, компанийн 64, сонин болон мэдээллийн 10, бусад чиглэлийн 80 орчим вэб хуудас хакеруудын дайралтанд өртөж өнөөг хүртэл 88 вэб хуудас эргэн сэргээгдээгүй буюу хакердуулсан хэвээрээ байна. Үүнд Засгийн газар, татвар, эрчим хүчний болон дулааны станц, цагдаа, томоохон технологийн болон аялал жуулчлалын компаниудын вэб орсон нь манай улс хакеруудын дайралтад өртсөнийг бодитоор харуулж байна. Мэргэжилтнүүдийн үзэж буйгаар манайхан 14 жилийн өмнө анх кибер довтолгоонд өртсөн байна.

Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын үйл явцыг хэн удирдаж, хянах вэ?

- Байгууллага бүр мэдээллийн аюулгүй байдал болон системийн аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд мэдээллийн технологийн өдөр тутмын удирдлагыг хариуцсан хүнийг томилсон байх;
- Жижиг байгууллагын хувьд систем администратор нь бүх өгөгдөл, програм хангамж, техник хангамжид хандах эрхтэй байдаг учир шаардлагатай мэдлэг, чадвар, цогц чадавхитай байх ёстой;
- Мэдээллийн аюулгүй байдал нь хүн бүрийн хариуцах зүйл учраас байгууллагын ажилтан бүр мэдээллийн аюулгүй байдлыг арга хэмжээг зөв, зүйтэй, шударгаар хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд:
 - Системийн бүх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
 - Техникийн ажилтнуудад зориулсан аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулах
 - Мэдээллийн аюулгүй байдлын хяналтуудын байнга нягталж байх журмыг бий болгох
 - Бизнесийн стратеги өөрчлөгдсөн, энэ өөрчлөлтүүд танай мэдээллийн систем, сүлжээнд нөлөөлөхөөр бол аюулгүй байдлын архитектураа заавал нягталж байх зэргийг хийх ёстой юм байна.

Мэдээллийн аюулгүй байдлыг орхигдуулвал ноцтой үр дагаварт хүргэж болзошгүйг судалгаагаар илэрсэн дээрх жишээнүүд харуулж байна. Энэ нь үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд шууд аюул учруулах эрсдэлтэйг судлаачид нотолж байна. Үүний эсрэг юу хийх ёстой вэ? Кибер довтолгооны эсрэг хариу үйлдэл хийх үндэсний төвийн тэргүүн, доктор Т.Халтарын үзэж буйгаар дэлхийн ихэнх улсад хэрэгжүүлдэг дөрвөн түвшин бүхий цогц хандлагыг ашиглах хэрэгтэй бөгөөд энэ нь хууль тогтоомжийн, захиргааны, процедур-дэгийн, програм-техникийн гэсэн дөрвөн түвшинг тодорхойлж хамгаалах тухай асуудал юм. Тэдгээр хандлагыг доорхи хүснэгтээс харж болно.

Судалгааны эмхтгэл, X боть

Захиргаа-удирдлагын түвшин

| | | | |
|---|---|--|---|
| Эрсдлийн шинжилгээ, үнэлгээ (аюул, эмзэг сул байдал, цоорхой, түүний нөлөөлөл, хор уршгийг тодруулах) | Мэдээллийн аюулгүй байдлын стратеги, үзэл баримтлалаа тодорхойлох | Мэдээллийн аюулгүй байдлын бодлогоо боловсруулах | Мэдээллийн аюулгүй байдлын сөрөг арга хэмжээ, хяналтуудыг тусгасан хөтөлбөр боловсруулж батлах, хэрэгжүүлэх |
|---|---|--|---|

Дэгийн түвшин

| | | | |
|---|---|--|---|
| Ажлын байр тус бүрээр болон тоног төхөөрөмж тус бүрээр мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг шинжлэх, тодруулах | Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд ажилтан бүрийн хүлээж буй үүрэг, хариуцлагыг тодруулах | Тодруулсан шаардлага хүлээх үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны онцлогийг харгалзан МАБ-ын дэгүүдийг үе шаттай боловсруулах | Дэгийг туршиж, баталгаажуулсны дараа баталж мөрдүүлэх, нягтлан сайжруулж байх |
|---|---|--|---|

Программ-техникийн түвшин

| | | | |
|---|--|--|---|
| Сүлжээ, систем, үйлдлийн системд халдсан амжилттай халдлагыг шинжлэх, ангилах | Халдлага үйлдэхэд ашигласан эмзэг байдал, ҮС-ийн архитектурын дутагдлыг илрүүлэх | Илэрсэн алдаа, эмзэг байдлыг арилгах, мэдээлэл хамгаалах технологи, механизм боловсруулах, олох, суулгах | Суулгасан, сайжруулсан техникийн шийдлүүдийг туршин шалгах, ашиглалтанд оруулах |
|---|--|--|---|

4. Мэдээллийн аюулгүй байдал ба гадаад улс орнуудын зохицуулалт

4.1. Йоханнесбургийн зарчмууд

Энэ баримт бичиг нь мэдээлэл хайх, олж авах, хэлэх эрхийг цаг хугацаанд нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгай шалтгаанаар хязгаарлагдаж болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэвч, үндэсний аюулгүй байдал нь мэдээлэл олж авахыг хязгаарлаж чадахгүй. Йоханнесбургийн олон зарчмууд нь дараахи нууцлалын хуулийн асуудалтай холбоотой байна. Үүнд,

Зарчим 2:

- **Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны ашиг сонирхол**

А/ Хязгаарлалт нь цэргийн дайралт зэрэг гадаад эх сурвалжаас, эсвэл Засгийн газрыг унагах зөрчлийг өдөөн хатгах зэрэг дотоод эх сурвалжаас, хүч хэрэглэхэд хариу үзүүлэх хүчин чадал, аюул заналын эсрэг улсын оршин тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах үр дүн, бодит зорилгогүй бол үндэсний аюулгүй байдлын шалтгаан нь хууль ёсны болж зөвтгөгдөхгүй.

Б/ Ялангуяа, бэрхшээл, саад, буруу үйлдлээс Засгийн газрыг хамгаалах, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаархи мэдээллийг нууцлах, үйлдвэрлэлийн үймээн самууныг нууцлан дарах зэргээр Үндэсний аюулгүй байдалтай холбоогүй ашиг сонирхлыг хамгаалах үр дүн, бодит зорилго байвал Үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар уг хязгаарлалтыг хууль ёсны гэж үзэж зөвтгөж болохгүй.

Зарчим 15:

Нууц мэдээллийг задруулах талаарх нийтлэг журам

Хэрэв нэгд, Мэдээллийг задруулах нь бодитоор хохирол учруулаагүй, үндэсний



аюулгүй байдлын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулаагүй бол, хоёрт, мэдээллийг мэдэх нийтийн ашиг сонирхол задруулснаас үүсэх хор хохирлоос илүү бол хэн ч мэдээллийг задруулсныхаа төлөө үндэсний аюулгүй байдлын шалтгааны дор шийтгэгдэх ёсгүй.

Зарчим 16: Төрийн албаны хүрээнд олж авсан мэдээлэл

Мэдээлэл олж авах гэсэн нийтийн ашиг сонирхол нь илчилснээс гарах хохирлоос илүү байвал төрийн албаны шугамаар олсон мэдээллийг илчилбэл үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар ямар нэг хохирол учруулсан гэж хэнийг ч авч хэлэлцэхгүй. Эдгээр зарчмийг дэлхийн улс орнууд нууцын хууль тогтоомжийн шинэтгэл хийхдээ гол төлөв удирдлага болгодог байна.

Үндэсний аюулгүй байдал ба төрийн нууцийн зохицуулалт

ОХУ, Киргизийн БНУ, Таджикстан, Туркменстан, Украин, Гүрж, Казакстан, Солонгос, ИБУ-ИНВУ, ХБНГУ зэрэг улсын хуулиудын гол санааг энд тусгав.

Анхаарсан гол асуудлууд:

- Төрийн нууц (Улсын нууц)-ын тодорхойлолт
- Нууцын хамрах хүрээ
- Нууцлах хугацаа
- Нууцлалыг ил болгох
- Нууцыг тогтоох субъект зэрэг болно.

Төрийн нууцыг тодорхойлсон байдал

Туркменстан, Украин, Киргиз, Гүрж, Казакстан зэрэг улс нь төрийн нууцыг тодорхойлохдоо гол томъёолол нь зөвхөн мэдээлэл гэжээ. Үүгээрээ манай хуулиас ялгаатай байна. Туркменстан, Киргиз, Казакстаны хуульд “төрийн нууцын жагсаалтад орсон мэдээлэл нь нууц” гэсэн бол Украин, Гүржийн хуульд “Задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулах мэдээлэл” гэж нарийвчилсан байна.

Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийн 3-р зүйлд “Төрийн нууц гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийн томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон. Энэ нь мэдээлэл төдийгүй баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хүртэл төрийн нууцад хамаарах бөгөөд дээрх хүрээ нь бусад орны хуулийн хамрах хүрээнээс өргөн байгаа нь харагдаж байна.

ОХУ, Украин, Туркменстан, Таджикстаны хуулийг харьцуулахад үзэхэд бүтцийн хувьд ижил төстэй байсан бөгөөд харин агуулгын хувьд ОХУ, Украин, Тажикстаны хуульд нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтыг шууд тогтоож өгсөн байна. Украин, Гүржийн хууль нь илүү их дэлгэрэнгүй нэр томъёоны тайлбарыг нарийвчлан гаргасан, нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах гэх мэт технологийн үе шатны зохицуулалтын журмыг тодорхой тусгаж оруулжээ.

Төрийн нууцын хамрах хүрээ

Төрийн нууцын хамрах хүрээг ОХУ, Украин, Гүрж улсад дараахи нийтлэг байдлаар:



Судалгааны эмхтгэл, Х боть

- Батлан хамгаалах /цэргийн/ салбар
- Шинжлэх ухаан, техник, эдийн засгийн салбар
- Эдийн засаг, улс төрийн гадаад харилцаанд тагнуул, сөрөг тагнуул, эрэн сурвалжлах үйл ажиллагаа гэж заасан байна.

Энэ нь Монгол улсын төрийн нууцын хүрээг томъёолсонтой нэлээд төсөөтэй боловч Украин, Монгол улсын хуулинд “Үндэсний аюулгүй байдал” гэж тусгайлан оруулжээ. Манай хуулиар масштабаас хамаараад газрын зураг бүгд нууцад хамаарахаар байхад, Казахстан, Тажикстан болон Украины хууль тогтоомжинд газрын зургийн нууцлалтай холбоотой заалтууд орсон ч энэ нь зөвхөн цэрэг, дайны зориулалтаар ашиглах тохиолдол буюу эсвэл эдийн засгийн мэдээлэл агуулсан үед (Казахстан, Тажикстан) газрын зургийн өгөгдлүүдийг нууцалсан байдаг. Харин ч Төрийн нууцын тухай Гүржийн хуулинд “цэргийн зориулалттай тусгай газрын зургаас бусад” газрын зургийг нууцад ангилахыг хориглосон зүйл байна.

Нууцалж болохгүй мэдээллийн хүрээ

Төрийн нууцын тухай Тажикстан улсын хуулинд юуг төрийн нууц гэж үзэх ёсгүйг ангилан ялгасан заалт ороогүй байна. Монгол улсын хуулинд мөн адил тодорхой заагаагүй. Төрийн нууцын тухай Оросын Холбооны Улсын хуулинд үүн дээр нэмэлт болгосон алт болон бэлэн мөнгөний нөөц, төрийн өндөр, дээд тушаалын албан хаагчдын эрүүл мэндийн байдлыг төрийн нууц гэж үзэх ёсгүй гэж заажээ. ОХУ-ын Төрийн нууцын тухай хуульд:

- Онц байдал, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулах үйл явдлууд, байгалийн гамшиг, тэдгээрийн талаархи урьдчилсан мэдээлэл;
- Хүрээлэн байгаа орчин, эрүүл мэнд, эрүүл ахуй, боловсрол, соёл, хөдөө аж ахуйн байдал, түүнчлэн гэмт хэргийн нөхцөл байдал;
- Онцгой эрх, төрөөс иргэд, албан хаагч, байгууллага, аж ахуйн нэгжид олгож буй хөнгөлөлт, нөхөн төлбөр;
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа тухай баримт;
- ОХУ-ын валютын нөөц, алтны нөөцийн хэмжээ;
- Төрийн өндөр албан тушаалтны эрүүл мэндийн байдал;
- Төрийн байгууллага, түүний албан тушаалтны хууль бус үйлдлийн тухай мэдээллийг нууцалж болохгүй гэжээ.

Киргиз, Украин зэрэг улсын хуулиудад мөн ;дээрхитэй төстэй заалтууд оржээ. Туркменстанд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, түүнчлэн хувь хүний аюулгүй байдал, эрүүл мэндэд нь аюул учруулж болох мэдээллийг нууцад хамааруулж болохгүй гэж хуульчилсан байна. Орос, Туркменстаны хуулиар иймэрхүү төрлийн мэдээллийг төрийн нууц гэж үзсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр тусгасан байгаа нь хуулийн хэрэгжилтийг нэлээд өндөрсгөж байгааг харуулж байна. Казакстаны хуульд Төрийн албан тушаалтан, агентлагийн хууль бус үйл ажиллагаа буюу зүй бус үйлдэл, шударга ёсыг зөрчснийг нуун дарагдуулсан мэдээллийг нууцлахыг хориглосон байна.

Гүржид олон улсын гэрээ хэлэлцээр, мөн байлдааны зориулалттай тусгай газрын зургаас бусад газрын зураг төрийн нууцад хамааруулж болохгүйг заасан нэмэлт заалттай. Гүржид мөн Төрийн өндөр дээд албан тушаалтны эрүүл мэндийн байдал, авилга, албан тушаалтнуудын хууль бус үйлдэл, гэмт хэргийн нөхцөл байдлын талаархи мэдээллийг нууцалж болохгүй гэжээ.

ХБНГУ -д Мэдээллийн эрх чөлөөний хуулиар гол зохицуулалтаа хийгээд “хариуцлага”-ын талаар Эрүүгийн хуулиндаа тусгасан нь дэвшилттэй буюу аль болох нээлттэй байх

зарчмыг хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй болсныг судлаачид тэмдэглэдэг. ХБНГУ-ын Эрүүгийн хуулиар “Бие даасан, ардчилсан Үндсэн хуулийн журам болон олон улсын зэвсэгт хяналт тавих гэрээг зөрчсөн Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай гэрээ хэлэлцээр байгуулсан талуудаас нуун дарагдуулсан баримтуудыг төрийн нууцад хамааруулахгүй” гэж хуульчилжээ.

Германы “Мэдээллийн эрх чөлөөний хууль”-д задалж болохгүй мэдээллийн хүрээг заасан байдаг. Үүнд:

- Хэрэв мэдээллийг задалсан нөхцөлд олон улсын харилцаа, Германы Зэвсэгт хүчний цэргийн аюулгүй байдал, дотоодын болон гадаадын аюулгүй байдлын сонирхол, санхүүгийн монополийн эсрэг болон журамлах эрх бүхий газрын хяналт тавих үүрэг, гадаад санхүүгийн хяналтын асуудал, хууль бус гадаад худалдаанаас урьдчилан сэргийлэх гэсэн арга хэмжээ, одоо явагдаж буй хууль эрх зүйн үйл явц, хүн бүр шударга хуулийн үйлчилгээ авах эрх, ба эрүүгийн, засаг захиргааны болон сахилга батын холбогдолтой мөрдөн байцаалтын үйл ажиллагаа зэрэгт хохирол учрахаар байвал;
- Хэрэв мэдээллийг бусдад задруулснаар олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах бол;
- Хэрэв Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд нууцлах шаардлага тавьсан бол эсвэл Агентлагт итгэх итгэл буурах бол;
- Хэрэв тухайн мэдээлэл нь хуулийн зохицуулалтын эсвэл ангилсан мэдээллийн талаархи Материалын болон Байгууллагын Хамгаалалтын Ерөнхий Захиргааны Зохицуулалтын дагуу нууцад хамаарах эсвэл мэргэжлийн холбогдолтой болон тусгай албан ёсны нууцад хамаарах;
- Өөр төрийн байгууллагаас нэг удаа өөрсдийн үйл ажиллагаанаас гадуур мэдээлэл өгөхийг шаардах;
- Хэрэв мэдээллийг задалснаар нийгмийн даатгалын институтын эдийн засгийн сонирхол болон эдийн засгийн ажил хэрэгт холбогдох Холбооны засгийн газрын санхүүгийн сонирхлыг хөндөх бол;
- Нууц мэдээлэл авах, хүртэх гэсэн санал тавьж цуглуулсан үед гуравдагч талын нууцлалыг хадгалах сонирхол нь хүчин төгөлдөр байсан тохиолдолд;
- Холбооны Засгийн Газрын Тагнуулын газар, агентлагууд болон бусад төрийн агентлагууд Германы Аюулгүй Байдлын Актын 10 (3)–р зүйлд заасны дагуу гүйцэтгэж байгаа бол зэрэг болно.
- Харин дээр дурьдсанаас бусад бүх мэдээлэл нээлттэй, ил тод байдаг байна.

ОХУ, Туркменстан, Киргиз, Гүрж, Казакстаны хуулиудад нууцалж болохгүй мэдээллийн хүрээг тодорхойлсон нь, Украин, Казакстан улсын хуулиудад нууцад хамаарах мэдээлэл олж авах хүсэлт гаргах, нууц мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан нь манайд жишиг болохоор байна.

Нууцлах хугацаа

Судалж үзсэн улс орнуудын нууцын талаархи хуулиудыг авч үзэхэд, нууцлах хугацаа гэж хатуу тогтоогоогүй хуультай улс нь ОХУ, Туркменстан, Казакстан зэрэг бөгөөд эдгээр улсын хуулийн дэвшилтэй заалт нь 5 жил тутамд нууцад хамаарах эсэхийг шалгаж, зэрэглэлийг хянаж, шаардлагагүй гэж үзвэл ил болгодог байна. Харин Украин, Гүрж зэрэг улсад нууцлах хугацааг зэрэглэлээс хамааруулан Украинд 30 жилээс хэтрэхгүйгээр, Гүржид 20 жилээс ихгүй байхаар хуульчилсан байхад Монгол Улсад 60 хүртэл жилийн хугацаагаар зарим категоригийг байнгын нууц байхаар зохицуулжээ.

Судалгааны эмхтгэл, Х боть

Казахстанд баримт бичгийг нууцлах хугацааны хязгаар 30 жилээс хэтрэхгүй байхаар заажээ Гүржид: тусгайлан хөтөлсөн онц чухал баримт бичгийг 20 жил, маш нууц баримт бичгийг 10 жил, нууц баримт бичгийг 5 жил нууцлахаар заасан байна. Таджикстаны нууцын систем маш ээдрээтэй буюу 7төрлийн нууцлалын хугацаа заасан бөгөөд (гэхдээ л Монголын 10 заалтыг бодвол арай цөөн). түүнчлэн баримт бичгийг тодорхойгүй хугацаанд нууцлахыг нээлттэй зөвшөөрчээ. Украины хуулиар тусгайлан хөтөлсөн баримт бичгийг нууцын ангиллын хугацаа 30 жил, (маш нууц) 10 жил, (нууц) 5 жил хүртэл байна.

Ихэнхи орны тухайлбал, Казахстан, Туркменстан зэрэг улсын хууль тогтоомжийн давуу тал нь ангиллын хугацааг албан ёсоор тавихаас зайлсхийж, “Төр болон ард түмний ашиг сонирхол” эсвэл “Онцгой нөхцөлд” л байнга нууцлахыг зөвшөөрсөн байх бөгөөд харин бусад орны хууль тогтоомж нь нууцын ангиллын хугацаа дууссаны дараа нээлттэй болгох зарчим баримталдаг аж.

Нууцыг ил болгох

Гүрж, ОХУ-д төрийн нууцыг ил болгох үндэслэлийг тогтоосон байна. Үүнд:

- Олон улсын нөхцөл байдлын улмаас тухайн мэдээллийг ил болгохоор үүрэг хүлээсэн;
- Тухайн мэдээллийг нууцлах шаардлагагүй болсон;
- Тогтоосон хугацаа дуусгавар болсон зэрэг болно.

Манайд нууцын ангилалд хамаарах мэдээллийг ил болгох талаар Төрийн нууцын тухай Монгол Улсын хуулинд:

- цаашид нууцлах шаардлагагүй гэж үзэх нөхцөл байдал шинээр үүсэх
- ангилалын нууцлах хугацаа дууссах
- бусад үндэслэл гэж тодорхойлжээ.

Нууцын зэрэглэлд хамааруулсан мэдээллийг ил болгох ажиллагааг Засгийн газрын эрх мэдэлтнүүдэд хариуцуулбал (ялангуяа Улсыг аюулаас хамгаалах байгууллага) ямар ч баримт бичгийг нийтэд дэлгэдэггүй гэдгийг бусад орны туршлага харуулж байна. Улсыг аюулаас хамгаалах байгууллага нь угаасаа нууцыг хамгаалах нэрийн дор хүнд суртал гарган байнга нууцлахыг боддог аж.

Монгол Улсад Төрийн нууцын хуулиар нууцад хамаарах мэдээллийг хайж олох нь хариуцлага хүлээх үйлдэл байдаг бол Украин, Казакстан улсын хуулиудад нууцад хамаарах мэдээлэл олж авах хүсэлт гаргах, нууц мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан нь эх сурвалжтай холбоотой аливаа хэрэг маргаан дээр шүүх хуралдаан дээр үр дүнтэй ашиглагдаж болох ач холбогдол бүхий зохицуулалт гэж үзэж байна.

3.2 БНСУ (Өмнөд Солонгос улс)-ын зохицуулалт

Өмнөд Солонгос улсад Төрийн нууцтай холбоотой асуудлыг зохицуулдаг “Үндэсний аюулгүй байдлын тухай”, Төрийн байгууллагад байгаа мэдээллийг задруулах талаархи” зэрэг үндсэн 2 гол хууль үйлчилдэг.

Үндэсний аюулгүй байдлын хууль нь 1948 онд анх батлагдсан бөгөөд түүнээс хойш хэд хэдэн удаа өөрчлөлт орёон байна. Үндэсний аюулгүй байдлын хуулийн 3, 4 дүгээр зүйл нь “тагнуул”, “төрийн эсрэг” үйл ажиллагаа явуулах гэмт хэрэгт удаан хугацаагаар шоронд хорих, цаазаар авах ял оноохоор заасан, гэхдээ эдгээр нэр томъёо нь хуулиндаа маш бүдэг тодорхойлогддог төдийгүй, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө ямар нэг зөрчил гаргалгүйгээр хэрэгжүүлснийхээ төлөө хүмүүс ихэвчлэн хорих ял авдаг

байна. Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу “төрийн эсрэг” байгууллага гэдэг нь “тушаал гаргах, хяналт тавих бүтэцтэй, Засгийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилготой эсвэл төрийн үйл ажиллагаанд саад болохоор байгуулагдсан Солонгосын БНУ-ын гадна болон дотор байгуулагдсан нэгдэл, бүлэг” гэж тодорхойлогддог. Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу Хойд Солонгос нь улс гэгдэхээсээ илүү “төрийн эсрэг” байгууллага гэж тодорхойлогддог аж.

Төрийн байгууллагад байгаа мэдээллийг задруулах талаархи хууль нь 1996 онд батлагдаж, 1998 оны 1 дүгээр сард хүчин төгөлдөр болсон. Энэ хууль нь иргэдийг төрийн байгууллагад байгаа мэдээллийг авах хүсэлт гаргахыг зөвшөөрөх хууль зүйн баталгаа нь болж өгдөг.

Энэхүү хуулийн хүрээ нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой байгууллагын олж цуглуулсан, бий болгосон мэдээлэлд хамаарахгүй юм. 8 төрлийн ангилал байдаг бөгөөд үүнд: бусад актаар тодорхойлсон нууцууд, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, дипломат харилцаанд хохирол учруулж болох мэдээлэл, хувь хүн, өмч, олон нийтийн аюулгүй байдалд бодит гэм хор учруулж мэдэх мэдээлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаах талаарх мэдээлэл, аудит, хяналт шалгалтын мэдээлэл, засгийн газрын байгууллагын ажиллагаанд бодит бэрхшээл саад учруулж болох мэдээлэл, хувь хүний талаарх хувийн мэдээлэл, худалдааны болон олон нийтийн ашиг сонирхолд бодит хохирол учруулж болох худалдааны нууцууд, үл хөдлөх хөрөнгийн наймаа, бараа хураах зэрэг задруулбал хувь хүнд бодит хохирол учруулж болох мэдээлэл орно.

Агентлагууд нь мэдээллийг задруулах эсэхийг тодорхойлох, мэдээллийг задруулах асуудлыг хэлэлцэх хороог байгуулах ёстой. Төрийн байгууллагын задруулахыг хориглосон мэдээллийнх нь төлөө иргэд давж заалдаж болно.

Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу “төрийн нууц” гэдэг нь Хойд солонгост ашигтай байж болох ямар ч мэдээлэл орж болно гэж тодорхойлогдсон. Энэ томъёолол нь Өмнөд солонгосын шүүхэд маш өргөн хүрээнд тайлбарлагддаг аж. Олон нийтийн эзэмшилд хамаарч буй мэдээлэл нь “төрийн нууц” гэж шүүхэд тооцогдох бөгөөд энэ тайлбар нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нь зөрчиж, Өмнөд солонгост өргөнөөр тархаад буй бусад мэдээллийг дамжуулсныхаа төлөө хүмүүсийг хориход хүргэсэн Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу авч үзэх хэргүүдийн шалтгаан болоод байна шэж судлаач шинжээчид, Хүний эрхийн төлөө ажилладаг олон улсын байгууллагууд үнэлэлт дүгнэлт өгдөг.

4.1. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын зохицуулалт

Англи улсад Төрийн нууцын талаархи 1989 оны акт голлох үүрэгтэй үйлчилдэг. Энэхүү акт нь төрийн мэдээллийн тодорхой хэлбэрүүдийг хууль бусаар олж авах явдлаас урьдчилан сэргийлэх үндсэн зорилгын хүрээнд, мөн 1911 оны актын нэгэн хэсэг болсон арга хэрэгслээс бусад аргаар албан тушаалтан бусад этгээдүүд мэдээллийг эрх мэдэлгүйгээр задруулахаас урьдчилан сэргийлэх үндсэн агуулгыг багтаадаг. 1989 оны акт нь 1911 оны Төрийн нууцын талаархи актын 2 дугаар хэсгийн Шинэчлэлийн хүрээнд батлагдсан. бөгөөд үндсэн агуулга нь төрийн мэдээллийг дураараа (эрх мэдэлгүйгээр) задруулах явдал нь гэмт хэргийн шинжтэй болохыг тодорхойлсон.

Төрийн нууцыг илүү сайн хамгаалахын тулд энэхүү акт нь эрх мэдэлгүйгээр бичиг баримтыг задруулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах, төрийн албан хаагч болон Хатан хааны албан хаагчид үүргээ үл биелүүлэх, хууль бусаар бичиг баримтад хориг тавих нь гэмт үйлдлийн шинжийг бий болгох явдлыг бүрдүүлжээ.

1989 оны Төрийн нууцын актаар хамгаалагдсан мэдээллийн 4 ангилал байна. Үүнд:

- Аюулгүй байдал, тагнуултай холбоотой мэдээлэл



Судалгааны эмхтгэл, Х боть

- Батлан хамгаалахтай холбоотой мэдээлэл
- Олон улсын харилцаа, гадаад улс орон, олон улсын байгууллагаас ирсэн нууц, итгэмжит мэдээлэл
- Гэмт хэрэг, тусгай мөрдлөгийн бүрэн эрхтэй холбоотой мэдээлэл багтана.

Аюулгүй байдал, тагнуултай холбоотой мэдээлэл гэдэгт аюулгүй байдал, тагнуулын ажиллагаа, түүний нэг хэсэг, түүнд дэмжлэг үзүүлж буй ажил зэрэг нь хамаарна. Аюулгүй байдал, тагнуултай холбоотой мэдээлэлд эдгээр ажиллагаагаар болон дэмжлэг үзүүлж буй хүмүүс, бусад этгээдийн шилжүүлсэн болон тэдгээрт байгаа мэдээлэл хамаарна. 1989 оны Акт нь аюулгүй байдал, тагнуулын ажиллагаа гэж юу болохыг тайлбарлаагүй байдаг ч бичигдмэл хуулиар дараахи ажиллагааг оруулж болохоор заажээ. Үүнд: Аюулгүй байдлын ажиллагаа, Нууц тагнуулын ажиллагаа, Төв штабын Ерөнхий нийгэмлэгийн ажиллагаа багтана.

Батлан хамгаалахтай холбоотой мэдээлэл гэдэгт хэмжээ, хэлбэр, зохион байгуулалт, байлдааны тушаал, ажиллагаа, төрийн бэлэн байдал, Хатан хааны зэвсэгт хүчний сургалт; зэвсэг, хадгалалт, хүчний бусад зэвсэг, түрэмгийлэн эзлэлт, үүнтэй холбоотой судалгаа; батлан хамгаалах бодлого, стратеги, цэргийн төлөвлөгөө, тагнуул; дайны үед хэрэг болох үйлчилгээ, чухал хангамжийг дэмжих арга хэрэгсэл, төлөвлөгөө зэрэг багтана.

Олон улсын харилцаатай холбоотой мэдээлэл гэдэгт улс хоорондын, олон улсын байгууллага хоорондын, нэг болон хэд хэдэн улс хооронд, нэг болон хэд хэдэн олон улсын байгууллага хоорондын харилцааг агуулж, мөн өөр нэг улс, олон улсын байгууллагатай харилцаж буй Нэгдсэн вант улсын харилцаанд нөлөөлөх чадвартай олон улсын байгууллага, Нэгдсэн Вант улсаас бусад улстай холбоотой ямар нэг мэдээлэл хамаарахаар тодорхойлогдсон байна. Олон улсын байгууллага гэж зөвхөн улсууд л гишүүнээр элсдэг байгууллагыг ойлгох бөгөөд ийм байгууллагын ямар нэг салбарт мөн хамааралтай байна.

Гэмт хэрэг, тусгай мөрдлөгтэй холбоотой мэдээлэл гэдэгт эрх мэдэлгүйгээр задруулсан доорхи мэдээлэл хамаарна:

- Гэмт хэрэг үйлдсэний үр дагавар
- Хууль ёсны үйлдлээс гадуур өнгөрөхөд дэмжлэг үзүүлж буй арга хэрэгсэл
- Хууль ёсны хамгаалалтад буй хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх бусад үйлдэл, ажиллагаа
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сэжигтэй этгээдийг яллах, цагаатгахтай харшлах үйлдэл зэрэг болно.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь. 1989 оны Төрийн нууцын талаархи акт нь Хүний эрхийн Европын конвенцийн 10 дугаар зүйлээр хамгаалагдсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд хөндлөнгөөс оролцох явдлыг хуульчилсан. 10/2/ дугаар зүйлээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэрэгжилтийг дараахи байдлаар илэрхийлсэн байна.

Үүнд, “Хуулиар тодорхойлогдсон, гэмт хэрэг, эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахын тулд, бусдын эрх, нэр хүндийг хамгаалахын тулд, нууц итгэмжит мэдээллийг хамгаалахын тулд, шүүхийн шударга байдал, бүрэн эрхийг дэмжихийн тулд ардчилсан нийгэм, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, олон нийтийн аюулгүй байдалд шаардлагатай байх зорилгоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдал нь ял шийтгэл, хязгаарлалтууд, нөхцөл байдалд илрэлээ олж болно” гэж заажээ.

Төрийн нууцын Акт ба Мэдээллийн эрх чөлөөний тухай акт. Төрийн нууцын акт болон

Мэдээллийн эрх чөлөөний актын хоорондын харилцан нөлөөллийн үндсэн цэг нь 1989 оны Төрийн нууцын актын дагуу эн тэргүүний гэмт хэрэг гэж тодорхойлогдсон элемент болох мэдээллийг задруулахыг зөвшөөрөх утгыг илэрхийлнэ. Энэ нь мэдээллийн дээрхи 4 ангилалд орсон мэдээллүүдийг хэлж байгаа юм. Харин дараахи мэдээллийг задруулах нь Төрийн нууцын хуулиар хориглогдсон байна. Үүнд:

1. Аюулгүй байдлын ажиллагаа, түүний дагуу бий болсон мэдээллийг чөлөөлөх,
2. Үндэсний аюулгүй байдлыг батлан хамгаалах зорилгоор задруулахаас чөлөөлөгдөх шаардлагатай мэдээлэл,
3. Хатан хааны зэвсэгт хүчний аюулгүй байдал, үр нөлөөт байдал, хүчин чадал, колонийн хүчний хамтын ажиллагаа, Английн арлуудын батлан хамгаалалд хортой нөлөө үзүүлж болох мэдээллийг задруулахгүй,
4. Олон улсын харилцаанд хортой нөлөө үзүүлж болох мэдээллийг задруулахгүй,
5. Бусад улс, тодорхой олон улсын байгууллагаас ирсэн нууц итгэмжит мэдээлэл,
6. Тодорхой мөрдлөг, гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой мэдээлэл,
7. Хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл зэрэг болно.

5. Хувийн мэдээллийн нууцлалт

5.1. Канад улсын “Хувийн мэдээллийн хамгаалалт ба Электрон баримт бичгийн хууль

Канад улсын энэхүү хууль нь хувийн нууц мэдээллийг хамгаалах харилцааг зохицуулдаг. Уг хуулиар хувийн хэвшлийн байгууллагууд бизнесийн үйл ажиллагааны туршид хувь хүний (ажиллагсдынхаа) мэдээллийг хэрхэн цуглуулах, хэрэглэх болон дэлгэх (задлах) талаарх бүхий л харилцааг зохицуулдаг байна. Түүнчлэн энэхүү актаар электрон баримт бичгийг хэрэглэхэд тус дөхөм үзүүлэх харилцааг ч зохицуулдаг.

Европын холбоо нь “Канадын хувийн мэдээллийг хамгаалах хууль нь Европын иргэдийн хувийн мэдээллийг хамгаалахад ч шаардлага хангасан зүйн баримт бичиг” гэдгийг батлан хэлдэг. Уг хуулинд “Хувийн мэдээлэл” гэж чухам юу болохыг тодорхой заасан бөгөөд үүнд тухайн бие хүнийг таньж мэдэж болох бүхий л мэдээлэл багтана гэж томъёолжээ. Харин тухайн хүний нэр, эрхлэх ажил болон тухайн ажил олгогч байгууллагын бизнесийн хаяг, утасны дугаар тэрхүү мэдээлэлд хамрагдахгүй аж.

Хуулиар тухайн хүнд дараахи эрхийг олгосон байна. Үүнд:

- Яагаад байгууллага нь тухайн хүний талаарх мэдээллийг цуглуулах, хэрэглэх, ямар тохиолдолд дэлгэх (задлах) ёстойг мэдэх эрхтэй;
- Тухайн байгууллагаас хувь хүний талаархи мэдээлэл цуглуулах, хэрэглэх, дэлгэх (задлах) үйл ажиллагаа нь үндэслэлтэй, зүй ёсны байхыг шаардах болон тэрхүү мэдээллийг ямар нэгэн зорилгоор ашиглахгүй байх, тухайн хүний зөвшөөрсний үндсэн дээр хэрэглэх ёстойг шаардах эрхтэй;
- Тухайн байгууллагаас хэн гэдэг этгээд хувь хүний мэдээллийг хамгаалах үүрэг хүлээсэн болохыг мэдэх эрхтэй;
- Тухайн байгууллага нь хувь хүний мэдээллийг хамгаалахдаа нягт нямбай, иж бүрэн, орчин үеийн шаардлагад нийцсэн байдлаар зохион байгуулж буй эсэхийг шаардах эрхтэй;
- Шаардлагатай үед хувь хүний мэдээлэлд нэвтрэхдээ тухайн хүнээс зөвшөөрөл авах болон анхааруулга өгсөн эсэхийг асуух эрхтэй;
- Тухайн байгууллага хувийн нууцлалын эрхэд үл хүндэтгэсэн байр сууринаас хандсан тохиолдолд тэдний мэдээллийг хамгаалах талаар хяналт тогтоосон эсэх асуудлаар гомдол гаргах эрхтэй зэрэг болно.

Судалгааны эмхтгэл, Х боть

Хуулиар тухайн байгууллагад дараахь шаардлагыг тавьдаг. Үүнд:

- Хувь хүний мэдээллийг цуглуулах, хэрэглэх, дэлгэх (задлах)-дээ харилцан зөвшилцөх;
- Тухайн хүний хувийн мэдээллийг цуглуулах, хэрэглэх, түүнчлэн дэлгэх (задлах)-ээс гадна тухайн мэдээлэл ажил хэргийн салшгүй хэсэг учраас
 - Мэдээллийг хууль ёсны дагуу шударгаар цуглуулах
 - Хувь хүний мэдээллийн чиг шугам нь тодорхой, ойлгомжтой, хялбар байх зэрэг болно.

Канадын Стандартын Холбооны гаргасан “Хувь хүний мэдээллийг хамгаалах” загвар кодын үндсэн дээр цуглуулсан, хэрэглэсэн, ил болгох мэдээлэл нь хувь хүний зөвшөөрөлгүйгээр, хууран мэхлэх замаар ашиглагдахыг энэхүү хуулиар хамгаалдаг. Тухайлбал, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор мөрдөн шалгахтай болон аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудалд ч энэ нь хамаатай. Уг акт нь хуулийн этгээд бүрийг албан ёсоор бүртгэх болон заавал биелүүлэх заалтуудыг 1995 онд үүсэн байгуулагдсан Канадын Стандартын Холбооны гаргасан “Хувь хүний мэдээллийг хамгаалах загвар код /хэм хэмжээ/”-нд тулгуурлан хийгджээ.

5.2. Унгар улсын “Хувийн мэдээллийн хамгаалалт болон олон нийтэд мэдээллийг ил болгох” хууль, Баталсан он: 1992 (Act No LXIII of 1992).

Энэ хуулийн зорилго нь хүн бүр хувийн мэдээлэл болон нийтийн сонирхол бүхий мэдээлэлд нэвтрэхэд хяналт тавих, уг хуулийн дагуу санал болгосон тохиолдолд эсрэг байр суурь илэрхийлэх эрхийг баталгаажуулахад оршино.

Хувийн мэдээлэл гэдэгт нь жирийн хүнд холбогдох, хамаарах ямар нэгэн мэдээллүүд буюу тухайн хүнтэй хамааралтай мэдээллүүдээс татаж авсан дүгнэлт, магадлагаа хамаарна. Үүнийг “Data subject” буюу мэдээллийн субъект гэж нэрлэдэг. Тухайн байдалд, мэдээллийн субъект нь түүний хувийн шинж чанарыг нь хадгалсан дата-гаар хамгаалагдана

Мэдээллийн тусгай нэр төрөл гэдэгт:

- а/ үндэсний цөөнхийн гарал үүсэл, яс үндэс, эсвэл үндэсний цөөнхийн талаархи эх сурвалж, улс төрийн үзэл бодол, улс төрийн намын гишүүнчлэл, шашин шүтлэг эсвэл шашны талаархи итгэл үнэмшил (сүсэг);
- б/ Эрүүл мэнд, эмгэг дон, бэлгийн чиг баримжаа (sexual life) болон гэмт хэргийн ял шийтгэл зэрэг нь хамаарагдана.

Олон нийтэд хамаарал бүхий мэдээлэл гэдэгт нь хувийн мэдээллээс гадна төрийн болон засаг захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын боловсруулсан мэдээллүүд (дата өгөгдлүүд) хамаарна.

Өгөгдлийн боловсруулалт (data processing) гэдэгт түүвэр, дуу бичлэг, санах байгууламж, үйл явц (процесс), ашиглалт (дамжуулалт болон илрүүлэлт хамаарна) болон хувийн мэдээллийн устгасан хэсэг, үйл ажиллагааны (procedure) анхаарал татахааргүй хэсэг зэрэг хамаарна. Мэдээллийн өөрчлөлт болон тэдгээрийг ирээдүйн хэрэглээнээс урьдчилан сэргийлэх мөн энэ хэсэгт хамаатай.

Хувийн мэдээллийг хамгаалах үйл явц нь доорхи зарчмын дагуу явагддаг. Үүнд:

Хувийн мэдээллийг үл боловсруулна. (Байгаагаар нь хадгална)

а/Мэдээллийн субъект зөвшөөрсөн байна.

б/ Бусад хууль, тухайлбал нутгийн өөрөө удирдах ёсны хуулийн тодорхой зүйл

заалтаар зөвшөөрөгдсөн байна.

Доорхоос бусад мэдээллийн төрөлд боловсруулалт хийхгүй.

а/Мэдээллийн субъект нь өөрөө хүлээн зөвшөөрч бичсэн байна.

б/Олон улсын гэрээг дээдлэх үүднээс эсвэл Үндсэн хуулиар олгогдсон суурь эрхийг баталгаажуулах, мөн Үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн мөрдлөг болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд

в/Хуулиар зохицуулагдсан бусад зүйлс зэрэг болно.

г/Тусгайлан тодорхойлсон ангиллын хувийн өгөгдлийг ил болгохыг нийтийн (улсын) эрх ашгийн үүднээс хуулиар зохицуулах боломжтой. Бусад бүх тохиолдолд, ийм өгөгдлийг ил болгохдоо зөвшөөрөл авах шаардлагатай, эсвэл бичгээр зөвшөөрөгдсөн тусгай ангиллын өгөгдөлд хамаарах ёстой. Хэрэв эргэлзээтэй бол ийм зөвшөөрөл байхгүй гэж үзнэ.

д/Нийтийн өмнө зарлаж мэдээлсэн болон өөрөө ил болгох зорилгоор тавьсан хувийн өгөгдөлд тусгай зөвшөөрөл хэрэггүй.

е/Өгөгдлийн эзний хүсэлтийн дагуу хамааралтай өгөгдлийг боловсруулахыг зөвшөөрнө. Түүнд ингэнэ гэдгийг мэдүүлбэл зохино зэргээр зохицуулсан байна.

АНУ-ын “Онлайн дахь хүүхдийн хувийн нууцыг хамгаалах хууль”

Хүүхэд гэж 13 наснаас доошхи хувь хүнийг ойлгоно. Хуулийн зохицуулалт нь мэдээллийг хамгаалахын хажуугаар мөн нийтэд ил болгох үйл ажиллагааны хүрээнд явагдана. Хамгаалах тохиолдол, ил болгох тохиолдлыг тодорхой зааглаж, хуульчилсан байдаг. Ил болгох, илчлэх нь хувийн мэдээллийг хамгаалахтай салшгүй холбоотой гэдэг агуулга нь энэ хуулийн гол зарчим юм. Ямар нэгэн хууль бус үйл ажиллагааны хүрээнд, хуулиар зохицуулсан зүйлээс гажин хувь хүний мэдээллийг ил болгохыг энэ хуулиар бүрэн хориглосон.

Хувийн мэдээлэл гэдэгт тухайн хүүхдийн эцгийн /эхийн/ болон өөрийн нэр, гэрийн болон тухайн хүний харьяалагдах хаяг: хот, тосгон, гудамжны нэр, электрон шуудангийн хаяг, утасны дугаар, нийгмийн даатгалын дугаар /Social Security number/, хүүхэд болон эцэг эхэд хамаарах онлайн дээрх вэб сайт, чаат, ялгарах шинж тэмдэг зэрэг мэдээллүүд хамаарагдана. Мэдээллийг хамгаалах ажиллагааг хуулийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн тусгай оператор гүйцэтгэдэг.

Хувийн мэдээллийг ил болгоход хориглох зүйл:

1/ Оператороос ангид, цахим хуудасны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа хүнд өгсөн мэдээлэл болон тэрээр өөр бусад алив зорилгоор тухайн мэдээллийг ил болгох, эсхүл хэрэглэхээс бусад алив зорилгоор операторын тодорхой хэлбэрээр хүүхдээс цуглуулж авсан хувийн мэдээллийг гаргах;

2/ цахим хуудсаар, эсвэл хүүхдүүдэд чиглэсэн он-лайн үйлчилгээгээр дамжуулан хүүхдээс авсан болон уг мэдээллийг хүүхдээс авсан гэдгийг тухайн үед мэдэж байсан, мөн мэдээлэл нь нийтийн жагсаалтын тараалтыг оролцуулан Интернэтийн сувгийн ямар нэгэн тодорхой хэлбэрээр нийтэд хүртээмжтэй байсан хувийн мэдээллийг үүсгэх Үүнд:

- вэбсайтын нүүр хуудас,
- захидлаар харилцагч найзын үйлчилгээ
- электрон шуудангийн үйлчилгээ
- мэссэж (message board)
- хөөрөлдөх өрөө (a chat room) зэрэг нь хамаарна.

6. Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой байгууллагуудын зохицуулалт

6.1. Словак улсын Үндэсний Зөвлөлийн хууль 1993 оны 1-р сарын 21-нд батлагдсан. 1995, 1998, 1999, 2002, 2003 онд уг хуулинд нэмэлт өөрчлөлтүүд хийж байжээ.

Энэхүү хууль Словак улсын Мэдээллийн алба /Information service/-ны үйл ажиллагааг зохицуулдаг. Дээрх хуулийн дагуу Мэдээллийн алба нь Словак улсын төрийн байгууллага бөгөөд Үндсэн хуулийн бүтэц, нийтлэг хэм хэмжээ болон улсын аюулгүй байдалтай холбоотой зарим асуудлыг хамгаалах үүрэгтэй ажилладаг.

Мэдээллийн албаны үүрэг зорилго нь нэгдүгээрт, доорхи мэдээллүүдийг цуглуулах, бүрдүүлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд оршдог. Үүнд:

- Үндсэн хуулийн бүтэц, газар нутгийн бүрэн бүтэн байдал, Словак улсын бүрэн эрхт байдалд заналхийлсэн үйл ажиллагаа;
- Словак улсын аюулгүй байдлын эсрэг шууд үйл ажиллагаа;
- Гадаадын тагнуулын байгууллагын үйл ажиллагаа;
- Зохион байгуулалттай гэмт хэрэг болон терроризм;
- Словак улсын эдийн засагт учруулах ноцтой сүрдүүлэг, заналхийлэл;
- Улсын нууцтай холбоотой мэдээллийг задруулсан байдал зэрэг болно.

Хоёрдугаарт, энэхүү алба нь Словак улсын Үндсэн хуулийн бүтэц болон аюулгүй байдлын эсрэг хилийн чанадад өрнөж буй үйл ажиллагааны талаархи мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн Словак улсын (хүлээн зөвшөөрөн нэгдсэн) газар нутаг дээр олон улсын гэрээ хэлцэл болон түүнтэй дүйцэхүйц хууль журмыг биелүүлэх үүрэгтэй.

Мэдээллийн алба нь Словак улсын Үндэсний зөвлөл, Словак улсын Ерөнхийлөгч болон Словак улсын Засгийн газрын үйл ажиллагаа болон шийдвэр гаргахад олон талт ач холбогдол бүхий мэдээллээр хангах үүргийг хүлээн ажилладаг. Түүнчлэн бусад төрийн байгууллагаас холбогдох үндсэн чухал мэдээлэл авах эрхтэйгээс гадна тэдгээрт Үндсэн хуулийн болон хууль бус үйл ажиллагаа явуулж болохгүйг шаардах сануулах эрхтэй байдаг. Мөн бусад улс орны ижил үүрэг, зорилго байгууллагатай хамтран ажиллах итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага юм

5.2. Серби улсын “Аюулгүй байдлын мэдээллийн агентлаг”-ийн хууль, Батлагдсан он: 2002.

Хуулиар Аюулгүй байдлын мэдээллийн агентлаг нь хараат бус байгууллага юм. Энэхүү агентлаг нь Серби улсын аюулгүй байдал, Серби улсын Үндсэн хуулийн хэм хэмжээг зөрчин үймүүлэх, нийгмийг эмх замбараагүй байдалд оруулах, нууцаар хорлох, сүрдүүлэх, заналхийлэх, айлган сүрдүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, Серби улсын аюулгүй байдалтай холбогдох аюулгүй байдлын тагнуулын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын асуудлуудыг хариуцдаг улсын байгууллагууд болон хуулиар бусад үүрэг хариуцлага нь тодорхойлогдсон байгууллагуудад албан мэдээлэл хүргэх зэрэг үйл ажиллагаа явуулна.

Холбогдох хууль болон бусад хэм хэмжээний дагуу эрх мэдэл бүхий байгууллага тухайн агентлагын үйл ажиллагаанд хяналт тавина. Агентлагын үйл ажиллагааны хүрээ нь эрх мэдэл бүхий улсын институт, байгууллага болон үйлчилгээний байгууллагатай хамтран, холбоотой ажиллахаар хязгаарлагддаг. Харин Серби улсын Засгийн газрын зөвшөөрлийн үндсэн дээр мөн Серби улсын аюулгүй байдлын тагнуулын бодлогын дагуу бусад орны

институт болон үйлчилгээний байгууллага, олон улсын байгууллагатай харилцаа холбоо тогтоон ажилладаг.

7. Мэдээллийн аюулгүй байдал–мэдээлэл авах эрхийг хангах тухайд

Дэлхийн олон улс орон мэдээллийн эрх чөлөөг Үндсэн хуулиараа баталгаажуулан, уг эрхээ эдлэх бодит механизмыг хангаж чадахуйц практик ач холбогдолтой бие даасан хуулиудыг батлан гаргасан байна. Одоогоор дэлхийн 60 гаруй орон иргэдийнхээ мэдээлэл олж авах эрхийг хуульчлан хэрэгжүүлж байгаагийн 40 нь 1992 оноос хойш, 20 нь 2000-2003 онд, үлдсэн нь түүнээс хойш батлагджээ. Ялангуяа манайхтай ижил ардчиллыг шинээр сэргээн тогтоож, хөгжүүлж яваа Болгар, Чех, Словак, Албани, Гүрж, Эстони, Латви, Киргыз гээд бараг ихэнхи орон ийм хуультай болжээ.


ОХУ “Мэдээлэл, мэдээжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль”-даа албан тушаалтнуудыг иргэдэд мэдээлэл өгөх үүргийг ногдуулсан байна. Улс орнууд ийм хууль тогтоомжийг батлахдаа олон улсын хэм хэмжээнд аль болох нийцүүлэхийг эрмэлзэж байна.

Йоханнесбургийн Олон улсын зарчим

- Төрийн байгууллагад хадгалагдаж буй мэдээлэл нь олж авахад хялбар, нээлттэй байх ёстой бөгөөд дээд зэргээр нээлттэй байх нь хуулийн үзэл баримтлалын гол цөм байна
- Төрийн байгууллагууд нь чухал мэдээллийг хэвлэн нийтэлж байх үүрэгтэй
- Төрийн байгууллагууд нээлттэй засаглалыг идэвхийлэн дэмжих ёстой
- Мэдээллийн хязгаарлалт нь маш ойлгомжтой, нарийн тодорхойлогдсон байна Засгийн газар, түүний байгууллагууд өөрийн буруутай үйлдлийг нуун дарагдуулахын тулд иргэдийн мэдээлэл олж авахад саад тотгор болох зүйлийг хуульчилж болохгүй. Гагцхүү нийгэмд ноцтой хор хохирол учруулах нөхцөлд л мэдээлэл өгөхөөс татгалзаж болно
- Иргэдийн мэдээлэл олж авах үйлдлийг хөнгөвчилсөн байх ёстой. Төрийн байгууллагууд иргэдийн мэдээлэл олж авах эрхийг бүрэн хангаж чадахуйц дотоод тогтолцоог бий болгох шаардлагатай
- Хувь хүмүүс мэдээлэл олж авахын тулд өндөр төлбөр төлөх ёсгүй
- Төрийн байгууллагын хурал хуралдаан олон нийтэд нээлттэй байх ёстой. Хаалттай хуралдаан зохион байгуулах тухай шийдвэр олон нийтэд нээлттэй байна.
- Дээд зэргээр нээлттэй байх зарчимд харшилсан, зөрчилдсөн хуул тогтоомжийг өөрчлөн сайжруулах ёстой. Дэлхийн улс орнуудад Мэдээллийн эрх чөлөөний хууль нь мэдээлэл, нууцтай холбоотой бүх хуулийн тулгуур хууль байдаг бөгөөд бусад хуулийн заалт нь гол хуультайгаа зөрчилдөхгүй байх зарчмыг баримталдаг байна.
- Гэм буруутай үйлдлийн тухай мэдээлэл түгээсэн иргэн-мэдээлэгчийг хамгаалах ёстой. Гэм буруутай үйлдэл гэдэгт гэмт хэрэг үйлдэх, хууль ёсны үүргээ зөрчих, шударга ёсыг хөсөрдүүлэх, авилгад өртөх, төрийн байгууллагын үйл ажиллагааг завхруулах зэргийг багтаан ойлгодог аж.

8. Мэдээллийн аюулгүй байдал-нууц эх сурвалжийг хамгаалах тухайд

Энэхүү асуудал нь өнгөц харахад Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн асуудал мэт байвч цаанаа олон нийтийн эрх ашигт нийцсэн, бүр цаашлаад Үндэсний аюулгүй байдал, тэр дундаа мэдээллийн аюулгүй байдалтай холбогдоно.



Нууц эх сурвалжийг хамгаалах нь

Олон нийт, улс орны эрх ашигт хохирол учруулахуйц үнэ цэнэ бүхий мэдээллийг ил гаргасан эх сурвалжийг нууц эх сурвалж гэдэг. Олон нийт, улс орны эрх ашигт хохирол учруулахуйц үнэ цэнэ бүхий мэдээллийг ил гаргасан эх сурвалжийн ажил, аюулгүй байдал, гэр бүлийг эрсдлээс сэргийлж сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага тухайн эх сурвалжтай холбоотой нэр, ажил, албан тушаал зэрэг мэдээллийг зориудаар нууцалдаг. Энэ бол эх сурвалжаа эрсдлээс сэргийлсэн хамгаалалт юм.

Европын конвенцийн дагуу Европын шүүхийн жишиг улс орнуудын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн хэм хэмжээгээр мөн зохицуулдаг. Европын Хүний эрхийн шүүх нь нууц эх сурвалж бол “хэвлэлийн эрх чөлөөний нэг үндсэн нөхцөл” бөгөөд түүнд халдах нь буруу үйлдлийг өөгшүүлэх “цэвдэг хүйтэн зүйл” хэмээн үзэж, эх сурвалжийг хамгаалах асуудалд хатуу тууштай байдаг. Эх сурвалжаа хамгаалах нь ямар ч эрх ашгаар хязгаарлагдахгүй гэсэн ойлголт.

Гүржийн “Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль”, Мексик, Францын “Эрүүгийн хууль”, Индонез, Мозамбик, Туркийн “Хэвлэлийн хууль”-иудад “Мэргэжлийн нууцын эх сурвалж үнэмлэхүй байдлаар хамгаалагдсан байх бөгөөд түүнийг задруулахыг хэн ч шаардах эрхгүй. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон шүүх хурлын явцад нууц мэдээллийн эх сурвалжийг задруулахыг хэнээс ч болов шаардах ёсгүй” гэсэн байдлаар хуульчилдаг.

Хязгаарлалт тавих, эх сурвалжийг нэрлэхийг шаардсан шийдвэрийг зөвхөн хуульд нарийвчлан томъёолж заасан үндэслэлээр зөвхөн ардчилсан нийгмийн ашиг сонирхлын үүднээс шүүхээс гаргахыг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ эх сурвалжийг нэрлэхийг шаардсан шийдвэр гаргах эрхийг шүүх хязгаарлалтгүйгээр эдлэх нь бас ардчилсан засаглалыг хөгжүүлэх зорилгод нийцэхгүй.

Шүүхийн эрх мэдлийг хатуу тогтоогоогүй тохиолдолд эх сурвалжаа нэрлэхгүй байх үндэслэлээ тайлбарлах дарамт сэтгүүлчдэд ирсээр байх болно. Бельги, Герман, Филиппин, Армени, Финляндад эх сурвалжийн нууцыг задруулахаас татгалзах эрхийг сэтгүүлчдэд олгосон байдаг боловч тухайн тохиолдлоос хамаарч тодорхой шалгуур, дэг журмын дагуу эх сурвалжийг задруулах шийдвэр гаргах шаардлагыг хуульд тусгайлан заасан байдаг байна.

Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах шалгуур үзүүлэлт, сэтгүүлчийн эрх:

Бельги улсын “Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах тухай” (хуулиар бол сэтгүүлчид болон редакцийн зөвлөлийн гишүүд нь дараахь 4 нөхцөл байдалд шүүхийн эрх бүхий албан тушаалтны шаардлагын дагуу мэдээллээ илчлэхээс татгалзах эрхтэй)

- Хэрэв эх сурвалжийн бодит, жинхэнэ, байдлыг илчилж болох мэдээлэл байвал;
- Хэрэв тухайн мэдээллийн эх үүсвэр, мөн чанарыг илчилж болохоор мэдээлэл байвал;
- Хэрэв видео хэлбэрээр харагдах бүтээл болон текстийн зохиогчийн жинхэнэ байдлыг нь илчилж болохоор мэдээлэл байвал;
- Илчлэх явдал нь мэдээлэл болон бичиг баримтыг илрүүлж болохоор бол зэрэг болно.

Англи улсын 1998 оны Дата (өгөгдөл мэдээллийг) хамгаалах тухай актын 10 дугаар зүйлд “Сурвалжлагчийн дуугүй байснаас үүдэн Үндэсний аюулгүй байдал, гэмт хэргийн илрүүлэлт, түүнээс урьдчилан сэргийлэх ажил шударга ёсны эрх ашигт аюул занал учруулахаас бусад тохиолдолд сэтгүүлчийг нууц мэдээллээ илчлэхийг албадах ёсгүй” гэж заажээ. Түүнчлэн шүүх болон захиргааны эрх бүхий албан тушаалтны өмнө гэрчээр дуудагдсан хэвлэгчид,

хянагчид, сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг ажилтнууд нь мэдээллийн эх сурвалж, дэмжигч, зохиогч, тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээ илрүүлэхтэй холбоотой асуултуудад хариулахаас татгалзах эрхтэй” гэжээ.

Дараах 4 шалгуурыг хангасан гэдгийг баталж чадахгүй бол нууцлах эрхийг нь шүүх хүлээн зөвшөөрч болно гэж үздэг. Үүнд:

- Харилцаа холбоо нь илчлэхгүй байх талаархи итгэл дээр суурилагдсан байх ёстой
- Энэхүү итгэлцэл нь талуудын хооронд өрнөж буй харилцаанд маш чухал ач холбогдолтой байх ёстой
- Хоорондын харилцаа нь дэмжлэг үзүүлсэн харилцаа байх ёстой
- Илчилснээс үүдэн харилцаанд нь бий болсон уршиг нь маргаанд хүргэж болох зүйлээс ч илүү байх ёстой зэрэг болно.

Сэтгүүлчийн үйл ажиллагаа явуулж буй сэтгүүлч болон бусад хүмүүс сэтгүүлчээр ажиллаж байхдаа олж цуглуулсан мэдээлэл болон факттай нь холбоотой шүүх хуралд гэрчээр оролцохыг шаардаж болохгүй. Эдгээр хүмүүст мэдээллийн эх сурвалжаа хэлэхээс татгалзах эрх бий.

Сэтгүүлчийн нууц эх сурвалжаа илчлэх эрхийг хязгаарлах үндэслэлүүд:

Шүүхээс дараахи 3 онцгой тохиолдолд эх сурвалжаа илчлэхийг сэтгүүлчээс болон редакцийн зөвлөлөөс шаардаж болдог.

- Нэг буюу түүнээс дээш хүний бие махбодод ноцтой аюул учруулах гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл бол
- Шаардсан мэдээлэл нь тэдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой бол
- Шаардсан мэдээлэл нь өөр арга замаар олж авч чадахааргүй бол зэрэг болно.

Мэдээллийг илчлэх нь дараахь тохиолдолд хууль ёсны болдог. Үүнд:

- Тухайн эх сурвалжаас зөвшөөрөл өгсөн
- Энэ зүйлийн дагуу олон нийтэд илүү ач холбогдолтой байх зорилгоор мэдээллээр хангасан бол
- Илчлэх нь зайлшгүй шаардлага, зорилгоор хийгдсэн бол
- Эрүү, иргэний хэрэг шүүх ажиллагааны зорилгоор илчилсэн бол
- Илчлэх нь нийтийн ашиг сонирхолд шаардлагатай бол зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Манай Улсын хувьд Мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг цогцоор нь авч үзэн, эрх зүйн орчныг төгс бүрдүүлэх нь тулгамдсан асуудлуудын нэг болжээ. Мэдээллийн аюулгүй байдлын талаархи эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ уг судалгаанд дурьдсан олон улсад баримталж буй хэм хэмжээ, зарчмыг мөрдлөг болгох нь чухал юм. Тэдгээр зарчим нь мэдээллийг нууцлахдаа иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг боогдуулах замаар хийж болохгүй гэсэн гол агуулга дээр үндэслэгддэг. Мөн мэдээллийн эрх чөлөө нь нээлттэй төрийн бодлогыг олон нийтээр дэмжих, хянах, шийдвэрт иргэдийн оролцоог дээдлэх гэсэн үндсэн гол санаан дээр тулгуурладаг.

Мэдээллийн аюулгүй байдал нь хувь хүн, иргэн, байгууллага, хамт олон, төрийн нэгдмэл цогц үйл ажиллагааны үндсэн дээр тогтдог гэдэг чухал зарчмыг мөн хадгалах нь чухал юм.



Мэдээллийн аюулгүй байдал нь дан ганц улс орны хэрэг биш нийт дэлхийн улс орнуудын хамтын идэвхтэй үйл ажиллагааны үндсэн дээр оршино гэдэг нь өнөөгийн эрх зүйн орчны бүрдэл, түүний хэрэгжилтийн бас нэг чухал хүчин зүйл нь болох учиртай.

Мэдээлэл технологийн өндөр хурдацтай хөгжлийн энэ үед хувь хүний мэдээллийг нууцлах, түүний хадгалалт хамгаалалт, олон нийтийн эрх ашгийн үүднээс ил болгох зэрэг асуудлыг цогцоор нь шийдэх нь бас нэг чухал асуудал юм.

Нийтэд нь дүгнэхэд, мэдээллийн аюулгүй байдал гэдэг дан ганц нууцлах гэсэн зарчим дээр тогтвол хүний язгуур эрх, эрх ашиг зөрчигддөг учраас нууцлал, нууцалсан мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлах хязгаар, цаг хугацаа зэргийг төгс зохицуулж, олон нийтийн мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах, хүртэх, тараах, түгээх эрх, эрх чөлөөнд ямагт хүндэтгэлтэй хандах учиртайг энэхүү судалгаанд хамрагдсан улс орнуудын эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалт харуулж байна.

* * *

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- “Нууцлагдсан мэдээллийн хамгаалалтын талаархи хууль”, Болгар, 2002
- “Словак улсын Үндэсний Зөвлөлийн хууль”, Словак
- “Хувийн мэдээллийн хамгаалалт болон олон нийтэд мэдээллийг ил болгох хууль” Унгар,
- “Хувийн мэдээллийн хамгаалалт ба Электрон баримт бичгийн хууль”. Канад, 2002
- “Аюулгүй байдлын мэдээллийн агентлагийн хууль”. Серби, 2002
- “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”, БНСУ
- “Хүүхдийн онлайн дахь нууцыг хамгаалах хууль”. АНУ, 1998
- “Датаг хамгаалах тухай хууль” Англи, 1998
- “Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”, Швед
- “Хэвлэлийн хууль”. ХБНГУ
- “Мэдээлэл, мэдээжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль”. ОХУ
- “Олон улсын хэм хэмжээ тогтоосон “Олон нийтийн мэдэх эрх: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хууль тогтоомжийн зарчим”. 19-р зүйл байгууллага, Лондон, 1999
- “Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн загвар”, 19-р байгууллага, Лондон, 1999
- “Йоханнесбургийн зарчим: Үндэсний аюулгүй байдал, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэл хүртэх тухай”. Лондон, 1995
- “Төрийн нууц ба Мэдээллийн эрх чөлөө”. “Глоб интернэйшнл” ТББ, УБ, 2006
- “Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах нь”, Ронан Бради. 2004
- “Төрөөс мэдээлэл хэрхэн олж авах вэ”, “Глоб Интернэйшнл” ТББ, “ННФ”, 2007
- “Кибер довтолгооны эсрэг хариу үйлдэл хийх үндэсний төв”-ийн тэргүүн, доктор Т. Халтарын судалгаа, нийтлэлүүд



МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ*Б. Мөнхцэцэг***Монгол Улсад далай ашиглах эрх зүйн орчин бүрдсэн байдал:**

Монгол орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд оноос эхлэн манай улс далайд гарцгүй орны хувьд Төрийнхөө далбааг мандуулсан хөлөг онгоцоор далайн олон улсын худалдаа, тээврийн үйл ажиллагаанд оролцох, далайн нөөц баялагийг ашиглах зорилго тавьж сүүлийн жилүүдэд зарим үр дүнд хүрчээ. Монгол Улсын Төрийн далбааг мандуулсан гадаад улсын хөлөг онгоцууд далайн олон улсын худалдаа, тээврийн үйл ажиллагаанд оролцож эхэлсэн байна.

1996 онд Монгол Улсын Засгийн газрын 316 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомт хотоор зарлаж, далайн баялаг ашиглах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад үүрэг болгосон юм.

Үүний дагуу 1999 онд “**Далай ашиглах тухай**” хуулийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлж батлуулсан байна. Энэ хуульд Монгол Улсын Далайн хэрэг эрхлэх газар буюу Далайн захиргааг байгуулах тухай асуудлыг тусгасан боловч тэр үеийн улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн байдлаас хамаарч шийдвэрлэгдээгүй байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1999 онд Далай ашиглах хуулийг хэрэгжүүлэх тухай Засгийн газрын 136 дугаар тогтоол гарч, Дэд бүтцийн хөгжлийн яамны /хуучин нэрээр/ орон тоо, төсөвт багтаан Монгол Улсын Хөлөг онгоцны бүртгэлийн боомт байгуулахыг Дэд бүтцийн хөгжлийн сайдад үүрэг болгожээ. Засгийн газрын энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх Дэд бүтцийн хөгжлийн сайдын 241 дүгээр тушаал гарч, Монгол Улсын Хөлөг онгоцны бүртгэлийн боомт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто тээврийн газарт байгуулагдсанаар Монгол Улсын Далайн захиргааны үндэс суурь тавигдсан түүхтэй

Далай ашиглах тухай хуульд 2007 онд зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулж, УИХ-аар хэлэлцүүлж батлуулснаар Монгол Улсын Далайн захиргаа албан ёсоор байгуулагдсан байна. Монгол Улс олон улсын гэрээ конвенциор хүлээсэн үүргээ биелүүлж далайн салбараа удирдлагаар хангах Үндэсний далайн байгууллагатай болж, дотоодын усан замын тээвэр болон далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, салбарыг хөгжүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, судалгаа хийх үндсэн үүрэгтэй ажиллаж байна

Далайн тээврийн салбарын эрх зүйн өнөөгийн нөхцөл байдал⁷

Монгол Улс нь 1996 онд НҮБ-ын дэргэдэх салбар нэгж болох Олон Улсын далайн байгууллага (ОУДБ)-д гишүүнээр элсэж орсон бөгөөд тус байгууллагаас гаргаж буй дүрэм журам, эрх зүйн баримт бичгүүдийг зохих журмын дагуу дагаж мөрдөн ажиллаж байна. УИХ-аас 1999 онд “Далай ашиглах тухай” хууль батлан гаргаснаас гадна НҮБ болон Олон Улсын Далайн Байгууллагаас баталсан 11 конвенци болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлт болох 10 гаруй протокол нийт 21 олон улсын гэрээнд нэгдэн орох баримт бичгийг батлан гаргаж далайн тээврийн салбарын эрх зүйн орчин бүрдснээр Монгол Улсын Засгийн Газраас 2003 онд “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх тухай” журам батлагдснаас гадна тус салбарын үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улс 1976-2008

⁷ Монгол Улсын Далайн захиргааны дарга Д. Галсандондогийн УИХ -ын ТГ -ын Судалгааны төвд ирүүлсэн албат тоот

онуудад Олон Улсын Далайн Байгууллага (ИМО) болон бусад олон улсын байгууллагаас гаргасан 21 конвенцид нэгдэж ороод байна. /Хавсралт 1/

Өнөөдрийн байдлаар далайн тээврийн салбарыг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд гадаадын эзэмшилтэй хөлөг онгоцыг бүртгэх үйл ажиллагааг Сингапур улс дахь Монгол-Сингапурын хамтарсан компани дээр Далайн захиргааны удирдлагын дор зохион байгуулж, Монгол Улсын далбаан дор аялуулах, хөрш зэргэлдээ БНХАУ-ын Тяньжин, Жиньзоу, Дандун боомт, ОХУ-ын Владивосток чиглэлийн боомтууд, гуравдагч орнууд болох БНАСАУ-ын Ражин боомт, БНСУ-ын Похань, Донхэ, Инчон зэрэг боомтуудтай хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулж, яриа хэлэлцээр хийх, далайн тээврийн салбарт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна. Монгол Улс далайгаар тээвэрлэсэн ачааныхаа даацаар ОУДБ-ын гишүүн 169 орноос 60 дугаар байранд ордог байна.

Далайд гарцгүйгээс үүдсэн бэрхшээлүүд:

Далайд гарцгүй газар зүйн байршлын хувьд алслагдмал байдал нь хөрш болон далайн эргийн орнуудын худалдаа, тээврийн тогтолцооноос хамааралтай байдаг. Далайд гарцгүй газар зүйн байршил нь дэлхийн эдийн засаг болон нийгмийн интеграцчилалд оролцох оролцоо болон улс орны өсөлт, хөгжилтөд нь хүндрэл учруулж дамжин өнгөрөгч орнуудаас хамааралтай байх нь олон улсын худалдаа хийх зардлыг өндөрсгөн, улмаар тухайн бүс нутаг дахь дэд бүтцийг ашиглан дөрөөлж хөгжих боломжийг хязгаарлаж байдаг. Мөн далайд гарцгүй орнуудын олон улсын худалдаанд оролцох нөхцөл хязгаарлагдмал юм.

Монгол улсын хувьд, газар зүйн байршлынхаа улмаас дэлхийн гол гол зах зээлүүдээс хол зайтай оршдог, худалдаа хийхэд гарах тээврийн өртөг зардал өндөр байдаг зэрэг саад бэрхшээлтэй тулгарсаар ирсэн орон. Монгол улсын импортын бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд гарах зардал дамжин өнгөрөгч орнууд болон Чех, Словак, Польш зэрэг Европын далайд гарцгүй орнуудтай харьцуулахад өндөр байгаа юм. Хөгжиж байгаа далайд гарцгүй орнуудын гадаад худалдааны үнэ өртөг өсөн нэмэгдэхэд нөлөөлдөг хамгийн гол хүчин зүйл хил, импортын тарифаас илүүтэйгээр гаалийн процедур болон тээврийн асуудал юм.

Бодлогын хувьд анхаарах асуудал ⁸

1. Далайн баялаг ашиглах үүднээс загас агнуурын квот эзэмших зөвшөөрөл эзэмших, үүний тулд ОХУ-ын Агнуурын тэнгис болон БНАСАУ-ын Ражин боомтын ойролцоо бусад загас агнуур эрхэлдэг улсуудын далайн эргийн усанд тодорхой хэмжээний загас агнуурын зөвшөөрөл авах, энэ асуудлаар НҮБ-ын Хүнс ХАА-н байгууллагад санал тавих
2. Хөрш орнуудтай хамтран далайн тээврийн хөлөг онгоц эзэмшиж, өөрийн уул уурхайн бүтээгдэхүүнийг зүүн өмнөд Азийн орнуудад хүргэх асуудлыг зохион байгуулах, мөн энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах боловсон хүчин бэлтгэхэд туршлагатай улс орнуудын тусламж авах
3. Далайд гарцтай болох эхний алхам нь БНХАУ-ын Тяньжин, Жиньзоу, Дандун боомтууд дээр тодорхой хэмжээний газрыг 50-100 жилийн хугацаагаар түрээслэн авах хөрөнгө мөнгөний эх үүсвэрийг шийдэх
4. ОХУ-ын Владивосток чиглэлийн боомтоор далайд гарахын тулд дотоодын Сайншанд –Дорнод чиглэлийн төмөр замын сүлжээг богино хугацаанд барьж ашиглалтанд оруулах, мөн Оросын төмөр замаар тээвэрлэх ачааны тарифийн

⁸ Монгол Улсын Далайн захиргааны дарга Д. Галсандондогийн УИХ-ын ТГ-ын Судалгааны төвд ирүүлсэн албат тоот

хөнгөлөлтийг удаан хугацаагаар авах

5. Далайн захиргааны хувьд тулгамдсан асуудал:

2009 онд Засгийн газар болон УИХ-ын Байнгын хороодоор зохих журмын дагуу хэлэлцэгдсэн 5 конвенц өнөөдрийг хүртэл УИХ-аар соёрхон батлах асуудлын жагсаалтанд багтахгүй хүлээгдэж байна. ОУДБ-аас эдгээр конвенцууд, ялангуяа “Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай конвенц” -д нэгдэж ороогүй аливаа гишүүн оронд том оврын хөлөг онгоц бүртгэх эрх олгохгүй байхаар зохицуулалт хийсэн нь манай хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж нөхцөл байдал өдөр ирэх тусам хүндэрсээр байна. Түүнчлэн УИХ-ын зүгээс олон улсын нийтлэг жишгийг баримтлан “Далай ашиглах тухай” хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар Далайн захиргааг Засгийн газрын харьяа бие даасан агентлаг болгон статусыг тодорхой болгох нь чухал байна.

Монгол улсын нэгдэн орсон болон нэгдэн орохоор төлөвлөж байгаа олон улсын Конвенци болон тэдгээрийн Протоколууд

Хавсралт 1

| № | Нэр | Нэгдэн орсон он |
|--|--|-----------------|
| Нэг. Нэгдэн орсон ОУ-ын конвенци, протоколууд | | |
| 1 | “Далайд гарцгүй улсуудын далбаагаа мандуулах эрхийг хүлээн зөвшөөрсөн Барселоны 1921 оны тунхаглал | 1976 |
| 2 | “Олон улсын далайн байгууллагын тухай” 1948 оны конвенц | 1996.5.28 |
| 3 | “Олон улсын далайн байгууллагын тухай” 1948 оны конвенцийн 1991 оны протокол | 2007.5.4 |
| 4 | “Олон улсын далайн байгууллагын тухай” 1948 оны конвенцийн 1993 оны протокол | 2008.1.7 |
| 5 | “Далайн эрх зүйн тухай” НҮБ-ын 1958 оны конвенц | 1996.8.13 |
| 6 | “Далайд гарцгүй орны транзит худалдааны тухай” НҮБ-ын 1965 оны конвенци, | 1966 |
| 7 | “Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай 1978 оны конвенци | 2001.12.14 |
| 8 | “Далайд хөлөг онгоц мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх олон улсын дүрмийн тухай” 1972 оны конвенци | 2001.12.14 |
| 9 | “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай” 1974 оны конвенци | 2001.12.14 |
| 10 | “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай” 1974 оны конвенцийн 1978 оны протокол | 2008.1.7 |
| 11 | “Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай” 1974 оны конвенцийн 1988 оны протокол | 2007.5.4 |
| 12 | “Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай” 1973 оны конвенци (1-5Хавсралт) | 2001.12.14 |
| 13 | “Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас сэргийлэх тухай” 1973 оны конвенцийн 1997 оны протокол (6-р Хавсралт) | 2007.5.4 |
| 14 | “Багтаамжийн хэмжилтийн тухай” 1969 оны конвенци | 2001.12.14 |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | |
|----|---|------|
| 15 | “Даацын тэмдэглэгээний тухай” 1966 оны конвенци | 2003 |
| 16 | “Даацын тэмдэглэгээний тухай” 1966 оны конвенцийн 1988 оны протокол | 2007 |
| 17 | “Газрын тосны бохирдлоос учруулсан хохирлын талаархи иргэний хариуцлагын тухай 1969 оны Конвенц | 2003 |
| 18 | Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан олон улсын конвенцийн Протокол | |
| 19 | Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны олон улсын конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах тухай Протокол | 2006 |
| 20 | Далайн навигацийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай 1988 оны конвенц | 2005 |
| 21 | Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Протокол | 2005 |

Хоёр. Монгол Улсын Их Хуралд өргөн барьж батлагдаагүй хүлээгдэж байгаа

| | | |
|--|---|------|
| 1. | Далайн нэхэмжлэлийн талаар хүлээх хариуцлагыг хязгаарлах тухай конвенци, | 2009 |
| 2. | Газрын тосны бохирдлоос далайд учирсан хохирлыг төлөх нөхөн төлбөрийн олон улсын сан байгуулах тухай конвенци, | |
| 3 | Хөлөг онгоцыг тэнцвэржүүлэгч ус агуулах сав, түүндэх үлдэгдэл тунадасны хяналт, удирдлагын тухай конвенци, | 2009 |
| 4 | Хөлөг онгоцны будагнаас далайд учруулах хор хөнөөлд тавих хяналтын тогтолцооны тухай олон улсын конвенци, | 2009 |
| 5. | Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай” 2001 оны конвенци | 2009 |
| Гурав. Элсэн орохоор судлаж байгаа конвенци | | |
| 1 | Далайн хиймэл дагуулын /сансарын/ хөдөлгөөнт холбооны олон улсын байгууллага байгуулах тухай 1976 оны "ИНМАРСАТ" конвенци, түүнийг хэрэглэх тухай протокол /Лондон, 1976/ | |
| 2 | Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын Далайчдын хөдөлмөр хамгааллын 2006 оны конвенци | |



**НИЙСЛЭЛ ХОТ ДУНДУУР УРСАН ӨНГӨРДӨГ ГОЛ МӨРНИЙ АШИГЛАЛТ,
МЕНЕЖМЕНТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААРХИ БУСАД ОРНУУДЫН
ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (Харьцуулсан судалгаа)**

Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Г. Гэрэл, О. Нарантуяа, Г. Чулуун

Сэдвийн агуулга

Оршил

- 1. Франц улсын усны бодлого ба усны нөөцийг ухаалгаар ашиглаж буй туршлага**
 1. Хураангуй хэсэг
 2. Үндсэн хэсэг
 3. 1964-өөс 2007 он хүртэлх хугацаан дахь усны менежментийн бодлого болон хууль тогтоомжийн хөгжил.
 4. Усны менежментийн арга хэрэгслүүд болон удирдлагын тогтолцоо
 5. Seine-Normandy-ийн Усны агентлагийн үзүүлэлтүүд

- 2. Лондон хотын Thames мөрнийг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалт**
 1. Темза мөрөн
 2. Эрх зүйн зохицуулалт
 3. Темза мөрнийг зохистой ашиглах, хамгаалах акт
 4. Темза мөрнийг ашиглах, хамгаалах талаарх үндсэн зохицуулалт

- 3. БНХАУ-ын Бээжин хотын дундуур урсах голыг сэргээх төсөл хэрэгжүүлж буй туршлага**
 1. “Бээжин хотын усны бохирдлоос сэргийлэн хамгаалах сэргээх тухай тогтоол”

- 4. БНСУ-ын Сөүл хот дундуур урсдаг гол мөрний талаархи мэдээлэл**
 1. Хан мөрний хяналтын хорооны дүрэм /Ерөнхийлөгчийн 22068 тоот захирамж/
 2. Сөүл тусгай хотын Хан мөрний цэцэрлэгт хүрээлэнгийн байгууламж байгуулах болон удирдан зохион байгуулах тогтоол

- 5. ОХУ-ын Москва голын ашиглалт, хамгаалалт, сэргээлтийн талаархи туршлага**
 1. Москва хот ба Москва гол)
 2. Москва голын бохирдолт, түүнийг саармагжуулах арга хэмжээ
 3. ОХУ –ын Усны кодексийн байгаль орчныг хамгаалах чадамж, агуулгын зарим онцлог
 4. Зарим санал

* * *

ОРШИЛ

УИХ -ын гишүүн П.Алтангэрэл, Д.Кёкүшюзан Батбаяр нарын захиалгаар дэлхийн зарим том гүрнүүдийн нийслэл дундуур урсан өнгөрдөг гол, мөрөн болон бусад усны эх үүсвэр, нөөцийг хамгаалах, сэргээх, зүй зохистой ашиглах туршлагауд, эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв.

Судалгаанд дэлхийн томоохон улс орнууд болох Их Британи, БНХАУ, БНСУ, ОХУ, Франц улсуудын холбогдох жишээнүүдийг сонгон авлаа. Судалгааны үр дүнгээс харахад, эрх зүйн бүлийн хувьд манай улстай ижил улс орнууд тухайлсан нэг голд зориулсан хууль батлахгүйгээр нийтлэг үйлчлэх Усны тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулиараа зохицуулж байна. Нийслэл хот дундуураа урсаж буй гол усаа тогтоол, журам, дүрэм, хөтөлбөр боловсруулах байдлаар хамгаалдаг байна.

Харин Англо-саксоны эрх зүйн бүлд хамаарагдах улс орнууд зарчмын өөр зохицуулалттай буюу тухайлсан нэг зүйл, юмс үзэгдэлд зориулан нийтлэг болон нийтлэг бус хэсэгчилсэн байдлаар үйлчлэх хууль тогтоомж батлан гаргадаг тул холбогдох жишээ болгон Их Британийн Лондон хотын дундуур урсах Темза мөрнийг хамгаалах эрх зүйн актын талаар орууллаа.

Нэг. Франц улсын усны бодлого ба усны нөөцийг ухаалгаар ашиглаж буй туршлага

Хураангуй хэсэг.

Францын усны менежмент нь Усны удирдлагын тогтолцоо болон хууль тогтоомжид үндэслэсэн чанар ба тоо хэмжээний хүрээнд, зохистой арга замаар болон холбогдох талуудын оролцоотойгоор хэрэгждэг. Өнөөдөр Усны менежментийн талаарх Францын системийг Европын улс орнууд суурь зарчим болгон авч хэрэгжүүлж байна. Усны удирдлагын тогтолцооны ирээдүйн төлөв байдалд нийцэн Францын өмнөх институционал, эдийн засгийн, төлөвлөгөөт арга хэрэгслүүд болон ус ашиглагчдын үүрэг роль өөрчлөгдсөн.

Усны удирдлагын тогтолцоо нь:

- усны менежментийн арга хэрэгслүүд
- Усны агентлаг
- Засгийн газар
- эрдэм шинжилгээний байгууллагууд
- голын ай сав газар зэрэг өргөн хүрээг хамарсан ойлголт юм.

1964-2007 он хүртэлх хугацаанд хэд хэдэн хууль батлан гаргасан нь Франц улсад институционал тогтолцоо бүхий усны менежментийн цогцыг бий болгосон. 1964 оны 12 сарын 16-ны хуулиар голын сав газрын менежментын талаарх орчин үеийн суурь зарчмуудыг тодорхойлж өгсөн. Мөн голын сав газрын асуудал хариуцсан 6-н байгууллага байгуулсан. Үүнээс бараг 30 орчим жилийн дараа, 1992 оны Усны тухай хуулиар голын сав газрын менежментийн төлөвлөгөө бүхий Францын усны менежментийн системийг шинэчлэн батласан. 2000 онд сав газруудын төлөвлөлт ба менежментийн суурь үндсийг багтаасан Усны удирдлагын тогтолцоог бий болгосон. 2006 он хүртэлх хугацаанд хэд хэдэн муж Европын Холбооны хууль дүрэмд нийцүүлэн усны менежментийн системээ шинэчилсэн.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. 1964-өөс 2007 он хүртэлх хугацаан дахь усны менежментийн бодлого болон хууль тогтоомжийн хөгжил.



- 1964 оны 12 сарын 16-ны Усны тухай хуулиар голын сав газар дах усны менежментийн суурь зарчмуудын үндсийг тодорхойлж өгсөн. Дараах 3-н суурь зарчмыг өнөөгийн цаг үе дэх хамгийн төгөлдөршсөн зохицуулалт хэмээн ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг:
 1. Томоохон голын сав газрын хувьд төвлөрсөн бус бие даасан менежменттэй байх
 2. Орон нутгийн засаг захиргааны байгууллага, ус ашиглагчид, усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн Усны зөвлөл (агентлаг) ажиллуулах буюу холбогдох оролцогчдын хамтарсан менежмент байх
 3. Чанарын болон тоон менежментэд зориулсан санхүүгийн урамшууллын арга хэрэгсэлүүд

Эдгээр зарчмуудыг анх бий болгохдоо голын сав газрын тодорхой хязгаарлагдмал хүрээг хадгалж хамгаалахад чиглэгдэж байсан. Хүрээлэн байгаа орчныг бохирдлоос хамгаалах зорилготой бохир усны төлбөр, усны хэрэглээг бууруулах, усны нөөцийг хадгалах зорилготой усны хэмжээнд тулгуурласан усны хэрэглээний татвар бий болох эрх зүйн үндсийг тавьсан.

Мөн Францын газар нутгийг 6-н том голын ай савд хувааж, эдгээрийг хариуцсан:

- Adour-Garonne,
 - Artois-Picardie,
 - Loire-Brittany,
 - Rhine-Meuse,
 - Rhone-Mediterranean-Corsica,
 - Seine-Normandy гэсэн тус бүр 6-н Усны агентлаг байгуулсан.
- 1992 оны 1 сарын 3-нд батлагдсан хуулиар 1964 оны хуульд тусгагдсан, тодорхой зорилгуудад чиглэсэн үндсэн менежмент болон хүрээлэн буй орчныг хамгаалах төлөвлөгөөт зорилт зэрэгт үндэслэсэн суурь бодлогоо шинэчилэн сайжруулсан. Ингэхдээ усны менежментийн усны эх үүсвэр, усны нөөц гэсэн ойлголтод гадаргын болон гүний ус, далайн эрэг хавийн ус зэрэг аливаа хэрэглэгч ашиглаж байгаа бүх төрлийн усыг багтаасан. Эдгээр дээр нэмээд усны экосистем, намагшилттай газруудыг хүртэл усны менежментийн бодлогод хамруулахаар заасан. Мөн усны нөөцийг эдийн засгийн нөөц гэдэг утгаар авч үзсэн.

Усны менежментийг явуулах гол хэрэгсэл болгон “Усны менежментийн мастер төлөвлөгөө”-г (SDAGE фр.) батлан гаргасан. Энэ төлөвлөгөөгөөр ай сав газар бүрийн түвшинд тохируулан 10-15 жилийн үечлэлтэй менежментийн төлөвлөгөө боловсруулсан. Харин дээр дурьдсан үндсэн 6-н ай сав багтахгүй бусад дэд сав газруудын хувьд тухайн орон нутгийн ус эзэмшиж ашиглагчид тухайн нутаг дэвсгэртээ ус хамгаалалын менежментийг явуулахаар зохицуулсан.

- 2000 оны 10 сард батлагдсан Усны удирдлагын тогтолцоо нь Европ дахь харьцангуй төгөлдөржсөн усны менежментийн арга хэрэгсэлд тооцогдож байна. үндсэн зорилго нь 2015 он хүртэлх хугацаанд бүх төрлийн усны нөөц, голын ай савыг экологийн хувьд цэвэршүүлэх:
 - усны нөөцийн тогтвортой менежемент;
 - усны экосистемийн бүх төрлийн доройтлоос урьдчилан сэргийлэх;
 - хоол хүнсний хангамжид зориулсан сайн чанарын ундны усны хангалттай хэмжээний нөөцийг хамгаалах замаар нэмэгдүүлэх;

Судалгааны эмхтгэл, Х боть

- гүний усны бохирдлыг бууруулах;
- аюултай бодисуудыг бүрмөсөн арилгах буюу боломжит хэмжээгээр бууруулах;
- Үер болон ган гачигийн аюулын хор нөлөөг бууруулахад оролцох;

Дээрх зорилгуудын хүрээнд “Усны менежментийн мастер төлөвлөгөө”-нд заасанчлан 6-н жил тутам хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийнэ. 2015 он хүртэл хэрэгжүүлэх гол үйл ажиллагаанууд:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд тухайн сав газар дахь хамтрагчид ба нийтийн үйлчилгээг авах.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн арга зам нь мөнгөн хөрөнгө, санхүүгийн урамшуулал, боломжит ажил үүргийг гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлэх арга хэрэгсэл.

➤ 2004 оны 4 сарын 21-нд Усны удирдлагын тогтолцоог дэмжих хуулийг батласан. Энэ хуулиар:

- 2015 он хүртэлх хугацаанд бүх төрлийн усны нөөц, эх үүсвэрүүдийг экологийн хамгийн сайн түвшинд аваачих;
- Аюултай, хортой бодисийн бохирдлыг бууруулах, боломжтой бол бүрмөсөн арилгах;
- Ус хамгаалах бодлого боловсруулах, хяналт үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Усны зохистой буюу зөв хэрэглээтэй хэрэглэгчдэд усны татвар, төлбөрийн тодорхой хэсгийг буцаан олгох зарчим бий болгосон.

Мөн энэ хуулиар Усны агентлаг бүр нийтээр даган мөрдөх “Усны менежментийн мастер төлөвлөгөө” болон үүнд нийцүүлэн тус бүрийн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх “Усны менежментийн төлөвлөгөө” боловсруулж хэрэгжүүлэхээр зохицуулсан.

➤ 2006 оны 12 сарын 30-нд Ус болон Усны хүрээлэн байгаа орчны тухай хуулийг батласан. Энэ хуулиар дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс хоёр суурь зорилго тавьсан.

- Усны хэрэглээ болон усны нөөц хоорондын тэнцвэрийг барих зорилгод тулгуурласан төлбөр, татвар ногдуулах, бууруулах, нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэрэг эдийн засгийн шинжтэй арга хэмжээ авах
- Ундны ус болон хаягдал бохир ус цэвэршүүлэх байгууламжуудыг нэмэгдүүлэх, эдгээрийн үйл ажиллагааг иргэдэд таниулах, сурталчилах

2. Усны менежментийн арга хэрэгслүүд болон удирдлагын тогтолцоо

“Усны удирдлагын тогтолцооны” үндсэн зарчимд тусгагдсаны дагуу Франц улсын усны бодлого нь Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны байгууллага, ус ашиглагч иргэдийн төлөөллийн хамтарсан хэлбэрээр хэрэгждэг. Үүнийг үндсэн 2 –н түвшинд хувааж авч үздэг.

Улс орны хэмжээнд.

1964 оны хуульд тусгагдснаар Байгаль орчны сайдын тогтоолоор батласан Усны үндэсний зөвлөл усны бодлоготой холбоотой хууль тогтоомж боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх асуудлыг хариуцдаг. Энэ зөвлөл нь яамны усны асуудал хариуцсан экспертүүд, орон нутгийн засаг захиргааны байгууллагын төлөөлөл, ус ашиглагч холбогдох байгууллагуудын төлөөлөл зэргээс бүрдэнэ.

Орон нутгийн буюу усны ай сав газрын хүрээнд.

Энэ хүрээнд үйл ажиллагаа явуулахад баримтлах гол эрх зүйн баримт бичиг нь 2000 оны 10 сард батлагдсан “Усны удирдлагын тогтолцоо” юм. Үүнд зааснаар усны бодлого, усны менежментийг хэрэгжүүлэхдээ Усны агентлаг бүр голын ай сав газрын хороо байгуулах ба хороо нь тухайн орон нутгийн удирдлагын төлөөллөөс 40%, ус ашиглагч холбогдох байгууллага, иргэдийн төлөөллөөс 40%, Засгийн газрын төлөөллөөс 20% гэсэн харьцаатайгаар байгуулагдана.

Энэхүү Сав газрын хорооны үндсэн үүрэг нь Усны менежментийн мастер төлөвлөгөөнд нийцүүлэн гаргасан тухайн нутаг дэвсгэртээ үйлчлэх Усны менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ёстой.

Төлөвлөгөөний хэрэгжилтэнд 6-н жил тутам хяналт үнэлгээ хийх ба шаардлагатай тохиолдолд уг төлөвлөгөөг засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

Усны агентлаг нь хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гаргахад нь Сав газрын хороонд зөвлөх үүрэгтэй. Агентлагийн санхүүжилт нь үндсэндээ ус бохирдуулсны төлбөр, бохир усыг нь цуглуулж цэвэрлэсний төлбөр зэргээс бүрдэх ба маш бага хэмжээгээр улсын төсвөөс татаас авдаг. Энэхүү татаас зөвхөн бичиг хэргийн буюу удирдлагын зардалд зориулагдана.

Усны агентлаг нь ус хэрэглэгчид болон ус бохирдуулагчдаас цуглуулсан мөнгөн хөрөнгийг ус цэвэршүүлэх, усны нөөц болон экосистемийг хамгаалах, усны бодлого болон менежментийн талаар судалгаа шинжилгээ хийхэд зориулна.

Үүний тулд дараах үйл ажиллагаанууд хэрэгжүүлнэ:

- Амралт зугаалгын бүс бий болгож тохижуулах зэргээр голын сав газрыг зохистой хэлбэрээр ашиглах, хөгжүүлэх;
- Тогтвортой усны хангамж буюу усны нөөцийн зохистой хэрэглээнд хяналт тавих;
- Хур тунадасны усыг тогтоох, хадгалах арга хэрэгслийг бий болгох, дэмжих замаар гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх;
- Гадаргын усны бохирдлыг хянах;
- Гүний усыг бохирдлоос хамгаалах;
- Үер болон далайн түвшнийг хянах;
- Усны экосистем болох ойн бүс болон намагшилт бүхий газрыг бохирдлоос хамгаалах, нөхөн сэргээх;
- Усны зохистой хэрэглээ бий болгосон, ус болон түүний экосистемийг бохирдлоос хамгаалж нөхөн сэргээсэн тохиолдолд мөнгө санхүүгийн хэлбэрээр урамшуулах;

3. Seine-Normandy-ийн Усны агентлагийн үзүүлэлтүүд

Франц улсын нийслэл Парис хотын дундуур Сена мөрөн урсдаг бөгөөд Сена-Норманд голын ай савд багтдаг. Энэхүү сав газарт ойролцоогоор 17,5 сая орчим хүн амьдардаг ба жил бүр 35 сая орчим гадаадын жуулчин ирдэг. Төвийн бүс нутаг болохын хувьд сууршлын бүсийн 80%, ХАА-н үйлдвэрлэлийн 40%, автомашин үйлдвэрлэлийн 60%, газрын тос боловсруулах үйлдвэрлэлийн 37% нь энэ сав газарт оршдог.

Иймээс Сена мөрөн нь Францын хамгийн их бохирдолтой хэсэгт тооцогдож байсан. Оиз, Марн, Ионн гэсэн томоохон голуудаар тэжээгддэг учраас усны нөөц, эх үүсвэрийн хувьд хангалттай хэмжээтэй байсан. Сенагийн нийт урт нь 55,000 км, усны нөөц- 97,000 км², урсгалын дундаж хурд- 460 м³/с.

1960-аад он хүртэл маш их бохирдолтой байсан учраас уг голд загас бараг байхгүй, ундны зорилгоор хэрэглэх нь байтугай, усанд орох, сэлэхэд ч хориотой байсан. 1964 онд



Судалгааны эмхтгэл, Х боть

Усны тухай хууль батлагдснаас хойш уг голыг сэргээх ажил эхэлсэн. Гэвч 1989 он хүртэл харьцангуй удаашралтай явагдаж байсан. 1990 оноос энэхүү ажил эрчимжсэн бөгөөд үүний үр дүнд 1992 онд Усны тухай хуулийг шинэчлэн батласан.

Одоогоор Сена голын бохирдол 25% хүртэл хэмжээгээр буурч 1 литр усан дахь нитратын хэмжээ-40мг болсон. Гэвч одоо болтол зарим төрлийн хорт бодисууд Сена голд орсоор байна. ХАА-н зориулалттай, хог ургамал, хортон шавьж устгах Атразин болон Фосфатын төрлийн бодисуудын хэрэглээг бууруулах, хориглох үүднээс усны бохирдлын төлбөрийг нэмэгдүүлэх зэргээр арга хэмжээнүүд авч байгаа ч тэр бүр үр дүнд хүрэхгүй байна.

Мөн эрчим хүчний системийн трансформатор, тосон таслуур зэрэг тоног төхөөрөмжид өргөнөөр ашиглагддаг Полихлорт бифенилийн бохирдол Сена гол нөлөөлж буй гол аюулуудын нэг юм. Удаан задардаг органик бохирдуулагч болох Полихлорт бифенил (РСВ) нь байгаль дээр задралгүйгээр олон арван жил хадгалагддаг, үр удамд нөлөөлж, хорт хавдар үүсгэдэг онцгой хортой бодис юм. Тосны алдагдал, түүний хаягдлыг зориулалт бусаар ашигласнаас хөрс, ус, агаар бохирдож, улмаар хүн амьтан хорддог.

2000 оны байдлаар Сена-Нормандын сав газар дагуу усны бохирдлыг хэмжих, хянах 441 цэг бий болгосон. Үүний 171 нь хүнд металлын бохирдлыг шалгадаг, 120 нь микро бохирдлыг шалгадаг.

Эх сурвалж:

1. www.environment.gouv.fr/ile-de-france
2. www.eau-seine-normandie.fr
3. Seine-Normandy Water Agency. 2002. Comment evolue la qualite des eaux depuis trente ans? Paris.

Хоёр. Лондон хотын Thames мөрнийг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалт

Темза мөрөн: Темза нь Английн нийслэл Лондон хотын төвөөр урсдаг томоохон мөрөн бөгөөд Оксфорд, Рийдэнг, Виндзор, Соутэнд, Кэмбл гэх мэт Английн 10 гаруй хотоор дамжин урсдаг байна. Темза мөрөн нь далайн түвшинээс дээш 361 фийт буюу 110 метрийн өндөр, 346 км урттай, 12,935 км² ай сав газрыг хамардаг бөгөөд уртын хэмжээгээр Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хэмжээнд 2 дугаарт ордог Англидаа нэгдүгээрт ордог байна.

Эрх зүйн зохицуулалт: Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улс нь эрх зүйн тогтолцооны хувьд Англо-Саксоны эрх зүйн бүлд хамаарагдах бөгөөд үүгээрээ манай улсын эрх зүйн тогтолцооноос ялгаатай юм. Тиймээс, Англо-саксоны эрх зүйн бүлд хамаарагдах улс орнуудын code-код, act - акт, law – хууль гэх эрх зүйн баримт бичиг нь үг зүйн хувьд бүгд монгол хэлээр “хууль” гэж орчуулагдах боловч үйлчлэх хүчин чадлынхаа хувьд Ром-германы эрх зүйн тогтолцоотой улс орнуудын “хууль” гэсэн ойлголтоос ялгаатайг анхаарахгүй орхиж болохгүй юм.

Өөрөөр хэлбэл “Жишгийн эрх зүй” хэмээгддэг Англо-саксоны эрх зүйн бүлд хамаарагддаг улс орны хувьд тодорхой нэг асуудлаар гаргасан шүүхийн шийдвэр ч хууль адил хүчин төгөлдөр үйлчилж дараагийн ижил нөхцөл байдалд адилхан хэрэглэгддэг бол эх газрын эрх зүй буюу Ром-германы эрх зүйн бүлд хамрагддаг улс орны хувьд тухайлсан нэг асуудал, нэг объектэд хандаж бие даасан хууль тэр болгон батлаад байдаггүйгээрээ онцлог.

Их Британи нь улс төрийн байгууламж болон эрх зүйн тогтолцооноосоо хамааран хууль зүйн систем нь нийтийн болон бусад гэж ангилагддаг байна. Үүнээс Английн нийслэл

Лондон хотын дундуур урсах Темза /Thames/ мөрнийг хамгаалах асуудлыг зохицуулсан “Темза мөрнийг зохистой ашиглах, хамгаалах акт” /Thames Conservancy Act 1972/ нь Их Британы “Орон нутгийн хууль тогтоомж”-д /Local act/ хамаарагддаг байна.

Темза мөрнийг зохистой ашиглах, хамгаалах акт : -ын тухайд анх 1932 онд баталсан бөгөөд 1950, 1959, 1966, 1972 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна. 1950 болон 1959 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Темза мөрнийг ашиглах, хамгаалахтай холбогдуулан Консерваторуудын эрх мэдлийг өргөтгөх, ирээдүйн нөөцөд зориулсан Консерваторуудын орлогын талаар холбогдох нэмэлтүүдийг хуульчилан баталсан байна.

Харин, 1966 оны нэмэлт өөрчлөлт оруулах тухай актад нэмэлт өөрчлөлтийн зорилгыг дараахь байдлаар тодорхойлсон байна. Үүнд: “Темза мөрнийг зохистой ашиглах, хамгаалах тухай 1932-оос 1959 оны актуудад дараахь өөрчлөлт оруулж байна: Ирээдүйн нөөцтэй холбоотойгоор Темза мөрнийг ашиглах аялалын усан онгоцуудыг бүртгэх, усан зогсоолуудын бүртгэлийн төлбөр зэрэгтэй холбоотойгоор Темза мөрний Консерваторуудын эрх мэдлийг өргөтгөх болон бусад зорилгоор энэхүү нэмэлт өөрчлөлтийг оруулж байна” гэж заасан нь тус нэмэлт өөрчлөлтийн ерөнхий агуулгыг тодорхой болгож байна.

Тус актын сүүлчийн нэмэлт өөрчлөлт болох 1972 оны нэмэлт өөрчлөлт оруулах тухай актад зааснаар “Темза мөрөнтэй холбоотой Консерваторуудын эрх мэдэл, тэдгээрийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, усны зарцуулалт, гүний усыг хамгаалах болон бусад зорилгоор энэхүү нэмэлт өөрчлөлт оруулав” гэж заажээ. 1972 оны нэмэлт өөрчлөлтөөр орсон гүний усыг хамгаалах талаар зохицуулалтыг “Темза мөрнийг зохистой ашиглах, хамгаалах акт”-ын ерөнхий зохицуулалтын талаарх дараахь хэсэгт тусгайлан авч үзсэнийг анхаарна уу.

Темза мөрнийг ашиглах, хамгаалах талаарх үндсэн зохицуулалт

1932 оны Темза мөрнийг зохистой ашиглах, хамгаалах тухай акт нь 14 бүлэг, 267 зүйл, 6 хавсралт бүхий томоохон эрх зүйн акт юм. Тус акт нь дараахь харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- Консерваторуудын бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагаа
- Усны зохицуулалт болон усан замыг зохистой ашиглах
- Хил хязгаар
- Бохирдлоос урьдчилан сэргийлэх
- Худалдааны хөлөг онгоцнуудын төлбөр
- Усны Зөвлөл болон Усны компаниудын ус ба төлбөр
- Мужын Зөвлөлүүд болон Мужын дүүргүүдийн хандив
- Төлбөр, хандив, хураамжийн шалгалт
- Санхүүгийн харилцаа
- Хууль зүйн үйл ажиллагаа

Хуримтлал болон тухайн актад заасан бусад харилцааг холбогдо бүлэг бүрт нарийвчлан зохицуулсан байна. Түүнчлэн Темза мөрнийг ашиглах хуулиар зөвшөөрөгдсөн аливаа үйл ажиллагаа явуулахад заавал лиценз авах бөгөөд тэрхүү лицензийг авах журам болон төлбөрийн нөхцлийг ч мөн тус актаар зохицуулсан байна. Мөн, Темза мөрний ашиглалт хамгаалалттай холбоотой аливаа харилцааг энэ актаас гадна “Усны нөөцийн тухай”/Water Resources Act/ хууль болон Темза мөрний сав газар дахь Гол Мөрний Хэрэг Эрхлэх Газрын шинэ чиг үүрэг бүхий /Thames Conservancy (New Functions of River Authorities in Thames Catchment Area) Order 1964/ журмаар зохицуулдаг байна.

Судалгааны эмхтгэл, Х боть

Тус актад зааснаар Темза мөрний ай сав газар, түүнчлэн мөрний Лондон боомтын харъяа болон хил хязгаар доторх хэсгийг хамгаалах Консерваторуудын эрх болон үүргийг тодорхойлоод энэхүү актын зорилго оршино гэжээ. Темза мөрний Лондон боомтод харъяалагдах нутгийн хил хязгаар доторх хэсгийн болон дээрх хязгаар доторх уг мөрний салааны ус, урсгал, цэвэр тунгалаг байдал зэргийг хадгалах хамгаалахтай холбоотой бүрэн эрхийг 1894-1924 оны Темза Мөрнийг зохистой ашиглах хамгаалах тухай актын дагуу Консерваторуудад олгосон болно.

Тус актын Консерваторуудын бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааг зохицуулсан 2-р бүлгийн 12 дугаар зүйлийн 3-т зааснаар:

- Консерваторууд нь 31 хүнээс бүрдэх бөгөөд тэднийг дараахь субъектууд томилно. Үүнд:
 - Хөдөө аж ахуй, загасчлалын яамнаас 1
 - Худалдааны зөвлөлөөс 1
 - Зам тээврийн яамнаас 2
 - Боомтын Газараас 1
 - Усны Зөвлөлөөс 2
 - Лондон Хотын Зөвлөлөөс 1
 - Корпорациас 1 гишүүдийг томилох бөгөөд. Үлдсэн 22 гишүүнийг Темза мөрөн дайран урсдаг Английн бусад муж болон Лондон хотын эргэн тойронд орших бусад хот, дүүргүүдийн Зөвлөлөөс тус актад тусгайлан заасан тооны хүмүүсийг тус тус томилдог байна.

Ийнхүү томилогдсон Консерваторууд нь Темза мөрнийг ашиглах, хамгаалахтай холбоотой дүрэм журмыг тогтоох бөгөөд хуралдаанаар дамжуулан энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Жил бүрийн 4 сард тогтмол хуралдах бөгөөд мөн Улирлын болон Онцгой хуралдаан хийнэ. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хороодыг зохион байгуулан ажиллаж болно. Консерваторууд нь жил бүр тогтмол Парламентын 2 танхимд хоёуланд нь жилийн ажлын тайлангаа илтгэх үүрэгтэй.

Консерваторууд нь Темза мөрний тус актаар заасан хил хязгаар доторх хэсгийн Эзэн хааны мэдлийн газраас бусад аль ч эдлэн, газар, эрэг, ус зэрэгт үзлэг шалгалт хийх зорилгоор нэвтрэх эрхтэй. Консерваторууд Темза мөрний дээгүүр дамжин өнгөрөх усан онгоц, завь, гаталга онгоц зэрэг бүхий л төрлийн усан тээврийг сайжруулах, гүүр, зам зэргийг шаардлагатай гэж үзвэл засах, өөрчлөх, өргөтгөх эрхтэй. Энэхүү чиг үүргүүдийн хүрээнд Консерваторуудын эдлэл эрх, хүлээх үүргийн талаархи нарийвчилсан зохицуулалтыг 2 бүлгийн 40 орчим заалтаар зохицуулсан байна. Тус актын 3 дугаар бүлэгт Лиценз бүхий үйл ажиллагааг зохицуулсан байна. Тухайлбал тус актаар дараахь үйл ажиллагаанд лиценз буюу зөвшөөрөл олгохоор зохицуулсан байна:

- Темза мөрний ёроолоос хайрга, элс, шороо зэргийг авах, ашиглах бол заавал Консерваторуудаас зөвшөөрөл, лиценз авах шаардлагатай бөгөөд зөвшөөрөл авалгүйгээр энэ үйлдлийг хийсэн этгээдийг үйлдэл тус бүр дээр нь хариуцлага оноож торгоно.
- Хувь хүн нь усан тээврийн хөгжил, хөдөлгөөн зэрэгт саад болохооргүй бол өөрийн эзэмшлийн газрын зэргэлдээ хөлөг онгоц, завьны зогсоол хийхэд Консерваторууд нь зөвшөөрлийг саадгүй олгоно.⁹
- Консерваторууд мөн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, тодорхой заасан газруудад кран, өргөгч машин механизм зэргийг тодорхой хөлстэйгээр байрлуулах зөвшөөрөл

⁹ 1932 оны Темза мөрнийг зохистой ашиглах, хамгаалах тухай акт, 60-р зүйл

өгч болно. Мөн дээрх машин механизмыг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нүүлгэн шилжүүлэх эсвэл, бүрмөсөн зайлуулах эрхтэй.

- Консерваторууд нь Темза мөрний дагуух ус ашиглалтыг зохицуулах бүрэн эрхтэй бөгөөд тус мөрөн дагуу байрлах усан тээрэм болон бусад хэлбэрийн ус ашиглалтуудад түрээсийн лиценз, зөвшөөрөл олгох эрхтэй.

Дээрх зөвшөөрлийг олгохдоо Консерваторууд нь Темза мөрөн дээрх усан замын хөдөлгөөнийг хязгаарлаж байгаа эсэх, хуулиар тухайн газраас ус авч ашиглах эрх бүхий хүмүүсийн эрхийг хөндөж байгаа эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр шийдвэр гаргана. Түүнчлэн, мөрөн болон мөрний салаадын ус, урсгал, цэвэр байдлыг үргэлж хангах нь Консерваторуудын үүрэг байна. Хэрэв хэн нэгэн хувь хүн хуулинд /актад/ зааснаас бусад шалтгаанаар доорх үйлдлүүдийг хийсэн нь батлагдсан тохиолдолд үйлдэл болгонд нь хариуцлага тооцож, зохих торгох шийтгэл онооно. Үүнд:

- Мөрний ус, урсгал болон салаадын цэвэр тунгалаг байдалд нөлөөлөхүйц хэмжээний хайрга, шороо, шавар, хог хаягдал, үнс зэргийг мөрөнд хаях
- Санаатайгаар тос, давирхай зэргийг мөрний ус, урсгалд хаях, урсгах

Түүнчлэн, Хэрэв хэн нэгэн хувь хүн хуулинд зааснаас бусад шалтгаанаар доорх үйлдлүүдийг хийсэн нь батлагдсан тохиолдолд үйлдэл болгонд нь хариуцлага тооцож, зохих хэмжээний дагуу торгох шийтгэл онооно. Үүнд:

- Мөрний урсгал, салаа зэрэг рүү бохир усны зайлуулах суваг шуудуу ухах, бүх төрлийн хортой болон бохир шингэн, хатуу биетийг мөрөнд оруулах
- Санаатайгаар аливаа хортой болон бохир шингэн, хатуу биетийг бохир усны зайлуулах сувгаар мөрний усанд хаях.

Дээрх тохиолдлуудад Консерваторууд нь дээрх үйлдлийг хийсэн этгээдэд бохир урсгал, хаягдлыг зогсоох сануулга бичгээр өгнө. Шаардлагатай тохиолдолд Консерваторууд сануулгын хугацааг сунгах боломжтой. Дээрх сануулгыг авсан хүн нь тогтоосон хугацаанд багтаан бохирын урсгалыг зогсоох үүрэгтэй бөгөөд Хэрэв, зогсоогоогүй тохиолдолд заасан хугацааны төгсгөлөөс эхлэн өгсөн шаардлагагыг биелүүлээгүй хоног бүрээр тооцож торгох шийтгэл ногдуулна. Ийнхүү бохирдуулсан тохиолдолд бохирдуулагч нь хувь хүн бол түүнийг зохих хэмжээгээр торгох шийтгэл ногдуулах бөгөөд хэрэв бохирдуулагч нь аж ахуйн нэгж бол тухайн аж ахуйн нэгжийг торгохоос гадна Темза мөрний ус, түүний тунгалаг байдал болон бусад байдлаар учруулсан бохирдолыг өөрийн зардлаар арилгах, нөхөн сэргээх шийтгэл ногдуулна.

Энэ мэтчилэн Темза мөрний ус ашиглах, Темза мөрөнд бохирдол үүсгэлгүйгээр зөвшөөрөгдсөн хэмжээнд, зөвшөөрөгдсөн төрлийн үйл ажиллагааг явуулахтай холбогдсон зөвшөөрөл, төлбөр хураамж, татвар, Темза мөрний усны ашиглалтад тавих хяналт болоод бохирдуулсан тохиолдолд хариуцлага тооцох журам зэргийг энэхүү актаар зохицуулсан байна.

1972 оны нэмэлт өөрчлөлтөөр Темза мөрний хамгаалалтын асуудалд ихээхэн анхаарлаа хандуулсан байх бөгөөд хамгаалалтын аливаа арга замыг Консерваторууд хуралдаанаар шийдвэрлэхээр заасан байна. Тус нэмэлт өөрчлөлт оруулах тухай актын 14 дүгээр зүйлд мөрний хамгаалалтын талаар дараахь зохицуулалтыг оруулсан байна. Үүнд: Темза мөрөн болон Лондонгийн ойролцоо газруудын газрын гүний ус бохирдсон буюу бохирдож болзошгүй байгаа тохиолдолд Консерваторууд шаардлагатай гэж үзвэл дараахь хамгаалалтын арга хэмжээг авна. Үүнд:

- Консерваторуудын тохиромжтой гэж үзсэн арга замаар уг бохирдлыг үүсгэж байгаа буюу үүсгэж болзошгүй байгаа зүйлийг зайлуулах, цэвэрлэх,



Судалгааны эмхтгэл, Х боть

- Энэ мэт усны бохирдлоос сэргийлэх, бохирдлын хэмжээг багасгах арга хэмжээ-нүүдийг авах

Дээрх зүйлд заасан бохирдол болон бохирдлын болзошгүй байдал нь аливаа этгээдийн буруутай үйлдэл болон хариуцлагагүй байдлаас шалтгаалсан бол дээр өгүүлсэн арга хэмжээнүүдийг авах зардлыг үндэслэлтэйгээр тухайн этгээдээр нөхөн төлүүлнэ. Хэрэв дээрх зүйлд заасан бохирдол болон бохирдлын болзошгүй байдал нь тухайн этгээдийн буруутай үйлдэл болон хариуцлагагүй байдлаас шалтгаалж гараагүй болох нь тогтоогдсон, мөн шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан ч тухайн этгээдийн хяналтаас гадуурх нөхцөл байдлаас үүдэн бий болсон нь тогтоогдсон тохиолдолд дээрх нөхөн төлбөрийг авахгүй байхаар заасан байна.

Темза мөрнийг зохистой ашиглах, хамгаалах тухай актаар Темза мөрний урсгал ус, газрын гүний усны бохирдол болон нөөцийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, мөрнийг ашиглах, хамгаалах, мөрнийг хамгаалах санхүүжилтыг бий болгох зэрэг бусад бүхий л асуудлыг Консерваторуудад олгосон нь тухайн актын үндсэн үзэл баримтлал байлаа.

Эх сурвалж:

Хууль тогтоомж:

1. Thames Conservancy Act 1932
2. Thames Conservancy Act 1950,59,66
3. Thames Conservancy Act 1972

Вэб сайт:

1. www.legislation.gov.uk
2. http://en.wikipedia.org/wiki/River_Thames

Гурав. БНХАУ-ын Бээжин хотын дундуур урсах голыг сэргээх төсөл хэрэгжүүлж буй туршлага

Бээжин хотын хамгийн том гол болох Юун дин хө нь сүүлийн жилүүдэд хуурайшлаас болж тасарсан. Үүнийг сэргээхээр “Юун дин хө ногоон байгаль орчны хөгжлийн бүс” нэртэй төсөл 2010 оноос хэрэгжиж эхэлсэн ба энэхүү төслийн гол зорилго нь энэ голыг сэргээх юм. Энэхүү төслөөр энэ голд 170 км хавцлын урсгал барьж нууруудтай холбох ба түүний хоёр эргээр нь ногоон модоор бүрхсэн голын сав газар байгуулснаар, шинээр голын усны талбай 1000 гектараар ихсэх юм байна. Энэхүү голын сав газар руу дахин цэвэршүүлсэн усаа оруулж голоо сэргээхээр төлөвлөсөн байна. Зөвхөн 2010 он гэхэд гол руу 1.3 тэрбум куб метр дахин цэвэршүүлсэн усыг гол руу оруулсан байна.

“Бээжин хотын усны бохирдлоос сэргийлэн хамгаалах сэргээх тухай тогтоол”

2010 оны 11 сарын 19-ний өдөр “Бээжин хотын усны бохирдлоос сэргийлэн хамгаалах сэргээх тухай тогтоол”-ыг Бээжин хотод Бүх Ардын Байнгын хорооны 21 дэх удаагийн хуралдаан дээр санал хураан баталсан ба энэ тогтоол нь 2011 оны 3 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

5-р зүйл

- Хот, Дүүрэг, Тосгоны Орчны Хамгааллын Захиргааны Удирдах салбар нь уг засаг захиргааны нэгжийн доторх усыг усны бохирдлоос сэргийлэн сэргээх, нэгдсэн хяналт тавих удирдлагыг хэрэгжүүлнэ.
- Хот, Дүүрэг, Тосгоны Усны Захиргааны Удирдах салбар нь уг засаг захиргааны нэгжийн доторх усны нөөцийн хамгаалал ба ус дахин цэвэршүүлэн ашиглах

удирдлага, бохир ус зайлуулах ба усан зам сувгийг сэргээх гэх мэт нэгдсэн ажлыг хариуцна.

8-р зүйл

Хотын Ардын Засгийн газар улсын усны орчин тойрны чанарын стандарт, Бээжин хотын усны орчин тойрны чанарын зорилго ба эдийн засаг, технологийн нөхцлийг харгалзан үзэж уг хотын ус руу бохирдсон зүйл зайлуулах стандарт тогтоох, түүнийг хатуу баримтлах ба тогтмол хугацаанд стандартанд үнэлгээ хийн тухайн цаг үед нь нийцүүлэн өөрчилнө.

11-р зүйл

Хотын Орчны Хамгааллын Захиргааны Удирдах салбар нь уг Хотын Усны Захиргааны Удирдах салбар, Хөрсны нөөц зэрэг Захиргааны Удирдах салбартай хамтран газрын гадаргын ус болон газар доорх усны орчны байдлын төсөл боловсруулах, Хотын Ардын Засгийн газарт мэдэгдэн зөвшөөрөл авч түүнчлэн олон нийтэд нийтэлнэ.

12-р зүйл

Хотын Усны Захиргааны Удирдах салбар нь холбогдох салбаруудтай хамтран усны бохирдлоос сэргийлэх сэргээх тусгай хэтийн төлөвлөгөө, усны нөөцийг нээн ашиглах зэрэг тусгай хэтийн төлөвлөгөөг харгалзан, зарим томоохон голуудын нэгдсэн сэргээх хэтийн төлөвлөгөөг зохиох ба хэрэгжүүлнэ.

13-р зүйл

Хотын Ардын Засгийн газар нь тогтмол хугацаанд усны бохирдлоос сэргийлэх сэргээх тусгай хэтийн төлөвлөгөө, усны сав газрын нэгдсэн сэргээх хэтийн төлөвлөгөө, газар доорх усны хамгааллын хэтийн төлөвлөгөө, газар тариалангийн усны бохирдлоос сэргийлэх сэргээх хэтийн төлөвлөгөө болон түүний хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөн дүгнэх ба үнэлгээний үр дүн нь цаашдаа усны орчны хамгааллын зорилгын хянан шалгах баримт болно.

14-р зүйл

Хотын Ардын Засгийн газар нь усны сав газрын усны орчны чанарын байдлаас хамааран гол усны бохирдсон зүйлийн төрлийн хяналтыг ихэсгэж болно.

15-р зүйл

Бээжин хот нь аажмаар усны сав газрын усны орчны нөөцийн нөхөн төлбөр олгох механизмыг бий болгож байна.

17-р зүйл

Хотын Орчны Хамгааллын Захиргааны Удирдах салбар нь уг Хотын Усны Захиргааны Удирдах салбартай хамтран уг хотын усны сав газар бүрийн бохир зайлуулах байгууллагуудын нэрсийг гаргана. Бохир зайлуулах байгууллагууд нь заавал усны бохирдсон зүйл зайлуулах автомат хэмжээг хянагч тоног төхөөрөмж суурилуулах ба орчин тойрны хамгаалал, Усны Захиргааны Удирдах салбарын хянах төхөөрөмжтэй холбогдон, түүнчлэн хяналтын төхөөрөмж хэвийн ажилж байгаа эсэхийг ханган батлах.

18-р зүйл

Бохир зайлуулах байгууллагууд нь улсын ба хотын холбогдох дүрэм журмын дагуу бохир зайлуулах үйлчилгээнд бүртгүүлэн, бохир зайлуулах зөвшөөрөл авах ба бохир зайлуулах төлбөр төлнө.

19-р зүйл



Судалгааны эмхтгэл, X боть

Шууд ус руу бохирдсон зүйл зайлуулдаг үйлдвэрийг заавал холбогдох хуулийн дагуу тоног төхөөрөмжтэй болгох, бохир зайлуулах хоолойг жишигт хүргэх, тэмдэг тавих, түүнчлэн бохир зайлуулах хоолойны байршил зэрэг мэдээллийг Дүүрэг, Тосгоны Орчны Хамгааллын Захиргааны Удирдах салбарт мэдэгдэнэ. Гол, нуур, усан сан, усан суваг руу бохир зайлуулах хоолойг байгуулсан бол Усны Захиргааны Удирдах салбарын дүрэм журмыг бас мөрдөнө.

26-р зүйл

Бээжин хот нь дараахь үйлдлийг хориглоно:

- Ус руу тосны төрөл, хүчил, шүлт, хүчтэй хортой хаягдал шингэн зайлуулах
- Усанд хэтэрхий их тосны төрөл эсвэл хортой бохирдсон зүйл ба машин, агуулах сав угаах
- Ус руу үйлдвэрийн хог шаар хаягдал, хэрэггүй зүйл зайлуулах ба асгах
- Гол, нуур, усан зам суваг, усан сангийн хамгийн өндөр усны түвшингээс доош голын сайранд хог хаягдал, бусад хортой зүйл хаях
- Хайрга чулууны нүх, үйлдвэрийн нүх, голын сайранд нүх ухан бохир ус зайлуулах, асгах, эсвэл хог хаягдал хадгалах эсвэл бусад бохирдсон зүйлийг ба бохир усыг аажмаар урсуулах замаар зайлуулан асгахыг хориглоно.
- Фосфор агуулагдсан угаалгын бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба худалдан борлуулах

27-р зүйл

Уг хот нь ус руу хортой бохирдсон зүйлийг зайлуулах тал дээр хатуу хяналт тавина.

28-р зүйл

Ус руу цацраг идэвхит хатуу биетэй хог хаягдал эсвэл өндөр цацраг идэвхитэй бодис агуулсан хог хаягдал зайлуулахыг хориглоно.

29-р зүйл

Сургууль, эмнэлгийн байгууллага, эрдэм шинжилгээний газар, байгууллага гэх зэрэг нэгжийн лаборатори, сорилын өрөө, химийн лабораторийн бий болгосон хаягдал шингэнийг улсын болон уг хотын аюултай хог хаягдлын холбогдох дүрэм журмын дагуу аюулгүй байдлыг ханган зайлуулна. Харин бохир усны хоолойгоор зайлуулах эсвэл шууд ус руу зайлуулахыг хориглоно.

33-р зүйл

Бээжин хот нь заавал арга хэмжээ аван их хэмжээний бохирдолтой ба их хэмжээгээр ус хороодог үйлдвэрүүдийг хязгаарлах. Худаг гаргах, арьс шир боловсруулах, цахилгаан эмчилгээ /гальюанизаци/, будах үйлдвэр, төмөрлөг хайлуулах үйлдвэр, хлор шүлт, химийн бордоо нийлүүлэх, коксжуулах зэрэг усыг ноцтой бохирдуулах төслийг шинээр байгуулах ба өргөтгөхийг хориглоно.

55-р зүйл

Уг хот нь ундны усны нөөцийг хамгаалах бүсийг тогтооно. Ундны усны нөөцийн хамгаалалтын бүсийг нэгдүгээр ба хоёрдугаар зэргийн хамгаалалтын бүс гэж хуваана. Ундны усны нөөцийн хамгаалалтын бүсийн гадна хүрээнд хэсэг газрыг зөвшөөрсөн хамгаалалтын бүс болгон тогтоож болно.

56-р зүйл

Ундны усны нөөцийн нэгдүгээр зэргийн хамгаалалтын бүс газарт ус түгээх тоног төхөөрөмж ба усны нөөцийг хамгаалахтай холбогдолгүй барилга байгууламжын төслийг

шинээр барих, өөрчлөх, өргөжүүлэхийг хориглоно. Өмнө нь баригдсан ус түгээх тоног төхөөрөмж ба усны нөөцийг хамгаалахтай холбогдолгүй барилга байгууламжыг хот эсвэл Дүүрэг, Тосгоны Ардын Засгийн газрын захирамжаар татан буулгах эсвэл үйл ажиллагааг хаана. Ундны усны нөөцийн нэгдүгээр зэргийн хамгаалалтын бүс дотор аялах, загас барих, эсвэл бусад төрлийн ундны усыг бохирдуулж болох үйл ажиллагааг хориглоно.

57-р зүйл

Ундны усны нөөцийн хоёрдугаар зэргийн хамгаалалтын бүс газарт бохирдсон зүйлийг зайлуулах барилга байгууламжын төслийг шинээр барих, өөрчлөх, өргөжүүлэхийг хориглоно. Өмнө нь баригдсан бохирдсон зүйлийг зайлуулах барилга байгууламжыг хот эсвэл Дүүрэг, Тосгоны Ардын Засгийн газрын захирамжаар татан буулгах эсвэл үйл ажиллагааг хаана. Ундны усны нөөцийн хоёрдугаар зэргийн хамгаалалтын бүс газарт аялаж байгаа этгээдэд ундны ус бохирдуулж болох үйл ажиллагааг хориглоно.

59-р зүйл

Газрын гадарга дээрх ундны усны нөөцийн хамгаалалтын бүс дотор дараах ажиллагааг хориглоно:

- Хортой бохирдсон зүйл ачсан машин тэргийг оруулах
- Хөдөө аж ахуйн тариалан, тариа тарих ажил эрхлэх
- Усан дээрх аялал, усанд сэлэх эсвэл бусад усны нөөцийг бохирдуулж болох үйл ажиллагаа

66-р зүйл

Бээжин хот нь усны нөөцийг нээн хэрэглэх ба усны бохирдлоос сэргийлэн сэргээхтэй хослуулан, усны хэрэглээний нийт хэмжээг хянах, усыг дахин цэвэршүүлэн хэрэглэхийг дэмжих, усны хэрэглээ болон усны нөөцийг тэнцвэржүүлэх, газрын гадаргын усыг буцааж сэргээх, газар доорх усны зохистой түвшинг хэрэгжүүлэх.

67-р зүйл

Хотын Усны Захиргааны Удирдах салбар холбогдох хотын орчин тойрны хамгаалах захиргааны удирдах салбартай хамтран уг хотын гол, голын тасалдал, голын сав газрыг сэргээх хэтийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

73-р зүйл

Хотын Усны Захиргааны Удирдах салбар нь усны хэмжээ, чанарын шаардлага ба эдийн засаг, техник технологийн нөхцөл зэрэг хүчин зүйлээс хамааран, уг хотын гол салбаруудын дахин цэвэршүүлсэн усны хэрэглээний үзүүлэлтийг тогтоох ба Хотын Ардын Засгийн газарт мэдэгдэн зөвшөөрөл авна.

74-р зүйл

Дахин цэвэршүүлсэн усны хэрэглэгчийг хэрэглэх зорилгоос нь хамааран, улсын ба уг хотоос тогтоосон дахин цэвэршүүлсэн усны чанарын стандартын дагуу дахин цэвэршүүлсэн усыг хэрэглэнэ. Дахин ус боловруулах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь хэвийн үйл ажиллагааг батлан хангах ба дахин цэвэршүүлсэн усны чанарыг хариуцна.

78-р зүйл

Энэ тогтоолын тогтоосон хэмжээг зөрчин, улс эсвэл уг хотын тогтоосон хог хаягдал зайлуулах стандартаас хэтрүүлэн хог хаягдал зайлуулсан тохиолдолд, хот эсвэл Дүүрэг, Тосгоны Орчны Хамгааллын Захиргааны Удирдах салбараас хугацаа тогтоон сэргээлгэх



Судалгааны эмхтгэл, X боть

ба түүнчлэн хог хаягдал зайлуулах төлбөрийн нийт хэмжээнээс 2-5 дахин их хэмжээний мөнгөөр торгоно. Энэ хог хаягдал зайлуулах төлбөрийг жилээр тооцно.

81-р зүйл

Хог хаягдал гадагшлуулахтай хамаатай үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага энэ тогтоолыг зөрчин, Хотын Ардын Засгийн газраас явуулж буй усны бохирдлоос сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй, усны орчин тойрныг бохирдуулвал, хот эсвэл Дүүрэг, Тосгоны Орчны Хамгааллын Захиргааны Удирдах салбар 10000-100000 хүртэлх ¥ /RMB/-аар торгоно. Хэрэв илүү хүнд байдалтай бол хот эсвэл Дүүрэг, Тосгоны Ардын Засгийн газар захирамж гарган үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авна.

Эх сурвалж:

<http://www.chinalawedu.com/falvfagui/1200a22016aaaa2010/20101220wangyo152617.shtml>

Дөрөв. БНСУ-ын Сөүл хот дундуур урсдаг гол мөрний талаархи мэдээлэл

БНСУ -ын төв дундуур том, жижиг 2 гол урсан өнгөрдөг. Хан мөрөн нь маш том, урт бөгөөд Сөүл хотын дундуур урсдаг. Харин хотын дундуур урсдаг жижигхэн гол нь Chonggechon юм. Энэхүү 2 голын хувьд хууль, эрх зүйн нарийн зохицуулсан хууль олдоогүй бөгөөд Хан мөрний цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах тогтоол /2010-3-1/-ыг баталсан байна. Харин Chonggechon-ий хувьд нарийн хууль эрх зүйн зохицуулалт одоогүй бөгөөд сэргээн засварлах төлөвлөгөөг олсон болно.

Chonggechon

Чонгэчон нь анх нилээд том гол байсан бөгөөд цаг хугацаа, хотжилтийн нөлөөгөөр багасч ширгэхэд хүрсэн бөгөөд БНСУ-ын одоогийн Ерөнхийлөгч И Мён Бак, тухайн үеийн хотын захирагчийн шийдвэрээр сэргээн засварлах ажил эхэлсэн. Энэ гол нь Улаанбаатар хотын дундуур урсдаг Сэлбэ голтой дүйх болов уу гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Чонгэчон нь сэргээн засварлагдах хүртэл манай Сэлбэ гол шиг бараг урсахаа больсон, хог шороондоо дарагдсан, хотын өнгө үзэмж болоод агаар, орчныг бохирдуулж байсан гол юм. 2002 онд хотын захирагч “Чонгэчоныг сэргээн засварлах төсөл”-ийг хэрэгжүүлэхээр болж 2 жилийн хугацаанд хэрэгжиж дууссанаар өнөөгийн дотоодын болоод гадаадын жуулчдын нүдийг булаасан, хүн бүрийн очих дуртай газар болсон. Энэхүү голын ус нь 2 газраас нийлүүлэгддэг. Нэгд өөрийн ундрагаас, хоёрт Хан мөрний уснаас татаж авч энэхүү голын урсгалыг хэвийн хэмжээнд урсгадаг. Эрхэм та Chonggechon гээд Google-ээр орвол одоогийн болоод өнгөрсөн үеийн түүх болоод зураг, видео бичлэгүүдийг үзэх боломжтой.

Чонгэчон төсөл нь 2008 оны 9 сард дуусч 2008 оны 10 дугаар сарын 1-нд нээлтээ хийсэн. Нийт 5,84 км урттай газрыг тохижуулахад дараах хэмжээний хөрөнгө зарцуулсан байна.

/Сая воноор/

| Он | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|--------|---------|---------|---------|---------|
| Зардал | 354,400 | 357,692 | 379,307 | 386,739 |

Хан мөрний хяналтын хорооны дүрэм

/Ерөнхийлөгчийн 22068 тоот захирамж, Солонгос хэлнээс орчуулав/

3 дугаар зүйл: Хяналтын хороо

1. Хорооны хурал нь байнгын болон түр хурал гэж ангилагдах бөгөөд байнгын хурал нь хагас жилд нэг удаа хуралдана. Харин түр хурал нь шаарлага гарсан үед хуралдана.
2. Хорооны дарга нь хорооны хурлыг зарлан хуралдуулах бөгөөд хурлыг даргална.
3. Хорооны хурал нь хүрэлцэн ирсэн гишүүдийн 2/3-ын саналаар шийдвэрээ гаргана.
4. Хорооны дарга гишүүн шаардсан, шаардлагатай гэж үзвэл холбогдох нутгийн удирдлагын байгууллагын дарга болон мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

3 дугаар зүйлийн 2 дугаар хэсэг. Санал хүсэлт барагдуулах хороо

1. Санал хүсэлт барагдуулах хороо нь дарга, 23 хүний бүрэлдэхүүнтэй байна.
2. Санал хүсэлт барагдуулах хорооны гишүүдээр дараах хүмүүс ажиллана. Сөүл хотын дарга, болон бусад хотын даргын санал болгосон тусгай хот, өргөтгөсөн хот, мужийн иргэн тус бүр нэг хүн, иргэний нийгмийн байгууллагын нэг хүн, аж үйлдвэрийн хүрээний нэг хүн, хүрээлэн буй орчныг хамгаалах байгууллагын нэг хүн байна.
3. Зөвлөгөө өгөх хорооны гишүүн нь 2 жилээр сонгогдох бөгөөд нэг удаа улиран ажиллаж болно.

4 дүгээр зүйл. Ажилчдын холбоо

1. Ажилчдын хороо нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
 - Хорооны зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлыг тогтоох
 - Хорооноос итгэмжлэн өгсөн ажлууд
 - Хорооны даргаас зааварчилсан ажлууд
2. Ажилчдын хороо нь ажилчдын хорооны дарга 1 хүн, нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байна.

5 дугаар зүйл. Хорооны тамгын газар

1. Хороо нь тамгын газартай байна.
2. Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл семинар, телевизийн нэвтрүүлэг хийж олон нийтэд цацаж болно.

Сөүл тусгай хотын Хан мөрний цэцэрлэгт хүрээлэнгийн байгууламж байгуулах болон удирдан зохион байгуулах тогтоол /Хууль зүйн яамны тогтоол 2010-03-01/
/Солонгос хэлнээс орчуулав/

1 дүгээр зүйл.

Энэхүү тогтоол нь хотын оршин суугчийн эрүүл чийрэг, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Хан мөрөнд шаардлагатай байгууламж /тоног төхөөрөмж/ байгуулах, түүнийг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

2 дугаар зүйл.

Энэхүү тогтоолд ард иргэдэд зориулсан байгууламжид дараах байгууламжууд хамаарна.

1. Усан дээрх байгууламж
 - Усан онгоц, усан онгоцны зогсоол, дарвуулт завь гэх мэт
 - Бусад усан дээр ашиглаж болох байгууламжууд

Судалгааны эмхтгэл, X боть

2. Биеийн тамир, спортын байгууламж
 - Хөл бөмбөг, гар бөмбөг, бейсболын талбай /хүүхдийн болон том хүний/, теннисийн талбай, бадминтоны талбай, Солонгос үндэсний нум сумын талбай, тоглоомын талбай, гольфийн талбай гэх мэт
 - Түүнчлэн хүмүүсийн өдөр тутмын эрүүл чийрэг амьдралыг дэмжихэд шаардлагатай байгууламжууд
1. Амралтын байгууламж
 - Усан оргилуур, усан сан, загас барих тусгай тохижуулсан цөөрөм гэх мэт
 - Ард иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэхэд шаардлагатай бусад зүйлс
2. Суралцах байгууламж
 - Байгаль орчны сургалтын танхим, загасны тухай, экологи, байгаль орчны сургалтын ажилтан, зөвлөгөө өгөх төв, яриа лекц хийх танхим гэх мэт
3. Тоглоомын байгууламж
 - Хүүхдийн тоглоомын талбай, унадаг дугуй унах талбай, нисэх онгоц болон бусад төрлийн техникийн загвар гэх мэт
 - Түүнчлэн бусад шаардлагатай хэрэгсэл
4. Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт
 - а) Автомашины зогсоол, ариун цэврийн өрөө, унадаг дугуйн зогсоол, гэрэлтүүлэг, сүүдрэвч гэх мэт
 - б) Түүнээс гадна цэцэрлэгт хүрээлэнг тохь тухтай болгоход шаардагатай зүйлс
5. Цэцэрлэгжүүлэлт
 - а) Зүлэгжүүлэгт, цэцгийн мандал, зэгстэй талбай, арвайн талбай, өвстэй талбай гэх мэт
 - б) Мөн түүнчлэн цэцэрлэгт хүрээлэнгийн өнгө үзэмж, тав тухыг сайжруулахад шаардлагатай зүйлүүд

3 дугаар зүйл.

Сөүл хотын дарга нь Хан мөрний цэцэрлэгт хүрээлэнг иргэдийн ашиглах байгууламжуудыг удирдан зохион байгуулна.

4 дүгээр зүйл.

1. Хотын дарга 3 дугаар зүйлд заасны дагуу Хан мөрний цэцэрлэгт хүрээлэнгийн байгууламжийг удирдах, зохион байгуулахтай холбоотой үүргийг засгийн газар болон энгийн хуулийн этгээд, байгууллага, иргэнээр захиалан хийлгэж болно.
2. 1 дэх хэсэгт заасны дагуу ажил гүйцэтгэж буй этгээд нь 3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
3. Бусад шаардлагатай харилцааг журмаар зохицуулна.

* * *

Тав. ОХУ -ын Москва голын ашиглалт, хамгаалалт, сэргээлтийн талаархи туршлага

а) Москва хот ба Москва гол (Зарим тоо баримт)



Дүрс 1. Москва голын сав газар (цайвар хэсэг)


ОХУ –ын нийслэлийн эл регион 10 сая давсан хүн амтай, олон салбар чиглэлийн үйлдвэрлэл хүчирхэг хөгжсөн, орон сууц - албан байгууллагын барилга байшингийн нягтшил ихтэй ... тийм ч учраас, их хотын ус суваг, усан хангамжийн асуудал төрийн ба нутгийн удирдлагын түвшиндээ, ялангуяа Москвагийн дум, Москвагийн Засгийн газрын анхаарлын төвд байнга байдаг.

Үйлдвэрлэл, ахуйн усан хангамжийн тулгамдсан асуудлууд хэр зэрэг оновчтой зөв зохистой шидэгдсэнээс хот гэдэг их айлын эрүүл ахуйн болон байгаль экологийн оршин тогтнох үндэс суурь ном ёсоор хангагдана. Нэг хүнд ногдох ус, усан хамгамжийн үзүүлэтээр орос орон дэлхийд (Бразил, Канадын дараагаар) 3 дугаарт жагсдаг. Москва хотын оршин суугч өдөрт дунджаар 400 – 470 л. ус хэрэглэдэг гэсэн үзүүлэлт бий. (Доорхи хүснэтийг үзнэ үү)

| | Улс орны нийслэл | Нэг хүнд ногдох усны дундаж хэрэглээ [л.] |
|----|------------------|---|
| 1. | • Афин | 160 |
| 2. | • Барселон | 235 |
| 3. | • Москва | 470 |
| 4. | • Лондон | 286 |
| 5. | • Вена | 317 |
| 6. | • Брюссель | 141 |

Судалгааны эмхтгэл, Х боть

- Оросын Холбооны Улсын нийслэл дундуур Москва-река урсдаг. ОХУ –ын нийслэлийн нутаг дэвсгэрт нийтдээ том жижиг 140 гол горхи (үүний 70 орчим нь бага гол), 4 нуур, 400 гаруй цөөрөм бий. Яуза, Сетунь, Городня, Сходня, Нищенка Истра ... зэрэг голууд нилээн томд тооцогддох бөгөөд тухайн нутаг дэвсгэр дээрх гол мөрний дийлэнх урсац Москва-рекага тэтгэдэг байна.
- ОХУ –ын нийслэлийн нутаг дэвсгэрт, мөн, газар доогуур урсдаг Нищенка, Пресня, Таракановка, Неглинная ... зэрэг хэд хэдэн гол бий. Газар доорхи голууд цас бороо, хөрсний усаар тэжээгдэж урсацын хэмжээ нь өөрчлөгдөж байдаг. Жишээ нь, Неглинная гол газар доогуур 7 км. урсаж, жил болгон дор хаяж 1.5 сая [м³] усаар Москва голыг тэжээдэг.



Дүрс 1. Москва хот орчмын Москва-река

- Москва голын нийт урт нь 502 км. Үүнээс, нийслэл Москва хотын нутаг дэвсгэрт хамаарах [тэр] хэсгийн урт нь 80 км. Москва голын [хотод хамаарах хэсгийн] ай сав 17600 км² талбай эзэлдэг бөгөөд энэ нь Москва хотын нутаг дэвсгэрийн 37,5% -той тэнцэнэ. Голын урсацын хэмжээ 109 м³/сек, гүний хэмжээ (зарим газраа 14 м. хүрдэг) дунджаар 3 – 6 м., урсгалын хурд ~0.5 м/сек байдаг. Москва гол усан тээвэрт ашиглагддаг.
- Москва хотын усан объектууд бүхэлдээ тухайн газар орны гадаргын усыг зайлуулах, хөрсний усыг сэлгэх “тохируулгын” бүхэл цогц нийлмэл систем юм. Москвагийн, жишээ нь, жижиг голуудыг хамгаалахгүйгээр, Москва голыг хамгаалах тухай ярих боломжгүй гэж үздэг. Тиймээс, энэ хандлага бодлогын түвшинд (хууль тогтоомжийн агуулгад) тусгалаа олж, Москвагийн удирдлага нийслэлийнхээ нутаг дэвсгэр дэх Бага голуудыг сэргээн тордох, эрүүлжүүлэн хамгаалах Концепц (Концепция восстановления и реабилитации малых рек г. Москвы) –г батлан хэрэгжүүлж байна. Москвагийн бага голуудын хамгаалалтын бүсийг тогтоосон нь дээрх Концепцийн дагуу хийгдсэн ажил байв. Мөн Москвагийн голуудын голдрилыг гүнзгийрүүлэх арга хэмжээг ч авч байна. Хотын засаг захиргаа энэ мэтээр олон бодит ажил өрнүүлж байдаг ч, хачирхалтай нь, өнөөг хүртэл, гол ус (түүний булан тохой) –г хэсэглэн хариуцуулж хамгаалах чиглэлд ахиц дэвшил гараагүй байна.

- Нийслэл дэх усны нөөцийг хамгаалахад чиглэлд хамгийн их хүндрэл учруулж байгаа асуудал бол гадаргуугийн хог новш янз бүрийн замаар голын голдрилд орох, голын эрэг тохойд хог хаягдал асгах, мөн, их хотын бохирын хаягдал гүйцэд цэвэрлэгдэлгүйгээр ариутгал татуургын сүлжээгээр дамжин гол ус бохирдуулах явдал юм. Томд тооцогдох 200 гаран үйлдвэр завод Москва голд хаягдал усаа [түүгээрээ] нийлүүлж байгаа нь байгааль хамгаалал талаасаа эрсдэл дагуулсан үйл ажиллагаа юм.

Хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа эрхэлдэг 30000 гаран үйлдвэрийн газар Москвад бий. Хотын нутаг дэвсгэрт аж үйлдвэрийн 71 тусгай бүс, 14 дулааны цахилгаан станц, 63 районны дулааны станц, 1000 гаран уурын зуух төвлөрчээ. Москва хотын автопарк 3 сая автомашинаас бүрдэх ба зөвхөн авто тээврийн байгууллага 2500 орчим байна. Москва хот 4 сая тонн. ахуйн хог гаргадаг, үүнийхээ 3 саяыг нь булдаг, 300 мянган тн. –ыг нь шатаадаг, 700 мянган тн. –ыг нь ялган боловсруулж 2 дахь түүхий эдээр ачуулдаг байна.

Товчхондоо, ийм “хүнд нөхцөл” –ийн дундуур Москва гол урсдаг. Москва гол зөвхөн москва хотыг бус өөр олон хот сууринг дайран урсдагийг ч бас дурсах ёстой гэж үзнэ. Москва гол “чац” томтой мөрөн тул, түүнийг жишээ нь, манай Туул голтой адилтган жиших боломжгүй ч энд мөн тэмдэглэж байна.

б) Москва голын бохирдолт, түүнийг саармагжуулах арга хэмжээ

Мэргэжилтнүүд, Москва голын бохирдолт хэр хэмжээнээс давсан байдалтай он удаан жил явж ирсэн нь, эдүгэ, “их байгалийн өөрөө цэвэрших чадамжаас олон дахин давсан” эмгэнэлт байдлыг үүсгэсэн гэж үзэж байна. Иймэрхүү, экологийн “ноцтой” нөхцөл байдал нь, орост, зөвхөн Москва голын ай савд ч үүсээд байгаа юм биш, нилээн хавтгайрсан шинж тархацтай байна гэж үзжээ. Москвагийн олон голын годрил – ёроолд ямар дүр зураг оршин байгааг аймшгийн кино-кадраар төсөөлүүлэн бичиж ярих нь элбэг болсон байна. Үүнийг лабораторийн нарийн анализ, судалгааны байгууллагуудын дүн шинжилгээ давхар нотолдог. Бид хойно зарим жишээг тоо баримтаар дурдах болно.

Москва голыг бохирдлын хамгийн гол үзэгдэл нь түүний ёроолд хуримтлагдсан “байгалийн биш” лаг тунадас юм. Зарим газрын ийм тунадас хатуурч мөртрээр яригдах зузаантай болж, дор нь хийн хурамтлал үүсч бий болсон байдаг гэнэ. Москвагийн засгийн газрын Хүрээлэн байгаа орчныг хамгаалах ... асуудал эрхэлсэн депетаментын мэдээнд, нийслэлийн хэмжээнд ажиллаж байгаа ус цэвэрлэх, ариутгах татуургын 109 байгууламжийн нийт хүчин чадал чамлагдаж байгааг дурдсан байна.

Москва голын уснаас Москваг дайран өнгөрч дуусдаг “гарц” дээрээс дээж авч шинжлэхэд дараахь үр дүн гарсан байна. (Хүснэгтийг үзнэ үү)

| Усны найрлага зарим дахь бодис | Зөвшөөрөгдөх дээд хэмжээг давсан байдал (дахин) |
|--------------------------------|---|
| ▪ Аммоний | 6,9 |
| ▪ Фосфатууд | 7 |
| ▪ Нитритууд | 8,4 |
| ▪ Железо | 2,5 |
| ▪ Марганец | 9 |
| ▪ Цинк | 2,1 |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | |
|--------------------------|-----|
| ▪ Алюминий | 2,4 |
| ▪ Нефтийн гаралтай бодис | 3,9 |
| ▪ Формальдегидууд | 5,5 |

Нэгэнт ийн бохирдсон Москва голыг хэрхэн цэвэршүүлэх вэ; гэдэг бол том асуулт юм. Нэмж бохирдуулахгүй байсан ч гол өөрөө аяндаа цэвэршиж чадахааргүй болсон тухай яригддаг. Хүмүүсийн хамгийн хийж чадах, хамгийн үр дүнтэй арга ажиллагаа бол нийслэлийн цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэлийн асуудал гэж үздэг байна. Борооны ус зайлуулах сувагийн шүүн тунгаах чадамж ч энд хамаатай. Өөрөөр хэлбэл, хот гэдэг их айлын гудамж талбай цэвэр цэмцгэр байх нь гол усаа хамгаалахад шийдвэрлэх нөлөөтэй гэсэн үг аж.

Москва голын хот дотрхи хэсэгт хамаарах 83 км. үргэлжлэх хэсгийн усан мандал доохи үндсэн голдрилын хог новш, иль лагийг бүрэн цэвэрлэхэд дор хаяж 10 млрд. доллар хэрэгтэй гэсэн тойм тооцоо гардаг байна. Холбооны болон орон нутгийн эдийн засгийн чадавхи энэ их мөнгийг гаргах боломгүй болохоор “тухайн уёан объектийг нэмж бохирдуулахгүй байхад” анхаарах “явцуу сонирхол” бас [арга буюу] үүсдэг бололтой юм.

Москва голын усыг ундны зориулалтаар ашигладаггүй нь түүний бохирдлыг тодорхойлох энгийн нэг хэмжүүр юм. Москва голын бохирдолд нэрвэгдсэн “хүнд хэсэг” -үүдийн загасыг хүнсэнд хэрэглэдэггүй. Москва голын [тааламжгүй газрын] загас хүнд металлын давс, нефтийн бүтээгдэхүүнээр хордсон байдаг тул түүнийг идэж гэмээнэ, тэдгээр бодис хэрэглэгчийн бие организмд нэвчинэ, аюултай. Бас, Москва гол өөрөө хөрс ба хөрс зэргэлдээх “цэвэр” усан сангуудыг бохирдуулах боломжтойг ч үгүйсгэдэггүй байна.

Москвагийн Засгийн газар Москва голыг хамгаалах асуудал ихээхэн анхаарч байна. 1999 оноос ОХУ –ын нийслэл Москва хот экологийн бодлогоо өөрчлөх бодлогын баримт бичиг (Их хотын экологийн аюулгүй байдлыг хангах Концепц) -ээ боловсруулан баталж мөрдөж байгаа юм. Хэдий тийм ч, олон нийтийн зүгээс усны ай савыг хамгаалах бодлого чадамжийг хотын удирдлагууд 1995 оноос эхлэн байнга сулруулж ирсэн гэх шүүмжлэл ч цөөнгүй гарч байдаг. Их хотын экологийн аюулгүй байдлыг хангах Концепцээс урган гарсан гэж хэлж болох хотын байгаль орчныг хамгаалах сэдэв чиглэлтэй эрх зүйн хэм хэмжээ тогтоосон 100 гаран хууль тогтоомж батлагдан гарчээ. Бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 он хүртэлх суурь програм (Хөтөлбөр)¹⁰ –аа ч баталсан байна.

с) ОХУ –ын Усны кодексийн байгаль орчныг хамгаалах чадамж, агуулгын зарим онцлог

Москва хот байгалийн усан объектоор нэн баян болохыг бид өмнө тоо баримтаар цухас дурдсан билээ. Тийм болохоор тэнд, засаг захиргааны зүгээс, зөвхөн нэр бүхий нэг – хоёр голыг хамгаалах тухай ярихаасаа илүү усан бассейнаа бүхэлд нь хамгаалах чиглэлд түлхүү анхаардаг байна. Манайд, монголд байдал [арга буюу] эсрэгээр тавигдаж, бид, бид эдүгээ ганцхан Туул голоо хамгаалах тухай ярьж байгаа нь зарчмын үүднээсээ бол ялгаагүй зүйл юм.

Бүгд Найрамдах Солонгос ... зэрэг зарим улс оронд зөвхөн тухайлсан нэг гол мөрнийг хамгаалах тухай хууль байх нь байдаг. Гэвч энэ дэд хэсэгт бид, зөвхөн ОХУ –ын хууль тогтоомжийн зарим зохицуулалт, тухайлсан холбогдох заалтууд, гол ус хамгаалах тулгамдсан асуудлуудыг авч үзэх зорилготой болно.

¹⁰ Оросын Холбооны Улсын хууль; гэсэн агуулгаар;

1. Холбооны хууль (2004.8.22, №122) –аар “буцаан авч”, 4 сарын дараа Холбооны хууль №199 (2004.12.29) –өөр, холбооны субъектад “буцааж олгосон” байгаль хамгаалах чиглэлэйн нилээн хэдэн бүрэн эрх бий. Тэнд зааснаар, байгалийн усан объектийг хамгаалах чиглэлээр холбооны субъектүүд “төрийн нэрийн өмнөөс хийгдэж байгаа мониторингийн үйл ажиллагаанд бүрэн эрхтэй ороцох, усан объектийн экологийн байдалд хохирол учруулсан этгээдээс хохирол нэхэмжлэх эрхтэй” гэж заажээ.
2. ОХУ –д, 2006 оны 6 сарын 3 –наас Усны нэгдсэн [шинэ] кодекс үйлчилж эхэлсэн. Энэ хуулийг олон нийт, хууль хэрэгжүүлэгчийн зүгээс шүүмжилж байсан ч, тэрээр эдүгээ, Москвагийн усан бассейныг хамгаалахад мөрддөг гол эрхзүйн баримт бичгийн үүргийг гүйцэтгэж байна. Тухайлсан нэг – хоёр гол мөрнийг хамгаалахад зориулсан хууль гарсан тохиолдолд “тэнд Водный Кодекс” хэрэг дээрээ мөрдөгдөхгүй болох аюул байдаг; гэж үзнэ.
 - Тэрхүү Водный кодекс (цаашид “кодекс” гэх) –ийн 55 дугаар зүйлд, усан объектийн өмчлөгчийн (гол ус хамгаалах чиглэлд) хүлээх үүргийг зааж өгсөн. Усан объектийн гол өмчлөгийнхөө хувьд төр өөрөө “цөөнгүй үүрэг” үүгээр бас хүлээсэн гэж хэлж болно. Төр тэр үүргээн хэрэгжүүлэхээр бүтцийн байгууллагуудаа ч зохих ёсоор байгуулдаг гэж хэлж болох үндэстэй. Усны нөөцийн холбооны агентлаг, ОХУ –ын Байгалийн баялгийн яам, Эрүүл ахуй, ариун цэвэр, халдвар судлал байгууллага (Госкомсанэпиднадзор) -ууд нь тэдгээр үүргийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээнэ.
 - Хувьчлагдсан усан объектийг өмчлөгч нь усыг бохирдуулахгүй байх, бохирдсон тохиолдолд хорт нөлөөллийг саармагжуулах үүрэг мөн хүлээнэ.
 - Москвагийн хууль тогтоомж, мэдээж хэрэг, холбооны хуульд нийцэж гарна. Москвагийн засгийн газрын тэргүүн, дэд тэргүүний захирамж, Москвагийн засгийн газрын тогтоол ... засаг захиргааны нэгжийн удирдлагаас гаргасан холбогдох шийдвэрүүдээр нийслэлийн усны нөөцийн ашиглалт хамгаалалтыг зохистой шийдэх боломжтой. Өөрөөр хэлбэл, ОХУ –д засаг захиргааны нэгжийн удирдлага төвөөс хараат биш байдлаар ажиллах боломжоор түлхүү (манайхыг бодвол харьцангуй илүү) хангагдсан байдаг.
 - Усны кодекс (2006) батлагдах хүртэл гол ус хамгаалах Москвагийн засгийн газрын хууль тогтоомжид олон зүйл тодорхой байх боломжгүй байсан гэж үздэг байна.
 - Эдүгэ, ОХУ –д Усны кодексийг мөрдөж хэрэгжүүлэх “дагалдах дүрэм журам” бүрэн дүүрэн гарч амжаагүйгээс ... тухайн асуудалд холбогдох жижиг сажиг олон зүйл нэг хэсэгтээ урьдын адил зохицуулалтгүй хэвээр явах төлөвтэй байгааг ч иргэний нийгмийн байгууллагууд анхааруулсаар байдаг. Ер нь, бүхнийг хуулиар зохицуулна гэсэн үзэл санаа өөрөө утопи шинжтэйг энд ч бас хамаатуулан тэмдэглэмээр байна.

Хотын хүн ам, нутаг дэвсгэр, хүрээлэн байгаа орчныг байгалийн болон техноген шинж чанартай гэнэтийн аюул ослоос хамгаалах “санхүүгийн баталгаа” –ны тухай Москва хотын хууль батлагдан (1997.11.5., хууль №46) хэрэгжиж байна. Энэ хуулийн 13 дугаар зүйлд зааснаар, үйл ажиллагаа нь осол аваарын улмаас (хүний хүчин зүйлээс хамааран) доголдож, улмаар, байгаль орчныг огцом бохирдуулах, оршин суугчийг хордуулах, айлган түгшээх магадлалтай “аюултай үйлдвэрлэл” эрхэлдэг үйлдвэрийн газруудад “аюулын зэрэг” - ангилал тогтоодог байна. Улмаар, мөн хуулийн 39 дүгээр зүйлд заасан ёсоор, тодорхой ангилалд багтсан “аюул тарих магадлалтай аж үйлдвэрийн обектууд” нийгэмд учруулж болзошгүй “ирээдүйн” эрсдэлээс “өөрийгөө болон нийгмийг хамгаалах баталгаа” болгож, “экологийн датгалд” заавал даатгуулах ёстой юм. Энэ бол, уг чанартаа “экологийн ...” нэртэй хариуцлагын даатгал мөн; гэж үзнэ.



d) Зарим санал

1. Байгалийн усан объектийн нөөц - ресурс харьцангуй багатай (mongolia ... г. м. мэт) бүс нутагт, нутгийн иргэд ердийн ухамсрын түвшиндээ “гол ус” гэдгийг яг харагдаж байгаа “усан толио” –гоор нь явцуу төсөөлдөг гэнэн үзэгдэл их байна. Тиймээс тэд, тухайн объектыг хамгаалах нэрийн дор “хаших, хашаалах” сонирхолд илүү хөтлөгддөг гэж үзэж болохоор байгаа юм.

Гол усыг хамгаална гэдэг бол, өргөн утгаараа, тухайн голын ай савыг бүхэлд нь хамгаалах үйл явц байдаг ажээ. Их голын ай савд, жишээ нь, хөрсийг хамгаалах нь усыг хамгаалж байгаа хэрэг мөн юм. Энэ байдал, ОХУ –ын холбогдох туршлагаас харагдаж байна.

2. Их хотын байгалийн усан объектыг хамгаалах арга – нөөцийн нэг бол үйлдвэр байгууллагын хаягдал усыг, тэнд нь орчин үеийн өндөр технологиор цэвэршүүлж, ахин дахин ашиглах, дотоод локаль эргэлтэд оруулах замаар, бохир усыг их голд оюулэх “нийлүүлэлт” –ийг багасгах явдал мөн; гэсэн мэргэжилтнүүдийн саналыг ч манайд бас анхаарах нь зүйтэй болов уу.
3. Тусгаар тогтносон хамтын нийгэмлэгийн орнуудын “Экологийн даатгалын тухай” загвар хууль (Модельный закон “Об экологическом страховании” от 15.11.2003 г.) гарсан байдаг. Ер нь, ОХУ (Москвагийн парламент, Засгийн газар) чухамхүү энэ “экологийн даатгал” –ын хүрээнд хамаатуулж, гол усаа технологийн үүсэлтэй эрсдэлээс хамгаалах “санхүүгийн баталгаа” бий болгож байгаа нь анхаарал татах аспект мөн; гэж үзнэ.

4. Монголд байгаль орчны чиглэлтэй 40 шахам үйлчилдэг. Эдгээр хуулийн агуулын нийтлэг хүрээнд тухайлсан нэг нэр бүхий гол горхийг хамгаалж болохгүй байх үндэсгүй мэт. Сайн бодож боловсруулаагүй олон хууль журам уул ус, гол орхийг гол усыг хамгаалах үүргээ тэр бүрий биелүүлэхгүй, харин ч бүр сөрөг эффект өгч, (зарим талаар) “тухайн объектын эс хамгаалалт” –ыг өөгшүүлэх чиглэлд үйлчилдэгийг судлаачид тэмдэглэж иржээ.

Гол мөрний ай савд ашиглалт олборлолт явуулж байгаа уул уурхайн болон барилгын компаниудын хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа нь хуулийг олон болгоноор буурахгүй. Энэ нь хуулийн хэрэгжилтийн практикаас нэгэнт тодорхой болсон зүйл юм. Тэгэхээр, хуулийн хүрээнд асуудлыг зөв зохицуулъя, үр дүнг нь үзье гэвэл нэгэнт гарсан хуулиа агуулгын хувьд төгөлдөршүүлэх хэрэгтэй.

5. Сүүлийн жилүүдэд, Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Экологийн хохирлыг нөхөн төлөх журмын тухай хууль ... гээд шинэ шинэ олон хуулийг санаачлан гаргах цаг болсон тухай их ярьж бичиж байна. Гарсан хойноо хэрэгжих магадлалыг нь бодолцвол бидэнд “Экологийн даатгалын тухай хууль” нэн тэргүүнд хэрэгтэй байгаа юм. Энэ хууль батлагдвал, ядаж Улаанбаатарын районд Туул голыг элдэв эрсдэл, бохирдлоос хамгаалахад ихээхэн хэрэг болно.



**ХОТЫН ТУХАЙ ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД
ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ** (Харьцуулсан судалгаа)

Ц. Товуусүрэн, Б. Буяндэлгэр, П. Амаржаргал, Б. Хатантуул

УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнгийн захиалгаар “Хотын тухай гадаадын зарим улс Үндсэн хуульд зохицуулсан байдал” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Судалгааны төвийн ахлах судлаач Ц.Товуусүрэн, Б.Буяндэлгэр, судлаач П.Амаржаргал, Б.Хатантуул нарын бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэв.

Энэхүү судалгааг хийхдээ гадаадын санамсаргүй сонгосон 19 орны Үндсэн хуулийн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллага гэсэн бүлэгт хотын тухай асуудал тусгалаа олсон эсэхийг харуулахын тулд тэдгээр улс орнууд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд яаж хуваагддаг тухай зүйл заалтуудад голлон анхаарсан бөгөөд мэдээллийн бусад эх үүсвэрээс одоогийн байдлаар хуулийн дагуу байгуулагдсан муж, бүсийн тоо, түүний бүрэлдэхүүнд орж байгаа хотуудын талаар олж харуулах зорилго тавьсан болно.

Судалгааны дүгнэлт.

1. Судалгаанд хамрагдсан 19 улсын хүрээнд авч үзэхэд Унгар, Лаос, Киргиз, Куба, Нидерланд, Португаль, ОХУ, Румын зэрэг 8 улс Үндсэн хуульдаа хот гэсэн нэрийг оруулсан байгаа боловч засаг захиргааны хамгийн том нэгжийн хэмжээнд тооцогдох хотын шалгуурыг хуулиар тогтоодог болох нь тодорхой байна. ОХУ нь Үндсэн хуульдаа “улсын зэрэглэлтэй хот” гэж заасан бөгөөд Холбооны субъектын тухай хуулиараа Москва, Санкт-Петербургийг л холбооны субъект болгосон байна. Үндсэн хуульдаа хот засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байх тухай заагаагүй, ерөнхий заалттай улс орнуудад хотыг парламентын баталсан хуулийн дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болгосон, мөн нэгжийн төв нь байхаар тогтоосон улс орнууд судалгаанд хамрагдсан орнуудад нийтлэг байна.
2. Улс орнуудын Үндсэн хуульд хотын эрх зүйн асуудлыг ихэвчлэн тодорхойлон заагаагүй байгаа бөгөөд хотууд ихэнхдээ мужийн бүрэлдэхүүнд багтдаг байна.
3. Улс орнуудын Үндсэн хуульд хотын талаар “хотын эрх зүйн байдлыг хуулиар тогтооно” гэж гол төлөв заасан байгаа нь өнгөц харахад хангалтгүй мэт боловч цаана нь хотын эрх зүйн байдлыг тогтооход өргөн хүрээний эрх мэдэл парламентад үлдэж байгаа юм.
4. Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан “хотын талаархи зохицуулалтууд” нь нэг талаас тодорхой болсон юм шиг атлаа тодорхой зохицуулалт хийх гэхээр хязгаарлаад байгаад л асуудлын гол нь оршиж байна.
5. Улс орнуудын Үндсэн хуульд хотуудын эрх хэмжээг тусгайлан заагаагүй ч Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулахдаа хотуудын нэрээр байгуулдаг хандлага нэлээд нийтлэг байна.
6. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төв нь томоохон хотууд байх хандлага ч нэлээд нийтлэг байна.
7. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрт орших хотын эрх хэмжээг нэмэгдүүлдэг хандлага ч байдаг юм байна. Жишээ нь: Улсын хэмжээнд мужийн, мужид дүүргийн эрх хэмжээ бүхий хот гэх мэт. Ийм зохицуулалтыг Үндсэн хуулиар

Судалгааны эмхтгэл, Х боть

биш Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулдаг байна.

8. Дээр дурдсан хандлагыг улс орнуудын нийтлэг жишиг гэж үзэн **Үндсэн хуулийн холбогдох заалтыг энэхүү жишгийн дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн талаар нийтлэг заалттай болгон тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн байдал, хилийн заагийг хуулиар тогтооно** хэмээн тогтоовол өнөөдөр манайд тохиолдож байгаа хотын эрх хэмжээний асуудал, баг, хорооны түвшинд Засаг даргын сонгууль явагдах эсэх, ер нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн доод шатны нэгжүүдийн удирдлагыг зохион байгуулалтын хэлбэр болгох, эсэх, бусад шийдвэрлэхэд бэрхшээлтэй байгаа асуудлыг ч шийдэхэд Үндсэн хууль саад болохгүй байх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна
9. Хотын талаархи үндсэн ойлголт, шалгуурын талаар **“Орон нутгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай, бусад орны туршлага”** УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн зарим судлаачдын хийж гүйцэтгэсэн судалгааны ажилд гаргасан дор дурдсан мэдээллийг анхааран үзэж шийдвэр гаргах нь зүйтэй юм.

“Орон нутгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай, бусад орны туршлага”

УИХ-ын Тамгын газрын судалгааны төвийн зарим судлаачдын хийж гүйцэтгэсэн судалгааны ажилд “Аливаа улс орны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн олон улсын хэмжээнд нэгдсэн шалгуур стандарт байхгүй ч ерөнхий зарчим, зүй тогтлыг анхаарахыг зөвлөдөг байна. Дэлхийн улс орнуудын засаг захиргааны бүтэц, хувиарлалтыг ерөнхийд нь авч үзвэл:

- Хот/Urban/
- Тосгон, хөдөө /rural/ гэсэн 2 ерөнхий төрөлд хуваагдаж байна.

“Хот” хэмээх ойлголтыг олон улсын түвшинд засаг захиргааны нэгж, муж хэмээх ойлголтуудаас салангид авч үздэг. Хот болон засаг захиргааны стандартыг тухайн улс орнуудын улс төрийн тогтолцоо, эдийн засгийн бүтэц, соёл заншил, газар нутаг, цаг уур хүн амын тоо гэх мэт зүйлсээс шалтгаалж нэг улсын 2 өөр хотод ч ижил стандарт баримтлах боломжгүй гэж үздэг байна.

Аливаа суурин газрыг хот гэж үзэхийн тулд хүн амаар нь хамгийн түрүүнд ангилал тогтоодог. НҮБ-ийн тодорхойлсноор: 1990-ээд оны үед Хүн амын хувьд 20 мянган хүнтэй бол жижиг хот (urban), 100 мянгаас дээш хүн амтай бол хот (city) хэмээн үзэж байсан бол орчин үед жижиг хотыг 15 мянган хүн амтай болгож буулгажээ. Хамгийн багадаа ийм хэмжээний хүн амтай байж л эдийн засаг, төсвийн хувьд бие даан оршин тогтнох боломжтой хэмээн үздэг байна.

Энэ тооны хязгаар бол Монгол улсын хувьд хүн амын тоог хот суурин газар амьдарч байгаа иргэдтэй харьцуулж үзэхэд тохиромжтой байж болох үзүүлэлт юм. Хот бие даасан, төсвөө өөрөө бүрдүүлж оршин тогтнож чадаж байхын тулд:

- Байнгын оршин суугч хүн ам нь харьцангуй олон байх;
- Хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар сайн хөгжиж, зөвхөн түүн дээрээ тулгуурлан оршин тогтнодог аж үйлдвэржсэн суурин газар байх; (Анхандаа хотуудыг тодорхой нэг томоохон үйлдвэрийг дагаж байгуулж байсан бол орчин үед аль болох эдийн засгийн байдлаар нь төрөлжүүлж аль нэг тодорхой салбараас хараат бусаар оршин тогтнох нөхцлийг хангахад анхаарах болсон).
- Аль нэг засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт оршиж төрөөс олгосон тодорхой эдэлбэр газартай байх гэх мэт шинжүүдийг агуулсан байх шаардлагатай юм.

Дээр дурьдсан байгаль орчин, экологийн хамгааллыг хангах, хүн амын эрүүл орчинд амьдрах нөхцлийг хангаж байхын тулд эдэлбэр газартай хотын газар нутгийг үндсэн 3 хэсэгт хувааж үздэг.

1. **Хөгжлийн идэвхтэй бүс:** Энэ бол голлох үйлдвэрлэл, үйлчилгээний салбар болон хотын захиргаа гэх мэтээр төсвийг бүрдүүлэх гол эх үүсвэрүүдийг багтаасан хэсэг юм.
2. **Хотын ногоон бүс:** Энэ нь ногоон байгууламжаасаа тусдаа ойлголт ба тусгайлан тогтоосон амралт, соёлын бүс байдаг. Энд ямар нэгэн үйлдвэрлэл явуулахыг хориглох ба үйлчилгээний томоохон бүсийг бий болгосон байна.
3. **Дагуул бүс:** Энэ нь голчлон дагуул хот эсвэл орон сууцны хороолол гэх мэтээр тодорхойлогддог.

Хотыг байгуулах, бий болгохын тулд үндсэн 2 шатыг дамжих, эсхүл энэ 2 ажлыг заавал гүйцэтгэсэн байх ёстой гэж үздэг. Үүнд:

1. **Хотын доорх инженерийн байгууламжийг бий болгосон байх.** Хүний эрүүл, аюулгүй амьдрах боломжийг бүрдүүлж аливаа байгалийн болоод нийгмийн эрсдэлээс хамгаалах бүхий л байгууламжийг бий болгох шаардлагатай.
2. **Газар дээрхи дэд бүтцийг бий болгох.** Энэ нь хүний аюулгүй, тухтай, эрүүл орчинд амьдрах, хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд зориулсан авто зам, цахилгаан, шугам сүлжээ гэх мэтийг байгуулсан байх, тэр нь байгаль орчинд хор нөлөөгүй байх.

Дээр дурьдсан үе шат (үйл ажиллагааны дараалал)-аас харж байхад хамгийн ихээр анхаарч байгаа асуудал бол **байгаль орчны хамгаалал** болж байна. Хүн ам хэдий чинээ хот суурин газарт төвлөрч амьдарч эхэлнэ, төдий чинээ байгаль орчинд үзүүлэх хор нөлөөл их болдог. Ялангуяа, дэлхийн улс орнуудын хотжих процесс, хот суурин газрын үйлдвэржилт, хүн амын өсөлтөөс шалтгаалж сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал ихээр явагдаж байгааг олон улсын байгууллагууд цохон тэмдэглэж байгаа.

Ийнхүү хотыг байгуулсаны дараахь байгаль орчны асуудлууд тавигдаж байгаа ч хотыг өөрийг нь барьж байгуулахад тооцвол зохих байгаль орчны асуудал байдаг. Өөрөөр хэлбэл, хотод амьдарч байгаа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн тулд байгаль орчны нөлөөллөөс хамгаалахад дараахь зүйлсийг харгалзаж үзэх юм. Үүнд:

- Усны нөөц
- Мөнх цэвдэг
- Газар хөдлөлтийн идэвхжил
- Байгалийн гэнэтийн үзэгдэлд өртөх магадлал

Хот суурин газар хөгжихийн хэрээр засаг захиргааны нэгж бүтцэд ч тодорхой өөрчлөлт гардаг гэж үздэг. Улс орнуудын хот байгуулах гол шалгуур нь хүн ам, нийгэм эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ, ажлын байрны хангагдсан байдал зэрэг байдаг. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан Монгол орны хот, суурингуудыг үнэлэхэд нийт хот суурины 34.7 хувь нь тохиромжтой, 51.5 хувь нь хязгаарлагдмал тохиромжтой, 11.1 хувь нь тохиромжгүй гэсэн ангилалд багтаж байна. Хязгаарлагдмал тохиромжтой гэсний учир нь дээрхи шалгууруудыг бүрэн хангаж чадахгүй, аль нэг нь “зөрчилтэй” байгаа юм” гэсэн байна.



Гадаадын зарим улс орны Үндсэн хуульд хотын талаар зохицуулсан нь

Судалгааны багийн судалгаанд хамруулсан Ази, Америк, Африк, Европ тивийн гол төлөв төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улсуудын хувьд Үндсэн хуулийн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт хотын тухай заалтууд дор дурдсан байдлаар тусгагдсан байна.

1. Унгар Улс**Үндсэн хууль. IX бүлэг. 41 дүгээр зүйл. Засаг захиргааны нэгж**

1/ Унгар Улс нийслэл, тойрогт хуваагдах бөгөөд , цаашид хот, коммун гэсэн засаг захиргааны нэгжид хуваагдана.

2/ Нийслэл дүүрэгт хуваагдах ба хот дүүрэгтэй байж болно.

71 дүгээр зүйл. Сонгууль

Парламентын гишүүд нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүд, нийслэл, бусад нэгжийн мэрийг нийт ард түмнээс шууд нууц, тэгш эрхийн үндсэн дээр сонгоно.

Нэмэлт мэдээлэл: Унгар Улс 19 тойрог, нийслэлд хуваагдах бөгөөд тойргийн нэр нь төвийнхөө нэртэй ихэвчлэн давхцахгүй. 1996 оноос 19 тойргийг 7 бүсд хамааруулан бүлэглэсэн байна. Будапешт дэд бус нутагт хамаарна. Түүнчлэн 23 хотын эрх хэмжээтэй байх бөгөөд анхан шатны нутаг дэвсгэрийн нэгжээс давуу эрхтэй, гэхдээ тухайн тойрогтоо хамааралтай байдаг.

2. Намиби Улс**Үндсэн хуулийн 102 дугаар зүйл. Бүс нутаг, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтэц.**

1/ Намибийн төрийн удирдлагыг бүс нутаг, орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор бүс нутгийн болон орон нутгийн байгууллагад хуваагдах бөгөөд тэдгээрийн хуваарийг парламентын баталсан хуулийн дагуу тогтооно.

2/ Бүс нутаг, орон нутгийн байгууллагын хилийн заагийг арьсны өнгө, үндэстэн ястан, оршин суугчдын гарал үүслээс үл хамааран зөвхөн газар зүйн байдлаар тогтооно.

...

4/ Засаг захиргааны орон нутгийн эрх барих байгууллага нь парламентын баталсан хуулийн дагуу дүүрэг, обшин, тосгоны зөвлөл байх ба бусад нутгийн өөрөө удирдах байгууллага байна. Мужуудын хилийг бүрэн эрхэт комисс энэ зүйлийн 2-т заасны дагуу тодорхойлно.

Нэмэлт мэдээлэл: Намиби 13 бүс, 107 тойрогт хуваагдана. Засаг захиргааны хуваарийг бүрэн эрхэт комиссын санал оруулсанаар Үндэсний ассамблей батлах буюу буцаана.

3. Марокко Улс**Үндсэн хуулийн 94 дүгээр зүйл. Орон нутгийн нэгж.**

Хаант улс бүс нутаг, тойрог, муж, коммунд хуваагдана. Тэдгээрийг шинээр байгуулахдаа тусгай хууль гаргаж байгуулна.

Нэмэлт мэдээлэл: Марокко Улс 16 бүс, 62 тойрог, мужид хуваагдаж байв. 1997 онд бүс нутгийн тухай хууль баталж, шинээр бүс байгуулж одоо 37 муж, 2 милайгаас бүрдэж байна. Марокко Улс 20 томоохон хоттой. Үүнээс Касабланка, Рабат хот 16 бүсийн тоонд багтдаг.

4. ӨАБНУ

Үндсэн хууль (1997)-ийн 103 дугаар зүйл. Муж

1/ ӨАБНУ дор дурдсан мужид хуваагдана:

а/ Дорнод Кейл

б/ Чөлөөт улс

в/ Гаутенг

г/ Квазулу Наталь

д/ Мпумаланга

е/ Умард Кейл

ж/ Умард муж

з/ Бйруун хойт муж

и/ Өрнөд Кейл

2/ Мужуудын хилийг Үндсэн хууль батлагдах хүртэл мөрдөж байснаар тогтооно.

Нэмэлт мэдээлэл: 2007 оны байдлаар 1 саяаас дээш хүн амтай 6 муж, 500000-1000000 хүн амтай 8 муж, бүгд 20 муж байгаагийн дотор Йохансбург, Кейптаун, Тшване, Матлосане зэрэг хэд хэдэн хот хамрагддаг. Тэдгээрийн зарим нь хэдэн зуун жижиг суурингаас бүрддэг байна.

5. Япон Улс. Үндсэн хууль

Наймдугаар бүлэг. Орон нутгийн өөрийн удирдлага 92 дугаар зүйл.

Орон нутгийн нийтийн эрх зүйн этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдох журмыг орон нутгийн хараат бус байдлын зарчимд нийцүүлэн хуулиар тогтооно.

Нэмэлт мэдээлэл: 47 Мужаас /都道府県 todōfuken/ бүрдэх ба нэг нийслэл хот /to—Tokyo/. Хоёр хотын зэрэглэл /fu—Kyoto and Osaka/ 43 аймаг (ken), нэг тусгай дүүрэг)(dō—Hokkaidō) байна.

6. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс.

Үндсэн хууль Наймдугаар бүлэг. Орон нутгийн захиргаа

75 дугаар зүйл. (шинэ) Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс нь аймаг, дүүрэг, тосгон гэсэн 3 түвшний орон нутгийн засаг захиргааны нэгжтэй байна.

Аймгийн түвшин нь аймаг болон том хотоос бүрдэнэ;

Дүүргийн түвшин нь дүүрэг болон хотоос бүрдэнэ;

Тосгоны түвшин нь тосгоноос бүрдэнэ.

Аймгийг засаг дарга, том хотыг том хотын засаг дарга, дүүргийг захирагч, хотыг хотын захирагч, тосгоныг тосгоны захирагч тус тус захирна.

Засаг дарга, захирагч, хот тосгоны захирагч нар нь өөрсдийнх нь ажилд туслах үүрэг бүхий орлогчтой байна.

Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Үндэсний ассамблейгаас Тусгай бүсийг бий болгох шийдвэр гаргаж болох бөгөөд тусгай бүс нь аймагтай ижил статустай байна.

77 дугаар зүйл. (шинэ) Хотын захирагч нь хотын хөгжил, хотын нийтийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, захирах, хотын төлөвлөгөөнд заасны дагуу цэвэр байдал, дэг журмыг сахиулах болон хууль, журамд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлэх эрх, үүрэгтэй.

78 дугаар зүйл. Тосгоны захирагч нь төрийн шийдвэр, тушаал, хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тосгонд нийгмийн дэг журам, энх тайвныг сахиулах, тосгоныг бүх талаар хөгжүүлэх асуудлыг хариуцна.

Нэмэлт мэдээлэл: Лаос улс нь 18 аймагт хуваагдах бөгөөд (khoueng), нэг хотын захиргаа, нэг тусгай бүсээс (khetphiset) бүрдэнэ.

7. Бүгд Найрамдах Киргиз Улс.

Үндсэн хууль Хоёрдугаар хэсэг. Орон нутгийн төрийн захиргаа

76 дугаар зүйл.

Аймаг, дүүрэг, хотод гүйцэтгэх эрх мэдлийг нутгийн захиргааны байгууллагууд хэрэгжүүлнэ.

77 дугаар зүйл.

1. Орон нутгийн төрийн захиргааны байгууллага нь Үндсэн хууль болон бусад хуульд үндэслэн үйл ажиллагаа явуулна.
2. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг холбогдох нутаг дэвсгэрт заавал биелэгдэх шинжтэй эрх зүйн актыг эрх хэмжээний хүрээнд гаргаж болно.

Нэмэлт мэдээлэл: Киргиз улс нь долоон мужаас (oblastlar) бүрдэх бөгөөд нэг хот (shaar) байна.

8. Бангладеш Улсын Үндсэн хууль

Гуравдугаар бүлэг. Нутгийн өөрийн удирдлага. 59 дүгээр зүйл.

1. Бүгд найрамдах улсын засаг захиргааны нэгж тус бүрт хуулийн дагуу сонгогдсон гишүүдээс бүрдсэн нутгийн өөрөө удирдах байгууллага байна.
2. Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурьдсан байгууллага нь өөрийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээр парламентаас баталсан хуульд заасан чиг үүргийг гүйцэтгэнэ:
 - засаг захиргаа болон албан тушаалтны чиг үүрэг;
 - нийгмийн дэг журмыг сахиулах;
 - олон нийтийн үйлчилгээ ба эдийн засгийн хөгжлийг дээшлүүлэх төлөвлөгөөг зохиож, гүйцэтгэх.

9. Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хууль 117 дугаар зүйл.

1. Нутгийн өөрөө удирдах байгууллага орон нутгийн иргэдийн нийгмийн халамжийн асуудал болон хуульд заасны дагуу нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэнэ.
2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын төрлийг хуулиар тогтооно.

Нэмэлт мэдээлэл: Өөрөө удирдах 8 муж(Do•도), 5 бие даасан хот Bu(부), 20 газар Мок (목) бүрдэнэ.

10. Бүгд Найрамдах Куба Улс

Үндсэн хууль. Есдүгээр бүлэг. Улс төр-захиргааны хуваарь, 102 дугаар зүйл. Улс орон улс төр захиргааны зорилгоор аймаг, хотод хуваагдах бөгөөд тэдгээрийн тоо, хил хязгаар нэрийг хуулиар тогтооно. Хуулиар шинэчилсэн хуваарийг тогтоож болно.

Нэмэлт мэдээлэл: Куба улс нь 15 муж, нэг тусгай хотын захиргаанаас бүрдэнэ. 2010 оны 8 дугаар сард Үндэсний хурлаас шинээр хоёр муж бий болгосон.

11. Нидерландын Вант Улс.

Үндсэн хууль. Долоодугаар бүлэг. Аймаг, хот, усны зөвлөл болон бусад нийтийн захиргааны байгууллага

123 дугаар зүйл.

1. Аймаг болон хот нь Парламентын актаар тарж, шинээр байгуулагдаж болно.
2. Парламентын актаар хотын болон аймгийн хилийн заагийг шинэчлэн тогтоож болно.

Нэмэлт мэдээлэл: 12 муж, 418 хотын захиргаанаас бүрдэнэ.

12.Украин Улс

Үндсэн хууль. Арван нэгдүгээр бүлэг. Нутгийн өөрийн удирдлага

140 дүгээр зүйл.

- Нутгийн өөрийн удирдлага гэдэгт нутаг дэвсгэр дэх олон нийт буюу тосгоны оршин суугчид, эсхүл хэд хэдэн тосгоны оршин суугчдын сайн дурын холбоо, гацааны оршин суугчид, том хотын оршин суугчид нь орон нутгийн шинжтэй асуудлаа Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд бие даан шийдвэрлэх эрхийг эдэлнэ.
- Киев хот болон Свестаполь дахь нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой онцлог асуудлуудыг Украины тусгай хуулиар зохицуулна.
- Нутгийн өөрийн удирдлагыг орон нутгийн олон нийт хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх ба шууд хэлбэрээр болон нутгийн өөрийн удирдлагын байгууллага болох тосгон, гацаа, хотын зөвлөл болон тэдгээрийн гүйцэтгэх байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.
- Дүүрэг ба аймгийн зөвлөлүүд нь нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд бөгөөд тосгон, гацаа, хотын нутаг дэвсгэрийн олон нийтийн эрх ашгийг төлөөлнө.
- Хот, дүүргийн захиргааны зохион байгуулалтын асуудлыг хотын зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.
- Тосгон, гацаа, хотын зөвлөл нь оршин суугчдын санаачилсны дагуу танхим, гудамж, хороолол болон бусад нийтийн өөрийн удирдлагын байгууллагыг байгуулж, тэдгээрт санхүү, хөрөнгө, болон бүрэн эрхийг шилжүүлж болно.



Судалгааны эмхтгэл, Х боть

Нэмэлт мэдээлэл: 12 муж, 418 хотын захиргаанаас бүрдэнэ.

13. Бүгд Найрамдах Португал Улс

Үндсэн хууль. Наймдугаар бүлэг. Нутгийн удирдлага

235 дугаар зүйл. Нутгийн удирдлага бол ардчилсан нийгмийн салшгүй хэсэг мөн.

236 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэлбэр

1. Португалийн эх газар нь дүүрэг, хот, районд хуваагдана.
2. Азорэс болон Мадеирийн өөртөө засан тогтнох тойрог нь муж, дүүрэгт хуваагдана.
3. Хот, арлын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

Нэмэлт мэдээлэл: Хоёр өөртөө засах муж /Regixes Autnomas/, 18 дүүрэг / Distritos/, 7 их хотын зэрэглэлийн газар /Grande Brea Metropolitana/, 12 хотын нэгдэл / Comunidades Urbanas/ 308 хотоос /Concelhos/ бүрдэнэ.

14. Оросын Холбооны Улс. Үндсэн хууль

5 дугаар зүйл

1. Оросын Холбооны улс нь бүгд найрамдах улс, муж, хязгаар, холбооны /улсын/ зэрэглэлийн хот, автономит муж, автономит тойрог гэсэн эрх тэгш субъектүүдээс бүрдэнэ.

Нэмэлт мэдээлэл:

ОХУ-ын холбооны субъектын тоонд Москва, Санкт-Петербургээс гадна нийт 20 том хотоос 12 хотын нэрээр нэрлэгддэг холбооны субъект байна.

15. Казахстан Улс. Үндсэн хууль, 1 дүгээр бүлэг. 2 дугаар зүйл.

3. Тус улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн байгууламж, улсын нийслэлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

Нэмэлт мэдээлэл:

Казахстан Улс 14 мужид хуваагдах бөгөөд мужууд нь дүүрэгт хуваагддаг. 14 мужид Астана, Алма-Атагаас гадна 8 хот муж багтдаг байна.

16. Румын Улс. Үндсэн хууль

1991 оны Үндсэн хуулиар тус улсын нутаг дэвсгэр нь засаг захиргааны хувьд коммун, хот, уезд /хошуу/-эд хуваагдана гэж заажээ.

Нэмэлт мэдээлэл:

Румын Улс засаг захиргааны 41 тойрог, нийслэл Бухарестад хуваагдана. Тойргууд нь хот, коммунд хуваагддаг. Одоогийн байдлаар 319 хот 2686 коммун байгаа бөгөөд 113 хот дүүргийн эрх хэмжээтэй байна.

17. Болгар Улс. Үндсэн хууль, 135 дугаар зүйл.

(1) Болгар улсын нутаг дэвсгэр нь коммун, мужид хуваагдана. Тус улсын нутаг дэвсгэрийн хуваарь, нийслэл болон бусад том хотуудын эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

(2) Засаг захиргаа-нутаг дэвсгэрийн шинэ нэгж, түүний өөрийн удирдлагын байгууллагыг хуулиар байгуулж болно.

136 дугаар зүйл

(1) Коммун нь засаг захиргаа-нутаг дэвсгэрийн үндсэн нэгж бөгөөд түүнд нутгийн өөрийн удирдлага хэрэгжинэ.

(2) Коммуны хилийг хүн амын саналын дагуу шийдвэрлэнэ.

(3) Коммун нь хуулийн этгээд мөн.

Нэмэлт мэдээлэл: Болгар Улс София болон том хотуудын нэрээр нэрлэсэн 28 мужид хуваагддаг.

18. Чех Улс. Үндсэн хууль, 99 дүгээр зүйл.

Бүгд найрамдах Чех улс нь нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгж болох коммунд хуваагдана. Түүний дээд шатны нутгийн өөрийн удирдлагын нэгж нь земель, муж болно.

Нэмэлт мэдээлэл: 2000 оноос эхлэн Чех Улс 13 муж, Прага хотод хуваагдах болжээ. Мужийн хурал байгуулагдан ажиллах бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийг мужийн зөвлөл, мэр удирдах журамтай. Будойвице, Пильзень, Карловар, Либерец, Оломуц зэрэг хотуудын нэрээр нэрлэгдсэн мужууд байгаагаас гадна Брно зэрэг томоохон хотууд мужийн төв байна.

19. Литва Улс. Үндсэн хууль, 11 дүгээр зүйл.

Литва улсын нутаг дэвсгэрийн нэгж түүний хилийг хуулиар тогтооно.

Нэмэлт мэдээлэл: Литва улс нь 10 тойрогт хуваагдах бөгөөд тэдгээр нь 60 дүүрэг, 500 гаруй орон нутгийн нэгжид хуваагддаг. 60 дүүргийн нэлээд нь хотууд байдаг. Дүүрэг шууд сонгуулиар байгуулагдсан хурал ажиллах бөгөөд дүүргийн дарга, орон нутгийн нэгжийн улирдыг томилдог байна. Тэдгээрийг сонгодог болох тухай яригддаг ч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай тулгараад байгаа юм байна.

Ашигласан материал:

1. http://www.kantei.go.jp/foreign/constitution_and_government_of_japan/constitution_e.html
2. <http://www.lexadin.nl/wlg/legis/nofr/oeur/lxwelao.h>
3. <http://www.libertas-institut.com/de/mittelsteuropa/Kyrgyz%20Constitution.pdf>
4. <http://dic.academic.ru/dic.nsf/ruwiki/1337335#.D0.9C>
5. http://www.servat.unibe.ch/icl/ks00000_.html
6. http://www.cubanet.org/ref/dis/const_92_e.htm
7. <http://www.legislationline.org/documents/section/constitutions/country/12>
8. <http://www.rada.gov.ua/const/conengl.htm>
9. <http://net.jogtar.hu/jr/gen/getdoc.cgi?docid=94900020.tv&dbnum=62>
10. <http://www.parliament.bg/en/const>
11. <http://dic.academic.ru/dic.nsf/ruwiki/1337335#.D0.9C>
12. <http://www.psp.cz/cgi-bin/eng/docs/laws/1993/1.html>
13. <http://www.lexadin.nl/wlg/legis/nofr/eur/lxwepor.htm>

* * *

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (Лавлагаа мэдээлэл)

Д. Мягмарцэрэн

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ОХУ-ын Үндсэн хуулиар хэн эзэмшиж байгаагаас үл хамааран өмчийн бүх хэлбэр эрх тэгш байхаар заасан байдаг. Харин төрийн өмчийн тухай ойлголт нь эдийн засгийн харилцаанд онцлог шинж чанартай байдаг. Учир нь Төр эдийн засгийн харилцаанд хоёр талтайгаар оролцдог.

- **Нэгдүгээрт**, төр өөрийн бүрэн эрхийн дагуу эдийн засгийн харилцаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн актуудыг батлан гаргах замаар эдийн засгийн харилцааг зохицуулах байдлаар оролцдог.
- **Хоёрдугаарт**, эдийн засгийн хаилцаанд өөрийн эзэмшил ашиглалд буй материаллаг болон материаллаг бус эд хөрөнгийн үндсэн дээр улс орны нийгэм эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх үүрэг бүхий оролцогч нь болдог.

Иймээс төрийн өмч нь улсын материаллаг болон материаллаг бус үнэт зүйлсийг агуулсан өмчийн харилцааны нэг хэлбэр нь байдаг. Энэ харилцааны субъект нь үндсэндээ төрийн байгууллагууд байдаг бол объект төрийн өмч хөрөнгө байдаг.

ОХУ-ын төрийн өмчлөлд дараах зүйлүүд багтана.

- Улсын төсвийн болон төсвийн бус нөөцийн баялаг,
- ОХУ-ын Төв банкны баялаг болон өмч хөрөнгө,
- ОХУ-ын алтны нөөц,
- Улсын эрдэнэсийн сан,
- Улсын урлаг соёлын түүхэн өв хөрөнгө, дурсгалт зүйлс,
- Археологи, ашигт малтмалын ховор олдвор,
- Хот байгуулалт, архитектур, хөшөө дурсгалын үнэт зүйлс,
- Улсын хамгаалалтад байгаа байгаль орчны тодорхой бүсүүд,
- Цахилгаан эрчим хүчний системийн эд хөрөнгө,
- Сансрын нислэгийн аппаратууд, хиймэл дагуулууд,
- Цөмийн материалууд
- ОХУ-ын зэвсэгт хүчний эд хөрөнгө,
- ОХУ-ын яамд, төрийн байгууллагуудын эд хөрөнгө,
- Төрийн өмчит үйлдвэрийн газруудын эд хөрөнгө,
- Улсын мэдлийн гүүр, замууд
- Ашигт малтмал
- Усны нөөц
- Далай тэнгисийн олзворууд
- Ой,
- улсын нөөцийн хөдөлгөөнт агуулах, хангамжийн газрууд,
- Тэсрэх бодис, байлдааны болон бусад төрлийн зэвсэг үйлдвэрлэл, цөмийн болон цацраг идэвхит бодисийн үйлдвэр,
- Төрийн байгууллага болон төрийн удирлагын үүрэг бүхий байгууллагуудын

- харилцаа холбоо, инженерийн дэд бүтэц,
- Үндэсний аюулгүй байдал болон улсын нийгэм эдийн засагт нөлөөлөхүйц стратегийн ач холбогдол бүхий үйлдвэр аж ахуйн газрууд, байгууллагууд багтана.

ОХУ-ын төрийн өмчийн зүйл нь:

- газар
- мөнгөн хөрөнгө: хувьцаа болон бусад үнэт цаас,
- хувьцаат компани дахь төрийн эзэмшлийн хувь хэмжээ,
- Төрийн байгууллагуудын байр,
- Гадаад өр,
- Оюуны өмчийн зүйл, материаллаг бус эд хөрөнгө

Хилийн чанад дахь төрийн өмч хөрөнгө нь ОХУ-ын хуулийн дагуу захиран зарцуулагдагана. Орон нутаг дахь төрийн өмчийг тухайн нутгийн өөрөө удирдах байгууллага захиран зарцуулах эрхтэй.

Төрийн өмчийн хэлбэр, тэдгээрийг захиран зарцуулахтай холбоотой харилцааг ОХУ-ын Үндсэн хууль болон Иргэний хууль, бусад эрх зүйн актаар зохицуулна. Ерөнхийлөгчийн зарлиг, ОХУ-ын парламентын шийдвэр (Төрийн Дум), Засгийн газар болон тухайн өмч хөрөнгийг хариуцах яамны шийдвэрийг үндэслэн төрийн өмчийг захиран зарцуулна. Гэхдээ эдгээр шийдвэрүүдийн дагуу хууль бусаар төрийн өмчийг бусдад шилжүүлэн өгөхийг хориглодог. Хариуцсан яам нь төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусдад шилжүүлэх буюу төрийн өмчлөлөөс гаргах тохиолдолд Засгийн газар болон парламентын шийдвэрийг үндэслэнэ.

Төрийн өмчийг бусдад шилжүүлэхэд хариу төлбөртэй болон хариу төлбөргүй байж болно. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэхэд нийтийн орон сууцны барилга болон холбогдох инженерийн дэд бүтцийг үнэ төлбөргүй шилжүүлнэ. Төрийн өмчийг бусдад шилжүүлэх үйл явц болон гарсан шийдвэр нь ижил тохиолдолд нийтлэг байдлаар үйлчлэх зарчим баримтлана. Бусдад шилжүүлэхийг хориглосон бүртгэлд байгаа төрийн өмчийн шилжүүлэлтийн талаарх шийдвэрийг парламентын шийдвэрийн үндсэн дээр гүйцэтгэх засаглалын тэргүүн гаргана. Тухайн орон нутаг дахь нутгийн өөрөө удирдах байгууллагын мэдэл дэх төрийн өмчийг бусад орон нутаг дахь төрийн байгууллагад шилжүүлэх тохиолдолд нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрээр шилжүүлнэ.

Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмшиж ашиглан захиран зарцуулахдаа төрийн ашиг сонирхол болон тогтоосон хууль журмыг зөрчихийг хориглох бөгөөд мөн энэ нь нийтийн ашиг сонирхолд нийцсэн байхыг шаардана. Энэ зарчим улсын бүх нутаг дэвсгэрт ижил мөрдөгдөнө. Төрийн өмчийн удирдлага зохион байгуулалт нь төрийн чиг үүргийг хангахад чиглэгдэнэ.

ОХУ-ын нэрийн өмнөөс төрийн өмчийг захиран зарцуулах эрх мэдэл нь Засгийн газарт хадгалагдах ба үүн дотроо Өмчийн харилцааны яам гол үүрэг гүйцэтгэнэ. Энэхүү Яам нь Холбооны Комисстой хамтран үнэт цаас хөрөнгийн зах зээл дээр улсын хувьцааны багц болон бусад үнэт цаастай холбогдох асуудлыг шийдвэрлэнэ. Улсын хөрөнгийн сантай хамтран төрийн өмчийн хувьцааны багцын худалдаа арилжааг эрхэлнэ. Эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан Холбооны албатай хамтран төрийн өмчийн үйлдвэр аж ахуйн газар байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

Иймээс энэхүү Яам нь төрийн өмчийг зохистой ашиглах, эдийн засагт шинэчлэл хийх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд гол үүрэгтэй юм.



Үүний тулд дараахь зүйлүүдийг хийж гүйцэтгэнэ:

- гүйцэтгэх засаглалын бусад байгууллагууд болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран төрийн мэдлийн өмч хөрөнгийг захиран зарцуулах;
- санхүүгийн бүртгэл тооцооны тогтолцоогоор төрийн мэдлийн өмч хөрөнгийн эзэмшилд ашиглалтад хяналт тавих;
- төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах бусад байдлаар захиран зарцуулахад хууль эрх зүйн арга замаар ОХУ-ын ашиг сонирхлыг илэрхийлж хамгаалах;
- төрийн өмчийг хувьчлах болон буцааж төрийн өмчид авах хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах буюу хянах, гарсан үр дүнг Засгийн газрын өмнө хариуцах;
- хууль болон бусад эрх зүйн актад нийцүүлэн төрийн өмчийг захиран зарцуулах төсөл боловсруулах;
- улсын төсөв болон үүнтэй холбогдох төрийн өмчийн эд хөрөнгийн захиран зарцуулалтыг хянах, урьдчилсан төлөвийг тодорхойлох;

Орон нутгийн өмчийг захиран зарцуулахдаа нутгийн өөрөө удирдах байгууллагаас бүрэн эрх олгогдсон төлөөллийн байгуулах байгуулах замаар шийдвэрлэнэ. Энэхүү төлөөллийн байгууллагын эрх үүргийг дараахь эрх зүйн үндсэн дээр тодорхойлно. Үүнд:

- ОХУ-ын хуульд зааснаар;
- Засгийн газрын тэргүүний шийдвэрээр;
- Төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага хоорондын гэрээгээр;

Төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага хоорондын гэрээнд дараах зүйлүүдийг багтаана:

- Бүрэн эрх олгосон зорилго, хамрах хүрээ;
- Эрхээ хэрэгжүүлэх арга зам;
- Гэрээний хугацаа;
- Талуудын эрх үүрэг;
- Санхүүгийн эх үүсвэр;
- Гэрээний зөрчилд ноогдуулах хариуцлага;
- Талууд гэрээнээс татгалзах нөхцөлд үүсэх үр дагавар зэргийг тодорхой тусгасан байна.

Ихэвчлэн дараахь шалтгааны улмаас талууд гэрээнээс татгалзах нөхцөл бүрддэг. Үүнд:

- төрийн байгууллагын санаачлагаар гэрээнээс татгалзахад, төрийн өмчийг захиран зарцуулахтай холбоотой үүргийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх байгууллага бий болсон бол;
- нутгийн захиргааны байгууллагын санаачлагаар гэрээнээс татгалзахад, өөрийн бүрэн эрхийн хүрээнд өгөгдсөн үүргийг биелүүлэх боломжгүй бол гэрээнээс татгалзах саналаа өгдөг байна.

Төрийн өмч хөрөнгийн захиран зарцуулалтад дараахь байгууллагууд ерөнхий хяналт тавьдаг. Төрийн Дум, Засгийн газар, Салбарын яам, Аудитын газар, Ерөнхийлөгчийн дэргэдэх Ерөнхий хяналтын газар. Харин нарийвчилсан байдлаар санхүүгийн хяналтыг Улсын хяналт шалгалтын алба болон тусгайлсан эрх үүрэг бүхий төрийн байгууллагууд хэрэгжүүлдэг.

Төрийн Думын эрх үүргийн хүрээнд:

- а) төрийн өмчийг захиран зарцуулсан талаар Засгийн газраас ирүүлсэн тооцоо, мэдээ, баримттай танилцах;
- б) төрийн өмчийг захиран зарцуулах талаар Думын гишүүдээс гаргасан саналыг хүргүүлэх;
- в) улсын төсвийн орлогын эх үүсвэрүүдийг хянах, тэр дундаа төсөвт орлого оруулдаг төрийн өмчийг хувьчлах, худалдах асуудалд онцгой анхаарал тавьдаг.
- ОХУ-ын Засгийн газрын хувьд:
 - а) төрийн өмчийн эд хөрөнгийг захиран зарцуулахтай нь холбогдуулан эрх бүхий Яамны тайлан тооцоо, үйл ажиллагааг хянах;
 - б) төрийн өмчийн эд хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий Яамны тайлан тооцоог батлах
 - в) төрийн өмчийн эд хөрөнгийг захиран зарцуулах талаар хууль зөрчсөн үйлдэлд эрх хэмжээнийхээ хүрээнд арга хэмжээ авах.
- Салбарын Яамны хувьд:
 - а) төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын талаар хийсэн хяналт шалгалтын мэдээг гаргах;
 - б) төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын талаарх мэдээ, баримтуудыг бэлтгэх, зохих этгээдийн асуулгад хариу өгөх;
 - в) төрийн нэрийн өмнөөс төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын талаар хяналт шалгалт хийж, гарсан үр дүнг холбогдох хууль журмын дагуу зүй зохистой байгаа эсэхийг хянана.

Төрийн өмчийн эд хөрөнгийг захиран зарцуулахад дараахь зарчмыг баримтлана.

- Хуулийн дагуу,
- Эзэмшиж ашиглаж буй этгээд нь олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнээс гажихгүй байх;
- Хяналттай, тооцоотой байх,
- Ил тод байх,
- Эзэмшиж ашиглаж буй этгээд нь бие даан эрх үүргээ хэрэгжүүлэх боломжтой байх,
- Үр ашигтай байх;
- Үр ашигтай байх нөхцлүүдээс сонгон шалгаруулах;
- Эзэмшиж ашигласан төлбөрөө улсын төсөвт эргүүлэн төлдөг байх.

Төрийн өмчийг захиран зарцуулах арга замууд нь зорилгоо хэрхэн биелүүлж байгаагаар тодорхойлогдох ба хоёр төрлийн хэлбэрээр илэрнэ.

Эрх зүйн арга зам – энэ нь өмчийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн баримт бичиг болон төрийн байгууллагын шийдвэр, тогтоосон журам, тухайн өмчийн харилцаан дахь бусад ердийн процедураар илэрнэ. Эдгээр нь ОХУ-ын хуулинд хамаарна.

Эдийн засгийн арга зам - Төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглаж буй үйлдвэр аж ахуйн газруудын үйл ажиллагаа болон тухайн өмчийн харилцаанд оролцогч бусад этгээдийн эдийн засгийн ашиг сонирхлоор илэрнэ.

Эдийн засгийн удирдлага дахь төрийн өмчийн харилцаа нь ОХУ-ын Иргэний хууль болон бусад эрх зүйн актуудаар зохицуулагддаг. Мөн үүнд хамаарах үйлдвэр аж ахуйн газрыг Засгийн газар болон Ерөнхийлөгчийн шийдвэрийг үндэслэн төрийн өмчийн асуудал



Судалгааны эмхтгэл, Х боть

хариуцсан салбарын яам үүсгэн бий болгодог.

Төрийн өмчийн эд хөрөнгийг бусад алив нэг арилжааны болон арилжааны бус үйл ажиллагааг эрхлэдэг этгээдтэй хамтрах, хорших хэлбэрээр ашиглах нь бүрэн нээлттэй. Үүнд барилга байшин, мөнгөн хөрөнгө, үнэт цаас гэх мэт мөнгөн дүнгээр илэрхийлэгдэж болох эдийн болон эдийн бус бүх төрлийн өмч хөрөнгийг нэрлэж болно. Ийнхүү төрийн өмчийг бусадтай хамтран ашиглах хэлбэрээр төсвийн ашиг орлогыг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Засгийн газар үүнийг ээлжит Төсвийн хуулийн төслийн хамт Төрийн Думын хуралдаанд оруулж ирэн шийдвэрлүүлнэ.

Энэ төрлийн хөрөнгө оруулалтын гэрээг ашгийн төлөөх арилжааны байгууллагатай хийх тохиолдолд Сангийн яамны сайд төрийг төлөөлөн гарын үсэг зурна. Харин арилжааны бус байгууллагатай хийсэн гэрээнд гэрээний зорилгын дагуух Салбарын яамны сайд гарын үсэг зурдаг.

Барилга барих, техник технологийн шинэчлэл хийх зэрэг их бүтээн байгуулалтын шинжтэй томоохон төслүүдэд төрөөс төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах тохиолдолд уг төсөлд оролцох төрийн эрх мэдлийн хувь хэмжээ хөрөнгө оруулалтынхаа хувь хэмжээг даган пропорциональ байдлаар нэмэгддэг.

Хэрэв төр төсвийн хөрөнгө оруулалттай төслөөс татгалзах тохиолдолд Засгийн газар дангаар шийдвэрээ гаргах бөгөөд боломжтой гэж үзвэл хамтран ажиллаж байсан нөгөө этгээддээ өөрийн эзэмшлийн өмч хөрөнгөө хувьчлах арга замаар шилжүүлж болдог.

Төрийн өмчийг захиран зарцуулах эрх зүйн арга замуудад түрээс, лизинг, хариу төлбөргүй ашиглах гэх мэт Иргэний хууль болон бусад салбар чиглэлийн хууль зүйн актуудаар зохицуулагддаг олон төрлийн санхүүгийн арга хэлбэрүүд багтдаг. Үүнээс төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх талаар дэлгэрэнгүй авч үзье.

Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх тухай асуудлыг Сангийн яам шийдэх бөгөөд түрээслэх хүсэлт гаргагч нь тус улсын иргэн, ААН, байгууллага болон хууль ёсоор бүртгэгдсэн гадаад улсын хөрөнгө оруулалттай ААН, байгууллага, гадаад улсын иргэн, ААН, байгууллага хэн ч байж болно. Түрээслүүлэхдээ сонгон шалгаруулалт явуулах буюу сонгон шалгаруулалтгүйгээр шилжүүлэн өгч болно. Хэрэв төрийн өмчийн эд хөрөнгийг сонгон шалгаруулалтгүйгээр түрээслүүлэх тохиолдолд Засгийн газар болон Ерөнхийлөгчийн зөвшөөрлийг үндэслэн Сангийн яам шийдвэрлэнэ. Хүсэлт гаргагчдаас сонгон шалгаруулалт хийж төрийн өмчийг түрээслэх бол Сангийн яам сонгон шалгаруулалтын Хороо, шалгуур үзүүлэлт зэргийг бий болгож зохион байгуулна.

Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэж ашиглагч нь Сангийн яамнаас гаргасан аргачлал, заавар, хувь хэмжээний дагуу түрээсийн төлбөр төлнө. Түрээсийн төлбөрийн суурь хэмжээг жил бүр хянан үзэх бөгөөд хэрэв төлбөрийн хувь хэмжээг бууруулах, нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзвэл хууль тогтоох байгууллагад хандана.

Түрээсийн төлбөрийг тогтоосон хугацаанд улсын төсөвт оруулах ба зарим тохиолдолд түрээсийн гэрээ дууссаны дараа төлбөрөө хийж болохоор онцлог зохицуулалт буюу онцгой нөхцөл байж болдог.

Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх тухай гэрээг Сангийн яамны оролцоогүй хийхийг хориглодог ба ийм тохиолдолд ОХУ-ын Иргэний хуулийн зааснаар уг гэрээ хүчингүйд тооцогдоно.

Түрээсийн гэрээнд дараах зүйлүүд тусгагдана.

- Түрээслэх эд хөрөнгийн бүрэлдэхүүн
- Түрээсийн төлбөр төлөх нөхцөл болон хугацаа. Хугацааны хувьд тодорхой үе шатаар болон гэрээний үүрэг дуусахад гэх мэт
- Түрээсийн төлбөрийн хэмжээ
- Нөхөн төлбөр болон харилцан тохиролцооны нөхцөл
- Түрээслэгч болон түрээслүүлэгчийн эрх үүрэг
- Түрээсийн эд хөрөнгийн олон нийтийн өмчлөлд хамаарах хэсгийн ашиглалт, төлбөр болон бусад нөхцөлүүд
- Түрээсийн гэрээний зөрчилд хүлээлгэх хариуцлага, түрээсийн төлбөр төлөх боломжгүй болох гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл
- Гэрээ цуцлах нөхцөл

Хувийн сонирхол, хандлагаар түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхийг хатуу хориглодог. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэгч нь тухайн өмч хөрөнгөнд заавал даатгалын гэрээ хийх ёстой бөгөөд уг хөрөнгийн үнэлгээнд нийцүүлэн тооцсон хэмжээгээр батлан даалтын төлбөр урьдчилан төлнө. Энэхүү баталгаа мөнгөн хөрөнгийг Сангийн яам тусгай дансанд байршуулж хадгалах ба түрээсийн гэрээ дууссаны дараа түрээслэгчид буцаан олгоно. Хэрэв түрээслэгч гэрээгээр эзэмшиж ашиглаж буй хөрөнгийг өөр бусад этгээдэд давхар буюу дамжуулан түрээслэх бол заавал Сангийн яамнаас зөвшөөрөл авна.

Төрийн өмчит үйлдвэр, ААН дээрх журмаар түрээсийн гэрээ байгуулж өмчийн эрхээ бусдад шилжүүлж болно. Энэхүү өмчийн эрхийн хүрээнд тус хуулийн этгээдийн эзэмшиж байсан хөдлөх болон үл хөдлөх бүх өмчийн эрх багтаж болно. Тухайлбал, газрын эрх, ашигт малтмал олборлох, усны нөөц ашиглах гэх мэт. Хэрэв ийнхүү төрийн өмчийн эд хөрөнгийг цогцоор нь түрээслэх бол гэрээний хугацаа 10 жилээс хэтрэхгүй байна. Гэрээний хугацаа дууссаны дараа Сангийн яам гэрээний зүйлийг худалдах зэргээр гэрээний гүйцэтгэлийг дуусгаж болох бөгөөд хэрэв цаашид гэрээг үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзвэл хугацааг сунгаж болно. Харин түрээслэгч гэрээг цаашид үргэлжлүүлэхээс татгалзах тохиолдолд Сангийн яам түрээсийн гэрээ байгуулах тухай нийтэд хандсан зар гаргана. Энэ тохиолдолд түрээсийн гэрээ байгуулах тухай хүсэлт гаргагч нь уг хүсэлтээ заавал бичгээр хийж Сангийн яаманд ирүүлэх ба Сангийн яам уг этгээдтэй дахин гэрээ байгуулна.

Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэгч нь түрээсийн гэрээ дууссаны дараа төрийн өмчийн эд хөрөнгийг хүлээлгэн өгөх акт үйлдэж Сангийн яаманд хүргүүлнэ. Үүний дагуу талууд бүртгэл, шалгалтын ажиллагаа явуулж өмч хөрөнгийг хүлээлцэнэ. Төрийн өмчийн эд хөрөнгийг хүлээлцэх акт нь түрээсийн гэрээний салшгүй хэсэг байна.

Төрийн өмчийн эд хөрөнгийн менежментийн эдийн засгийн арга зам гэсэн ойлголтод консалтинг, маркетинг, төлөвлөлт, хяналт шинжилгээ-мониторинг, аудит, бүртгэл тооцоо, даатгал гэсэн маш олон зүйлс багтана. Консалтинг нь Засгийн газар буюу түүнээс эрх олгогдсон байгууллага эдийн засгийн харилцаан дахь төрийн өмчийг үр ашигтайгаар захиран зарцуулахад чиглэгддэг. Консалтингийн бүтээгдэхүүн нь дараахь зүйлсийг хэрхэн шийдвэрлэх талаар гол анхаарлаа хандуулдаг.

- Төрийн өмчийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах хөтөлбөр
- Төрийн өмчийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад шаардагдах эрх зүйн орчин
- Төрийн өмчийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж буй эсэх талаарх мониторингийн систем
- Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах, буцаан төрийн өмчид авах талаарх бизнес төлөвлөгөө



Судалгааны эмхтгэл, Х боть

Консалтингийг тусгай мэргэшсэн өндөр ур чадвар бүхий баг гүйцэтгэх ба энэхүү мэргэшсэн зөвлөгчдийг сонгон шалгаруулалтын журмаар Засгийн газраас сонгоно. Сонгон шалгаруулалтын хороог Сангийн яам болон Төрийн өмчийн сангийн төлөөллүүдээс бүрдүүлнэ. Хорооны дарга нь Сангийн сайд байна. Шалгарсан консалтингийн багтай хамтран ажиллахад нэг жилийн гэрээ хийх ба шаардлагатай тохиолдолд зөвхөн хоёр удаа хугацааг нь сунгадаг.

* * *

ОХУ -ын төрийн өмчийн эд хөрөнгийг захиран зарцуулах талаарх хууль тогтоомжууд:

1. Гражданский кодекс Российской Федерации.
2. Федеральный закон «Об акционерных обществах»
3. Федеральный закон «О приватизации государственного имущества и об основах приватизации муниципального имущества в Российской Федерации»





2

БҮЛЭГ

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН БОЛОН СОНГУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ХОРООНЫ ТАЛААРХИ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Р. Хатанбаатар, Г. Алтан - Оч (Ph.D), П. Амаржаргал,
Ч. Базар (Ph.D), А. Пагма*

СЭДВИЙН АГУУЛГА

1. Гадаадын зарим орны парламентын Өргөдөл, гомдлын хорооны дүрэм, чиг үүрэг

- 1.1. Европын Парламент
- 1.2. ХБНГУ
- 1.3. Австрали
- 1.4. БНЭУ

1. Гадаадын зарим орны парламентын сонгуулийн асуудал хариуцсан хорооны чиг үүрэг

- 2.1. ХБНГУ
- 2.2. Шинэ Зеланд
- 2.3. Филиппин
- 2.4. АНУ

Гурав. Судалгааны дүгнэлт

Ашигласан материал

* * *

УДИРТГАЛ

УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга Ж.Сүхбаатарын захиалгаар “Гадаадын зарим орны парламентын Өргөдөл, гомдлын болон сонгуулийн асуудал хариуцсан хороодын талаархи харьцуулсан судалгаа”сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Эрхэм гишүүний захиалгад гадаад орнуудын парламентын сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны ажиллах чиг үүрэг, дүрмийн талаархи судалгааг хийж өгөхийг хүссэн бөгөөд үүний дагуу ийм дэд хороо байдаг эсэх талаар холбогдох эх сурвалжуудаас үзэхэд гадаадын парламентын байнгын хороодын бүтцэд зөвхөн сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтыг хариуцсан дэд хороотой улс байхгүй байгаа ба харин зарим улсын парламентад сонгуулийн эрх, сонгуулийн шинэчлэл, сонгуулийн шалгалтын асуудлыг хариуцсан хороод ажилладаг байна. Иймд эдгээр улсын парламентын сонгуулийн асуудал хариуцсан хороод нь ямар чиг үүрэг гүйцэтгэдэг талаар судалгаанд тусгасан болно.

Судалгааны зорилго:

Гадаадын зарим орны, тухайлбал, ХБНГУ, Австрали, БНЭУ, Филиппин, Шинэ Зеланд, Европын Парламентын Өргөдөл, гомдлын болон сонгуулийн асуудал хариуцсан хороодын чиг үүргийг харьцуулан судалж, дүгнэлт гаргахад оршино.



Судалгааны эмхтгэл, X боть

Судалгааны зорилтууд:

- Гадаадын зарим орны парламентын Өргөдөл, гомдлын байнгын хорооны дүрэм, чиг үүргийн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Гадаадын зарим орны парламентын сонгуулийн асуудал хариуцсан хороодын чиг үүргийн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Дээрх орнуудын парламентын өргөдөл, гомдлын болон сонгуулийн асуудал хариуцсан хороодын чиг үүргийн талаар харьцуулан дүгнэлт гаргах зэрэг болно.

Судалгааны аргачлал:

- Гадаадын зарим орнуудын Үндсэн хууль, парламентын Дэгийн холбогдох бүлэг заалт,
- Гадаадын зарим орны сонгуулийн асуудал хариуцсан байгууллага, бүтцийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулах
- Судалгааны материалыг харьцуулан нэгтгэн дүгнэх

Хамрах хүрээ:

1. ХБНГУ, Австрали, БНЭУ, Европын Парламентын Өргөдөл, гомдлын байнгын хороодын дүрэм, чиг үүрэг
2. ХБНГУ, Филиппин, Шинэ Зеландын сонгуулийн асуудал хариуцсан хороодын чиг үүрэг.

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын Газрын Судалгааны төвийн ахлах референт Р. Хатанбаатар ахалж, ХБНГУ-ын парламентын талаар ахлах референт Г. Алтан-Оч, Европын Парламент, АНУ-ын Конгрессын талаар шинжээч Ч. Базар, Австрали, Филиппины парламентын талаар шинжээч А. Пагма, БНЭУ, Шинэ Зеландын парламентын талаархи судалгааг судлаач П. Амаржаргал нар тус тус хийж гүйцэтгэв.

* * *

1. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДҮРЭМ, ЧИГ ҮҮРЭГ

1.1. Европын Парламентын Өргөдөл, гомдлын хороо

1.1.1. Өргөдөл гомдлын хорооны ажиллах зарчим

Тухайн өргөдөл гаргагч нь Европын Холбооны үйл ажиллагааны хүрээнд холбогдох асуудлаар Өргөдөл гомдлын хороонд саналаа илэрхийлэх бөгөөд уг асуудлыг тусгай журам, процедурын хүрээнд шийддэг. Хороо нь шийдвэр гарсны дараа өргөдөл гаргагчид аль болох түргэн шуурхай мэдээлэх үүрэг хүлээдэг.

Өргөдөл гомдлын хороо нь үйл ажиллагаандаа доорхи зарчмийг баримтлана. Үүнд:

- Тухайн асуудлаар эрж мөрдөх урьдчилсан яриа хэлэлцээр хийсэн эсэх болон нийтээр дагаж мөрдөх хуультай холбоотой мэдээлэл мөн эсэхийг Европын комиссоос асуух
- Европын Парламентын бусад хороонд өргөдөл, хүсэлтийн талаар мэдээлэх

болон цаашдын зарчим, үйл ажиллагаа /тухайлбал, цаашдын хууль тогтоох үйл ажиллагаандаа/ харгалзаж үзэх эсэхийг лавлах

- Зарим үл давтагдах кейсийг бэлтгэх болон Парламентын хуралдаанд танилцуулах, Парламентын үйл ажиллагааны тайланд оруулах, асуудалд хамаатай бүс нутаг, улс оронд очиж бодит байдалтай танилцах, асуудлын талаархи анхааруулга, зөвлөмжийг хорооны тайланд тусгах
- Тал талаас нь бодож цэгнэсэн, өргөдөл гаргагчийн сэтгэлд нийцэхүйц, таарамж тохиромж бүхий шийдвэр гаргахыг хичээх зэрэг болно.

Өргөдөл гомдлын хорооны уулзалт нь сар бүр болдог бөгөөд түүнээс гадна Парламентын завсарлагын үеэр 8-р сард өдөр бүр хуралддаг. Парламентын Нарийн бичгийн даргын газар /Тамгын газар/ өргөдөл гомдлын /хүсэлтийн/ үйл явцыг ямар менежментээр явуулахыг Хороонд зөвлөхийн зэрэгцээ, Хорооны уулзалтанд бэлтгэх үйл ажиллагааг байнга, тасралтгүй явуулдаг.

Өргөдөл гомдлын хороо нь өргөдөл гаргагчийн асуудлыг бодитой шийдэхийн тулд Үндэсний болон орон нутгийн эрх баригчдад /Холбооны гишүүн улсын/ хандаж, тэдэнтэй санал солилцох зэргээр холбоотой ажилладаг. Өргөдөл гомдлын хороо нь Үндэсний болон Орон нутгийн эрх баригчид /Холбооны гишүүн улсын/-ын хүрээнд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох эрхгүй. Европын Парламент нь шүүх эрх мэдэл эдлэхгүй бөгөөд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, шүүн таслах үйл ажиллагаа явуулахгүй.

1.1.2. Европын Парламентын Өргөдөл гомдлын хороонд өргөдөл гаргах процедур

Хэн, ямар асуудлаар өргөдөл гаргаж болох вэ?

- Европын холбооны иргэн
- Европын Холбооны гишүүн улсуудад байнгын оршин суугч
- Европын Холбооны гишүүн улс дахь холбоод, компани, байгууллага /хууль ёсны этгээд буюу хувь хүн/-ын удирдах байгууллагууд

Ямар асуудлаар хандаж болох вэ?

Өргөдөл гомдлын /хүсэлтийн/ агуулга нь Европын Холбооны ашиг сонирхол болон үүрэг хариуцлагатай холбогдож байх ёстой.

- Европын иргэдийн эрхтэй холбоотой асуудал
- Хүрээлэн буй байгаль орчны асуудал
- Хэрэглэгчийг хамгаалах
- Иргэдийн чөлөөтэй шилжин суурьших, бараа, үйлчилгээ авах, дотоод худалдаа
- Ажил эрхлэлт болон нийгмийн асуудал
- Мэргэжил, мэргэшлийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх
- Европын Холбооны хуулийн хэрэгжилттэй холбоотой бусад асуудал

Өргөдөл хүсэлтийг ямар хэл дээр бичих вэ?

Өргөдөл хүсэлт нь Европын Холбооны албан ёсны хэлээр бичигдсэн байх ёстой.

Өргөдөл гомдлыг ямар хэлбэрээр хүлээн авах вэ?

- Шуудангаар
- Онлайнгаар

Өргөдөл нь учрыг олоход хялбар, ойлгомжтой, тавьсан асуудал нь баримт факттай, илүү



Судалгааны эмхтгэл, X боть

дутуу зүйлгүй, гаргацтай тодорхой бичигдсэн, хамаарагдах товч дүгнэлтийг хийсэн байх ёстой.

Шуудангаар явуулахдаа :

- Өөрийн бүтэн нэр, улс орон, байнгын оршин суугаа хаяг,
- Гарын үсгээ зурсан байх шаардлагатай.

Өргөдлийн үл хүлээн зөвшөөрөгдөх байдал:

Европын Холбоонд хамаарагдах үйл ажиллагааны хүрээнд өргөдөл бичигдээгүй бол Холбоо нь “үл зөвшөөрөх” гэсэн үндэслэл гаргана. Түүнчлэн Өргөдөл гомдлын хороо нь өргөдөл гаргагчид хандан Хүний эрхийн Европын шүүх болон бусад холбогдох байгууллага /Үндэсний эрх баригчид, Үндэсний Омбудсмен болон гишүүн орнуудын парламентын өргөдөл гомдлын хороо/-нд хандан өргөдөл гаргах талаар тухайн хүнд зөвлөнө.

1.1.3. Өргөдөл гомдлыг хэвлэх

Өргөдөл гаргагч зөвшөөрсөн тохиолдолд албан ёсны сэтгүүл дээр өргөдөл гаргагчийн нэр болон өргөдлийн дугаарын хамт нийтэлнэ. Мөн боломжтой бол Интернэт дээр байрлуулна. Хувийн мэдээллийг хамгаалах зорилгоор өргөдөл гаргагч нь өөрийн нэрийг тавихыг хүсээгүй тохиолдолд түүний хүсэлтийг хүндэтгэн үзнэ. Гэхдээ Европын Парламент нь өргөдөл гаргагч этгээдийн нууцлалыг хадгалах шаардлагыг хүндэтгэхийн зэрэгцээ өргөдөл гаргагчийн хүсэлт нь маш тодорхой, хоёрдмол утгагүйгээр бичигдсэн байхыг чухалчлана. Мөн Европын Парламентын вэб хуудсан дээр Өргөдөл гомдлын хорооны улзалтын талаархи мэдээлэл ил тод мэдээлэгддэг.

Өргөдлийг илгээх загварчлал:

Европын Парламентын вэб сайт руу орж тодорхой асуултад хариулсны дараа өргөдлөө илгээдэг юм байна. Түүнд өргөдөл гаргагчийн овог, нэр, улс, хотын нэр, шуудангийн код, И мэйл хаяг, ямар нэгэн холбоо, групп, компанийг төлөөлж байгаа бол түүний нэр, өргөдлийг хэвлэх үү үгүй гэдгийг тодорхой бичээд илгээдэг аж. Түүнчлэн өргөдлийн утгийг илэрхийлсэн товч гарчиг болон өргөдлийн агуулгыг тусгай хүснэгтэд бичиж илгээнэ. Өргөдөл явсан даруйд түүнийг хүлээж авсан тухай мэдээлэл ирэх бөгөөд түүнд өргөдлийн дугаар болон өргөдөл гаргагчийн нэрийн хамт бүртгэсэнээ мэдэгддэг.

1.1.4. Өргөдөл гаргах эрх

Maastricht-ийн Олон улсын гэрээ хэлцлийн дагуу Европын Холбооны иргэд нь Европын парламентад Европын холбооны үйл ажиллагааны талаар өргөдөл гомдол, санал хүсэлтээ гаргах эрхтэй байдаг. Тэрхүү өргөдөл гомдол, санал хүсэлт нь Европын парламентын Өргөдөл гомдлын хороогоор шалгагддаг бөгөөд хороо нь дүрэм журмынхаа хүрээнд шийдвэр гаргадаг. Хороо нь Европын комисстой хамтран ажилладаг.

Хууль зүйн үндэслэл

Хороо нь Европын холбооны үйл ажиллагааг зохицуулсан Олон улсын гэрээ хэлцлийн 227-р зүйл (Article 227 TFEU) дээр үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг. Доорхи мэдээллүүд нь 227-р зүйл дээр үндэслэгдсэн болно.

Зорилго:

Өргөдөл гаргах эрх нь Европын иргэд ба Европын холбооны улсуудын байнгын оршин суугчдад хадгалагдана. Тодорхой асуудлаар Европын иргэд болон Европын холбооны улсуудад байнгын оршин суугчид нь Европын Холбооны байгууллага буюу Европын Парламентад хандаж өргөдөл, санал хүсэлт гаргах эрхтэй бөгөөд тэдгээрийн тавьсан

асуудлыг хялбар замаар хангаж өгөхөд, улмаар асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд энэхүү хорооны зорилго орших юм.

Ололтууд:

А. Зарчим:

Олон улсын гэрээ хэлцлийн 227 -р зүйл (Article 227 TFEU) дээр үндэслэнэ.

1. Парламентад өргөдөл өгөх эрх:

- Европын холбооны иргэн болон Холбооны гишүүн орнуудын бүртгэлийн албанд бүртгэлтэй унаган болон хууль ёсны иргэн, байгууллага, холбоод нь парламентын хороонд өргөдөл гаргах эрхтэй.

2. Хамрах хүрээ:

- Өргөдөл нь Европын Холбооны үйл ажиллагааны хүрээнд хамрагдсан асуудал руу чиглэгдсэн, түүнд нөлөө үзүүлэхүйц өргөн агуулгатай, ач холбогдол бүхий тайлбартай байна.

Б. Журам:

Өргөдөл гомдлын хорооны журам нь Парламентын үйл ажиллагааны журмын 201-203-д заагдсаны дагуу байх бөгөөд эдгээр нь Парламентын хорооны үүрэг, хариуцлагыг зохицуулдаг юм.

1. Албан ёсны боломж

- Өргөдөл гаргагчийн нэр, оршин суугаа улс, үндэс, байнгын хаяг болон өргөдөл нь Европын холбооны албан ёсны хэл дээр бичигдсэн байна.

2. Боломжгүй байдал

Өргөдөл гаргагч нь өргөдлийг явуулахын өмнө түүний хүсэлт, тавьж буй асуудал нь Европын Холбооны эрхлэх үйл ажиллагааны хүрээнд буй эсэхийг сайтар нягтлах хэрэгтэй. Түүнчлэн Европын Парламентад хамаарахгүй асуудал бол парламентын хороо нь өргөдөл гаргагчид хаана хандаж болох тухайлбал Үндэсний болон орон нутгийн эрх баригчдад тухайн асуудлаар өргөдөл гаргаж болохыг нь зөвлөдөг. Тухайлбал, 2010 онд Хороо нь 628 боломжтой, 318 боломжгүй өргөдлийг хүлээн авсан байна.

3. Өргөдлийг авч хэлэлцэх

Өргөдөл гомдлын Хороо нь Европын комиссоос холбогдох мэдээллийг бэлтгэх өгөхийг шаардах, түүнчлэн өргөдөл гаргагчийн асуусан зүйл дээр саналаа өгөх, ялангуяа үйлчилж буй хуульд өөрчлөлт хийхийг тэмүүлсэн, хүссэн байх тохиолдолд бусад хороодтой зөвлөлдөх зэргээр ажилладаг.

Өргөдөл гомдлын Хороо нь олон нийтийн сонсгол хийх, гишүүдэд захидал илгээх, өргөдөлд дурьдсан асуудалтай газар дээр нь очиж танилцах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. /2008 онд Франц, Кипр, Болгар, Румынь зэрэг орнуудад ажилласан талаар Европын парламентын вэбсайтад мэдээлжээ/

Хангалттай мэдээлэл цугларсны дараа Хорооны хурал хийх төслийг гаргадаг бөгөөд тэрхүү хуралд комиссыг урьдаг. Комисс нь хуралд албан ёсны мэдээлэл болон тайлбарыг амаар тавьдаг бөгөөд өргөдөл дэх асуудлуудад бичгээр хариу өгдөг. Өргөдөл гомдлын Хорооны гишүүдэд комиссын бүрэн эрхт төлөөлөгчид асуулт тавьж хариултаа авах боломж энэ уулзалтаар олддог.

4. Нэмэгдэл үйл ажиллагаа /Further action/

Энэ нь доорхи нөхцөл байдлаас хамаарна:

- Хэрэв өргөдөлд хувь хүнтэй холбоотой асуудал дурьдагдсан бол Хороо нь зохих эрх мэдэлтнүүдэд хандах, Холбооны улсын тухайн асуудлыг хариуцсан бүрэн эрхтэй албан тушаалтанд, зарим тохиолдолд Парламентын удирдлагад хандах, Үндэсний эрх мэдэл бүхий удирдагчдаас асуух;
- Хэрэв өргөдөл нь ерөнхий ач холбогдол бүхий утга агуулгатай байх юм бол, жишээ нь нийтээр дагаж мөрдөх хууль зөрчигдсөн байдлыг комисс илрүүлсэн тохиолдолд комисс нь хууль ёсны үйлдэл тогтоох, өргөдөл гаргагчдад хамаатай Шүүхийн тогтоол шийдвэрийг үр дүнтэй гаргуулах;
- Өргөдөл нь Парламентаар болон Комиссоор улс төрийн арга хэмжээ авах үр дүн гаргах нөхцлийг ч бий болгож болно
- Ямар ч тохиолдолд өргөдөл гаргагчид хариу өгөх ёстой.

Өргөдөл гомдолтой холбоо бүхий зарим нэг жишээ дурьдвал:

1. Англи дахь Үнэнч шударга амьдралын талаарх кэйс

Өргөдөл гомдлын хороонд даатгалын гэрээг эзэмшигчдийн зүгээс “Үнэнч шударга амьдралын даатгалын нийгэмлэг” даатгалын компани санхүүгийн алдагдалд орсноос даатгуулагчаа хохироож буй талаар бичсэн 2 өргөдөл иржээ. Өргөдөл гаргагчид Англи улс нь даатгалын компаниудын үүрэг хариуцлагын талаар хангалттай сайн хууль эрх зүйн орчин бүрдүүлээгүй гэж тайлбарласан байна. Өргөдлийн үр дүн нь Европын Парламент нь Өргөдөл гомдлын хороог мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулах шийдвэр гаргасанд оршино.

2. Lyons-Turin-ны төмөр замын нүхэн гарц / tunnel/

Суса тосгоны оршин суугчид орон нутгийн эрх баригчдын дэмжлэгтэйгээр Lyons-Turin-ны төмөр замын нүхэн гарцын барилга байгууламж нь байгаль орчин болон хүн амын эрүүл мэндэд муугаар нөлөөлж буй тухай бичсэн өргөдөл Европын Парламентын Өргөдөл гомдлын хороонд ирүүлжээ. Хорооны төлөөлөгчид газар дээр нь очиж танилцаад хүрээлэн буй байгаль орчинд үл нөлөөлөх, түүнээс хараат бус байх зураг төсөл гаргахыг шаардсан дүгнэлт гаргасан байна.

Энэхүү дүгнэлт нь Тусгай эрх олгогдсон төлөөлөгч Баррот болон өргөдөл гаргагчдыг газар дээр нь очиж аялуулан, Өргөдөл гомдлын хороо болон Тээвэр, Аялал жуулчлалын хороод хамтарсан уулзалт хийсний үр дүнд тал талаас нь сайтар эргэцүүлэн бодож гаргасан баримт бичиг юм. Дүгнэлтээ Италийн Засгийн газарт илгээжээ. Дүгнэлтийг нээлттэй үлдээсэн бөгөөд цаашид Өргөдөл гомдлын хороо нь Тээвэр болон Байгаль орчны хороотой хамтран Lyons-Turin-ны төмөр замын нүхэн гарцыг оршин суугч болон байгаль орчинд хор хөнөөлгүйгээр барьж байгуулахад тавих хяналтаа үргэлжлүүлсэн байна.

1.2. ХБНГУ-ын Бүндэстагийн Өргөдлийн байнгын хороо

Германы Бүндэстаг нь ХБНГУ-ын парламент юм. Чухал салбар бүрээр бүндэстагт байнгын хороод ажилладаг. Байнгын хороо нь 15 - 42 гишүүнтэй байх бөгөөд чуулган дахь фракцуудын (бүлгийн) бүтцийг хадгалсан байдаг. Гадаад хэрэг, Европын холбоо, Батлан хамгаалах болон **Өргөдөл (петицион)** гэсэн дөрвөн байнгын хороог ХБНГУ-ын Үндсэн хуулиар тогтоосон байдаг. Харин бусад бүх хороог парламентын бүрэн эрхийн хугацаа эхлэхэд тоог нь тогтоож, бүрэлдэхүүнийг нь баталдаг.[□]

Бүндэстагийн сонгуулийг 5 жил тутамд явуулдаг. Сонгогчид 18 нас хүрсэн байх гэдэг ерөнхий шаардлага тавигдахаас гадна уншиж, бичдэг чадвартай байх шаардлагатай. Бүндэстагийн Өргөдлийн байнгын хороо 26, Сонгуулийн шалгалт, гишүүний бүрэн эрх

болон дүрмийн байнгын хороо 13 гишүүнтэй. Өргөдлийн байнга хороо нь Бундэстагийн нэр дээр иргэнээс өргөдөл (петицион)-өөр гаргасан хүсэлт болон гомдлыг хариуцах хороо юм. Иргэн бүр Бундэстагт хандаж өргөдөл гаргах үндсэн эрх нь Германы Үндсэн хуулийн 17-р зүйлд тусгагдан баталгаажсан байдаг. Тус байнгын хорооны статусыг Үндсэн хуулийн 45с дэх зүйлд заасан хуулиар зохицуулна гэж тусгайлан онцгойлж тодорхойлсон байна¹¹:

45с дэх зүйл

1. Бундэстаг нь 17 дахь заалтанд тусгагдсаны дагуу иргэнээс Бундэстагт хандаж гаргасан хүсэлт, гомдлыг барагдуулах Өргөдлийн байнгын хороог байгуулж ажиллуулна.
2. Гомдлыг шалгаж барагдуулахад Байнгын хорооны эдлэх эрх үүргийг холбооны хуулиар зохицуулна.

Байнгын хорооны энэхүү эрх нь, баримт бичиг гаргуулах эрх, мэдээлэл олж авах, төрийн захиргааны байранд нэвтрэх зэрэг үйл ажиллагаатайгаа холбоотой нотлох баримтыг олж авах баталгааг хангаж өгдөг. Үүнийг зөвхөн хуулийн дагуу айл явцыг нууцлах шаардлагатай, эсвэл бусад хүчээр нууцлах нөхцөл байдалд л татгалзаж болно. Шүүх болон төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй байдаг. Өргөдлийн байнгын хороо нь өргөдөл гаргагч, гэрч болон мэргэжилтнийг урьж авчран байцааж (мэдүүлэг авах) болно.

2009 оны тайлангийн жилд 18,881 өргөдөл ирсэн нь өмнөх оноос даруй 800 гаруйгаар их байна. Байнгын хороо 17,217 өргөдлийг барагдуулсан байна. Үүнээс 10,478 өргөдлийг парламентийн хуралдаанаар оруулалгүй шийдсэн байна. Үүнээс 38%-ийг зөвлөлгөө, мэдээлэл, зааварчилгаа, материал илгээх г.м. арга замаар шийдвэрлэсэн. 14.3% нь аноним, доромжилсон, эсвэл гутаасан шинжтэй сэтгэгдлээ илэрхийлсэн байдалтай байв. 8.5%-ийг нь холбогдох холбооны муж улсад шилжүүлсэн байна.

Парламентийн хуралдаанд 6,739 өргөдлийг оруулан хэлэлцүүлжээ. Үүнээс 4,731 (27.5%) нь “үгүй”, 1,316 (7,6 %) нь асуудалд эерэг, 692 (4.1%)-ийг холбогдох байгууллага руу нь шилжүүлж шийдсэнээр хариу гаргасан байна. Уламжлал ёсоор, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэлсэн ажилтай холбоотой өргөдөл хамгийн олон буюу 3,930 өргөдөл иржээ. Харин Хуульзүйн яамтай холбоотой өргөдөл мэдэгдэхүйц өсөж 2,399 болсон байна.¹²

2009 онд дараахь өргөдлүүд хамгийн их олон нийтийн санал авчээ:¹³

1. Интернэтийн сайтуудыг эс индексжүүлэх болон хориглох (134,015 хүн үзэглэсэн)
2. Хөгжмийн урлагийн тоглолтын болон механикаар олшруулах эрхийн нийгэмлэг (106,575)
3. Компьютерийн тоглоомыг хориглохын эсрэг (73,002) г.м.

Өргөдлийн тоо 2002 оноос хойш байнга өсөх хандлагатай байна.¹⁴

¹¹ Германы Бундэстаг-Deutscher Bundestag (Wikipedia) (http://de.wikipedia.org/wiki/Deutscher_Bundestag#Aussch.C3.BCcsse)

¹² Ажлын хуудас 7-Бундэстагийн сонгууль, Хичээлийн сэдэв: Германы ардчилал/Arbeitsblatt 7- Wahlen zum Bundestag, Thema im Unterricht: Die deutsche Demokratie

¹³ 17 дахь Бундэстагийн Байнгын хороод/Bundestagsausschüsse des 17. Deutschen Bundestages (Wikipedia)

¹⁴ Бундэстагийн Өргөдлийн байнгын хороо/Petitionsausschuss des Deutschen Bundestages (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Petitionsausschuss_des_Deutschen_Bundestages

Иргэн хувийн асуудлаар ганцаарчилсан өргөдөл гаргаж болно. Харин ерөнхий асуудлаар олон нийтийн өргөдөл гаргана. 2005 оноос хойш онлайнаар өргөдөл ирүүлэх боломжтой болсон. Үүнийг **цахим-өргөдөл** гэж нэрлэдэг. Олон нийтийн өргөдөл гаргаж байгаа үед өргөдлийн текстийг эхлээд 6 долоо хоногийн турш онлайн байршуулдаг (өргөдөл гаргагч хүсвэл өөр хугацаа тавьж болно) ба энэ хугацаанд хэн ч танилцаад өөрийн нэрийг бичиж үзэглэж болдог.

Үйл ажиллагааны үндсэн зарчим бол бүх өргөдлийг тэгш үзэхэд оршино. 2008 оноос хойш Бундэстагийн шинэ вэбсайт ажиллаж эхэлсэн ба форумар дамжуулан иргэд санал хүсэлтээ гаргах, мэтгэлцээнд оролцох боломжтой болсон. Өргөдлийн хариуг иргэн эмайлээр авах буюу хэрэв олон нийтийн өргөдөл бол Интернэтэд нийтэлнэ. Хичнээн өргөдлийн дагуу өөрчлөлт оруулсан эсэхийг мэдэх боломж хараахан байхгүй.

Хүсэлт ихэвчлэн хууль, эрзүйн актуудтай холбоотой санал (хүчингүй болгох, нэмэлт оруулах эсвэл өөрчлөх) зонхилдог. Иргэдээс гаргадаг гомдол ихэнхдээ хууль юмуу захиргааны байгууллагын шийдвэрийн эсрэг чиглэсэн байдаг. Бундэстагийн дарга өргөдлийг хүлээж аваад Өргөдлийн байнгын хороонд шилжүүлдэг. Хэрэв өргөдлийн утга нь мэргэжлийн зөвлөлгөө авах шаардлагатай бол холбогдох байнгын хорооны саналыг авдаг.¹⁵

Өргөдлийн байнгын хороо нь хүлээж авсан өргөдлийг шийдвэрийн төсөлтэй нь хамтатган жагсаалтаар сар бүр Бундэстагийн чуулганд оруулж тайлагнана. Үүнээс гадна тус байнгын хороо нь жил бүр Бундэстагт бичгээр тайлангаа тавьдаг. Тайлангуудыг хэвлэж тараах ба чуулганы үед тайлагнагч амаар тодруулга хийж болно. Зөвхөн аль нэг бүлгээс юмуу чуулганд оролцогч гишүүдийн 5% шаардсан тохиолдолд амаар тайлагнаж болно. Өнөөдрийг болтол, шийдвэрийн төслийг дэмжихгүй байсан тохиолдол Бундэстагт огт гараагүй. Өргөдөл гаргагчид гаргасан шийдвэрийг мэдэгдэнэ. Ингэхдээ шалтгаануудыг заавал заасан байна.

Бундэстагийн өргөдлийн байнгын хороонд 80 гаруй хүн өндөр ачаалалтайгаар ажилладаг. Хоёр Герман нэгдсэнээс хойш өргөдлийн тоо эрс өссөн ба жилд дунджаар 20 мянга гаруй болдог. Ийнхүү өргөдлийн хороо нь ажиллах явцдаа олонхи өргөдөл гаргагчид зөвлөлгөө өгч, туслалцаа үзүүлэхээс гадна Бундэстагт гаргасан хууль болон захиргааны шийдвэр нь алдаатай, орхигдуулсан (*хуулийн цоорхой* [ГА]), шударга бус байсныг илрүүлж, эрхзүйн орчныг сайжруулахад чухал үүрэгтэй юм.

Өргөдлийн хороо ирсэн өргөдөлд хариу өгөхгүй байж болох тохиолдол бий. Жишээ нь, аноним, будлиантай (учир нь олдохгүй [ГА]), эсвэл шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй байгаа асуудлаар өгсөн өргөдөл хамаарна. Ирсэн нийт өргөдлийн нилээд их (ойролцоогоор 25%) хувь л өөрт хамаарах тул Бундэстагийн өргөдлийн байнгын хороо шийдвэрлэдэг.¹⁶

1.3. Австралийн Парламентын Төлөөлөгчдийн Танхимын Өргөдөл, хүсэлтийн байнгын хорооны чиг үүрэг /Standing Committee on Petitions/

Австралийн Парламентын доод танхим болох Төлөөлөгчдийн Танхим нь 15 байнгын хороотой бөгөөд Өргөдөл, хүсэлтийн байнгын хороо нь 2008 оны 12 дугаар сард батлагдсан Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн дагуу байгуулагдсан байна. Тус Дэгийн 16 дугаар хэсгийн 220 дугаар зүйлд Төлөөлөгчдийн Танхимын Өргөдөл, хүсэлтийн байнгын хорооны чиг үүргийг “Аливаа асуудлаар Төлөөлөгчдын Танхимд хандсан өргөдөл, хүсэлт, гомдлыг хүлээн авч барагдуулах явдал мөн” гэж тодорхойлжээ. Тус Байнгын хороо нь

¹⁵ Мөн тэнд

¹⁶ Бундэстагийн Өргөдлийн байнгын хороо/Petitionsausschuss des Deutschen Bundestages (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Petitionsausschuss_des_Deutschen_Bundestages

10 гишүүнтэй байх ба 6 Засгийн газрын гишүүн депутат, 4 Засгийн газрын гишүүн бус депутатаас бүрдэнэ гэдгийг мөн Дэгд заажээ¹⁷. Түүнчлэн Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн 15 дугаар хэсгийн 204-209 дэх зүйлд өргөдөл, гомдол гаргах журмыг тодорхойлсон байна¹⁸. Одоо үүнийг авч үзье.

Өргөдөл, хүсэлтийн хэлбэр, агуулга

1. Өргөдөл нь дараахь нөхцөлийг хангасан байна. Үүнд:
 - Төлөөлөгчдийн Танхимд хандсан байх,
 - Танхимын эрх хэмжээнд хамааралтай асуудлаар өргөдөл, хүсэлтийг гаргах,
 - Хүсэлт гаргаж буй шалтгааныг тодорхой дурьдах,
 - Танхимын зүгээс ямар үйлдэл хийх хүсэлтийг агуулах,
2. Өргөдлийн үг хэллэг, нэр томъёо нь хоёрдмол утгагүй байх ба өргөдөл нь 250 үгээс хэтрэхгүй байна. Нэр томъёоны ойлголтыг өргөдлийн нэгдүгээр хуудасны дээд талд бичих ба харин хүсэлтийг өргөдлийн нэг хуудас алгасан дээд талд нь бичнэ.
3. Өргөдөл, хүсэлтийн үг хэллэг, агуулга нь хууль бус байж болохгүй ба хууль бус үйлдлийг дэмжсэн байж болохгүй. Хэллэг нь аядуу байх,
4. Өргөдөл, хүсэлт англи хэл дээр байх ба эсхүл албан ёсны орчуулгатай байна. Орчуулагчийн нэр, хаягыг бичнэ.
5. Өргөдөлд ямар нэгэн баримт, захидал хавсаргах шаардлаггүй. Хавсаргасан тохиолдолд Танхимд танилцуулахын өмнө тэдгээрийг өргөдлөөс хасна.
6. Компаниас гаргасан өргөдөл дээр тухайн компаний тамгыг дарсан байх ёстой. Компаний тамгагүй тохиолдолд хүсэлтийг гарын үсэг зурсан хувь хүмүүсийн хүсэлт гэж ойлгоно.

Гарын үсэг зурах журам

- Өргөдлийн эхний хуудсан дээр гол хүсэлт гаргагчийн гарын үсэг, нэр, хаягийг бичнэ.
- Өргөдөлд хүн бүхэн өөрөө гарын үсгээ зурна. Зөвхөн өөрөө гарын үсгээ зурах боломжгүй хүн бусдаар өөрийн нэрийн өмнөөс гарын үсэг зуруулах боломжтой.
- Гарын үсэг нь хувилсан, хуулсан, наасан, хуудасны ар талд болон хоосон хуудсан дээр зурсан байж болохгүй.
- Парламентын гишүүн өргөдлийн гол хүсэлт гаргагч болон гарын үсэн зурагч байж болохгүй.

Өргөдөл, хүсэлт гаргах танилцуулах

- Өргөдөл, хүсэлтийг шууд Байнгын хороонд болон парламентын гишүүнээр дамжуулан гаргаж болно.
- Өргөдөл, хүсэлтийн Байнгын хороо өргөдлийг журмын дагуу шалгаж, шаардлага хангасан өргөдлийг Танхимд танилцуулахаар хүлээн авна.

Өргөдөл, хүсэлтийг танилцуулах

- Өргөдөл, хүсэлтийг хоёр замаар танилцуулж болно. Үүнд:

¹⁷ House of Representatives Standing and Sessional Orders. <http://www.aph.gov.au/>

¹⁸ Rules for form and content of petitions. House of Representatives Standing and Sessional Orders <http://www.aph.gov.au/>

Судалгааны эмхтгэл, X боть

- Чуулган дээр Өргөдөл, хүсэлтийн Байнгын хорооны дарга танилцуулах мөн Байнгын хорооны өөр нэг гишүүн энэ асуудлаар танилцуулга хийж болно. Танилцуулах хугацаа 10 минут.
- Тус Байнгын хорооны бусад гишүүд Үндсэн хорооны хуралдаан дээр болон хэлэлцүүлгийн завсарлагаанаар Дэгийн зохих заалтын дагуу танилцуулна.

Өргөдөл, хүсэлтийн талаар шийдвэр гаргах

Төлөөлөгчдийн танхимаас авах арга хэмжээ

- Өргөдөл, хүсэлтийн хэлэлцүүлгийг танилцууллагын үед Дэгийн 207 б-д заасны дагуу явуулна.
- Байнгын хорооноос тэр дор нь буцаасан өргөдөл, хүсэлтээс бусад өргөдөл, хүсэлт Танхимаар хэлэлцэгдэн шийдвэрлэгдэнэ.
- Өөр бусад Байнгын хорооны хамаарах асуудлаархи өргөдөл, хүсэлтийг зохих хороонд шилжүүлнэ.
- Өргөдөл, хүсэлтийн Байнгын хороо Төлөөлөгчдын Танхимын нэрийн өмнөөс хүсэлт гаргагчид хариуг өгч, энэ талаар Танхимд тайлагнана.

Өргөдөл, хүсэлтийг хариу авахаар сайдуудад шилжүүлж болно

- Өргөдөл, хүсэлтийг Танхимд танилцуулсаны дараа өргөдөлд хөндөгдсөн асуудлыг хариуцсан сайдад хуулбарыг илгээж болно.
- Сайд өргөдлийг хүлээн авч 90 хоногийн дотор Байнгын хороонд бичгээр хариуг ирүүлнэ.
- Байнгын хорооны дарга сайдын ирүүлсэн өргөдлийн хариуг мэдээлнэ. Үүний дараа энэ хариуг Танхимын хуралдааны тэмдэглэлд хэвлэх ба вебсайтад байршуулна.

1.4. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Парламентын Өргөдөл, гомдлын хороо “Парламентын Доод танхимын /Lok Sabha/ ёс зүйн болон үйл ажиллагааны дүрэм”

Энэхүү дүрэм нь Доод танхимаас 1952 онд батлагдаж, 1952 оны 4 дүгээр сарын 17 нд Энэтхэгийн онцгой сэтгүүлд хэвлэгдсэн байна.

306 дугаар зүйл. Өргөдөл гомдлын хороо

Тухайн танхимын зарлан дуудсанаар эсхүл тодорхой тохиолдолд тогтоосон хугацаагаар танхимын дарга өргөдөл, гомдлын хороог томилох бөгөөд арван таваас доошгүй гишүүдээс бүрдэнэ:

Төрийн сайд хорооний гишүүн байж болохгүй бөгөөд, хэрэв гишүүн хороонд орсоны дараа сайдаар томилогдсон бол ийнхүү томилогдсон өдрөөс эхлэн хорооний гишүүн байж болохгүй.

307 дугаар зүйл.

1. Хороо нь өөрт нь хандан гаргасан бүх өргөдөл, гомдлыг хянан хэлэлцэж, дүрэмтэй нийцэж байгаа тохиолдолд хорооноос өргөдөл, гомдлын талаар чиглэл өгнө. Өргөдөл, гомдлын талаар чиглэл өгөөгүй бол өгөх хурлын дарга өргөдөл, гомдлыг шийдвэрлэх талаар хэдийд ч чиглэл өгч болно.
2. Хурлын дарга эсхүл хорооноос өгсөн чиглэлд заасны дагуу өргөдөл, гомдлыг бүтнээр эсхүл товчилсон хэлбэрээр тарааж болно.
3. Хороо нь өөрт нь хандаж гаргасан өргөдөл, гомдолд заагдсан тусгай асуудлаар

нотлох баримтыг цуглуулсаны дараа тухайн хэрэгт авах арга хэмжээг санал болгох эсхүл ирээдүйд ийм хэрэг бий болохоос урьдчилан сэргийлэх талаар танхимд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

* * *

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ХОРООДЫН ЧИГ ҮҮРЭГ

2.1. ХБНГУ-ын Бундэстагийн Сонгуулийн шалгалт, гишүүний бүрэн эрх болон дүрмийн байнгын хороо

Сонгуулийн шалгалт, гишүүний бүрэн эрх болон дүрмийн байнгын хороо нь Бундэстагийн анхны байнгын хороо юм. Тус хороо нь Бундэстагийн Ахмадын зөвлөлөөс оруулж ирсэн дүрмийн зөрчилтэй холбогдолтой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээс гадна парламентын эрхзүй, дүрмийн реформтой холбогдолтой асуудлыг хэлэлцдэг. Ахмадын зөвлөл нь дарга, орлогчид, бүлгүүдээс санал болгосон 23 гишүүнээс бүрдэх ба Бундэстагийн хуралдааны (чуулганы [ГА]) хэлэлцэх асуудлыг тогтоож, Тамгын газрын айл ажиллагааг зохицуулдаг.

Тус хороо нь Бундэстагийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг мөн хэлэлцдэг. Сонгуулийн шалгалтын хүрээнд, тус байнгын хороо нь Бундэстагийн сонгуулийн дүн алдаагүй үнэн зөв эсэхийг шалгаж тогтоодог. Бундэстаг нь сонгуулийн бүрэн эрхийн хугацааны турш ажиллах 9 гишүүн болон 9 орлогчийг сонгож, Сонгуулийн шалгалтын хороог байгуулдаг. Зөвхөн Бундэстаг л энэ хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөх эрхтэй.¹⁹

Үндсэн хуулийн 41-р зүйлд тусгасны дагуу сонгуулийн дүнг шалгах үүрэг Бундэстагт оногдоно. Сонгуулийн дүнг зарласнаас хойш 2 сарын дотор холбооны сонгуулийн дүн хүчинтэй эсэх эсэргүүцлийг (татгалзах хүсэлт) Бундэстаг хүлээн авна. Европын парламентын дүн ч үүнд бас хамаарна. Тус хороо нь эсэргүүцэл бүрийг нэг бүрчлэн авч үзэх ба нарийвчлан шалгах, дэнслэх явцдаа гэрч, мэргэжилтэн болон асуудалд холбогдох бусад хүнийг сонсож болно. Эсэргүүцэл тус бүрээр уг хороо нь чуулганы хуралдаанд шийдвэрийн төслийг тухайн байр суурийг илэрхийлэх учир шалтгааны хамт оруулан хэлэлцүүлнэ. Энэхүү үйл ажиллагааг Сонгуулийн шалгалтын тухай хуулинд нарийвчлан тусгасан болно.²⁰

Сонгууль бүрийн дараагаар үр дүнг нь эсэргүүцсэн хэдэн арван эсэргүүцэл Бундэстагт ирдэг. Өнөөдрийг болтол нэг ч сонгуулийн дүн хүчингүй болсон тохиолдол гараагүй байна. Энэ нь эсэргүүцэл үндэслэлгүй байх юмуу эсвэл холбогдох асуудал сонгуулийн дүнд нөлөөлөх хэмжээний биш байсантай холбоотой. Бундэстагийн гаргасан шийдвэрийн эсрэг Үндсэн хуулийн цэцэд эсэргүүцэл илэрхийлж болох юм. Өнөөдрийг хүртэл Үндсэн хуулийн цэц Бундэстагийн бүхий л шийдвэрийг баталгаажуулж ирсэн.²¹ Мөн тухайн байнгын хорооны саналыг үндэслэн, гишүүн нь сонгуулийн бүрэн эрхийн хугацааны туршид парламентын суудлаас огцрох эсэх асуудлыг Бундэстаг шийдвэрлэдэг (жишээ нь, иргэний эрхээ алдсан тохиолдолд).²²

¹⁹ Сонгуулийн шалгалт, гишүүний бүрэн эрх болон дүрмийн байнгын хороо/Ausschuss für Wahlprüfung, Immunität und Geschäftsordnung (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Ausschuss_f%C3%BCr_Wahlpr%C3%BCfung,_Immunit%C3%A4t_und_Gesch%C3%A4ftsordnung

²⁰ Мөн тэнд

²¹ Бундэстагийн дүрэм/Geschäftsordnung des Deutschen Bundestages http://bundesrecht.juris.de/btgo_1980/BJNR012380980.html#BJNR012380980BJNG000900311

²² Германы Бундэстагийн Хороонууд/German Bundestag-Committees, Partnership for Democratic Governance and Security <http://www.pdgs.org/Archivo/bund-comm2.htm#1>

2.2. Шинэ Зеландын парламентын Төлөөлөгчдийн танхимын Хууль зүй ба сонгуулийн Байнгын хороо

Тус Байнгын хорооны чиг үүргийг парламентын Төлөөлөгчдийн танхимын байнгын дүрэм / Standing Orders of the House of Representatives/-ээр тодорхойлсон байна. Шинэ Зеланд улсын Төлөөлөгчдийн танхимын байнгын дүрэм нь 1996 оны 2 дугаар сарын 20-нд хүчин төгөлдөр болж, 2008 оны 11 дүгээр сарын 11 өдрийн нэмэлт, өөрчлөлтийг тусгав.

180 дүгээр зүйл. Хороог үүсгэн бий болгох

Шинээр Парламентын бүрэн эрхийн үйл ажиллагаа эхлэх бүрийд тухайн байнгын хороодыг үүсгэн байгуулна.

184 дүгээр зүйл. Тусгай асуудлаархи хороод болон тэдгээрийн асуудлууд

Хууль зүй /Зүй ёс/ ба Сонгуулийн хороо: Шүүх,Эзэн хааны эрх зүйн болон хуулийн төсөл боловсруулах, сонгуулийн холбогдолтой асуудал, хүний эрх , хууль зүй орно.

185 дугаар зүйл. Хорооны чиг үүрэг

Уг дүрмийн 184 дүгээр зүйлд заасны дагуу хороо нь танхимаас гаргасан асуудлыг хэлэлцэж мэдээлэл хийнэ. Үүнд:

- Хуулийн төсөл
- Өргөдөл, гомдол ...

191 дүгээр зүйл. Хорооны бүрэн эрх /нотлох баримт/

Хорооны дарга нь хорооны нэрийн өмнөөс аливаа этгээдээс нотлох баримт гаргаж авах болон хороонд ирэх хүсэлтийг гаргаж болно..

194 дүгээр зүйл. Дэд хороо

Хороо нь дэд хороо байгуулж болно. Хороо нь энэхүү байнгын дүрэмд нийцүүлэн дэд хорооны журмыг зохицуулна. Хороонд хамаарах дүрэм нь дэд хороонд хамаарна.

196 дугаар зүйл.

Танхимаас санал оруулаагүй тохиолдолд хороо нь гишүүдийн эсрэг хувийн зан байдалтай нь холбоотой шаардлага гаргах, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа хийхийг хориглоно.

2.3. Филиппины Парламентын Төлөөлөгчдийн Танхимын Сонгуулийн эрх ба сонгуулийн шинэчлэлийн хороо /Standing Committee Suffrage and Electoral Reforms/

Филиппины Парламентын Төлөөлөгчдийн Танхим нь нийт 59 байнгын хороотой. Сонгуулийн эрх ба сонгуулийн шинэчлэлийн хороо нь 35 гишүүнтэй ба сонгуулийн эрхийг хамгаалах, сайжруулах болон сонгууль, бүх нийтийн санал асуулга, өргөх бичиг барих, санаачлага гаргахтай холбоотой асуудлыг хариуцан ажилладаг байна.

Филиппин улсад сонгогчийн бүртгэлийн асуудлыг 1996 онд батлагдсан “Сонгогчийн бүртгэлийн тухай” /”**The Voter’s Registration Act of 1996.**”/ хуулиар зохицуулдаг бөгөөд сонгогчийн бүртгэлийн асуудлыг Сонгуулийн ерөнхий Комиссоос /**Commission on Elections**/ гадна Сонгуулийн Бүртгэлийн Зөвлөл /**Election Registration Board** /хариуцан ажилладаг байна. Түүнчлэн сонгуулийн шалгалтын асуудал хариуцсан Сонгуулийн Шалгагчдын Зөвлөл /**Board of Election Inspectors**/ мөн ажилладаг байна.

2.4. АНУ

АНУ-ын Конгресст Өргөдөл гомдлын болон Сонгогчдын нэрсийн жагсаалт бүртгэлийн хяналтын хороо /committee/ байдаг эсэх талаар холбогдох эх сурвалжуудаас үзэхэд Конгрессын бүтцэд дээрхи байнгын хороод байдаггүй нь ажиглагдлаа. Конгрессийн гишүүдийн хууль ёсны үүрэг хариуцлагын нэг нь сонгогчдоос ирсэн өргөдөл гомдлыг шүүн үзэх, улмаар барагдуулах үйл ажиллагаа бөгөөд тэдгээрийг гишүүний орон нутаг дахь бие төлөөлөгчид хариуцан гүйцэтгэж, эцсийн хяналтыг гишүүн тавьдаг байна.

Сонгогчийн нэрсийн жагсаалт бүртгэлийн хорооны хувьд Холбооны улсын онцлогоос хамаарч муж улсууд өөр өөрийн хуулиар сонгуулийг явуулдаг бөгөөд сонгуультай холбоотой аливаа маргаантай асуудалд Конгрессын гишүүд ашиг сонирхлын зөрчлийн үүднээс оролцдоггүй ажээ.

Гурав. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

- Судалгаанд авч үзсэн гадаад орнуудын парламентын Өргөдөл, гомдлын Байнгын хороод нь иргэд, байгууллагаас өргөдөл, хүсэлт, гомдол хүлээн авах дүрэм, журмыг нэлээн нарийвчлан тодорхойлсон байна. Тухайлбал, хаана, хэнд, ямар асуудлаар хэрхэн хандах, ямар хэл дээр бичих, хэмжээ, загвар, өргөдөл, гомдлыг хэлэлцэх, хариу өгөх, хэвлэх зэргийг тодорхой заадаг байна.
- Зарим орны парламентын Өргөдөл, гомдлын хорооны статусыг Үндсэн хуулиар тусгайлан тодорхойлж, тус байнгын хорооны үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгч байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, Германы Бундэстагийн Өргөдөл, гомдлын байнгын хорооны статусыг Үндсэн хуулийн 45с дэх зүйлд заасан хуулиар зохицуулна гэж тусгайлан онцгойлж тодорхойлсон байна.²³
- Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын сонгуулийн асуудал хариуцсан хороод нь сонгуулийн эрх, сонгуулийн шинэчлэл, сонгууль хуулийн дагуу болсон эсэхийг хянан шалгах асуудлыг бүхэлд нь хариуцан ажилладаг болох нь харагдаж байна.
- Үүний зэрэгцээ дээрхи үйл ажиллагаа нь ихэвчлэн сонгуулийн тодорхой асуудлыг зохицуулсан тусгай хуулийн дагуу явагддаг байна. Тухайлбал, Германд “Сонгуулийн шалгалтын тухай” /**Scrutiny of Elections Act**/ хуулиар энэ асуудлыг нарийвчлан зохицуулсан байдаг бол Филиппинд сонгогчдийн бүртгэлийн асуудлыг “Сонгогчийн бүртгэлийн тухай” /**The Voter’s Registration Act of 1996.**”/ хуулиар зохицуулдаг ажээ.
- Түүнчлэн зарим оронд сонгогчийн бүртгэлийн асуудал, сонгуулийн хяналтын асуудлыг хуулийн дагуу хариуцсан бие даасан тусгай байгууллагууд ажилладаг байна. Жишээ нь, Филиппинд Сонгуулийн ерөнхий Комиссоос /**Commission on Elections**/ гадна сонгогчдын бүртгэл хариуцсан Сонгуулийн Бүртгэлийн Зөвлөл /**Election Registration Board**/ сонгуулийн шалгалтын асуудал хариуцсан Сонгуулийн Шалгагчдын Зөвлөл /**Board of Election Inspectors**/ ажилладаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Германы Бундэстаг/Deutscher Bundestag (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Deutscher_Bundestag#Aussch.C3.BCsse

²³ Мөн тэнд

2. Ажлын хуудас 7-Бундэстагийн сонгууль, Хичээлийн сэдэв: Германы ардчилал/Arbeitsblatt 7- Wahlen zum Bundestag, Thema im Unterricht: Die deutsche Demokratie_files_RZN5F9.doc
3. 17 дахь Бундэстагийн Байнгын хороод/Bundestagsausschüsse des 17. Deutschen Bundestages (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Bundestagsaussch%C3%BCsse_des_17._Deutschen_Bundestages
4. Бундэстагийн Өргөдлийн байнгын хороо/Petitionsausschuss des Deutschen Bundestages (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Petitionsausschuss_des_Deutschen_Bundestages
5. Германы Бундэстагийн Хороонууд/German Bundestag-Committees, Partnership for Democratic Governance and Security <http://www.pdgs.org/Archivo/bund-comm2.htm#1>
6. Бундэстагийн дүрэм/Geschäftsordnung des Deutschen Bundestages http://bundesrecht.juris.de/btgo_1980/BJNR012380980.html#BJNR012380980BJNG000900311
7. Сонгуулийн шалгалт, гишүүний бүрэн эрх болон дүрмийн байнгын хороо/Ausschuss für Wahlprüfung, Immunität und Geschäftsordnung (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Ausschuss_f%C3%BCr_Wahlpr%C3%BCfung,_Immunit%C3%A4t_und_Gesch%C3%A4ftsordnung
8. www.europarl.europa.eu. European Parliament Fact Sheets, 2.5.0. EU citizens' right petition
9. The Constitution of India, Lok Sabha Secretariat November, 2006
10. Энэтхэг Улсын Парламентын “ Доод танхимын /Lok Sabha/ үйл ажилгаатай холбогдох үйл ажилгааны дүрэм” 2010 он, Тамгын газар Шинэ Дэли, 14 дахь хэвлэл
11. “Rules of procedure and conduct of business in Lok Sabha” Fourteenth edition, July, 2010. Lok Sabha Secretariat, New Delhi. <http://www.parliament.nz/>
12. House of Representatives Standing and Sessional Orders. <http://www.aph.gov.au/>
13. Rules for form and content of petitions. House of Representatives Standing and Sessional Orders <http://www.aph.gov.au/>
14. Standing Orders of the House of Representatives, 2008. <http://www.parliament.nz/en-NZ/PB/Rules/StOrders/>



**СОНГОГЧИЙН ИРЦ, САНАЛЫН БОСГЫН ТАЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ** (Мэдээлэл-лавлагаа)

*Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, Ц. Болормаа, Б. Хатантуул,
Ө. Мөнхтунгалаа*

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Сүхбаатарын 2011 оны 5 сарын 11-ний өдрийн албан бичгээр ирүүлсэн судалгааны захиалгын дагуу дараахь мэдээлэл-лавлагааг Судалгааны төвийн судалгааны баг хийж гүйцэтгэлээ. Энэхүү мэдээлэл-лавлагааны түүвэрлэлтийг хийхдээ сонгосон 54 орны сонгуулийн хууль тогтоомжийг судлахаас гадна хамгийн сүүлийн үеийн шинэчлэгдсэн мэдээлэл бүхий олон улсын парламентын холбооны албан ёсны мэдээллийн эх сурвалж болох www.iri.org сайтын мэдээллийг давхар ашигласан нь мэдээллийн үнэн бодит эсэхэд эргэлзээ төрүүлэхгүй болно. Тус ажил нь харьцуулсан мэдээлэл бүхий хоёр хүснэгтээс бүрдэнэ.

Нэгдүгээр хүснэгтэд дэлхийн 54 орны парламентын /2 танхимтай парламентын хувьд доод танхим/ гишүүдийн тоо, сонгуулийн тогтолцоо, сонгууль хүчинтэйд тооцох сонгогчдын ирц болон саналын босгын талаарх мэдээллийг харьцуулан нэгтгэсэн юм. Нэгдүгээр хүснэгтийн харьцуулсан мэдээллийн түүвэрлэлтийн үр дүнгээс харахад сонгож авсан 54 орны 14 нь сонгуулийн холимог тогтолцоог, 16 нь мажоритар, үлдсэн 24 орон нь сонгуулийн пропорционал тогтолцоогоор парламентын сонгуулиа зохион байгуулдаг байна.

Сонгуулийг хүчинтэйд тооцох сонгогчдын ирцийн хувьд ихэнхи улс орон сонгуулийн хуулиндаа ирцийн хувь тогтоогоогүй байна. Энэ нь тухайн орны хууль тогтоомжид "... иргэд сонгууль өгөх эрхтэй..." хэмээн заасантай холбоотой бөгөөд энэ эрхээ эдлэх эсэх нь хувь хүний эрхийн асуудал учраас заавал ирцийн хэмжээ тогтоох шаардлага байгаагүй байж болох талтай.

Судалгаанд хамрагдсан 54 орны 14 нь **Compulsary voting** буюу **Заавал сонгууль өгөх** хуулийн зохицуулалттай байна. Заавал сонгууль өгөх энэ зохицуулалт нь албадлага хэрэглэдэг, албадлага хэрэглэдэггүй гэсэн 2 төрөлтэй байх бөгөөд Өмнөд Америк, Африкийн зарим орон түүн дээр Австрали болон Шинэ Зеланд нь албадлага бүхий сонгууль заавал өгөх зохицуулалтыг хэрэглэж байна. Харин Бельги, Грек, Дани гэх мэд Европийн зарим орон албадлага хэрэглэдэггүй ч сонгууль заавал өгөх зохицуулалтыг хэрэглэж байна. Харин Унгар болон Казакстан сонгууль хүчинтэй байх сонгогчдын ирцийг 50 хувь байхаар хуулиар тогтоосон бол, Узбекистан нь 33 хувь байхаар зохицуулсан байна.

Мажоритар зарчмаар сонгууль зохион байгуулж байгаа 16 орны хувьд Унгар, Австрали, АНУ, Казакстан, Узбекистан, Канад зэрэг орон сонгогчдын саналын босгийг 50 + 1 гэж тогтоосон бол Энэтхэг 50-иас доошгүй хувь, бусад нь хамгийн олон санал авснаар сонгогдох зохицуулалт хийсэн байна.

Хоёрдугаар хүснэгтийн хувьд 185 орны сүүлчийн сонгуулийн ирцийн сонгогчдын мэдээллийг багтаасан байна. Тус мэдээллээс үзэхэд 185-аас 19 орон нь 50-иас доош хувийн ирцтэй байсан бөгөөд үүнээс Гайти 22%, Габон 30%, Гамби 38%, Мали 33 хувийн ирцийн үзүүлэлттэй байсан юм. Хамгийн өндөр буюу 90 ба түүнээс дээш ирцтэй 17 улс байсан бол бусад улс орны хувьд 50 хувиас дээш хувийн ирцтэй байна. Үүнээс дийлэнхи улс нь 60-80 хувийн ирцтэй байгаа нь харагдаж байна. Судалгааны захиалгын дагуу ирүүлсэн хүсэлтийн хүрээнд доорхи 2 харьцуулсан хүснэгтийг хавсралтаар оруулав.



Дэлхийн зарим улсын сонгуулийн тогтолцоо, сонгогчдын ирц болон саналын босгын талаарх харьцуулсан мэдээлэл

Харьцуулсан хүснэгт - 1

| № | Улсын нэр | Парламентын доод танхимын нэр, гишүүдийн тоо | Сонгуулийн тогтолцоо | Сонгууль хүчинтэй байх ирц | Саналын босго (мажоритар) |
|---|--|--|--|-----------------------------------|---------------------------|
| 1 | Чех Act of Law 247/1995 Coll., on elections to the Parliament of the Czech Republic www.psp.cz | Депутатуудын Танхим, 200 | пропорционал 5% | Сонгуулийн хуулинд заалт байхгүй | |
| 2 | Унгар Act No XXXIV of 1989 on the election of members of Parliament, Hungary www.legislation-line.org | Үндэсний Ассамблей, 386 | Холимог 1) 176 гишүүн мажоритариар сонгоно 2) 152 гишүүнийг олон мандаттай нутаг дэвсгэрийн тойргоос пропорционалиар, 5% 3) 58 гишүүн нийт улсын нэг тойргоос пропорционалиар, 5% | 50% | 50%+1 |
| 3 | Польш The act of 12 april 2001 on elections to the Sejm of The Republic of Poland and the Senate of the Republic of Poland www.legislation-line.org | Сейм, 460 | Пропорционал, 5% 1) 69 нь бүх Польшийн нэг тойргоос 2) 391 нь олон мандаттай тойргуудаас | Сонгуулийн хуулинд заалт байхгүй | |
| 4 | Их Британи Political Parties and Elections Act 2009, United Kingdom www.legislation.gov.uk | Нийтийн танхим, 650 | Мажоритар, 646 нэг мандаттай тойргууд | Холбогдох хуулиудад заалт байхгүй | Хамгийн олон саналаар |

| | | | | | |
|----|---|----------------------------------|---|---|--------------------------|
| 5 | Швед The Elections Act, SFS 2005:837, www.sweden. gov.se Instrument of Government, SFS 1974:152 www.riksdagen.se | Риксдаг, 349 | Пропорционал, 4 % олон мандаттай 29 тойрог | Сонгуулийн хуулинд заалт байхгүй | |
| 6 | Испани Ley Orgánica del Régimen Electoral General, Spain Central Electoral Commission, Representation of the People institutional act | Депутатуудын Конгресс, 350 | Холимог 1) муж бүрээс 2 гишүүн мажоритариар сонгогдоно. Нийт 102 гишүүн 2) олон мандаттай 50 тойргоос пропорционалиар 248 депутат сонгоно | Сонгуулийн хуулинд заалт байхгүй | Хамгийн олон саналаар |
| 7 | ОХУ Федеральный закон Российской Федерации от 18 мая 2005 г. N 51-ФЗ О выборах депутатов Государственной Думы Федерального Собрания Российской Федерации www.rg.ru | Төрийн дум, 450 | Пропорционал, 7% улсын хэмжээний нэг тойрог | Сонгуулийн хуулинд заалт байхгүй | |
| 8 | Австрали Commonwealth Electoral Act 1918, Australia www.austlii.edu. au | Төлөөлөгчдийн Танхим, 150 | Мажоритар, нэг мандаттай 148 тойрог | Сонгуулийн эрхтэй бүх хүн заавал сонгуульд орох үүрэгтэй | 50%+1 |
| 9 | Шинэ Зеланд Electoral Act 1993 (Reprint as at 17 June 2005), New Zealand http://legislation. knowledge- basket.co.nz | Төлөөлөгчдийн Танхим, 120 | Холимог 1) нэг мандаттай 63 тойрогт мажоритар 2) уугуул иргэдийн нэг мандаттай 7 тойрогт мажоритар 3) 50 гишүүнийг улсын хэмжээний нэг тойргоос пропорционалиар сонгоно, 5% | Сонгуулийн хуулинд заалт байхгүй | Хамгийн олон саналаар |
| 10 | Алжир | Үндэсний арлын ассамблей, 389 | Пропорциональ | Сонгуулийн хуулийн сервер ажиллахгүй байв | - |

Судалгааны эмхтгэл, X боть

| | | | | | |
|----|--------------------|-------------------------|--------------------------|--|-----------------------|
| 11 | Ангол | Үндэсний ассамблей, 223 | Холимог 90/130 | Сонгуулийн хуулиар зохицуулаагүй. 2008 оны сонгууль 87,36%-ийн ирцтэй байсан | Хамгийн олон саналаар |
| 12 | Ботсвана | Үндэсний ассамблей, 63 | Мажоритар | Сонгуулийн хуулиар зохицуулаагүй. 2009 оны сонгууль 76,71% ирцтэй байсан. | Хамгийн олон саналаар |
| 13 | Камерун | Үндэсний ассамблей, 180 | Холимог | Сонгуулийн хуулийн сервер ажиллахгүй байв 2007 оны сонгууль 62 %-ийн ирцтэй | Хамгийн олон саналаар |
| 14 | Кабом-Верде | Үндэсний ассамблей, 72 | Пропорционал | Сонгуулийн хуулиар зохицуулаагүй. 2011 оны сонгууль 71%-ийн ирцтэй байсан | |
| 15 | Конго | Үндэсний ассамблей, 137 | Мажоритар | Сонгуулийн хуулиар зохицуулаагүй. 2007 оны сонгууль албан ёсоор ирц зарлаагүй ч маш доогуур ирцтэй байсан гэсэн мэдээ байна. | 50%+1 |
| 16 | Жибути | Үндэсний ассамблей, 65 | Мажоритар /намын нэрээр/ | Сонгуулийн хуулиар зохицуулаагүй. 2008 оны сонгууль 72,6%-ийн ирцтэй байсан | босгогүй |
| 17 | Кени | Үндэсний ассамблей, 224 | Мажоритар | Сонгуулийн хуулиар зохицуулаагүй. 2007 оны сонгууль албан ёсоор ирц зарлаагүй ч маш өндөр ирцтэй байсан гэсэн мэдээ байна. | Хамгийн олон саналаар |

| | | | | | |
|----|--|---|--|--|--|
| 18 | Марокко | Төлөөлөгчдийн танхим, 325 | Пропорционал | Сонгуулийн хуулийн сервер ажиллахгүй байв, 2007 оны сонгууль 37%-ийн ирцтэй байсан | - |
| 19 | Намиби | Үндэсний ассамблей, 72 | Пропорционал | Сонгуулийн хуулиар зохицуулаагүй. 2009 оны сонгууль 70%-ийн ирцтэй байсан | -. |
| 20 | ӨАБНУ | Үнлэсний ассамблей, 400 | Пропорционал | Сонгуулийн хуулиар зохицуулаагүй. 2009 оны сонгууль 77,3%-ийн ирцтэй байсан | - нийт саналын тоог мандатын тоон дээр нэмэх нэг гэсэн томъёо ашиглана |
| 21 | Маврикий | Үндэсний ассамблей, 72 | Мажоритар / манайхтай адил/ | Сонгуулийн хууль олдоогүй, ҮХуульд зохицуулаагүй. 2010 оны сонгууль 77,82%-ийн ирцтэй байсан | босогүй |
| 22 | Армен Эх сурвалж: Electoral code of the Republic of Armenia | Үндэсний Ассамблей /1 танхимтай/ Гишүүн-131 | Холимог: -41 суудал нь энгийн олонхи ¹ -90 суудал нь намын жагсаалт буюу нам эвсэл-босго-5%-7% ² | Хуулиар тогтоосон босго байхгүй ³ | 41 суудал нь энгийн олонхи |
| 23 | Австри Эх сурвалж: Federal Law on Parliamentary Elections, (Regulations on federal parliamentary elections 1992 – RFPE) | Үндэсний Зөвлөл | Пропорционал /намын жагсаалт-хаалттай/ Босго-4% | Хуулиар тогтоосон босго байхгүй | - |
| 24 | Бельги Эх сурвалж: www.ipu.org | Төлөөлөгчдийн танхим | Пропорционал /намын жагсаалт/ Босго-5% | Compulsory voting буюу заавал санал өгөх үүрэгтэй - албадлага хэрэглэдэггүй | - |

Судалгааны эмхтгэл, X боть

| | | | | | |
|----|--|--|--|---|--|
| 25 | Дани Эх сурвалж: Parliamentary Election Act of Denmark | Парламент /1 танхимтай/ Гишүүн -230 | Пропорционал Хамгийн багадаа 2% | Хуулиар тогтоосон сонгогчдын ирцийн босго байхгүй | - |
| 26 | Франц Эх сурвалж: www.ipu.org | Үндэсний Ассамблей Гишүүн -577 | Мажоритар /2 шатлалтай/ | Хуулиар тогтоосон сонгогчдын ирцийн босго байхгүй. Харин Сенатын сонгуульд иргэд заавал санал өгөх үүрэгтэй. / Compulsory voting/ - албадлага хэрэглэдэггүй | -Эхний шатанд нийт саналын үнэмлэхүй олонхийн санал /50+1/ авснаар, -Хэрэв үнэмлэхүй олонхи болоогүй бол 2 дахь санал хураалтад Нийт бүртгэгдсэн сонгогчдийн хамгийн багадаа 12,5 % санал авснаар |
| 27 | Герман Эх сурвалж: www.ipu.org | Бундестаг Гишүүн -622 | Холимог: -Пропорционал системээр Намын жагсаалт санал өгнө. Босго-5% -299 гишүүн мажоритар зарчмаар сонгогдоно. | Хуулиар тогтоосон сонгогчдын ирцийн босго байхгүй Нэг сонгогч 2 саналын эрхтэй. Бие даан нэр дэвшигчид өгөх, намын жагсаалтад өгөх | Мажоритар системийн хувьд тойрог бүрээс анхны санал хураалтаар хамгийн өндөр санал авсан нь сонгогдоно. |
| 28 | Грек Эх сурвалж: www.ipu.org | Грекийн Парламент /1 танхимтай/ Гишүүн -300 | Холимог: -Энгийн олонхи -Пропорционал / намын жагсаалт босго-3%/ Нэг болон олон мандаттай 56 тойргоос 288 суудал, Улсыг олон мандаттай нэг тойрог болгон 12 Төрийн Депутатыг сонгоно. | Compulsory voting /албадан сонгууль/ буюу заавал санал өгөх үүрэгтэй | Нэг мандаттай 8 тойрогт энгийн олонхийн зарчмаар. |
| 29 | Латви Эх сурвалж;The Saeima Election Law, Electoral Register Law www.ipu.org | Парламент /1 танхимтай/ Гишүүн -100 | Пропорционал /Намын босго-5%/ | Хуулиар тогтоосон сонгогчдын ирцийн босго байхгүй | - |

| | | | | | |
|----|--|---|---|---|---|
| 30 | Португал Эх сурвалж: Law no. 14/79 www.ipu.org | Бүгд Найрамдах Ассамблей /1 танхимтай/ Гишүүн -230 | Пропорционал /хаалттай намын жагсаалт бүхий/ | Хуулиар тогтоосон сонгогчдын ирцийн босго байхгүй | - |
| 31 | Энэтхэг www.ipu.org | Ардын танхим /2 танхимтай/ /Lok Sabha / House of the People Гишүүн -545 | Мажоритар Бүх ард түмнээс шууд сонгодог 543, Энэтхэгийн англичуудын нийгэмлэгээс Ерөнхийлөгч томилдог 2, | Хуулиар тогтоогүй. | 50 % -иас доошгүй |
| 32 | Солонгос www.ipu.org | Үндэсний Ассамблей /1 танхимтай/ / National Assembly/ 299 гишүүн | Холимог -245 гишүүнийг 1 мандат бүхий 245 тойргоос ердийн олонхийн саналаар сонгодог. -54 гишүүнийг улсын 1 тойрог болгон сонгогчдын өгсөн саналыг хувь тэнцүүлэн хуваарилах. Намын босго 3% | Хуулиар тогтоогүй. | Хамгийн олон санал |
| 33 | Япон www.ipu.org | Төлөөлөгчдийн танхим /2 танхимтай/ /Shugiin , House of Representatives/ 480 гишүүн. | Холимог 300 гишүүнийг 1 мандаттай 300 тойргоос олонхийн саналаар сонгодог. Үлдсэн гишүүдийг 6-29 олон мандат бүхий 11 тойргоос хувь тэнцүүлэх аргаар сонгодог. | Хуулиар тогтоогүй. | Нийт хүчинтэй саналын 1/6- ийг авах. |
| 34 | Сингапур www.ipu.org | Парламент /1 танхимтай/ / Parliament/ 94 гишүүн | Мажоритар 84-ийг нь 1 мандат бүхий 9 тойрог, 5-6 мандат бүхий 14 тойрог 9 гишүүнийг олон нийтээс нэр дэвшүүлж парламентын сонгуулийн хороогоор хэлэлцэж шийдвэрлэсний дараа Ерөнхийлөгч томилно. | Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг. | Хамгийн олон санал. Олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогддог. 1 гишүүнийг парламентад суудал аваагүй, намуудаас хамгийн олон суудал авсан, үндэсний цөөнхийн төлөөллөөс сонгогдсон тооцно. |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | | | |
|----|---------------------------------|--|--|--|---------------------|
| 35 | Малайз www.ipu.org | Төлөөлөгчдийн танхим /2 танхимтай/ /Dewan Rakyat , House of Representatives/ 222 гишүүн | Мажоритар сонгуулийн нэг мандаттай олон тойрогос энгийн олонхийн саналаар | Хуулиар тогтоогоогүй. | Хамгийн олон санал. |
| 36 | Тайланд www.ipu.org | Төлөөлөгчдийн танхим /2 танхимтай/ /House of Representatives, Saphaphuthan Ratsadon / | Холимог - Гишүүдийг олон мандаттай олон тойргоос --400 гишүүнийг олонхийн аргаар, 80 гишүүнийг хувь тэнцүүлэх аргаар сонгодог. Намын хаалттай жагсаалттай. | Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг. | |
| 37 | Филлипин www.ipu.org | Төлөөлөгчдийн танхим /2 танхимтай/ Kapulungan Ng Mga Kinatawan / House of Representatives 280 гишүүн | <u>Холимог</u> - 228 нь мажоритар тогтолцоогоор, -52 суудлыг нутгийн цөөнх болон уугуул иргэдийн санал дээр үндэслэн намын жагсаалтаар хувь тэнцүүлэх аргаар сонгодог. Намын босго 2% | Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг. | Хамгийн олон санал |
| 38 | Индонез www.ipu.org | Төлөөлөгчдийн зөвлөл /1 танхимтай/ Dewan Perwakilan Rakyat / House of Representatives/ | <u>Пропорционал</u> Намын нэрийн жагсаалтаар, саналын хувь тэнцүүлэх аргаар. Олон мандат бүхий сонгуулийн 33 тойрогтой. Намаас нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байна гэсэн квоттой. Намын босго 2,5 % | Хуулиар тогтоогоогүй. | --- |
| 39 | Казахстан www.ipu.org | Мажилис / 2 танхимтай/ Mazhilis / House of Representatives/ 107 гишүүн | Пропорционал 98 депутатыг бүх ард түмний сонгуулиар, намын нэрсийн жагсаалтаар хувь тэнцүүлэх зарчмаар сонгох бөгөөд 9 депутатыг "Казахстаны ард түмний Ассамблей"-аас сонгоно. Бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Намын босго 7 % | 50% | --- |

| | | | | | |
|----|---|--|--|---|--|
| 40 | Узбекистан www.ipu.org | Хууль тогтоох танхим /2 танхимтай/ / Legislative Chamber, Qonunchilik palatasi/ 150 гишүүн | Мажоритар Шууд сонгогддог 135, шууд бус 15. 2 шатлалтай мажоритар тогтолцоотой. | 33 % | 50%+1 |
| 41 | Пакистан www.ipu.org | Үндэсний Ассамблей /2 танхимтай/ National Assembly гишүүн 342 | Мажоритар суудлын 60 нь эмэгтэй гишүүнд, 10-ыг нь Мусулман буюу цөөнхөд хуваарилсан. | Хуулиар тогтоогоогүй. | Хамгийн олон санал. |
| 42 | Сири www.ipu.org | Ардын хурал /1 танхимтай/ / The People's Assembly, Majlis Al-Chaab/ 250 гишүүн | Мажоритар Олон мандаттай олон тойргоос энгийн олонхийн аргаар сонгодог. | Хуулиар тогтоогоогүй. | Хамгийн олон санал. |
| 43 | Аргентин /Argentina Republic/ 1.www.ipu.org 2.http://pdba. georgetown.edu/ Constitutions/ Argentina/ argentina.html 3.Codigo ctoral#2.135-1983 | 2 танхимтай –Доод танхим- Депутатуудын танхим / Camara de Deputados/-257 гишүүнтэй | Хувь тэнцүүлсэн -D'Hondt /намын жагсаалт/ын босго-3% | Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг. | - |
| 44 | Бразил /Federative Republic of Brazil/ 1.www.ipu.org 2. http://pdba. georgetown.edu | 2 танхимтай –Доод танхим- Депутатуудын танхим / Chamber of Deputies/-513 гишүүнтэй | Хувь тэнцүүлсэн -D'Hondt /намын жагсаалт, намын босго-5%/ | Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг. | - |
| 45 | Чили /Republic of Chile/ 1.www.ipu.org 2. Constitution of Chile,1980 3.Ley Organica del Electoral | 2 танхимтай- доод танхим- Депутатуудын танхим / Camara de Deputados/-120 гишүүнтэй | Хувь тэнцүүлсэн Намын нэрсийн хувь тэнцүүлсэн тогтолцоо-60 тойргоос тус бүр 2 гишүүн сонгогддог | Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг. | 1 суудал-33,4% 2 суудал авахын тулд нийт саналын 66,7% |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | | | |
|----|--|---|---|---|--|
| 46 | <p>Колумби /Republic of Colombia/ 1. www.ipu.org 2. http://pdba.georgetown.edu</p> | <p>2 танхимтай -Доод танхим- Төлөөлөгчдийн танхим /House of Representative/-166 гишүүнтэй</p> | <p>Хувь тэнцүүлсэн -D'Hondt /намын жагсаалт Намын босго- хаалттай/</p> | <p>Хуулиар тогтоосон босго байхгүй.</p> | - |
| 47 | <p>Гондурас /Republic of Honduras/ 1. www.ipu.org 2. Ley Electoral-44,2004 3. http://pdba.georgetown.edu/ElecSys/Honduras.</p> | <p>1 танхимтай- Үндэсний Конгресс / National Congress/-128 гишүүнтэй</p> | <p>Хувь тэнцүүлсэн -D'Hondt /намын жагсаалт, Намын босго байхгүй/</p> | <p>Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг.</p> | - |
| 48 | <p>АНУ /The United States of America/ 1. www.ipu.org 2. http://pdba.georgetown.edu 3. en.wikipedia.org/wiki/Elections_in_the_United_States 4. The Constitution of the USA</p> | <p>2 танхимтай-Доод танхим- Төлөөлөгчдийн танхим /House of Representative/-435 гишүүнтэй+</p> | <p>1 мандаттай мажоритар</p> | <p>Хуулиар тогтоосон босго байхгүй.</p> | <p>Үнэмлэхүй олонхи буюу 50%+1 саналыг хуулиар шаарддаггүй</p> |
| 49 | <p>Уругвай /Oriental Republic of the Uruguay/ 1. www.ipu.org 2. http://pdba.georgetown.edu</p> | <p>2 танхимтай- Доод танхим- Депутатуудын танхим/ Samara de Deputados/-99 гишүүнтэй</p> | <p>Хувь тэнцүүлсэн -D'Hondt /намын жагсаалт Намын босго байхгүй/</p> | <p>Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг.</p> | - |
| 50 | <p>Парагвай /Republic of Paraguay/ 1. www.ipu.org 2. http://pdba.georgetown.edu 3.Codigo Electoral #834, 1996</p> | <p>2 танхимтай- Доод танхим- Депутатуудын танхим / Samara de Deputados/-80 гишүүнтэй</p> | <p>Хувь тэнцүүлсэн -D'Hondt /намын хаалттай жагсаалт, намын босго байхгүй/</p> | <p>Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг.</p> | - |

| | | | | | |
|----|---|--|--|--|--|
| 51 | Мексик /United States of Mexico/ 1. www.ipu.org 2. http://pdba.georgetown.edu 3.Codigo Federal de Instituciones y Procedimientos Electorales | 2 танхимтай- Доод танхим- Депутатуудын танхим / Camara de Deputatos/-500 гишүүнтэй | 2 санал бүхий Холимог 200 гишүүн -Хувь тэнцүүлсэн/40 мандаттай 5 тойрог/ 300 гишүүн- 1 мандаттай 300 тойрог/ Олонхийн | Хуулиар саналаа заавал өгөх шаардлага тавьдаг | Хамгийн олон санал |
| 52 | Никарагуа /Republic of Nicaragua/ 1. www.ipu.org 2. http://pdba.georgetown.edu | 1 танхимтай- Үндэсний Ассамблей / National Assembly/-92 гишүүнтэй | Хувь тэнцүүлсэн -D'Hondt /намын жагсаалт/ | Хуулиар тогтоосон босго байхгүй | - |
| 53 | Канад /Canada/ 1. www.ipu.org 2. http://pdba.georgetown.edu 3. http://www.elections.ca 4. Canada Electoral Act 2000 | 2 танхимтай- Доод танхим- Нийтийн танхим / House of Orgmons/-308 гишүүнтэй | 1 мандат бүхий мажоритар | Хуулиар тогтоосон босго байхгүй | Үнэмлэхүй олонхи буюу 50%+1 саналыг хуулиар шаарддаггүй |
| 54 | Венесуэл /Republic of Venezuela/ 1. www.ipu.org 2. http://pdba.georgetown.edu | 1 танхимтай- Үндэсний Ассамблей / National Assembly/-165 гишүүнтэй | Холимог 110 суудал- мажоритар 68 тойргоос-1, 15 тойргоос-2, 4 тойргоос-3 гишүүн тус тус 52 суудал -Хувь тэнцүүлсэн /D'Hondt/ 3 суудал -нутгийн уугуул иргэд | Хуулиар тогтоосон босго байхгүй. | Хамгийн олон санал |

* * *

**Олон Улсын Парламентын Холбооны гишүүн орнуудын сүүлчийн сонгуулийн
ирцийн байдал**

Харьцуулсан хүснэгт-2

| № | Улсын нэр, парламентын танхимын нэр | Сүүлийн сонгуулийн огноо | Сонгогчдын ирцийн хувь (%) |
|----|---|--|----------------------------|
| 1 | Бутан - Үндэсний ассамблей - Үндэсний зөвлөл | 2008,03,24 2007,12,31 2008,01,29 | 79,45 54,87 - |
| 2 | Боливи - Депутатуудын танхим - Сенатын танхим | 2009,12,06 2009,12,06 | - - |
| 3 | Босни-Герцогвина - Төлөөлөгчдийн танхим - Ард түмний танхим | 2010,10,03 2007,03,14 | 56,49 - |
| 4 | Ботсвана - Үндэсний ассамблей | 2009,10,16 | 76,71 |
| 5 | Бразил - Депутатуудын танхим - Холбооны сенат | 2010,10,02 2010,10,02 | 81,88 81,88 |
| 6 | Болгар - Үндэсний ассамблей | 2009,06,05 | 60,95 |
| 7 | Буркино-Фасо - Үндэсний ассамблей | 2007,05,06 | 56,43 |
| 8 | Бурунди - Үндэсний ассамблей - Сенат | 2010,06,23 2010,06,28 | 66,68 - |
| 9 | Камбож - Үндэсний ассамблей - Сенат | 2008,06,27 2006,01,22 | 78,21 99,89 |
| 10 | Камерун - Үндэсний ассамблей | 2007,06,07 2007,09,30 | 62,0 |
| 11 | Канад - Нийтийн танхим - Сенат | 2011,05,02 Мэдээлэл байхгүй | - - |
| 12 | Кабо-Верде -Үндэсний ассамблей | 2011,02,06 | 71,0 |
| 13 | Төв африкийн БНУ -Үндэсний ассамблей | 2011,01,13 | 61,16 |
| 14 | Чад - Үндэсний ассамблей | 2011,02,13 | 62,56 |
| 15 | Чили - Депутатуудын танхим - Сенат | 2009,12,13 2009,12,13 | 86,66 84,63 |
| 16 | БНХАУ -Бүх хятадын ардын төлөөлөгчдийн их хурал | 2008,03,05 | - |
| 17 | Колумб - Төлөөлөгчдийн танхим - Сенат | 2010,03,14 2010,03,14 | 43,74 - |

| | | | |
|----|---|--|-------------------------------|
| 18 | Коморын арлууд - Холбооны ассамблей | 2009,12,06 2009,12,20 | Тойргуудад 40- 78 % |
| 19 | Конго - Үндэсний ассамблей - Сенат | 2007,06,24 2007,08,05 | Доогуур ирцтэй байсан - |
| 20 | Коста-Рика - Хууль тогтоох ассамблей | 2010,02,07 | 69,08 |
| 21 | Кот-д' Ивуар - Үндэсний ассамблей | 2000,12,10 | 31,54 |
| 22 | Хорват - Парламент | 2007,11,25 | 57,17 |
| 23 | Куба - Ардын засгийн Үндэсний хурал | 2008,01,20 | 96,89 |
| 24 | Кипр - Төлөөлөгчдийн танхим | 2006,05,26 | 89,0 |
| 25 | Чех - Депутатуудын танхим - Сенат | 2010,05,28 2010,05,29 2010,10,15 2010,10,23 | 62,6 44,59 |
| 26 | БНАСАУ - Ардын Дээд Хурал | 2009,03,08 | 99,98 |
| 27 | БНАКонго Улс - Үндэсний ассамблей - Сенат | 2006,06,30 2007,01,19 | 70,29 - |
| 28 | Дани - Парламент | 2007,11,13 | 86,59 |
| 29 | Жибути - Үндэсний ассамблей | 2008,02,08 | 72,61 |
| 30 | Доминик - Хурлын танхим | 2009,12,18 | 54,87 |
| 31 | Доминикан - Депутатуудын танхим - Сенат | 2010,05,16 2010,05,16 | 56,44 56,44 |
| 32 | Экватор - Үндэсний ассамблей | 2009,04,26 | 75,0 |
| 33 | Египет - Ардын ассамблей - Шура ассамблей | 2011,02,13-д парламентын 2 танхимыг тараасан байна. | |
| 34 | Эл Салвадор - Хууль тогтоох хурал | 2009,01,18 | 53,58 |
| 34 | Экваторын Гвиней - Ардын төлөөлөгчдийн хурал | 2008,05,04 | Ирц бага байсан |
| 36 | Эритрей - Үндэсний ассамблей | 1994 оноос хойш мэдээлэл байхгүй | |
| 37 | Этиопи - Ардын төлөөлөгчдийн танхим - Холбооны танхим | 2010,05,23 2010,05,23 | 93,44 - |
| 38 | Финланд - Парламент | 2011,04,17 | 70,5 |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|----|--|--|------------------------------|
| 39 | Франц - Үндэсний ассамблей - Сенат | 2007,06,10 2007,06,17 2008,09,21 | 60,42 59,99 - |
| 40 | Габон - Үндэсний ассамблей - Сенат | 2006,12,17 2006,12,24 2009,01,18 | Том хотуудад 12-30 % - |
| 41 | Гамби - Үндэсний ассамблей | 2007,01,25 | 38,0 |
| 42 | Гүрж - Парламент | 2008,05,21 | 53,39 |
| 43 | Герман - Бундестаг - Бундсрат | 2009,09,27 Мэдээлэл байхгүй | 70,78 - |
| 44 | Грек - Парламент | 2009,10,04 | 70,92 |
| 45 | Гренада - Төлөөлөгчдийн танхим | 2008,06,08 2008,08,20 | 80,3 - |
| 46 | Гватемал - Конгресс | 2007,09,09 | 60,46 |
| 47 | Гвиней-Биссау - Үндэсний ардын ассамблей | 2008,11,16 | 82,0 |
| 48 | Гайана - Үндэсний ассамблей | 2006,08,28 | 68,82 |
| 49 | Гайти - Депутатуудын танхим - Сенат | 2010,11,28 2010,11,28 2011,03,20 | 22,0 22,0 - |
| 50 | Гондурас - Үндэсний конгресс | 2009,11,29 | 50,0 |
| 51 | Унгар - Үндэсний ассамблей | 201,04,11 | 64,38 |
| 52 | Исланд - Парламент | 2009,04,25 | 85,1 |
| 53 | Энэтхэг - Ардын танхим - Төрийн зөвлөл | 2009,04,16 2009,05,13 2010,03,19 2010,06,03 | 63,16 - - - |
| 54 | Индонез - Төлөөлөгчдийн танхим | 2009,04,09 | 70,99 |
| 55 | Иран - Исламын парламент | 2008,03,14 | 49,47 |
| 56 | Ирак - Төлөөлөгчдийн зөвлөл | 2010,03,07 | 62,4 |
| 57 | Ирланд - Төлөөлөгчдийн танхим - Сенат | 2011,02,25 2007,06,23 | - - |
| 58 | Израйл - Парламент | 2009,02,10 | 65,2 |
| 59 | Итали - - Депутатуудын танхим - Сенат | 2008,04,13 2008,04,14 2008,04,13 2008,04,14 | 80,51 80,4 |

| | | | |
|----|---|--------------------------------|-------------------------|
| 60 | Ямайка - Төлөөлөгчдийн танхим - Сенат | 2007,09,03 2007,09,03 | 60,4 - |
| 61 | Япон - Төлөөлөгчдийн танхим - Зөвлөхүүдийн танхим | 2009,08,30 2010,06,11 | 69,27 57,92 |
| 62 | Йордан - Төлөөлөгчдийн танхим - Сенат | 2010,11,09 2010,11,25 | 53,0 - |
| 63 | Казахстан - Сенат - Мажилис | 2008.10.4. 2007.08.18 | - 68,41% |
| 64 | Кени -Үндэсний ассамблей | 2007.12.27 | Мэдээлэл будилаантай |
| 65 | Кирибати -Ассамблейн танхим | 2007.08.22, 30 | 56,7% |
| 66 | Кувейт -Үндэсний Ассамблей | 2009.05.16 | 59% |
| 67 | Киргизстан Дээд Зөвлөл | 2010.10.10 | 55,9% |
| 68 | Лаос Үндэсний Ассамблей | 2011.04.30 | - |
| 69 | Латви Парламент | 2010.10.02 | 62,63% |
| 70 | Ливан Үндэсний ассамблей | 2009.06.07 | 53,98% |
| 71 | Лесото 1.Сенат 2.Үндэсний ассамблей | 2007.03.09 2007.02.17 | - 49% |
| 72 | Либериа 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2005.10.11 2005.10.11 | 74,9% 74,9% |
| 73 | Ливи Ардын Ерөнхий конгресс | 2009.03.01 | - |
| 74 | Лихтенштейн Ландтаг | 2009.02.08 | 84,63% |
| 75 | Литва Сейм | 2008.10.12, 26 | 48,6% |
| 76 | Люксембург Депутатуудын танхим | 2009.06.07 | 90,93% |
| 77 | Мадагаскар 1.Шилжилтийн Дээд Зөвлөл 2.Шилжилтийн конгресс | 2010.10.12 2010.10.11 | - - |
| 78 | Малави Үндэсний Ассамблей | 2009.05.19 | - |
| 79 | Малайз 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | Мэдээлэл байхгүй 2008.03.08 | - 74,72% |
| 80 | Мальдив Ардын Мажилис | 2009.05.09 | 78,87% |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|--|--------------------------------|------------------|
| 81 | Мали Үндэсний ассамблей | 2007.07.01, 22 | 33% |
| 82 | Мальта Төлөөлөгчдийн танхим | 2008.03.08 | 93,3% |
| 83 | Маршаллын арлууд Парламент | 2007.11.19 | 50% |
| 84 | Мавритани 1.Сенат 2.Үндэсний ассамблей | 2009.11.08, 15 2006.11.19 | - 73% |
| 85 | Маврикий Үндэсний ассамблей | 2010.05.05 | 77,82% |
| 86 | Мексик 1.Сенат 2.Депутатуудын танхим | 2006.07.02 2009.07.05 | 59,9% - |
| 87 | Микронези Конгресс | 2011.03.08 | - |
| 88 | Монако Үндэсний зөвлөл | 2008.02.03 | 76,85% |
| 89 | Монтенегро Скупшина | 2009.03.29 | 66,19% |
| 90 | Марокко 1.Зөвлөхүүдийн танхим 2.Төлөөлөгчдийн танхим | 2009.10.03 2007.09.07 | - 37% |
| 91 | Мозамбик Бүгд найрамдах улсын Ассамблей | 2009.10.28 | 44,44% |
| 92 | Мьянмар 1.Үндэстний танхим 2.Төлөөлөгчдийн танхим | 2010.11.07 2010.11.07 | 76,78% 77,26% |
| 93 | Намиби 1.Үндэсний зөвлөл 2.Үндэсний ассамблей | 2010.11.26,27 2009.11.27,28 | - 70% |
| 94 | Науру Парламент | 2010.06.19 | 92,69% |
| 95 | Балба Парламент | 2008.04.10 | 63% |
| 96 | Нидерланд 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2007.05.29 2010.06.09 | - 75,4% |
| 97 | Шинэ Зеланд Төлөөлөгчдийн танхим | 2008.11.08 | 79,46% |
| 98 | Никарагуа Үндэсний Ассамблей | 2006.11.05 | 66,73% |
| 99 | Нигер Үндэсний ассамблей | 2011.01.31 | 49,22% |
| 100 | Нигери 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2011.04.09 2011.04.09 | - - |
| 101 | Норвеги Стортингет | 2009.09.14 | 76,37% |

| | | | |
|-----|---|------------------------------|------------------|
| 102 | Оман 1.Төрийн зөвлөл 2.Зөвлөлдөх зөвлөл | 2007.11.10 2007.10.27 | - 62,7% |
| 103 | Пакистан 1.Сенат 2.Үндэсний Ассамблей | 2009.03.04 2008.02.17 | - 44% |
| 104 | Палау 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2008.11.05 2008.11.05 | 73,27% 42,66% |
| 105 | Панам Үндэсний Ассамблей | 2009.05.03 | 70,04% |
| 106 | Папау Шинэ Гвиней Үндэсний парламент | 2007.06.30 | - |
| 107 | Парагвай 1.Сенат 2.Депутатуудын танхим | 2008.04.20 2008.04.20 | 69,56% 65,48% |
| 108 | Перу Бүгд найрамдах улсын конгресс | 2011.04.10 | 83,71% |
| 109 | Филиппин 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2010.05.10 2010.05.10 | 73,42% 73,42% |
| 110 | Польш 1.Сенат 2.Сейм | 2007.10.21 2007.10.21 | 53,88% 53,88% |
| 111 | Португал Бүгд найрамдах улсын ассамблей | 2009.09.27 | 59,74% |
| 112 | Катар Зөвлөгчдийн танхим | 2010.06.01 | - |
| 113 | БНСУ Үндэсний Ассамблей | 2008.04.09 | 46% |
| 114 | Молдова Парламент | 2010.11.28 | 63,37% |
| 115 | Румын 1.Сенат 2.Депутатуудын танхим | 2008.11.30 2008.11.30 | 39,2% 39,2% |
| 116 | ОХУ 1.Холбооны зөвлөл 2.Төрийн дум | - 2007.12.02 | - 63,78% |
| 117 | Руанда 1.Сенат 2.Депутатуудын танхим | 2003.10.02 2008.09.15, 18 | - 98,5% |
| 118 | Сент Киттс ба Невис Үндэсний ассамблей | 2010.01.25 | 83,51% |
| 119 | Сент Луция 1.Сенат 2.Ассамблейн танхим | 2007.01.09 2006.12.11 | - 58,46% |
| 120 | Сент Винсент ба Гернадин Ассамблейн танхим | 2010.12.13 | 62,33% |
| 121 | Самао Хууль тогтоох Ассамблей | 2011.03.04 | 90% |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|---|--------------------------|------------------|
| 122 | Сан Марино Их Ерөнхий Зөвлөл | 2008.11.09 | 68,48% |
| 123 | Сан Томе ба Принсипи Үндэсний Ассамблей | 2010.08.01 | 88,45% |
| 124 | Саудын Араб Зөвлөлдөх зөвлөл | 2009.02.28 | - |
| 125 | Сенегал 1.Сенат 2.Шндэсний Ассамблей | 2007.08.19 2007.06.03 | - 68% |
| 126 | Серб Үндэсний ассамблей | 2008.05.11 | 61,35% |
| 127 | Сейшел Үндэсний Ассамблей | 2007.05.10, 12 | 85,9% |
| 128 | Сьерра Леоне Парламент | 2007.08.11 | 75,8% |
| 129 | Сингапур Парламент | 2011.05.07 | - |
| 130 | Словак Үндэсний зөвлөл | 2010.06.12 | 58,84% |
| 131 | Словени 1.Үндэсний зөвлөл 2.Үндэсний Ассамблей | 2007.11.21 2008.09.21 | - 63,1% |
| 132 | Соломоны арлууд Үндэсний парламент | 2010.08.04 | - |
| 133 | Сомали Холбооны шилжилтийн парламент | 2004.08.20 | - |
| 134 | ӨАБНУ 1.Провинцуудын үндэсний зөвлөл 2.Үндэсний Ассамблей | 2009.04.22 2009.04.22 | - 77,3% |
| 135 | Испани 1.Сенат 2.Депутатуудын конгресс | 2008.03.09 2008.03.09 | 76,03% 75,32% |
| 136 | Шри Ланка Парламент | 2010.04.08, 20 | 61,26% |
| 137 | Судан 1.Төрийн зөвлөл 2.Үндэсний Ассамблей | 2010.05.24 2010.04.11 | - - |
| 138 | Суринам Үндэсний Ассамблей | 2010.05.25 | 73,21% |
| 139 | Свазиланд 1.Сенат 2.Ассамблейн танхим | 2008.10.10 2008.09.19 | - - |
| 140 | Швед Риксдаг | 2010.09.19 | 84,63% |
| 141 | Швейцар 1.Холбооны зөвлөл 2.Үндэсний Зөвлөл | 2007.10.21 2007.10.21 | 48,28% 48,28% |
| 142 | Сири Ардын Ассамблей | 2007.04.22 | 56% |

| | | | |
|-----|--|--------------------------|------------------|
| 143 | Тажикистан 1.Үндэсний Ассамблей 2.Төлөөлөгчдийн танхим | 2010.03.25 2010.02.28 | - 90,84% |
| 144 | Тайланд 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2008.03.02 2007.12.23 | 55,62% 74,45% |
| 145 | Македони Собрание | 2008.06.01 | 57,06% |
| 146 | Тимон Лесте Үндэсний парламент | 2007.06.30 | 80,54% |
| 147 | Того Үндэсний Ассамблей | 2007.10.14 | 84,92% |
| 148 | Тонга Хууль тогтоох Ассамблей | 2010.11.25 | 90,85% |
| 149 | Тринидад ба Тобаго 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2010.06.18 2010.05.24 | - 69,45% |
| 150 | Турк Үндэсний их Ассамблей | 2007.07.22 | 84,16% |
| 151 | Туркменистан Ассамблей | 2008.12.14 | 93,87% |
| 152 | Тувалу Парламент | 2010.09.16 | - |
| 153 | Уганда Парламент | 2011.02.18 | 59,29% |
| 154 | Украин Дээд Рада | 2007.09.30 | 62,02% |
| 155 | Арабын Нэгдсэн Эмират Холбооны Үндэсний Зөвлөл | 2006.12.16 | - |
| 156 | Их Британи 1.Лордуудын танхим 2.Нийтийн Танхим | - 2010.05.06 | - 65,1% |
| 157 | Танзани Үндэсний Ассамблей | 2010.10.31 | 43% |
| 158 | АНУ 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2010.11.02 2010.11.02 | - - |
| 159 | Уругвай 1.Сенат 2.Төлөөлөгчдийн танхим | 2009.10.25 2009.10.25 | 89,91% 89,91% |
| 160 | Узбекистан 1.Сенат 2.Хууль тогтоох танхим | 2010.01.10 2010.01.10 | - 87,76% |
| 161 | Вануату Парламент | 2008.09.02 | 70,38% |
| 162 | Венесуэл Үндэсний Ассамблей | 2010.09.26 | 66,45% |
| 163 | Вьетнам Үндэсний Ассамблей | 2007.05.20 | 99,64% |

| | | | |
|-----|---|--------------------------|-------------|
| 164 | Йемен 1.Зөвлөлдөх зөвлөл 2.Төлөөлөгчдийн танхим | 2001.04.28 2003.04.27 | - 75,98% |
| 165 | Замби Үндэсний Ассамблей | 2006.09.28 | 70,56% |
| 166 | Зимбабве 1.Сенат 2.Ассамблейн танхим | 2008.03.29 2008.03.29 | - - |

| | | | |
|-----|---|--|-----------------|
| 168 | Афганистан -Төлөөлөгчдийн танхим - Удирдагчдын танхим | 2010,09,18 2011,01,22 | 45,0 - |
| 169 | Албани - Албаны парламент | 2009,06,28 | 50,77 |
| 170 | Алжир - Үндэсний ардын ассамблей - Үндэстний зөвлөл | 2007,05,17 2009,12,29 | 35,51 96,12 |
| 171 | Андорра - Ерөнхий зөвлөл | 2011,04,03 | 74,12 |
| 172 | Ангола - Үндэсний ассамблей | 2008,09,05 2008,09,06 | 87,36 |
| 173 | Антигуа- Барбуда - Төлөөлөгчдийн танхим - Сенат | 2009,03,12 2009,04,27 | 80,27 - |
| 174 | Аргентин - Депутатуудын танхим - Сенат | 2009,06,28 2009,06,28 | 74,36 72,39 |
| 175 | Армени - Үндэсний ассамблей | 2007,05,12 | 59,99 |
| 176 | Австрали - Төлөөлөгчдийн танхим - Сенат | 2010,08,11 2010,08,21 | 90,0 90,0 |
| 177 | Австри - Үндэсний зөвлөл - Холбооны зөвлөл | 2008,09,28 Мэдээлэл байхгүй | 78,81 |
| 178 | Азербайжан - Үндэсний ассамблей | 2010,11,07 | 50,14 |
| 179 | Бахам - Хурлын танхим - Сенат | 2007,05,02 2007,02,02 | 91,38 - |
| 180 | Бахрайн - Төлөөлөгчдийн зөвлөл - Шура зөвлөл | 2010,10,23 2010,10,30 2010,11,24 | 67,0 - |
| 181 | Бангладеш - Парламент | 2008,12,29 | 87,13 |
| 182 | Барбадос - Хурлын танхим - Сенат | 2008,01,15 2008,02,12 | 63,54 - |
| 183 | Беларус - Төлөөлөгчдийн танхим - Төрийн зөвлөл | 2008,09,28 2008,07,14 2008,10,14 | 76,74 - - |

| | | | |
|-----|---|--------------------------|---------------------|
| 184 | Бельги - Төлөөлөгчдийн танхим - Сенат | 2010,06,13 2010,06,13 | 89,92 89,21 |
| 185 | Белиз - Төлөөлөгчдийн танхим - Сенат | 2008,02,07 2008,03,14 | 74,49 - |
| 186 | Бенин - Үндэсний ассамблей | 2011,04,30 | Мэдээлэл байхгүй |



(Footnotes)

1. Electoral code of the Republic of Armenia, section 5, chapter 19, article 95
2. Electoral code of the Republic of Armenia, section 5, chapter 23, article 115.2
3. Electoral code of the Republic of Armenia, section 5, chapter 19, article 96
4. АНУ-ын Конгрессын Доод танхимд сонгогдох гишүүдийн тоо тухайн муж улсын хүн амын тооноос хамаардаг.



ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АСУУДЛААР ӨДӨР ТУТМЫН ХЭВЛЭЛҮҮДИЙН НИЙТЛЭЛД ХИЙСЭН КОНТЕНТ-АНАЛИЗ

(Лавлагаа мэдээлэл, 1999 - 2011.03)

*Ж. Алтанцэцэг, Б. Ариунжаргал, Ө. Мөнхтунгалаг, Б. Мөнхцэцэг,
Т. Мягмаржав, Р. Нургуль, М. Оюунтулга, Ц. Янжинцэрэн*

Хэвлэлийн нийтлэл, мэдээлэлд тусгагдсан асуудлууд

Судалгаанд өдөр тутмын хэвлэл 8 сонинг сонгон авч Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн 8 судлаач шинжээчид 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Нургуль “Үнэн”, “Монголын үнэн”, 1999.01-2011.03
2. Ц.Янжинцэрэн “Зууны мэдээ”, 1999.01-2011.03
3. Б.Мөнхцэцэг “Зууны шуудан”, “Үндэсний шуудан”, 2007.01-2011.02
4. Ж.Алтанцэцэг, Ө.Мөнтунгалаг, “Өдрийн сонин”, 1999.01-2011.03
5. М.Оюунтулга, Б.Ариунжаргал, “Өнөөдөр”, 1999.01-2011.03
6. Т.Мягмаржав “Нийгмийн толь”, “Ардчилал”
7. Б.Ариунжаргал “Ардын эрх” 2005-2011.03 сонины нийтлэлд, мэдээллийг уншиж боловсруулалт хийсэн бөгөөд нэгтгэлийг судлаач Б.Мөнхцэцэг хийж гүйцэтгэв.

Энэ судалгаанд хамрагдсан бүх сонинд **448** материал нийтлэгдснээс Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн санал шүүмжлэл **154 буюу 34,3%**, 2000 оны нэмэлт өөрчлөлт оруулахыг буруу гэсэн санал шүүмжлэл **183 буюу 40,8%**, Үндсэн хуулийг шинээр дахин бичих нь зүйтэй гэсэн санал шүүмжлэл **6 буюу 1,5%**, бусад санал шүүмжлэл, мэдээлэл **105 буюу 23,4%** нийтлэгджээ. Эдгээр нийтлэлийг сонин тус бүрээр гаргавал

| № | Сонины нэр | Нийт | Нэмэлт, өөрчлөлт оруулах нь зөв | 2000 оны 7 нэмэлт, өөрчлөлт оруулах нь буруу | Шинээр бичих ёстой | Бусад санал шүүмжлэл |
|-----|-----------------------|-------------|---------------------------------|--|--------------------|----------------------|
| 1. | Үнэн, Монголын үнэн | 58 | 23 | 14 | 0 | 21 |
| 2. | Зууны мэдээ | 94 | 21 | 32 | 3 | 38 |
| 3. | Зууны, ндэсний шуудан | 40 | 17 | 8 | 3 | 12 |
| 4. | Өдрийн сонин | 54 | 20 | 25 | 0 | 9 |
| 5. | Өнөөдөр | 156 | 36 | 102 | 0 | 18 |
| 6. | Нийгмийн толь | 6 | 6 | 0 | 0 | 0 |
| 7. | Ардын эрх | 17 | 10 | 2 | 0 | 5 |
| 8. | Ардчилал | 23 | 21 | 0 | 0 | 2 |
| 9. | Бүгд | 448 | 154 | 183 | 6 | 105 |
| 10. | Хувь | 100% | 34,3% | 40,8% | 1,5% | 23,4% |

2000 онд Үндсэн хуульд оруулсан 7 өөрчлөлтийг шүүмжилж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь буруу гэсэн нийтлэлүүд Өнөөдөр сонинд 102 буюу 55,7%, Зуун мэдээ сонинд 32 буюу 17,4%, Өдрийн сонин 25 буюу 13,6% нь тус тус нийтлэгджээ. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зөв гэсэн нийтлэл Үнэн сонинд 23 буюу 17,8%, Зууны

мэдээ сонинд 21 буюу 16,2%, Ардчилал сонинд 21 буюу 16,2% нь 2000 онд Үндсэн хуульд оруулсан 7 өөрчлөлтийг дэмжиж тус тус нийтлэгдсэн байна.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан талаархи санал, шүүмжлэлийн тоон хүснэгт

| № | 2000 оны өөрчлөлт | Сонины нэр | | | | | | | | |
|----|---|------------|-------------|-----------------|--------------|---------|---------------|-----------|----------|------|
| | | Үнэн | Зууны мэдээ | Үндэсний шуудан | Өдрийн сонин | Өнөөдөр | Нийгмийн толь | Ардын эрх | Ардчилал | Нийт |
| 1. | Үндсэн хуулийн гуравдугаар бүлэг 22-р зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана. | 3 | 5 | - | 1 | 1 | 1 | - | - | 11 |
| 2. | Үндсэн хуулийн 24-р зүйлийн 1 дэх хэсэг Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно. | 3 | 5 | 1 | - | - | 1 | - | 1 | 11 |
| 3. | Үндсэн хуулийн 27-р зүйлийн 2 дахь хэсэг Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна. | 4 | - | - | - | 2 | - | - | - | 6 |



| | | | | | | | | | |
|--|---|----|---|---|---|---|---|---|----|
| <p>4. Үндсэн хуулийн 27-р зүйлийн 6 дахь хэсэг</p> <p>Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ.</p> | 7 | 5 | - | - | - | 1 | - | - | 13 |
| <p>5. Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэг</p> <p>Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.</p> | 6 | 5 | 2 | 3 | 2 | 1 | 3 | 2 | 24 |
| <p>6. Үндсэн хуулийн гуравдугаар бүлэг 33 зүйлийн 1 -ийн 1 дэх хэсэг</p> <p>Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.</p> | 4 | 5 | - | 1 | 1 | - | - | - | 11 |
| <p>7. Үндсэн хуулийн 39-р зүйлийн 2 дахь хэсэг</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p> | 1 | 15 | - | - | - | - | - | - | 16 |
| <p>8. Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг 57-р зүйл, 1 дэх хэсэг</p> <p>Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.</p> | 3 | 3 | 3 | - | - | - | - | - | 9 |

| | | | | | | | | | | |
|-----|--|----|----|----|----|-----|---|----|---|-----|
| 9. | Үндсэн хуулийн нэгдүгээр бүлэг 5-р зүйлийн 5 дахь хэсэг , Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтанд байна. | 1 | 2 | 2 | - | - | - | 2 | - | 7 |
| 10. | Үндсэн хуулийн зургадугаар бүлэг 68-р зүйлийн 1 дэх хэсэг , Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. | - | - | 4 | 1 | - | - | 4 | 6 | 15 |
| 11. | Өөрчлөлт оруулах шаардлагатай | 32 | 45 | 12 | 6 | 6 | 4 | 9 | 9 | 123 |
| 12. | Өөрчлөх шаардлагагүй | 14 | 18 | 8 | 29 | 102 | - | 2 | - | 173 |
| 13. | Бусад | 17 | 6 | 9 | 25 | 28 | - | 3 | - | 88 |
| | Бүгд | 63 | 69 | 29 | 60 | 136 | 4 | 14 | 9 | 384 |

* * *

НЭГ: Үндсэн хуульд оруулсан 2000 оны нэмэлт, өөрчлөлтүүдтэй холбоотой гарсан санал шүүмжлэл

1. Үндсэн хуулийн гуравдугаар бүлэг 22-р зүйлийн 2 дахь хэсэг: Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана.

Шүүмжилсэн асуудал:

- Үндсэн хуульд заасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Үндсэн бүрэн эрх”-ийн заримыг хасч, цаашлан засаглал эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн агуулгыг өөрчилж, үүрэг хариуцлагын заагтай, харилцан хамааралтай, хяналттай байх зарчмыг зөрчиж байна.
- Ялсан нам, хүчин Ерөнхий сайдыг томилохдоо Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөх тухай заалт тодорхой бус байсныг Ц.Элбэгдорж овжноор ашиглаж, цаг хожиж 3 сар Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж төрийг улам хямруулсан билээ.
- Монгол Улс Парламентын Бүгд Найрамдах Улс учраас Ерөнхий сайдыг томилоход Ерөнхийлөгч голлох үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээхгүй.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Юуны өмнө хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын ялгааг сэргээж өгөх хэрэгтэй.
- ✓ Төрийн тогтолцоог боловсронгуй болгох.
- ✓ Ерөнхий сайдаа томилж чадахгүй бол УИХ өөрөө тарах шийдвэр гаргах ёстой гэсэн зарчмыг Үндсэн хуулинд оруулсан нь хүлээх хариуцлагыг тодорхой болгох юм.

2. Үндсэн хуулийн 24-р зүйлийн 1 дэх хэсэг : ” УИХ-ын дарга дэд даргыг УИХ-ын

Судалгааны эмхтгэл, X боть

гишүүд дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно”.

Шүүмжилсэн асуудал:

- Гишүүд саналаа чөлөөтэй /хараат бусаар/ гаргах эрхийг хаасан
- Намын шууд хяналт буюу нүдлэн хамгаалалт тогтоосон
- Даргын тоо нэмсний дээр бүлэггүй гишүүний сонгогдох эрхийг хассан гэж үздэг.
- Хамгийн буруу замд нууц санал хураалт оруулдаг. Санал хураалт ил байхгүй бол янз бүрийн хувийн тоглолт, бүлэглэлүүд бий болдог. Нууц санал хураалтыг далимдуулан нөгөө намтай хамтарч Засгийн газраа огцруулах зүйлд их гарч байсан.
- Улсын Их Хурлын гишүүн хэдийгээр улс төрийн намаас нэр дэвшиж, сонгуульд оролцдог боловч сонгогдсоныхоо дараа ард түмний элч болдог учир тэдний хараат бус байдлыг алдагдуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь хяналт тавих, намын бодлогыг Үндсэн хуульд оруулж болохгүй.
- Улсын Их Хурлын гишүүдийн хэн нь ямар санал өгөхийг хянах боломжийг Үндсэн хуулиар нээж өгөх нь ардчилсан нийгмийн үндсэн зарчимд нийцэхгүй байна.
- Санал хураалт далд байх нь үзэл бодлоо хэний ч дарамт шахалтгүйгээр чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх нь ардчиллын баталгаа. Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн илээр санал хурааж сонгодог болсноор Парламент идээ бээрийг шахах механизмгүй болж байгаа юм.
- Улсын Их Хурлын гишүүдийн заримых нь Улсын Их Хурлын дэд даргаар сонгогдох эрхийг хязгаарласан энэ заалт нь хүний аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагын гишүүний нь хувьд ялган гадуурхахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн 10 хэсгийн заалттай нийцэхгүй байна.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно.
- ✓ Тоо нэмэхэд биш дээд даргыг цөөнхөөс сонгох жишиг ердийн хуулиар тогтоосон хэрэглэж болох байв.
- ✓ Улсын Их Хурлын гишүүний уг эрх нь хасагдаж, зөвхөн нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх болж байна.

3. Үндсэн хуулийн 27-р зүйлийн 2 дахь хэсэг: “Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа 50-иас доошгүй ажлын өдөр чуулна.”

Шүүмжилсэн асуудал:

- Улсын Их Хурал хууль тогтоох байнгын байгууллага байх нэг шалгуурыг үгүйсгэсэн.
- Үлдсэн хоногт юу хийх вэ? /Байнгын хороод хуралдах уу, Томилолтоор явцгаах уу/
- Байнгын ажиллагаатай парламентад Чуулган гол хэлбэр мөнийг харгалзаагүй.
- Улсын Их Хуралд байнга сууж, хууль тогтоох гишүүний үүрэг багасаж ачаагаа хөнгөлсөн.
- Байнгын Парламентын гол хэлбэр нь чуулган. Гадаадын бусад оронд ч Парламент нь жилд 30-40 хоног завсарлаад бусад үед нь байнгын бэлэн

байдалд ажилладаг. Гэтэл манайд жилд 100 хоног ажиллаад бусад үед нь Улсын Их Хурлын гишүүд хаана яваа нь мэдэгдэхгүй, сураг тасардаг.

- Ирц бүрдэх хувь, асуудал шийдэгдсэн гэж үзэх хувь, чуулах хугацаа, нууц санал хураалт зэрэг Улсын Их Хурлын хамт олны хүч, боломжийг аль болохуйцаар түлхүү дайчлах хугацааны, ирцийн, саналын нөөцийг чингэж бууруулах нь Улсын Их Хурлын гишүүн бол нийт иргэн улсын ашиг сонирхолыг эрхэмлэн баримтална гэсэн заалтад харшилж байна.
- Улсын Их Хурлын чуулганы болон байнгын хорооны хуралдааны ирцийн хувийг бууруулсан нь буруу.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааны хүчинтэй байх ирцийн хувийг ердийн олонхи болгох
- ✓ 20-хон гишүүний саналаар хууль баталж болохоор хэт хялбарчилж байгаа нь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгож байна гэж үзэх үндэслэлгүй юм.

4. Үндсэн хуулийн 27-р зүйлийн 6 дахь хэсэг "Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ"

Шүүмжилсэн асуудал:

- Гишүүд чуулгандаа ирэх нь ховордсонтой холбоотой өөрчлөлт $39 : 2 = 19.5/20/$
- Чуулган хүчин төгөлдөр байх шаардлага илт суларсан.
- Асуудал шийдэхэд олонхийн зарчим алдагдсан, төлөөллийн үүрэг ач холбогдлыг багасгасан.
- Саналаа чөлөөтэй гаргах боломж хаагдсан /багасгасан/
- Намын хяналт ноёлох байранд гарав. Энэ өөрчлөлт нь мөн чанартаа хурлын ирц нь бүрддэггүй, гишүүдээ цуглуулж чаддаггүй, сахилга, зохион байгуулалтгүй парламентад зориулж хийгдсэн өөрчлөлт. Ингэснээр Улсын Их Хурлын чуулганд 76 гишүүний 39 нь хүрэлцэн ирснээр хурал хүчинтэй болж 20 гишүүний саналаар хууль батлагдаж байх болох нь.
- Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах гэсэн ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах чухал заалтыг мөн орхигдуулжээ. Энэ нь төрийн дээд өндөрлөгүүдийн харилцан хяналт тавих бүтэн системийн чухал нэгэн гинжийг тасдаж, төрийн машинд тавих шаардлага хяналтын мөрөөр авах арга хэмжээг үгүйсгэсэн байна.
- Нууцаар санал хураахад гишүүд намын удирдлагын саналыг дэмжихгүй байгаа бол энэ нь мөнхүү намын өөрийн нь дотоод амьдралын асуудал, согог болохоос биш Үндсэн хууль дахь дутагдал, асуудал биш билээ.
- Гишүүд байнгын хорооны хуралдаан дээр саналаа ил хураалгадаг. Гэтэл нэгдсэн хуралдаан дээр нууцаар санал өгөөд асуудлыг унагаж байна. Энэ их зөрүүтэй.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Тулгуур хуулийн үзэл баримтлал ба үндсэн бүдүүвчийн гол чухал санаа, шүтэлцээг ингэж өрөөсгөлөөр өөрчилж болохгүй.
- ✓ Сөрөг хүчин оролцохгүй, харин олонхи шийдвэрээ гаргаад хэрэгжүүлж, эцэстээ



Судалгааны эмхтгэл, Х боть

- хариуцлага хүлээх бололцоо олгох хэрэгтэй юм.
- ✓ Энэ өөрчлөлт нь Улсын Их Хуралд олонхийн суудал авсан нам бодлогоо хараат бусаар явуулах боломжийг мөн олгож байна.
- ✓ Улсын Их Хуралд хэлэлцэгдэж буй аливаа асуудлаар саналаа илээр гаргаж шийдвэрлэх нь ил тод байдлыг нэвтрүүлэх, сонгосон гишүүд нь ямар асуудлаар ямар байр суурь баримталсныг мэдэх сонгогчдын эрхийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
- ✓ Марксист сэтгэлгээний эмгэгээр монголчилсон төрийн удридлагын парламентын хэлбэрийг сонгодог төрхөөр нь дахин байгуулах.

5. Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэг Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

Шүүмжилсэн асуудал:

- “Улсын Их Хурлын гишүүн Засгийн Газрын гишүүн давхар нэгэн зэрэг байх нь эрх мэдлийн хуваарилалтанд нийцээгүй .
- Засгийн газрын бүрэлдэхүүнд орох Улсын Их Хурлын гишүүдийн тоо, хэмжээ хязгаарыг тогтоож өгөөгүй учраас бүх сайдууд нь Улсын Их Хурлын гишүүн байх тохиолдол ч гарч байсан.
- Парламент, Засгийн газар тусдаа байх ёстой. Учир нь одоо бид төрийн эрх мэдэл хуваарилах зарчим баримталж байгаа.
- Засгийн газрын үйл ажиллагааг Улсын Их Хурлын зүгээс хянах, түүнд хатуу шаардлага тавих, алдаа оноог нь илчилж зэмлэх, сайшаах, авилга, мафи, сөрөг үр дагвар авчрах, лобби зэргээс сэргийлэх, хууль тогтоох засаглалыг гүйцэтгэх засаглалаас зааглаж биеэ даасан байдлыг нь бэхжүүлэх зэрэг, зорилго, бодлогын үүднээс Улсын Их Хурлын гишүүн хүн Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэх нь зохистой, ашигтай биш.
- Засгийн газарт хяналт тавих Улсын Их Хурлын үүрэг бүдгэрч хэн нь хууль тогтоогч, хэрэгжүүлэгч гэдгээ ч мэдэхээ байсан.
- Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн болсноор гүйцэтгэх засаглалын Улсын Их Хуралд тайлагнах зарчим алдагдсан. Тайлагнана гэдэг нь эрх зүйн шинжлэх ухаанд хариуцлагын 1 хэлбэр болдог. Үр дагавар нь өнөөг хүртэл арилахгүй байна.
- Үндсэн хуулийн нэг гол үзэл баримтлалыг хөсөрдүүлэн “халдварын голомт” үүсгэв.
- Хууль тогтоогчдод гүйцэтгэх засаглал, хөрөнгө мөнгөтэй хутгалдах боломжийг олгож, парламентын хяналтыг сулруулсан.
- Эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулж, парламентыг гүйцэтгэх эрх мэдэл нь давамгайлж байсан хуучин тогтолцоо сэргэсэн.
- Хүмүүс үүнийг нэг талаар нэг том юмны ард нуугдаж буй намуудын хуйвалдаан, нөгөө талаар албан тушаалын амбицад хөтлөгдөж байна гэж үзэж байна. Үүнийг Үндсэн хуульд суулгахын цаад санаа нь Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрт хаалт тавих л явдал байх.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Засгийн газрын бүрэлдэхүүнд орох Улсын Их Хурлын гишүүдийн тоог сайд нарын 3/1-ээр хязгаарлах.

- ✓ Хэрэв заавал хавсаргах бодлого баримталж байгаа бол хууль тогтоогч Үндсэн хуульдаа дараах хязгаарлалтыг хийх хувилбарууд байж болохоор байна.
- ✓ Зөвхөн Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн байж болохоор
- ✓ Ерөнхий сайд, Засгийн Газрын гишүүдийн гуравны нэг хүртэл хувь нь Улсын Их Хурлын гишүүн байж болохоор гэх мэт тодорхой хязгаарлалтыг салбар хуулиар тогтоох боломжгүй тул аль зохимжтойг нь Үндсэн хуульдаа суулгаж өгөх ёстой.
- ✓ Засгийн газрыг 100 хувь парламентын гаднаас бүрдүүлэх нь гүйцэтгэх засаглалд тогтворгүй байдал үүсгэж, улс төрийн намууд ч бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлэх чадамжгүй болдог. Иймээс тодорхой хязгаартай байх.
- ✓ Төрийн тогтолцоог боловсронгуй болгох нь зүйтэй.
- ✓ Нэг нь нөгөөгөөсөө тодорхой хамааралтай байх ёстой. Тэгж байж засаглал гэдгийг бүрэлдүүлнэ. Засаглалын хяналт тэнцлийн ийм тогтолцоо байхыг үгүйсгэж болохгүй юм.

6. Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэг: Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах

Шүүмжилсэн асуудал:

- Төрийн алба улс төржиж намчирхсан тул мэргэжлийн карьерийн болон улстөрийн албан тушаалын зарчмын ялгаа алдагдсаж төрийн албан тушаал арилжаа наймааны хэрэгсэл болсон байна.
- “Түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах” гэсэн заалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхээс хассан байна. Монгол Улсын Үндсэн хууль хэрэгжсэнээс хойш өнөө болтол огт хэрэгжүүлээгүй энэ заалтыг Монгол Улсын хэд дэх Ерөнхийлөгч хэний Засгийн газрын үед хэрэгжүүлэхээс болгоомжилж одоо Үндсэн хуулиас хасаж байгаа нь ойлгомжгүй байна. Засгийн газрыг огцруулах эсэх эцсийн шийдвэрийг Парламент өөрөө гаргаж байгаа манай орны нөхцөлд уг заалтыг Үндсэн хуулиас яаравчлан хасах шаардлагагүй гэж үзэж байна.
- Зөв хүнээ Ерөнхий сайдаар томилж чадаагүй, үүнээс болж бодлого хэрэгжээгүй гэсэн тайлбар хийх боломжийг эрх баригчдад олгож байсан сургамжийг ч харгалзан үзэх үндэстэй.
- Субъект эсрэгээрээ солигдсон.
- Ерөнхийлөгч Хууль санаачлах эрхийг хасаж нам эдлэх болсон Ерөнхийлөгчийн хийдэг ажил, хийгддэг асуудлыг намтай урьдчилан зөвшилцөн зарчмыг гуйвуулан эргүүлж зөвхөн намуудын хүсэл зориг болгосноор болзошгүй хуйвалдаан гарч, бүлгийн сонирхлыг төрийн тэргүүнд тулгах суваг нээгдэв.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Төрийн албыг намчирхах явдлаас үүрд ангижруулах нь хойшлуулшгүй арга хэмжээ билээ.
- ✓ Ард олны сонголтоор гарч ирээгүй хүнийг улс төрийн ямарваа нэгэн албан тушаалд томилж болохгүй.
- ✓ Төр ба улстөрийн намын харилцааг Үндсэн хуульдаа оновчтой тусгах хэрэгтэй. Улмаар улстөрийн намын хуульд өөрчлөлт оруулах ёстой.

Судалгааны эмхтгэл, Х боть

- ✓ Парламентийн засаглалын мөн чанар болсон Сонгуулийн үр дүнд олонхи болсон нам гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаа бий болгохдоо нэр хүндтэй, чадварлаг, нөлөө бүхий хүмүүсээр бүрдүүлэх нь зүйтэй, үүнийг нам биш, намын удирдлага биш чухамхүү сонгогчид л шийдэх.
- ✓ Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс авч үзвэл парламентын засаглалтай улсад хууль тогтоох байгууллагад олонхи болсон улс төрийн хүчин нь Засгийн газраа байгуулдаг учраас Ерөнхий сайдад хэнийг нэр дэвшүүлэхээ шийдэх бүрэн эрх нь олонхи болсон улс төрийн хүчинд хадгалагдах ёстой.

Үндсэн хуулийн зургадугаар бүлэг 68-р зүйлийн 1 дэх хэсэг: “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно”

Шүүмжилсэн асуудал:

- Үндсэн хуулийг тийм цаг үед өөрчилнө гэсэн жор байдаггүй. Хамгийн наад зах нь одоогийн зохицуулж буй Үндсэн хуулийн эерэг, сөрөг талыг баттай олж харсан тэр нөхцөлд л хуулийг өөрчлөх учиртай.
- Үндсэн хуулиар хамаа бусаар оролдоно гэдэг улсаараа жонглёрдоно гэсэн үг. Нэг үгээр хэлбэл туйлын болгоомжтой хандах ёстой.
- Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1-д “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачлагыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Хуулинд “мэдүүлж болно” гэсэн болохоос яг таг мэдүүлнэ гэж заагаагүй.
- Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хууль гаргах хэрэгтэй. Хэрхэн өөрчлөх вэ, ямар бүрэлдэхүүнтэй байх, ард түмний санал асуулгаар ямар асуудлыг шийдэх вэ гэдгийг тодруулсан байх ёстой.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Үндсэн хуулийн институтууд, парламентад суудалтай намууд Үндсэн хуульдаа оруулах өөрчлөлтийнхөө асуудлаар нэгдмэл саналтай байх нь чухал”
- ✓ Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг бүх ард түмний хэлэлцүүлгийн үндсэн дээр бодитой хандах
- ✓ Үндсэн хуулийг өөрчилнө гэхээсээ илүүгээр түүний зүйл заалтуудыг тодруулсан хуулиуддаа сайн боловсруулж нарийсгах, засан сайжруулах хэрэгтэй.
- ✓ 68.1-р заалтыг дэлгэрүүлж, нэмэлт тодотгол хийсэн органик хууль, албан ёсны тайлбар үгүй нөхцөлд ямарч зөрчил, дур зоргын асуудал алхам хийгдэж болох талтай ч энэ талаарх жишээ, туршлага болсон Францын Үндсэн Хуулийн Зөвлөлийн тогтсон жишиг бидний мөрдөх, дагах ёстой үзэл баримтлал, үлгэр дууриал байх учиртай.
- ✓ Үндсэн хуулийг хэлэлцэн баталсан Ардын Их Хурал сум, дүүрэг бүрийн төлөөлөлтэй байсан. Ийм бүрэлдэхүүнээр баталсан хуульд гар хүрэхдээ их бэлтгэлтэй, өөрөөр хэлбэл тусгай журмаар хэлэлцэх ёстой.
- ✓ Үндсэн хуулийг амьдруулдаг хууль нь Үндсэн хуулийн, процессын хуулиуд юм. Үүнийг яаралтай батлах хэрэгтэй.

Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг 57-р зүйл, 1 дэх хэсэг: Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

Шүүмжилсэн асуудал:

- Суурин соёл иргэншил рүү явж байгаа нь ойлгомжтой үед “хот” гэдэг ойлголтыг устгаад хаясан нь хамгийн буруу. Бор-Өндөр, Дархан-Уул эсвэл аймгийн төвүүдийг хотын статустай болгох.
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бие даасан эдийн засгийн цогц байх тухай заалт хэрэгжихгүй байна.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Хотын статусыг хуульд оруулж, нийслэл болоод орон нутгийн хотуудын эрхийг баталгаажуулах өөрчлөлт хийх хэрэгтэй.
- ✓ Одоогийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөх.
- ✓ Орон нутагт хотын статус өгч бие даан хөгжих боломжийг Үндсэн хуульдаа суулгаж өгөх.

Хоёр. Бусад шүүмжлэлтэй хандаж байгаа заалтууд буюу Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлууд**Шүүмжилсэн асуудал:**

- Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтанд байна” гэсэн заалт хувийн өмч болох “мал” төрийн хамгаалалтад орж “Өмчийг төрөл хэлбэрээр нь ялгаварлаж болохгүй” “гэсэн 16-р зүйлтэйгээ зөрчилдөж байгаа юм.
- Үндсэн хуульд байгаа сонгуулийн тогтолцоотой хэсгийг эргэж харах хэрэгтэй.
- Сонгууль бүрийн дараа сонгуулийн хууль болохгүй байна өөрчилье гээд өөрчлөхдөө сайжруулах бус улам муу болгоод байдаг.
- Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгоно гээд заасан болохоор пропорциональ системийг хааж байгаа юм гэж манай зарим хуульч ярьдаг Цэц ч тэгж үздэг.
- Улстөрчид Үндсэн хуулийн аливаа нэг эгзэгтэй асуудлыг зөвхөн өөрсдөдөө ашигтайгаар тайлбарлаж байна. Энэ байдлыг аль болох багасгах өөрчлөлт хийх хэрэгтэй.
- Парламентын засаглалтай атлаа ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгодог.....?
- Сонгуулиар бий болсон эвсэл задарвал яах вэ?
- Хамгийн гол авч хаясан үг, өгүүлбэр бол “Шаардлагатай гэсэн нөхцөлд Монгол Улсын Ерөнхийлөгч Засгийн газрыг огцруулах санал”-ыг УИХ-д оруулдаг байсан. Үүнийг үг дуугүй аваад хаячихсан.
- Нэмэлт өөрчлөлт хийх бол ард нийтийн өргөн хэлэлцүүлэг явуулахаас парламентын хэдэн гишүүнд ашигтайгаар засаж болохгүй.
- Үндсэн хуульд нууцаар халдсан.Тухайн үед Монголд 14 нам байхад зөвхөн гурван нам нь хуйвалдаад л ийм юм хийсэн.
- Шууд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал байхгүй, эхлээд 2000 оны нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгох хэрэгтэй. Ер нь Үндсэн Хуулийн алдаатай зүйлийг засч зөв гольдролд нь оруулах цаг болсон.
- Үндсэн Хуульд зарчмын олон алдаа бий. Зарчмын гэдэгт сонгуулийн тогтолцооноос эхлээд олон багц асуудал орох ёстой.
- 2000 оны өөрчлөлтийн хамгийн гол гай нь Үндсэн хуулийн төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг үгүйсгэсэнд оршино. Тэгээд л одоо Улсын Их Хурлын гишүүд нь гүйцэтгэх байгууллагын ажил хийгээд тэрбум тэрбум төгрөг тэвэрч зарцуулаад л явж байх жишээтэй. Засгийн газарт тавьдаг парламентын хяналт суларсан. Бусад орны олон зуун гишүүнтэй парламентад байдаг

жижигхэн үзэгдлийг цөөхөн гишүүнтэй Монголд том үзэгдэл болохыг анзааралгүй хэрэглэсэн буруутай. Жишээ нь, 2000-аад гишүүнтэй Английн парламентад 20 -хон сайд юу ч биш. Манай 76 гишүүнд 15 сайд байна гэдэг аймаар тоо.

Дэвшүүлсэн санал:

- ✓ Нэгдлийн мал хувьчлагдаж хувийн өмч болсон тул өмчийг ялгавар болохгүй учраас “Мал сүрэг үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгалалтанд байна” гэх заалтыг хасах нь зүйтэй.
- ✓ Сонгуулийн тогтолцоог үндсэн хуульд зааж өгч сонгуулийн хуулиар албан тушаалд хүрэх ашиг хонжоо олох гэсэн санаархлыг таслан зогсоох шаардлагатай.
- ✓ Улсын Их Хурал, Засгийн газар, нам гуравыг хольж, Улсын Их Хурлын гишүүд ачааллаа 1/3-ээр хөнгөлж, Ерөнхийлөгчийн эрхийг ёс бусаар хязгаарласан 2000 оны өөрчлөлтөө цуцалж Үндсэн хуулийн уг эхийг сэргээх.
- ✓ Тодорхой журмаар хэн, ямар эрх, ямар хүрээнд эдлэх, процедур, өргөн барих, Улсын Их Хурал хэрхэн хэлэлцэх зэргийг хуульчлах шаардлагатай
- ✓ Үндсэн хуулийг өөрчлөхийн тулд маш олон мэргэжлийн байгууллагын санал авах шаардлагатай.
- ✓ Үндсэн хуульд өөрчлөлт оруулах процесс нийгмийн зөвшилцөл дээр явах ёстой.
- ✓ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал ч, орон нутгийн гэх он дамжсан нүсэр сонгууль хийхийн оронд Ерөнхийлөгчөө парламент дотроосоо сонгодог болох
- ✓ Санал асуулгыг ард нийтийн дунд Үндсэн хуулийг өөрчлөх буюу Засгийн газрын гишүүдийн 3/1 нь Улсын Их Хурлын гишүүн байх нь зөв үү? Буруу юу? гэж явуулаад нэг талаас иргэдээ бүртгэх нөгөө талаас санал тоолох машинаа ч турших нэг боломж юм.
- ✓ Нэмэлт өөрчлөтийг /2000 оны/ хүчингүй болгох ёстой. Үндсэн хуулийг ард түмний санал асуулгаар баталдаг.
- ✓ Үндсэн хуулийг шинээр бичих хэрэгтэй.
- ✓ Ном журмын дагуу, хийгээд 2000 онд хийсэн хууль бус зүйлээ нэн даруй цуцлах ёстой гэж бодож байна.
- ✓ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа чухам ямар тодорхой журмыг баримтлах, энэ асуудлыг ил тод байлгах, ард нийтийн санал асуулга авах эсэх, түүнчлэн Үндсэн хуулийн Цэц санал дүгнэлт хэрхэн гаргах зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай.
- ✓ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй гэж муйхарлан зүтгэж байгаа юмгүй. Итали зэрэг оронд парламент Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар болбол тэр парламент биш, шинээр сонгогдсон дараагийн парламент уг нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж баталдаг хуультай байдаг. Өөрөөр хэлбэл, “өөрчлөх” гэж хорхойссон хүмүүсээр биш ашиг сонирхлын зөрчилгүй бүрэлдэхүүнээр шийдвэрлүүлдэг
- ✓ Үндсэн хуулийг амьдруулдаг хууль нь Үндсэн хуулийн **процессын хуулиуд** юм. Ялангуяа манайх шиг дураараа хадуурдаг, зоргоороо хууль томъёолдог, хувийнхаа бодлыг хуульд оруулчих хүсэлтэй хүмүүст ийм эрхийг хэмжээ хязгааргүй олгож болохгүй.
- ✓ Үндсэн хуулийг өөрчилнө гэхээсээ илүүгээр түүний зүйл заалтуудыг тодруулсан хуулиуддаа сайн боловсруулж нарийсгах, засан сайжруулах хэрэгтэй.

Судалгааны арга зүй

Судалгааг хэвлэлийн нийтлэлийн агуулгын задлан шинжлэл буюу контент - анализын аргаар хийлээ. Задлан шинжилгээг хийхдээ тухайн нийтлэлийн үнэн худал, эерэг сөрөг агуулгыг тодорхойлох бус судалгааны удирдамжинд заасны дагуу Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь шаардлагатай, шаардлагагүйн талаарх шүүмжилсэн асуудал, үндэслэл, дэвшүүлсэн санал, зөвлөмж зэргийг тоон мэдээллээр гаргаж, сонин бүрт олон дахин давхардсан гол шүүмжлэл, санал зөвлөмжийг агуулгаар нь тусгаж нэгтгэсэн болно.

Нэгдсэн дүгнэлт

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг агуулгын хувьд зохистой эсэх, өөрчлөлт хийсэн арга нь зөв эсэх гэсэн 2 асуудлаар иргэд ихэвчлэн саналаа илэрхийлсэн байна.

Дүгнэлт-1

Үндсэн хуулийн агуулгын хувьд дараах зүйл, заалтуудыг онцлон шүүмжилж санал бодлоо илэрхийлсэн байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн 22-р дугаар зүйлийн 2 дахь хэсэг
2. Үндсэн хуулийн 24-р зүйлийн 1 дэх хэсэг
3. Үндсэн хуулийн 27-р зүйлийн 2 дахь хэсэг
4. Үндсэн хуулийн 27-р зүйлийн 6 дахь хэсэг
5. Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэг
6. Үндсэн хуулийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 2
7. Үндсэн хуулийн 39-р зүйлийн 2 дахь хэсэг
8. Үндсэн хуулийн 5-р дугаар зүйлийн 5 дахь хэсэг
9. Үндсэн хуулийн 57-р зүйл, 1,3 дах хэсэг
10. Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг /Хүний эрх, эрх чөлөө/
11. Үндсэн хуулийн 68-р зүйл 1 дэх хэсэг

Эдгээрээс эхний 7 нь 2000 оны нэмэлт, өөрчлөлт оруулах үед дараахь зөрчил, дутагдал гарсан болохыг хамгийн их давтамжтай шүүмжилсэн байна.

Дүгнэлт-2

2000 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг хийсэн аргын хувьд дараах асуудлууд хамгийн их шүүмжлэгдэж, олон дахин давтагдсан байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг парламентад суудалтай намууд хуйвалдааны аргаар хийсэн.
2. Ард түмний саналыг аваагүй.
3. Парламентад суудалгүй намуудаас санал аваагүй.
4. Ул суурьтай судалгаа хийгээгүй, богино хугацаанд батлагдсан.
5. Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчим алдагдсан.
6. Процедурын алдаатай.
7. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг нэг нам дангаараа оруулсан.
8. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай тусгайлан хууль гаргах хэрэгтэй.

Иргэдийн нэг хэсэг нь Үндсэн хуулийг цаг үеэ дагаж өөрчлөгдөх ёстой, энэ нь амьдралын



Судалгааны эмхтгэл, Х боть

шаардлага хэмээн үзэж байхад нөгөө хэсэг нь Үндсэн хуулинд хэн дуртай нь хууль санаачилж өөрчлөлт оруулах ёсгүй хэмээн үзэж байна.

* * *

ХАВСРАЛТ 1 - ҮНЭН, МОНГОЛЫН ҮНЭН /1999-2011/


Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

| № | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал, эх сурвалж |
|---|---|--|---|
| 1 | <p>Үндсэн хуулийн 22-р дугаар зүйлийн 2 дахь хэсэг Нийт 3</p> | <p>1.МАХН-ын дарга Н.Энхбаяр: Ард түмний захиалгаар энэхүү нэмэлт өөрчлөлтийг санал болгож байгаа Үнэн /одоо Монголын үнэн/, 1999.12.24, №166 Монгол Улс Ерөнхий сайдаа томилж чадахгүй 7 сар болж дэлхийг гайхуулсан. Ерөнхий сайдаа томилж чадахгүй УИХ-аа тараая гэж тэр үед МАХН-ын бүлэг санал тавж байсан.</p> <p>2.УИХ дахь МАХН-ын бүлгийн ажлын хэсгийн ахлагч Х.Баатар: Үндсэн хуулинд төрийн үйл ажиллагааг саадгүй явуулахад чиглэсэн өөрчлөлт орууллаа Үнэн /одоо Монголын үнэн/, 2000.01.07, №4 Монгол Улс Парламентын Бүгд Найрамдах Улс учраас Ерөнхий сайдыг томилоход Ерөнхийлөгч голлох үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээхгүй.</p> <p>3.УИХ-ын гишүүн М.Далайхүү: “Нохойд виски өгч болохгүй” Үнэн /одоо Монголын үнэн/, 2000.12.22, №239 Ерөнхийлөгчийн эрх хязгаарлагдсан уу? Ялсан нам, хүчин Ерөнхий сайдыг томилохдоо МУ-ын Ерөнхийлөгчтэй зөвшилцөх тухай заалт тодорхой бус байсныг Ц.Элбэгдорж овжноор ашиглаж, цаг хожиж 3 сар Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж төрийг улам хямруулсан билээ.</p> | <p>Ерөнхий сайдаа томилж чадахгүй бол УИХ өөрөө тарах шийдвэр гаргах ёстой гэсэн зарчмыг Үндсэн хуулинд оруулж байгаа юм. Энэ нь хүлээх хариуцлагыг тодорхой болгох юм.</p> <p>Ийм учраас УИХ-д олонхи авсан нам эвслээс Ерөнхий сайдад нэр дэвшүүлсэн хүний талаар зөвшилцөж, саналаа илэрхийлэх л ёстой. Эцсийн эцэст Засгийн газар хангалтгүй ажиллах, хууль зөрчих явдал гарвал тухайн Ерөнхий сайд, нам л хариуцлага хүлээнэ шүү дээ. Иймээс Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарласан заалт ер ороогүй.</p> <p>Хууль тааруу, муу байж болно. Харин тодорхой байх ёстой.</p> |
| 2 | <p>Үндсэн хуулийн 24-р зүйлийн 1 дэх хэсэг Нийт 1</p> | <p>1.Б. Номин: Үндсэн хуулийн “дордуулсан” заалтуудыг эргэж харахаар хууль санаачилжээ. Монголын үнэн /Үнэн/, 2011.01.11, №07 УИХ-ын дарга, дэд даргыг илээр санал хураан сонгож байгаа нь УИХ-ын гишүүдийн саналаа чөлөөтэй гаргах эрхэд халдсан, намын хяналтыг хатуу тогтоох болсон заалт гэж санаачлагчид үзэв</p> | <p>Үндсэн хуулийн 24-р зүйлийн 1 дэх хэсгийг “УИХ-ын дарга, дэд дарга, байнгын хорооны даргыг УИХ-ын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж болно. УИХ-ын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам эвслийн бүлэг тус бүрээс УИХ-ын дэд даргыг сонгоно” гэж өөрчлөн найруулсан. Ингэснээр 1992 оны Үндсэн хуулийн агуулгыг хэвээр үлдээж буй хэрэг гэнэ. Мөн л 2000 онд дордуулж оруулсан 7 заалтын нэг.</p> |
| 3 | <p>Үндсэн хуулийн 27-р зүйлийн 2 дахь хэсэг, Нийт 3</p> | <p>1.УИХ-ын гишүүн Ж.Бямбадорж: Үндсэн хуулийн өөрчлөлт зөв гэдгийг түүх харуулна Монголын үнэн /Үнэн /, 1999.12.28, №167 УИХ-ын гишүүдийн амралтыг нэмэгдүүлэхийн тулд нэг чуулган 76 хоног хуралдах ёстойг 50 хоног болголоо гэж тайлбарласан нь буруу ойлголт юм. Долоо хоногт 6 хоногийн ажлын өдөртэй байхад нэг чуулган 76 хоногтой байна гэж Үндсэн хуулиар заасан юм. Гэтэл түүнээс хойш ажлын 5 өдөртэй болсон. Энэ чигээрээ байвал УИХ хяналт шалгалт хийлгүй хуралдсаар өнгөрөхөөр юм.</p> | <p>Иймд нэг чуулганы хоорондох УИХ-ын ажлын хоногийг 50 болгосон юм.</p> |

| | | | |
|---|--|--|--|
| | | <p>2.Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Д.Дашцэдэн: Төрийн тогтвортой ажиллагааг хангахад чиглэсэн заалтууд оржээ. Монголын үнэн /Үнэн /, 2000.01.05, №2 Ажлын 75 өдөр гэдэг бол /1992-1996 он/ маш олон хуулийг хэлэлцэж батлах шаардлагатай үед л тохирч байсан юм.</p> | <p>Одоо УИХ хуралдахаасаа илүү чуулганаар хэлэлцэх асуудлыг оновчтой сайн боловсруулах шаардлага байгаа.</p> |
| | | <p>3.УИХ-ын гишүүн М.Далайхүү: “Нохойд виски өгч болохгүй” Монголын үнэн /Үнэн /, 2000.12.22, №239 75 биш 50 хоног хуралдлаа Яг өнөөдрийн байдлаар УИХ дахь намын бүлэг 1 дэх өдөр, байнгын хороод 2-3 дахь өдөр цаг давхцуулан зэрэг зэрэг хуралдаж, 4-5 дахь өдөр чуулганаа хийж байна. Дэгийн хуулиар УИХ-ын гишүүд байнгын хорооны хуралд оролцож санал бодлоо хэлж зарчмын зөрүүтэй саналаа томьёолж өгөөгүй бол чуулганы хуралдаан дээр ярих эрхгүй байдаг. Энэ тохиолдолд УИХ-ын гишүүд “нэг мухлагаас нөгөө мухлаг руу ниснэ” гэдэг шиг “нэг байнгын хорооны хурлаас нөгөө байнгын хорооны хурал руу” гүйлдэн хуулийн төслийн талаарх бодол санаагаа хагас дутуу нэг юм хэлж амжиж байна. Бид чин үнэнийг хэлэхэд ажлын цагаар хуулийн төсөлтэй сайтар танилцаж амжихгүй хагас бүтэн сайнд гэртээ цаас шагайж, тавтайхан амарч ч чадахгүй өнгөрөөж байна ...Бидэнд хуулийн төсөл дээр ажиллах, хяналт шалгалтын ажилд оролцох, сонгогчидтойгоо аажуу уужуухан уулзахад багагүй цаг хугацаа хэрэгтэй байна.</p> | <p>өглөө 11 цаг хүртэл ирцээ хүлээгээд 75 хоног хуралдсан нэр зүүж үүрэглэж суухын оронд цагтаа чуулганаа эхлээд үр бүтээлтэйхэн 50 хоног хуралдчихвал илүү үр дүнтэй биз дээ?</p> |
| 4 | <p>Үндсэн хуулийн 27-р зүйлийн 6 дахь хэсэг Нийт 7</p> | <p>1.МАХН-ын дарга Н.Энхбаяр: Ард түмний захиалгаар энэхүү нэмэлт өөрчлөлтийг санал болгож байгаа Монголын үнэн /Үнэн /, 1999.12.24, №166 - Ер нь өнөөдөр УИХ-аас эхлээд манай бүх шатны ИТХ хуралдаж чадахгүй байгаа. Сэлэнгэ аймгийн Засаг даргыг огцруулах талаар тус аймгийн ИХТ дахь МАХН-ын бүлэг санал гаргахад цөөнх болж байгаа эвслийн бүлэг хурал хаяад байж байна. Тэгэхээр хурлаа явуулж байя. УИХ дахь МАХН-ын бүлгийн хувьд зарим үед хурал хаяхаас өөр аргагүй байдалд цөөнгүй орж байсан. - Санал хураалтыг ил болгоё гэснийг намын диктатурыг тогтоох гэлээ гэж шүүмжилж байна. УИХ-ын гишүүн хүн жирийн иргэнтэй адилаар саналаа нууцаар өгөх хүн биш. Намын бүлэг дээр аль нэгэн УИХ-ын гишүүн хэлэлцэж буй асуудлаар өөр байр суурьтай байгаа бол түүнээ хэлээд нэгдсэн хуралдаан дээр өөрийнхөөрөө саналаа өгдөг.</p> | <p>- Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад гишүүдийн s, Засгийн газартай холбоотой зарим асуудлыг шийдэхэд 2/3, ард нийтийн санал асуулга явуулахад 2/3-ын санал авч байж шийдвэрлэгдэнэ гэсэн босгууд бүгд хэвээрээ байгаа. Өөрөөр хэлбэл, хурц амин чухал асуудлуудыг шийдвэрлэх босго өөрчлөгдөхгүй. Ердийн хууль хэлэлцэхийн тулд УИХ хэвийн үйл ажиллагаа явуулахын үүднээс ердийн олонхийн ирцийг барих нь зүйтэй гэж үзэж байна. - Ард түмэн бидний эрх ашгийг хамгаал гэж сонгосныхоо төлөө тэр хүний ямар асуудал дээр ямар байр суурьтай байгааг, байсныг мэдэж байх ёстой гэж бодож байна. Тэгэхээр гишүүд маань ямар санал өгөв, бид алдаж байна уу үгүй юу гэдгээ тодорхойлоход энэ ил санал хураалт намын удирдлагад ч хэрэгтэй.</p> |
| | | <p>2.Хөдөлмөрийн баатар Ү.Аварзэд: Үндсэн хуулийг тодотгож өөрчлөхөөс өөр аргагүй Монголын үнэн /Үнэн /, 1999.12.24, №166 - Гишүүд байнгын хорооны хуралдаан дээр саналаа ил хураалгадаг. Гэтэл нэгдсэн хуралдаан дээр нууцаар санал өгөөд асуудлыг унагаж байна. Энэ их зөрүүтэй юм..</p> | <p>Ард түмний элч, төлөөлөгчийн хувьд тухайн асуудалд хэрхэн хандаж буй нь ил тод байх хэрэгтэй. УИХ-ын гишүүний санал, сонгогчдын саналтай нийлж байгаа эсэх нь нууц байж болохгүй.</p> |
| | | <p>3.Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Д.Дашцэдэн: Төрийн тогтвортой ажиллагааг хангахад чиглэсэн заалтууд оржээ. Монголын үнэн /Үнэн /, 2000.01.05, №2 Өнгөрсөн практикаас харж байхад УИХ, байнгын хороодын чуулганы ирц бүрдэж байсан нь үгүй..</p> | |

| | | |
|--|--|--|
| | <p>4.УИХ-ын гишүүн, хуульч Ж.Бямбадорж: Намынхаа болон олонхийн эрх ашгийг бодсон Монголын үнэн /Үнэн /, 2000.01.07, №4 1996 оноос хойш МАХН олон удаа байр сууриа илэрхийлж байв. Заримдаа хурал хаядаг. Ингэхлээр хурал хүчингүй болдог.</p> | <p>Иймд сөрөг хүчин оролцохгүй, харин олонхи шийдвэрээ гаргаад хэрэгжүүлж, эцэстээ хариуцлага хүлээх бололцоо олгох хэрэгтэй юм.</p> |
| | <p>5. Ц.Нямдорж: Үндсэн хуулийн цэц хуулийн бус улс төрийн агуулгаар шийдвэр гаргалаа Монголын үнэн /Үнэн /, 2000.03.23, №56 - Далд санал хураалтаар энэ улс төрийг тогтворжуулж чадахгүй юм байна гэдгийг бид яс махандаа хүртэл мэдэрсэн. Хэдийгээр биднийг хуйвалдлаа гэж байгаа ч жинхэнэ хуйвалдаан чинь энэ далд санал хураалтын цаана явагдаад байгаа. Өнөөдөр энэ эрх баригч намуудын задрал бутралд хөшүүрэг өгсөн нэг зүйл нь энэ далд санал хураалт шүү дээ.</p> | |
| | <p>6.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цаг үеийн захиалга мөн. Монголын үнэн /Үнэн /, 2000.12.14, №233 Хуралдааны ирцийн өндөр хувиас шалтгаалж УИХ-ын хэвийн үйл ажиллагааг хангахад бэрхшээл учирдгийг бид мэднэ. Хамгийн гол нь УИХ-ын гишүүдийн нэлээд хэсэг нь хурал орхисон үед УИХ-ын чуулганы хуралдаан зогсож гацдаг аюултай. -Ер нь аливаа нууц юмны цаана хээл хахууль, төрийн тогтворгүй байдлыг бий болгох аюул нуугдаж байхыг үгүйсгэх аргагүй гэдгийг энд дурдах нь илүүц биш гэж үзэж байна.</p> | <p>Энэ өөрчлөлт нь УИХ-д олонхийн суудал авсан нам бодлогоо хараат бусаар явуулах боломжийг мөн олгож байна. УИХ-д хэлэлцэгдэж буй аливаа асуудлаар саналаа илээр гаргаж шийдвэрлэх нь ил тод байдлыг нэвтрүүлэх, сонгосон гишүүд нь ямар асуудлаар ямар байр суурь баримталсныг мэдэх сонгогчдын эрхийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.</p> |
| | <p>7.УИХ-ын гишүүн М.Далайхүү: “Нохойд виски өгч болохгүй” Монголын үнэн /Үнэн /, 2000.12.22, №239 Нууцыг ил болгох учир: ... нууцаар санал өгдөг байсан тэр үед... шуудхан яривал хэнийг унагах вэ, хэнийг гаргах вэ гэдэг талаар ард түмнээсээ сонгогдсон төлөөлөгч, УИХ-ын гишүүд өөрсдөө... “хор”-дож эхэлдэг байв. ...Энд нэг зүйлийг онцолж хэлэхэд Засаг даргын сонгууль болоход МАХН-аас сонгогдсон төлөөлөгчдөөс 2-3 хүн байнга нөгөө талд өгдөг. Ингээд “урвагчийг” эрж олох ажилд мордож, эцэс төгсгөлгүй бие биеэ хардаж, хатуу ширүүн үг хаялцаж чи бидээ хүрдэг боловч нэгэнт нууцаар өгсөн болохоор яг тэр гээд “тогтоож” болдог ч нотолж чаддаггүй байв. ... нууцаар санал өгч байсан тохиолдолд “хор” найруулж найруулчихаад сонгогчиддоо очихдоо би шулуун шударга л байсан. Харин хэсэг нөхөд “хор” найруулаад ажил хийлгэхгүй зовоолоо гээд хэнэг ч үгүй гөлийгөөд суудаг байсан юм шүү дээ. Ирцийг бууруулсны учир: ... далд санал хураалт, ирцийн коворумыг барьцаалан албан тушаалын төлөө үхэн хатан тэмцэгчид олширч ... эрх дархтай нэг нь улсын хөрөнгийг дур мэдэн үрэн таран хийж, эрх мэдлээ урвуулан ашиглах явдал аймаг, нийслэл, сум, дүүрэг, улсын хэмжээнд газар авч эхэлсэн юм. Энэ зохисгүй үйл ажиллагаанаас болж төр дээр дооргүй хямарч, сонгогч түмний итгэл алдарч, хатуу гар, Ерөнхийлөгчийн засаглалын тухай яриа газар авч байсныг сонгогч түмэн сайн санаж байгаа байх.</p> | |

| | | | |
|---|--|--|---|
| 5 | <p>Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэг Нийт 3</p> | <p>1.МАХН-ын дарга Н.Энхбаяр: Ард түмний захиалгаар энэхүү нэмэлт өөрчлөлтийг санал болгож байгаа Монголын үнэн /Үнэн /, 1999.12.24, №166 -Дараачийн асуудал нь УИХ-ын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн байж болно гэсэн заалтыг Энхбаяр Ерөнхий сайд болох гэж сэрүүн зүүдэлж байна гэж шүүмжилж байна. ... Тэгэхээр энэ хуулийг өөртөө тохируулж байгаа хэрэг огтхон ч биш ээ.</p> | <p>Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Байгаль орчны яам зэрэгт харьцангуй мэргэжлийн хүн тавина. Ц.Элбэгдоржийн Засгийн газрын адил ЗГ-ын бүх гишүүд УИХ-ын гишүүн байх гэж туйлшрахгүй. Өнөөдрийн үйлчилж байгаа хууль шиг УИХ-ын гишүүн ЗГ-ын гишүүн байж болохгүй гэсэн нөгөө туйлшрал руу ч орж болохгүй.</p> |
| | | <p>2.Б.Номин: Үндсэн хуулийн “дордуулсан” заалтуудыг эргэж харахаар хууль санаачилжээ. Монголын үнэн /Үнэн/, 2011.01.11, №07 Хууль тогтоогчдод гүйцэтгэх засаглал, хөрөнгө мөнгөтэй хутгалдах боломжийг олгож, парламентын хяналтыг сулруулсан энэ заалтыг дээр, дооргүй ад үзсээр ирсэн. Энэ тухай МУ-ын гавьяат хуульч Б.Чимид “Уг 7 өөрчлөлтийг хүчингүй болгох тухай бус угаасаа хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрч П.Очирбат Ерөнхийлөгчид хадгаладаж байсан/анхны/ эх хувийг сэргээсүгүй гэсэн хууль гаргамаар байгаа юм” хэмээсэн удаатай.</p> | <p>УИХ-ын гишүүн Д.Энхбат нарын 15 гишүүн санаачилсан төсөлдөө санал авахаар өчигдөр ЗГ-т хүргүүлжээ. Тэдний төслөөр юуны өмнө Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газрын бүрэлдэхүүний гуравны нэгээс дээшгүй нь УИХ-ын гишүүн байж болно” гэж нэмэхээр тусгажээ. 2000 оны “дордуулсан” 7 өөрчлөлтийг бага ч болов залруулахаар чармайсан бололтой</p> |
| | | <p>3.Б.Мижид: Манай Үндсэн хууль улстөрчдөөс улстөрийн өндөр соёл, ёс зүйтэй байхыг шаарддаг. Монголын үнэн /Үнэн/, 2011.01.13, №09 -УИХ-ын гишүүн ЗГ-ын гишүүн болсноор гүйцэтгэх засаглалын УИХ-д тайлагнах зарчим алдагдсан. Тайлагнана гэдэг нь эрх зүйн шинжлэх ухаанд хариуцлагын 1 хэлбэр болдог. Үр дагавар нь өнөөг хүртэл арилахгүй байна.</p> | |
| 6 | <p>Үндсэн хуулийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 2 Нийт 3</p> | <p>1.Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Д.Дашцэдэн: Төрийн тогтвортой ажиллагааг хангахад чиглэсэн заалтууд оржээ. Монголын үнэн /Үнэн /, 2000.01.05, №2 -Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор УИХ-д оруулах нь чухал ач холбогдолтой. Гүйцэтгэх засаглалыг хомсдуулж улс орныг эзэнгүйдүүлж болохгүй.</p> | <p>Бага хугацаанд Ерөнхий сайдаа томилдог байх хэрэгтэй.</p> |
| | | <p>2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цаг үеийн захиалга мөн. Монголын үнэн /Үнэн /, 2000.12.14, №233 Энэ өөрчлөлтийг хийхдээ 1992 оны Үндсэн хуулийг хэрэгжүүлсэн 9 жилийн хугацаанд “зөвшилцөх” гэдэг ганц үгнээс шалтгаалж төрийн тэргүүн, эрх барьж буй улс төрийн хүчний хооронд гарч байсан нэг бус удаагийн зөрчил, үл ойлголцох байдал, уг асуудлаас шалтгаалж огцорсон Засгийн газар удаан хугацаанд “үүрэг гүйцэтгэгч” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж, энэ бүхний эцэст төрийн тэргүүн бидний хүссэн хүнийг зөвшөөрөөгүй учраас зөв хүнээ Ерөнхий сайдаар томилж чадаагүй, үүнээс болж бодлого хэрэгжээгүй гэсэн тайлбар хийх боломжийг эрх баригчдад олгож байсан сургамжийг ч харгалзан үзэх үндэстэй.</p> | <p>Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс авч үзвэл парламентын засаглалтай улсад хууль тогтоох байгууллагад олонхи болсон улс төрийн хүчин нь Засгийн газраа байгуулдаг учраас Ерөнхий сайдад хэнийг нэр дэвшүүлэхээ шийдэх бүрэн эрх нь олонхи болсон улс төрийн хүчинд хадгалагдах ёстой.</p> |



| | | | |
|---|---|--|--|
| | | <p>3.Б.Мижид: Манай Үндсэн хууль улстөрчдөөс улстөрийн өндөр соёл, ёс зүйтэй байхыг шаарддаг. Монголын үнэн /Үнэн/, 2011.01.13, №09 Ер нь Үндсэн хуулиараа нэг их ноцолдоод байдаггүй дэлхийн туршлага бий. Харин 1992 онд бид төр, намын харилцааны асуудлыг хөндөөгүй. Үндсэн хуульд зөвхөн эвлэлдэн нэгдэж болно, олонхи суудал авсан улстөрийн нам Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ гэсэн заалт л орсон. Тухайн үед нам, төрийн харилцаа ямар байхыг сайтар ойлгосон хүн байгаагүй гэхэд болно. Парламентын нам болох ёстой гэсэн л яриа байсан. Нөгөө талаас нэг нам дангаараа 70 жилийн турш улс орны бодлогыг гартаа авч ирсэн үе байсныг ч хэлэх үү сөрөг хүчнийхэн төрд байр сууриа хадгалахын тулд МАХН-ын хүч сөрөг хүчнийхэн төрд байр сууриа хадгалахын тулд МАХН-ын хүч нөлөөг багасгах зорилготой байсан.</p> | <p>Тэгэхээр төр, намын харилцааг Үндсэн хуульдаа оновчтой тусгах хэрэгтэй. Улмаар улстөрийн намын хуульд өөрчлөлт оруулах ёстой.</p> |
| 7 | <p>Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг 57-р зүйл, 1 дэх хэсэг Нийт 3</p> | <p>1.Эрдэнэтийг хотын статустай болгохыг орхончууд хүсч байна. Монголын үнэн /Үнэн/, 2010.06.08, №107 Орхон аймгийн иргэд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, Эрдэнэтийг хотын статустай болгохыг хүлээж байгаа аж. Тус аймгийн Баян-Өндөр суманд нийт хүн амынх нь 97% амьдардаг. Нэг багт 8000 гаруй хүн ногддог гэнэ. Тиймээс ачаалал асар их, нэг үгээр төвлөрөл хэрээс хэтэрчээ</p> <p>2.Д.Элбэрэлт: Хошуу цорвойж, хоосон амлалтад нүүрээ улалзуулахыг хүсэхгүй байна. Монголын Үнэн /Үнэн/, 2010.05.12, №89 -51 мянган хүнтэй орон нутгийн засаг захиргааг 250 мянган хүнтэй нийслэлийн засаг захиргааны нэгжтэй дүйцүүлж байгаа нь шударга бус.</p> <p>3.УИХ-ын гишүүн Д.Дондог: Цаг алдах тусам жижиг мажоритараар явуулах санал дийлээд байна. Монголын үнэн /Үнэн/, 2011.01.13, №09 -Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага нийгмийн амьдралаас урган гарсаар байдаг. Бор-Өндөр, Дархан-Уул эсвэл аймгийн төвүүдийг хотын статустай болгох санал ард иргэдээс ирдэг. Гэвч Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаас нааш шийдвэрлэх боломжгүй.</p> | <p>Харин Эрдэнэтийг хот болгосноор эл асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж иргэд үзэж байсан юм.</p> <p>Тиймээс Үндсэн хуулийн өөрчлөлтөөр засаг захиргааны бүтэцэд дорвитой шинэчлэл хийх хэрэгтэйг тэрбээр онцлолоо</p> |
| 8 | <p>Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг 60-р зүйл 2 дахь хэсэг /нийт1/</p> | <p>1.С.Пүрэвжав/Хөвсгөл:/Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг эрх мэдэлтэй болгоё. Монголын үнэн /Үнэн/, 2010.06.04, №104, 105 ИТХ-ын хуралдааны үед нам эвслийн бүлгүүд намынхаа явцуу эрх ашгийн үүднээс хандах, сонгогдож томилогдсон дарга нараа үндэслэлгүй огцруулах шаардлага тавих, хэлэлцэж байгаа асуудлыг зориуд мушгин гуйвуулах, зөрчил маргаан үүсгэх хуралдаанаа хаях, мухардалд хүргэх зэрэг зохисгүй байдал түгээмэл гарах болсон нь сонгогчдод итгэл алдах сэтгэгдэл төрүүлэх болов. Энэ нь баг хорооны ИТХ, ИНТХ-аас хурлын дарга сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэхэд бүр ч түгээмэл гарах болсон.</p> | <p>-Үндсэн хуульдаа гар хүрэхээр их яригдах боллоо. Гар хүрэхээр бол нэлээд өргөн хүрээтэй хандаж хуулийн зарим заалт тухайлбал, сум, хороо, багийн Засаг даргыг сонгодог тогтолцоонд өөрчлөлт оруулж орон нутгийн сонгуулиар сум, дүүргийн Засаг дарга нарыг, ард нийтийн сонгуулиар баг, хорооны Засаг дарга, сум дүүргийн Засаг дарга нар томилдог болгох шаардлагатай. Ингэснээр нутаг жалгаараа талцах ах, дүү танил талаа машин машинаар зөөх зэрэг болхи арга дэлгэрч байгаа өнөөгийн гаж тогтолцоо арилах болно.</p> |

| | | | |
|----|--|--|--|
| 9 | <p>Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг Хүний эрх, эрх чөлөө /нийт 2/</p> | <p>1.Хүнсний эрх “хөгцөрчээ” Монголын Үнэн /Үнэн/, 2010.07.08, №132</p> <p>-Олон улсын хэмжээнд хүн амын хүнсний эрхийг хэрэгжүүлэхтэй шууд болон шууд бус холбоотой хэд хэдэн гэрээ конвенцид манай улс нэгдэн орж үүрэг, амлалт авсан байдаг. Харин Үндсэн хуульдаа “хүнсний эрх” гэж тусгайлан томъёолсон зүйл үгүй. Хүн амын хүнсний эрхийг цогцоор нь хэрэгжүүлэх, хамгаалах, хохиролыг барагдуулах эрх зүйн орчин бүрдээгүйгээс л хүмүүс хэрэглэсэн хүнснээсээ болж эрүүл мэндээрээ хохирч, эд эрхтэнээ гэмтээж байгаа нь үнэн.</p> <p>2.МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, академич С.Нарангэрэл: Үндсэн хуульд нэмэлт оруулах нь өөрчлөхтэй харьцуулахад арай зөөлөвтөр “Үнэн”/одоо “Монголын Үнэн”/ 2010.01.20, №12 Манай улсын Үндсэн хуульд хүн боолчлогдохоос ангид байх, шаардлага хангахуйц орон байр, ундны ус, хоол хүнсээр хангагдах эрхийг нарийвчлан тусгаагүй байгаа юм.</p> | <p>2. Үүнийг нэмж болно. Тийм учраас нэмэлт оруулах нь өөрчлөхтэй харьцуулахад арай зөөлөвтөр байна гэсэн үг.</p> |
| 10 | <p>ӨӨРЧИЛНӨ</p> | <p>Депутатууд санал бодлоо илэрхийлж байна: Пүрэвдорж/41-р тойрог Үндсэн хуулийн зарчмыг өөрчлөх шаардлагагүй “Үнэн”/одоо “Монголын Үнэн”/ 2007.01, №2/8 Үндсэн хуулийн нийгмийн амьдралд чөдөр тушаа болсон заалтыг зоригтой өөрчлөх хэрэгтэй.</p> | <p>Гэхдээ Үндсэн хуулийн зарчмыг өөрчлөх шаардлагагүй. Бидний баталсан Үндсэн хууль дэлхийд үнэлэгдэхээр болж чадсан.</p> |
| 11 | | <p>УИХ-ын гишүүн Д. Лүндээжанцан: Сонгуулийн хууль сонгогчдын сэтгэлд нийцсэн байх учиртай “Үнэн”/одоо “Монголын Үнэн”/, 2010.01.14 №08 Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага бий. Хэдийгээр өөрчлөх хэрэгтэй гэж ярьдаг ч яаж өөрчлөх аргаа мэддэггүй. Түүнээс биш сайн дурын уран сайханч шиг хэн дуртай нь хүссэн үедээ Үндсэн хуулийг өөрчлөөд байж болохгүй. Үндсэн хуулийг өөрчлөх үндэслэл тооцоо муутай, сэтгэлийн хөдөлгөөнөөр тэр улсад ийм, энэ улсад тийм л хуультай байдаг гэх байдлаар ханддаг. Үндсэн хууль хэн дуртай нь тоглодог хөдөлгөөнт тоглоом биш</p> | <p>Юуны өмнө Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хууль гаргах хэрэгтэй. Хэрхэн өөрчлөх вэ, ямар бүрэлдэхүүнтэй байх, ард түмний санал асуулгаар ямар асуудлыг шийдэх вэ гэдгийг тодруулсан байх ёстой.</p> |


Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй

| | <p>Асуудлын ерөнхий ангилал,давалт</p> | <p>Гарсан шүүмжлэл, эх сурвалж</p> | <p>Дэвшүүлсэн санал, эх сурвалж</p> |
|---|--|---|--|
| 1 | <p>22- 2 Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана.</p> <p>/Энэ заалтыг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн/ / нийт 1/</p> | <p>1.Ерөнхийлөгч тавьсан хоригоо тайлбарлаж УИХ-ын зарим байнгын хороонд хүргүүлжээ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2000.01.05, №2</p> <p>-Энэ бол УИХ-ыг тараахсан гэсэн сонгогчдыг хоосон үгээр хуурах, Үндсэн хуульд ашиг тус муутай өөрчлөлт хийж байгаа талаар шүүмжлэлийг ямар нэг хэмжээгээр намжаах гэсэн оролдлого мөн.</p> | <p>Ерөнхийлөгчийн засаглал бүхий улс оронд хэрэглэдэг аргыг МУ-д хэрэглэх гэж оролдон будлиантуулж, Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлал болон МУ-ын Үндсэн хуулийн 20-р зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн” гэж заасанд харшилж байна</p> |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|---|--|--|--|
| 2 | <p>24-1 Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно. /Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/ Нийт 1</p> | <p>1.Ерөнхийлөгч тавьсан хоригоо тайлбарлаж УИХ-ын зарим байнгын хороонд хүргүүлжээ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2000.01.05, №2 -Тэгэхээр 8-аас доош суудал авсан намын гишүүн болон бие дааж нэрээ дэвшүүлэн сонгогдсон гишүүн УИХ-ын дэд даргаар сонгогдож болохгүй боллоо.</p> | <p>УИХ-ын гишүүдийн заримынх нь дэд даргаар сонгогдох эрхийг хязгаарласан энэ заалт нь хүнийг аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагын гишүүний нь хувьд ялган гадуурхахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн 16-р зүйлийн 10 дахь хэсгийн заалтад харшилж байна.</p> |
| 3 | <p>27-2 Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна. /Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/ Нийт 1</p> | <p>1. Ерөнхийлөгч тавьсан хоригоо тайлбарлаж УИХ-ын зарим байнгын хороонд хүргүүлжээ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2000.01.05, №2 - Бямба гариг амралтын өдөр болсон тул ийм өөрчлөлт хийж байгаа гэж тайлбарлаж байна. УИХ байгуулагдсан цагаасаа хойш хагас жил тутам 75 өдөр чуулж одоог хүртэл Бямба гаригт хуралдаан хийдэггүй байсан. Ажлын 5 өдөрт шилжсэнээр 7 хоногийн ажлын цаг 13 хувиар хорогдсон юм. Гэтэл чуулганы хугацааг 33 хувиар хорогдуулах өөрчлөлт хийв. УИХ-ын чуулганы хуралдаан 7 хоногт 4 болдог байсныг 1996 онд 2 болгож хорогдуулсан. Үнэн хэрэгтээ 7 хоногт 2 хуралдаж чадахгүй чуулганы хуралдааны ирц хүрэхгүй байнга тасалдаж байгаа. Сүүлийн 4 жилийн турш үргэлжилж байгаа ийм сахилгагүй, хариуцлагагүй, хуулийг хэрэгсдэггүй байдалд зохицуулж Үндсэн хуулийг өөрчилж байгаа ажилд гарч байгаа сайн өөрчлөлт, "гацааг гаргаж" байгаа шилдэг арга гэж тайлбарлаж боломгүй, харин төрийн албыг нэн цалгардуулна</p> | |
| 4 | <p>27-6 Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ. /Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/ Нийт 1</p> | <p>1.Ерөнхийлөгч тавьсан хоригоо тайлбарлаж УИХ-ын зарим байнгын хороонд хүргүүлжээ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2000.01.05, №2 -УИХ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд гишүүд саналаа илээр гаргаж байх шинэ журам тогтоож, УИХ-ын гишүүд намынхаа удирдлагын шийдвэрийн дагуу саналаа өгч байгаа эсэхэд хяналт тавих болж байгаа нь УИХ-ын гишүүд саналаа чөлөөтэй гаргах боломжийг хязгаарлаж сонгогчдынхоо биш, намынхаа эрх ашгийг илэрхийлж байхад хүргэнэ. -УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдаанд гишүүдийн 66.7 хувь оролцвол хүчинтэйд тооцдог Үндсэн хуулийн заалтыг өөрчилж, 50.1 хувь болгон бууруулж байгаа нь төрийн дээд эрх барих байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгож байна гэж үзэх үндэслэлгүй юм</p> | <p>1.УИХ-ын гишүүн юуны өмнө сонгогчдынхоо хууль ёсны эрх ашиг, хүсэл зоригийг илэрхийлж байхын тулд УИХ-р аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналаа чөлөөтэй гаргах боломжоор хангагдсан байх нь чухал. УИХ-ын гишүүдийн санал гаргах эрхийг намын хяналтад авах нь МУ-ын Засгийн эрхийг ард түмний мэдлээс намын мэдэлд ямар нэгэн хэмжээгээр шилжүүлнэ. Энэ нь ... Үндсэн хуулийн 3-р зүйлийн 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэх бололцоог хязгаарлаж байна</p> |

| | | | |
|----------|---|---|--|
| <p>5</p> | <p>29-1 Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. /Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/ Нийт 2</p> | <p>1.Ерөнхийлөгч тавьсан хоригоо тайлбарлаж УИХ-ын зарим байнгын хороонд хүргүүлжээ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2000.01.05, №2 МУ-ын Үндсэн хууль хүн төрөлхтөний төр ёс, хууль цаазын хөгжлийн чиг хандлагыг баримтлан “эрх мэдлийг хуваарилах” зарчмыг хуульчлан хэрэгжүүлсэн юм. Хууль тогтоох гол бүрэн эрхтэй УИХ-ын гишүүн нь гүйцэтгэх засаглалын дээд болон төв байгууллагуудыг толгойлж байх нь Үндсэн хуулийн энэхүү тулгуур зарчимд харшилж байна.</p> | |
| | | <p>2.Депутатууд санал бодлоо илэрхийлж байна: Тэрбиш /Хэний аймаг/: Үндсэн хуулийн зарчмыг өөрчлөх шаардлагагүй “Үнэн”/одоо “Монголын Үнэн”/ 2007.01, №2/8 УИХ-ын гишүүн ЗГ-ын гишүүн байхын эсрэг зогсдог хүний нэг нь би.</p> | <p>Үндсэн хуульд өөрчлөлт оруулахдаа ард түмний саналыг авч байгааг ээ. Сонгуулийн тогтолцоог холимог болгох хэрэгтэй.</p> |
| <p>6</p> | <p>33-1-2 Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах; /Энэ заалтыг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/ Нийт 1</p> | <p>1.Ерөнхийлөгч тавьсан хоригоо тайлбарлаж УИХ-ын зарим байнгын хороонд хүргүүлжээ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2000.01.05, №2 Ерөнхийлөгч сайд нь ... Ерөнхийлөгчтэй зөвшилцөнө гэсэн заалт “саналаа танилцуулах, дуулгах” төдий агуулгатай болов.</p> | <p>Засгийн газрыг эмхлэн байгуулахад Ерөнхийлөгч бодитой оролцох бололцоогүй болсон нь төр, засгийн дээд байгууллагуудын эрх хэмжээний хуваарилалт, тэнцвэр, уялдаа, харилцан хяналт тавих Үндсэн хуулийн нэг гол үзэл баримтлалыг илт гажуудуулж байна.</p> |



| | | | |
|---|---|--|--|
| 7 | <p>39-2 Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.</p> <p>/Энэ заалтыг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн/ Нийт 1</p> | <p>1. Б.Чимид: Их хурал нь Үндсэн хуулиа гуйвалтгүй биелүүлж байхыг хууль дээдлэх ёс гэнэ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2007.01.11, №7</p> <p>-Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг айхтар сүрхий танасан. Тухайлбал, Ерөнхий сайд, сайд нарыг томилоход санаачлах эрх болох зөвшилцөх гэдэг үгийн цаана байгаа “тохиролцох” гэдгийн утгыг алдагдуулаад намууд Ерөнхий сайд болох хүнийг Ерөнхийлөгчид хугацаа тогтоож тулгадаг болсон.</p> <p>... Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын хоорондын холбоо буюу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын хоорондын харилцааны Үндсэн хуулийн үндсийг, өөрөөр хэлбэл, хүйн холбоог эвдчихсэн. Одоо бол нэр хүндийн буюу хүсэл зоригийн холбоо байгаагаас бус Үндсэн хуулийн холбоо тасарчихсан. Энэ нь цааш цаашдаа яваад, шарх үсэрхийлдэгтэй адил парламент, Засгийн газар хоёр нь нийлчихээр хүний эрхийг зөрчих суурийг тавьж өгсөн гэж болно.</p> <p>- Дээрх өөрчлөлт бол нэг ёсондоо УИХ-ын гишүүн болсон хүн сайд болохын төлөө л хийсэн өөрчлөлт гэдэг нь амьдралаар нотлогдсон.</p> | <p>1.Анх өөрчлөлт хийхэд анхны Үндсэн хуулийг батлалцсан Гандан хийдийн тэргүүн хамба Чойжамц гуай нэг үг хэлсэн байдаг. “Бид Үндсэн хууль баталсандаа сэтгэл сайхан байдаг. Гэхдээ энэ өөрчлөлтийн зөв бурууг түүх аяндаа харуулна биз ээ” гэсэн. Сүүлийн 4, 5 жилд түүх харуулчихлаа даа. Тиймээс Үндсэн хуульд өөр юуг өөрчлөх вэ гээд байх биш өмнөх өөрчлөлтийг хүчингүй болгож, уг эхийн зарчмын заалтыг сэргээх хэрэгтэй. Тэгэхгүй бол төрийн байгуулалтын хямрал арилахгүй, улам л гүнзгийрч, ариа хэлэлцээний аргаар засах аргагүйд хүрч мөргөлдөөнд ч оруулж магадгүй.</p> |
| 8 | <p>Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг /59-2/ Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.</p> <p>Нийт 1</p> | <p>1.Б.Чимид: Их хурал нь Үндсэн хуулиа гуйвалтгүй биелүүлж байхыг хууль дээдлэх ёс гэнэ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2007.01.11, №7</p> <p>Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг буюу “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний тухай “удирдлагын заалтуудыг өөрчлөх ажлын хэсэг гараад, төсөл боловсруулж, орон нутгаас санал авсан сурагтай. Би зарим төсөлтэй танилцсан. Мөн л ардчиллын зарчмын хийг дарж, ирийг мохоосон, захиргаадсан үг өгүүлбэртэй төсөл болсон байна лээ. Жишээлбэл, баг, хорооны эрх барих байгууллага болсон иргэдийн нийтийн хурлыг үгүй болгох утга агуулга “орхисон” байна билээ.</p> <p>- Бас хорооны иргэд хамтарч хуралдаад орон нутгийнхаа асуудлыг шийдвэрлэх эрхгүй болгох, хуралдаад шийдвэрлэсэн байлаа ч та нар ямар эрх зүйн үндэстэй юм бэ гэх хэмжээнд хүргэх өөрчлөлтийг хийх гээд зэхэж байна.</p> | |
| 9 | <p>/60-2/ Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.</p> | <p>1.Б.Чимид: Их хурал нь Үндсэн хуулиа гуйвалтгүй биелүүлж байхыг хууль дээдлэх ёс гэнэ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2007.01.11, №7</p> <p>Засаг даргыг хурлаас нэр дэвшүүлдгийг зогсоож хэн нэг хүнийг дээрээс нь томилох /нэг ёсондоо нэг намын хүн томилоод л захиргаадуулах/ систем руу оруулахаар завдаж байна</p> | |

| | | | |
|----|--|---|---|
| 10 | <p>1/57-3/ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ Нийт 2</p> | <p>1.Б.Чимид: Их хурал нь Үндсэн хуулиа гуйвалтгүй биелүүлж байхыг хууль дээдлэх ёс гэнэ. Үнэн /одоо Монголын үнэн/, 2007.01.11, №7 -Мөн ард түмний шийдвэрлэх эрхийг хасах нэг ноцтой заалт оруулахаар ярьж байгаа бололтой. Тухайлбал, аймаг, сум, баг мэтийн засаг захиргааны нэгжийг өөрчлөхдөө тэр нутгийн хурал хийгээд иргэдийн саналыг үндэслэнэ гэснийг “харгалзана” гэдэг үгээр солих бололтой. Харгалзана гэдэг чинь олон түмний саналын эсрэг шийдвэрлэх хууль зүйн боломжийг олгож байна гэсэн үг. Энэ заалт бол АИХ-ын 420 гаруй депутатаас төсөлд нэмж оруулсан их хатуу заалт</p> <p>2.Б.Чимэд: Үүрэгт тангарагаа өргөхдөө Үндсэн хуулиар гул барих ёсгүй. “Үнэн”/одоо “Монголын Үнэн”/ 2008.08.22, №165 Ноднин УИХ дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарилалт нутгийн удирдлагын зохион байгуулалтын талаар Үндсэн хуулийн одоо байгаа зүйлийг өөрчилнэ гэсэн төсөл гарчээ гэхээр нь би аваад үзэхгүй юу. Тэгсэн сум, аймаг зэрэг засаг захиргааны нэгжийг шинээр өөрчлөх асуудлыг тухайн сум, аймгийн ИТХ болон тэр нутгийн иргэдийн өөрсдийнх нь саналыг үндэслэн шийдвэрлэнэ гэснийг яаж өөрчлөх гэсэн гээч. Бод доо. “Үндэслэн” гэдэг ганцхан үгийг “харгалзан” гэж өөрчлөх гэнэ.</p> | <p>Ер нь ард түмнийхээ саналыг авч тэр үндсэн дээр хууль хийнэ гэдэг бол хууль зүйн биелэх үндэслэлийг сайжруулна гэсэн үг.</p> <p>Энэ чинь байж болшгүй зүйл гээд тухайн үед бид санал тавьсан. ... Сумыг татан буулгачихаад уулзалт хийхдээ “Та нарын саналыг харгалзах гэж мөн ч их зүтгээд барсангүй. Олонхид ялагдлаа” гэж аргалах уу.</p> |
| 11 | <p>5-5 Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна. Нийт 1</p> | <p>1. Депутатууд санал бодлоо илэрхийлж байна: Үндсэн хуулийн зарчмыг өөрчлөх шаардлагагүй “Үнэн”/одоо “Монголын Үнэн”/ 2007.01, №2/8 Бат-Эрдэнэ /Баянгол дүүргийн ЗДТГ-ын дарга/: Харамсалтай нь бид өнөөдөр мал малчин 2-тоо хандаж чадахгүй байна.</p> | |
| 12 | <p>68-1 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Нийт 1</p> | <p>1.Үндсэн хуулийг Цэц бас өөрчилж болох нь ээ “Үнэн”/одоо “Монголын Үнэн”/ 2000.12.02, №225 - Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1-д “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачлагыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц УИХ-д өргөн мэдүүлж болно. Хуулинд “мэдүүлж болно” гэсэн болохоос яг таг мэдүүлнэ гэж заагаагүй</p> | <p>Монгол Улсын төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага болох УИХ, Цэцийн “гарыг харах” шаардлагагүй бөгөөд харин УИХ “нэмэлт өөрчлөлт орууллаа, та нар хэрэгжилтэд хяналт тавирай” гэхэд л хангалттай юм</p> |

ХАВСРАЛТ 2

ЗУУНЫ МЭДЭЭ СОНИН /1999-2011/

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

| № | Асуудлын ерөнхий ангилал,давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
|---|----------------------------------|-----------------------------|------------------|
|---|----------------------------------|-----------------------------|------------------|



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----------|--|---|---|
| <p>1.</p> | <p>2000 онд ҮХ-д оруулсан нэмэлт өөрчлөлт 1,24-1."УИХ-ын дарга дэд даргыг УИХ-ын гишүүд дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно". / 5 /</p> | <p>1. Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Санаачлагчдын тайлбараас //ЗМ 1999.12.28 № 265 /265/ 2 Шүүмжлэл байхгүй. 2. Үндсэн хуулийг өөрчлөх нь засгийн эрхэнд хэн ямар нам гарахтай хамаагүй // ЗМ 1999.12.24 № 262 /262/ 1. 2 - УИХ-ын гишүүн П. Жасрай Үндсэн хуульд өөрчлөлт хийх нь албан тушаалын мэт харагдаж байж болох юм. -УИХ-ын гишүүн Ж.Бямбадорж : Төрийн тогтолцоог боловсронгуй болгож, төрийн машиныг зөв ажиллууль гэвэл өөрчлөлт зайлшгүй -УИХ-ын гишүүн Ц. Өөлд: Засгийн газар олон удаа огцорлоо. Энэ дутагдлуудыг арилгахад чиглэсэн заалтуудыг хийсэн 3. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цагийн үеийн захиалга. // ЗМ 2000.12.13 № 292/559/ 1.2 8 хүн: Л.Рэнчин, Н.Лувсанжав, С.Цэрэндорж, Ш.Түдэв, Я. Шуурав, Г.Чулуунбаатар Ерөнхийлөгч олон удаа татгалзаж тэдгээрийн үр дагавар болж төрийн тасралтгүй шууд үйл ажиллагаа алдагдаж байгаа явдлууд давтагдахгүй байх боломж бүрдэнэ. Хуримтлагдсан зөрчилт нөхцөл байдлыг шийдвэрлэх учирзүйн үүднээс 4. А. Цоож Үндсэн хуулийн зарим заалтыг эргэж харъя // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 8 Тэгэхдээ үндсээр нь өөрчилнө гэсэн үг биш бөгөөд агуулгыг нь хэвээр хадгалж, зарим заалтыг өөрчлөн шинэчлэх нь зүйтэй болов уу. 5. Э. Бат - үүл Ардын их хурал // ЗМ 2007.1.15 № 11 /2457/ 10 Хянаваас, АИХ хэмээх дээд танхимтай парламент нь ардчиллын өсөлт бойжилтод дэм болохоосоо хор болж мэдэхээр төлөвтэй</p> | <p>1, УИХ-ын 65 гишүүний оруулсан санаачилсан төслөөр 7 нэмэлт өөрчлөлт оруулсан байна Санаачлагчдын тайлбараас.../ҮХ- 24-1/ 2. -Гэтэл Монгол төрийг боловсронгуй болгох том агуулга явж байгаа - Төрийн тогтолцоог боловсронгуй болгох ... - Өөрчлөлт хийх нь зөв 3. 24- р зүйлийн 1 өөрчлөн найруулах 4. -Төрийн байгууллалтын тогтолцоо. -Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын талаар нилээд өөрчилж 5. Парламентын дээд танхим АИХ байх үед депутат хэмээх мэдээллийн байнгын амьд уг сурвалжаар дамжуулан олон түмэн төрийн бодлогын нарийн ширийнийг мэдэж ойлгож авах боломж өргөн байсан</p> |
| <p>2.</p> | <p>27-2 "УИХ-ын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа 50-иас доошгүй ажлын өдөр чуулна." /5/</p> | <p>1. Үндсэн хуулийг өөрчлөх нь засгийн эрхэнд хэн ямар нам гарахтай хамаагүй // ЗМ 1999.12.24 № 262 /262/ 1. 2 - УИХ-ын гишүүн П. Жасрай Үндсэн хуульд өөрчлөлт хийх нь албан тушаалын мэт харагдаж байж болох юм. - УИХ-ын гишүүн Ж.Бямбадорж : Төрийн тогтолцоог боловсронгуй болгож, төрийн машиныг зөв ажиллууль гэвэл өөрчлөлт зайлшгүй - УИХ-ын гишүүн Ц. Өөлд: Засгийн газар олон удаа огцорлоо. Энэ дутагдлуудыг арилгахад чиглэсэн заалтуудыг хийсэн 2. Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Санаачлагчдын тайлбараас //ЗМ 1999.12.28 № 265 /265/ 2 3. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цагийн үеийн захиалга. // ЗМ 2000.12.13 № 292/559/ 1.2 8 хүн: Л.Рэнчин, Н.Лувсанжав, С.Цэрэндорж, Ш.Түдэв, Я. Шуурав, Г.Чулуунбаатар Ерөнхийлөгч олон удаа татгалзаж тэдгээрийн үр дагавар болж төрийн тасралтгүй шууд үйл ажиллагаа алдагдаж байгаа явдлууд давтагдахгүй байх боломж бүрдэнэ. Хуримтлагдсан зөрчилт нөхцөл байдлыг шийдвэрлэх учирзүйн үүднээс ... 4. А. Цоож Үндсэн хуулийн зарим заалтыг эргэж харъя // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 8 Тэгэхдээ үндсээр нь өөрчилнө гэсэн үг биш бөгөөд агуулгыг нь хэвээр хадгалж, зарим заалтыг өөрчлөн шинэчлэх нь зүйтэй болов уу</p> | <p>1 - Гэтэл Монгол төрийг боловсронгуй болгох том агуулга явж байгаа - Төрийн тогтолцоог боловсронгуй болгох ... - Өөрчлөлт хийх нь зөв 2. УИХ-ын 65 гишүүний оруулсан санаачилсан төслөөр 7 нэмэлт өөрчлөлт оруулсан байна Санаачлагчдын тайлбараас.../ҮХ- 27-2/ 3. 27- р зүйлийн 2 өөрчлөн найруулах 4. -Төрийн байгууллалтын тогтолцоо. -Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын талаар нилээд өөрчилж</p> |

| | | | |
|-----------|--|---|---|
| <p>3.</p> | <p>27-6"УИХ-ын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. ЕС болон 3Г-ын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ" /5/</p> | <p>1. Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Санаачлагчдын тайлбараас //ЗМ 1999.12.28 № 265 /265/ 2 Тайлбар Шүүмжлэл байхгүй.</p> <p>2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цагийн үеийн захиалга. // ЗМ 2000.12.13 № 292/559/ 1.2 8 хүн: Л.Рэнчин, Н.Лувсанжав, С.Цэрэндорж, Ш.Түдэв, Я. Шуурав, Г.Чулуунбаатар</p> <p>Ерөнхийлөгч олон удаа татгалзаж тэдгээрийн үр дагавар болж төрийн тасралтгүй шууд үйл ажиллагаа алдагдаж байгаа явдлууд давтагдахгүй байх боломж бүрдэнэ.</p> <p>Хуримтлагдсан зөрчилт нөхцөл байдлыг шийдвэрлэх учирзүйн үүднээс</p> <p>3. Н. Лүндэндорж. Олигархийн дарангуйллаас ардчилалд хүрэх зам // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 4</p> <p>Үндсэн хууль оршино гэдэг нь Үндсэн хууль гэсэн нэртэй бичвэр байхын нэр биш юм.</p> <p>Төр эрх мэдлээ намд алдсан нь</p> <p>4. А. Цоож Үндсэн хуулийн зарим заалтыг эргэж харъя // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 8</p> <p>Тэгэхдээ үндсээр нь өөрчилнө гэсэн үг биш бөгөөд агуулгыг нь хэвээр хадгалж, зарим заалтыг өөрчлөн шинэчлэх нь зүйтэй болов уу</p> <p>5. Э. Бат - үүл Ардын их хурал // ЗМ 2007.1.15 № 11 /2457/ 10</p> <p>Хянаваас, АИХ хэмээх дээд танхимтай парламент нь ардчиллын өсөлт бойжилтод дэм болохоосоо хор болж мэдэхээр төлөвтэй</p> | <p>1. УИХ-ын 65 гишүүний оруулсан санаачилсан төслөөр 7 нэмэлт өөрчлөлт оруулсан байна Санаачлагчдын тайлбараас.../УХ- 27-6/</p> <p>2. 27-р зүйлийн 6, өөрчлөн найруулах</p> <p>3. Марксист сэтгэлгээний эмгэгээр монголчилсон төрийн удирдлагын парламентын хэлбэрийг сонгодог төрхөөр нь дахин байгуулах</p> <p>4. -Төрийн байгууллалтын тогтолцоо. -Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын талаар нилээд өөрчилж</p> <p>5. Парламентын дээд танхим АИХ байх үед депутат хэмээх мэдээллийн байнгын амьд уг сурвалжаар дамжуулан олон түмэн төрийн бодлогын нарийн ширийний мэдэж ойлгож авах боломж өргөн байсан.</p> |
| <p>4.</p> | <p>29-1 Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.</p> <p>/5/</p> | <p>1. Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Санаачлагчдын тайлбараас // ЗМ 1999.12.28 № 265 /265/ 2</p> <p>2. Үндсэн хуулийг өөрчлөх нь засгийн эрхэнд хэн ямар нам гарахтай хамаагүй // ЗМ 1999.12.24 № 262 /262/ 1. 2</p> <p>а. УИХ-ын гишүүн П. Жасрай Үндсэн хуульд өөрчлөлт хийх нь албан тушаалын мэт харагдаж байж болох юм.</p> <p>б. УИХ-ын гишүүн Ж.Бямбадорж : Төрийн тогтолцоог боловсронгуй болгож, төрийн машиныг зөв ажиллуулъя гэвэл өөрчлөлт зайлшгүй</p> <p>в. УИХ-ын гишүүн Ц. Өөлд: Засгийн газар олон удаа огцорлоо. Энэ дутагдлуудыг арилгахад чиглэсэн заалтуудыг хийсэн</p> <p>3. Н. Багабанди. УИХ хариуцлагаа ерөнхийлөгчид тохох гэж байна хэмээн үзжээ // ЗМ 2000.1.5 № 03/270/ 2</p> <p>Үндсэн хуулийн өөрчлөлтийг: манай улсад албан ёсоор үйл ажиллагаа 20 намын 17-д дуулаагүй, засгийн эрхийг барьдаг сонгогчид санал бодлоо хэлэх боломж олгоогүй.. явцуу хүрээнд хийгджээ.</p> | <p>1. УИХ-ын 65 гишүүний оруулсан санаачилсан төслөөр 7 нэмэлт өөрчлөлт оруулсан байна Санаачлагчдын тайлбараас.../УХ- 29-1/</p> <p>2. а.Гэтэл Монгол төрийг боловсронгуй болгох том агуулга явж байгаа б. Төрийн тогтолцоог боловсронгуй болгох ... в.Өөрчлөлт хийх нь зөв</p> <p>3. Хориг тавьсан үндэслэл 29-р зүйлийн 1 дэх хэсэг Зарим заалт бусад заалтуудтай харшилсан нь хөнгөн гоомой хандсаныг нотолж байгаа эдгээр үндэслэлийг анхааралдаа авч, үндсэн хуулийнхаа нийт агуулгаар сэтгэж тал талаас нь шүүн хэлэлцэж, УИХ-д бүрэн эхээр нь танилцуулж, Монголын ард түмний язгуур эрх ашигт чанд нийцүүлэн шийдвэрлэнэ.</p> |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----------|---|---|---|
| | | <p>4. Б. Цогтгэрэл Үндсэн хуулийг өөрчлөх эдийн засгийн үндэслэл /Цуврал// ЗМ 2009.12.17 № 294 (3366) 3, Монгол нийгмийн өнөөгийн дүн төрх, түүний хандлага нь шинжлэх ухааны үндэслэл гаргах гэж оролдсон билээ. Эцэст нь ҮХ өөрчлөхөөс өөр аргагүй байна гэдэг дүгнэлт хийсэн.</p> <p>5. Э. Бат - үүл Ардын их хурал // ЗМ 2007.1.15 № 11 /2457/ 10</p> <p>Хянаваас, АИХ хэмээх дээд танхимтай парламент нь ардчиллын өсөлт бойжилтод дэм болохоосоо хор болж мэдэхээр төлөвтэй</p> | <p>4. 29-р зүйлийн 1 УИХ-ын гишүүн нь ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй</p> <p>5. Парламентын дээд танхим АИХ байх үед депутат хэмээх мэдээллийн байнгын амьд уг сурвалжаар дамжуулан олон түмэн төрийн бодлогын нарийн ширийнийг мэдэж ойлгож авах боломж өргөн байсан</p> |
| <p>5.</p> | <p>33-1-2 2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах / 5 /</p> | <p>1. Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Санаачлагчдын тайлбараас //ЗМ 1999.12.28 № 265 /265/ 2</p> <p>2. Үндсэн хуулийг өөрчлөх нь засгийн эрхэнд хэн ямар нам гарахтай хамаагүй // ЗМ 1999.12.24 № 262 /262/ 1. 2</p> <p>а. УИХ-ын гишүүн П. Жасрай Үндсэн хуульд өөрчлөлт хийх нь албан тушаалын мэт харагдаж байж болох юм.</p> <p>б. УИХ-ын гишүүн Ж.Бямбадорж : Төрийн тогтолцоог боловсронгуй болгож, төрийн машиныг зөв ажиллуулъя гэвэл өөрчлөлт зайлшгүй</p> <p>в. УИХ-ын гишүүн Ц. Өөлд: Засгийн газар олон удаа огцорлоо. Энэ дутагдлуудыг арилгахад чиглэсэн заалтуудыг хийсэн</p> <p>3. Н. Багабанди. УИХ хариуцлагаа ерөнхийлөгчид тохох гэж байна хэмээн үзжээ // ЗМ 2000.1.5 № 03/270/ 2</p> <p>Үндсэн хуулийн өөрчлөлтийг: манай улсад албан ёсоор үйл ажиллагаа явуулдаг 20 намын 17-д дуулгаагүй, засгийн эрхийг барьдаг сонгогчид санал бодлоо хэлэх боломж олгоогүй.. явцуу хүрээнд хийгджээ</p> | <p>1, УИХ-ын 65 гишүүний оруулсан санаачилсан төслөөр 7 нэмэлт өөрчлөлт оруулсан байна Санаачлагчдын тайлбараас.../ҮХ- 33-1-2/</p> <p>2. а.Гэтэл Монгол төрийг боловсронгуй болгох том агуулга явж байгаа</p> <p>б. Төрийн тогтолцоог боловсронгуй болгох ...</p> <p>в.Өөрчлөлт хийх нь зөв</p> <p>3. Хориг тавьсан үндэслэл 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 2</p> <p>Зарим заалт бусад заалтуудтай харшилсан нь хөнгөн гоомой хандсаныг нотолж байгаа эдгээр үндэслэлийг анхааралдаа авч, үндсэн хуулийнхаа нийт агуулгаар сэтгэж тал талаас нь шүүн хэлэлцэж, УИХ-д бүрэн эхээр нь танилцуулж, Монголын ард түмний язгуур эрх ашигт чанд нийцүүлэн шийдвэрлэнэ</p> |
| | | <p>4. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цагийн үеийн захиалга. // ЗМ 2000.12.13 № 292/559/ 1.2 8 хүн: Л.Рэнчин, Н.Лувсанжав, С.Цэрэндорж, Ш.Түдэв, Я. Шуурав, Г.Чулуунбаатар</p> <p>Ерөнхийлөгч олон удаа татгалзаж тэдгээрийн үр дагавар болж төрийн тасралтгүй шууд үйл ажиллагаа алдагдаж байгаа явдлууд давтагдахгүй байх боломж бүрдэнэ.</p> <p>Хуримтлагдсан зөрчилт нөхцөл байдлыг шийдвэрлэх учирзүйн үүднээс</p> <p>5. Н. Лүндэндорж. Олигархийн дарангуйллаас ардчилалд хүрэх зам // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 4</p> <p>Үндсэн хууль оршино гэдэг нь Үндсэн хууль гэсэн нэртэй бичвэр байхын нэр биш юм.Төр эрх мэдлээ намд алдсан нь</p> | <p>4. 33-р зүйлийн 1.2 өөрчлөн найруулах</p> <p>5. Ерөнхийлөгчийн засаг бол хадны мангаа зөвхөн холбооны улсад хааяа байж болдог хэлбэр гэсэн буруу төсөөллөөс салж, түүнд шилжих явдал мөн /ҮХ- 33/</p> |

| | | | |
|-----------|--|--|--|
| <p>6.</p> | <p>22-2 Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана. /5/</p> | <p>1. Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Санаачлагчдын тайлбараас //ЗМ 1999.12.28 № 265 /265/ 2 2.Үндсэн хуулийг өөрчлөх нь засгийн эрхэнд хэн ямар нам гарахтай хамаагүй // ЗМ 1999.12.24 № 262 /262/ 1. 2 а. УИХ-ын гишүүн П. Жасрай Үндсэн хуульд өөрчлөлт хийх нь албан тушаалын мэт харагдаж байж болох юм. б. УИХ-ын гишүүн Ж.Бямбадорж : Төрийн тогтолцоог боловсронгуй болгож, төрийн машиныг зөв ажиллуулъя гэвэл өөрчлөлт зайлшгүй в. УИХ-ын гишүүн Ц. Өөлд: Засгийн газар олон удаа огцорлоо. Энэ дутагдлуудыг арилгахад чиглэсэн заалтуудыг хийсэн 3. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цагийн үеийн захиалга. // ЗМ 2000.12.13 № 292/559/ 1.2 8 хүн: Л.Рэнчин, Н.Лувсанжав, С.Цэрэндорж, Ш.Түдэв, Я. Шуурав, Г.Чулуунбаатар Ерөнхийлөгч олон удаа татгалзаж тэдгээрийн үр дагавар болж төрийн тасралтгүй шууд үйл ажиллагаа алдагдаж байгаа явдлууд давтагдахгүй байх боломж бүрдэнэ. Хуримтлагдсан зөрчилт нөхцөл байдлыг шийдвэрлэх учирзүйн үүднээс 4. Л. Одончимэд. Социализмын үеийн хуульчдын гараар бүтсэн гэхэд Үндсэн хууль сайн болсон Э.Өнөр. // ЗМ 2010.01.12. 2,7 Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бие даасан эдийн засгийн цогц байх тухай заалт хэрэгжихгүй байна. 5. Н. Лүндэндорж. Олигархийн дарангуйллаас ардчилалд хүрэх зам // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 4 Үндсэн хууль оршино гэдэг нь Үндсэн хууль гэсэн нэртэй бичвэр байхын нэр биш юм. Төр эрх мэдлээ намд алдсан нь</p> | <p>1. УИХ-ын 65 гишүүний оруулсан санаачилсан төслөөр 7 нэмэлт өөрчлөлт оруулсан байна Санаачлагчдын тайлбараас.../ҮХ- 22-1/ Гэтэл Монгол төрийг боловсронгуй болгох том агуулга явж байгаа 2. а.Төрийн тогтолцоог боловсронгуй болгох, б.Өөрчлөлт хийх нь зөв 3. 22- р зүйлийн 2, заалт нэмэх 4. Одоо өөрчилвөл юуны өмнө хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын ялгааг сэргээж өгөх хэрэгтэй. 5. Марксист сэтгэлгээний эмгэгээр монголчилсон төрийн удирдлагын парламентийн хэлбэрийг сонгодог төрхөөр нь дахин байгуулах</p> |
| <p>7.</p> | <p>39-2 Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ /15/</p> | <p>1. Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Санаачлагчдын тайлбараас //ЗМ 1999.12.28 № 265 /265/ 2 2.Г. Совд Үндсэн хууль өөрчилнө гэдэг маш осолтой зүйл. // ЗМ 1999.11.1 № 216/216/ 2 Үндсэн хууль өөрчилнө гэдэг маш осолтой зүйл, засгийн газар олон дахин өөрчлөгдөхөд манайхан их хямарсан / ҮХ- 39-2 / 3. Б. Оюун-эрдэнэ Үндсэн хуулийг өөрчлөхөд намууд бус бүлэглэлүүд саад болж мэднэ // ЗМ 1999.12.20 № 257, 258 1. 2 Үндсэн хууль бүрхэг гэсэн шалтаг олж чадсан 4. Н. Энхбаяр Үндсэн хуулийн заалтууд тодорхой биш тул эрх ашгийн бүлэглэлүүд тоглоод байна. /Ярилцсан Г. Эрдэнэбат. // ЗМ 1999.12.24 № 262 /262/ 2 Үндсэн хуульд оруулахаар тохиролцсон өөрчлөлтүүд Монголын төр гацалгүй тотмол, байнга тууштай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна /ҮХ- 39-2 /</p> | <p>1, УИХ-ын 65 гишүүний оруулсан санаачилсан төслөөр 7 нэмэлт өөрчлөлт оруулсан байна Санаачлагчдын тайлбараас.../ҮХ- 39-2/ 2.Хууль нь тогтвортой улсад засгийн газар нь хичнээн ч солигдсон ч дараагийн Засгийн газар хуулиа хэрэгжүүлнэ шүү дээ. Засгийн газар хэдий тогтвортой байдаг ч хуулиа дураараа өөрчилдөг бол олон улс гүрэн манайд итгэх аргагүй болно. /ҮХ- 39-2 / 3. Намууд мөн ийм 10 шахам зүйлийн өөрчлөлт хийх санал тавьж байна. Үүнд : Засгийн газрыг байгуулах тухай.../ ҮХ- 39-2 / 4. Ард түмэн биднийг ажлаа хийж чадахгүй бол тар гэдэг. Бид чухам үүнд нийцсэн өөрчлөлтийг хийхийг хүсэж байна.</p> |



| | | |
|--|--|--|
| | <p>5. Ц. Нямдорж. Цэц энэ үгийг ингэж ойлгож байна гэж асуудлыг шийддэг байгууллага биш /Ярилцсан Д.Отгонбаяр // ЗМ 2000.3.23 № 68 /335/ 3</p> <p>ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийг ямар нэгэн аргаар хүчингүй болгох гэсэн улс төрийн сонирхол цаад талд нь байна. Өөр юм энд юу ч байхгүй.</p> <p>6. Б. Ууган. Үндсэн хуулийн цэц улс төрийн байгууллага болчихоо юу даа. // ЗМ 2000.3.23 № 68 /335/ 2</p> <p>Үндсэн хуулийн өөрчлөлтийн энэхүү асуудал Үндсэн хуулийн тодорхойгүй бүрхэг заалтуудаас шалтгаалсан...</p> <p>7.Ц. Шаравдорж Цэц өөрөө хуулийг зөрчлөө. /Ярилцсан Л. Цог. // ЗМ 2000.3.28 № 72 /339/ 1.2</p> <p>Цэц ийм алхам хийснээрээ МУ-ын ҮХ-д халдаж, түүнийг зөрчлөө гэж үзэж байна.</p> <p>8. Н. Лүндэндорж. Олигархийн дарангуйллаас ардчилалд хүрэх зам // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 4</p> <p>Үндсэн хууль оршино гэдэг нь Үндсэн хууль гэсэн нэртэй бичвэр байхын нэр биш юм. Төр эрх мэдлээ намд алдсан нь</p> <p>9. Д. Гарам Үндсэн хуульд долоон зүйлийн нэмэлт орлоо Зууны мэдээ 24 цаг 1999.12.24 № 263 /263/ 2</p> <p>Ерөнхий сайдад нэр дэвшигч дээр тохиролцож чадалгүй хагас жил шахуу болсон болсон олны бухимдалыг төрүүлсэн Нөгөөтэйгүүр сөрөг хүчин өөрийнхөө эрх үүргийн дагуу энэ явдлыг шүүмжилж, улмар гарах гарц нь УИХ өөрөө тарах явдал</p> <p>10. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цагийн үеийн захиалга. // ЗМ 2000.12.13 № 292/559/ 1.2 8 хүн: Л.Рэнчин, Н.Лувсанжав, С.Цэрэндорж, Ш.Түдэв, Я. Шуурав, Г.Чулуунбаатар</p> <p>Ерөнхийлөгч олон удаа татгалзаж тэдгээрийн үр дагавар болж төрийн тасралтгүй шууд үйл ажиллагаа алдагдаж байгаа явдлууд давтагдахгүй байх боломж бүрдэнэ.</p> <p>Хуримтлагдсан зөрчилт нөхцөл байдлыг шийдвэрлэх учирзүйн үүднээс</p> <p>11. Э. Бат - үүл Ардын их хурал // ЗМ 2007.1.15 № 11 /2457/ 10</p> <p>Хянаваас, АИХ хэмээх дээд танхимтай парламент нь ардчиллын өсөлт бойжилтод дэм болохоосоо хор болж мэдэхээр төлөвтэй</p> <p>12. Б. Түвшинтөгс Үндсэн хуульд үрчлээ суух болоогүй // ЗМ 2007.1.12 № 9 /2457/ 10</p> <p>Үндсэн хуулиа хир буртаггүй байлгах ариун үйлсэд нэгтэх</p> <p>13. Л. Одончимэд. Социализмын үеийн хуульчдын гараар бүтсэн гэхэд Үндсэн хууль сайн болсон Э.Өнөр. // ЗМ 2010.01.12. 2,7</p> <p>Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бие даасан эдийн засгийн цогц байх тухай заалт хэрэгжихгүй байна.</p> | <p>5. Арай гэж зөвшилцөлд хүрсэн юмыг үл ялих шалтгаар нурааж хойшлуулна гэдэг Монголын төр сайн юм болохгүй.</p> <p>6. Засгийн газар огцорсон тохиолдолд Ерөнхий сайд, Засгийн газрын танхимыг бүрэлдүүлж чадахгүй удааширч, төрийн алба зогсолтод ордгийг давтахгүй байхыг ҮХ-ийн нэмэлтээр хаасан/ҮХ-39-2/</p> <p>7. Үндсэн хуульд ер нь томоохон өөрчлөлт хийх шаардлагатай. Төрийн тогтолцоо..... Засгийн газар...../ҮХ- 39-2/</p> <p>8. . Марксист сэтгэлгээний эмгэгээр монголчилсон төрийн удридлагын парламентийн хэлбэрийг сонгодог төрхөөр нь дахин байгуулах</p> <p>9. УИХ-д суудалтай намуудын тэргүүн нар зөвшилцсөний дагуу ҮХ-д 7 зүйлийн нэмэлт орлоо:</p> <p>10. 39- р зүйлийн 2, нэмэлт оруулах</p> <p>11. Парламентын дээд танхим АИХ байх үед депутат хэмээх мэдээллийн байнгын амьд уг сурвалжаар дамжуулан олон түмэн төрийн бодлогын нарийн ширийнийг мэдэж ойлгож авах боломж өргөн байсан...../ҮХ- 39-2/</p> <p>12. Парламентын засаглал илүү /ҮХ-39-2/</p> <p>13. Одоо өөрчилвөл юуны өмнө хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын ялгааг сэргээж өгөх хэрэгтэй. /ҮХ- 39-2/</p> |
|--|--|--|

| | | | |
|----|---|---|---|
| | | <p>14. Д. Готов. Улс төрийн тогтолцоо зөвхөн мөнгөн дээр тулгуурлаж байна. // ЗМ 2010.02.02 № 27. 5 МУ ҮХ-ндаа зохих өөрчлөлт оруулах замаар зах зээлийг, хөгжлийн жолоог зөв залж, гарсан алдаа дутагдлаа засах шаардлага байна.</p> <p>15. Нарангэрэл С. Засгийн газрыг огцруулсан тогтоол Үндсэн хуулийн олон заалтыг зөрчсөн. УИХ Үндсэн хууль зөрчсөн // ЗМ 1999.8.18. №159 /159/ 1, 2</p> <p>Үндсэн хуулийн 66-р зүйлийн 2 дахь хэсгийн 4 –рт ерөнхийлөгч ерөнхий сайдыг огцруулах асуудлаар онцгой эрх тогтоосныг шүүмжилж</p> | <p>14.- Одоогийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөө</p> <p>-Улс төрийн тогтолцоог өөрчлөө</p> <p>-Төрийн удирдлагын системд өөрчлөлт оруулахаар хуулиа өөрчлөө</p> <p>-улс төрийн намуудын үйл ажиллагаа хэм хэмжээг тогтоож өгье</p> <p>-Төр засгийн үйл ажиллагаанд зарим чиглэлээр эрх үүргийг нь өргөтгөө</p> <p>15. УИХ нь ерөнхий сайдыг болон засгийн газрыг огцруулах асуудлаар Үндсэн хууль зөрчсөн</p> |
| 8. | <p>5.5 Мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалтанд байна. /2/</p> | <p>1. Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна. Харин монгол хүн... 2010.01.09 № 10. 6, 7</p> <p>Эрүүл, аюулгүй амьдрах, орон гэргүй иргэд, хараа хяналтгүй хүүхдийн тоо</p> <p>2. Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна 2011.01.09. № 10 6,7</p> <p>-Хаягаа монголоор бичсэн газар ховор</p> <p>-Гэмт хэргийн улмаас 2011 онд 1191 хүний халуун амь үрэгдсэн.</p> <p>-Өнөөдөр монгол орон гэргүй иргэд, хараа хяналтгүй хүүхдийн тоо өдрөөс дөрт нэмэгдсээр байна</p> | <p>1. Хүний эрх зөрчигдөж байна.</p> <p>2. -Төрийн албан ёсны хэл монгол хэл</p> <p>-амьд явах эрх баталгаа</p> <p>-ажиллах амрах, амьдрах орчин, хүний эрх зөрчигдөж байна.</p> |
| 9. | <p>57-1 “МУ-ын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг хороонд хуваагдана.” /3/</p> | <p>1. Л. Одончимэд. Социализмын үеийн хуульчдын гараар бүтсэн гэхэд Үндсэн хууль сайн болсон Э.Өнөр. // ЗМ 2010.01. 12. 2,7</p> <p>Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бие даасан эдийн засгийн цогц байх тухай заалт хэрэгжихгүй байна</p> <p>2. Д. Готов. Улс төрийн тогтолцоо зөвхөн мөнгөн дээр тулгуурлаж байна. // ЗМ 2010.02.02 № 27. 5 МУ ҮХ-ндаа зохих өөрчлөлт оруулах замаар зах зээлийг, хөгжлийн жолоог зөв залж, гарсан алдаа дутагдлаа засах шаардлага байна.</p> <p>3. А. Цоож Үндсэн хуулийн зарим заалтыг эргэж харъя // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 8</p> <p>Тэгэхдээ үндсээр нь өөрчилнө гэсэн үг биш бөгөөд агуулгыг нь хэвээр хадгалж, зарим заалтыг өөрчлөн шинэчлэх нь зүйтэй болов уу</p> | <p>1. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж нь бие даасан эдийн засгийн цогц байх тухай заалт хэрэгжихгүй байгаа /ҮХ- 57,58/</p> <p>Хотын статусыг хуульд оруулж, нийслэл болоод орон нутгийн хотуудын эрхийг баталгаажуулах өөрчлөлт хийх хэрэгтэй</p> <p>2.- Одоогийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөө / ҮХ- 57/</p> <p>-Улс төрийн тогтолцоог өөрчлөө</p> <p>-Төрийн удирдлагын системд өөрчлөлт оруулахаар хуулиа өөрчлөө</p> <p>-улс төрийн намуудын үйл ажиллагаа хэм хэмжээг тогтоож өгье</p> <p>-Төр засгийн үйл ажиллагаанд зарим чиглэлээр эрх үүргийг нь өргөтгөө</p> <p>3. -Төрийн байгууллалтын тогтолцоо.</p> <p>-Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын талаар нилээд өөрчилж /ҮХ- 57/</p> |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|-------------|--|---|
| 10. | УХ- 21-1 | <p>1. Ж. Амарсанаа Хамгаалагчийн үүрэг маань мэргэн буучийн төвшинд очсон. Ерөнхий сайдын ажлыг хийж үзсэн гэхэд болно // ЗМ 1999.10.11 № 197 2, 3 Үндсэн хуулийн өөрчлөлт хийхэд сайн ойлголгүй бужигнаан дунд биш, улс төрийн цар хүрээтэй цогц бодлоготой уялдуулж байж өөрчилж болох /УХ- 21-1/ 2. Н. Лүндэндорж. Олигархийн дарангуйллаас ардчилалд хүрэх зам // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 4 Үндсэн хууль оршино гэдэг нь Үндсэн хууль гэсэн нэртэй бичвэр байхын нэр биш юм. Төр эрх мэдлээ намд алдсан нь 3. Б. Цогтгэрэл Үндсэн хуулийг өөрчлөх эдийн засгийн үндэслэл /Цуврал./ // ЗМ 2009.12.17 № 294 (3366) 3, Өөрчлөх нь зөв 4. А. Цоож Үндсэн хуулийн зарим заалтыг эргэж харъя // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 8 Тэгэхдээ үндсээр нь өөрчилнө гэсэн үг биш бөгөөд агуулгыг нь хэвээр хадгалж, зарим заалтыг өөрчлөн шинэчлэх нь зүйтэй болов уу</p> | <p>1. УИХ-ын гишүүдийг цөөлөхөөс / УХ- 21/ эхлээд засгийн эрх мэдлийг зөв тэнцвэржүүлэхэд чиглэсэн өөрчлөлт хийх шаардлага бий.</p> <p>2. Марксист сэтгэлгээний эмгэгээр монголчилсон төрийн удирдлагын парламентийн хэлбэрийг сонгодог төрхөөр нь дахин байгуулах /УХ- 21-1/ 3. 21-р зүйлийн 2 УИХ-ын гишүүнийг МУ-ын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ,..... 4. Монгол улсын төрийн тогтолцоог өөрчлөх</p> |
| 11. | УХ-12-3 /2/ | <p>1.Ц. Ойдов Чиний сүлдийг таван жилийн дараа солино гэж хэлж байлаа Ярилцсан Ц. Цолмон // ЗМ 2002.1.12 № 10 /896/ 2 Долоо хоногийн дотор 10-аад хубилбар зураад ажлын хэсэгт өгчихлөө. Шөнөдөө 3 удаа зурдаг байсан. Сүлд бүтсэн түүхээс. 2. А. Цоож Үндсэн хуулийн зарим заалтыг эргэж харъя // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 8 Тэгэхдээ үндсээр нь өөрчилнө гэсэн үг биш бөгөөд агуулгыг нь хэвээр хадгалж, зарим заалтыг өөрчлөн шинэчлэх нь зүйтэй болов уу.</p> | <p>1. -Төрийн сүлд хамгийн их шүүмжлэл дагуулсан /УХ-12-3/ - Төрийн сүлдийг өөрчлөх /УХ- 12.3 /</p> <p>2. -Төрийн байгууллалтын тогтолцоо. -Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын талаар нилээд өөрчилж /УХ- 57/</p> |
| 12. | УХ- 16 /4/ | <p>1. Б. Чимид Хүний эрхийг хангах асуудлын төв, орон нутгийн засаг захиргааны байгууллага хариуцах ёстой 2002.1.14 № 11, 12 /897,898/ 6 Хамгийн ноцтой зөрчигдөж байгаа эрх нь хувь хүний эрх юм /УХ- 16/ 2. Хүний эрх ба үндсэн хууль онолын бага хурал 2002.1.14 № 11, 12 /897,898/ 6 Хүн хоорондоо сөргөлдөж, биенийхээ эрхийг зөржих явдал бол нийгмийн зохистой орчин бүрдээгүй, хүмүүсийн ухамсар дорой гэдэг ч юмуу. 3. Ж. Содоншагай. Үндсэн хуулийн төрсөн өдрийн бялууны амт. 2010.1.12. № 8. 1, 3 Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө чадвал олж аваад, чадахгүй бол хадмынхаа хаяанд амдрах эрхтэй. 4. Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна. Харин монгол хүн... 2010.01.09 № 10. 6, 7 -Хаягаа монголоор бичсэн газар ховор -Гэмт хэргийн улмаас 2011 онд 1191 хүний халуун амь үрэгдсэн. -Өнөөдөр монгол орон гэргүй иргэд, хараа хяналтгүй хүүхдийн тоо өдрөөс дөрт нэмэгдсээр байна</p> | <p>1. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр гэдэг боловсруулж гаргана. /УХ- 16/ 2. хүний эрх /УХ- 16/ 3. Хүний эрх /УХ- 16/ 4. Хүний эрх зөрчигдөж байна. /УХ- 16/ • -Төрийн албан ёсны хэл монгол хэл • -амьд явах эрх баталгаа • -ажиллах амрах, амьдрах орчин, хүний эрх зөрчигдөж байна.</p> |

| | | | |
|-----|-------|---|---|
| 13. | Бусад | 1. А. Цоож Үндсэн хуулийн зарим заалтыг эргэж харья // ЗМ 2007.1.08 № 5 /2453/ 8 Тэгэхдээ үндсээр нь өөрчилнө гэсэн үг биш бөгөөд агуулгыг нь хэвээр хадгалж, зарим заалтыг өөрчлөн шинэчлэх нь зүйтэй болов уу | 1. -Төрийн байгууллалтын тогтолцоо. -Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын талаар нилээд өөрчилж /ҮХ- 57/ |
| 14. | | Б. Цогтгэрэл Үндсэн хуулийг өөрчлөх эдийн засгийн үндэслэл /Цуврал/. // ЗМ 2009.12.17 № 294 (3366) 3, 7 Монгол нийгмийн өнөөгийн дүн төрх, түүний хандлага нь шинжлэх ухааны үндэслэл гаргах гэж оролдсон билээ. Эцэст нь ҮХ өөрчлөхөөс өөр аргагүй байна гэдэг дүгнэлт хийсэн. | 31-р зүйлийн МУ-ын Ерөнхийлөгчийг нийт ард түмнээр сонгож байгаа ч эрх хэмжээ нь бага 31-р зүйлийн 2 МУ-ын Ерөнхий сайд, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд түүнд өөрчлөлт оруулах.... |

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй

| № | Эх сурвалж | Гарсан шүүмжлэл | Дэвшүүлсэн санаа |
|----|--|--|---|
| 1. | Нарангэрэл С. Засгийн газрыг огцруулсан тогтоол Үндсэн хуулийн олон заалтыг зөрчсөн. УИХ Үндсэн хууль зөрчсөн 1999.8.18. №159 /159/ 1, 2 | Үндсэн хуулийн 66-р зүйлийн 2-4 –рт ерөнхийлөгч ерөнхий сайдыг огцруулах асуудлаар онцгой эрх тогтоосныг шүүмжилж | УИХ нь ерөнхий сайдыг болон засгийн газрыг огцруулах асуудлаар Үндсэн хууль зөрчсөн |
| 2. | Г. Совд Үндсэн хууль өөрчилнө гэдэг маш осолтой зүйл. 1999.11.1 № 216/216/ 2 | Үндсэн хууль өөрчилнө гэдэг маш осолтой зүйл, засгийн газар олон дахин өөрчлөгдөхөд манайхан их хямарсан /ҮХ- 39-2 / | Хууль нь тогтвортой улсад засгийн газар нь хичнээн ч солигдсон ч дараагийн Засгийн газар хуулиа хэрэгжүүлнэ шүү дээ. Засгийн газар хэдий тогтвортой байдаг ч хуулиа дураараа өөрчилдөг бол олон улс гүрэн манайд итгэх аргагүй болно. / ҮХ- 39-2 / |
| 3. | Н. Багабанди. УИХ хариуцлагаа ерөнхийлөгчид тохох гэж байна хэмээн үзжээ 2000.1.5 № 03/270/ 2 | Үндсэн хуулийн өөрчлөлтийг: манай улсад албан ёсоор үйл ажиллагаа явуулдаг 20 намын 17-д дуулгаагүй, засгийн эрхийг барьдаг сонгогчид санал бодлоо хэлэх боломж олгоогүй.. явцуу хүрээнд хийгджээ. | Хориг тавьсан үндэслүүдээ тайлбарласан : 33-р зүйлийн 1- 2 29-р зүйлийн 1 Зарим заалт бусад заалтуудтай харшилсан нь хөнгөн гоомой хандсаныг нотолж байгаа эдгээр үндэслэлийг анхааралдаа авч, үндсэн хуулийнхаа нийт агуулгаар сэтгэж тал талаас нь шүүн хэлэлцэж, УИХ-д бүрэн эхээр нь танилцуулж, Монголын ард түмний язгуур эрх ашигт чанд нийцүүлэн шийдвэрлэнэ гэж найдаж байгаагаа илэрхийлжээ |
| 4. | Х. Цэвлээ Төрийг түвээдэг Хорт могойн хорлол гэж байдаг юм билээ 2000.1.5 № 03/270/ 3 | Зөвшилцөж гэдэг энэхүү ухаалаг мөртлөө танхай үгийг амьдралд хэрэгжүүлэх механизм нь харилцан санал солилцож тохиролцоонд хүрч болох..... ҮХ-ийн 33-р зүйлийн 1. 2-т ... дотор эсвэл гэсэн шинээр нэмсэн | |
| 5. | Б. Ууган. Үндсэн хуулийн цэц улс төрийн байгууллага болчихоо юу даа. 2000.3.23 № 68 /335/ 2 | ҮХ-ийн өөрчлөлтийн энэхүү асуудал ҮХ-ийн тодорхойгүй бүрхэг заалтуудаас шалтгаалсан... | МУ-ын Ерөнхий сайд, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах.... |
| 6. | Н. Энхбаяр МАХН Үндсэн хуульд дангаараа өөрчлөлт оруулахгүй. Ярицсан Г. Эрдэнэбат 2000.11.29 № 280/547/ 2. | Цэц ҮХ-д оруулсан өөрчлөлтийн агуулгын талаар ямар нэг маргаан байхгүй гэдэг. Харин процедурын алдаа гаргасан гэж үздэг | МАХН Үндсэн хуульд дангаараа өөрчлөлт оруулахгүй. 7 өөрчлөлтийг дахин өргөн барихаас өөр арга байхгүй |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|---|--|---|
| 7. | Энхсайхан М. Цэц үндсэн хуулийн манаач болохоос зохиогч биш.: Одоогийн хуультайгаа 2000 оны сонгуульд орохоос өөр арга байхгүй 2000.4.3. № 76 /343/ 1 | Үндсэн хуульд орж өөрчлөлтийг үзэл санааных нь хувьд би дэмжиж чадахгүй байгаа юм. | Өөрчлөлт оруулах боломжгүй |
| 8. | Н. Жанцан Цэцийн шийдвэр эцсийнх байна. /Ярилцсан Л. Цог/ 2000.7.18 № 166/433/ 1.2 | ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулиар зааж тогтоож өгсөн дэг жаягийг хатуу сахих ёстой | Цэцийн шийдвэр эцсийнх байна. |
| 9. | Хууль батлах эрхээсээ анх удаа татгалзав 2000.12.15 № 294/561/ 1. | Парламентийн цөөнхийн гишүүдийг: Нэмэлт өөрчлөлтийг 2-р хэлэлцүүлэгт шилжүүлсэн юм. Энэ үеэр гишүүдийг асуулт тавьж санал хэлэх боломж олгоогүй нь ийнхүү мэдээлэл хийхэд хүргэжээ. | Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлахад оролцогчийг гэж..... Б.Эрдэнэбат, С. Оюун, Л.Гүндалай, Ж.Наранцацралт |
| 10. | Б. Чимид Мэдэгтүн, сахигтун гэдэг чинь үндсэн хуулийн туйлын хүслэн /Ярилцсан Д. Отгонбаяр 2002.1.11 № 9 /895/ 3 | Шинэ хуучин намуудын хардлага. Гадаадынхны хэлснийг жа жа гээд хуулчихсан гэж ойлгож болохгүй | Газрын реформыг үндсэн хууль гарсны дараа шууд хийчихсэн бол ингэж будилахгүй л байсан болов уу. Мэдэгтүн, сахигтун гэдэг чинь Үндсэн хуулийн туйлын хүслэн |
| 11. | Н. Жанцан Ард түмний өмчид эзнээс нь асууж байж халдах ёстой . Ярилцсан Н. Наран. 2005. 01.13. № 10 (1833) 1, 3 | Хэн нэгэн албан тушаалтанд таалагдаагүй юмуу эсвэл хуулийн сахилгыг өөрсдийн мугаас сахиж чадаагүйгээ ҮХ-аас болсон мэт ойлгох, эсхүл эрх мэдлээ нэмэхэд чиглэсэн заалтуудын тухайд маш болгоомжтой хандах шаардлагатай. | Үндсэн хуульд орсон нэг шинэ санаа бол хүн бүхэн дээдэлж, хуулийн өмнө хүн бүхэн тэгш эрхтэй байх ёстой |
| 12. | Ц. Сарантуяа Хөгжлөөс түрүүлдэг ч түүнийгээ даган боловсронгуй болдог хууль. 2005.01.13. № 10 (1833) 4 | Төрийн чанар өөрчлөгдөж эсхүл алдагдаж огт өөр төр болж хувирсны эцэст ҮХ-ийг өөрчлөх гэдэг нь цоо шинэ Үндсэн хууль бий болохыг хэлнэ. | Нийгмийн хөгжлийн явцад нарийвчилсан зохицуулалт шаардлагатай үед Үндсэн хуульд өөрчлөлт оруулах боломжтой ҮХ-ийг өөрчлөх гэдэг нь цоо шинэ Үндсэн хууль бий болохыг хэлнэ. |
| 12. | В. Удвал Миний цуглуулга - Үндсэн хууль Ярилцсан Л. Марал 2007.1.12 № 9 /2457/ 10 | 2000 онд оруулсан ҮХ- ийн нэмэлт өөрчлөлт шиг нуухыг нь авах гээд нүдийг сохлов гэдэг шиг ардчилсан зарчмыг алдагдуулсан | Ийм өөрчлөлтийг дахин хийж болохгүй ээ. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуульгүйгээр үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт хийх боломжгүй |
| 13. | Б. Түвшинтөгс Үндсэн хуульд үрчлээ суух болоогүй 2007.1.12 № 9 /2457/ 10 | Үндсэн хуулиа хир буртаггүй байлгах ариун үйлсэд нэгтэх | Парламентын засаглал илүү /ҮХ-39-2/ |
| 14. | Б. Хаш Үндсэн хуулийн төлөө холбоо байгууллалаа.: Үндсэн хуулийн өөрчлөлтийг хүчингүй болгохын төлөө 2007.1.15 № 11 /2459/ 2 | Иргэний нийгмийн төлөөлийг багасган , УИХ-аар дамжуулж олигархууд засгийн газарт шургалах боломжийг олгосон гэж депутатууд үзэж байна. | 2000 онд оруулсан ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгохын төлөө ажиллана. Өөрчлөлт оруулахаа түр азнах |
| 15. | В. Удвал Нэмэлт өөрчлөлтөд үндсэн хуулийн суурь зарчмаас гажсан зүйл бий. 2008.07.31 № 182 (2942) 1,3 | Нэг буруу жишиг тогтвол тэр нь цаашаа үргэлжилнэ. Гишүүд тангаргаа өргөж чадахгүй байгаа нь явж явж сонгуулийн маргаантай холбоотой.. | Өөрчлөлтөд үндсэн хуулийн суурь зарчмаас гажсан зүйл бий. |
| 16. | С. Оюун Үндсэн хуулийг хоёр намын зөвшилцлөөр өөрчилдөггүй. 2008.08.01 № 183 (2943) 2 | Үндсэн хуулийг хоёр намын зөвшилцлөөр өөрчилдөггүй. | Үндсэн хуулийг намын зөвшилцлөөр өөрчилдөггүй. |
| 17. | Д. Отгонбаяр 'Намууд тохиролцоод үндсэн хуульд гар хүрдэг зөв жишиг үү... Отгонбаяр Д.' 2008.08.04 № 185 (2945) 1,3 | Үндсэн хуулийг хоёр намын зөвшилцлөөр өөрчилдөггүй | Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг буцааж болно. Гэхдээ энэ нь нэг талаасаа МАХН АН 2 зөвшилцсөнөөр хийдэг зүйл биш. |

| | | | |
|-----|--|---|---|
| 18. | Д. Отгон баяр. Загас толгойноосоо.... | Нэмэлт өөрчлөлтөөр 76 гишүүний олонхи буюу 39 нь байхад хурлын ирц бүрдлээ гэж үздэг..19-20 гишүүн хууль баталж, энэ мэт өөрчлөлт оруулж байна | Энэ бол үндсэн хуль суурь зарчмаас гажсан төдийгүй төлөөллийн ардчилалдаа эргээд сөргөөр нөлөөлхүйц зүйл |
| 19. | Л. Дашням Монгол төрийн нуруун дээр нэг биш, нэг хэсэг нам “Мордчихсон” 2010.1.13. №9 11, | Төрийн үйл ажиллагаа гэхэд тогтвортой бус засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилт монголчуудын амьдралд бодит өөрчлөлт авчирч чадахгүй байна. Авилга газар авсан. Ядуурал 30-40 хувиасаа буурахгүй байна. Хүн ард маань эрүүл орчинд, эрүүл саруул аж төрж чадахгүй байна. | Үндсэн хууль шинэчлэгдэж болно гол нь нуухыг нь авах гээд нүдийг сохолж болохгүй. Өөрчлөгдөхөд хүрвэл бид бас оролцохыг эрмэлздэг Үндсэн хуулийнхаа утга агуулга, бүтээгч шинэчлэгч хүчин оролцоог бид хамгаалах л болно. |
| 20. | Ц. Сарантуяа Хөгжлөөс түрүүлдэг ч түүнийгээ даган боловсронгуй болдог хууль. 2005.01.13. № 10 (1833) 4 | Төрийн чанар өөрчлөгдөж эсхүл алдагдаж огт өөр төр болж хувирсны эцэст ҮХ-ийг өөрчлөх гэдэг нь цоо шинэ Үндсэн хууль бий болохыг хэлнэ. | Нийгмийн хөгжлийн явцад нарийвчилсан зохицуулалт шаардлагатай үед Үндсэн хуульд өөрчлөлт оруулах боломжтой ҮХ-ийг өөрчлөх гэдэг нь цоо шинэ Үндсэн хууль бий болохыг хэлнэ. |

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

| № | Эх сурвалж | Гарсан шүүмжлэл | Дэвшүүлсэн санаа |
|----|---|---|--|
| 1. | Ж. Амарсанаа Хамгаалагчийн үүрэг маань мэргэн буучийн төвшинд очсон. Ерөнхий сайдын ажлыг хийж үзсэн гэхэд болно 1999.10.11 № 197 2, 3 | ҮХ-ийн өөрчлөлт хийхэд сайн ойлголгүй бужигнаан дунд биш, улс төрийн цар хүрээтэй цогц бодлоготой уялдуулж байж өөрчилж болох /ҮХ- 21-1/ | УИХ-ын гишүүдийг цөөлөхөөс /ҮХ- 21/ эхлээд засгийн эрх мэдлийг зөв тэнцвэржүүлэхэд чиглэсэн өөрчлөлт хийх шаардлага бий. |
| 2. | Б. Оюун-эрдэнэ Үндсэн хуулийг өөрчлөхөд намууд бус бүлэглэлүүд саад болж мэднэ 1999.12.20 № 257, 258 1. 2 | Төрийн засаглалын хэлбэрийг өөрчлөх түүний тогтвортой байдлыг хангахад чиглэсэн заалтууд | Намууд мөн ийм 10 шахам зүйлийн өөрчлөлт хийх санал тавьж байна. Үүнд : Засгийн газрыг байгуулах тухай.../ҮХ- 39-2 / |
| 3. | Н. Энхбаяр Үндсэн хуулийн заалтууд тодорхой биш тул эрх ашгийн бүлэглэлүүд тоглоод байна. /Ярилцсан Г. Эрдэнэбат.1999.12.24 № 262 /262/ 2 | ҮХ-д оруулахаар тохиролцсон өөрчлөлтүүд Монголын төр гацалгүй тогтмол, байнга тууштай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна /ҮХ- 39-2 / | Ард түмэн биднийг ажлаа хийж чадахгүй бол тар гэдэг. Бид чухам үүнд нийцсэн өөрчлөлтийг хийхийг хүсэж байна. |
| 4. | Үндсэн хуулийг өөрчлөх нь засгийн эрхэнд хэн ямар нам гарахтай хамаагүй 1999.12.24 № 262 /262/ 1. 2 | 1. УИХ-ын гишүүн П. Жасрай Үндсэн хуульд өөрчлөлт хийх нь албан тушаалын мэт харагдаж байж болох юм. 2. УИХ-ын гишүүн Ж.Бямбадорж : Төрийн тогтолцоог боловсронгуй болгож, төрийн машиныг зөв ажиллуулъя гэвэл өөрчлөлт зайлшгүй в. УИХ-ын гишүүн Ц. З. 3.Өөлд: Засгийн газар олон удаа огцорлоо. Энэ дутагдлуудыг арилгахад чиглэсэн заалтуудыг хийсэн | 1.Гэтэл Монгол төрийг боловсронгуй болгох том агуулга явж байгаа 2. Төрийн тогтолцоог боловсронгуй болгох ... 3.Өөрчлөлт хийх нь зөв |
| 5. | Д. Гарам Үндсэн хуульд долоон зүйлийн нэмэлт орлоо Зууны мэдээ 24 цаг 1999.12.24 № 263 /263/ 2 | Ерөнхий сайдад нэр дэвшигч дээр тохиролцож чадалгүй хагас жил шахуу болсон болсон олны бухимдалыг тэрүүлсэн Нөгөөтэйгүүр сөрөг хүчин өөрийнхөө эрх үүргийн дагуу энэ явдлыг шүүмжилж, улмар гарах гарц нь УИХ өөрөө тарах явдал | УИХ-д суудалтай намуудын тэргүүн нар зөвшилцсөний дагуу ҮХ-д 7 зүйлийн нэмэлт орлоо: |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|--|---|--|
| 6. | Үндсэн хуулийг өөрчилснийг буруутгаж улс төрийн хожоо хайх утгагүй 1999.12.28 № 265 /265/ 1. 3 | Засгийн газрыг огцруулсантай холбогдуулан хийсэн өөрчлөлт | Зөв өөрчлөлт байсан гэж дэмжсэн санлууд |
| 7. | Монгол улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт: Санаачлагчдын тайлбараас 1999.12.28 № 265 /265/ 2 | Тайлбар | УИХ-ын 65 гишүүний оруулсан санаачилсан төслөөр 7 нэмэлт өөрчлөлт оруулсан байна Санаачлагчдын тайлбараас |
| 8. | Шаардлагатай өөрчлөлтүүд хийгдсэн 2000.1.6 № 04/271/ 2 | Ерөнхийлөгчийн эрхийг зарим талаар хянасан, зарим талаар нэмсэн зүйл бий. УИХ-ын гишүүн Ж.Норовсамбуу, Ц.Өөлд | Дэгийн хуулиар хөөцөлдөөд ч, УИХ-ын хуулиар хөөцөлдөөд ч чадаагүй. Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцээд олонхиороо хүлээж авах бололцоогүй гэж үзвэл иргэн ба хуулийн этгээд энэ чиглэлээр ҮХ зөрчсөн асуудлаараа ҮХЦ-д асуудал тавьж болно. |
| 9. | Б. Энэбиш Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт парламентыг төгөлдөржүүлсэн /Ярилцсан Г. Эрдэнэ. 2000.1.6 № 04/271/ 2 | Парламентын засаглалтай мөртлөө Ерөнхийлөгчийн засаглалтай орных шиг ойлгомжгүй заалт ҮХ-д байсныг, мөн тэгж ойлгож байсныг нэмэлт өөрчлөлтөөр нэг мөр болгосон. | Үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаад зарим хуулинд өөрчлөлт орно |
| 10. | Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг УИХ хүлээж авсангүй 2000.1.11 № 08/275/ 2 | Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээж авах эсэх дээр санал хураахад хуралдаанд оролцсон 52 гишүүний 51 нь уг хоригийг хүлээж авах шаардлагагүй хэмээн саналаа өгөв. | |
| 11. | Ц. Шаравдорж Цэц өөрөө хуулийг зөрчлөө. /Ярилцсан Л. Цог. 2000.3.28 № 72 /339/ 1.2 | Цэц ийм алхам хийснээрээ МУ-ын ҮХ-д халдаж, түүнийг зөрчлөө гэж үзэж байна. | Үндсэн хуульд ер нь томоохон өөрчлөлт хийх шаардлагатай. Төрийн тогтолцоо..... засгийн газар...../ҮХ- 39-2/ |
| 12. | Г.Эрдэнэбат Цэц Үндсэн хуулийн өөрчлөлтөд анхнаасаа улс төрийн шалтгаанаар оролцжээ. 2000.7.28 № 175/442/ 1.2 | Ардчилсан холбоо эвслийн 10 гаруй хүн нэмэлт өөрчлөлтийг зөвшөөрөхгүй олон хоносон УИХ-ын дарга Б. Энэбиш. ҮХЦ дүгнэлт гаргахдаа хууль зөрчжээ. Процедурын алдаа гэж юуг хэлэх вэ гэдгийг нарийвчлан зааж өгөөгүй. Ц. Нямдорж, Н.Тогтох: ҮХЦ 02 тоот дүгнэлтийг гаргахдаа хууль зөрчжээ. Цаашдаа ҮХ-д өөрчлөлт оруулах процедурыг тодорхой болгосон хууль санаачлах хэрэгтэй байх | Ц. Нямдорж ҮХ-д ард нийтийн санал асуулгаар болон УИХ-ын 57 гишүүн санал нэгдэн өөрчлөлт оруулдаг. Бид 2 дахь хувилбараар нь өөрчлөлт оруулсан |
| 13. | УИХ-ын гарц буюу цэцийг буланд шахсан давхар нүүдэл. 2000.12. 01 № 282/549/ 2. | Үндсэн хуулийн Цэцийн их суудлын шийдвэр үү. Захиалгат алхам уу | Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг хадгалж үлдэхээр шийдлээ. 65 гишүүн төслийг ҮХ-д оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл 7 заалт |
| 14. | Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь цагийн үеийн захиалга. 2000.12.13 № 292/559/ 1.2 | Хуримтлагдсан зөрчилт нөхцөл байдлыг шийдвэрлэх учирзүйн үүднээс: Л.Рэнчин, Н.Лувсанжав, С. Цэрэндорж, Ш.Түдэв, Я. Шуурав, Г.Чулуунбаатар | 22- р зүйлийн 2, заалт нэмэх 39- р зүйлийн 2, нэмэлт оруулах 24- р зүйлийн 1, 27-р зүйлийн 6, 33-р зүйлийн 1.2, өөрчлөн найруулах 33- р зүйлийн 1.1, 35- р зүйлийн 2, 69- р зүйлийн 1/Олонхиор шийдэж болох/ |
| 15. | Н. Лүндэндорж. Олигархийн дарангуйллаас ардчилалд хүрэх зам 2007.1.08 № 5 /2453/ 4 | Үндсэн хууль оршино гэдэг нь Үндсэн хууль гэсэн нэртэй бичвэр байхын нэр биш юм. Төр эрх мэдлээ намд алдсан нь | 1.Марксист сэтгэлгээний эмгэгээр монголчилсон төрийн удирдлагын парламентын хэлбэрийг сонгодог төрхөөр нь дахин байгуулах /ҮХ- 21-1/ 2. Ерөнхийлөгчийн засаг бол хадны мангаа зөвхөн холбооны улсад хааяа байж болдог хэлбэр гэсэн буруу төсөөллөөс салж, түүнд шилжих явдал мөн /ҮХ- 33/ |

| | | | |
|-----|---|--|---|
| 16. | А. Цоож Үндсэн хуулийн зарим заалтыг эргэж харъяа 2007.1.08 № 5 /2453/ 8 | МУ шилжилтийн үеэ дуусгаж хөгжлийн дараагийн үе шатандаа орж байна. Чухам үүнтэй холбоотойгоор ҮХ-даа нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага урган гарч байгаа билээ. | Тэгэхдээ үндсээр нь өөрчилнө гэсэн үг биш биш бөгөөд агуулгыг нь хэвээр хадгалж, зарим заалтыг өөрчлөн шинэчлэх нь зүйтэй Үндсээр нь зарим заалтыг өөрчлөн шинэчлэх 1. Уламжлалт шашныг тодорхойлж бусад урсгалыг хоргилохгүй байх /ҮХ- 9-1, 2,3/ 2. Төрийн сүлдийг өөрчлөх /ҮХ- 12.3 / 3. Монгол улсын төрийн тогтолцоог өөрчлөх 4. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын талаар нилээд өөрчилж /ҮХ- 57/ |
| 17. | Б. Энэбиш Парламентын засаглал руу хялайх хэрэггүй Ярилцсан Б. Түвшинтөгс 2007.1.11 № 8 /2456/ 13 | Хэлцэх процедур, цаг хугацааны талаар шүүмжлэл гардаг | Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжид харъяалагддаггүй хүн байдаггүй бүх одоогийн хийх гэж буй өөрчлөлтбүх хүнд хамаатай, илүү өргөн асуудал учраас бүх нийтийн хэлэлцүүлэг хийж байж шийдэх нь зөв байх |
| 18. | Э. Бат - үүл Ардын их хурал 2007.1.15 № 11 /2457/ 10 | АИХ хэмээх дээд танхимгүй 76- хан гишүүн бүхий нь нэг танхимтай парламент нь ардчилалын өсөлт бойжилтод дэм болохоосоо хор болж мэдэхээр төлөвтэй байна. | 1. Төрийн дээд эрх мэдлийг харьцангуй цөөн хүний гарт өгөхдөө шийдвэр гаргах хүний тоо хичнээн цөөн байх тусмаа ашиг сонирхлоо нийцүүлэн хуйвалдан тохиролцоо бололцоог олгож, төр олигархижих аюултай 2. Төрийн олигархижилт нь дахин хувиарилах үндэсний орлого огцом өсөх, байгалийн асар их хэмжээний баялаг илэрэн, үүний улмаас асар их авилга, урамшуулал өгөх чадалтай гадаад том улсын хөрөнгө оруулагчид.... 3. Парламентын гишүүдийг цөөдүүлсэн нь тойргийн хэмжээ орон зайн хувьд ч, сонгогчдын тооны томрох шалтгаан болжээ. /ҮХ- 20-1/ 4. Нэг тойргийн хүн амын тоо дунжаар 30000 орчим байгаа нь сонгогчдоос нэр дэвшигчээ таньж мэдэн сонголт хийх чадавхийг ноцтой сулруулсан.... 5. Тухайн үедээ парламентын доод танхим болох Улсын бага хурал нь бүхэлдээ ард түмний шууд төлөөлөл болох... 6... Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэмээн хуваан хувиарилж, харилцан хянан тэнцвэржүүлэх зорилготой төрийн эрх мэдлийн хувиарилалтын зарчим нь Үндсэн хуулийн утгыг ухан хүртэж чадаагүйн уршгаар дорвитой хэрэгжээгүй 7. Парламентын дээд танхим АИХ байх үед депутат хэмээх мэдээллийн байнгын амьд уг сурвалжаар дамжуулан олон түмэн төрийн бодлогын нарийн ширийнийг мэдэж ойлгож авах боломж өргөн байсан...../ҮХ- 39-2/ |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|--|--|--|
| 19. | Д. Мөнхжаргал Үндсэн хуулийн өөрчлөлт ба тоглоом - ын сайд нар 2007.2.23 № 46 /2494/ 3 | Өнөөдөрийн засаглалын хомсдол, улс төрийн амбиц олигархуудын ноёрхлын замыг 2000 онд ҮХ-ийн өөрчлөлтүүдтэй холбоотой гэж үзвэл үүнд МАХН, түүний удирдлага томоохон үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой | Санал нууцаар хураадгийг болиулж зөвхөн илээр гаргадаг болсон нь гишүүд саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжийг хязгаарлаж сонгогчдын бус намын эрх ашгийг дээгүүр тавихад хүргэж байна. Энэ даамжирсаар Монгол Улсын Засгийн эрхийг намын мэдэлд шилжүүлэх муу үр дагавартайг ерөнхийлөгч Н. Багабанди сануулж байжээ. |
| 20. | Мөнх Д. Үндсэн хуульд « салхи оруулах « цаг болсон уу . 2007.04.13 № 89 (2537) 3 | Энэ нь 18 яамны сайдын нэгээс бусад нь УИХ-ын гишүүн байгаатай холбоотой гэх шүүмжлэл | МАХН-ын нэрийн дор нэгдсэн хэсэг бүлэг хүмүүс сонгуулийн аргаар / гэхдээ шударга бус/ шургалж, улс төрийг хариуцлагагүй, төрийн тогтолцоог хяналтгүй болгоод байгаа юм биш биз гэж хардаад байгаа.... Үндсэн хууль түүхэн өөрчлөлтийг шаардаад байгаа юм биш үү |
| 21. | Ж. Роозон Үндсэн хууль, түүнийг зөрчсөн үйлдлүүд. 2007.06.28 № 154 (2602) 3 | Тодотгох, найруулгыг нь харж үзмээр зүйл.... | Үндсэн хуулийн, эргэлзээтэй хоорондоо зөрчилтэй зарим заалт Хөдөлмөрлөх.... үг хэлэх гэх мэт... |
| 22. | Б. Цогтгэрэл Үндсэн хуулийг өөрчлөх хууль зүйн үндэслэл /Цуврал/. 2009.12.08 № 286 (3358) 1, 3 | Монгол улс хөгжлийн түвшинээрээ/ 153-рт/ хаана явж байна вэ? Яагаад улс орон хөгжихгүй хувь хүний амьдрал дээшлэхгүй байна вэ? Төсөв санхүүгийн сахилга бат алга... Эдийн засгийн бодлогын дархлаагүй... Сонгуулийн системийн гажиг.... Засаг захиргааны хэт тархай хувиарлалт... Хүний эрх чөлөөг.... | Засгийн газрын бүтцийн болоод эдийн засгийн төв байгууллагуудын бүтцийг тогтвортой хадгалах.... Эдийн засгийн төв байгууллагуудын бодлогын бие даасан байдалд хууль зүйн баталгаа бий... Үндэсний хөгжлийн цогц бодлогоо төгөлдөржүүлэн баримтлах алхамыг нэн даруй хийх хэрэгтэй.... |
| 23. | Б. Цогтгэрэл Үндсэн хуулийг өөрчлөх эдийн засгийн үндэслэл /Цуврал/. 2009.12.17 № 294 (3366) 3, 7 | Өөрчлөх нь зөв | Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хийх цаг болсон 21-р зүйлийн 2 УИХ-ын гишүүнийг МУ-ын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ,..... 29-р зүйлийн 1 УИХ-ын гишүүн нь ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй 31-р зүйлийн МУ-ын Ерөнхийлөгчийг нийт ард түмнээр сонгож байгаа ч эрх хэмжээ нь бага 31-р зүйлийн 2 МУ-ын Ерөнхий сайд, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд түүнд өөрчлөлт оруулах.... |
| 24. | Л. Одончимэд. Социализмын үеийн хуульчдын гараар бүтсэн гэхэд Үндсэн хууль сайн болсон Э.Өнөр. 2010.01.12. 2,7 | Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бие даасан эдийн засгийн цогц байх тухай заалт хэрэгжихгүй байна. | Одоо өөрчилвөл юуны өмнө хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын ялгааг сэргээж өгөх хэрэгтэй. /ҮХ- 20, 21,22, 39-2/ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж нь бие даасан эдийн засгийн цогц байх тухай заалт хэрэгжихгүй байгаа /ҮХ- 57,58/ Хотын статусыг хуульд оруулж, нийслэл болоод орон нутгийн хотуудын эрхийг баталгаажуулах өөрчлөлт хийх хэрэгтэй |

| | | | |
|--|--|---|--|
| 25. | Д. Готов. Улс төрийн тогтолцоо зөвхөн мөнгөн дээр тулгуурлаж байна. 2010.02.02 № 27. 5 | МУ ҮХ-ндаа зохих өөрчлөлт оруулах замаар зах зээлийг, хөгжлийн жолоог зөв залж, гарсан алдаа дутагдлаа засах шаардлага байна. | <ul style="list-style-type: none"> • Одоогийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хувиарийг өөрчлөө / ҮХ- 57/ • Улс төрийн тогтолцоог өөрчлөө. • Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарьт хэрэв өөрчлөлт орвол төрд хяналтын тогтолцоог хүчтэй болгох, хариуцлагыг өндөржүүлэх мэргэжлүүлэх..... /ҮХ- 60/ • Төрийн удирдлагын системд өөрчлөлт оруулахаар хуулиа өөрчлөө • Улс төрийн намуудын үйл ажиллагаа, хэм хэмжээг тогтоож өгье • Төр засгийн үйл ажиллагаанд зарим чиглэлээр эрх үүргийг өргөтгөө. |
| Шинэ Үндсэн хууль гаргах шаардлагатай | | | |
| 1. | 'Б.Чимид Үндсэн хууль гэдэг хэн ч халдашгүй цайз биш, гэхдээ ... 2005.01.13. № 10 (1833) 4 | 1.ҮХ гэдэг хэн ч халдашгүй цайз биш, 2. ҮХ гэдэг хэн бүхний дураар хандаж ялангуяа улс төрийн явцуу эрх сонирхол бүхий бүлэг бүхний өөрчилж баруун зүүн тийш нь мушгиж байдаг гуйвуулгын талбар биш | Үндсэн хуулийг өөрчилнө нэдэг бол шинэ Үндсэн хууль гаргаж ирэх тухай асуудал гэхээс өөрөөр ойлгох аргагүй |
| 2. | Ц. Сарантуяа Хөгжлөөс түрүүлдэг ч түүнийгээ даган боловсронгуй болдог хууль. 2005.01.13. № 10 (1833) 4 | Төрийн чанар өөрчлөгдөж эсхүл алдагдаж огт өөр төр болж хувирсны эцэст ҮХ-ийг өөрчлөх гэдэг нь цоо шинэ Үндсэн хууль бий болохыг хэлнэ. | Нийгмийн хөгжлийн явцад нарийвчилсан зохицуулалт шаардлагатай үед Үндсэн хуульд өөрчлөлт оруулах боломжтой ҮХ-ийг өөрчлөх гэдэг нь цоо шинэ Үндсэн хууль бий болохыг хэлнэ. |
| 3. | Үндэсний хувьсгалаар хийгдэх шинэ үндсэн хуулийн тухай Төсөл Үндэсний шинэ нам. 2010.02.19.№ 40 12 | 1. Харь үзлээр өрсөлдөх олон нам хэрэг дээрээ Үндсэн хуулийн цоож болж байна. 2.1992 оны ҮХ-ийн үйлчлэлийн 20 жилийн үр дүн нь Олигархийн засаглал мөн. ҮХ-ийг өөрчлөх асуудлыг хамгийн бага сонирхох бүлэглэл нь олигархиуд байх болно | |

Түүвэрт: 1999, 2000, 2001, 2002, 2005, 2007, 2008, 2009, 2010, 2011/1 сар/ оны материал орсон

* * *

ТОВЧ ДҮГНЭЛТ

Зууны мэдээ сонинд нийтлэгдсэн 1992 оны үндсэн хуулийн өөрчлөлтийн холбогдолтой түүвэр хийхэд дараах онуудын нийтлэлүүд хамрагдсан. Үүнд: 1999, 2000, 2001, 2002, 2005, 2007, 2008, 2009, 2010, 2011/1 сар/

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь буруу: 32 санал

- Маш осолтой зүйл, засгийн газар олон дахин өөрчлөгдөхөд манайхан их хямарсан...
- Өөрчлөлт хийх нь албан тушаалын мэт харагдаж байж болох юм..
- Ардчилсан бус аргаар хандах нь улс төрийн хувьд ч, эрх зүйн хувьд ч цээртэй байх билээ ...

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зөв: 27 санал

- Сайн ойлголгүй бужигнаан дунд биш, улс төрийн цар хүрээтэй цогц бодлоготой уялдуулж байж өөрчилж болох
- Засгийн эрх мэдлийг зөв тэнцвэржүүлэхэд чиглэсэн өөрчлөлт хийх шаардлага бий
- Монгол төрийг боловсронгуй болгох том агуулга явж байгаа



Судалгааны эмхтгэл, Х боть

- Засаглалыг хурдан шуурхай зохион байгуулахад энэхүү өөрчлөлтийн зорилго оршсон гэх мэт

Үндсэн хуулийг өөрчилнө гэдэг бол шинэ Үндсэн хууль гаргах: 3 санал

- Өөрчилнө нэдэг бол шинэ Үндсэн хууль гаргаж ирэх тухай асуудал гэхээс өөрөөр ойлгох аргагүй
- Үндэсний шинэ нам. Монгол улсын үндсэн хуулийн Төсөл

Бусад :

Үндсэн хуулийн цэц 10

Үндсэн хуулийн өдөрт зориулсан ҮХ -ийн бүтсэн түхээс - 14

Хүний эрх 4

Мэдээ 4

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа процедурын алдаа хийсэн гэж үзсэн. 2010 оны 12 сарын 23-нд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хууль батласан.

* * *

ХАВСРАЛТ 3

ЗУУНЫ ШУУДАН/1999-2011/, ҮНДЭСНИЙ ШУУДАН /2007-2011/

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

| | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
|----|---|---|---|
| 1. | 2000 онд Үндсэн Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт 24-1. "УИХ-ын дарга дэд даргыг УИХ-ын гишүүд дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно". | 1. "Эмзэг асуудлыг Ерөнхийлөгч сэдрээх шаардлагагүй" УИХ-ийн гишүүн Р.Гончигдорж Хамгийн буруу замд нууц санал хураалт оруулдаг.Санал хураалт ил байхгүй бол янз бүрийн хувийн тоглолт, бүлэглэлүүд бий болдог.Нууц санал хураалтыг далимдуулан нөгөө намтай хамтарч ЗГ- аа огцруулах зүйлд их гарч байсан. | 1.Үндсэн хуулийг өөрчилж болно.Нэмэлт өөрчлөлт хийх нь өөрөө яах ч аргагүй Үндсэн хуулийн хэрэгжилтийн явцад бий болдог.Тиймээс өмнөх 7 өөрчлөлтийг буцаах хэлбэрээр томъёолвол хүлээн зөвшөөрөхгүй. 2. ҮХ-ийн 24.1"УИХ-ын дарга , дэд дарга, байнгын хорооны даргыг УИХ-ын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж сонгоно" гэж өөрчлөх саналтай байгаа ажээ. /Гангэрэл/ |
| 2. | 29-1. "УИХ-ын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил албан тушаал хавсарч болохгүй" | 1."15 гишүүний санаачилгаар Үндсэн хуулийг өөрчлөх галт тэрэг хөдөллөө" Ч.Гангэрэл 2011,01,11 ҮХ-д өөрчлөлт оруулах бүх тохироо бүрдчихээд байна.Улс төрийн талаасаа 2 нам хамтарч засгийн эрх барьж байгаа энэ үе.Нөгөө талаас өөрчлөтүүд нь 2000 оны 7 өөрчлөлт шиг зүйл битгий байгаасаа гэсэн болгоомжлол 2."Үндсэн хуулийн үзэл баримтлалыг нягтлан шинжлэхүй"Б.Дэлгэрмаа 2008,01,18 "УИХ гишүүн ЗГ-ын гишүүн давхар нэгэн зэрэг байх нь эрх мэдлийн хуваарилалтанд нийцээгүй. | 1.ЗГ-ын бүрэлдхүүнд орох УИХ-ын гишүүдийн тоог сайд нарын 3/1-ээр хязгаарлах |

| | | | |
|----|---|---|--|
| 3. | <p>33-1-2. УИХ-д олонхи суудал авсан нам эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг , аль ч нам эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам,эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайд нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг ЕС-аар томилох саналыг 5 хоногийн дотор УИХ-д оруулах”</p> | <p>1. “СЕХ Үндсэн хуулийн Шүүхээс бултаж байна” Д.Ламжав 2008.07.31 Намууд зөвшилцөнө гэдэг нь Үндсэн хууль зөрчсөн ямар ч хуульд байхгүй асуудал. - 2008 оны УИХ-ын сонгуулийн талаар СЕХ шийдвэр гаргалгүй Ерөнхийлөгчид албан бичгээр мэдүүлсэн нь СЕХ-ны аливаа шийдвэр Цэцийн хяналтанд байх 66.2.2 заалтыг зөрчсөн үйлдэл болжээ. 2.Үндсэн хуулийн үзэл баримтлалыг нягтлан шинжлэхүй”Б.Дэлгэрмаа 2008,01,18 Төрийн алба улс төржиж намчирхсан тул мэргэжлийн карьерийн болн улстөрийн албан тушаалын зарчмын ялгаа алдагдсаж төрийн албан тушаал арилжаа наймааны хэрэгсэл болсон байна.</p> | <p>1.Хуульд байхгүй зүйлийг хийж байгаагаараа төрийн байгууллага, албан тушаалтны баримтлах гол зарчмыг зөрчиж байгаа хэрэг. - СЕХ үүрэгт ажлаа хуулийн дагуу хийгээгүй байхад тэр албан бичгийг нь Ерөнхийлөгч УИХ-д оруулж ирэлгүй буцаах ёстой 2.Парламентийн засаглалын мөн чанар болсон Сонгуулийн үр дүнд олонхи болсон нам гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаа бий болгохдоо нэр хүндтэй, чадварлаг, нөлөө бүхий хүмүүсээр бүрдүүлэх нь зүйтэй. Үүнийг нам биш, намын удирдлага биш чухамхүү сонгогчид л шийдэх. Ард олны сонголтоор гарч ирээгүй хүнийг улс төрийн ямарваа нэгэн албан тушаалд томилж болохгүй. -Төрийн албыг намчирхах явдлаас үүрд ангижруулах нь хойшлуулшгүй арга хэмжээ билээ.</p> |
| 4. | <p>5-5 “Мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтанд байна”</p> | <p>1.Монголын тусгаар тогтнолын баталгаа яруу алдарт мал сүргээ” Ганчимэг 2010,12,20 “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтанд байна” гэсэн заалт хувийн өмч болох “мал” төрийн хамгаалалтад орж “Өмчийг төрөл хэлбэрээр нь ялгаварлаж болохгүй “гэсэн 16-р зүйлтэйгээ зөрчилдөж байгаа юм. 2.Үндсэн хуулийн үзэл баримтлалыг нягтлан шинжлэхүй”Б.Дэлгэрмаа 2008,01,18 Мал сүрэг төрийн хамгаалалтанд байна.</p> | <p>Төрийн хамгаалалтад “хүн” байх ёстой.</p> |
| 5. | <p>57-1 “МУ-ын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг хороонд хуваагдана.”</p> | <p>1.“Үндсэн хуулийг ард түмэн өөрчилсөн тохиолдолд хэн ч засвар хийхгүй” УИХ –ийн гишүүн Ө.Энхтүвшин 2011.01.03 2.Үндсэн хуульд өөрчлөлт оруулахгүй бол түгжирч гацаад байгаа олон асуудал бий ,,хотын тухай асуудал Эрдэнэт, Хатгал, Бор-өндөр, Бэрх гэх мэт.Суурин соёл иргэншил рүү явж байгаа нь ойлгомжтой үед “хот” гэдэг ойлголтыг устгаад хаясан нь хамгийн буруу, 3.“Үндсэн хуулийн сонгуулийн тогтолцоотой хэсгийг эргэж харах хэрэгтэй.” Ө.Энхтүвшин УИХ-ын гишүүн Парламент хяналтгүй болж байгаагийн шалтгаан нь ч УИХ-ын гишүүн сайдын албыг давхар хашиж болдогтой холбоотой</p> | <p>2. Орон нутагт хотын статус өгч бие даан хөгжих боломжийг ҮХ-даа суулгаж өгөх 3. ҮХ-ийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалыг хамгаалсан заалтууд ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заагаад өгсөн учраас бусуд зүйлийг нэмэлт өөрчлөтөөр өөрчилж болно.</p> |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|----|--|--|---|
| 6. | 60-2,, аймаг нийслэлийн ЗД-ыг ЕС, сум дүүргийнхнийг харьяа аймаг нийслэлийн ЗД, баг хорооныхыг харьяа сум дүүргийн ЗД 4 жилийн хугацаагаар томилоно. | <p>1.Үндсэн хуулийн үзэл баримтлалыг нягтлан шинжлэхүй”Б.Дэлгэрмаа 2008,01,18 НӨҮЁ-ны байгууллагуудын,тэдгээрийн цаашдын хувь заяа буюу ИНХ,ИТХ-ын олонхи намынхаа даргыг ЗД-д нэр дэвшүүлж нэг намын аппаратын ажилтнуудаар дүүрдэг гаж тогтолцоо</p> <p>2. “ҮХ-д гар хүрсэн шиг хүрье” Б.Түвшинтөгс 2011.01.13,,,,,,,, нэгэнт өөрчлөлт хийхээр галт тэрэг хөдөлгөж байгаа бол нийтээр хүртэх том эрх ашгаа 1-рт тавьж далайцтайхан өөрчлөлт хийх ёстой болов уу?</p> <p>3.“Үндсэн хуулийг ард түмэн өөрчилсөн тохиолдолд хэн ч засвар хийхгүй” УИХ –ийн гишүүн Ө.Энхтүвшин 2011,01,03 Өөр нэг нь баг хорооны засаг нар улс төрийн албан тушаалтан байгаа явдал.</p> | <p>1. Олон нийтийн сонгуулийг жинхэнэ утгаар нь буюу улс төрийн намууд бус иргэний хөдөлгөөн ,ИНБ,ТББ-ууд оролцох - Баг хорооны засаг дарга нар улс төрийн намуудын томилгоо болж байгааг ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулж л засах хэрэгтэй.</p> <p>2. Аймаг нийслэлийн ЗД- нарыг Ерөнхий сайд томилдог тогтолцоог өөрчлөх</p> |
| 7. | УИХ-ийн гишүүнийг ард түмнээс шууд сонгоно. Пропорциональ Системд таардаггүй | <p>1.“Үндсэн хуулийн сонгуулийн тогтолцоотой хэсгийг эргэж харах хэрэгтэй” Ө.Энхтүвшин 2011.02.23 Сонгуулийн хуулиа боловсронгуй болгож чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь ҮХ болчихоод байна. ҮХ-д байгаа сонгуулийн тогтолцоотой хэсгийг эргэж харах хэрэгтэй. УИХ-ийн гишүүнийг шууд сонгоно гээд заасан болохоор пропорциональ системийг хааж байгаа юм гэж манай зарим хуульч ярьдаг Цэц ч тэгж үзээд хөдлөхгүй байгаа.</p> <p>2.СЕХ Үндсэн хуулийн Шүүхээс бултаж байна” Д.Ламжав 2008.07.31 -Сонгууль бүрийндараа сонгуулийн хууль болохгүй байна өөрчлөх гээд өөрчлөхдөө сайжруулах бус улам муу болгоод байдаг. -Улстөрчид ҮХ-ийн аливаа нэг эгзэгтэй асуудлыг зөвхөн өөрсдөдөө ашигтайгаар тйалбарлаж байна.Энэ байдлыг аль болох багасгах өөрчлөлт хийх хэрэгтэй.</p> <p>3.“ҮХ-д гар хүрсэн шиг хүрье” Б.Түвшинтөгс 2011.01.13,,,,,,,, нэгэнт өөрчлөлт хийхээр галт тэрэг хөдөлгөж байгаа бол нийтээр хүртэх том эрх ашгаа 1-рт тавьж далайцтайхан өөрчлөлт хийх ёстой болов уу?</p> | <p>1.Энэ саад болоод байгаа зүйлээ нилээд сайн найруулах хэрэгтэй. Энэ бол үндсэн хуульд оруулах ёстой томоохон өөрчлөлт мөн.</p> <p>2.Сонгуулийн тогтолцоог үндсэн хуульд зааж өгөх хэрэгтэй. Сонгуулийн хуулиар албан тушаалд хүрэх ашиг хонжоо олох гэсэн санаархлыг таслан зогсоох шаардлагатай.</p> <p>3.УИХ-ын гишүүнийг ард түмэн шууд сонгоно гэсэн заалтаа нэг мөр ойлгож, сонгуулийнхаа тогтолцоог тэрхүү үзэл санаанд бүрэн дүүрэн нийцүүлэх</p> |

| | | | |
|----|----------------------------------|--|--|
| 8. | | <p>1. Парламентийн засаглалтай атлаа ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгоно</p> <p>2. Сонгуулиар бий болсон эвсэл задарвал яах вэ?</p> | |
| 9. | <p>68-2 Өөрчлөх хэрэгтэй</p> | <p>1. СЕХ Үндсэн хуулийн Шүүхээс бултаж байна” Д.Ламжав 2008.07.31 ҮХ бол ард түмний мэдлийн хууль.хэдэн гишүүн санаачилж УИХ-аар хэлэлцэж өөрчлөлт оруулж болохгүй.ҮХ-ийг ард түмэн батлахгүй юм бол засгийн эрх мэдэл ард түмэнд байгаа гэж яаж хэлэх юм вэ.</p> <p>2. “Үндсэн хуулийг ард түмэн өөрчилсөн тохиолдолд хэн ч засвар хийхгүй” УИХ –ийн гишүүн Ө.Энхтүвшин 2011,01,03 Үндсэн хуулийн 68,69 дүгээр зүйлд Үндсэн хуульд нэмэлт оруулах босгыг их өндөр тавьчихсан,УИХ-ын гишүүдийн 4/3 ирц байх гэх мэт,</p> <p>3. “ҮХ-д гар хүрсэн шиг хүрье” Б.Түвшинтөгс 2011.01.13 УИХ-ын нэр бүхий 15 гишүүний санаачилсан ҮХ-д өөрчлөлт оруулах 2 өөрчлөлт нь эхлэл төдий байна</p> <p>4.“Бид галт тэргийг л хөдөлгөлөө” УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин2011.01.13 ҮХ-ийг гажуудуулсан тэр гажуудлаас гарах гэсэн оролдлого.Өргөнг өөрчлөлт оруулья гэвэл өргөн хэлэлцүүлэг явуулах ёстой.</p> | <p>1.Нэмэлт өөрчлөтийг хүчингүй болгох ёстой.Үндсэн хуулийг ард түмний санал асуулгаар баталдаг.Нэмэлт өөрчлөлт хийх бол ард нийтийн өргөн хэлэлцүүлэг явуулахаас парламентийн хэдэн гишүүнд ашигтайгаар засаж болохгүй Шууд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал байхгүй, эхлээд 2000 оны нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгох хэрэгтэй.Ер нь ҮХ-ийн алдаатай зүйлийг засч зөв горилдролд нь оруулах цаг болсон.</p> <p>2. Дээрх зүйл заалтуудыг өөрчлөх боломжийг, нөхцлийг, эрхийг нь эрх бүхий субъектэд нээж өгснөөрөө -Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын “ тухай хуулийг баталсан явдал. УИХ нэмэлт өөрчлөлт оруулахаас гадна нийт ард түмний санал асуулгаар ҮХ-ийг өөрчилж болно гээд заасан.Үүгээр ҮХ д нэмэлт өөрчлөлт оруулах боломжийг нь ард түмэнд нээж өгч байгаа юм.Нэгэнт ард түмэн өөрчилсөн бол ҮХ-ийн цэц хэрэг үүсгэх, Ерөнхийлөгч хориг тавих гээд бүх боломжийг нь хязгаарлаж ямар нэгэн засварыг хэнч хиихгүй болгож байгаа юм</p> <p>3. Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн гэх он дамжсан нүсэр сонгууль хийхийн оронд Ерөнхийлөгчөө парламент дотроосоо сонгодог болох</p> <p>4.Санал асуулгыг ард нийтийн дунд ҮХ-ийг өөрчлөх буюу ЗГ-ын гишүүдийн 3/1 нь УИХ-ын гишүүн байх нь зөв үү? Буруу юу? Гэж явуулаад нэг талаас иргэдээ бүртгэх нөгөө талаас санал тоолох машинаа ч турших нэг боломж юм.</p> |

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй

| № | Эх сурвалж | Гарсан шүүмжлэл | Дэвшүүлсэн санаа |
|----|--|--|--|
| 1. | <p>“Үндсэн хуулийг өөрчлөхийг журамласан хууль цоорхойтой байна” Б.Түвшинтөгс 2011.01.26</p> | <p>УИХ-ын хувь гишүүдийн хувьд хууль санаачлах эрхтэй гэдгээр гул барьж хүссэн үедээ төсөл өргөн барихыг нь нээлттэй үлдээсэн нь алдаа болсон юм биш үү.Ард түмний оюунаар шүүгдсэн ардчилсан үндсэн хуулийг арван хэдэн гишүүний саналаар өөрчилдөг буруу жишиг тогтох бий.</p> | <p>Гавьяат хуульч Б.Чимэдийн санал болгосон хуулийн төсөлд эхлээд хууль санаачлах эрхтэй субъектийн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах саналыг парламентаар хэлэлцэж ямар нэгэн сонирхлын зөрчил байхгүй байна гэж үзвэл төслөө УИХ-д өргөн барихыг зөвшөөрдөг байх.</p> |
| 2. | <p>Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар хэн юу хэлэв УИХ-ийн дарга Д.Дэмбэрэл 2011.01.26</p> | <p>Үндсэн хуулийг өөрчлөхийн тулд маш олон мэргэжлийн байгууллагын санал авах шаардлагатай.</p> | <p>ҮХ-д өөрчлөл оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг 39 гишүүний бүрэлдхүүнтэй байгуулж УИХ-ын даргын захирамжаар баталсан тэд журмын тухай хуулийн дагуу төсөл боловсруулж 5 сарын 1ний дотор УИХ-д саналаа танилцуулах ёстой.</p> |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|----|---|--|--|
| 3. | Үндсэн хүүлийн өөрчлөлтийн талаар хэн юу хэлэв УИХ дахь МАН-ын бүлгийн ахлагч Д.Лүндээжанцан 2011.01.26 | Буруу жишиг тогтох бий гэж эмзэглэж байна. ҮХ-ийн дархлаа гэдэг нэг том ухагдхууныг бодолцох хэрэгтэй. | Дур дураараа төсөл санаачлаад тэрийг нь УИХ хэлэлцээд байж таарахгүй. |
| 4. | Үндсэн хүүлийн өөрчлөлтийн талаар хэн юу хэлэв. Ч.Сайханбилэг УИХ дахь АН-ын бүлгийн ахлагч. 2011.01.26 | Гэнэт л 15 гишүүн гарын үсэг зураад хуулийн төсөл санаачлаж болохгүй | ҮХ-д өөрчлөлт оруулах процесс нийгмийн зөвшилцөл дээр явах ёстой. |
| 5. | Үндсэн хүүлийн өөрчлөлтийн талаар хэн юу хэлэв П.Цагаан Ерөнхийлөгчийн зөвлөх 2011.01.26 | ҮХ-д дахиан дахин өөрчлөлт оруулж нөхөөстэй дээл шиг болгож болохгүй. 2000 онд өөрчлөлт оруулж маш өндөр хувиар баталсан.Ердөө 10-хан жилийн дараа дахиад л өөрчлөлтийн асуулт хөндөж байна,ӨХ үндсэн хуулийн дархлааны асуудал хөндөгдөж байна. | Их тогтвортой ,урт хугацаанд мөрдүүлэхээр хуульчилж баталж байхдаа нэмэлт өөрчлөлт оруулах босгыг өндөр тогтоож өгсөн |
| 6. | Үндсэн хүүлийн өөрчлөлтийн талаар хэн юу хэлэв. Дашням Ардчилсан үндсэн хууль тогтоогчдын холбооны гүйцэтгэх захирал 2011.01.26 | Дахин дахин өөрчлөлт оруулах шаардлагагүй | Нэмэлт хуулиар өөрчлөлт оруулж болно.Ямар ч өрчлөлт оруулсан бүх ард түмнээр хэлэлцүүлдэг, мэргэжлийн байгууллагын саналыг авдаг байх ёстой. |
| 7. | “ҮХ-ийн өөрчлөлтийг сэтгэлийн хөөрлөөр хийдэггүй” УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан. 2011.01.13 | ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар ажлын хэсэг байгуулж ажиллах ёстой, Намуудын, нийгмийн маш олон зөвшилцлийг хангаж байж хийх ёстой. | -Оруулах өөрчлөлтийн хувьд далайцтай, өргөн хүрээнд авч үзэхийг үгүйсгэхгүй |
| 8. | “Хоёрын хооронд гар хүрэх хэрэггүй” иргэн Д.Ламжав 2011.01.13 | Хоёрын хооронд дутуу хүрэх шаардлагагүй, гишүүдийн яриад байгаа 2 заалт бол жижиг зүйл ҮХ-д зарчмын олон алдаа бий. Зарчмын гэдэгт сонгуулийн тогтолцооноос эхлээд олон багц асуудал орох ёстой. | ҮХ-ийг шинээр бичих хэрэгтэй |

* * *

ХАВСРАЛТ 4

ӨДРИЙН СОНИН /1999-2011/

Танилцуулга:

Өдрийн сонин 1999-2011 онд нийтлэгдсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар нийт 55 нийтлэлийг түүвэрлэн ашиглалаа. Нийт нийтлэгдсэн материалын агуулгаас Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж давхардсан байдлаар 20 нийтлэлд шүүмжлэлтэй асуудлыг дэвшүүлж санал, зөвлөмж бичжээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

| № | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
|----|---|---|---|
| 1. | <p>Үндсэн хуулийн 22-р дугаар зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана. Нийт 1</p> | <p>1.Үндсэн хуульд оруулсан нэмэлтийн талаар Ерөнхийлөгч, Цэц саналаа өглөө Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл бэлтгэх комисс байгуулах саналтай байна 2000.12.13 №293/546/ 1,2-р нүүр Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай албан тоотыг хүргүүлсэн. Тус тоотын агуулга нь Үндсэн хуулийн 22 зүйлийн 2, 33 зүйлийн 2 дахь хэсгүүдэд хийх өөрчлөлтүүд нь Үндсэн хуульд заасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Үндсэн бүрэн эрх” –ийн заримыг хасч, цаашлан засаглал эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн агуулгыг өөрчилж, үүрэг хариуцлагын заагтай, харилцан хамааралтай, хяналттай байх зарчмыг зөрчиж байна.</p> | <p>1. Үндсэн хуулийг энд тэндээс нь цөөн зарим заалтыг таслан авч өөрчлөхийг ажлаж, эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох зорилгыг нэгэн сэтгэлээр барьж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг бэлтгэх комиссыг УИХ-аас нэн даруй байгуулж, ажлыг нь нэн даруй эхлүүлэх саналыг УИХ-д оруулж байна. Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшил, иргэдийн эрх, эрх чөлөөний баталгаа болсон Үндсэн хуулийг дээдлэн хүндэтгэж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа туйлын хариуцлагатай, ул суурьтай хандах нь хууль санаачлах, тогтоогч хэн бүхний үүрэг мөн.</p> |
| 2. | <p>Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэг Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. Нийт 3</p> | <p>1.Ж.Сүхбаатар: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслөө Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад танилцуулж саналыг нь авна Өдрийн сонин , №11, 2011-01-15 УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний ажлыг давхар хийж болно гэж өөрчлөлт оруулсан нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын хяналт тэнцэл, хариуцлагын тогтолцоог алдагдуулж байна. Засгийн газрын бүрэлдэхүүнд орох УИХ-ын гишүүдийн тоо, хэмжээ хязгаарыг тогтоож өгөөгүй учраас бүх сайдууд нь УИХ-ын гишүүн байх тохиолдол ч гарч байсан. 2.Э.Батбаяр: Үндсэн хуульд хууль бусаар гар хүрдэг явдалд цэг тавилаа. Өдрийн сонин №11, 2011-01-13 УИХ-ын гишүүд ЗГ-ын гишүүдийн бүрэлдэхүүнийг бүхэлд нь хавсран ажилласан ч болохоор хуульчилсан. 3. Конституционализмын зүг хийж буй том алхам боллоо 2000.01.03 №02/255/ 3-р нүүр Д.Одбаяр Засаглалын хуваарилалт гэдэг нь 3 тийш нь харуулаад хол хол аваачаад тавьчихна гэсэн үг биш юм.</p> | <p>1. Тиймээс Засгийн газрын бүрэлдэхүүний гуравны нэгээс дээш нь УИХ-ын гишүүн байж болно гэж оруулж байгаа. 2. Энэ нь МУ-ын Үндсэн хууль дахь төрийн эрх мэдэл хуваарилах үзэл баримтлалтай зөрчилдсөн гэсэн үг. 3. Нэг нь нөгөөгөөсөө тодорхой хамааралтай байх ёстой. Тэгж байж засаглал гэдгийг бүрэлдүүлнэ. Засаглалын хяналт тэнцлийн ийм тогтолцоо байхыг үгүйсгэж болохгүй юм.</p> |
| 3. | <p>68-1 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Нийт 1</p> | <p>1. Конституционализмын зүг хийж буй том алхам боллоо 2000.01.03 №02/255/ 3-р нүүр Д.Одбаяр -Үндсэн хуулийн Цэц өргөн мэдүүлнэ гэж Үндсэн хуульд шууд заагаагүй. -Түүнчлэн эхлээд Үндсэн хуулийн Цэцээр хэлэлцүүлээд Цэц өргөн мэдүүлэхгүй бол санаачлагчид шууд УИХ-д оруулна гэсэн заалт ч байхгүй.</p> | <p>1. Ингэж шууд заагаагүй болохоор хууль санаачлах эрх нь хууль санаачлагчдад нээлттэй үлдэж байгаа юм. - Өөрөөр хэлбэл дарааллын хувьд ч гэсэн энэ нь нээлттэй асуудал. Энэ бол иргэний эрх зүйн тогтолцооны сул тал, зарим улс төрчдийн утгагүй маргааны сэдэв юм.</p> |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----------|--|--|---|
| <p>4.</p> | <p>3-1 Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. Нийт 1</p> | <p>1.МУ-ын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж: Монгол Улсын Үндсэн Хуулийн өдрийн мэндчилгээ Өдрийн сонин, №11, 2011-01-13 Монгол Улсад төрийн эрх мэдэл зөвхөн ард түмний гарт байдаг. Энэ тухай Үндсэн хуулинд тусгайлсан заалттай. Энэ эрх мэдэл маань ард түмний гарт байж чадаж байна уу гэвэл бас тийм биш байна. Төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагаа ил тод бус, шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангах, хяналт тавихад иргэдийн оролцоо, тэр тусмаа шууд оролцоо бараг байхгүй байна.</p> | <p>1.Аливаа зүйл цагийн аясаар өөрчлөгдөн шинэчлэгддэг жамтай. Үндсэн хууль ч үүнээс гажихгүй, зарим өөрчлөлт, баяжилтыг нэхэж байж магадгүй. Гэхдээ Үндсэн хуульд хөндөж болохгүй суурь зарчмууд гэж бий. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн хэн ч халдаж болохгүй үзэл санаа, зүйл заалт, үг, үсэг бүрийг тууштай хамгаалах нь бидний үүрэг. Төр засгийн эрхийг Үндсэн хуулийн бус аргаар авахаар бусдыг уриалан өдөөн хатгаж буй ямар ч улс төрийн нам, хүчин, хувь хүн, ямар ч сайхан үгээр өнгөлөн далдалсан уриа лозунгаар өөрийгөө зөвтгөх учир байхгүй.</p> |
| <p>5.</p> | <p>33-1-1 Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Нийт 1</p> | <p>1.Ерөнхийлөгч чиг үүргээсээ хальсан эрх эдэлж байна. Өдрийн сонин, №04, 2000.01.05 Эрхтэй эрхгүй гэж ярихаар энэ асуудал сунжирсан урт процесс болж мэдэх юм.</p> | <p>1. Ер нь s-с дээш хувиар баталчихсан Үндсэн хуулийн өөрчлөлтөд Ерөнхийлөгч хориг тавих нь илүү үйлдэл.</p> |
| <p>6.</p> | <p>68.1 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. 68.2 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна.</p> | <p>1.Ц.Шаравдорж: Үндсэн хуулийг өөрчлөх биш, журмыг боловсруулах ажлын хэсэг -Өдрийн сонин 2009.12.24 №308 2-р нүүрт Энэ нилээд ерөнхий заалт</p> | <p>1.Тийм учраас тодорхой журмаар хэн, ямар эрх, ямар хүрээнд эдлэх, процедур, өргөн барих, УИХ хэрхэн хэлэлцэх зэргийг хуульчлах шаардлага гарч байна.</p> |
| <p>7.</p> | <p>1.Ж.Сүхбаатар: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслөө Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад танилцуулж саналыг нь авна Өдрийн сонин , №11, 2011-01-13</p> | <p>Д.Энхбат, З.Алтай гээд УИХ-ын 15 гишүүн хоорондоо ярилцаад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн барихаар шийдээд байгаа. Үндсэн хууль тогтоогчдын холбоо, уг хуулийн эх баригч, иргэний хөдөлгөөнийхөн, судлаачид гээд маш олон хүн 1999-2000 онд Үндсэн хуульд оруулсан долоон өөрчлөлтийг шүүмжилж сэтгэл дундуур байдгаа олон жил илэрхийлж ирсэн. Тулгуур хуульд өөрчлөлт оруулснаас улбаатайгаар төрийн эрх мэдлийн тогтолцоонд гажуудал үүссэн.</p> | <p>1.Энэ тухай бид хэдэн сарын өмнөөс ярилцан санал солилцоод долоон өөрчлөлт бүгдээрээ болж бүтэхгүй зүйл ч биш юм байна. Хамгийн гол шүүмжлэл, гажуудал дагуулсан зарим нэг заалтыг өөрчлөхөөс аргагүй. Иймд бид энэ долоон өөрчлөлтийн хоёр заалтыг өөрчлөх нь зүйтэй гэж үзсэн. Зарим хүмүүс дордохын долоо гэж шүүмжлэн бүгдийг нь буцаан хэвэнд нь оруулах шаардлагатай гэдэг</p> |

| | | | |
|-----|---|--|--|
| 8. | <p>Хоёр намын дарга буулт хийлээ, гэхдээ ялагдал биш бололтой //ӨС. 2000.01.05 №04/257/ 1, 2</p> | <p>- Хуулиар бол ард нийтийн санал асуулгаар, эсвэл УИХ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. УИХ энэ эрхээ эдлэхдээ хэтэрхий явцуу хүрээнд эдэлсэн гэж Ерөнхийлөгч үзэж байгаа ажээ.</p> <p>- Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг эсэргүүцэж байгаа ганц гишүүн тэрээр “ Цэцийн дарга чуулганд үг хэлье гээд байхад яагаад боломж олгоогүй юм, УИХ-аар ямар ч хуулийн төслийг хэлэлцэхдээ долоо хоногийн өмнө материалыг тараадаг хуультай. Гэтэл нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн төслийг яагаад хэдхэн цагийн өмнө тараав.</p> | <p>-Харин хуралдааны төгсгөлд Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах эсэх талаар санал хураахад Ж.Гомбожав гишүүнээс бусад нь хүлээж авахаас татгалзав.</p> |
| 9. | <p>Баярцогт С. Би Үндсэн хуулийн Цэцэд хандана. //ӨС. 2000.01.05 №04/257/ 2</p> | | <p>Үндсэн хуулийн Цэц санал хэлэх ёстой. Энэ бол формальный асуудал байгаа. Гэхдээ үүнээс болоод ҮХ-ийг өөрчлөхөө болих асуудал байхгүй.</p> |
| 10. | <p>Эв нэгдэл Ерөнхийлөгчид таалагдаагүй нь юу өгүүлнэ вэ -Өдрийн сонин 2000.01.07 №06/259/ 3-р нүүрт</p> | <p>Гэтэл эвдрэлцээд байна. Биднийг эвлэрүүлээд өгөөч” гэхэд жишим ч үгүй суудаг байсан Ерөнхийлөгч гуай харин “ юу болов” гэсэн шиг сүртэй лүндэн буулгаж эвлэрсэн гишүүдийн баталсан хуульд бүхэлд нь хориг тавилаа. Парадокс гэдэг ийм л юм байдаг байх !!! Эвлэрүүлэх ёстой хүн нь шүү!!! Ингэхэд ер нь Ерөнхийлөгч Багабанди юуны төлөө тангараг өргөсөн хүн бэ ?... Эвлэрсэн үедээ монголчууд бүхнээс илүү хүчтэй болчих гээд байдгийг түүх гэрчилж байсан тул хаа нэгтэйгээс чөтгөр гараад ирэхийг үгүйсгэхгүй юм. Гэтэл харин Монголын улс төрчид эв нэгдэлтэй байгаа нь эв нэгдлийг илэрхийлэгчид таалагдахгүй болсон нь чухам юу өгүүлнэ вэ</p> | |
| 11. | <p>Цэц өөрийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар маргаан үүсгэж байна Ц.Шаравдорж 2000.11.30 №282/535/ 2-р нүүр</p> | <p>УИХ-ын гишүүн, ХЗБХ-ны дарга Ц.Шаравдорж:Үндсэн хуулийн цэц ард түмний төлөөллийн байгууллага УИХ-аас Үндсэн хуульд заасан журмын дагуу баталж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг чандлан сахиулж УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газарт энэ дагуу үйл ажиллагаа явуулах боломж олгохгүй, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөө хамгаалах үүргээ гүйцэтгэхийн оронд түүнийг хүчингүй болгохоор зүтгэж байгаа нь Цэц өөрийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар маргаан үүсгэж байна.</p> | <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц өөрийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар маргаан үүсгэж, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу, Цэцийн дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрөөгүй эсвэл зөвшөөрсөн тогтоол гараагүй байхад Цэцийн дарга Н.Жанцан их суудлын хуралдаан зарлан хийлгэж Цэцээр хууль зөрчүүлэх гэж байна.</p> |
| 12. | <p>УИХ-ын гишүүн Ц.Шаравдоржийн байр суурь Д.Далай 2000.11.30 №282/535/ 1-р нүүр</p> | <p>Цэц Үндсэн хуульд бусад хууль нийцэж байгаа эсэхийг хянах ёстой болохоос биш Үндсэн хуулинд хяналт тавих ёсгүй.</p> | <p>Хууль бус хуралдаанаас хууль бус шийдвэр гарна гэж бодсон учраас УИХ-ын байр суурийг илэрхийлчихээд гараад явсан.</p> |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|--|---|---|
| 13. | <p>Олонхийн хуульчид Цэцийг эрхээ хэтрүүлсэн гэж үзэв Засгийн газар нэг ч хоног эзэнгүй байхгүй 2000.11.30 №282/535/ 3-р нүүр</p> | <p>УИХ-ын гишүүн Ж.Бямбадорж, Д.Лүндээжанцан, Ц.Шаравдорж нар хэвлэлийн бага хурлыг "УИХ-ын гишүүний байр суурь биш зөвхөн хуульчийнхаа хувьд илэрхийлж буй байр суурь" гэдгийг сануулав. Үндсэн хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгосон нь Цэц эрхээ хэтрүүлж байна. Цэцийн гаргасан шийдвэр нь тодорхой бүлгийн эрх ашигт нийцсэн захиалгат үйлдэл, Цэцийн энэ бүрэлдэхүүнийг хууль мэддэг хүмүүсээр тавих хэрэгтэй. Цэцийн дүгнэлт УИХ-ын тогтоол гараагүй байхад гарсан, мөн дунд суудлын хуралдаан шиг явагдсан. Цэцийн энэ үйлдэл гэмт хэрэг.</p> | <p>Цэцийг УИХ өөрөө сонгодог тул бас татаж авч болно. Цэцийн энэ шийдвэрээс үүдэн эрх зүйн акт бүрдүүлэх ёстой.</p> |
| 14. | <p>Улс төржөөд буй бүлэглэлээ зарлалал яасан юм бэ /Ардчилсан хүчнийхэн Цэцийн шийдвэрийн тухай 2000.11.30 №282/535/ 3-р нүүр</p> | <p>Батбаяр: Цэцийн шийдвэр үндсэндээ буруу. Энэ бол хуулийн тайлбар биш. Зүгээр л улс төрийн явуулага. Цэц байгуулагдсанаасаа хойш УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн байж болох эсэх талаар хэдэнтээ шийдвэр гаргасан. Цэцийн энэ шийдвэр нь Засгийн газрын сулруулж, дараа нь түлхэн унагах гэсэн үндсэн бэлтгэл ажиллагаа. М.Энхсайхан: Цэцийн шийдвэр зөв буруу гэж маргах асуудал бидэнд үгүй. Энэ бол хуулиа хүндэтгэж сурах ардчиллын чухал ойлголт. Р.Амаржаргал: Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг агуулгын хувьд би бүрэн дэмждэг. Гэхдээ УИХ өмнө нь Цэцийн шийдвэрийг хуулийн дагуу авч хэлэлцээд хүлээн зөвшөөрсөн эсэх тухай шийдвэр гаргах ёстой. Гэтэл тэр шийдвэр гараагүй. Д.Бямбасүрэн: Үндсэн хуулийн Цэц ардчиллын зарчмаар маш чухал шийдвэр гаргалаа. Нэмэлт, өөрчлөлт ерөнхийдөө хуйвалдааны шинжтэй байсныг тухайн үед МАХН-ын дарга ч хүлээн зөвшөөрч байсан. Хямрал үүсэх боломжийг МАХН өөрөө үүсгэж байна. З.Энхболд: Цэцийн шийдвэр эцсийнх учир Ардчилсан хүчнийхэн буруу ч бай, зөв ч бай үргэлж хүндэтгэж ирсэн.</p> | <p>Батбаяр: Цэцийн энэ шийдвэр нь Парламентад эргээд нууц санал хураалт хуйвалдааны зам нээгдлээ. 1999 онд МАХН-тай хамтарч Үндсэн хуульд өөрчлөлт хийсэн нь Үндсэн хуулийн хямралаас гарах гэсэн оролдлого юм. Ингэхээр Үндсэн хуулийг өөрийг нь өөрчлөх зөвшилд хүрэхээс өөр аргагүй. М.Энхсайхан: Улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөх эсэх нь эрх баригчдаас шууд хамаарна. Р.Амаржаргал: Нэгэнт хуулиа эрхэмлэх шаардлага бий учир Цэцийн шийдвэрийг дагаж мөрдөхөөс аргагүй гэж бодож байна. Д.Бямбасүрэн: МАХН-ын дарга асар их ширүүн тэмцлээр олсон суудлаа бусад улс төрийн хүчинд бэлгэнд өгнө гэж ойлголтоор ярьж байна. Гэтэл сонгууль болно шүү дээ. Тухайн тойргийн сонгогчид МАХН-д сэтгэл алдраагүй хэвээр бол түрийчийнхээрээ өгнө биз. З.Энхболд: МАХН төр засгийн бүх эрх мэдлийг барьж байна. Тэд өөрсдөө асуудлаа шийдэг.</p> |
| 15. | <p>Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулав. 2009.12.17 №302/3379/ 5-р нүүр Х.Баттөгс</p> | <p>Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагджээ.</p> | |
| 16. | <p>Ц.Шаравдорж: Үндсэн хуулийг өөрчлөх биш, журмыг боловсруулах ажлын хэсэг 2009.12.24 №308 2-р нүүр Х.Баттөгс</p> | <p>Ц.Шаравдорж: Үндсэн хуулийг өөрчлөхөд зайлшгүй тодорхой журам барих хэрэгтэй гэдэг хатуу ойлголттой болсон. Шууд хэн нь, эсвэл хэдэн УИХ-ын гишүүд нэг өдөр санаачлаад Үндсэн хуулинд ийм өөрчлөлт оруулья гээд баталчихвал дэндүү шударга бус юм болно.</p> | <p>Яагаад гэвэл энэ чинь Үндсэн хуулийн өөрчлөлтийн тухай асуудал байхгүй юу. Энэ хуулиар л нийгмийн бусад харилцааны хуулиуд зохицуулагдаж байгаа. Ийм санаагаар л Үндсэн хууль өөрчлөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан.</p> |

| | | | |
|-----|--|--|---|
| 17. | Хэрвээ Үндсэн хуулийг хөндөхөд хурвал урьдчилан тохирсон хуультай байх ёстой. 2009.12.22 №306/3383/ 2-р нүүр О.Билэгт | Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан. Юуны өмнө Үндсэн хуульд өөрчлөлт оруулах санаачлагчид нь хэн байхыг зааж өгөх шаардлагатай. Урьд нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан боловч олон түмний шүүмжлэлд багагүй өртсөн. | Тус ажлын хэсэг нь Үндсэн хуульд өөрчлөлт орох тэр журам нь ямар байх юм бэ гэдэг хуулийг боловсруулах юм байна. Гэхдээ хуулийн тулгуур зарчмыг хөндөхгүй. |
| 18. | ҮШН тавдугаар Үндсэн хуулийн төсөл боловсруулснаа зарлалаа. 2010.02.23 №43, 2-р нүүр О.Билэгт | ҮШН-ын 10 дугаар бүгд хуралаа хийсэн байна. Тэд энэ удаагийн хуралдаанаараа шинэчлэлийг Үндсэн хуулиас эхлэх хэрэгтэй хэмээн үзэж 5 дугаар үндсэн хуулийн төсөл боловсруулснаа зарласан байна. 1992 онд батлагдсан 4 дүгээр Үндсэн хуульд хувийн эрх, эрх ашгийг онцгойлон үзээд үндэсний эрх ашгийг дээдлэх, баталгаажуулах заалтууд тусгагдаж чадаагүй гэж шүүмжилсэн байна. | Үндсэн хуулийн төслөөр Үндэсний их хуралдайг байгуулж, бас намын шалгуураар сонгогдох улсын бага хуралдайг байгуулах. Парламентаас улс төр, эдийн засгийн албан тушаалын томилгоо хийхийг болиулж, хуралдайчдаас сайдын албыг давхар хаших боломжгүй болгохоор төсөлдөө тусгажээ. |

Танилцуулга:

Өдрийн сонини 1999-2011 онд нийтлэгдсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар нийт 55 нийтлэлийг түүвэрлэн ашиглалаа. Нийт нийтлэгдсэн материалын агуулгаас Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй гэж давхардсан байдлаар 29 нийтлэлд шүүмжлэлтэй асуудлыг дэвшүүлж санал, зөвлөмж бичжээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй

| № | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
|----|--|---|---|
| 1. | 22- 2 Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана. | 1. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Ерөнхийлөгч хориг тавилаа 2000.12.21 №301/554/ 1-р нүүр Н.Багабанди: Үндсэн хуулийн 22 дугаар зүйлд оруулсан нэмэлт нь тус хуулийн 20 дугаар зүйлтэй зөрчилдөж байна. | 1.Ер нь манай Үндсэн хуулийн үзэл баримтлалаар төрийн эрх барих дээд байгууллагыг тараах эрхийг төрийн тэргүүнд олгож болохгүй. |
| 2. | 24-1 Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно. Нийт 2 | 1.Ерөнхийлөгч чиг үүргээсээ хальж эрх эдэлж байна. Ж.Гомбожав, 2000.01.05 №04/257/ 2-р нүүр Нам, эвслийн бүлгээс намын дэд даргыг сонгоно гэсэн байгаа.Гэтэл энэ хуулиар бол УИХ-ын Дэд даргад гишүүд, түүнчлэн гишүүн өөрөө нэрээ дэвшүүлэх эрхтэй. 2. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Ерөнхийлөгч хориг тавилаа 2000.12.21 №301/554/ 1-р нүүр Улсын Их Хурлын гишүүдийн заримынх нь УИХ-ын дэд даргаар сонгогдох хассан энэ заалт нь Үндсэн хуулийн 16.10 дахь хэсгийн заалттай зөрчилдөж байна. | 1.Энэ өөрчлөлтөөр УИХ-ын гишүүний уг эрх нь хасагдаж, зөвхөн нам, эвслийн бүлэг УИХ-ын дэд даргад нэр дэвшүүлэх болж байна. |
| 3. | 27-2 Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна. | | |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----------|--|---|---|
| <p>4.</p> | <p>27-6 Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ. Нийт 2</p> | <p>1. Ерөнхийлөгч Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд хориг тавьжээ. –Өдрийн сонин 2000.01.03. № 02/255/ 2-р нүүрт -УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдааны ирцийн хувийг бууруулав. -УИХ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд гишүүд саналаа зөвхөн илээр гаргаж, УИХ-ын гишүүд намынхаа удирдлагын шийдвэрийн дагуу саналаа өгч байгаа эсэхэд хяналт тавих нь Засгийн эрхийг ард түмний мэдлээс намын мэдэлд ямар нэгэн хэмжээгээр шилжүүлж, сонгогчид Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна. 2. Засгийн газрын гишүүдийн гурваны нэг хүртэл хувь нь УИХ-ын гишүүн байж болох хувилбарыг Цэц дэвшүүлээ 2000.12.13 №293/546/ 2-р нүүр Тус нэмэлт өөрчлөлт нь уг чанартаа хурлын ирц нь бүрддэггүй, гишүүдээ цуглуулж чаддаггүй, сахилга зохион байгуулалтгүй, парламентад зориулж хийгдсэн өөрчлөлт болжээ. Энэ өөрчлөлт батлагдвал 76 гишүүний 39-нь хүрэлцэн ирсэнээр хурал хүчинтэйд тооцогдож 20 гишүүний саналаар хууль батлагдах болох нь.</p> | <p>1. 20-хон гишүүний саналаар хууль баталж болохоор хэт хялбарчилж байгаа нь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгож байна гэж үзэх үндэслэлгүй юм. 2. Үндсэн хуулийн цэц дэлхийн олон орны парламентын чуулганы ирцийг ямар байдгийг судлан үзлээ. Төсөл өргөн баригчдын санал болгож байгаа хувиар чуулган хийдэг хэд хэдэн орон байсан боловч тэдгээр орны парламентын гишүүдийн тоо 200-600 гаруй хүнтэй байдаг тул хэзээ ч хуулийг 100-аас доош гишүүд баталдаггүй.</p> |
| <p>5.</p> | <p>29-1 Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. Нийт 2</p> | <p>1.Засгийн газрын гишүүдийн гуравны нэг хүртэл хувь нь УИХ-ын гишүүн байж болох хувилбарыг Цэц дэвшүүлээ 2000.12.13 №293/546/ 2-р нүүр Хууль санаачлагч Үндсэн хуулийн 29.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон тохиромжтой гэж үзсэн хувилбар байвал түүнийгээ сонгож болох нь мэдээж. 2.Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Ерөнхийлөгч хориг тавилаа 2000.12.21 №301/554/ 1-р нүүр Н.Багабанди:УИХ-ын гишүүн нь Засгийн газрын гишүүнээр хавсаран ажиллах нь буруу</p> | <p>1.Тодорхой хязгаарлалтыг салбар хуулиар тогтоох боломжгүй тул аль зохимжтойг нь Үндсэн хуульдаа суулгаж өгөх ёстой. 2.Н.Багабанди:УИХ-ын гишүүн нь Засгийн газрын гишүүнээр хавсаран ажиллах талаар Үндсэн хуулийн Цэцийн санал болгосон хязгаарлалтыг зайлшгүй хийж өгөх шаардлагатай.</p> |

| | | | |
|-----------|---|--|---|
| <p>6.</p> | <p>33-1-2 Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;</p> <p>Нийт 2</p> | <p>1. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Ерөнхийлөгч хориг тавилаа 2000.12.21 №301/554/ 1-р нүүр Н.Багабанди:Ерөнхийлөгч зөвшөөрөх ба татгалзах эрхгүй, зөвхөн уламжлах үүрэгтэй болгож байгаа учир “Ерөнхийлөгчийн санал” гэж үзэх үндэслэлгүй, улмаар Ерөнхийлөгчийн Үндсэн бүрэн эрхэд хамааралтай заалт. Энэ заалт нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын хувьд өөрчилсөн байна.</p> <p>2.Үндсэн хуульд оруулсан нэмэлтийн талаар Ерөнхийлөгч. Цэц саналаа өглөө Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл бэлтгэх комисс байгуулах саналтай байна. 2000.12.13 №293/546/ 1,2-р нүүр Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналын тухай албан тоотыг хүргүүлсэн. Тус тоотын агуулга нь Үндсэн хуулийн 22 зүйлийн 2, 33 зүйлийн 2 дахь хэсгүүдэд хийх өөрчлөлтүүд нь Үндсэн хуульд заасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Үндсэн бүрэн эрх” –ийн заримыг хасч, цаашлан засаглал эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн агуулгыг өөрчилж, үүрэг хариуцлагын заагтай, харилцан хамааралтай, хяналттай байх зарчмыг зөрчиж байна.</p> | <p>2. Үндсэн хуулийг энд тэндээс нь цөөн зарим заалтыг таслан авч өөрчлөхийг азнаж, эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох зорилгыг нэгэн сэтгэлээр барьж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг бэлтгэх комиссыг УИХ-аас нэн даруй байгуулж, ажлыг нь нэн даруй эхлүүлэх саналыг УИХ-д оруулж байна. Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшил, иргэдийн эрх, эрх эрх чөлөөний баталгаа болсон Үндсэн хуулийг дээдлэн хүндэтгэж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа туйлын хариуцлагатай, ул суурьтай хандах нь хууль санаачлах, тогтоогч хэн бүхний үүрэг мөн.</p> |
| <p>7.</p> | <p>39-2 Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.</p> <p>Нийт 1</p> | <p>Засгийн газрын гишүүдийн гурваны нэг хүртэл хувь нь УИХ-ын гишүүн байж болох хувилбарыг Цэц дэвшүүлээ 2000.12.13 №293/546/ 2-р нүүр Тус заалт нь нэмэлт өөрчлөлтөөр оруулсан нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхээс хассан байна. Үндсэн хууль хэрэгжсэнээс хойш өнөө болтол огт хэрэгжүүлээгүй энэ заалтыг Монгол Улсын хэд дэх Ерөнхийлөгч хэний Засгийн газрын үед хэрэгжүүлэхээс болгоомжилж одоо Үндсэн хуулиас хасаж байгаа нь ойлгомжгүй байна.</p> | <p>Засгийн газрыг огцруулах саналыг Ерөнхийлөгч Парламентад оруулж бүрэн эрхтэй болох тухай заалт дэлхийн олон орны үндсэн хуульд байдаг. Засгийн газрыг огцруулах эсэх эцсийн шийдвэрийг Парламент өөрөө гаргаж байгаа манай орны нөхцөлд уг заалтыг яаравчлан хасах шаардлагагүй гэж үзэж байна.</p> |
| <p>8.</p> | <p>68-1 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Нийт 1</p> | <p>1. Ерөнхийлөгч Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд хориг тавьжээ. –Өдрийн сонин 2000.01.03. № 02/255/ 2-р нүүрт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц саналаа өгөх боломжийг олгоогүй нь Үндсэн хуулийн 68.1-г зөрчсөн байна.</p> | |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|--|--|---|
| 9. | <p>16-10 Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд түүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно; Нийт 1</p> | <p>УИХ-ын гишүүдийн заримынх нь УИХ-ын дэд даргаар сонгогдох эрхийг хязгаарласан нь хүнийг аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагын гишүүний нь хувьд ялган гадуурхахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн 16.10 дахь хэсгийн заалтад харшилж байна.</p> | |
| 10. | <p>Ерөнхийлөгч Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд хориг тавьжээ. 2000.01.03. № 02/255/ 2-р нүүрт</p> | <p>Үндсэн хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн “эрх мэдлийг хуваарилах” зарчим , төр, засгийн дээд байгууллагуудын бүрэн эрхийн уялдаа, харилцан хяналт үзэл баримтлалыг гажуудуулж байна.</p> | |
| 11. | <p>Манайд Ерөнхийлөгчийн эрх мэдэл харин ч хэтэрсэн Монгол Улсын Анхны Ерөнхийлөгч П.Очирбат 2000.01.13 №11/264/ 2-р нүүрт</p> | <p>Юуны туханд хүрэлгүй Үндсэн хуулиа өөрчлөх хандлага байж боломгүй байна.</p> | <p>Засаглалын эрх мэдлийг харьцангуй тэнцвэртэй байлгахыг бодож 1992 оны шинэ Үндсэн хуулийг хийсэн. Тийм учраас энэ эрх мэдлийн тэнцвэржилтийг алдагдуулмааргүй байгаа юм.</p> |
| 12. | <p>Ерөнхийлөгч чиг үүргээсээ хальж эрх эдэлж байна. Ж.Гомбожав, 2000.01.05 №04/257/ 2-р нүүр</p> | <p>1.Эд нар нэмэлт өөрчлөлтийг хэтэрхий түргэн түүхий хийснээс маргаан дэгдэх нөхцөлийг бий болголоо. 2. Миний бодлоор бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийдээ Өршөөлийн хууль, Цахилгааны хууль, “НИК”-ийн хувьчлалаар тохиролцоо хийсэн байх гэж таамагладаг.</p> | |
| 13. | <p>Цэц Үндсэн Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгож улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөв /ярилцлага/ Д. Оюунцэцэг 2000.11.30 №282/535/ 1,2,3-р нүүр</p> | <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн их суудлын хуралдаанаар Үндсэн хуулинд 1999 оны 12 сарын 24-нд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчиж байгаа эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэх Д.Чулуунжав УИХ нь үндсэн хуулийн 8 заалтыг зөрчлөө. Үндсэн хуулийг ердийн хуультай адилтгаж үзлээ. Нэмэлт өөрчлөлтөнд Ерөнхийлөгч, УИХ, ЗГ-ын статустай тохирохгүй, концепци зөрчсөн зүйл олон орлоо. УИХ цэцийн шийдвэрийг хүчингүй гэж үзсэн нь Цэцийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадварыг алдагдахуйц тогтоол гэгчийг гаргаж Цэцээр даажигналаа. Цэц Үндсэн хууль зөрчсөн 8 заалтын 3-ыг нь зөрчсөн гэж дүгнэсэн.</p> | <p>УИХ-аас баталсан Үндсэн хуулинд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1.2, 68,1, 70,1 дүгээр заалтыг зөрчсөн байх тул тус нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгосугай. 1992 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр батлагдсан бүх заалт хүчинтэй болохыг дурьдаад Цэцийн шийдвэр эцсийнх бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болно гэж Үндсэн хуулийн Цэцээс мэдээлсэн.</p> |

| | | | |
|-----|---|---|---|
| 14. | Нурах уулын бэлд төрийн гэрийг барьчихлаа Д.Чулуунжав 2000.11.30 №282/535/ 2-р нүүр | Үлдсэн 5-ыг нь анхаарч үзээч. Нэмэлт өөрчлөлтөөр хэт даварсан парламентын бүгд найрамдах улсын загвар бий болсон. Бусад намууд яаж ч нэгдэж сонгуульд ороод нэмэргүй. Нурж унах гэж буй уулын бэлд төрийн гэрийг барьчихлаа. 1992 оны Үндсэн хуулийг 1960 оны Үндсэн хууль болгох чиглэлд хийсэн алхам болж байна. | Үндсэн хуулийн Цэц шийдвэрээ гаргаж үлдсэн 5 заалтыг хууль зөрчсөнийг дахин анхаарч үзээч. |
| 15. | Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга Н.Жанцантай уулзлаа / сур/ Ж.Гангаа 2000.11.30 №282/353/ 1-р нүүр | Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны дараа Цэцийн дарга Н.Жанцан сэтгүүлчийн асуусан асуултанд хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс үзээрэй гэж хариулсан байна. | Цэцийн их суудлын хуралдааны шийдвэр бол эцсийнх |
| 16. | Р.Амаржаргал: Өнгөрснөө бус ирээдүйгээ харж ажиллаа МҮАН-ын хурлын чуулганы хуралдаан дээр намын тэргүүн Р.Амаржаргалын тавьсан илтгэл 2000.12.05 №286/539/ 5-р нүүр | УИХ-ыг дангаар бүрдүүлж байгаа улс төрийн хүчин Үндсэн хуулинд гар хүрч байгаа нь олон намын тогтолцоо бүхий парламент ёсны мөн чанарт харш үйлдэл мөн. | Бидэнд нэгдмэл эрх ашиг бий. Энэ бол Монгол Улсын эрх ашиг. |
| 17. | Эрх баригчдаас бусад нам Засгийн газрыг хууль бус гэв Орон нутгийн хөгжлийн намын дарга Х.Ганбаатар: Нам төвтэй нийгэмийн чиглэлд хийсэн өөрчлөлт боллоо УИХ-ын гишүүн Эх орон-МАШСН-ын дарга Б. Эрдэнэбат: Монгол Улсын Засгийн газаргүй долоо хонолоо. МТН-ын дарга Л.Дашням: Ерөнхийлөгч хориг тавих байх л даа Д.Оюунцэцэг 2000.12.08 №289/542/ 3-р нүүр | Х.Ганбаатар: Үндсэн хуулийн гол үзэл санаа нь Монголд иргэний ардчилсан нийгэм байгуулах тухай байдаг. Гэтэл Үндсэн хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт нь нам төвтэй нийгмийн чиглэлд хийсэн өөрчлөлт болж байна. Б. Эрдэнэбат: Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахыг үгүйсгэхгүй. Гэхдээ нэг нам хэт давамгайлсан УИХ-аар өөрчлөлт оруулах ёсгүй. Хууль тогтоох засаглал гүйцэтгэх засаглалтайгаа нэг болох гэж байна. Л.Дашням: Үндсэн хууль бол бүх ард түмний оюуны бүтээл. Тэгэхээр нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ч бас ард нийтийн санал асуулгаар шийдэгдэх ёстой. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа процедурын алдаа гаргасан гэдэг боловч концепцийг нь хөндөж, төрийн байгууллагын уялдааг өөрчилж, нэг намын эрх ашгийг тусгасан. | Х.Ганбаатар: Хуулийн төслийг бүх ард түмнээр хэлэлцүүлэх зүйтэй. Б. Эрдэнэбат: УИХ-аар хэлэлцэж, нийт ард түмний санал явуулсаны үндсэн дээр шийдвэрлэх нь зүйтэй. УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний албыг давхар хашиж болохгүй. Үүнийг сахин биелүүлэх ёстой. Л.Дашням: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан ч Монгол Улсын Ерөнхийлөгч дахин хориг тавих байх. Үндсэн хуулинд нэмэлт оруулсан парламент түүнийг мөрдөхгүй гэж өмнө нь шийдсэн. Хэрэв тэгж тогтсон нь үнэн бол энэ парламент биш дараагийн парламент мөрдөх байх. |
| 18. | Үндсэн хуульд оруулсан нэмэлтийн талаар Ерөнхийлөгч. Цэц саналаа өглөө Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл бэлтгэх комисс байгуулах саналтай байна 2000.12.13 №293/546/ 1,2-р нүүр | Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналын тухай албан тоотыг хүргүүлсэн. Тус тоотын агуулга нь Үндсэн хуулийн 22 зүйлийн 2, 33 зүйлийн 2 дахь хэсгүүдэд хийх өөрчлөлтүүд нь Үндсэн хуульд заасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Үндсэн бүрэн эрх” –ийн заримыг хасч, цаашлан засаглал эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн агуулгыг өөрчилж, үүрэг хариуцлагын заагтай, харилцан хамааралтай, хяналттай байх зарчмыг зөрчиж байна. | Үндсэн хуулийг энд тэндээс нь цөөн зарим заалтыг таслан авч өөрчлөхийг азнаж, эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох зорилгыг нэгэн сэтгэлээр барьж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг бэлтгэх комиссыг УИХ-аас нэн даруй байгуулж, ажлыг нь нэн даруй эхлүүлэх саналыг УИХ-д оруулж байна. |
| | | | Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшил, иргэдийн эрх, эрх эрх чөлөөний баталгаа болсон Үндсэн хуулийг дээдлэн хүндэтгэж, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа туйлын хариуцлагатай, ул суурьтай хандах нь хууль санаачлах, тогтоогч хэн бүхний үүрэг мөн. |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----|---|--|--|
| 19. | Цөөн хэлэлцүүлэгт оролцох ёс суртахууны эрхгүй гэж мэдэгдлээ 2000.12.15 №295/548/ 2-р нүүр | Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн эхний хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүн Ж.Наранцацралт, С.Оюун, Б.Эрдэнэбат, Л.Гүндалай нар тэдний үгийг ч сонсолгүй, хүчээр хийж хоёрдугаар хэлэлцүүлэгт оруулсантай холбогдуулан хэвлэлийн бага хурал хийлгэсэн байна. УИХ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг санаачлах, батлах эрхтэй боловч хэлэлцэх эрхгүй. Энэ заалтыг зөрчлөө. Цэцийн шийдвэрийг хэрэгжүүлэх ёстой. Өөрсдийн алдаатай үйлдлээ нуухын тулд Үндсэн хуульдаа халдлаа. | Цэцийн шийдвэр гарснаар үүрэг гүйцэтгэгчээр Засгийн газрын танхимыг солих ёстой байсан. |
| 20. | Үндсэн хуулиа шүтэхгүй бол өөр юуг шүтэх юм/ ярилцлага/ Б.Чимид 2002.01.11 №008/8828 2,3-р нүүр | Үндсэн хуулийг тайлбарлах эрх нь уг Цэцийн хийх ажил. Гэтэл шинэ төслөөр энэ 2 чухал заалтыг аваад хаячихсан. Одоо тэгээд хөдөлгөөнгүй мод шиг болчихсон. | Үндсэн хуулиа тухайлсан хөтөлбөрөөр улсын хэмжээнд дорвитой тайлбарлан нийтээр ойлгуулах далайцтай ажил хийснийг санахгүй байна. Үндсэн хуулиа сахин дагаж, шүтэн бишрэх ойлголтыг ард түмэнд өгөхөөсөө өмнө өөрчлөх хэрэгтэй гэсэн саналыг дээдсүүд өгөөд байгаа нь тийм ч таатай биш зүйл. |
| 21. | Хүмүүсийн хүсч хүлээж байсан бүгдийг багтаасан хууль болсон Ж.Элбэгсайхан 2007.01.12 №008/2460/ 11-р нүүр | Ж.Элбэгсайхан: Үндсэн хууль улс төрийн дээд баримт бичгийн хувьд зарим зүйлийг нэгбүрчлэн тусгахад хэцүү байсан. Үндсэн хуулийн цэцийн хувьд ч ерөнхий заалт байгаа. | Манай Үндсэн хууль бол гар хүрч болохгүй баримт бичиг биш л дээ. Харин анх ямар ардчилсан зарчмын үндсэн дээр баталсан тэр зарчимаа л барих хэрэгтэй. |
| 22. | Ардын их хурал “амилж” депутатууд Үндсэн хуулийн өөрчлөлтөд санаа зовлоо Б.Янжмаа 2007.01.15 №011/2663/ 2-р нүүр | Үндсэн хуулийн 15 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “Үндсэн хууль 15 жил” санал солилцох уулзалтад Ардын их хурлын 330 гаруй төлөөлөгч оролцсон байна. Хуралдааны үеэр санал хэлсэн нийт төлөөлөгчид Үндсэн хуулийн өөрчлөлтөд шүүмжлэлтэй хандсан байна. | АИХ-ын төлөөлөгчид Үндсэн хуулийг хэрэгжүүлэх, хамгаалах төрийн бус байгууллага бий болгох хэрэгтэй гэж үзсэн байна. “ Улс төр, эдийн засгийн бүлэглэлүүд явцуу ашиг сонирхолд хөтлөгдөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаас сэргийлнэ” гэжээ. |
| 23. | Б.Чимид: Үндсэн хуулийг өөрчлөхөд үндэстэй шалтгаан хэрэгтэй. 2009.07.17 №173 2-р нүүр | Үндсэн хуулийг өөрчилнө гэдэг яриа бараг үлгэр домог болж дээ. 1999-2000 онд нэг өөрчлөлтийг хоёр дахин хийсэн. Түүнийг дордуулсан 7 өөрчлөлт гэж нэрлэсэн нь ч бий. Ажиглаад байхад нийгмийн хямралт байдлаас гарах, улс төрийн хямрал, засаг төрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд гарч байгаа алдаа зөрчил, сонгуулийн будлиантай холбогдуулж Үндсэн хуулийг нүд үзүүрлэдэг болоо юу даа. | Даруухан хэлбэл манай үндсэн хуулийг социализмын дараах үеийн хуулиудын дотор дөнгүүртээ орно гэж гадаадын судлаачид үздэг юм билээ. Учир юу вэ гэхээр Үндсэн хуулийг өөрчилнө гэхээсээ илүүгээр түүний зүйл заалтуудыг тодруулсан хуулиуддаа сайн боловсруулж нарийсгах, засан сайжруулах хэрэгтэй. |
| 24. | Б.Чимид: Гуйвуулж хэрэглэдэг өвчин манай парламентад архагшжээ. 2009.01.12 №008/3398/ 2-р нүүр Д.Доржпагма | Хамааралтай, хамааралгүй болгон дээр л Үндсэн хууль л болохгүй байна гэсэн үг их цухалзах болжээ. Хамаг юмны бурууг түүнд чихэж, хариуцлагаас зайлсхийж, морь бусгадаг бул хар чулуу шиг болгоод байгаатай санал нийлдэггүй. 2000 оны эцсээр УИХ Үндсэн хуулинд өөрчлөлт оруулахдаа Ж.Гомбожав л эсэргүүцэж үг хэлсэн. Өөр гонхийх ч хүн олдоогүй, үг хэлэх боломж бараг олгоогүй. | |

| | | | |
|-----|--|--|---|
| | | Гишүүд үдийн зоогоо хүртэж ирээд шууд хоёрдугаар хэлэлцүүлэг гэх зүйлийг дүр эсгэн санал байхгүй байна гэж хэлээд л баталчихсан юм шүү дээ. Жам ёсоор хийсэн зүйлийг албан тушаалаа ахихдаа тохируулж, завших, намын эрх ашигтаа тохируулах маягаар гуйвуулж хэрэглэдэг өвчин манай улсын парламентад энэ үеэс эхэлж одоо бүр архагшжээ. Эрдэмтэн, судлаачид дүгнэлт хийгээд сонин энэ тэрд мөн ч олон удаа бичсэн дээ. Хүлээж авч байгаа зүйл алга. | |
| 25. | МНН-ын нарийн бичгийн дарга Э.Батбаяр: Үндсэн хуульд хууль бусаар гар хүрдэг явдалд цэг тавилаа 2011.01.13 №11 Б.Хонгор | Э.Батбаяр: Шууд хэлэхэд 1999, 2000 онд УИХ-аас Үндсэн хуулинд хууль бусаар гар хүрсэн гэж дүгнэх болно. Яах аргагүй энэхүү, нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг илтэд гажуудуулсан заалтууд суусан. | УИХ-аас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг батлан гаргасан. Ингэснээр Үндсэн хуульд хууль бусаар өөрчлөлт оруулдаг жишгийг таслан зогсоож, Үндсэн хуулийн тогтвортой шинжийг хадгалан, түүний үндсэн бүтэц, тулгуур үзэл баримтлалыг өөрчлөхгүйгээр нийгмийн зайлшгүй шаардлагатай асуудлаар Үндсэн хуулиа дээдлэх журам хуульчлагдаж баталгаажсан юм. |
| 26. | Ц.Элбэгдорж:Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийн мэндчилгээ 2011.01.13, №11 | Аливаа зүйл цагийн аясаар өөрчлөгдөн шинэчлэгддэг жамтай. Үндсэн хууль ч үүнийг гажихгүй, зарим өөрчлөлт баяжилтыг нэхэж байж магадгүй. | УИХ-аас баталсан Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эдгээр суурь зарчмуудыг дахин нэрлэж баталгаажуулсан нь чухал ач холбогдолтой зүйл болсон билээ.Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн хэн ч халдаж болохгүй үзэл санаа, зүйл заалт, үг, үсэг бүрийг тууштай хамгаалах нь бидний үүрэг. |

ХАВСРАЛТ 5

ӨНӨӨДӨР СОНИН /1999-2011/

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

| № | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
|---|---|---|---|
| | 2000 онд ҮХ-д оруулсан нэмэлт өөрчлөлт 24-1. "УИХ-ын дарга дэд даргыг УИХ-ын гишүүд дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно". | Ил санал хураалтын талаар: 1) 24.1 дэх хэсэгт "УИХ-ын дарга,дэд даргыг УИХ-ын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно...", 27.6 дахь хэсэгт "6... Ерөнхий сайд ЗГ-ын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ" гэж төсөлд тусгажээ. | 1)УИХ-ын гишүүн хэдийгээр улс төрийн намаас нэр дэвшиж, сонгуульд оролцдог боловч сонгогдсоныхоо дараа ард түмний элч болдог учир тэдний хараат бус байдлыг алдагдуулах,үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь хяналт тавих,намын бодлогыг ҮХ-д оруулж болохгүй гэж үзэж байна. |



| | | | |
|----|--|--|--|
| 1. | | <p>МУ-ын Шинэ ҮХ-иар нам төвтэй улс төрийн тогтолцоог халсан билээ.Олон намын тогтолцоо ҮХ-иар баталгаажигж нам,төрийн үйл хэргийг тусгаарлах бодлого хүчтэй явж байгаа өнөө үед УИХ-ын гишүүдийн хэн нь ямар санал өгөхийг хянах боломжийг ҮХ-иар нээж өгөх нь ардчилсан нийгмийн үндсэн зарчимд нийцэхгүй байна. -ҮХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна. (ҮХЦ-ийн гишүүд: ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат) -ӨН,2000-12-13, № 289</p> | <p>- Хэрвээ ҮХ-д улс төрийн намаас нэр дэвшиж гардаг өндөр албан тушаалтнуудыг сонгоходоо илээр санал хураадаг зарчим тогтвол МУ-ын ҮХ-ийн 23.1 дэх хэсэгт байгаа “УИХ-ын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн,улсын ашиг сонирхолыг эрхэмлэн баримтлана” гэсэн заалттай зөрчилдөнө гэж үзэж байна. -ҮХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна. (ҮХЦ-ийн гишүүд: ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат) -ӨН,2000-12-13, № 289</p> |
| | | <p>2) Саналаа илээр гаргаж, ердийн олонхиор асуудлыг шийдвэрлэнэ гэдэг бол УИХ дахь олонхийн таслах, шийдэх эрх монополь хийгээд үнэмлэхүй эрх болж хувирна. Чингэж нэг ба хоёрдугаар нэмэлт, тавдугаар өөрчлөлт нь засаглалыг хуваах, тэнцвэржүүлэх талаархи Үндсэн хуулийн амин чухал үзэл санааг зөрчиж, ардчилсан Үндсэн хуулийг бузарласан байна. Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2-р хэсгийн үзэл санаанд. Монгол Улсын Үндсэн хуулийн гол үзэл баримтлалд харшилж байна.</p> | <p>2/ Шахаа, дарамтын аргаар хүчлэн бүтээсэн төрийн машин хэвийн ажиллаж байсан түүхгүй. Төрийн машиныг олонхийн саналаар сонгож, олонхийн хүслээр томилж, нэр хүнд, эрх ба нөлөө бүхий хүмүүс зөвшилцөн тохирч байж бүтээх нь ардчилсан арга билээ. -Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно. Улс төр судлаач Д.Чулуунжав Цэцэд ханджээ. -ӨН, 2000-01-12, №9.</p> |
| | | <p>-Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно. Улс төр судлаач Д.Чулуунжав Цэцэд ханджээ. -ӨН, 2000-01-12, №9. 3) -Иргэн Д.Чулуунжав ҮХ-д оруулсан нэмэлт,өөрчлөлт бүр ньҮХ-тайгаа бүхэлдээ зөрчилдөж байна гэв.Саналыг илээр хураах болсон нь УИХ-ын гишүүн хэмээх ард түмний элчийг намын дуулгавартай зарц болгох алхам бөгөөд улмаар намжсан төрийг дахин төрүүлэх оролдлого юм.Ерөнхийлөгчийн эрхийг илт хумьж олонхийн мэдэлд шилжүүллээ.Парламент дахь намын бүлэгт харьяалагдаагүй гишүүд УИХ-ын даргаар сонгогдох эрхгүй болов гэж үзжээ. Ж.Бямбажав:Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар УИХ-аас гаргасан тусгай журам бий юу?</p> | <p>Ж.Бямбажав:Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар УИХ-аас гаргасан тусгай журам бий юу? 5/ Д.Чулуунжав: Үндсэн хуулийг хэлэлцэн баталсан АИХ сум,дүүрэг бүрийн төлөөлөлтэй болсон.Иймд бүрэлдэхүүнээр баталсан хуульд гар хүрэхдээ их бэлтгэлтэй ,өөрөөр хэлбэл тусгай журмаар хэлэлцэх ёстой байсан. -Д.Чулуунжав: Гишүүн бүр өөрийн бодол ,байр суурь дээр тулгуурлан саналаа өгөх ёстой.Дарамтанд орж саналаа өгснөө ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг шийдэлцсэний дараа зарим гишүүн олон түмний сонорт хүргэсэн. Ж.Бямбажав: Ил санал хураадаг болохоор төрийн ардчилал алдагдаж ,намуудын ноёрхол тогтнох үндэслэл тавигдах юм биш үү?</p> |

| | | | |
|------------------|--|---|---|
| | | <p>4) Д.Лүндээжанцан: -Тийм тусгай журам байхгүй.Тэгэхдээ нийт гишүүдийн 75-аас дээш %-ийн саналаар нэмэлт өөрчлөлтийг батална гэдэг бол чамлахааргүй өндөр босго.</p> <p>Н.Жанцан: Саналыг илээр хураадаг болсоноор ард түмний намын дуулгавартай зарц болголоо гэж Та яагаад үзэж байгаа юм бэ?</p> <p>5)Д.Чулуунжав: УИХ-ын гишүүд харьяалагддаг намынхаа даалгавар , дарамтаар ажилладаг болсон.Илээр санал хураадаг болсон нь үүний нэг нотолгоо.</p> <p>-УИХ-ын баталсан хууль ҮХ-ийг зөрчсөн гэж Цэц үзлээ. И.Ринчинханд -ӨН, 2000-03-16, №62</p> <p>6) УИХ-ын гишүүдийн заримых нь УИХ-ын дэд даргаар сонгогдох эрхийг хязгаарласан энэ заалт нь хүний аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагын гишүүний нь хувьд ялган гадуурхахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн 10 хэсгийн заалттай нийцэхгүй байна.</p> <p>-УИХ-ын гишүүдийн санал гаргах эрхийг намын хяналтанд авах нь Үндсэн хуулийн 3.1-ийг зөрчиж байна.</p> <p>АЖ</p> | <p>- А.Ганбаатар : Ярих хийх хоёр нь зөрж байх нь ардчиллын зарчимд нийцэхгүй.Саналыг нууцаар хураахад хэлэх, хийх хоёр зөрөх нөхцөл бүрэлддэг. Түүнээс гадна бидний сонгосон хүмүүс ямар асуудлаар ямар байр суурь баримталж байна вэ гэдгээ сонгогчид мэдэж байх ёстой.Тиймээ ч одоо ихэнх санал хураалт ил байгаа.</p> <p>- С.Нарангэрэл: Санал хураалт далд байх нь ,үзэл бодлоо хэний ч дарамт шахалтгүйгээр чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх нь ардчиллын баталгаа. УИХ-ын дарга,дэд дарга,Ерөнхий сайд,Засгийн газрын гишүүдийн илээр санал хурааж сонгодог болсоноор Парламент идээ бээрийг шахах механизмгүй болж байгаа юм.</p> <p>-УИХ-ын баталсан хууль ҮХ-ийг зөрчсөн гэж Цэц үзлээ. И.Ринчинханд -ӨН, 2000-03-16, №62</p> |
| <p>2.</p> | <p>27-2 “УИХ-ын ээлжит чуулган хагас жил тутуам нэг удаа 50-иас доошгүй ажлын өдөр чуулна.”</p> | <p>1. П.Очирбат:ҮХ-д жилдээ 150, 1 удаа 75-аас доошгүй хоног чуулна гэснийг ажил хүнд,толгой өвдлөө гэсэн шалтгаар 30 хувийг нь хасчихсан.Тэгээд 1 удаа 50 хоног чуулдаг болгосон.Үүнийг ажлын 6 өдрийг 5 болгосонтой холбон тайлбарладаг.Энгийн иргэдийн ажлын өдөр 10%-иар хасагдсан. Харин тэднийх 30%-иар хасагдсан. Эндээс дарга хүний ажлын өдөр ажилчныхаас бага байх ёстой гэсэн буруу логик гарч ирсэн. Байнгын Парламентын гол хэлбэр нь чуулган. Гэтэл манайд жилд 100 хоног ажиллаад бусад үед нь УИХ-ын гишүүд хаана яваа нь мэдэгдэхгүй,сураг тасардаг.</p> <p>-Үндсэн хуулийг *хольсны* долоон жилийн ойг тэмдэглэлээ...</p> <p>ӨН, 2007-01-15, №011/2969/</p> <p>/Ерөнхийлөгч асан П.Очирбат,гавьяат хуульч Б.Чимид нартайхийсэн ярилцлага.</p> <p>2)УИХ-ын чуулах хугацааг 50 өдөр болгосон нь УИХ-д цаашид үүрэгдэх ачааг биш, харин компанийн эзэдгишүүдийн эрх ашгийг элтээр бодсон өөрчлөлт болжээ. УИХ-ын цаашдын ачаалал болон УИХ-ын гишүүн тойргийн явцуу ашиг, сонирхлоос улам бүр залхаж, хөндийрч буй өнөөгийн байдлын алиныг нь ч тооцсон гэсэн чухал хугцааг чингэж богиносгох шалтгаан үгүй байна.</p> <p>- Ирц бүрдэх хувь, асуудал шийдэгдсэн гэж үзэх хувь, чуулах хугацаа, нууц санал хураалт зэрэг УИХ-ын хамт олны хүч, боломжийг аль болохуйцаар түлхүү дайчлах хугацааны, ирцийн, саналын нөөцийг чингэж бууруулах нь УИХ-ын гишүүн бол нийт иргэн улсын ашиг сонирхолыг эрхэмлэн баримтална гэсэн заалтад харшилж байна.</p> <p>-Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно. Улс төр судлаач Д.Чулуунжав Цэцэд ханджээ. -ӨН, 2000-01-12, №9.</p> | <p>1/ П.Очирбат: Гадаадын бусад оронд ч Парламент нь жилд 30-40 хоног завсарлаад бусад үед нь байнгын бэлэн байдалд ажилладаг.</p> <p>- Жилийн 365 хоногоос 112 нь баяр,амралтын өдөр гэж бодвол 253 нь ажлын өдөр түүний (75+75=)150 өдөрт нь эрхэм гишүүд чуулж, 153-т нь бусад хурал, зохион байгуулалтын ажлаа явуулж болох л баймаар. УИХ-ын чуулганы болон Байнгын хорооны хуралдааны хүчинтэй байх ирцийн хувийг ердийн олонхи болгох санал юм.</p> <p>-Өөр хуулиуд байсаар байтал Үндсэн хуулиа хөндөх гэх юм: Засгийн газрын төлөө бүү өрсөлдөөч, цаг нь ирэхээр хүн нь олдоно.</p> <p>-ӨН,1999-12-24, № 299</p> <p>Б.Лигдэн</p> <p>- УИХ хагас жил тутуам 75-аас доошгүй чуулдаг байсныг 50 болгон багасгаж, УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдааны ирцийн хувийг бууруулахаар төлөвлөжээ.</p> <p>-Үндсэн хуулийн үзэл баримтлалыг өөрчлөхүйц нэмэлт, өөрчлөлтийг санаачлагчид эл өөрчлөлтөөс үүсэх зэрэг ба сөрөг талыг судалсан танилцуулга, судалгааны материалыг хавсраагүй байна.</p> |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----------|---|---|--|
| <p>3.</p> | <p>27-6”УИХ-ын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд болон ЗГ-ын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ”</p> | <p>1) 4.УИХ-ын чуулганы болон Байнгын хорооны ирцийг цөөрүүлсэн буюу ҮХ-ийн 27.6 дахь хэсэгт оруулах өөрчлөлтийн талаар Энэ өөрчлөлт нь мөн чанартаа хурлын ирц нь бүрддэггүй, гишүүдээ цуглуулж чаддаггүй, сахилга,зохион байгуулалтгүй парламентад зориулж хийгдсэн өөрчлөлт болжээ. Энэ өөрчлөлт батлагдвал УИХ-ын чуулганд 76 гишүүний 39 нь хүрэлцэн ирснээр хурал хүчинтэй болж 20 гишүүний саналаар хууль батлагдаж байх болох нь. 2/ Байнгын хорооны хурлаар жишээ авхад өнөөдөр Аюулгүй байдал,гадаад бодлогын байнгын хороо гэхэд 9 гишүүнтэй байгаа түүний 5 нь цуглаж,3 гишүүний саналаар аюулгүй байдлын асуудлаа шийдэх болох нь.Үүний улмаас Парламент дах сахилга, зохион байгуулалтгүй байдлыг ҮХ-д өөрчлөлт хийж өөгшүүллээ. 3/ УИХ-д 20 хүн хууль баталдаг болсноор парламент ард түмний төлөөлөл биш боллоо гэж үзэхэд хүрэхээс сэрэмжлэхийг хүсэж байна.</p> | <p>1) ҮХЦ дэлхийн олон орны Парламентын чуулганы ирцийн хувь ямар байдгийг судлан үзлээ.Гэхдээ тэдгээр орны парламентын гишүүдийн тоо нь 200-600 гаруй хүнтэй байдаг тул хэзээ ч хуулийг 100-аас доош гишүүний саналаар батлах ойлголт байхгүй байна. -ҮХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна. (ҮХЦ-ийн гишүүд: ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат) -ӨН,2000-12-13, № 289</p> |
| | | <p>Энэ өөрчлөлт нь парламентаар батлагдан гарах хуулийн чанарт нөлөөлөхийг үгүйсгэхгүй байна. Мөн Парламентад 20 суудал авсан ганц намын саналаар хууль батлагдах магадлал өндөр болж байна -ҮХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна. (ҮХЦ-ийн гишүүд: ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат) -ӨН,2000-12-13, № 289 4) Ерөнхий сайд засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ гэжээ. Саналаа нууцаар гаргахаар заасан нь 1992 оны Үндсэн хуулийн дутагдал огт биш юм. Намуудийн өнөөгийн удирдлага, лидер хэмээгчдийг жинхэнэ чанар, байдлаас үзэхэд саналаа нууцаар гаргах нь тун ч зөв шийдэл мөн. Нууцаар санал хураахад гишүүд намын удирдлагын саналыг дэмжихгүй байгаа бол энэ нь мөнхүү намын өөрийн нь дотоод амьдралын асуудал, согог болохоос биш Үндсэн хууль дахь дутагдал, асуудал биш билээ. -Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно. Улс төр судлаач Д.Чулуунжав Цэцэд ханджээ. -ӨН, 2000-01-12, №9.</p> | <p>4) 5-р өөрчлөлт нь өмнө дурьдсан дутагдлын зэрэгцээ түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулах гэсэн ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах чухал заалтыг мөн орхигдуулжээ. Энэ нь төрийн дээд өндөрлөгүүдийн харилцан хяналт тавих бүтэн системийн чухал нэгэн гэнжийг тасдаж, төрийн машинд тавих шаардлага хяналтын мөрөөр авах арга хэмжээг үгүйсгэсэн байна. -Тулгуур хуулийн үзэл баримтлал ба үндсэн бүдүүвчийн гол чухал санаа, шүтэлцээг ингэж өрөөсгөлөөр өөрчилж болохгүй. -Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно. Улс төр судлаач Д.Чулуунжав Цэцэд ханджээ. -ӨН, 2000-01-12, №9.</p> |
| <p>4.</p> | <p>29-1 “УИХ-ын гишүүн нь Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.”</p> | <p>1) Санал болгосон 7 нэмэлтийн 4 нь шууд Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүдийг томилохтой холбоотой бөгөөд бусад 3 нь дашрамд ҮХ-иар бататгаад авах гэсэн зүйл юм гэж ойлгогдоно. Ерөнхий сайдтай холбоотой 4 нэмэлтийн гол цөм нь УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд 1998 -1-15-нд суулгаж өгсөн УИХ-ын гишүүн Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүн байж болно гэсэн заалтыг сэргээсэн хэрэг юм. Эндээс дараах хэд хэдэн зүйл ажиглагдаж байна. 2)Ерөнхий сайд,ЗГ-ын гишүүн нь УИХ-ын бүрэлдэхүүнээс томилогдсон туршилт 2 удаа байсан бөгөөд үүнээс юу хожив? юу алдав? гэдгийг судалж үзээгүй бөгөөд давтах зайлшгүй шаардлага гарвуу гэвэл үгүй.</p> | <p>Д.Лүндээжанцан, Д.Дондог, Т.Очирхүү нарын гишүүд Засгийн газрын гишүүний албыг хавсран хашдаг УИХ-ын гишүүдийн тоог цөөлөх тухай хуулийн төсөл нь Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт буруу байсныг УИХ хүлээн зөвшөөрч байгааг харууллаа гэж бодож байна.</p> |

| | | | |
|--|--|---|--|
| | | <p>Зүгээр л амбиц түшсэн хийсвэр механизм үүсгэж, түүнийг бусад орны Парламентат ёсны “туршлага”, Парламент, ЗГ-ын холбоо бэхжүүлэх арга гэж үзэж байгаа болохоос “Ардчилсан холбоо” эвслийн УИХ-ын хольцгүй гурван ЗГ-аас ийм сургамж гарлаа гэсэн дүн шинжилгээ байхгүй.</p> <p>3) УИХ-ын гишүүд яагаад Ерөнхий сайд, ЗГ руу зүтгээд байна вэ гэсэн сонин асуудал гарч байна.Хүмүүс үүнийг нэг талаар нэг том юмны ард нуугдаж буй намуудын хуйвалдаан, нөгөө талаар албан тушаалын амбицад хөтлөгдөж байна гэж үзэж байна. Үүнийг ҮХ-д суулгахын цаад санаа нь ҮХЦ-ийн шийдвэрт хаалт тавих л явдал байх.</p> <p>-Өөр хуулиуд байсаар байтал Үндсэн хуулиа хөндөх гэх юм: Засгийн газрын төлөө бүү өрсөлдөөч, цаг нь ирэхээр хүн нь олно. -ӨН,1999-12-24, № 299 Б.Лигдэн</p> | <p>-- 2000 оны өөрчлөлтөөр орж ирсэн энэ зохицуулалтын улмаас өнөөдөр 16 гишүүнтэй Засгийн газрын танхимын 13 нь УИХ-аас томилогдоод байгаа.Мөн засгийн газрыг 100 хувь парламентын гаднаас бүрдүүлэх нь гүйцэтгэх засаглалд тогтворгүй байдал үүсгэж, улс төрийн намууд ч бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлэх чадамжгүй болдог.</p> <p>- УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн гэсэн 2 албыг нэг хүн хаших нь буруу гэж боддог. Унасан сайд буцаад УИХ-д орж ирэхгүй байхыг Сонгуулийн хуулиар зохицуулж болно. Тухайлбал, УИХ-ын гишүүнээс татгалзуулж байж сайд болдог ч юм уу.Түүнээс биш хаалгаар гарсан хүн буцаад цонхоор ороод ирж болохгүй шүү дээ.</p> |
| | | <p>4) УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн гэсэн 2 албыг 1 хүн хаших нь их онцгүй.ЗГ огцорлоо гэхэд тэр кабинетын гишүүд итгэл хүлээсэнгүй гэсэн үг.Хэрэв кабинетын гишүүн нь УИХ-ын гишүүн байвал буцаад л УИХ-даа ирнэ.Нөгөө итгэл хүлээгээгүй гишүүн нь эргээд дараачийн ЗГ-ыг байгуулалцах нь.</p> <p>-Д.Ламжав: Ардчиллыг бэхжүүлэх чиглэлээр ҮХ-д хийх өөрчлөлтийг алгуурлаж болохгүй. И.Ринчинханд -ӨН,2000-12-22,№297</p> <p>5) Маргаад байгаа асуудлаа шийднэ гээд ҮХ руугаа дайрч ороод байвал төрийг төвхнүүлж чадахгүй, харин ч хямралыг гүнзгийрүүлж мэднэ. ҮХ маань нийгэм дэх улс төрийн хүчнүүдийн харьцаа,тэнцвэрийг зохицуулдаг юм.</p> <p>Парламент, Засгийн газар тусдаа байх ёстой.Учир нь одоо бид төрийн эрх мэдэл хуваарилах зарчим баримталж байгаа.</p> <p>-Б.Чимид: Маргаантай асуудлыг органик хуулиудаар зохицуулж болно.Ярилцсан Т.Тунгалаг -ӨН, 2000-07-24, №170/1023/</p> <p>6) МУ-ын ҮХ-д байгаа өөр 1 гүнзгий алдаа бол Засаглалыг хувааж, тэдний хооронд эрхийн тэнцвэртэй харьцаа тогтоож, төрийн засаглалыг ардчиллыг хангаж чадаагүй.Үүнээс болж харилцан бие биенээсээ хараат бус байгуулагдаж эрхийн тэнцвэрт харьцаа тогтсон төрийн засаглалууд нь ҮХ-иар олгогдсон эрхээрээ ҮХ-ийн хүрээнд зангидагдаж,зөвхөн ҮХ-иас хараат байж, түүгээр шүүгдэж, бие биенээ хазаарлан тогтоож байх чанар нь алдагджээ.</p> <p>7) Гэвч өмнөх хуулиудаас шинэ ҮХ-д давтагдан үлдсэн зарчмын гол алдаа бол төрийн засаглалын байгууллагуудыг тус тусад нь харилцан хараат бусаар ард түмнээр байгуулахаар тогтоогоогүйд оршино.</p> | <p>- Засгийн газрын үйл ажиллагааг УИХ-ын зүгээс хянах, түүнд хатуу шаардлага тавих, алдаа оноог нь илчилж зэмлэх, сайшаах, авилга, мафи, сөрөг үр дагвар авчрах, лобби зэргээс сэргийлэх, хууль тогтоох засаглалыг гүйцэтгэх засаглалаас зааглаж биеэ даасан байдлыг нь бэхжүүлэх зэрэг, зорилго, бодлогын үүднээс УИХ-ын гишүүн хүн Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэх нь зохистой, ашигтай биш юм. Улсын Ерөнхийлөгч Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн ажлыг хавсран гүйцэтгэх, Цагдаагийн дарга Улсын ерөнхий прокурорын үүргийг хавсрах УИХ-ын дарга Ерөнхий сайд хавсран гүйцэтгэх. УИХ-ын гишүүн засгийн газрыг гишүүний үүргийг хавсрах зэрэг нь үндсэндээ нэг зүйлүүд.</p> <p>- Улс төрийн ажил, албан тушаалыг бизнесийн хамгийн ашигтай төрөл мэтээр үзэж, ашиг завшаан горилхийлж, идэх өмчилхийг хүсэмжлэгч улстөрчдийн нүдэнд Монголын шилдэгийн шилдэг мэрэгжилтэй ч тээгэлдэггүй, торддоггүй ажээ.</p> <p>- Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно. Улс төр судлаач Д.Чулуунжав Цэцэд ханджээ. -ӨН, 2000-01-12, №9.</p> |

| | | | |
|--|--|--|--|
| | | <p>8/ УИХ-ын гишүүн ажил хийж чадахгүй байгааг нь учир мэдэх хүмүүс хэлсээр, мэдсээр байхад дээр нь бас сайдын мөр их ажилыг хавсруулж хийлгэх гээд зүтгээд байна. Өөрөө ч бас хийе гээд мэрийгээд байгаа тэр цөөн хэдэн хүнээс 2-3 дахин их мэдлэг бэлтгэл бүхий хүмүүс тэдний намд өөрт нь ч намд ч, нам бусуудын дотор ч өнөөдөр гэхэд хэдэн арваараа бэлээхэн байж байна.</p> <p>-УХ-ийн үзэл санаанд гажуудал их бий. -ӨН,1997-01-11,№ 008/046/ МУИС-ийн багш: Л.Мөнх-Эрдэнэ 9) МУ-ын ҮХЦ, ҮХ-ийн 68.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд МУ-ын ҮХ-д оруулах нэмэлт,өөрчлөлтийн төслийн талаар УИХ-д дараах саналыг өргөн мэдүүлж байна. ҮХ-ийн 29.1 дэх хэсэгт оруулах өөрчлөлтийн талаар ҮХЦ-д ҮХ дахь эрх мэдэл хуваарилах үндсэн үзэл баримтлалтай холбогдсон маргаан удаа дараа гарч байсны улмаас энэ асуудлыг Цэцийн гишүүд дэлхийн 40 гаруй орны ҮХ-д хийсэн харьцуулсан судалгаанаас судалсан . Хууль санаачлагч дэлхийн зарим орны туршлага болон МУ-ын онцлогоос хамаарч,УИХ-ын гишүүн нь ЗГ-ын гишүүнийг хавсран ажиллаж болно гэж үзэж байгаа, тухайлж хэлбэл 1 хүн засаглалын давхар эрх мэдэл авч болно гэх нөхцөлд үүнд зайлшгүй хязгаарлалт тавих шаардлагатай. 10/ Одоогийн санаачилсан төсөлд УИХ-ын гишүүд,ЗГ-ын гишүүдийн бүрэлдэхүүнийг бүхэлд нь хавсран ажилласан ч болохоор томъёолсон байна.Энэ нь манай ҮХ дахь эрх мэдэл хуваарилах үндсэн үзэл баримтлалтай зөрчилдөж байна. -УХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна. (ҮХЦ-ийн гишүүд: ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат) -ӨН,2000-12-13, № 289</p> <p>11/ Б.Чимид: Одоо мөрдөж байгаа 300 орчим хуульд ҮХ-ийнхаа заалтыг ягштал ойлгож,гүнзгийрүүлсэн танин мэдэхүй,арга зүйн үндэс бүхий нь ховор.Энэ нь ҮХ-ийн эрхзүйн үндэстэй холбоотой.Үүнээс шалтгаалан хуулиа ухаж мэдэхээс өмнө гуйвуулж тайлбарлаад, тэрэндээ орооцолдож,өөртөө тохируулан өөрчлөх гэсэн оролдлого нуухын аргагүй болсон. Монгол улс ҮХ-т байгуулалттай.ҮХ-иар тоглоно гэдэг галаар тоглохтой адил.Үүнийг ойлгоогүйн гайгаар дээрх өөрчлөлтийг хийсэн. 2000 онд ҮХ-нд өөрчлөлт оруулна гэхэд АИХ-ын депутатууд эрс эсэргүүцэж, нэн даруй зогсоо, ядаж, УИХ,ЗГ 2-оо салга гэж шаардсан.Тэр үед 7 зүйлд өөрчлөлт оруулсан.Үүнийг би “Дордуулсан 7 өөрчлөлт” гэж нэрлэсэн.</p> | <p>- Хэрэв заавал хавсаргах бодлого баримталж байгаа бол хууль тогтоогч ҮХ-даа дараах хязгаарлалтыг хийх хувилбарууд байж болохоор:</p> <p>-Зөвхөн Ерөнхий сайд УИХ гишүүн байж болохоор</p> <p>-Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүдийн гуравны нэг хүртэл %-нь УИХ-ын гишүүн байж болохоор</p> <p>-Хууль тогтоогч дээрх 2 хязгаарлалтаас илүү тохиромжтой гэж үзсэн хувилбар байвал түүнийгээ сонгож болох нь мэдээж.</p> <p>-Харин тодорхой хязгаарлалтыг салбар хуулиар тогтоох боломжгүй тул аль зохимжтойг нь ҮХ-даа суулгаж өгөх ёстой.</p> <p>-УХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна. (ҮХЦ-ийн гишүүд:ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат) -ӨН, 2000-12-13, № 289</p> |
|--|--|--|--|

| | | | |
|-----------|---|---|--|
| | | <p>Гэтэл тэд 2-р давхарт ирж хуралдаад УИХ-ын, 3-р давхарт ирж гарч хуралдаад ЗГ-ын гишүүн болж байна.Эндээс л хямрал үүдэлтэй.Учир нь ЗГ-ын тэргүүн нь намын дарга, Парламентын бүлэг нь намынхаа талд орох учиртай тул намын дарга нь парламентыг захирах болчихсон.Үүнийгээ Герман, Англид ингэдэг гэж тайлбарладаг.Дууриахад учир бий.</p> <p>12/ Улс төр судлаач ,цөөнгүй гишүүн, гуравдагч хүчний намуудын байр суурийг нэгтгэсэн хүсэл нь биелэх цаг ойртов.Энэ нь ҮХ-д 2000 онд оруулсан М У Парламентын тогтолцоотой юу,ЗГ нь илүү билүү гэх мэтээр засаглалын тогтолцоог "бантан" болгосон заалтууд. 2000 онд АН, МАХН хамтраад 24 цагийн дотор ҮХ-д долоон заалт бүхий өөрчлөлт оруулсан байдаг. Тухайн үеийн УИХ буюу АН,МАХН –ынхан ийм өөрчлөлт хийх төслөө 12 сарын 23 нд өргөн бариад 24-нд нь баталчихсан юм билээ.Өргөн барьснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэнэ энэ тэр гэсэн заалтыг сануулах "тэнэг"амьтан улс төрийн томоохон хуйвалдааны үед гарахгүй нь мэдээж.ЗГ-ын гишүүн УИХ-ын гишүүн байж болно гээд л эхэлдэг эдгээр заалтын "ид шид" –ийг өнгөрсөн 10 жилийн турш амсаад "дордохын долоо"гээд нэрлэчихсэн.Үүнийг хүсэн хүлээсэн ньолонхи байна.ЗГ уг нь гүйцэтгэгч.Одоогийн ЗГ-ын 16 сайдын 3 –аас бусад нь УИХ-ын гишүүн.</p> <p>-"Дордохын долоон өөрчлөлтийг" цуцлах галт тэрэг хөдлөв. 2011-1-15 № 12</p> | <p>11/ Б.Чимид: Жнь: Английн Парламент 2 танхим,1800 гишүүнтэй, Герман 700 гаруй гишүүнтэй.Энд ЗГ-ийн 10 гаруйхан хүн ямарч хувь эзэлж чадахгүй.Гэтэл манайд 16 сайд нь ороод л хуучнаасаа 3 хүн нэмээд л хууль баталчихаж байна.Ө/х: 20 хүн хууль баталдаг болчихсон ийм нөхцөлд 1 хүн 5%-ийн санал санал эзэлнэ.Тэгэхээр бусад УИХ-ын гишүүний хэрэг ч алга. Үүнийг л шүүмжилж байна.Халдварын голомт гэж юу вэ гэж та асуух байх.Энэ бол Төрийн эрх мэдлийг 1 хүн,1 байгууллагын мэдэлд оруулахгүйн тулд гаргасан зарчим.ҮХ-д оруулсан өөрчлөлтийн лайг одоо бид амсаж байна.</p> <p>12/ Ингээд ЗГ-т хяналт тавих УИХ-ын үүрэг бүдгэрч хэн нь хууль тогтоогч, хэрэгжүүлэгч гэдгээ ч мэдэхээ байсан.</p> <p>-"Дордохын долоон өөрчлөлтийг" цуцлах галт тэрэг хөдлөв. 2011-1-15 № 12</p> |
| <p>5.</p> | <p>23-1 Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.</p> | <p>1/ Дутагдлынхаа сөрөг үр дагварт уцаарлахдаа Үндсэн хуульд халдаж боломгүй санагдана. Ард түмний элч төлөөлөгчийг дан ганц намын дуулгавартай зарц болгох оролдлого хийх нь Үндсэн хуулийн 23.1. мөн 1.2-т харшилж байна.</p> <p>-Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно. Улс төр судлаач Д.Чулуунжав Цэцэд ханджээ. -ӨН, 2000-01-12, №9.</p> | <p>1/ Тохиолдлын гэхээр хүмүүс нэр дэвшиж УИХ-д сонгуулчихаад түүнийхээ сөрөг үрийг амсаж байгаа нь тухайн намын удирдлагын буруу, түүний боловсон хүчний бодлогын алдаа болно.</p> |
| <p>6.</p> | <p>33-1 УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ-аар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;</p> | <p>1. П.Очирбат: ҮХ-ийн өөрчлөлтийн асуудлаар ҮХЦ дунд суудлынхаа хурлаар буруу гэсэн шийдвэр гаргасан. Хуулиараа 15 хоногийн дотор УИХ хариу өгөх ёстой байтал хэдэн сар өнгөрсөн.11 сарын 30-нд дахин их суудлынхаа хурлаар хэлэлцээд эцсийн шийдвэр гаргасан. Ерөнхийлөгч ч хориг тавьсан.Тиймээс тэр нэмэлт хүчингүй.Ийм байхад 2000 оны 12 сарын 14-нд хүчингүй болгосон нэмэлтийг тэр чигээр нь УИХ-аар баталсан. Тиймээс УИХ өөрөө ҮХ-иа зөрчсөн.</p> <p>-Үндсэн хуулийг *хольсны* долоон жилийн ойг тэмдэглэеэ...</p> <p>ӨН, 2007-01-15, №011/2969/</p> <p>/Ерөнхийлөгч асан П.Очирбат,гавьяат хуульч Б.Чимид нартайхийсэн ярилцлага</p> <p>2) МУ-ын ҮХ-ийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ баталсан ба Ерөнхийлөгчийн хоригийг УИХ хүлээж авсангүй.Энэ асуудлыг тойрч үүссэн маргааны талаархи ҮХЦ-ийн шийдвэр хараахан гараагүй байна.МУ-ын ҮХ-д оруулсан нэмэлт,өөрчлөлтийн агуулга, арга хэлбэр нь улс төрийг улам бүр хурцатгасан төдийгүй Монголын төрд хямралт байдлыг үүсгэж, улс төрийн ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй болоод байна.</p> | <p>5/ МУ Ерөнхийлөгчийн эрх хэмжээг нэмэх эсхүл хязгаарлахад чиглэсэн заалтыг ҮХ-д оруулахдаа аль алинд нь туйлын болгоомжтой хандах хандах нь чухал байна.Төсөлд байгаа МУ-ын Ерөнхийлөгчийн эрх хэмжээг хязгаарлахад чиглэсэн 39.2 дахь хэсэгт орсон нэмэлт, 33.1 дэх хэсгийн 2-т орох өөрчлөлтийг хасахын зэрэгцээ Ерөнхийлөгчийн эрх хэмжээг нэмэгдүүлэхээр заасан 22.2 дахь хэсэгт оруулах нэмэлтийг нэгэн адил хасах шаардлагатай гэж үзэж байна.</p> <p>-ҮХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна.</p> <p>(ҮХЦ-ийн гишүүд: ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат)</p> <p>-ӨН,2000-12-13, № 289</p> |

| | | | |
|--|--|--|--|
| | | <p>3/ ҮХ-ийн тулгуур үзэл санаа, зарчмууд түүний дотор эдүгээ нэгэнт төлөвшиж эхэлсэн, төрийн эрх мэдлийн тэнцвэртэй хуваарилалтийг доголдуулж байна. Ийм эгзэгтэй өөрчлөлтийг зөвхөн парламентын намуудын удирдлагын хүрээнд яаруу давчуу шийдвэрлэсэн нь улс төрийн хувьд хөнгөн гоомой, ҮХ-ийг өөрийн нь зөрчсөн алхам боллоо гэж үзэхээс өөр аргагүй.</p> <p>4/ Өнөөгийн УИХ-д төрийн мэргэн ухаан, алсыг харсан төвшин нуруутай, төв тулхтай бодлого, улс төрийн үйл ажиллагааны соёл яах аргагүй дутагдаж байдгийн нэгэн тод илрэл боллоо.</p> <p>-МАХН-ын гишүүд, судлаачид уриалга гаргав. Тэд ҮХ-д оруулсан өөрчлөлтийг ҮХ-ийг өөрийг нь зөрчсөн алхам боллоо гэж үзэж байна.</p> <p>-ӨН, 2000-01-22, № 42</p> | <p>6/ Аль ч ангийн үндсэн хуульд Үндсэн хуульд яаран сандран гар хүрээд байдаггүй нь нийтлэг жишиг гэлтэй. Үүний тулд тусгайлсан хамгаалалтууд хийж өгдөг ажээ.</p> <p>- Грек, Норвег, Финлянд, Швед зэрэг улсад дараалж сонгогдсон хоёр парламентаар дамжуулан хэлэлцэж байж Үндсэн хуулийг шинээр батлах, нэмэлт өөрчлөлт од байна.</p> <p>уулах асуудлыг шийддэг</p> |
| | | <p>5) ҮХ-ийн 39.2 дахь хэсэгт оруулах нэмэлт, 33.1 дэх хэсгийн 2-т оруулах өөрчлөлтийн талаар:</p> <p>Хууль санаачлагч ҮХ-ийн 33.1 дэх хэсгийн 2-т өөрчлөлт хийснээрээ өмнө нь энэ хэсэгт байсан “Түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулах” гэсэн заалтыг МУ-ын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхээс хассан байна. МУ-ын ҮХ хэрэгжсэнээс хойш өнөө болтол огт хэрэгжүүлээгүй энэ заалтыг МУ-ын хэд дэх Ерөнхийлөгч хэний ЗГ-ын үед хэрэгжүүлэхээс болгоомжилж одоо ҮХ-иас хасах байгаа нь ойлгомжгүй байна. ЗГ-ыг огцруулах эсэх эцсийн шийдвэрийг Парламент өөрөө гаргаж байгаа манай орны нөхцөлд уг заалтыг ҮХ-иас яаравчлан хасах шаардлагагүй гэж үзэж байна.</p> <p>-ҮХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна.</p> <p>(ҮХЦ-ийн гишүүд: ҮХЦ-ийн дарга Н.Жанцан, Гишүүд: Ж.Болдбаатар, Д.Чилхаажав, Ж.Бямбажав, Ж.Амарсанаа, В.Удвал, Н.Чинбат)</p> <p>-ӨН, 2000-12-13, № 289</p> <p>6/) Ерөнхийлөгч түмний өмнө хүлээсэн үүргээ биелүүлж хуулиар олгосон эрхээ эдлэн хориг тавив. Хоригийг хүлээн авах эр зориг, ердийн ухамсар энэхүү Их хуралд байсангүй. Харин Ерөнхийлөгчийг үндсэн хуульд хориг тавих эрхгүй гэж зарим гишүүн мэдэмхийрч, хориг тавьсаны нь төлөө Ерөнхийлөгчийг үндсэн хуулийн цэцэд өргөн мэдүүлж байдаг цагаандаа гарчихсан гишүүн ч байдаг байна. Ийм Парламент зөвхөн монголд л байж дахин будилаан тарилгүй шиг байж байгаад энэ хавар хугацаагаа дуусгах болтугай.</p> <p>7) Харин иргэн би Монгол Улсын Үндсэн хуулийг нүд цавчилгүй хамгаалж өмгөөлж байх үүргээ биелүүлж чадаагүй нь төлөө Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийг Үндсэн хуулийн цэцэд өгмөөр байна.</p> <p>-Харин Н.Багабандийг Үндсэн хуулиа хамгаалж чадаагүйнх нь төлөө Цэцэд өгмөөр байна.</p> <p>-ӨН, 2000-01-31.28</p> | <p>- Сонгуулийн бүрэн эрхийн хугацааны сүүлчийн чуулганаар Үндсэн хуультай холбоотой асуудлыг авч хэлэлцэхгүй нь нийтлэг зүйл гэж хэлж болно.</p> <p>- Гэтэл Дани зэрэг оронд Үндсэн хуулийг парламентаар хэлэлцэж баталсны дараа зургаан сарын дотор ард түмний санал асуулга явуулж, сонгогчдын 40 %-ийг дэмжлэг авбал монарх батламжлан сая мөрдөж эхэлдэг аж. Иймэрхүү жишгийг Ирланд, Испани, Франц зэрэг орнууд дагадаг.</p> <p>- Харин Франц Улсан ерөнхийлөгч Парламентаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, парламентын гишүүдийн 3-ний 5-ын санал авсан бол референдумаар санал хураалгахгүй байж болдог онцлогтой.</p> <p>- Сонгогчдын санал асуулгаар Үндсэн хуулиа баталдаг улс ч бий. Сенегал 1963 онд, Гамби, 1970 онд, Камерун, Филиппин 1972 онд Үндсэн хуулиа ийм зарчмаар баталжээ.</p> <p>-Харин Н.Багабандийг Үндсэн хуулиа хамгаалж чадаагүйнх нь төлөө Цэцэд өгмөөр байна.</p> <p>-ӨН, 2000-01-31.28</p> |

| | | | |
|----|---|---|--|
| 7. | <p>39-2 “МУ-ын Ерөнхий сайд ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн УИХ-д өргөн мэдүүлнэ.</p> <p>Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй 7 хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол УИХ-д өөрөө өргөн мэдүүлнэ.”</p> | <p>1/ ҮХ-ийн 33.1 дэх хэсгийн 2-т оруулах өөрчлөлтийн талаар: ҮХ-ийн нэмэлт оруулахаар төсөлд тусгасан 39.2 дахь хэсгийн заалт нь үндсэндээ ҮХ-д байгаа өмнөх заалтаа бүрэн үгүйсгэсэн байна. Тухайлбал, Ерөнхий сайд нь төрийнхөө тэргүүнд саналаа тулган 7 хоногт зөвшилцөөгүй тохиолдолд УИХ-д өөрөө өргөн барьж байхаар болжээ.МУ-ын Ерөнхийлөгч төрийн тэргүүн болохынхоо хувьд гүйцэтгэх эрх мэдлийн бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлоход голлох үүрэгтэй оролцох нь түүний үүрэг байх ёстой. Энэ нэмэлтээр Ерөнхийлөгч МУ-ын Төрийн тэргүүний хувьд ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах асуудалд Ерөнхий сайдтай санал зөрсөн тохиолдолд өөрийн саналаа тусгуулах боломж үндсэндээ хаагдсан. -ҮХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна. (ҮХЦ-ийн гишүүд:ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат) -ӨН, 2000-12-13, № 289</p> | <p>1/ ҮХ-д тусгагдсан агуулгаараа “зөвшилцөх” хэмээх ойлголт нь төрийг хямралгүй байлгах үндэс мөн.Энэ утгаараа зөвшилцөх нь тэдний үүрэг байх ёстой. Харин 7 хоногийн хугацаа тавьж, нэг нь нөгөөгөө үл тоомсорлох нь төрийг хямрал руу түлхэх аюултай.Үүгээрээ энэ заалт ҮХ-ийн 30.1 дэх хэсгийн “МУ-ын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн. Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” гэсэн заалттай зөрчилдөж байна. -ҮХЦ нэмэлт, өөрчлөлтийн эсрэг байна. (ҮХЦ-ийн гишүүд:ҮХЦ-ийн дарга Н.Жанцан,Гишүүд:Ж.Болдбаатар,Д.Чилхаажав, Ж.Бямбажав,Ж.Амарсанаа,В.Удвал, Н.Чинбат) -ӨН, 2000-12-13, № 289</p> |
| 8. | <p>67 “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.”</p> | <p>1)П.Очирбат: ҮХ-ийн өөрчлөлтийн асуудлаар ҮХЦ дунд суудлынхаа хурлаар буруу гэсэн шийдвэр гаргасан. Хуулиараа 15 хоногийн дотор УИХ хариу өгөх ёстой байтал хэдэн сар өнгөрсөн.11 сарын 30-нд дахин их суудлынхаа хурлаар хэлэлцээд эцсийн шийдвэр гаргасан. -Үндсэн хуулийг *хольсны* долоон жилийн ойг тэмдэглэлээ... ӨН, 2007-01-15, №011/2969/ /Ерөнхийлөгч асан П.Очирбат,гавьяат хуульч Б.Чимид нартай хийсэн ярилцлага</p> | |
| 9. | <p>68-1 “ҮХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг ҮХЦ УИХ-д өргөн мэдүүлж болно</p> | <p>1) 68-1 тухайлбал Ерөнхийлөгч,УИХ-ын гишүүн,ЗГ гаргаж саналыг ҮХЦ УИХ-д мэдүүлэх эсвэл ард нийтийн санал асуулгаар явуулах тухай ҮХ-д заасан байгаа.Гэтэл нэмэлт өөрчлөлтийг УИХ-ын гишүүн ч гэсэн Парламентад суудалтай намуудын дарга нар санаачилж байгаа нь намын онц эрхийг бий болгож буй мэт. - Өөр хуулиуд байсаар байтал Үндсэн хуулиа хөндөх гэх юм: Засгийн газрын төлөө бүү өрсөлдөөч, цаг нь ирэхээр хүн нь олдоно. 1999-12-24, № 299 Б.Лигдэн 3) 68.1-р заалтыг дэлгэрүүлж, нэмэлт тодотгол хийсэн органик хууль,албан ёсны тайлбар үгүй нөхцөлд ямарч зөрчил, дур зоргын асуудал алхам хийгдэж болох талтай ч энэ талаарх жишээ,туршлага болсон Францын ҮХ-ийн Зөвлөлийн тогтсон жишиг бидний мөрдөх,дагах ёстой үзэл баримтлал, үлгэр дууриал байх учиртай.Мэргэжлийн улс төрчид, хуульчид маргаж болохгүй юм. -МУ-ын Үндсэн хуулийн 68-р зүйлийн 1-р заалтыг учир утга. 2000 оны 2-24, №044/897/ Д.Чулуунжав /Улс төр судлаач/</p> | |

| | | |
|--|--|--|
| | <p>4) Ж.Бямбажав: Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар УИХ-аас гаргасан тусгай журам бий юу? -Д.Лүндээжанцан: -Тийм тусгай журам байхгүй.Тэгэхдээ нийт гишүүдийн 75-аас дээш %-ийн саналаар нэмэлт өөрчлөлтийг батална гэдэг бол чамлахааргүй өндөр босго.</p> <p>5) Д.Чулуунжав: Үндсэн хуулийг хэлэлцэн баталсан АИХ сум,дүүрэг бүрийн төлөөлөлтэй болсон.Иймд бүрэлдэхүүнээр баталсан хуульд гар хүрэхдээ их бэлтгэлтэй ,өөрөөр хэлбэл тусгай журмаар хэлэлцэх ёстой байсан.</p> <p>Н.Жанцан: Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэх,батлах тусгай журам байхгүй тохиолдолд УИХ-ын хуралдааны дэгийн тухай гэх мэт хуулийг мөрдөх ёстой юу?</p> <p>6/ Д.Лүндээжанцан: Мөрдөх ёстой. Н.Жанцан: Тийм бол УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн 40-р зүйлд тухайн асуудлыг хэлэлцэхээс 7 хоногийн өмнө гишүүдэд тараана ...төслийн талаархи санал дүгнэлтийг Засгийн газар болон холбогдох бусад байгууллагаас авна гэсэн заалт бий. Үүнийг мөрдөөгүйн учир юу вэ?</p> <p>7/ Д.Лүндээжанцан: Бүлэг тус бүр дээрээс хэд хэдэн удаа хэлэлцээд 64 гишүүн нь уг төслийг санаачилж ,хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан тохиолдолд бусад хуулийн адил энэхүү журмыг заавал баримтлах шаардлагагүй гэж үзэцгээсэн.</p> <p>В.Удвал:64 гишүүн төслийг нь санаачилсан юм гээд түүнийг хэлэлцэлгүй шууд баталдаг хуулийн ямар заалт байна вэ?</p> <p>8/ Д.Лүндээжанцан: Уг төслийн нэгэнт нь урьд ярилцаж тохироод хэлэлцсэн бол түүнийг хэлэлцэх үед гишүүд заавал үг хэлэх шаардлагагүй шүү дээ.Олон хүн үг хэлээгүй болохоор Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг ажил хэрэгч бусаар хэлэлцсэн гэж үзээд байх шиг байна.</p> <p>Д.Дэмбэрэлцэрэн:Үндсэн хуулийн албан ёсны тайлбар байхгүй байгаа нөхцөлд УИХ-ын баталсан хууль , Цэцийн гаргасан дүгнэлт нэг ёсны тайлбар болж байдаг гэж би ойлгодог.Тэгвэл Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн чуулганы протоколыг мөн тайлбарлаж байгаа баримт бичиг гэж үзэж болох уу?</p> <p>9/ Д.Чулуунжав: Албан ёсны тайлбар гэж үзэж болохгүй.Ер нь хуулийн бүтээдэг хэрэглэдэг байгууллага тайлбар гаргах ёсгүй.Энэ үүднээс авч үзвэл Цэцийн шийдвэрийг л тайлбарын ач холбогдолтой гэж үзэж болох юм.</p> <p>10/ С.Нарангэрэл:Протокол нь түүхэн ямар нөхцөлд уг хууль батлагдав гэдгийг мэдэхэд тус болно.</p> <p>11/А.Ганбаатар: Хэлэлцүүлэгийн үед гишүүдийн гаргасан санал хожмоо их ач холбогдолтой байдаг учраас протокол нь баримт нотолгоо болно.</p> <p>Н.Жанцан:Үндсэн хуульд намын аргаар өөрчлөлт хийлээ гэснээ тайлбарлна уу?</p> | <p>1)Тэгвэл минийхээр хамгийн гол баримтлах зарчим бол 68.1-д “ҮХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг ҮХЦ УИХ-д өргөн мэдүүлж болно” гэсэн заалт юм.</p> <p>-УИХ-ынхан “болно” гэсэн үгээр тоглох л үлджээ: Ерөнхийлөгчийн алдааг ашиглах нь ашиглав бололтой.</p> <p>-ӨН,2000-01-06 №04/857/ Б.Лигдэн</p> |
|--|--|--|

| | | | |
|-----|---|--|--|
| | | <p>12/ Н.Баасанжав: Нам эвслийн бүлгүүд дээрээ урьдчилан ярьж тохирчихоод гарын үсэг зурчихаад чуулган дээр бараг шууд баталчихсан.УИХ үйл ажиллагаа явуулах гол хэлбэр нь чуулган шүү дээ.Гарын үсэг зурж асуудлыг шийдэх ёсгүй.</p> <p>-УИХ-ын баталсан хууль ҮХ-ийг зөрчсөн гэж Цэц үзлээ. И.Ринчинханд -ӨН, 2000-03-16, №62</p> <p>13) ҮХ-ийн 68-р зүйлийг "...саналыг ҮХЦ УИХ-д өргөн мэдүүлж болно" гэж заасан. Гэтэл УИХ энэ удаа ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулахдаа ҮХЦ саналаа гаргах эрхийг цаг хугацаагаар хавчиж,эдлүүлэх ямарч ч боломжгүй болгож ҮХ-ийг зөрчсөн.Түүнчлэн Ерөнхийлөгчтэй зөвшилцөлгүй түүнээс санал авалгүй, орон нутагт томилолтоор явж байхад нь ар хударгаар нь ҮХ-д өөрчлөлт оруулсан явдал нь ҮХ-ийн 30.1 дэх хэсэгт заасан заалтыг зөрчсөн.</p> <p>- МУ-ын ҮХЦэцэд,ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулж Монголын өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч,хуульч С.Нарангэрэл ҮХЦ-д хандсан байна. /1999.12.25./ -ӨН, 2000-01-03,№1/854</p> | |
| 10. | <p>68-2 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно.</p> | <p>1)ҮХ-ийн 68-р зүйлийн 2 дахь заалтын "болно" гэдгээр халхавчлан УИХ, ард нийтийн санал асуулга авах зориг байхгүй. Нэгэн иргэний бичсэн "Парламентын түрэмгийлэл" гэдэг нь ортой ч юм шиг.</p> <p>-УИХ-ынхан "болно" гэсэн үгээр тоглох л үлджээ: Ерөнхийлөгчийн алдааг ашиглах нь ашиглав бололтой.</p> <p>ӨН, 2000-01-06 №04/857/ Б.Лигдэн</p> | |
| 11. | <p>69-1 Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална.</p> | <p>1) ҮХ-ийн 68, 69-р зүйлд МУ-ын ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 6 заалтын эхний 2 нь ямар процедураар эхлэх, дараагийн 4 нь хэрхэн батлах, яаж дагаж мөрдөх тухайд холбогдох юм шиг байна.</p> <p>УИХ 69-р зүйлийн 1-ээр бүх асуудлыг шийджээ.</p> <p>Энгийн логикоор "мэдүүлнэ" гэж яагаад идэвхтэй хэлсэнгүй вэ, бас "мэдүүлж болно" гэж яагаад идэвхгүй хэлж байна вэ гэдэг асуулт гарах нь.Харсаар байтал Санаачилгыг гурван субъект гаргах нь, саналыг Цэц УИХ-д өргөн мэдүүлж болох нь.</p> <p>-УИХ-ынхан "болно" гэсэн үгээр тоглох л үлджээ: Ерөнхийлөгчийн алдааг ашиглах нь ашиглав бололтой.</p> <p>-ӨН,2000-01-06 №04/857/ Б.Лигдэн</p> <p>2) Цэцийн гишүүн Ж.Амарсанаа маргаан үүсгэн хянан шалгасны хувьд үндсэн илтгэлийг тавив. Түүний илтгэлээс үзвэл иргэн -С.Нарангэрэл өргөдөлдөө өнгөрсөн оны 12 сарын 24-нд ҮХ-д оруулсан өөрчлөлт нь ҮХ-ийн 3.1. дэх,16.16 дахь ,68.1дэх,69.1 мөн 30.1 заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзсэнбайна.</p> | |




Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|--|--|--|--|
| | | <p>Н.Жанцан: Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэхэд УИХ-ын 76 гишүүн бүрэн бүрэлдэхүүнээрээ байх ёстой гэж та үзэж байна уу?</p> <p>3) С.Нарангэрэл: Үндсэн хуулийн 69-р зүйлийн 1-д нэмэлт өөрчлөлт оруулахдаа нийт гишүүдийн 4-ний 3-аас доошгүй нь (энэ нь 57 гишүүн гэсэн үг) зөвшөөрснөөр батална гэж байгаа. Нийт гишүүд гэдгийг УИХ-ын 76 гишүүн бүрэн байх ёстой гэж ойлгодог. Гэтэл санал хураалтад ердөө 61 гишүүн оролцсон.</p> <p>-УИХ-ын баталсан хууль ҮХ-ийг зөрчсөн гэж Цэц үзлээ. И.Ринчинханд -ӨН, 2000-03-16, №62</p> | |
|--|--|--|--|

| | | | |
|-----|---|--|---|
| 12. | <p>25-2 -ын....</p> <p>4.Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.</p> | <p>1) УИХ-ын чуулганы болон Байнгын хорооны хуралдааны хүчинтэй байх ирцийн хувийг ердийн олонхи болгох санал юм. Үүнээс үзвэл, 76 гишүүний 39 нь хуралдаанд оролцож, хэрэв хууль батлахад ердийн олонхи болбол 20 нь хууль хэлэлцэн батлаж гаргаад байх нь. Энэ нь УИХ-ын гишүүдийн бараг дөрөвний нэг нь гэсэн үг.</p> <p>2/ Монголын Парламент заримынх нь үздэгээр шинэ гэгддэг. Шинэ тусмаа хууль тогтоох туршлага төдийлөн суугагүй нөхцөлд иймэрхүү байдалтай ажиллавал хуулийг лоббидох боломж их гарна. Гэхдээ саналд хууль хэлэлцэн батлах хувийг хэлээгүй байгаа нь эрхбиш дийлэнх олонхи гэсэн ойлголт хэвээр байхыг үгүйсгэхгүй. Тэгвэл 39 гишүүний 27 нь санал өгнө гэсэн үг. Дээр дурьдсан бүхнээс үзэхэд ҮХ-д бусад хууль, дотоод журмаар зохицуулж болохоор ийм гол биш зүйлийг түрээ барин өөрчлөлт оруулах гээд байх нь ийм том намууд, ийм том удирдагчдын сонирхлыг чухам юу татаад байна вэ? гэсэн зүй ёсоор гарна биз дээ. Энэ Парламент ядаж хугацааныхаа дунд үед асуудлыг тавиад чуулганаараа ёс журмаар нь хэлэцэх ёстой гэсэн бол өөр хэрэг. Ер нь их дуулгаваргүй Парламент л даа.</p> <p>-Өөр хуулиуд байсаар байтал Үндсэн хуулиа хөндөх гэх юм:</p> <p>Засгийн газрын төлөө бүү өрсөлдөөч, цаг нь ирэхээр хүн нь олдоно.</p> <p>1999-12-24, № 299 Б.Лигдэн</p> | <p>1) Энэ 7 нэмэлт нь ҮХ-ийн “УИХ-ын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн 25-2 дахь хэсгийн 4 дэх заалтад хамааруулан жич буюу хэвших сурснаар нь бусад хуулиар зохицуулж болох асуудал юм. Б.Чимидтэй санал нэг байна.</p> <p>2/ Аль нь амьдралд илүү тохирох тухай асуудлыг УИХ бусад хуулиар туршиж байж нягтлан судлаад дараа нь шалгарсан тэр механизмыг ҮХ-даа суулгаж өгөх хэрэгтэй.</p> <p>3/ Нөгөө 3 нэмэлтийн тухайд УИХ-тай холбоотой асуудлыг заавал ҮХ хөндөхгүйгээр УИХ-ын болон Дэгийн тухай, бусад хуулиар зохицуулж бас болох юм.</p> <p>-Өөр хуулиуд байсаар байтал Үндсэн хуулиа хөндөх гэх юм:</p> <p>Засгийн газрын төлөө бүү өрсөлдөөч, цаг нь ирэхээр хүн нь олдоно.</p> <p>1999-12-24, № 299 Б.Лигдэн</p> |
| 13. | <p>66-1 Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.</p> | <p>1) Д.Сугар /УИХ гишүүн: Цэц бол ҮХ-ийн биелэлтэд дээд хяналт тавих эрхтэй, түүнийг чандлан сахиулах баталгаа болохынхоо хувьд өөрийн эрх мэдлийн хүрээнд зөв шийдвэр гаргасан. Энэ шийдвэр эцсийн бөгөөд хүчин төгөлдөр учир бид биелүүлэх үүрэгтэй. Хамгийн гол нь төрийг хямруулалгүйгээр зохицуулах олон гарц бий. Уг шийдвэрийг гэмт хэрэг гэж тооцохын тулд Эрүүгийн хуульдаа шинэ зүйл анги нэмэх болох байх.</p> <p>-ҮХЦ гэмт хэрэг үйлдсэн үү? Ярилцлага, 2000-12-01, №279</p> | |

| | | | |
|------------|---|--|---|
| | | <p>2)Д.Солонго: МУИС-ийн ХЗДС-ийн багш: ҮХЦ-ийн шийдвэр парламентын *санаанд* тэр бүр нийдэггүй нь дэлхий дахинд нийтлэг ажиглагддаг зүйл.Мөн ЗГ-ын үйл ажиллагаанд хяналт тавих явдал нэг үүрэг нь болсон манай ҮХЦ-ийн бүрэлдэхүүнд ЗГ-ийн 2 агентлагийн захирал байж л байна шүүдээ.Энэ бол маш буруу.Цэцийн шийдвэр төрийг хямрал руу түлхэж байна гэж үзээд *гэмт хэрэг* гэснийг нь би хувьдаа буруутгахгүй. -ҮХЦ гэмт хэрэг үйлдсэн үү?Ярилцлага, 2000-12-01,№279 3) - Иргэн Н.Хайдав УИХ-ыг ҮХЦ-д олгосон онц эрхэд халдаж,ҮХ-д өөрчлөлт хийхдээ Цэцийн оролцоог хайхраагүй гэжээ. 4/ Иргэн Н.Баасанжав ҮХ-д намын аргаар өөрчлөлт оруулсан гэсэн байр суурьтай байв.</p> | <p>2)Д.Солонго: МУИС-ийн ХЗДС-ийн багш: Дашрамд хэлэхэд дэлхийн улс орнууд ҮХ-ийнхаа эх баримт бичигт гар хүрэхээс ихэд болгоомжилдог.Өөр бусад хуульд өөрчлөлт оруулах, тайлбар хийх зэргээр зохицуулах олон аргыг хэрэглэдэг. ҮХ-ийн тухайд *Амьд хууль* гэсэн нэр томъёог ч хэрэглэдэг. -ҮХЦ гэмт хэрэг үйлдсэн үү?Ярилцлага, 2000-12-01,№279</p> |
| <p>14.</p> | <p>66-2 Хууль, зарлиг, Улсын Их Хурал,... бусад шийдвэр, Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.</p> | <p>1) ҮХ-ийн нэмэлт өөрчлөлт нь ҮХ зөрчсөн эсэх тухай асуудлыг Цэц хэлэлцээд “Үндсэн хууль зөрчсөн” гэсэн 03 тоот дүгнэлтийг 2000-3-15-ны өдөр гаргасан.Үүнийг нь УИХ 15 хоногийн дотор хэлэлцэж “зөвшөөрнө”, “зөвшөөрөхгүй” гэсэн 2 шийдвэрийн аль нэгийг гаргах байсан боловч 100 хоногийн дараа хэлэлцсэн.Олонхи гишүүдийн дэмжсэнээр “ҮХЦ нь өөрийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар дүгнэлт гаргасан учир ҮХЦ-ийн 03 тоот дүгнэлтийг зөвшөөрөх, зөвшөөрөхгүй байх талаар ямар нэгэн шийдвэр гаргах боломжгүй” гэж УИХ үзэв. -Цэц бүрэн эрхдээ үл хамаарах асуудлаар дүгнэлт гаргасан гэж УИХ үзлээ. Ц.Нямдорж: УИХ Цэцийн дүгнэлийг биш ҮХЦ-ийн бүрэлдэхүүнийг авч хэлэлцэх шаардлагатай. Ярилцсан Д.Оюун-Эрдэнэ. 2000-7-29, №175 2) ҮХ-д өөрчлөлт оруулах саналыг УИХ дахь МАХН-ын бүлэг санаачлан Парламентын хуралдаанд яаравчлан оруулж,дөчин хэдхэн хором хэлэлцэн шийдвэр гаргуулсан.Эрхэм гишүүдийн энэхүү шийдвэр нь олон түмний дургүйцлийг хүргэж,маргаан ҮХЦ-д хүрч,Цэц хянан хэлэлцээд шийдвэрээ гаргалаа. -УИХ дахь МАХН-ын бүлэг ҮХ-д өөрчлөлт оруулахаар хэлэлцсэн протокол. -ӨН,2000-03-21,№66 3) С.Нарангэрэл: УИХ-ын 1999 оны 12-24нд баталсан ҮХ-ийн нэмэлт өөрчлөлт нь дараах хуулийн заалтуудыг ноцтой зөрчсөн учраас хүчингүй болгож өгөхийг хүсэж, ҮХЦцээд хандлаа. ҮХ-ийн 3.1 дэх заалтыг ноцтой зөрчсөн. УИХ-ын дарга Гончигдорж өргөн барьж,1 гишүүнээс бусад нь санал гаргалгүй яаран ахар богино хугацаанд баталсан бөгөөд эл асуудал чуулганы энэ удаагийн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байсан. 4) 23-р зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг ноцтой зөрчсөн нь дараах байдлаар нотлогдсон. 5) УИХ-д суудалтай намууд нийт иргэд,улсын ашиг сонирхол,үндэсний эрх ашгийг бүрэн төлөөлж чадахгүй байгаа.</p> | <p>4) УИХ-д суудалтай зөвхөн 3 намд ҮХ-ийн нэмэлт оруулах эрх байгаа гэж үзсэн нь өрөөсгөл.Дээд шүүхэд бүртгэлтэй 20 шахам улс төрийн нам хэлэлцэж зөвшилцөлд хүрэх ёстой.</p> |



| | | | |
|------------|---|--|--|
| | | <p>6) ҮХ-д яаран сандран "хуйвалдааны" замаар өөрчлөлт оруулсан нь ҮХ-ийн 16.9 дэх хэсгийн заалтыг ноцтой зөрчсөн.</p> <p>7) ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг иргэд сонгогчдод шүүн тунгаах ямарч боломж олгохгүйгээр УИХ-д хэлэлцэж баталсан нь 16.16-р заалтыг ноцтой зөрчсөн.</p> <p>8) ҮХ-ийн 69.1 дэх заалтыг ноцтой зөрсөн. Учир нь ҮХ-ийн 21.1-д заасан "УИХ 1 танхимтай, 76 гишүүнтэй байна" гэж заасан. Гэтэл энэ удаагийн УИХ хичнээн гишүүнтэй болсон, хэдэн гишүүн санал хураалтад оролцсоноос үзэхэд тодорхой болж байна.</p> <p>9) ҮХ-ийн 68-р зүйлийг "....саналыг ҮХЦ УИХ-д өргөн мэдүүлж болно" гэж заасан. Гэтэл УИХ энэ удаа ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулахдаа ҮХЦ саналаа гаргах эрхийг цаг хугацаагаар хавчиж, эдлүүлэх ямарч ч боломжгүй болгож ҮХ-ийг зөрчсөн. Түүнчлэн Ерөнхийлөгчтэй зөвшилцөлгүй түүнээс санал авалгүй, орон нутагт томилолтоор явж байхад нь ар хударгаар нь ҮХ-д өөрчлөлт оруулсан явдал нь ҮХ-ийн 30.1 дэх хэсэгт заасан заалтыг зөрчсөн.</p> <p>- МУ-ын ҮХЦ-ээд, ҮХ-д нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулж Монголын өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч, хуульч С.Нарангэрэл ҮХЦ-д хандсан байна.</p> <p>/1999.12.25./</p> <p>-ӨН, 2000-01-03, №1/854</p> | |
| <p>15.</p> | <p>20-р зүйл "УИХ бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгална"</p> | <p>1) Шинэ ҮХ төрийн тогтолцоог бүхэлд нь эрхийн үүднээс ардчилж, ард түмэн, үндэстний эрх төгөлдөр байдлыг хангасан эрх барих дээд байгууллага болж чадаагүй юм. Энэ нь ҮХ-ийн үзэл санаа, мөн чанарыг ойлгоогүй, түүнийг зөвхөн улсын гол хууль гэж үздэг хуульчийн нүдээр харж байсан, нөгөө талаар дагуулийн дэглэм ноёрхож байх үед ҮХ-ийг бараг Хөгжлийн мөрийн хөтөлбөр мэт ойлгодог сэтгэлгээнээс бүрмөсөн ангижраагүй байсны уршиг болов уу.</p> <p>2) Түүнээс гадна ҮХ-ийн "Их цааз" төсөл харьцангуй дэвшилттэй үзэл санааг агуулж байсан боловч АИХ-аар батлагдахдаа энэ шинжээ ихээхэн алдсан нь тухайн АИХ-ын Депутатуудын бүрэлдэхүүн, боловсрол, чадвараас шалтгаалсан бизээ. Эдгээр хүчин зүйлээс шалтгаалан МУ-ын ҮХ-д ҮХ-ийн хамгийн гол үзэл санаа болох ҮХ бол дээд эрх, эрх барих дээд байгууллага байх ёстой зарчим тодорхой тусгагдаж чадаагүй.</p> <p>3) ҮХ-д "УИХ бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгална" гэж тогтоосон нь ҮХ-ийн үзэл санааг зөрчиж байгаа төдийгүй тэр нь ҮХ-иар тогтоож хязгаарласан хууль тогтоох эрх мэдлийг бус, ерөөс хууль тогтоох эрх мэдлийг эдэлж байгаагаараа парламент бус, харин онцгой хууль тогтоох эрх мэдлийг хадгалсан төрийн эрх барих дээд байгууллага болж хувирчээ.</p> <p>-ҮХ-ийн үзэл санаанд гажуудал их бий.</p> <p>-ӨН, 1997-01-11, № 008/046/</p> <p>МУИС-ийн багш: Л.Мөнх-Эрдэнэ</p> | <p>1) УИХ-ыг Ерөнхийлөгч тараах шийдвэр гаргах нэмэлтийг Үндсэн хуульд оруулах нь Үндсэн хуулийн 20 зүйлийн "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн" гэсэн заалттай зөрчилдөж байна.</p> <p>2) -Ерөнхийлөгч зөвшөөрөх эрхгүй зөвхөн уламжлах үүрэгтэй болгож байгаа учир "Ерөнхийлөгчийн санал" гэж нэрлэх үндэсгүй, ингэхлээр Ерөнхийлөгчийн "үндсэн бүрэн эрх-д хамааралгүй болж байна.</p> |

| | | |
|--|--|---|
| | <p>4) Үндсэн хуульд 2000 онд оруулсан долоон өөрчлөлтийг олон хүн шүүмжилдэг.</p> <p>Таныхаар энэ өөрчлөлтийг эерэг ,сөрөг тал нь юу вэ?</p> <p>Монголын төрийг энэ долоон өөрчлөлт бүрэн дампуурсан. Засгийн газар нь УИХ-аа бараг хянах хэмжээнд очсон.Засгийн газар нь зохион байгуулалтайгаар УИХ-ын гишүүддээ авлига өгдөг болсон.Эерэг тал харагдахгүй байна. Тиймээс тэр гайтай долоон заалтын үйлчилгээг хамгийн түрүүнд зогсоох ёстой.</p> <p>Хууль тогтоогч ,гүйцэтгэх засаглалын гишүүн гээд хэн нь мэдэгдэхгүй ,хариуцлага хүлээх чадамжгүй их эрх мэдэлтэн бий болгочихоод байна.</p> <p>5/ 1992 оны Үндсэн хуулийг хэр болсон гэж Та үздэг вэ?</p> <p>1992 онд зах зээлийн эдийн засгийн орчин ,дэлхий дахины нийтлэг хандлагыг мэдээгүй ,ардчиллын утгыг гүйцэд ойлгоогүй нөхцөлд Үндсэн хууль баталсан л даа.Тиймээс нэг харахаар Парламентын нэг бол Ерөнхийлөгчийн засаглалтай ч юм шиг болсон.Гэвч түүнийг тэр хэмжээнд нь мөрдсөн бол ямар нэг хэмжээгээр хяналттай байх байсан.</p> <p>Одоо бол УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн гэдгээрээ гэдгээрээ бусдадаа дарамт үзүүлж байна.</p> <p>6/ ҮХ-д 20 жил тутамд өөрчлөлт оруулж ирсэн гэдэг.Таны бодлоор одоогийн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага байгаа юу?</p> <p>Өнөөдөр олон хүн төр орлохоор зүтгэж байна,энэ нь тэр хэмжээгээр төрийн удирдлага сарнихын шинж.</p> <p>Эрх зүйн дэглэмийг тогтоох ёстой.УИХ нь төрийн дээд эрхийг барьж бүх асуудлыг хэлэлцэх гээд Засгийн газрын эрх мэдлийг ч булаагаад байна. ҮХ-ийн төрийн тогтолцоог буруу хийснээс Монгол Улсын төрийн байгууламж сүйрэлд орно гэж олон хүн үзэж байна.</p> <p>7/ Тэгэхээр бид гадаад ,дотоод ертөнцийн байдлыг зэрэгцүүлж харах ёстой.Бид үнэхээр сайн ҮХ-тай , төрт ёс зөв явж байгаа бол ард түмний амьдрал дээшилж ,гадаад ертөнцөд Монголын нэр хүнд хоног хоногоор дээшилнэ.</p> <p>8/ Ард түмний санал асуулга явуулж байж шийдэх ёстой.Үүний тулд улс төр,эдийн засаг ,нийгэм дэх одоогийн ҮХ-ийн нөлөөллийн талаар дүн шинжилгээ хийх ёстой. Ардчилсан ҮХ баталснаас хойших олот,амжилтыг дүгнээд түүндээ үндэслээд уг ҮХ-ийн эерэг ,сөрөг талыг ард түмэндээ танилцуулах ёстой.Тэгэхгүйгээр ганцаарчилсан тоглолт хийх хэрээр алдаа гарна.</p> <p>ҮХ-д өөрчлөлт оруулахаар ҮШН-ын боловсруулсан төсөлтэй та танилцсан уу? Засаглалын хэлбэр өөрчлөх,үндэсний үзэлд суурилсан хуультай болох гэх мэт энэ төслийн зарчимтай Та санал нийлж байгаа юу?</p> | <p>4/ Ер нь дэглэмийн хяналтын систем болсон шүүх засаглалыг шударга ажиллуулах бүх нөхцөлийг ҮХ-иар бүрдүүлэх ёстой.Одоо бол Засгийн газар шүүх засаглалаа захирах гээд байна шүү дээ. Уг нь ЗГ-ын гүйцэтгэх үйл ажиллагааны дэглэмд хуулийн хэрэгжүүлэлтээр шүүх засаглал хяналт тавих ёстой.</p> <p>Хуулийг замбараагүй болгосон энэ үйл ажиллагааг яаралтай цуцлахгүй бол цаашаа юунд хүргэж мэднэ.</p> <p>6/ 1992 онд би “Монгол түүхэн уламжлалаа бодоод Ерөнхийлөгчийн засаглалтай улс байх ёстой”гэсэн санал хэлж байсан юм.Ерөнхийлөгч нь Гүйцэтгэх засаглалын тэргүүн бөгөөд төрөө удирддагйх, хууль тогтоох байгууллага нь төрдөө хяналт тавьдаг байх учиртай.Төрийн ажиллах нөхцөл,дэглэмийг УИХ тогтооно.</p> <p>-Ц.Хурц: (Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын Холбооны дэд тэргүүн)</p> <p>Ард түмний саналыг сонсож байж үндсэн хуулийг өөрчлөх ёстой.Ярилцлага. –ӨН, 2010-03-23, №68</p> <p>8/ Дэлхийд системийн анализ гэж бий болсон.Нэг системийг үнэлэхийн тулд 20-30 үзүүлэлт гаргаж, хамаарал, үл хамаарлаас шалтгаалж зөв яваа эсэхийг тодорхойлдог болсон.Ийм системийн анализ хийх эрдэмтэд , залуу боловсон хүчнүүд манайд бий болчихсон.</p> |
|--|--|---|



| | | | |
|------------|---------------------|---|--|
| | | <p>9/ Төсөлд зайлшгүй анхаарах авах юм олон байна. Болохгүй зүйл ч байна.Болохыг нь олон талаас нь нягтлан хэлэлцэж ,сайжруулж болно.Энэ төслийг боловсруулахад оюунлаг хүмүүс оролцож ,их ухаан заржээ.Тэгэхээр үүнийг шүүн тунгааж , цаашид боловсруулахад оюунлаг хүмүүс оролцож,их ухаан заржээ.Цаашид үүнийг шүүн тунгааж, цаашид боловсруулах ҮХ-ийн төслийн нэгэн тулгуур материал болгож болно.Зарчмыг нь дэмжиж байгаа.</p> <p>10/ Ерөнхийлөгчийн засаглалыг Та дэмждэг гэлээ.Нэг хүний ноёрхол тогтчих юм биш үү? Манай уламжлалт төрт ёс нь хаант засаглал. Ерөнхийлөгчийг яаж сонгох,ямар үед эгүүлэн татах, ямар үйл ажиллагаа явуулбал дэмжих, эс дэмжих гэх мэтийг хуульдаа тусгаж,зохицуулах ёстой. Монголд хариуцлага алга.Хэн ч ямар ч хэрэг өдүүлсэн бараг хайхрахаа больсон. Ялангуяа УИХ бүр хяналтгүй болсон.Өнөөдрийн УИХ-ын танхимд юу дуртайгаа хийж шийдэж байхад “боль” гэж хэлэх хэн ч алга ,гаргасан шийдвэр нь буруу байхад хариуцлага хүлээх эзэн ч байхгүй.</p> <p>11/ 2000 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг АН,МАХН нийлж хийсэн гэдэг.Одоо энэ хоёр нам эрх барьж байгаа.Тэгэхээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хэцүү юм биш үү.Бас УИХ-ыг тарааж ,үндэсний хувьсгал хийж байж Үндсэн хуулийг өөрчилнө гэж ҮШН үзээд байна.Үндсэн хуульд өөрчлөлт хийхийн тулд заавал хувьсгал хийх ёстой юм уу? Хувьсгал нь юу юм.Монголчууд төрт ёсыг дэндүү сайн мэднэ.Дуулиан шуугиант мөргөлдөөн, тэмцлээр төр тогтоомооргүй байна.Тиймээс ширээний ард сууж хэлэлцээд ард нийтээрээ яриад зохицуулж болно. Бузгай хувьсгал хийлээ гэсэн чинь дээд зэрэглэлийн харгислал тогтоочихыг үгүй гэх газаргүй.Тиймээс Үндсэн хуульд өөрчлөлт оруулах ажилд тун болгоомжтой хандах ёстой.</p> <p>-Ц.Хурц: (Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын Холбооны дэд тэргүүн) Ард түмний саналыг сонсож байж үндсэн хуулийг өөрчлөх ёстой.Ярилцлага. –ӨН, 2010-03-23, №68</p> | <p>9/ Хоёр шатлалтай. Парламенттай байх саналыг би 1992 онд ярьж байсан. 10/ Ардчилсан нийгмийн замаар дэлхий замнаж буй нөхцөлд дэг журамтай, хариуцлагатай төрт ёсыг бий болгохын тулд юу хийх ёстой вэ гэдгээ бодох нь чухал. - Хоёр танхимтай УИХ байх нь хяналт, хариуцлагын г бий болгох зорилготой. 11/ Жирийн хар ухаантай малчин өвгөдийн яриа төрт ёс тогтооход илүү чимэг , үндэслэл болно. -Ц.Хурц: (Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын Холбооны дэд тэргүүн) Ард түмний саналыг сонсож байж үндсэн хуулийг өөрчлөх ёстой.Ярилцлага. –ӨН, 2010-03-23, №68</p> |
| <p>16.</p> | <p>Бусад</p> | <p>1)Хууль батлагдсаны дараах хяналтын тухай тодорхой заалтууд ч манай ҮХ-д бий.Ийм заалтын тоонд 70.1-р, 64.1-р, 66.1-р, мөн зүйлийн 2-ын 1-р , мөн зүйлийн 4-р хэсгийг хамруулан үзэж байна. Ингэж Монгол улс бол ҮХ-ийн хяналтын хувьд хууль батлагдахын өмнөх ба батлагдсаны дараах хяналтын аль алиныг нь хэрэгжүүлдэг улс мөн юм. -МУ-ын Үндсэн хуулийн 68-р зүйлийн 1-р заалтыг учир утга. 2000 оны 2-24, №044/897/ Д.Чулуунжав /Улс төр судлаач/ 2) ҮХ-ийг өөрчлөхөөс өөр аргагүй бодит шаардлага үндэс гэж байна.1992 оны ҮХ-ийн хувьд түүнийг өөрчлөх зайлшгүй гэхээр олон согог дутагдал бий.1992 оны ҮХ нь дараах объектив болон субъектив олон шалтгаан нөхцөлтэйгээр мэндэлсэн.</p> | <p>1)ҮХ-д оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт ҮХ-иас урган гарах органик хуулиуд,ердийн хуулиуд,хуулийн хүчинтэй тогтоол, зарлиг,шийдвэр зэрэг нь ҮХ-д бүрэн нийцэж байна уу эсвэл харшилж байна уу гэдгийг зарим улс орон уг хууль, шийдвэрүүд батлагдаж, үйлчилж эхлэхээс бүр өмнө дээд хэмжээнд хянан үзэж,үнэлж дүгнэдэг. Ийм урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэх улсын тоонд Франц, Иран зэрэг орон орно.</p> |

| | | |
|--|--|---|
| | <p>3)Ардчилсан төрийн тогтолцооны талаархи зөв үзэл, онолын орчин үеийн төвшинд боловсрогдож чадаагүй</p> <p>4) Монгол үндэстэн,монгол төр, МУ-ын уламжлал, онцлогийг олон талаар зохиц хэмжээнд тусгаж шингээгээгүй</p> <p>5) “төрийн дээд эрхийн жолоог ард түмний гарт,ард түмний мэдэлд үлдээж чадсан байх” сайн ҮХ-ийн гол шаардлагыг хөсөрдүүлсэн</p> <p>6) Төрийн машины хэмжээ, зардлыг зөвшөөрч болох зохистой хэмжээнээс нь 3-4 дахин ихэсгэж нүсэрдүүлсэн.</p> <p>7) Үл биелэх шинжтэй, үл хэрэгжих нөхцөлтэй олон заалт агуулсан</p> <p>8)Колони, хараат байсан орныг шинэ эзэд,“ивээн тэтгэгчдийн” нь эрхшээл, нөлөөнд түргэн автуулах, цаашид холдохооргүй болгоход зориулж зохиомжилсон засаглалын тийм улбагар, сүржин атлаа даржин хэлбэрийг сонгосон</p> <p>9) Буруу нэр томъёо, олон салаа утгатай хэллэг олон агуулсан г.м.</p> <p>Гурван намын удирдагчдын санал болгож буй зүйлүүд нь зөвхөн л УИХ-ын өдөр тутмын үйл ажиллагаанд шинэ ҮХ-ийн үзүүлж буй зарим нэг бэрхшээлийг л багасгахад чиглэгджээ. Гэхдээ хүн бүрийн нэгэнт мэддэг , ил болсон хэдхэн зөрчлийг л гэтлэхэд зориулагджээ.Энэ бол 1992 оны ҮХ-д өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагын зөвхөн “хамрын үзүүр дээр байгаа нь” гэж дүрсэлж болох ялихгүй согог.</p> <p>-Хэнд зориулсан өнгөц өөрчлөлт юм болоо?</p> <p>-ӨН, 1999 оны 12-24 №299</p> <p>Д.Чулуунжав /Улс төр судлаач/</p> <p>10) МУНН дарга Ү.Хүрэлсүх: Үндсэн хуульд гар хүрэх ийм суурь асуудлыг МАХН гэнэт гарган тавьж тулгалт хийж буйд гайхаж байна.</p> <p>Тулгалт гэдгийг би цаг хугацааны хүчин зүйл , уг асуудлыг ярих өмнөх боломжит нөхцөл байдлуудтай нь холбон хэлмээр санагдлаа. МАХН-ын хувьд УИХ –ын ирэх сонгуульд олонхи нь болно гэдэгтээ дэндүү эрт тооцож байгаа бололтой.Харин УИХ-д суудалтай бусад нам нь энэ асуудалд тохиролцоонд хүрсэн бол тэр нь хуйвалдаан л байж таараа.Яагаад гэвэл УИХ-д суудал бүхий намууд сонгуулийн өмнөхөн Үндсэн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулах нэрээр өөрсдөө ашигтай засвар хийгээд байх нь ийм оролдлого хийх нь зохисгүй юм.</p> | <p>- Хууль батлагдахаас өмнө эсвээс тухайн хуулийг Парламентаар хэлэлцэж эхлэхээс өмнө , зарим тохиолдолд батлах эсэх талаар санал хураалт явагдахаас өмнө уг хууль нь ҮХ-д нийцэж буй эсэхэдҮХ-ийн зөвлөлөөс,ҮХ-ийн Шүүх (ҮХЦ)-ээс санал,дүгнэлт гаргаж Парламентад өгдөг. Хэрвээ хууль,шийдвэр нь ҮХ-д нийцэхгүй байна гэж ҮХ-ийн зөвлөл, Цэц үзвэл тэдгээрийг Парламент авч хэлэлдэггүй, санал хураалт,санал асуулга явуулдаггүй.</p> <p>-МУ-ын Үндсэн хуулийн 68-р зүйлийн 1-р заалтыг учир утга.</p> <p>2000 оны 2-24, №044/897/</p> <p>Д.Чулуунжав /Улс төр судлаач/</p> <p>-Гурван намын удирдагчдын санал болгож буй зүйлүүд нь зөвхөн л УИХ-ын өдөр тутмын үйл ажиллагаанд шинэ ҮХ-ийн үзүүлж буй зарим нэг бэрхшээлийг л багасгахад чиглэгджээ.Гэтэл цаана нь улс орны ашиг тус,үндэстний эрх ашиг, монгол төрийн хувь заяа, жирийн иргэдийн амьдрал, ирээдүйтэй холбоо бүхий нэн гүнийн, нэн чухал, нэн тулгарсан олон өөрчлөлт хүлээгдсэн хэвээрээ,Монголын нийгмийг түгшээж, ан цав үүдсэн янзаараа үлдэх байна.</p> <p>-Хэнд зориулсан өнгөц өөрчлөлт юм болоо?</p> <p>-ӨН, 1999 оны 12-24 №299</p> <p>Д.Чулуунжав /Улс төр судлаач</p> <p>10/ МУНН-ын дарга Ү.Хүрэлсүх: Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг бүх ард түмний хэлэлцүүлгийн үндсэн дээр авч үзэх нь бодитой хандлага болох бизээ</p> |
|--|--|---|

| | | |
|--|--|--|
| | <p>11/ Монголын Либерил Ардчилсан Намын дарга Т.Төрмөнх: МАХН-ын санаачилга бол УИХ-ын 2000 оны сонгуульд МАХН л бүх тойрогт авах юм шиг бодоод одооноос ширээ сандлаа хувиарлах талаар санаа зовж байгаа юм шиг харагдаж эхэллээ.Тийм л байсан юм бол анх Үндсэн хууль хэлэлцэж байхад яагаад үүнийг оруулж нэг мөр батлаагүй юм бэ гэдэг асуудал гарч байна.Нийгэм ийм байдалд орно гэж тодорхой тооны хүмүүс тэр дотроо С.Зориг тэргүүтэй ардчилсан хүчин хэлээд хэлээд МАХН ойлгохгүй байсан нь түүх болон үлдсэн. Монголын парламент хууль гаргаад дор дор нь солиод байвал монголчуудад хэн ч итгэхээ болино шүү дээ.</p> <p>-Улс төрчид дүргүй байна.-ӨН,1999-12-23 № 298</p> <p>12) П.Очирбат: 1990 оноос өмнөхтэй харьцуулбал дэвшилттэй боловч ҮХ-ийн чадамж, боломжтой харьцуулбал тулсан үр дүнд хүрээгүй.2000 онд зарим нэмэлт өөрчлөлт оруулснаас хойш хэрэгжих эрч саарсан.Зарим тохиолдолд хүрсэн дэвшлээсээ ухарсан.</p> <p>13/ П.Очирбат: ҮХ-д оруулсан нэмэлтийн гайгаар 2004 оны сонгуулийн дараа ЗГ-аа байгуулах гэж хичнээн юм болов.Эцэст нь 1992 оны хууль ч, 2000 оны нэмэлт ч үгүй болов. Намуудын хоорондын зөвшилцлийн дагуу 2 жилээр ээлжлэн ЗГ-аа барих болсон. Аль нь ч биелдэггүй 2 хуультай.</p> <p>-Үндсэн хуулийг *хольсны* долоон жилийн ойг тэмдэглэлээ...</p> <p>2007-01-15, №011/2969/</p> <p>/Ерөнхийлөгч асан П.Очирбат,гавьяат хуульч Б.Чимид нартайхийсэн ярилцлага.</p> <p>14) а/1924,1940,1960 мөн 1992 оны Үндсэн хуулиудад алинд нь ч өөрийгөө хамгаалах механизм байдаггүй.Хамгаалах механизм өөрт нь байхгүй тохиолдолд ҮХ-ийн Шүүх/Цэц/-ийн үүрэг чухал болдог.Бүх эрхийн эхлэл эх сурвалж нь *Хүний үнэлэмж халдашгүй* байх тухай заалт гэж гэж хууль зүйн ертөнцөд үздэг.Халдашгүй байдал буюу иммунитетийг улс орнууд ҮХ-иараа хүлээн зөвшөөрсөн байдаг ч *эрүүгийн* шинжтэй үйлдэлд холбогдуулан шалгах үед энэ эрхийг эдлэх нь зүй бус гэж үздэг.</p> <p>-Өөрийгөө хамгаалах механизм манай үндсэн хуульд байхгүй. -ӨН, 2008-01-10.</p> <p>Ярилцлага өгсөн: Ц.Сарантуяа.(ҮХЦ,Ханс Зайделийн сан)</p> <p>15) Эдгээр ҮХ-д оруулсан өөрчлөлтөөс болж төрийн эрх мэдлийн хуваарилалт алдагдсан нь өнөөдрийн улс төрийн хямралын шалтгаан гэж үзэв.Нэмэлт өөрчлөлт оруулах санааг МАХН 1999 онд УИХ-д суудалтай байхдаа МАХН,АН,МСДН хуйвалдан санаачилсан гэж буруутгав.</p> <p>-ҮХ-д оруулсан өөрчлөлтийг цуцлахыг шаардав.</p> <p>2007-2-14, № 037/2995/</p> | <p>11/ МЛАН-ын дарга Т.Төрмөнх: Үндсэн хуульд гэнэт гар хүрэхдээ тулсан юм бол үүнийг хэвлэл мэдээллээр нээлттэй байдлаар өргөн олонд мэдээлж ,нийгмийн идэвхтэй давхаргаар хэлэлцүүлэх нь зүйтэй.</p> <p>-Улс төрчид дүргүй байна.-ӨН,1999-12-23 № 298</p> <p>12) П.Очирбат: ҮХ-ийн гол үзэл баримтлалын дундуур нэмэлт оруулаагүй бол илүү хөгжих байсан.</p> <p>13/ П.Очирбат: ҮХ хямралын түвшинд орлоо.Тиймээс одоогийн УИХ үүнийг хүчингүй болгоод, 1992 оны ҮХ-ийг 2008 оны сонгуулиас эхлэн мөрдөх учиртай.</p> <p>- П.Очирбат: Сонгуулийг мөнгөөр хийдгээ болих хэрэгтэй.Мөн 1990 оны анхны ардчилсан сонгуулийн зарчмаар явуулах нь зөв. Авлигыг сонгууль эхлүүлсэн юм шүү дээ. Мөн Төрийн байгууллагыг намаас ангижруулах ёстой.(1960 оны үндсэн ҮХ-д МАХН удирдан жолоодогч хүчин байна гэсэн заалт байсан.Үүнийг сэргээчихээд байна)</p> <p>-Үндсэн хуулийг *хольсны* долоон жилийн ойг тэмдэглэлээ...</p> <p>2007-01-15, №011/2969/ /Ерөнхийлөгч асан П.Очирбат,гавьяат хуульч Б.Чимид нартайхийсэн ярилцлага.</p> <p>14) Жнь:хамгаалах механизмаа өөртөө агуулсан үндсэн хуулиуд байдаг.Жнь: Хүний үнэлэмж халдашгүй байх тухай, төр ардчилсан, нийгмийн баримжаат болох тухай,төрийн эрх мэдлийг хуваарилах талаархи заалтыг хөндөхийг ийм ҮХ-иар хориглодог. мөн Төрийн байгууламжийн хэлбэрийг өөрчлөхийг ч хориглох тохиолдол байна.</p> <p>-Өөрийгөө хамгаалах механизм манай үндсэн хуульд байхгүй. -ӨН, 2008-01-10.</p> <p>Ярилцлага өгсөн: Ц.Сарантуяа.(ҮХЦ,Ханс Зайделийн сан)</p> <p>15) Эрүүл нийгэм-иргэний хөдөлгөөнийхөн УИХ,Ерөнхийлөгч,Цэцээс ҮХ-д оруулсан хууль бус нэмэлт өөрчлөлтийг цуцлахыг шаардав.</p> <p>-ҮХ-д оруулсан өөрчлөлтийг цуцлахыг шаардав.</p> <p>2007-2-14, № 037/2995/</p> |
|--|--|--|

| | | |
|--|---|---|
| | <p>16) МАХН-ын удирдлагын санаачилсан ҮХ-д нэмэлт оруулах тухай зөвшилцөөнд Парламентад суудалтай 3 намын удирдагч нарын гарын үсэг зурсан зүйл,заалт сэтгэлд нийцэхгүй байна.Зөвшилцөөнд “МУ-ын ҮХ-ийн үзэл санааг улам гүнзгийрүүлэх,зарим зүйл,заалтыг боловсронгуй болгох үүднээс... ҮХ-д нэмэлт оруулахаар харилцан тохиролцож зөвшилцөв. ” гээд 2000-7-15-наас эхлэн мөрдөнө гэж мэдэгджээ.Энэ ерөнхий оршлоос үзэхэд ҮХ-ийн үзэл санааг улам гүнзгийрүүлэх гэсэн өгүүлбэр нь 7 нэмэлтээс харагдахгүй байна.</p> <p>- Өөр хуулиуд байсаар байтал Үндсэн хуулиа хөндөх гэх юм: Засгийн газрын төлөө бүү өрсөлдөөч, цаг нь ирэхээр хүн нь олдono. –ӨН,1999-12-24, № 299 Б.Лигдэн 17) Н.Багабанди: “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг бэлтгэх комиссыг УИХ-аас байгуулж, ажлыг нь нэн даруй эхлүүлэх саналыг УИХ-д оруулж байна. Үндсэн хуульд дахин оруулах гэж байгаа нэмэлт, өөрчлөлтийн зарим нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчмыг гажуудуулж, тодорхой зарим өөрчлөлт нь одоо байгаа заалттай нийцэхгүй зөрчил үүсгэж байгаа тухай 1999 оны 67, 2000 оны 01 тоот бичгүүддээ энэ тухай тодорхой бичсэн” 2000.12.138,№289.</p> <p>18) 1Удирдлагын академийн захирал, МАСН-ын тэргүүн Д.Бямбасүрэн: “Үндсэн хуулийг аль нэг явцуу эрх ашигт зохицуулан өөрчилж болохгүй.” №297. 2000.12.22</p> | <p>16) ҮХ-иа жам ёсны нь дагуу, Монгол төр ёсны уламжлал, ард түмнийхээ нийгэм сэтгэл зүйн онцлог хийгээд нийгмийн харилцааны өнөөгийн бодит байдалдаа сайтар нийцүүлэн бүх нийтээрээ хүлээн зөвшөөрөхүйц тийм үзэл санаа, арга хэлбэрээр боловсронгуй болгох түүхэн зорилт цаашид ч тавигдсаар байх болно. - МАХН-ын гишүүд, судлаачид уриалга гаргав.Тэд ҮХ-д оруулсан өөрчлөлтийг ҮХ-ийг өөрийг нь зөрчсөн алхам боллоо гэж үзэж байна. 2000-01-22, № 42 17/ Н.Багабанди:УИХ-ыг Ерөнхийлөгч гараах шийдвэр гаргах нэмэлтийг Үндсэн хуульд оруулах нь Үндсэн хуулийн 20 зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн” гэсэн заалттай зөрчилдөж байна. -Ерөнхийлөгч зөвшөөрөх эрхгүй зөвхөн уламжлах үүрэгтэй болгож байгаа учир “Ерөнхийлөгчийн санал” гэж нэрлэх үндэсгүй, ингэхлээр Ерөнхийлөгчийн “үндсэн бүрэн эрх-д хамааралгүй болж байна. -УИХ-ын гишүүдийн заримых нь УИХ-ын дэд даргаар сонгогдох эрхийг хязгаарласан энэ заалт нь хүний аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагын гишүүний нь хувьд ялган гадуурхахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн 10 хэсгийн заалттай нийцэхгүй байна. -УИХ-ын гишүүдийн санал гаргах эрхийг намын хяналтанд авах нь Үндсэн хуулийн 3.1-ийг зөрчиж байна. -УИХ хагас жил тутуам 75-аас доошгүй чуулдаг байсныг 50 болгон багасгаж, УИХ-ын чуулганы болон байнгын хорооны хуралдааны ирцийн хувийг бууруулахаар төлөвлөжээ. -Үндсэн хуулийн үзэл баримтлалыг өөрчлөхүйц нэмэлт, өөрчлөлтийг санаачлагчид эл өөрчлөлтөөс үүсэх эерэг ба сөрөг талыг судалсан танилцуулга, судалгааны материалыг хавсраагүй байна.</p> |
|--|---|---|



| | | |
|--|--|---|
| | <p>19) Ерөнхий сайд асан М.Энхсайхан:</p> <p>“Үндсэн хууль гэх мэт тулгуур асуудалд хичнээн ч хүч амтагдавч, хичнээн ихийг мэдэж байвч өөрчлөлтийг хийхдээ туйлын болгоомжтой байх учиртай сан. Наад зах нь Үндсэн хуулийн институтууд, парламентад суудалтай намууд Үндсэн хуульдаа оруулах өөрчлөлтийнхөө асуудлаар нэгдмэл саналтай байх нь чухал” №289. 2000.12.13</p> <p>20)УИХ-ын гишүүн Н.Ганбямба “Төрийн зүгээс зах зээлийн эдийн засгийн харилцаанд хэт хутгалдан орж байгаа механизмыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай.” №07/539/ 2007.01.11</p> <p>21)Б.Мандах-сэтгүүлч.</p> <p>“Үнэндээ Үндсэн хууль гэдэг нь батлагдан гарах бүхий л хууль, шийдвэрүүдийг ямар байх ёстойг зааж өгсөн, өөрөөр хэлбэл ямар хэлбэртэй байх вэ гэдгийг тогтоосон хэв загвартай тун төстэй зүйл аж. Хууль тогтоогчид хүссэн бүхнээ батлаад байх боломжийг Үндсэн хуулиар хаасан гэсэн үг. Энгийнчилж хэлбэл Үндсэн хууль гэдэг нь хууль тогтоогчдоос иргэдийг хамгаалах баталгаа л юм.” №10. 2011.01.14</p> <p>22)МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд захирал, дэд доктор Н.Лүндэндорж:</p> <p>“Үндсэн хуулийг тийм цаг үед өөрчилнө гэсэн жор байдаггүй. Хамгийн наад зах нь одоогийн зохицуулж буй Үндсэн хуулийн эерэг, сөрөг талыг баттай олж харсан тэр нөхцөлд л хуулийг өөрчлөх учиртай”</p> <p>№ 1999.12.21</p> | <p>-18/ Улс орны язгуур эрх ашгийн үүднээс Үндсэн хуульд өөрчлөлт хийх зүйл бий юу гэвэл бий. Тухайлбал, Ерөнхийлөгчийн засаглал тогтоох гэх юм уу, хоёр шаттай парламент бий болгох гээд өөрчлөлт оруулбал дорвитой өөрчлөлт хийх тухай асуудал байж болох юм. Түүнээс биш өнөөдөр МАХН-ын зүгээс УИХ-д тавьж байгаа шиг цаг зуурын шаардлагаар Үндсэн хуульд халдаж болохгүй.</p> <p>19) Үндсэн хуульд оруулах өөрчлөлтөө</p> <p>ардчилсан бус загнаж байж хийхэд хүрвэл Монголын төрийг цаашид хэврэгшүүлэх жишиг тогтоно гэж сэтгэл зовж байна.</p> <p>20/ Ер нь манай төрийн үйл ажиллагаанд шударга ёсны зарчим Үндсэн хуулийн дагуу үйлчилж байна уу” гэсэн сэдвээр ард түмний</p> <p>хэлэлцүүлэг явуулах нь зүйтэй.</p> <p>21) Үндсэн хуулийн зарчимд хүний жам ёсны эрхийг тусгасан болоод өөрчлөгдөн хувирах нь бага, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Ийм дээ ч Америкийн 200 жилийн настай Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн тоо манай 20 хүрэхгүй жилийн хугацаанд оруулсан өөрчлөлттэй бараг ижил. Мөн Японы Үндсэн хууль 1947 оны 5 сарын 3-наас хүчин төгөлдөр үйлчилж буй бөгөөд өдийг хүртэл нэг ч удаа нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Өх: жам ёсны эрх, Үндсэн хуулийн гол зарчим дээр тулгуурласан тохиолдолд л хууль урт настай оршдог аж.</p> <p>22)Үндсэн хууль гарган гэдэг аль нэгэн улс төрийн хүчин, хэн нэг хувь хүний шийдчих асуудал биш. Нийгмийн амьдралын хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд очсон бүлэглэлүүд нийлж байж Үндсэн хууль гаргадаг. Тэгж байж Үндсэн хууль, төрийн тогтолцоо, эрх зүйн тогтолцоо хүлээн зөвшөөрөгдөнө. Тиймээс улс төрийн хүчнүүдийн саналыг үгүйсгэх хэрэггүй.</p> |
|--|--|---|

| | | | |
|--|--|--|---|
| | | | <p>23) МУ-ын ҮХ-ийн 70 дугаар зүйлд “ Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэжээ. Тэгэхлээр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт бүр Үндсэн хуулийн “бие ба сэтгэлд” харшлах “ биеийг нь гэмтээх сэтгэлийг нь бузарлах” Үндсэн хуулиар нэгэнт тогтоосон эрх мэдлийн тэнцвэр ба шүтэлцээг эвдлэх ёсгүй.</p> <p>-Нам, эвслийн Улс төрийн товчоо болсон олонхийн гарт бүх зүйл орох болно. Улс төр судлаач Д.Чулуунжав Цэцэд ханджээ. -ӨН, 2000-01-12, №9.</p> |
|--|--|--|---|

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

| № | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
|----|---|---|---|
| 1. | 29-1 “УИХ-ын гишүүн нь Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.” | <p>Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Д.Энхбат тэргүүтэй УИХ-ын 15 гишүүн төсөл боловсруулсан байна. Тэд төсөлдөө санал авахаар Засгийн газарт хүргүүлжээ. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хууль баталсны дараа “эцэг” хуульд гар хүрэх анхны төсөл боловсруулсан нь энэ. Гишүүд төсөлдөө 2000 онд уг хуульд оруулсан долоон өөрчлөлтийг өөрчлөхөөр тусгажээ. Энэ талаар төсөл санаачлагчдын нэг Д.Энхбатаас тодрууллаа.</p> <p>-Үндсэн хуульд 2000 онд оруулсан долоон өөрчлөлтийг цэгцлэхээр төсөлд тусгасан гэсэн. Гол зохицуулалт нь юу вэ?</p> <p>1) Бид Үндсэн хуульд орон нутгийн засаг захиргаа гэх мэт том асуудал ярихаас илүү, өмнө нь хийсэн, нийгэмд шүүмжлэл дагуулаад буй долоон өөрчлөлтийг цэгцлэх байр сууринаас хандсан. Ингэхдээ Монголын засаглалын тогтолцоог гажуудуулж буй хоёр үндсэн заалтыг анхаарсан.</p> <p>2) Одоо Засгийн газрын бараг бүх гишүүн УИХын гишүүн байна. 38 хүн ажилдаа ирснээр УИХ асуудлыг шийддэг. Гэтэл тухайн намын хамгийн гол 15 хүн Бүлгээ үүсгээд, Засгийн газар, УИХ-аа “барьчихаар” УИХ бие даасан байдлаа алдчихаж байгаа юм. Дээрээс нь улсын төсвийг шүүмжилж, засах гэхээр Засгийн газрын гол хүмүүс УИХ-д сууж байдаг. Тэгэхээр Засгийн газраа УИХ хянаж чадахаа больдог.</p> <p>-Үндсэн хуульд 2000 онд оруулсан “дордохын долон өөрчлөлт”-ийг засна. -ӨН, 2011-01-12</p> | <p>1) Энэ бүхнийг засъя гэсэн юм. Гэхдээ практик ач холбогдлыг нь авч үзээд “Засгийн газрын нийт бүрэлдэхүүний гуравны нэг нь УИХын гишүүн байж болно” гэж тусгасан. Гадаад харилцааны, Хууль зүй, дотоод хэргийн, Ерөнхий сайд, Сангийн сайд нар УИХ-ын гишүүн байж болно гэж үзэж байгаа.</p> <p>-Үндсэн хуульд 2000 онд оруулсан “дордохын долон өөрчлөлт”-ийг засна. -ӨН, 2011-01-12</p> |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | |
|---|--|--|
| <p>2. 22-2 “ҮХ-д өөрөөр заагаагүй бол МУ-ын Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ –д өргөн мэдүүлснээс хойш 45 хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл МУ-ын Ерөнхийлөгч УИХ-ыг тараах тухай шийдвэр гаргана.”</p> | <p>1) ҮХ-д оруулах гэж буй өөрчлөлтүүд нь МУ-ын төр гацалгүй, хэвийн тогтмол ажилладаг байх эрх зүйн нөхцөлийг хангах явдал.Ингэж ажиллаж байж л төр хүчтэй байна гэж бид үздэг.1996 оноос сонгуулиас хойш Монголын төр хэд хэдэн удаа гацсан.Үүний 1 баримт нь үүрэг гүйцэтгэгч Ерөнхий сайдтай хагас жил болсон. Энэ нь ҮХ-д тодорхой бус зүйл цөөнгүй байгаа дээр ашиг сонирхлын бүлгүүд тоглож буйн жишээ ч болж чадах баримт юм.</p> <p>-Н.Энхбаяр: Үндсэн хуульд бид зарчмын, томоохон өөрчлөлт оруулах гэзгүй.</p> <p>1999 оны 12-24,№ 299/849/</p> <p>И.Ренчинханд</p> | <p>1) Ерөнхий сайдаа томилж чадахгүй удаж дэлхий дахиныг гайхуулсан. Ийм арчаагүй байдал гаргахгүй байх үүднээс Ерөнхий сайдыг 45 хоногийн дотор томилж чадахгүй бол УИХ өөрөө тарах,эсвэл Ерөнхийлөгч түүнийг тарааж байх нь зүйтэй гэж үзсэн.</p> <p>-Н.Энхбаяр: Үндсэн хуульд бид зарчмын, томоохон өөрчлөлт оруулах гэзгүй.</p> <p>1999 оны 12-24,№ 299/849/</p> <p>И.Ренчинханд</p> |
| <p>3. 3-зүйлийн 1 дэх заалт МУ-д засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна... 20-р зүйл Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.</p> | <p>1) Нам гишүүнээ сонгуульд нэр дэвшүүлдэг, тэд хууль батлах эрхийг ард түмнээс авдаг. Гэтэл 76 хүн УИХ-ын болон Байнгын хорооны даргыг өөрсдөө сонгож чадахгүй, намын Бүлгээс асууж байна. Тухайлбал, хоёр нам Засгийн газар байгуулахдаа албан тушаалуудаа тохиролцсон. Байгаль, орчин, Хүнс, Хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын суудал АН-ынх. Тиймээс АНын бүлгээс л нэр дэвшүүлнэ. МАН-ынхан үүнд саналаа өгөх эрхгүй. Энэ бол төрийн эрх мэдэл ард түмний гарт байна, УИХ төрийн эрх барих дээд байгууллага гэсэн заалтыг зөрчиж, гишүүний бүрэн эрхэд халдаж буй хэрэг. Гишүүд УИХ-ын бүтцийг байгуулахдаа санал өгөх эрхээ хасуулчихаж байгаа юм. Нам нь шийдсэн тул дуугүй сууна.</p> <p>-Үндсэн хуульд 2000 онд оруулсан “дордохын долон өөрчлөлт”-ийг засна. -ӨН, 2011-01-12</p> <p>2) Улс төр судлаач ,цөөнгүй гишүүн, гуравдагч хүчний намуудын байр суурийг нэгтгэсэн хүсэл нь биелэх цаг ойртов.Энэ нь ҮХ-д 2000 онд оруулсан М У Парламентын тогтолцоотой юу,ЗГ нь илүү билүү гэх мэтээр засаглалын тогтолцоог “бантан” болгосон заалтууд.2000 онд АН, МАХН хамтраад 24 цагийн дотор ҮХ-д долоон заалт бүхий өөрчлөлт оруулсан байдаг.Тухайн үеийн УИХ буюу АН,МАХН –ынхан ийм өөрчлөлт хийх төслөө 12 сарын 23 нд өргөн бариад 24-нд нь баталчихсан юм билээ.Өргөн барьснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэнэ энэ тэр гэсэн заалтыг сануулах “тэнэг”амьтан улс төрийн томоохон хуйвалдааны үед гарахгүй нь мэдээж. ЗГ-ын гишүүн УИХ-ын гишүүн байж болно гээд л эхэлдэг эдгээр заалтын “ид шид” –ийг өнгөрсөн 10 жилийн турш амсаад “дордохын долоо”гээд нэрлэхчихсэн.Үүнийг хүсэн хүлээсэн ньолонхи байна.ЗГ уг нь гүйцэтгэгч.Одоогийн ЗГ-ын 16 сайдын 3 –аас бусад нь УИХ-ын гишүүн.Ингээд ЗГ-т хяналт тавих УИХ-ын үүрэг бүдгэрч хэн нь хууль тогтоогч, хэрэгжүүлэгч гэдгээ ч мэдэхээ байсан.</p> <p>-“Дордохын долоон өөрчлөлтийг” цуцлах галт тэрэг хөдлөв. 2011-1-15 № 12</p> | <p>1) Бид төсөлдөө намыг Парламентаас тусгаарласан. Намын бүлэг зөвхөн УИХ-ын доторх хүрээнд ажиллана, дээр нь гарахгүй.</p> <p>- Улс төрийн өнөөдрийн нөхцөл байдлыг харж үзээд 2012 оны сонгуулийн дараа буюу наймдугаар сараас уг хуулийг мөрдөхөөр тусгасан. Уг өөрчлөлтөөр УИХ-ын бие даасан байдал, Засгийн газраа хянах чадвар, гишүүдийн болон улс төрийн намын хоорондох харилцааг илүү ил тод болгосон. Гишүүд УИХ-ын хуулийн хүрээнд л намтайгаа харьцана. Бусад таван заалт дээрх хоёроо бодоход нөлөө нь бага учир хөндөөгүй.</p> <p>-Үндсэн хуульд 2000 онд оруулсан “дордохын долон өөрчлөлт”-ийг засна. -ӨН, 2011-01-12</p> |

| | | | |
|----|--|---|--|
| 4. | <p>27-2 “УИХ-ын ээлжит чуулган хагас жил тутуам нэг удаа 50-иас доошгүй ажлын өдөр чуулна.”</p> | <p>1.УИХ-ын гишүүн Ша.Батбаяр: “УИХ-ын хуралдааны дэгтэй холбоотой заалтууд парламентын үйл ажиллагаанд зарим талаар саад болж байна. Жнь: гишүүд хуралдаандаа дандаа оролцох нь тэдний хариуцлагатай холбоотой асуудал мөн боловч ирц бүрдээгүйгээс улс орны эрх ашиг хохироход хүрч байна.” АЖ</p> <p>2.УИХ-ын гишүүн Ч.Сайханбилэг: “УИХ-ын гишүүн ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүн байж болох тухай заалтаар л лав хязгаарлагдахгүй. Тухайлбал: УИХ-ын нэг удаагийн (хавар намар) чуулган 75-аас доошгүй хоног хуралдах ёстой. Гэтэл ажлын 5 өдөрт шилжсэнээр нэгэн удаагийн чуулганы хуралдах хугацаа сунаж, чуулгануудын хооронд бараг амрах боломжгүй болоход хүрч байна.”</p> <p>-Парламентын намууд санал нэгдчихсэн юм байна. ӨН,1999.12.21</p> | |
| 5. | <p>Бусад</p> | <p>1)УХ-д нэмэлт ,өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы өчигдрийн хуралдаанаар баталлаа.10 гаруй жил ярьж байж түүхэн хууль гаргасан нь энэ.УХ-д нэмэлт өөрчлөлт оруулахдаа ямар зарчим баримтлахыг үүгээр зохицуулжээ.</p> <p>3/ Журмын тухай хуульд УХ-ийн хөндөж болохгүй заалтуудыг тодорхойлсон.Үүнийг хууль санаачлах бүрэн эрхийг хязгаарлаж байна гэсэн шүүмжлэл хэлэлцүүлэгийн үеэр гарсан...</p> <p>Бусад улсад ч ийм хязгаарлалт бий.</p> <p>4/ УХ-д үндсэн бүтэц , суурь үзэл баримтлал гэж байдаг.Үүнийг л өөрчилж болохгүй гэсэн үг.Тухайлбал МУ ардчилсан Бүгд Найрамдах Улс байна.Монгол хэл төрийн хэл байна.гэх мэт заалтыг өөрчлөхийг зөвшөөрөхгүй шүү дээ.</p> <p>5/ УХ-д нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн чуулганаар хэлэлцэх эсэхийг 3-ны 2 батлахдаа заалт бүрээр нийт гишүүний 4-ний 3 –ын саналаар шийднэ.</p> <p>6/ Мөн заавал гурван удаа хэлэлцүүлнэ.</p> <p>Эдгээрийг нэлээд өндөр босго гэж үзэх гишүүд ч байсан.</p> <p>7/ Харин ч Б.Чимид гуайн ахалсан Дэд ажлын хэсгийн өгсөн 40 хуудас төслөөр бол ямар ч өөрчлөлт оруулах боломжгүй байсан.Нийт сум дүүрэг , багийн 50 %-с дээш зөвшөөрөл авсан байх гэх мэт заалт байсныг харьцуулахад гайгүй.Одоо Ерөнхийлөгч , Цэц ,ЗГ-аас санал аваад л төслөө чуулганд оруулна.</p> <p>Журмын хуулийг баталсан учир УХ-д 2000 онд оруулсан дордуулсан долоон өөрчлөлтийг цуцлах боломжтой боллоо гэсэн үг үү?</p> <p>Журмын тухай хуулийн төсөл боловсруулж оруулж ирээд дээрх процедурын дагуу хэлэлцүүлнэ.Шууд хүчингүй болгох үндэс байхгүй.</p> | <p>1)Санал хураах үеэр танхимд 10-хан гишүүн суугаад л нэгнийхээ өмнөөс товчлуур дарж хууль батлах нь бий.Ийм тохиолдолд хариуцлага тооцох зохицуулалт байдаг уу?</p> <p>-Чуулган нээхэд 39 хүнээс дээш ирцтэй байх учиртай.Тэгээд тухайн хүн гараад явсан бол картыг нь сугалахгүй ,зэрэг санал өгсөнд тооцоод л явна.</p> <p>- Зарим тохиолдолд гишүүд “Гадны хүнтэй уулзах ажилтай байна .10 минут гарчихаад ирье бол уг асуудлыг дэмжиж байгаа миний өмнөөс дараарай” гээд баталгаа өгөөд танхимаас гарах нь бий.</p> <p>- УХ-д өөрчлөлт оруулах хуулийн журмын тухай хуульд “УХ-д нэмэлт өөрчлөлт оруулах төслийн хэлэлцэж буй бол гишүүн нэг л саналыг эрх эдэлнэ.Бусдын өмнөөс товчлуур дарахыг хориглоно.гэж тусгасан.57-гоос дээш гишүүн байж хуулийг хэлэлцэнэ гэх мэт процедурыг тодорхой заасан.</p> <p>-Ө.Энхтүвшин: Үндсэн хуульд 2000 онд оруулсан өөрчлөлтөд “гар хүрэх “боломжтой болсон. 2010-12.24 № 297</p> <p>4) Аль ч ангиллын үндсэн хуульд Үндсэн хуульд яаран сандран гар хүрээд байдаггүй нь нийтлэг жишиг гэлтэй.Үүний тулд тусгайлсан хамгаалалтууд хийж өгдөг ажээ.</p> <p>- Грек,Норвег,Финланд ,Швед зэрэг улсад дараалж сонгогдсон хоёр парламентаар дамжуулан хэлэлцэж байж Үндсэн хуулийг шинээр батлах,нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг шийддэг байна</p> |



| | | |
|--|---|--|
| | <p>8/ Тэр 7 өөрчлөлт оруулах төслийг 2000 оны 12 сарын 23-нд өргөн бариад 24-нд нь баталчихсан. Ерөнхийлөгч,Цэцээс ч санал аваагүй.Хуулийн төслийг өргөн барьснаас долоо хоногийн дараа хэлэлцэнэ гэдэг процедурыг ч зөрчсөн байдаг. Арай л эргэлзээтэй юм болсон.Тэр үед Журмын хууль ч гэж байсангүй.Тиймээс л ийм хууль хэрэгтэй гэж үзсэн.</p> <p>-Ө.Энхтүвшин: Үндсэн хуульд 2000 онд оруулсан өөрчлөлтөд “гар хүрэх “боломжтой болсон.</p> <p>2010-12.24 № 297</p> <p>9)Монгол улсад одоо мөрдөж байгаа нэн шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 19 жилийн хугацаанд 2000 онд нэг дор долоон өөрчлөлт оруулсан. Нийгмийн хурдацтай хөгжил бодит байдлын өөрчлөлт ,цаг үеийн шаардлагад Үндсэн хуулийн зарим зүйл заалт төдийлөн нийцэхгүй болсныг нийгмийн амьдралын 20- иод жилийн үр дүн харуулах болсныг УИХ-ын дарга Д.Дэмбэрэл хүлээн зөвшөөрчээ.</p> <p>10/ УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ахлуулсан 40 хүний бүрэлдэхүүнтэй, 108 хоногийн томилолттой “Ажлын хэсэг” байгуулагдсан.</p> <p>11/ УИХ МУ-ын ҮХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах Ажлын хэсгийнхэнд зориулж, “МУ-ын ҮХ-д нэмэлт,өөрчлөлт оруулах журам” – ыг нь хуульчилж өгсөн.</p> <p>12/ Энэ хуулиар ҮХ-ийн хэн ч халдашгүй халдашгүй амин сүнс-үзэл баримтлал, үндсэн бүтэц, хөдөлшгүй зарчмыг өөрчлөхийг хязгаарлажээ.</p> <p>13/ ҮХ-д оруулах нэмэлт,өөрчлөлт нь ҮХ-иар хүлээн зөвшөөрсөн хүний үндсэн эрх, эрх чөлөөг дордуулахгүй байх,</p> <p>-14/ Төрийн эрх мэдлийг хуваарилсан зарчим, МУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал,</p> <p>- Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал,</p> <p>15/ Ардчилсан ёс, шударга ёсыг сахих, хууль дээдлэх,</p> <p>16/ Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс бөгөөд нутаг дэвсгэр нь зөвхөг засаг захиргааны нэгжид хуваагдах,</p> <p>17/ Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх,</p> <p>18/ Нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч олон хэвшил бүхий эдийн засагтай байх,</p> <p>19/ Монгол хэл төрийн албан ёсны хэл мөн болох,</p> <p>20/ Энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах зэрэг 25 зүйл, хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглосон.</p> <p>Дээрхээс бусад зүйл,заалтыг өөрчлөх, сайжруулах нь нээлттэй гэсэн үг.</p> <p>Харин иргэд УИХ-аас Үндсэн хуульд гар хүрэхдээ улс төрийн хонжоогоор гурилдахгүй урт настай өөрчлөлт хийхийг хүлээж байна.</p> <p>-Улс төрийн хонжоогоор “гурилдаж “болохгүй Өнөөдөр 2011-1-19 № 15</p> | <p>- Сонгуулийн бүрэн эрхийг хугацааны сүүлчийн чуулганаар Үндсэн хуультай холбоотой асуудлыг авч хэлэлцэхгүй нь нийтлэг зүйл гэж хэлж болно.</p> <p>- Гэтэл Дани зэрэг оронд Үндсэн хуулийг парламентаар хэлэлцэж баталсны дараа зургаан сарын дотор ард түмний санал асуулга явуулж , сонгогчдын 40 %-ийг дэмжлэг авбал монарх батламжлан сая мөрдөж эхэлдэг аж.Иймэрхүү жишгийг Ирланд,Испани ,Франц зэрэг орнууд дагадаг.</p> <p>-Харин Франц Улсан ерөнхийлөгч Парламентаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж , парламентын гишүүдийн 3-ний 5 ын санал авсан бол референдумаар санал хураалгахгүй байж болдог онцлогтой.</p> <p>- Сонгогчдын санал асуулгаар Үндсэн хуулиа баталдаг улс ч бий. Сенегал 1963 онд ,Гамби,1970 онд,Камерун,Филиппин 1972 онд Үндсэн хуулиа ийм зарчмаар баталжээ.</p> <p>-Харин Н.Багабандийг Үндсэн хуулиа хамгаалж чадаагүйнх нь төлөө Цэцэд өгмөөр байна.</p> <p>-ӨН,2000-01-31.28</p> <p>9) Иргэний эрүүл амьдрал ,аюулгүй орчинд ажиллах амьдрах ,амьд явах нөхцөлийг баталгаатай бүрдүүлэх , нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж,орон нутгийн засаг захиргааны байгууллагын эрх мэдлийг өргөтгөх ,засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг оновчтой болгох ,Үндсэн хуулийн хамгаалалт ,хяналтыг бэхжүүлэх зэрэг нийгмийн санаа бодлыг талцуулсан олон асуудлыг УИХ-ын ажлыг хэсэг ултай судлан , төсөл боловсруулах шаардлагатай.</p> <p>-Улс төрийн хонжоогоор “гурилдаж “болохгүй Өнөөдөр 2011-1-19 № 1</p> <p>- Өөрчлөлт хийх гарцыг зөв тодорхойлох ёстой.</p> <p>2010-2-25 №46</p> |
|--|---|--|

| | | |
|--|--|--|
| | <p>21/ Р.Гончигдорж: ҮХ-ийг өөрчлөх нь зайлшгүй хийх алхам.</p> <p>Ажлын дундуур улс төрийн хүчнүүдийн хооронд яс хаяж буй нь Монгол орны нэгэнт сонгож авсан шинэтгэлийг удаашруулж, түүн дээр хожих гэсэн хамгийн явуургүй улс төрийн бодлого.</p> <p>/Өдрийн сонинд саяхан өгсөн ярилцлага/</p> <p>22/ Р.Гончигдорж: Нэг үг, үсэг ч өөрчлөх хэрэггүй</p> <p>ҮХ-ийн нэг үг, үсгийг өөрчлөх нь Монголын хууль тогтоомжуудад хэдэн зуун мянган өөрчлөлт оруулах тийм үр дагаврыг бий болгоно. Энэ бол асуудлын нэг тал.</p> <p>- Нөгөө талаас нь авч үзвэл бид хэрэгжүүлэх асуудлаа хэлбэрэлтгүй туйлд нь хүргэж амжаагүй үедээ бий болсон тодорхой бэрхшээлийн өмнө сөгдөөд ҮХ-иа өөрчлөх гэж хялбарчлаад байвал төрийн байгууллагын тогтвортой байдал, манай хөгжлийг тодорхойлсон тэр ҮХ-ийнхаа үзэл баримтлалын хэлбэрэлтгүй байдлыг хангаж чадахгүйд хүрнэ.</p> <p>/ҮХ-ийн ойд зориулсан ЭШ-ний хуралд 1997 оны эхээр хэлсэн үг/</p> <p>/Өдрийн сонинд саяхан өгсөн ярилцлага/</p> <p>-Их хурлын даргын төрөл арилжсан нь.</p> <p>-ӨН, 2000-01-13, №10/863/</p> <p>ҮШН-аас боловсруулсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийн талаар зарим нам , хөдөлгөөнийхний байр суурийг сонирхсон.</p> <p>23) Улс төр судлаач Л.Эрдэнэтуул:</p> <p>-ҮШН-аас дэвшүүлсэн санаа цаг үеэ олсон ,нийгэмд дуншиж байсан асуудлыг хөнджээ гэж үзэж байна. Тэр тусмаа үндсэн хуульд өөрчлөлт оруулах үндэсний хувьсгал бол нийгэм , улс төрийн хямралыг тайлах гарц болно. Өөрчлөх цаг болсон. 1992 оны Үндсэн хууль Оросын социализмын загварыг барууны хөрөнгөт загвараар солих шилжилтийн үеийн нөхцөлийг хангах зорилготой байсан. 20 жилийн алдаа, оноог дэнслэхэд барууны загварын сайн гэхээс илүү сөрөг тал нь Монголд наалджээ.</p> <p>24/ Б.Батболд/МУНН-ын дарга/</p> <p>Хамгийн гол нь Үндсэн хуулийн өөрчлөх тухай бид санал нэгдэж байгаа. Хууль өөрчлөх тухай илтгэгчийн саналаас авах, гээх зүйл олон байна. "Хүчтэй Ерөнхийлөгчтөй Парламентын засаглалтай байна." Гэсэн. Гүйцэтгэх засаглалын хүчтэй болгон гэж үгүй. Халуун байхад хүйтэн байдаг. Энэ хоёрын яг голоор нь байх нь зөв. Гэтэл заавал хүчтэй засаглалтай байна гэдэг нь халуун , хүйтний аль нэг туйл руу явж байна.</p> | <p>21/ Р.Гончигдорж: ҮХ-ийг өөрчлөх нь зайлшгүй хийх алхам.</p> <p>Олонхи нь олонхи шиг, цөөнхи нь нь цөөнх шиг байж зөвшилцөж ажлаа явуулахыг хуйвалдлаа гэдэг нь ямар сонирхол вэ? МУ улс төр, эдийн засгийн хос том шилжилтийг хийж байна. Улс төрийн шинэтгэл дэх том асуудлыг сая шийдлээ./ ҮХ-д хийх өөрчлөлтийг хэлж байна. Ред./</p> <p>- Мөн их хувьчлалыг явуулах ёстой. Аль аль нь улс орны эрх ашгийн үүднээс зайлшгүй хийгдэх учиртай алхмууд. Хийх үүрэг нь УИХ-д ноогдсон.</p> <p>-Их хурлын даргын төрөл арилжсан нь.</p> <p>-ӨН, 2000-01-13, №10/863</p> <p>23/Л.Эрдэнэтуул: Тэр тусмаа үндсэн хуульд өөрчлөлт оруулах үндэсний хувьсгал бол нийгэм , улс төрийн хямралыг тайлах гарц болно. Өөрчлөх цаг болсон. Монголд хүчтэй төвлөрсөн засаг хэрэгтэй.</p> <p>- Хэдийгээр ардчилал эрх чөлөө олсон ч хөгжиж дэвжээгүй. Бидэнд жинхэнэ Монгол бүтээгч загвар хэрэгтэй байна. Монгол үндэстний мөхлийн аюулаас аврах үндэсний үзэлд тулгуурласан загвараа гаргахын тулд гарцаагүй Үндсэн хуульд өөрчлөлт оруулах ёстой.</p> <p>- Төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засаг, монгол хүний чанарыг дээшлүүлэх нийгмийн бодлого хэрэгтэй. Хувьсал хийхийн зорилго нь энэ гурван зүйл .</p> <p>24/ Б.Батболд/МУНН-ын дарга</p> <p>УИХ-ыг хоёр танхимтай болгох санал гарлаа.</p> <p>Ерөнхийлөгчийн засаглалтай үед энэ нь Гүйцэтгэх засаглалд чөдөр тушаа л болно. Улс төр бол шинжлэх ухаан . Тиймээс шинжлэх ухааны талаас харж үндэслэлтэй саналууд дэвшүүлэхгүйгээр таамгаар явж болохгүй гэсэн байр суурьтай байна.</p> |
|--|--|--|

| | | |
|----------------|---|--|
| | <p>25/ Л.Цог/Үндсэн хууль тогтоогчдын холбооны Удирдах Зөвлөлийн гишүүн/ Одоо монголд ардчилсан биш ард түмний эсрэг дэглэм тогтсон байгаа.Үүнийг өөрчлөх үйлсийг 1992 оны Үндсэн хуультай холбож байгаа нь харин төөрөлдсөн хэрэг.1992 оны Үндсэн хуультай холбож байгаа нь харин төөрөлдсөн хэрэг.1992 оны Үндсэн хуульд 2000 онд өөрчлөлт оруулчихсан шүү дээ.Үүгээр 1992 оны хуулийн гол судсыг тасалчихсан.Тиймээс 2000 оны Үндсэн хуульд тулгуурлаж өөрчлөлтөө хийнэ гэвэл би 100 хувь санал нийлнэ.</p> <p>26/ Хоёр танхим гэдэг нь хууль зүйн ойлголт. Монгол хоёр Парламенттай болоод нэгнийх нь баталсныг нь нөгөө нь дэмжихгүй байдал руу орно.1990 онд байгуулсан АИХ-ын дараа УБХ байгуулсан.Үүн шиг байна гэвэл асуудал өөр.Хэрэв хоёуланг нь байгуулна гэвэл одоо 76 гишүүнээ тэжээж чадахгүй байгаа ард түмний нуруунд ачаа нэмэгдэнэ.1992 онд Ерөнхийлөгчийн ,хаант засаглал,сонгодог парламент гэх мэт олон хувилбар ярьсаар эцэст нь тухайн түүхэн нөхцөлдөө нийцүүлж,одоогийн хувилбарыг сонгосон.</p> <p>27/ Д.Энхбат/ Эрс шинэчлэл хөдөлгөөний ерөнхий зохицуулагч/ 1992 оны үндсэн хууль ардчиллын баталгаа болж ,үүргээ гүйцэтгэлээ.Үндсэн хуулийн зарим заалтыг өөрчлөх ёстой гэсэн үзэл бодлыг хуваалцдаг.ҮШН-ын боловсруулсан төсөлтэй танилцсан.Хүчтэй Ерөнхийлөгчтэй,парламентын засаглалтай байхаар томьёолж байна.Байж болох хувилбар. Засгийн газар хүчгүй байгаа.ҮШН уг засаглалыг Ерөнхийлөгчөөс хамаатай ч хүчтэй болгохоор томьёолж байна.</p> <p>28/ Ази ,Дорно дахины ард түмэн хүчирхэг засаглалтай байхыг илүүд үздэг.Харин засаглалын хуваах,хуваарилах нь баруун Европоос гаралтай үзэл.Бид өнгөрсөн 20 жилд либерал үзлийг хэтэрхий шүтсэн.Ийм үзэлд тулгуурласан дэлхийн эдийн засаг төгс биш байна.</p> <p>- Өөрчлөлт хийх гарцыг зөв тодорхойлох ёстой. 2010-2-25 №46</p> | <p>25/ Л.Цог/Үндсэн хууль тогтоогчдын холбооны Удирдах Зөвлөлийн гишүүн/ 2000 оны Үндсэн хуульд тулгуурлаж өөрчлөлтөө хийнэ гэвэл би 100 хувь санал нийлнэ. Монголын нөхцөлд ямар хувилбар хэрэгтэйг л сайн ойлгох ёстой.2000 онд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтүүдийг хүчингүй болгох хэрэгтэй.Тэгэхгүй бол дахиад л туршилт хийхэд хүрнэ.Болохгүй байгаа нь үнэн гарцыг зөв тодорхойлох хэрэгтэй.</p> <p>27/ Д.Энхбат/ Эрс шинэчлэл хөдөлгөөний ерөнхий зохицуулагч/ Тиймээс монгол үндэсний үзлийг гаргаж байгаа нь зөв.Харин дан Ерөнхийлөгчийн засаглалтай байхыг дэмжихгүй.Парламент муу ч сайн ч олон нийтээс сонгогддог,асуудлыг ганц хүн биш олноороо шийдэх нь илүү л дээ.</p> <p>- Өөрчлөлт хийх гарцыг зөв тодорхойлох ёстой. 2010-2-25 №46</p> |
| <p>6. 68-1</p> | <p>1) -Ц.Нямдорж: ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаан болж УИХ-ын чуулганаар хэлэлцэнҮХ-д оруулсан нэмэлт,өөрчлөлт нь түүний өөрийнх нь заалттай зөрчилдсөн гэсэн дүгнэлт гаргав. Үүнд: Асуудлыг шийдвэрлэх гол баримт нотолгоо болох Монгол төрийн түүхэнд үлдсэн Улсын Бага Хурал (УБХ), АИХ-ын хуралдаанаар ҮХ-ийн 68-р зүйлийг хэлэлцсэн протокол, уг зүйлийн 5 удаагийн томъёолол, тэдгээрээс үүдэлтэй дүгнэлтийг олон нийтэд хүргэсэн.</p> <p>-Ц.Нямдорж: ҮХ-ийн Цэц улстөржсөн шийдвэр гаргасан. ӨН-2000-03-23, №68 Р.Жаргалант</p> | <p>1/ Маргаантай гол асуудал бол 68.1 дэх заалт.Гэвч үүнийг ҮХЦ ул хайхран нотлох баримтын эсрэг шийдвэр гаргасан гэж Ц.Нямдорж үзээд уг хуулийг хэлэлцэн батлах үеийн хүмүүсийн санал бодлын зарим онцлогийг харуулсан материалыг сэтгүүлчдэд тараав.</p> |

1992 - 2011 онуудад “Өнөөдөр” сонинд гарсан Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалтай холбоотой нийтлэгдсэн нийтлэлүүдэд хийсэн дүгнэлт

| Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй | | | |
|---|--------------------------|--------------------------------------|------------------|
| № | Холбогдох зүйл, заалтууд | Гарсан шүүмжлэл, эх сурвалжийн (тоо) | Дэвшүүлсэн санал |
| 1 | 24-1.” | 6 | 7 |
| 2 | 23-1 | 1 | 1 |
| 3 | 27-2 “ | 3 | 4 |
| 4 | 27-6” | 4 | 3 |
| 5 | 29-1 | 12 | 13 |
| 6 | 33-1 | 7 | 7 |
| 7 | 22-2 | 1 | 0 |
| 8 | 39-2 “ | 1 | 1 |
| 9 | 67 | 1 | 0 |
| 10 | 68-1 | 13 | 1 |
| 11 | 68-2 | 1 | 0 |
| 12 | 69-1 | 4 | 0 |
| 13 | 25-2 -ын.... 4. | 2 | 4 |
| 14 | 66-1 | 4 | 1 |
| 15 | 66-2 | 9 | 1 |
| 16 | 20-р зүйл | 11 | 9 |
| 17 | Бусад | 22 | 23 |
| | Бүгд: | 102 | 75 |

| Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай | | | |
|---|-------------------------------------|--------------------------------------|------------------|
| | Холбогдох зүйл, заалтууд | Гарсан шүүмжлэл, эх сурвалжийн (тоо) | Дэвшүүлсэн санал |
| 1 | 22-2 | 1 | |
| | 29-1 | 2 | 1 |
| 1 | 3-зүйлийн 1 дэх заалт, 20-р зүйл | 2 | 2 |
| 2 | 33-1 | 1 | 0 |
| 3 | 27-2 | 2 | 0 |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|---|-------|----|----|
| 4 | Бусад | 28 | 19 |
| Бүгд: | | 36 | 22 |
| Тайлбар: Нийт 120 нийтлэлээс уншиж, судалж сонгож авсан | | | |

ХАВСРАЛТ 6

НИЙГМИЙН ТОЛЬ /2009-2011/

| № | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
|----|--|---|---|
| 1. | 2000 онд хийсэн долоон зүйлийн өөрчлөлтийг хийх шаардлагатай /4/ 22 –р зүйл 2-1, 24-р зүйл 1-1, 27-р зүйл 6-1, 29-р зүйл 1-1 | <p>Л.Цог.</p> <p>Долоон зүйлийн нэмэлт хийгээд анхны Үндсэн хуулийг танихын аргагүй болгочихсон.2010-01-14</p> <p>1. УИХ-ыг 76-аас доошгүй гишүүнтэйгээр хуралддаг байсныг 50-аас доошгүй болгосон. Бүр болоогүй 50-иас дээш байсныг болиулж 20 хүн хууль баталдаг болгочихлоо.</p> <p>2. УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн байж болдог ийм сонин холилдсон юм хийчихээд гүйцэтгэх эрх мэдлийг, хууль тогтоох эрх мэдэлтэй нийлүүлж хяналтгүй болгосон.</p> <p>3. Дээр нь Ерөнхийлөгчийн эрх мэдэлд халдсан.</p> <p>4. Мөн УИХ-ын дарга нарыг нууц санал хураалтаар сонгодог байсан бол одоо эд нар ил санал хураагаад сонгодог болсон.</p> <p>5. Хамгийн гол авч хаясан үг, өгүүлбэр бол “Шаардлагатай гэсэн нөхцөлд Монгол Улсын Ерөнхийлөгч Засгийн газрыг огцруулах санал”-ыг УИХ-д оруулдаг байсан. Үүнийг үг дуугүй аваад хаячихсан. Ингээд долоон зүйлийн нэмэлт өөрчлөлт хийгээд бидний баталсан анхны Үндсэн хуулийг танихын аргагүй болгочихсон.</p> <p>6. Үндсэн хуульд нууцаар халдсан. Тухайн үед Монголд 14 нам байхад зөвхөн гурван нам нь хуйвалдаад л ийм юм хийсэн.</p> | <p>1. Хэрэв нэмэлтээр оруулсан зүйлүүд нь болохгүй байна гээд өөрчлөх гэж байгаа бол ойлгож болж байна. Гэтэл өөр юм болохгүй байна гээд юу оруулахаа мэдэхгүй хий дэмий суугаад байгааг ойлгохгүй байгаа юм.</p> <p>2. Өөрөөр хэлбэл одоогийн эрх баригчид өөрсдийнхөө хариуцлагагүй үйл ажиллагааг нууж хаахын тулд амьгүй Үндсэн хууль руу асуудлыг чихэж байна.</p> <p>3. Үндсэн хууль бол нийгмийн амьдралын суурь, араг яс нь байдаг. Гэхдээ үүнд гар хүрч огтхон ч болохгүй гэсэн үг биш. Ном журмын дагуу, хийгээд 2000 онд хийсэн хууль бус зүйлээ нэн даруй цуцлах ёстой гэж бодож байна.</p> |

АРДЧИЛАЛ /1996-1997/, /2009-2011/

| № | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
|----|---|--|--|
| 1. | <p>Үндсэн хуульд өөрчлөлт хийх шаардлагатай. /9/</p> <p>29-р зүйл 1-2, 24-р зүйл 1-1, Журам гаргах талаар 6</p> | <p>Иргэн Д.Ламжав. УИХ-ын гишүүд ТББ-ыг удирдаад хуулиа зөрчөөд явж байгаа. Ярилцлага авсан Б.Билгүүн 2009-08-21</p> <p>1. Үндсэн хуулийн 66-ын 2-т Улсын дээд шүүхийн шийдвэрийг Үндсэн хуулийн шүүхийн хяналтад оруулаагүй. Энэ бол ноцтой том алдаа байгаа юм. 2. 35-ын 2-т шүүхийг мөн хөгийн байдалд оруулчихсан. 3. Үндсэн хуулийн 29-мйн 1-т Засгийн газрыг дан УИХ-ын гишүүдээр бүрдүүлж болох заалтыг нэмэлтээр оруулчихсан байгаа юм. 4. Өөр нэг сонин алдаатай заалт бол 50-ийн 1.4-т Үндсэн хуулиас бусад хуульд Улсын дээд шүүх албан ёсны тайлбар хийж болох тухай юм.</p> | <p>1. Үндсэн хуулийн 1-ийн 1 дэх өгүүлбэрийг "Монгол Улс төрийн шашингүй, Парламентийн Бүгд найрамдах улс" хэмээн томъёолж ийм заалт хиймээр байна. 2. Үндсэн хууль Нэгдүгээрт: нийт ард түмний санал асуулгаар батлагддаг байх ёстой. Хоёрт: хугацаагаар хамгаалах ёстой. Гуравт: УИХ-д өндөр хувиар батлагддаг байх. Энэ бол төслийг батлахаас биш Үндсэн хуулийн өөрчлөлтийг батлах юм биш. Эцсийн батлах нь ард түмэн байх ёстой гэдэг зарчмаар.</p> |
| 2. | | <p>Л.Дашням. Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын үндэсний холбооны гүйцэтгэх захирал. Үндсэн хуулийн долоон нэмэлт өөрчлөлтөөс болж монголын төр хэврэгшсэн. 2010-01-13</p> <p>1. 2000 онд хийсэн өөрчлөлт бол төрийн эрхэнд байгаа намуудын хуйвалдаан маягаар үндсэн хуулийнхаа гол утга санаанд халдсан өөрчлөлт байсан. Энэ өөрчлөлтөөс болж Монгол төр их хэврэгшсэн. 2. Хууль тогтоох субъект гурав л байдаг. Ерөнхийлөгч, Засгийн газар, УИХ-ын гишүүн. Гэтэл энэ өөрчлөлтөөс болж хууль тогтоох субъектууд хилилдсон. 3. Одоогийн УИХ-ын гишүүд өөрсдийн эрх ашгаа төрийн эрх ашгаас дээгүүр тавьж тэр ашгаа хуульчлан баталгаажуулахыг оролддог болжээ. 4. Ерөнхийлөгч хууль батлах үйл явцад хүлээж байгаад хориг тавих биш, хууль тогтоож байгаа процесст оролцох боломжтой байсан. Энэ боломж хаагдсан.</p> | <p>1. УИХ-аас Үндсэн хуульд нэмэлт оруулбал ямар журмаар хийх талаар хууль гаргаад дараа нь өөрчлөлтийн талаар ярих нь зөв байх. 2. Яг хуулиараа ярих юм бол УИХ дотор намын бүлэг байх ёсгүй. 3. Гэтэл УИХ-ын тухай хуулиар намын бүлэгтэй байхаар тогтсон. Нам нь УИХ-ын үйл ажиллагаанд оролцоод бүр цаг аваад бүлгээр хэлэлцдэг болчихсон. 4. Уг нь нам ямар ч хамаагүй. УИХ хуулиа баталж Хуульдаа төрийн бодлогыг шингээх ёстой шүү.</p> |
| 3. | | <p>Э.Баяр. /Ер нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай эсэх талаар гишүүдийн байр суурь/ 2010-01-13</p> <p>УИХ-ын гишүүн Б.Чойжилсүрэн. Бүхэлд нь өөрчлөх хэрэгтэй. Үндсэн хуульдаа засвар өөрчлөлт оруулахдаа хоёрын хооронд жижиг сажиг зүйл тусгахын оронд нэг мөсөн шинээр гаргах хэрэгтэй.</p> | <p>16 Парламентын засаглал уу Ерөнхийлөгчийн засаглал уу гэдгийг тодорхой болгох хэрэгтэй. 2. Английн хуулийг орчуулаад хэрэгжүүлбэл үр дүнтэй юм шиг санагддаг.</p> |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|----|--|--|---|
| 4. | | <p>УИХ-ын гишүүн Д.Энхбат. /Өөрчлөлт оруулах тодорхой журамтай болох нь хамгийн чухал./ 2010-01-13</p> <p>1.Том хуульдаа өөрчлөлт оруулах бодит шаардлага байгаа.</p> <p>2.Үндсэн хуультай зайлшгүй холбоотой зүйл ялангуяа Монгол Улсын парламент 76-хан гишүүнтэй. Үүний 13 нь буюу олонхи болсон намын гишүүд сайд болох хир зохимжтой вэ.</p> | <p>1.20 жил явсан зарчмаа задалж ор үндсээр нь өөрчилж байхаар засч сайжруулаад л явах нь зүйтэй.</p> <p>2. Юуны түрүүнд өөрчлөлт оруулах тодорхой журамтай болох нь хамгийн чухал.</p> |
| 5. | | <p>УИХ-ын чуулган. Ү.Одбаяр. Намрын чуулганаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулна./УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл хуралдаж намрын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоосон захирамж гаргажээ./ 2010-09-27</p> | <p>1. Намрын чуулганаар нийтдээ 27 асуудал хэлэлцэхээр болжээ.</p> <p>2. Үүний 19 дүгээрт. Монгол Улсын Үндсэн Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төсөл байна.</p> |
| 6. | | <p>Э.Мөнгөн. /УИХ-ын чуулган/ Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журамтай боллоо. 2010-12-03</p> <p>1. Шинэ үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэх хүн олон болсон.</p> <p>2. Тиймээс Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төслийг нэр бүхий 9 гишүүн санаачлан өргөн барьсан юм. Дэд ажлын хэсгийг Б.Чимэд ахлан хуулийн чиглэлээр мэргэшсэн 20 гаруй эрдэмтэн ажилласан бөгөөд 6 бүлэг 34 зүйлтэй хуулийн төсөл боловсруулан УИХ-ын ажлын хэсэгт гардуулжээ.</p> | <p>1. Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэх үед гишүүн Н.Энхболд, Су. Батболд, Г.Баярсайхан нар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төсөлд тавих шаардлага, ард нийтийн санал хураалтаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын талаарх холбогдох зүйл заалтуудыг хэлэлцүүлгийн шатанд нарийвчлан авч үзэх шаардлагатай гэсэн санал гаргажээ.</p> |
| 7. | | <p>Л.Номин. Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, парламент алдаагаа засч эхлэх нь. 2011-01-13</p> <p>1.Сүүлийн 10 жилд Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар зөвхөн 15 гишүүн дэмжиж байгаа бус бусад нь ч мөн өөрчлөх нь чухал гэж үзэж байгаа хэмээн төсөл санаачлагчдын нэг УИХ-ын гишүүн З.Алтай хэлсэн юм.</p> <p>2.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслөө гишүүд Ерөнхийлөгч, ерөнхий сайд нарт санал авахаар хүргүүлжээ.</p> | <p>1. Засгийн газрын гишүүдийн гуравны нэг нь УИХ-ын гишүүн байж болно гэсэн заалтыг оруулахаар болсон байна.</p> <p>2. Ерөнхий сайд болон чиглэлийн яамдыг тэргүүлэх сайд нар нь байж болно гэж заасан гэв.</p> <p>3.УИХ-ын дарга, дэд дарга, байнгын хороодын дарга нарыг сонгохдоо нууц санал хураалтаар шийдэх аж.</p> |
| 8. | | <p>П.Ариун. Монголчууд хамгийн ардчилсан хуулиа 19 жилийн өмнө баталсан 2011-01-14</p> <p>1. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг баталсан.УИХ-ын нэр бүхий 15 гишүүн</p> <p>2. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулаад байна.</p> <p>3. Үндсэн хуульд өөрчлөлт оруулахдаа “Гишүүдийн гуравны хоёр нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг дэмжвэл хэлэлцэх, дөрөвний гурвын саналаар хуулийн төслийг батлах” гэх мэт заалт оржээ.</p> | |

| | | | |
|-----|-----------|---|---|
| 9. | | <p>П.Ариун. АИХ-ын депутат асан. Ц.Өөлд. 2011-01-14 1. УИХ саяхан Үндсэн хуульд оруулах журмын тухай хууль баталлаа. 2. УИХ-ын 15 гишүүн Үндсэн хуульд ганц хоёрхон өөрчлөлт хийхээр хуулийн төсөл өргөн барьсан байна.</p> | <p>1. Улс орныг цаашдаа авч явах арга замыг тодорхойлсон төрийн тогтвортой байх заалтыг улам бэхжүүлсэн байх гэх мэт цогц байдлаар энэ хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй. 2. Өмнөх Засгийн газрын Монгол орон, ард түмний төлөө хийж байсан зүйлийг хууль ёсоор үргэлжлүүдэг байхыг хуульчилж өгөөсэй. 3. Ёс зүйтэй төртэй болохын тулд л Үндсэн хуулиа өөрчлөх ёстой.</p> |
| 10. | Бусад /2/ | <p>Ц.Хас /Коммунист дарангуйллыг халсан үндсэн хууль/ 2010-01-13 1. Улсын бага хурал ч биш, АИХ ч биш, МАХН ч биш Монголын нийт ард түмэн нийтээрээ хэлэлцэж санал бодлоо нэмэрлэн байж баталсан энэ хуулийн ачаар дэлхий дахинаа бүрэн эрхт, тусгаар тогтносон Монгол Улс хэмээн нэрлүүлж таван тивийн улс гүрнүүдтэй эрх тэгш харилцаж байна.</p> | <p>1. Улс төрийн элдэв хүчин, эрх мэдэл, хувийн ашиг завшаан хөөгчид хэн дуртай нь дур мэдэн хасч янзлаад, хайчилж засаад байхгүй бол энэ үүргээ биелүүлсээр ч байх болно.</p> |
| 11. | | <p>УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангийн байр суурь. Үндсэн хууль бүрэн бүтэн хууль болж чадсан. 2010-01-14 П.Туяа. 1. Өнөөдөр Үндсэн хуулийг харж байхад бүрэн бүтэн хууль болж чадсан гэж боддог. Энэ долоон өөрчлөлт сайн саар зүйлийн аль алийг агуулсан 2. Төрийг гацаахгүй байхад энэ нэмэлт өөрчлөлт чиглэсэн.</p> | <p>1. Суурь ямар зарчимд өөрчлөлт оруулахгүй байх вэ 2. Алийг нь ард түмнээр хэлэцүүлэх вэ гэдгийг хуульчлах</p> |

ХАВСРАЛТ 7

АРДЫН ЭРХ СОНИН 2005-2011

| Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй | | | |
|---|--|---|--|
| № | Асуудлын ерөнхий ангилал, давталт | Гарсан шүүмжлэл, эх сурвалж | Дэвшүүлсэн санал |
| 1. | Үндсэн хуулийг өөрчлөх шаардлагагүй. /2/ | <p>1. УИХ-ын гишүүн Н.Ганбямба: “Төрийн зүгээс зах зээлийн эдийн засгийн харилцаанд хэт хутгалдан орж байгаа механизмыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай.” №07/539/ 2007.01.11</p> <p>2. Б.Мандах-сэтгүүлч. “Үнэндээ Үндсэн хууль гэдэг нь батлагдан гарах бүхий л хууль, шийдвэрүүдийг ямар байх ёстойг зааж өгсөн, өөрөөр хэлбэл ямар хэлбэртэй байх вэ гэдгийг тогтоосон хэв загвартай тун төстэй зүйл аж. Хууль тогтоогчид хүссэн бүхнээ батлаад байх боломжийг Үндсэн хуулиар хаасан гэсэн үг. Энгийнчилж хэлбэл Үндсэн хууль гэдэг нь хууль тогтоогчдоос иргэдийг хамгаалах баталгаа л юм. №10. 2011.01.14</p> | <p>1. “Ер нь манай төрийн үйл ажиллагаанд шударга ёсны зарчим Үндсэн хуулийн дагуу үйлчилж байна уу” гэсэн сэдвээр ард түмний хэлэлцүүлэг явуулах нь зүйтэй</p> <p>2. Үндсэн хуулийн зарчимд хүний жам ёсны эрхийг тусгасан болоод өөрчлөгдөн хувирах нь бага, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Ийм дээ ч Америкийн 200 жилийн настай Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн тоо манай 20 хүрэхгүй жилийн хугацаанд оруулсан өөрчлөлттэй бараг ижил.</p> <p>Мөн Японы Үндсэн хууль 1947 оны 5 сарын 3-наас хүчин төгөлдөр үйлчилж буй бөгөөд өдийг хүртэл нэг ч удаа нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Өөрөөр хэлбэл жам ёсны эрх, Үндсэн хуулийн гол зарчим дээр тулгуурласан тохиолдолд л хууль урт настай оршдог аж.</p> |
| Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай | | | |



Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | |
|-----------|--|--|---|
| <p>2.</p> | <p>29-1 УИХ-ын гишүүн ерөнхий сайд, засгийн газрын гишүүн байгааг буруу гэж үзсэн. /3/</p> | <p>1. С.Мөнхжаргал-сэтгүүлч “Үндсэн хуульд оруулсан 2000 оны өөрчлөлт засаглалын хуваарилалтыг үгүй хийснээрээ иргэдийн төлөөлөл парламентыг “устгах” аюул дагуулжээ.” № 08/540/ 2007.01.12]</p> <p>2. Б.Сэмүүн-сэтгүүлч “1992 оны Үндсэн хуульд байсан нэг чухал зүйл нь засаглалын эрх мэдлийг нарийн зааглаж, УИХ-ын гишүүн хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрахыг хориглосон. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын гишүүн буюу сайдын албан тушаалыг хавсарч гүйцэтгэхийг ч мөн хориглоно гэсэн үг.” № 240 2010.12.09</p> <p>3. С.Нарангэрэл Шинжлэх ухааны доктор, профессор “1999.12.24-нд Үндсэн хуулийн гол үзэл баримтлалд зарчмын шинжтэй өөрчлөлт оруулж, Угтаа дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн эрх мэдлийг хувиарлах зарчмыг үгүйсгэж, парламентын зүгээс Засгийн газарт хяналт тавих боломжийг алдагдуулсан.” № 20/552/ 2007.01.30</p> | <p>2. 2000 оны өөрчлөлтөөр орж ирсэн энэ зохицуулалтын улмаас өнөөдөр 16 гишүүнтэй Засгийн газрын танхимын 13 нь УИХ-аас томилгодоод байгаа. Мөн засгийн газрыг 100 хувь парламентын гаднаас бүрдүүлэх нь гүйцэтгэх засаглалд тогтворгүй байдал үүсгэж, улс төрийн намууд ч бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлэх чадамжгүй болдог.</p> <p>3. Д.Лүндээжанцан, Д.дондог, Т.Очирхүү нарын гишүүд Засгийн газрын гишүүний албыг хавсран хашдаг УИХ-ын гишүүдийн тоог цөөлөх тухай хуулийн төсөл нь Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт буруу байсныг УИХ хүлээн зөвшөөрч байгааг харууллаа гэж бодож байна.</p> |
| <p>3.</p> | <p>2000 оны долоон өөрчлөлтийг тохиролцож хийсэн гэж ард түмэн үзэж байгаа /2/</p> | <p>1.С.Ламбаа “МАХН 2000 онд дангаараа шахам УИХ-д гарч ирээд 2001 онд олонхиороо батлаад тэр өөрчлөлтийг эргүүлж Үндсэн хуульд оруулсан. Цэцийн унагаасан өөрчлөлтийг олонхиороо сэргээгээд Үндсэн хуульд оруулчихсан. Сэргээхдээ намын тогтолцооны үед тохиролцсон зүйл гэж ярьсан байдаг юм” № 151/939/ 2008.07.31</p> <p>2. УИХ-ын гишүүн асан Р.Амаржаргал “Үндсэн хуульд өөрчлөлт оруулах гэхээсээ илүү Үндсэн хуультайгаа ижил хүчин төгөлдөр үйлчилдэг нэмэлт гэдэг хэлбэрээр тодорхой заалтуудыг тодорхой болгоод явах бололцоо бий. Хотыг арай өргөн томьёолох хэрэгтэй байна. Гэхдээ ямар өөрчлөлтийг, ямар үзэл баримтлал дээр тулгуурлаж байж яаж оруулах вэ гэдгээ их тулхтай, тал бүрээс нь ярьж, шаардлагтай бол ард нийтийн санал асуулга хийж байгаад хийх ёстой” № 156/944/ 2008.08.07</p> | <p>1.Манай нам Үндсэн хуульд бүхэлд нь шинэчилсэн найруулга хийе гэж үзэж байгаа. Төрийн тогтолцооны асуудал дээр. Шинэчилсэн найруулгыг 1992 онд баталсан анхны эх дээр хийе гэж байгаа. Олон нийтийн санал асуулга хийлгүй оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгочихоод анхны эх дээрээ шинэчилсэн найруулга хийе гэж байгаа юм.</p> <p>2.Өнөөдрийн парламент шийдлээ олоод Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм бол, дахин маргаан гаргахгүйн тулд, хоёр нам хуйвалдаад ингэчихлээ гэж хэлүүлэхгүйн тулд аард нийтийн санал асуулгаар баталгаажуулах нь зөв.</p> |
| <p>4.</p> | <p>5-5 “Мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтанд байна” /2/</p> | <p>1.УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл: “1992 онд ҮХ-ийг баталж байх үед АИХ-ын депутатуудын 70 орчим хувь нь нэгдлийн дарга нар байсан. Тэр үед нэгдлийн дарга нар маань нэгдлийг хувьчлуулахгүй байх санааг агуулж Монгол мал бол төрийн хамгаалалтанд байна гэсэн заалтыг оруулсан юм. Гэтэл нөхцөл байдал өөрчлөгдөн нэгдлийн мал хувьчлагдсан. Иймд одоо өмчийг ялгавартайгаар ҮХ-д оруулж өгч байна гэсэн үг л дээ. Энэ нь ҮХ-ийн “Өмчийг төрөл хэлбэрээр нь ялгаварлан үзэж болохгүй” гэсэн 16-р зүйлтэй зөрчилдөж эхэлсэн.” № 247. 2010.12.20.</p> <p>2.Байнгын хорооны хуралдаан дээр Д.Одхүү нарын гишүүд эсрэг санал гарган хөндөж болохгүй хэсгээс “мал сүрэг үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтанд байна” гэх заалтыг хасах нь зүйтэй хэмээн санал оруулсан боловч дэмжигдэлгүй цөөнх болсон байна. № 247 2010.12.20</p> | <p>1.2000 оны 7 өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүртэл журмын хууль хэрэгтэй болоод байна.ӨХ: тухайн өөрчлөлтүүд ҮХ-аа суучихсан, зүйл заалт болоод явчихсан байгаа. Журмын хуульд анхаарах ёстой зүйл байгаа юм. Тэр нь 2000 оны ҮХ-д оруулсан 7 нэмэлт бол хуулиар журамлаагүй улс төрийн тохиролцоогоор хийгдчихсэн зүйл.</p> <p>2.Хуулийн төслийг батлахдаа гурван хэлэлцүүлгээр шийдвэрлэнэ, УИХ-ын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр санал хураана” гэж найруулав. Түүнчлэн “санал хураалтын дүнтэй санал нийлээгүй гишүүн нэг удаа үндэслэл, шалтгаанаа тайлбарлаж санал хураалгах эрхтэй. Хэрэв санал нь батлагдвал уг зүйл, хэсэг, заалтын найруулгыг сонсож, дахин санал хураалгана. Харин гишүүн, цөөнх хоёрдугаар хэлэлцүүлгээр батлагдсан саналаасаа зөрүүтэй болон өөр зүйл, хэсэг, заалт нэмэх санал гаргаж болохгүй” гэж өөрчлөн найруулахаар боллоо.</p> |

| | | | |
|----|---|--|---|
| 5. | <p>Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хууль хэрэгтэй /2/</p> | <p>1.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн ахлагч Д.Дондог: "Цаашид Үндсэн хуульд өөрчлөлт оруулах болзол, нөхцөлийг хуульчилж өгөх ач холбогдолтой." № 251,252. 2010.12.24</p> <p>2.УИХ-ын гишүүн Л.Гантөмөр Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан 7 өөрчлөлтийг буцаан сэргээх санал гаргасан байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын хуулийг батлах гэж байгааг хууль тогтоочдод хуулийг өөрчлөх ямар ашиг сонрхол байна вэ гэдэг талаас харахад хүргэж байна. Хамгийн эхний хардлага Сонгуулийн хуулиас өмнө Үндсэн хуулийг өөрт ашигтайгаар өөрчлөх вий гэх болгоомжлол юм.</p> | <p>1.Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахын тулд 4/3 саналаар шийднэ гэж босгыг өндөргөсөн. Мөн ҮХ-д өөрчлөлт оруулах тохиолдолд ЗГ, Ерөнхийлөгч, ҮАБЗ, МБ, олон нийтийн саналыг авах тухай зохицуулалт бий. Үүнд ҮХ-д өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэхэд байгууллага албан тушаалтан өгөх саналаа 30 хоногийн дотор ирүүлэх, хэрэв энэ хугацаанд амжихгүй бол зөвшилцөн, хойшлуулах зэрэг зохицуулалт хийсэн.</p> |
| | | <p>3.Үндсэн хуульд "Иргэд өөрийн төлөөллийг УИХ-д шууд сонгох эрхтэй" гэж заасан нь улс төрийн намуудад санал өгдөг буюу пропорциональ тогтолцоог ашиглахад хаалт болно гэх болгоомжлол үлстөрчдөд бий. Бусад орны практикт үүнийг "парламентыг шууд сонгоно" гэдэг байдлаар зохицуулсан байдаг бөгөөд ийм байдлаар өөрчлөх сонирхол байсныг үгүйсгэхгүй. Уг нь дээрхи Итали зэрэг оронд парламент Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар болбол тухайн парламент нь биш, шинээр сонгогдсон дараагийн парламент уг нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж баталдаг хуультай байдаг байна. Өх: "өөрчлөх" ямар нэг ашиг сонирхолтой хүмүүсээс зайлсхийж ашиг сонирхлын зөрчилгүй бүрэлдэхүүнээр шийдвэрлүүлнэ гэсэн үг. № 251,252. 2010.12.24</p> | <p>Журмын хуульд өөрчлөлт оруулахдаа МУ-ын Үндэсний эрх ашигтай холбоотой Үндсэн хуулийн тулгуур зарчмууд багтсан. Өх: МУ-ын тусгаар тогтнолын тухай, хилийг хуулиар хамгаалах зэрэг заалтууд үүнд хамаарагдана. Ерөнхийлөгчийн сонгуулийн болон үлдээд буйф бүрэн эрхийн хугацааг сунгах, өөрчлөхийг хориглох тухай, Ерөнхийлөгчид нэр дэвшигчдэд тавигдар шаардлагыг сулруулж болохгүй тухай, мөн ЗГ-ын гишүүний бүрэн эрхийг нэмэгдүүлэх давуу байдал олгохыг хориглах тухай заалтууд орсон байна.</p> <p>2.Үндсэн хуулинд өөрчлөлт оруулж болохгүй байх тохиолдлын хязгаарыг тогтоож өгсний дээр, хууль санаачлагчид нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол ямар хүрээнд оруулж болохыг тогтоож өгснөөрөө зарчмыг тунхаглах биш харин нэгэнт тунхагласан зарчмыг биелүүлэх арга зам, хариуцах эзэн, цаг хугацаа, үүрэг хариуцлага, болзошгүй сөрөг үзэгдлээс сэргийлэх, маргаантай асуудлыг зөв гарц олж шийдэх журмыг л тогтооход чиглэсэн байна.</p> |
| 6. | <p>Бусад:</p> | <p>1.УИХ-ын гишүүн С.Оюун: "Шинэ, дэвшилттэй, ардчилсан Үндсэн хуулийг батлаад 19 жилийн нүүрийг үзэж байна. Энэхүү хуулинд дэвшилттэй, зөв зүйтэй олон санааг тусгаж өгсөн. Олон намын тогтолцоо, парламентын засаглал, УИХ-аас Засгийн газрыг сонгодог гээд дэвшилтэт зарчим олон бий болсон. Өнгөц харахад тэр зарчмууд нь байгаа боловч өнгийгөөд харвал доторх хэрэгжилт нь хангалтгүй, алдаатай зүйлс байна. Үндсэн хуульд "Сонгуулиар ард түмэн нь засгаа сонгож, их хурал нь ард түмнээ төлөөлдөг" гэж бий. Гэтэл сонгууль нь асар их мөнгөн дээр тогтож мөнгөөр сонгох магадлал нь хэмжигддэг болсон." №10. 2011.01.14</p> <p>2.УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуу: "Үндсэн хуулиа өөрчлөх хэрэгтэйг хуучин гишүүд мэдэж байгаа. Өөрчилбөл өөрсдөө бас алга болно гэдгээ бүр ч сайн мэдэж байгаа." № 90 /1392/ 2010.05.06</p> | <p>1.Сонгуулийн дараа шударга бус болсон талаар гомдол ихээр гардаг. Иймд дараагийн жилүүдэд мэдээж Үндсэн хуулийг боловсронгуй болгох чиглэлд ажиллах хэрэгтэй. Баталсан энэ сайхан Үндсэн хуулиа хэрэгжүүлэх тал дээр анхаарах болж байна. Үндсэн хуулийг хэрэгжүүлэхэд иргэнээс эхлээд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хүртлээ өдөр тутмын үйл ажиллагаандаа тусгах, хариуцлагатай байх хэрэгтэй. Ингэхээр Үндсэн хуулийн хэрэгжилт энэ хугацаанд тийм сайн байна гэж хэлж чадахгүй нь. Хамгийн гол зүйл бол хэрэгжилтэнд анхаарах юм.</p> |



“Ардын эрх” сонины 2005-2011 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хүртэл хэвлэлд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар УИХ-ын гишүүд, эрдэмтэд, бусад хүмүүсийн шүүмжилсэн асуудал болон дэвшүүлсэн 13 саналыг түүвэрлэсэн болно. “Үндсэн хуулийг өөрчлөх шаардлагагүй” гэсэн 2, Төрийн эрх мэдлийг хувиарлах зарчмыг үгүйсгэж, парламентын зүгээс Засгийн газарт хяналт тавих боломжийг алдагдуулсан гэсэн 3, 2000 оны долоон өөрчлөлтийг тохиролцож хийсэн гэж ард түмэн үзэж байгаа гэсэн 2, мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтанд байна гэсэн 2, Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хууль хэрэгтэй байна гэсэн 3, бусад гэсэнд 2 зэрэг санал шүүмжлэлүүд нийтлэгдсэн байна.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нь бусад орнуудын практикаас үзэхэд маш төвөгтэй, нарийн асуудал бөгөөд ялангуяа ганц нэг заалтыг нь сугалж авч өөрлөхөд зарим заалттайгаа болон Үндсэн хуулийн концепцитай зөрчилдөх тохиолдолд гардаг талтай байна. Ийм алдаа дутагдал гаргахгүйн тулд Үндсэн хуулийн цэцийн саналыг харгалзан үзэх нь чухал юм. Мөн Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар ард нийтийн санал асуулга авах нь зүйтэй гэж бодож байна.



ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД УЛС ТӨРИЙН НАМУУД ОРОЛЦОХ НЬ
(Харьцуулсан судалгаа)

*Ц. Товуусүрэн, Р. Хатанбаатар, Б. Ариунжаргал, Г. Билгээ,
Ц. Болормаа, Г. Гэрэл, О. Нарантуяа, Б. Хатантуул*

ГАРЧИГ

Оршил

Нэг. Дэлхийн улс орнуудын орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хөгжлийн туршлага

Хоёр. Дэлхийн зарим улс орнуудын туршлага

1. Канад улс
2. Чили улс
3. Франц улс
4. Испани улс
5. Словени улс
6. Шинэ Зеланд Улс
7. БНСУ
8. Унгар улс
9. Казахстан улс

Ашигласан материал

* * *

ОРШИЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн Су.Батболдын захиалгаар “Орон нутгийн сонгуульд улс төрийн намууд оролцох нь” сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн ахлах референт Ц.Товуусүрэн (Дэлхийн улс орнуудын орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хөгжлийн туршлага), ахлах референт Р.Хатанбаатар (Казахстан, Унгар), судлаач Б.Ариунжаргал (Канад), Б.Хатантуул (Чили, Испани), Г.Билгээ (Франц), Ц.Болормаа (Словени), Г.Гэрэл (Шинэ Зеланд), О.Нарантуяа (БНСУ) нар хийж гүйцэтгэлээ.

Дэлхий дахины нийгмийн хөгжлийн орчин үеийн түвшинд орон нутгийн өөрийн удирдлагын янз бүрийн загварууд байдаг. Тухайн загварын хүрээнд төлөөллийн байгууллага нь ямар эрх хэмжээний хүрээнд ажилладаг, орон нутгийн сонгогдох зарчмын талаар бидний хийсэн судалгаа тодорхой ойлголтыг өгнө гэдэгт найдаж байна.

Энэхүү судалгааг хийхдээ Казахстан, Унгар, Канад, Чили, Испани, Франц, Словени, Шинэ Зеланд, БНСУ-ын орон нутаг, мужийн сонгуулийн тойргийн талаар болон тойрогт намаас нэр дэвшүүлэх, намуудын сонгуулийн сурталчилгаа, намын ажиглагчид сонгуульд хэрхэн оролцдог талаар харьцуулан судалсан болно.

* * *



Нэг. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ОРОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨГЖЛИЙН ТУРШЛАГА

Орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын зохион байгуулалт нь ардчилсан төрийн үйл ажиллагааны суурь асуудлын хүрээнд багтаж байна. Өнөөгийн байдлаар ардчилсан улс орнуудад нийгмийн амьдралын бүхий л талын өөрчлөлт, шинэчлэлт нь иргэдийн ухамсрын эрс өөрчлөлтийн нөхцөл дэхь нийгмийн амьдралын зохион байгуулалтын хэлбэр, ардчилсан шинэчлэлт өөрчлөлт хүн-нийгэм, иргэн-төрийн харилцааны хялбарчилсан ойлголтын хуучирсан тэмүүлэлтэй тулгарч буй нөхцлийн эргэн тойронд явагдаж байна. Орон нутгийн засаг захиргааны орчныг шинжилж үзвээс түүнд төрийн болон, олон нийтийн гэсэн хоёр эрх ашиг нэгэн зэрэг хамрагдаж байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Орон нутгийн засаг захиргааны онцлог, төв засгийн газартай харилцан ажиллах механизмыг зөв ойлгох явдал нь нутгийн өөрөө удирдах байгууллагууд үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. Францын нэрт түүхч, улс төрийн зүтгэлтэн Алексис де Токвиль төв засгийн газар нь ямар сайн мэргэшиж гэгээрсэн байлаа гээд ганцаараа том ард түмний асуудлыг төгс хамруулан шийдвэрлэж чадахгүй гэжээ. Энэ асуудал нь хүний хүчин зүйлийн хил хязгаараас давдаг учраас тэрээр энэ ажлыг төгс шийдвэрлэж чаддаггүй байна. Хэрэв төв Засгийн газар ганцаараа зөвхөн өөрийнхээ хүчээр хязгааргүй олон, янз бүрийн нийгмийн механизмыг буй болгож, үйл ажиллагаа явуулах оролдлого хийлээ гэхэд төгс бус үр дүн үзэх буюу түүний хүчин чармайлт нь зүгээр л талаар өнгөрөх болно.

Орон нутгийн өөрийн удирдлагын зарчим нь түүнийг хэрэглэгчдийн хүрээнд хамгийн эртний, хамгийн олон талтай зарчмын нэг мөн, Энэхүү зарчим нь эрт дээр үеэс эхлээд одоог хүртэл нийгмийн зохион байгуулалтын цорын ганц хэрэгсэл хэвээр үлдэж, нийгэм, хувь хүний хэрэгцээ шаардлагыг хангасаар иржээ. Нийгмийн хөгжлийг дагаад түүний төрийн байгууллагуудтай харилцан ажиллах хүрээ өргөжиж, удирдлагын бодлого нь нарийн төвөгтэй болж байна. Өөрийн удирдлагын үүрэг, түүний институциональ хэлбэршил нь удирдлагын хэлбэр, аргаас ихэвчлэн хамаарч ихээхэн өөрчлөгдөж байна.

Үнэхээр орон нутгийн түвшинд л хүмүүс өөрсдийн хувьд хамгийн чухал асуудлууд (шугам сүлжээний асуудал, нийгмийн дэг журам, үйлчилгээ авах г.м.)-тай тулгарч байгаа бөгөөд тэдгээр нь орон нутгийн түвшиндээ шийдэгдэж байх ёстой юм. Дэлхий дахины нийгмийн хөгжлийн орчин үеийн түвшинд орон нутгийн өөрийн удирдлагын янз бүрийн загварууд байна.

- Англи-саксоны хэлбэр Их Британи, АНУ, Канад, Австрали зэрэг бусад орнуудад үйлчилж байгаа бөгөөд орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд нь өөрт хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд харьцангуй бие даасан байх ба орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагад хяналт тавих үүрэг бүхий Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч байдаггүй.
- Эх газрын загвар (Франц, роман-герман, европ) одоо үед Африк, Латин-америкийн франц хэл бүхий улс орнууд, ойрхи дорнодын орнуудад үйлчлэх бөгөөд дээд шатны байгууллагадаа доод шатных нь шууд харъяалагдан удирдагдах, сонгодог иерархи пирамид, удирдлагын босоо тогтолцоо бүхий, нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай шууд хослуулах зарчимтай байдаг.
- Иберийн буюу эх газрын тогтолцоотой төстэй загвар, Бразил, Португаль, Мексик, зарим нэг онцлогтойгоор Испанид хэрэглэдэг.
- Зөвлөлт Холбоот Улсын загвар 1917 оны Октябрийн хувьсгалаас хойш ЗСБНХУ-д анх хэрэглэж эхэлсэн, хожим бусад социалист орнууд загвар болгон хэрэглэсэн, Өнөөдрийг хүртэл БНХАУ, БНАСАУ, Куба, зарим нэг социалист чиг баримжаатай хөгжиж буй орнууд энэхүү хэлбэрийн зарим хувилбарыг хэрэглэж байна.

Орон нутгийн өөрийн удирдлагын тодорхой загварыг сонгоход шаардагдах нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл явц нь тодорхой нөхцлүүдээс хамаардаг байна:

- нийгмийн эдийн засгийн загвар, өмчийн хүрээнд үүсэх харилцаа;
- нийгэм, төрийн ардчиллын хүчин зүйл;
- бүс нутаг, үндэсний болон орон нутгийн хүчин зүйл, орон нутаг дахь засаг захиргааны онцлог;

Орон нутгийн удирдлагын англо-саксоны загварын хүрээнд төлөөллийн байгууллага нь өөрт ногдсон эрх хэмжээний хүрээнд бие даасан үйл ажиллагаатай байх бөгөөд доод шатны байгууллага нь дээд шатны байгууллагадаа шууд харъяалагддаггүй. Үүнээс гадна англо-саксоны системд ард түмнээс шууд сонгогддог нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд төв засгийн газраас хяналт тавих, оролцох эрх бүхий бүрэн эрхт төлөөлөгч байдаггүй нь нийтлэг юм. Орон нутгийн удирдлагын ийм тогтолцоотой улс орнууд (юуны өмнө АНУ)-д төлөөллийн байгууллагын нэгэн адил **нутгийн захиргааны нэлээд тооны албан тушаалтнуудыг** ард түмнээс шууд сонгодог байна. Энд төлөөллийн байгууллагын комисс, байнгын хороод тус байгууллагын хурлаас батлах шийдвэрийн төслийг боловсруулахад томоохон үүрэг хүлээдгийн хувьд илүү өргөн эрх мэдэлтэй байдаг. Орон нутгийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт ихэнхдээ шууд бус замаар хэрэгжих бөгөөд салбарын яамд, шүүхийн шийдвэрээр дамжин хэрэгждэг.

Англо-саксоны улс төрийн систем бүхий улс орнуудын орон нутгийн удирдах байгууллагын эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг нарийвчлан судалж үзэхэд тэдгээр нь төрийн механизмын бүрэлдэхүүн хэсэг үндсэн тулгуур гэж дүгнэдэг байна. Эдгээр улсуудын хууль тогтоомжид хэрэглэдэг нутгийн удирдлага гэдэг нэр томъёо нь тэдгээрийн төрийн бусад байгууллагаас ангид байх, орон нутгийн чанар гэсэн ганц шалгуурыг үндэс болгож нутгийн удирдлагын зохион байгуулалт үйл ажиллагааны зарчмыг илэрхийлдэг байна.

Орон нутгийн удирдлагын эх газрын загвар нь орон нутагт төрийн удирдлагыг нутгийн өөрийн удирдлагатай шууд хослуулахад үндэслэгддэг байна. Энэ тогтолцоо анхлан Францад үүссэн байна. Энэ улсын түүхэнд энэ системийн онцлог анхнаасаа коммуунуудын өөрийн удирдлагын байгууллага бус эзэн хааны бүрэн эрхт төлөөлөгч нь орон нутгийн эрхийг барьж байсантай холбоотой байдаг. Орон нутгийн төлөөллийн байгууллага нь эх газрын тогтолцооны нөхцөлд зөвхөн хууль тогтоогчид нутаг дэвсгэрийн нийгэмлэгээр хүлээн зөвшөөрсөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр байгуулагдана. **Зарим нэг засаг захиргааны салбар (Францын кантон, тойрог)-т орон нутгийн төлөөллийн байгууллага байхгүй байж болдог.**

Эх газрын загвар нь дээд шатны салаа мөчиртөө доод шатных нь тодорхой хэмжээнд харъяалагддагаар тодорхойлогдоно. Жишээ нь Италийн Үндсэн хуулиар мужуудад бүс, коммуны эрх зүйн акт хуульд нийцэж буй эсэхийг шалгах эрх олгосон байдаг. Энэ зохицуулалт улсын хууль, мужийн эрх хэмжээнд өргөжин тэлжээ. Эх газрын загвар бүхий улсуудад нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд хуулиар шууд хориглоогүй асуудлаар үйл ажиллагаа явуулах гэсэн “далд зохицуулалт”-ын зарчим баталгаажсан байна. Ийм зохицуулалт хоёр янзаар хэрэгжиж байна:

- Орон нутгийн хамгийн доод шатныхаас бусад бүх нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд нутаг дэвсгэрийн нийгэмлэгийн төлөөллийн байгууллага (түүний дотор хоёр дахь шатны буюу завсарын шатны төлөөллийн байгууллага), нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, төв Засгийн газраас томилогдсон бүрэн эрхт төлөөлөгч (Франц, Итали) нэгэн зэрэг ажилладаг.
- Нутгийн өөрийн удирдлагын байгууллага зөвхөн хамгийн доод шатны нэгжүүдэд байгуулагдах бөгөөд бусад дээд шатны нийгэмлэг, завсарын шатанд төрийн дээд шатны байгууллагаас томилсон орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд

үйл ажиллагаа явуулдаг байна. Доод шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллага нь энэ нөхцөлд зөвхөн бүс нутгийн түвшин дэхь нутаг дэвсгэрийн нэгжийн төлөөллийн байгууллага хэлбэрээр оршин тогтнодог байна. (Польш, Болгар, Турк, Финлянд, Иран)

- Нутгийн өөрийн удирдлагын иберийн систем нь Испани, Португал, Латин-америкийн испани хэлтэй орнуудад өргөн дэлгэр үйлчилдэг. Энд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтцийн бүхий л түвшинд сонгуулиар байгуулагдах зөвлөл байх бөгөөд ард түмнээс эсвэл зөвлөлөөс сонгогдох гүйцэтгэх байгууллага (алькальд, регидор г.м.) ажилладаг байна. Зөвлөл нь орон нутагтаа мөрдөх норм тогтоох ба алькальд нь түүний гүйцэтгэх байгууллага байна. Дээд шатнаас томилогддог эрх мэдэлтэн байхгүй бөгөөд харин сонгогдсон алькальдыг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн төлөөлөгч болохынх нь хувьд төвөөс баталдаг байна.
- Орон нутгийн удирдлагын зөвлөлтийн загвар (зөвлөл, түүний гүйцэтгэх хороодын тогтолцоо) нь эрх мэдлийн хуваарилалтыг үгүйсгэж, доороосоо дээд шатандаа хүртэл засгийн бүх эрх төлөөллийн байгууллагуудад байх тухай үзэл баримтлал дээр суурилдаг. Энэ тогтолцоогоор бүх шатны зөвлөлүүд нутаг дэвсгэртээ засгийн эрхийг барьж, түүнд бусад байгууллага шууд болон шууд бусаар харъяалагддаг. Энэхүү тогтолцоонд бие даасан орон нутгийн байгууллага байх тухай ойлголт үгүй бөгөөд бүгд дээд шатандаа харъяалагддаг байна. Энэ тогтолцоонд дараах шинжүүд нийтлэг байна:
- орон нутгийн байгууллагын эрх зүйн үндсийг Үндсэн хууль, хууль тогтоомжийн актаар төвөөс хууль тогтоох байгууллагаас тогтооно;
- хатуу төвлөрсөн удирдлагын зарчимтай;
- патернализмын зарчим;
- нутгийн өөрийн удирдлагын байгууллага төр засгийн байгууллагын тогтолцоонд ажиллана;
- мужийн өмч, орон нутгийн төсөв гэх мэт ойлголт үгүй;

Дээр дурдсан орон нутгийн өөрийн удирдлагын загваруудын талаархи мэдээллээс товч дүгнэлт хийж үзвэл нутгийн өөрийн удирдлагын үр ашиг бүхий тогтолцоо үйлчилж байх шаардлагатай болох нь ойлгомжтой бөгөөд энэ нь дор дурдсан нөхцлийг бүрдүүлсэн байхыг шаардаж байна:

- Удирдах байгууллагын бүрэн эрхийг хууль тогтоомжид товч тодорхой томъёолж суулгасан байхыг шаардана;
- Өөрийн бүрэн эрхийн хүрээнд нутгийн захиргааны байгууллагуудын бие даасан байдлыг тогтоох;
- Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь санхүүгийн хатуу баазад суурилсан байх: нутгийн захиргааны түвшин бүрт төсвийн эх үүсвэрийн тодорхой эх үүсвэрийг тогтоосон байх, үүгээр төсвийн хуваарилалттай холбоо бүхий маргаан гарах үндэс болохгүй байх;
- Нутгийн өөрийн удирдлага өөрийн удирдлагын түүхийн гүнзгий уламжлал, иргэний нийгмийн хэвтээ холбоог өргөжүүлэх тогтолцоонд тулгуурлах бөгөөд ийм маягийн хэлхээ холбоог өргөжүүлэх хөшүүрэг болж байх;

1985 оны Европын орон нутгийн удирдлагын хартид нутгийн өөрийн удирдлага нь нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын хуулиар тогтоосон хүрээн дэхь эрх, бодит чадамж мөн бөгөөд нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд орон нутгийн иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн орон нутгийн асуудлаа иргэд бие даан шийдвэрлэх бодит эрх мэдлийн хүрээнд иргэдийн гаргасан санал, санаачлагыг дэмжих үндсэн дээр өөрийн хариуцлагадаа авч, төрийн хэргийн томоохон хэсгийг зохицуулж, удирдах гэж тогтоожээ.

Хөгжингүй орнуудад орон нутгийн өөрийн удирдлагын хүчтэй байгууллага нь ирээдүйн эвдлэн сүйтгэх хүч бүхий цохилтын долгионоос найдвартай хамгаалах баталгаа болох бөгөөд нийгэмд тогтвортой, ардчилсан, нийгэм-улс төрийн нөхцөл байдлыг бүрдүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Хот, суурингийн бүсийн асуудалтай холбоо бүхий олон тооны хурц асуудлыг шийдвэрлэх шаардлага эдийн засгийн боломжийг хуваарилах дээр тулж очдог бөгөөд нутгийн захиргааны байгууллага өргөн хүрээний эрх мэдэлтэй баймааж л энэ асуудлыг шийдвэрлэж чадна. Тогтвортой, хүчирхэг төр улсыг байгуулъя гэвэл суурь нь ард түмэндээ ойр дотно нутаг дэвсгэрийн удирдлагын бүтэц, нутгийн захиргааны бүтцийг буй болгох системтэй үйл ажиллагаагүйгээр оршин байх боломжгүй бөгөөд гагцхүү нутгийн өөрөө удирдах байгууллагын концепцитай байхыг л шаардана. Орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагад тухайлбал хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, хот суурин байгаа эсэх зэрэг хүчин зүйлүүд зайлшгүй нөлөөлдөг байна.

Одоо үед бид нутгийн удирдлагын шинэ загварыг нутагшуулан тогтоох шатанд байна. Гэвч энэ үйл явц эдийн засгийн тааламжтай бус нөхцөл байдал, төрийн захиргааны байгууллагууд хөл гараа бүрэн олоогүй, нийгмийн тогтвортой байдал хангагдаагүй, орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагыг төлөвшүүлэхэд оролцдог этгээдүүдийн тогтвортой үйл ажиллагаа, мэдрэмж дутагдаж буйтай холбоотой байна. Ямартай ч нутгийн өөрийн удирдлага нь нийгмийн ардчилсан удирдлагын нэг гол үндэс бөгөөд засаг захиргааны байгууллага ард түмэндээ илүү ойртох нөхцлийг улам тод харах нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

II. Дэлхийн улс орнуудын хувьд орон нутгийн сонгууль явуулах асуудлыг олон янзаар хуульчилдаг байна. Нэгдмэл улсуудын хувьд Ерөнхийлөгч, парламентаас авахуулаад бүх шатны сонгуулийг нэг хуулиар зохицуулсан орон олон байхаас гадна бие даасан орон нутгийн сонгуулийн хуультай орнууд ч байна. Холбооны улсуудын хувьд бол маш олон хувилбараар орон нутгийн сонгуулийг хуульчилсан байхаас гадна холбооны субъект бүрт ч ялгаатай байдаг учир ангилахад нилээд төвөгтэй.

Орон нутгийн сонгуульд улс төрийн намууд сонгуулийн хороо, комиссуудад төлөөллөө оруулах, нэр дэвшүүлэх, буцаан татах, дахин нэр дэвшүүлэх, сурталчилгаа явуулах, сонгуулийн явцыг ажиглах, сонгуулийн үр дүнтэй холбоотой гомдол гаргах зэрэг хэлбэрээр оролцоно.

Орон нутгийн сонгуулийг зохион байгуулж явуулах шат шатны хороод, комиссуудыг тухайн улс бүр өөр өөрөөр байгуулдаг байна. Зарим улсуудад 5 жил, 6 жил гэх мэт тодорхой хугацаагаар байгуулагдсан сонгуулийн хороод ажилладаг бол зарим улсад тухайн сонгууль бүрт зориулан сонгуулийн хороодыг байгуулна. Олон оронд сонгуулийн хороодод намуудын төлөөллийг оруулдаг бол мөн олон оронд аль шатны нутгийн удирдлагын байгууллагын сонгууль болохоос шалтгаалж хороодыг намуудын төлөөлөлтэй ба төлөөлөлгүй байгуулна. Дашрамд дурдахад, нилээд оронд нутгийн удирдлагын байгууллагыг сонгон байгуулахдаа тодорхой түвшнээс эхлэн бүх доод шатанд улс төрийн намуудын оролцоогүйгээр сонгон байгуулдаг байна.

Сонгуулийн хороодод улс төрийн намуудын төлөөллийг оруулах хуулиар юмуу журмаар зохицуулагдсан олон арга байна. Жишээлбэл, ХБНГУ-д бүх түвшний (холбооны, муж улсын, тойргийн, хэсгийн) сонгуулийн удирдагчид комиссийн гишүүд ба орлогчдоо томилохдоо улс төрийн намуудын саналыг харгалзах ёстой. Нам бүрийн санал болгох хүмүүсийн тоо нь уг намын өмнөх сонгуулиар авсан саналын тоонд пропорционал байна. Канадад сонгуулийн байгууллагын бүрэлдэхүүн нь үндсэндээ улс төрийн намуудын саналд үндэслэсэн байна. Тухайлбал, сонгуулийн бүрэн эрхт төлөөлөгчийн орлогчийг өмнөх сонгуулиар олонхийн санал авсан хүмүүсээс сонгодог бол сонгуулийн хэсгүүдэд

Судалгааны эмхтгэл, X боть

ажиллах хүмүүсийг өмнөх сонгуулиар уг тойрог дээр хоёрдахь тооны санал авсан намаас бүрдүүлнэ.

Сонгуульд нэр дэвшүүлэх хэд хэдэн аргыг улс орнуудад хэрэглэж байна:

- а) зөвхөн улс төрийн намууд нэр дэвшүүлэх (Австри, Швейцари),
- б) зөвхөн тодорхой тооноос доошгүй бүртгэгдсэн сонгогчид нэр дэвшүүлэх (Канад, Австрали),
- в) улс төрийн намууд ба тодорхой тооны бүртгэгдсэн сонгогчид хамтран нэр дэвшүүлэх (ХБНГУ, АНУ).

Тухайлбал, Канадад нэр дэвшүүлэх баримт бичигт зөвхөн хоёр бүртгэгдсэн сонгогчийн гарын үсэг байхад хангалттай байдаг бол, Австралид нэр дэвшүүлэх өргөдөлд арван бүртгэгдсэн сонгогч гарын үсэг зурсан байх хэрэгтэй бөгөөд эдгээрийн нэг нь нэр дэвшүүлэгч, нэг нь нэр дэвшүүлэгчийн саналыг дэмжигч, үлдсэн найм нь нэр дэвшигчийг дэмжихийг зөвшөөрсөн бүртгэгдсэн сонгогч байна.

АНУ -д улс төрийн намууд нэр дэвшүүлэхийн тулд тодорхой тооноос доошгүй бүртгэгдсэн сонгогчдын гарын үсэг цуглуулсан байх хэрэгтэй (Иллинойст 25 мянга, Нью-Йоркт 20 мянга, Охайо, Алабамад 5 мянга г.м.) Гэхдээ АНУ-д ихэнх орон нутгийн сонгууль улс төрийн намуудын оролцоогүй явагддагийг санах хэрэгтэй.

ХБНГУ-д Бундестагт суудалгүй боловч аль нэг муж улсын Ландтагт сүүлийн сонгуулиар таваас доошгүй суудал авсан улс төрийн нам сонгуулийн кампанид оролцох хүсэлтээ сонгуулийн удирдагчид мэдэгдэж, үүнийг нь үндэслэн холбооны сонгуулийн хороо уг байгууллагыг улс төрийн намын шинжтэй гэж үзсэн тохиолдолд уг нам сонгуульд нэр дэвшүүлж болно. Үүнээс гадна парламентад суудалгүй нам өөрийн кандидатаа нэр дэвшүүлж буй тойрог бүрт 200-гаас доошгүй, нэр дэвшигчдийн жагсаалтаа дэвшүүлж буй муж улс бүрт 1000-аас доошгүй сонгогчдын гарын үсэг цуглуулах шаардлагатай байдаг байна.

Улс төрийн намуудын сонгуульд оролцох өөр нэг чухал хэлбэр нь сонгуулийн ажиглагчдаа ажиллуулах юм. Аливаа улсын сонгуулийн хууль, холбогдох бусад дүрэм журамд улс төрийн намуудын ажиглагчдын эрхийн талаар харилцан адилгүй заасан байх боловч ерөнхийдөө доор дурдсан эрхүүдийг ямар нэгэн байдлаар тусгасан байдаг байна. Тухайлбал, ажиглагчид сонгуулийн комиссийн хуралд байлцах; санал хураалтанд оролцож буй сонгогчдийн тооны талаар мэдээлэл авах; санал хураалтын болон санал тоолох үеэр санал хурааж байгаа байранд байх; санал хураалтын явц, саналын хуудсыг тоолох процедур, сонгуулийн хэсэг дээр саналын дүнг гаргах зэргийг ажиглах; сонгуулийн комиссийн гишүүд ашиглагдаагүй үлдсэн саналын хуудсыг тоолох, хүчингүй болгоход байлцах; санал хураалтанд саад бололгүйгээр фото, аудио, видео бичлэг хийх; санал хураалтын дүнгийн протоколыг дээд шатны сонгуулийн комисст дамжуулах процессийг ажиглах; санал хураалтын дараа сонгуулийн комиссийн санал хураалтын дүнгийн талаархи протоколтой танилцах, уг протоколын баталгаажуулсан хуулбарыг авах зэрэг эрхийг голчлон зохицуулсан байна.

* * *

Хоёр. ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

1. Канад улс

Канад улс нь арван муж, гурван нутаг дэвсгэрээс бүрдсэн холбооны улс бөгөөд эдгээрийг бүсчилбэл: **Баруун Канад:** Бритиш Коламбиа болон Альберта, Саскачеван, Манитоба зэрэг тал нутгийн гурван мужаасбүрдэнэ. **Төв Канад:** Квебек, Онтарио мужуудаас бүрдэнэ. Канадын Атлантын Далайн Бүс нь далайн эргийн Нью-Брансвик, Принс Эдвардын арал, Нова Скотиа зэрэг гурван муж болон Ньюфаундленд ба Лабрадороос бүрдэнэ. **Зүүн**

Канад:

Төв Канад, Канадын Атлантын Далайн Бүсийг хамтад нь хэлдэг.

Хойд Канад:

Юкон, Баруун Хойд Нутаг Дэвсгэр, Нунавут зэрэг мужууд орно.

Канадын нутаг дэвсгэр том боловч Канадын Сонгуулийн байгууллага бүхэлдээ төвлөрсөн шинжтэй байдаг бөгөөд алба салбарууд нь нийслэл Оттава хотдоо байрладаг. Бүтцийн хувьд 308 тойргоос бүрддэг. Сонгуулийн тойргуудыг арван жил тутам явагддаг хүн амын тооллогын дүнг үндэслэн өөрчлөн шинэчилдэг байна. Канад нь байнгын ажиллагаатай Сонгуулийн Менежментийн Байгууллага (СМБ)-тай. Канадад үндэсний түвшний СМБ нь үндэсний (холбооны) сонгуулийг хариуцан явуулдаг бол орон нутгийн СМБ-ууд нь орон нутгийн сонгуулийг хариуцан явуулдаг байна.

2006 оны сонгуулиас хойш холбооны парламентад таван нам төлөөлөлтэй байна

- Канадын Консерватив Нам (эрх баригч нам),
- Канадын Либерал Нам (албан ёсны сөрөг хүчин),
- Шинэ Ардчилсан Нам (ШАН),
- Блок Кэбэкуа,
- Канадын Ногоон Нам.

Намууд нь төв, орон нутгийн салбаруудад хуваагддаг. Намын салбар хорооны гишүүд тухайн орон нутгийн зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлдэг байна. Канадын Сонгуулийн хуулийн 6-р бүлгийн 65, 66 дугаар зүйлд нэр дэвшигчдэд тавигдах шаардлагын талаар заасан байна. 1970 оны өөрчлөлтөөр сонгуулийн сонгох эрхийг 21 нас хүрсэн иргэд эдэлдэг байсныг 18 нас болгосон байна. Намаас тойрог бүрт зөвхөн нэг нэр дэвшигчийг батлан гарын үсэг зурж болно. (Сонгуулийн хуулийн 68 дугаар зүйл) Тухайн сонгуулийн тойрогт эвсэл, намаас дэвшигч нас барсан эсвэл нэрийг татан авсан бол 74.1-т заасны дагуу өөр нэр дэвшигчийг нэр дэвшүүлэх өдөр дуусахаас өмнө нэр дэвшүүлж болно. (Сонгуулийн хуулийн 68-2 дугаар зүйл)

Олон намын тогтолцоонд суурилсан СМБ-ын гишүүд улс төрийн намуудын төлөөлөгчдийн үүрэг гүйцэтгэхийнхээ зэрэгцээ сонгуулийн үйл явцыг төвийг сахих зарчмын дагуу явуулж, өөрийг нь томилсон намын эрх ашгийг хамгаална. Тэд өөрсдийг нь томилсон намын эрх ашгийг хамгаалахаас гадна өөрийнхөөсөө бусад намын эрх ашгийг давуу байлгахгүйн төлөө ажиллана. Намаас сонгогдсон СМБ-ын гишүүд тодорхой хугацаанд алба хаших бөгөөд үүргээ зохих ёсоор гүйцэтгэх бололцоогүй болсон, эсвэл өөрийг нь томилсон эрх баригчид ажлаас нь халахаас бусад тохиолдолд албан тушаал нь өөрчлөгддөггүй.

СМБ-ын гишүүдийн тоо улс орон бүрт өөр байдаг. Канад 3 гишүүнтэй байна. Экспертэд суурилсан СМБ-ын гишүүн 1 байдаг. Канад СМБ-ын гишүүдийнхээ алба хаших хугацааг



Судалгааны эмхтгэл, Х боть

тогтоодоггүй, өөрөөр хэлбэл нэгэнт томилогдсон бол өөр ажилд шилжээгүй, халагдаж чөлөөлөгдөөгүй нөхцөлд тэтгэвэрт гарах буюу 65 нас хүртлээ ажилладаг байна.

Экспертэд суурилсан СМБ-ын гишүүн байх шалгуурт:

- улс төрийн хувьд төвийг сахих зарчим,
- насны доод хязгаар,
- мэргэжлийн ур чадвар,
- сонгуулийн талаарх мэдлэг зэрэг ордог байна.

Экспертэд суурилсан СМБ-ын гишүүд голдуу хууль эрх зүй, төрийн удирдлага, улс төрийн шинжлэх ухаан, хэвлэл мэдээлэл зүйн салбарт мэдлэг туршлагатай, төвийг сахих чадвар нь олон нийтэд танигдсан хүмүүс сонгогддог байна. Орон нутгийн СМБ-ын гишүүнээр сүүлийн жилүүдэд улс төрийн намын үйл ажиллагаанд оролцож байгаагүй болон СМБ-ын гишүүнээр ажиллах хугацаандаа улс төрийн намын гишүүнээсээ татгалзсан хүнийг томилж ажиллуулахаар заасан байна.

Сонгуулийн сурталчилгааг хийхдээ орон нутгийн СМБ-ууд улс төрийн намууд болон нэр дэвшигчдэд төрийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийх цагийг хуваарилан зохицуулж өгдөг. Канадын СМБ улсын бүртгэлтэй улс төрийн намууд цахим сүлжээ ашиглан төлбөртэй, төлбөргүй сурталчилгаа хийх, цаг хуваарилах хөндлөнгийн байгууллагыг томилж өгдөг байна. Орон нутгийн Сонгуулийн ахлах түшээ (САТ) бүртгэл бүхий улс төрийн намуудад цахим сүлжээгээр дамжуулан төлбөртэй, төлбөргүй явуулах нэвтрүүлгийн цагийг хуваарилах хөндлөнгийн ажилтныг томилдог байна. Канадын хуулинд улс төрийн зар сурталчилгааг нэргүйгээр нийтлэхийг хориглодог. Үүнд:

- Бүх зар сурталчилгаа нь зохиогчийн нэртэй буюу ивээн тэтгэгчийн нэртэйгээр мөн тэдгээрийн улс төрийн харьяаллыг нэрлэсэн байх ёстой. Зар сурталчилгааг ивээн тэтгэгчийн нэргүйгээр буюу ивээн тэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хуулийн хариуцлага хүлээхээр заасан байна.
- Улс төрийн намын албан ёсны төлөөлөгчийг дэмжсэн аливаа гуравдагч талын сурталчилгааг (нэр устай буюу нэргүй байхаас үл хамааран) тэрхүү намын сурталчилгааны лимитэд оруулан тооцох ёстой гэж заасан байна.
- Канад улс цагийн олон бүстэй. Сонгуулийн сурталчилгааны дүнг Канадын зүүн хэсэг дахь Халифакс мужид мэдээлсэн байхад түүний баруун хэсгийн Ванкуверийн сонгогчид саналын байр хаахаас өмнө мэдсэн байхаар мэдээлэхийг хориглодог байна.
- Олон нийтийн санаа бодлын судалгааны хувьд хориглосон зүйл байдаг. Тухайн сонгуульд сонгогчид саналаа хэрхэн өгөхийг харуулсан буюу тодорхой асуудлыг аль нэг нэр дэвшигч болон улс төрийн нам дэмжиж байгааг харуулсан Санал асуулгын дүнг сонгуулийн өмнөх Баасан гаригийн шөнө дундаас санал хураалт дуусах хүртэл хугацаанд нийтлэх, нэвтрүүлэх, тараахыг хориглодог байна.

Канадад сонгуулийн ажиглагчийг Сонгуулийн тухай актад 2000 онд нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө санал өгөх байранд сонгуулийн ажилтнаас өөр хэн ч орох эрхгүй байсан. Харин дээрх актад нэмэлт, өөрчлөлт оруулснаар Сонгуулийн ахлах түшээгийн зөвшөөрснөөр сонгуулийн байранд зөвхөн ажиглагчдад орж гарч байх эрх олгох болсон байна.

Канадын Бритиш Колумбиагийн мужийн засаг захиргаанаас тус мужийн иргэдийн төлөөллөөс бүрдсэн зөвлөл байгуулж, улмаар сонгуулийн тогтолцоог хараат бусаар үнэлж дүгнэх, гаргасан зөвлөмжөө бүх нийтийн санал асуулгаар шийдвэрлүүлэх боломж олгосон нь урьд өмнө хаа ч байгаагүй, өвөрмөц бөгөөд цоо шинэ туршлага болсон байна.

Канад нь сонгуулийн төсвийг төрийн санхүүжилтээр хийхийг голчилдог. Сонгуулийн санхүүжилтэд гадаадын хандивлагчдийг оролцуулдаггүй байна. Канадын сонгуулийн байгууллага нь зохион байгуулалт, санхүүжилт сайтай, шинэ технологи нэвтрүүлэх болон бусад нөөцийг судалж эзэмших талаар идэвхитэй, тогтвортой ажилладаг байна. СМБ-нь дараахь үндсэн үүргийг хэрэгжүүлдэг байна:

1. Бүртгэгдсэн улс төрийн намуудад санхүүжилт олгох ажлыг зохион байгуулах,
2. Сонгуульд оролцож буй улс төрийн намууд, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг хянах, хууль хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
3. Нэр дэвшигчдийн санхүүгийн мэдээллийг нийтлэх.

Канадчууд ерөнхийдөө сонгуулийн үйл явц, сонгуулийн газартаа итгэл үзүүлдэг бөгөөд энэ нь улс төрийн тогтвортой орчин бэхжихэд нөлөөлдөг. Канадын сонгуулийн байгууллагын давуу тал нь үйл ажиллагааныхаа бараг бүхий л чиглэлээр засгийн газраасаа хараат бус, түүний дотор санхүүгийн хувьд бие даасан байдагтай нь холбоотойгоос гадна зөрчил илрүүлж асуудлыг түргэн шийдвэрлэх талаараа гадны нөлөөлөлгүй ажиллаж чаддаг байна.

2. Чили улс

Чили бол 15 регион, 51 провинц, 346 муниципалитет, коммунаас бүрдсэн унитар улс юм. Чили улсын Үндсэн Хууль, Сонгуулийн тогтолцооны органик хууль-18.556 (1986), Орон нутгийн органик хууль-18.695 (2006), Улс төрийн намуудын тухай хууль-18.603 /1987/ зэрэг хуулиудаар орон нутгийн сонгуулийн процедурыг зохицуулна. Парламентын болон орон нутгийн аль алиных нь сонгуульд нам, эвсэл, бие даагчдын зүгээс тойрог бүрт дээд тал нь хоёр хүний нэр дэвшүүлсэн жагсаалтыг гаргаж өгдөг байна. Сонгогчид өөрсдийн шилж сонгосон нэр дэвшигчийнхээ төлөө санал өгдөг.

Эхний суудлыг нийт дүнгээр хамгийн олон санал авсан жагсаалтад багтсан нэр дэвшигчдэд өгдөг. Нэг тойргийн хоёр суудлын хоёуланг авахын тулд хамгийн амжилттай өрсөлдөгчдийн санал нь хоёр дахь жагсаалтад өгсөн саналаас хоёр дахин их байх ёстой. Энэ тогтолцоонд тавьдаг босго маш өндөр учраас намууд сонгуульд эвсэл болон оролцох шаардлагатай болдог байна. Тухайн жагсаалтаар нэг суудал авахын тулд нийт саналын 33,4 хувийн санал авсан байх шаардлагатай. Харин хоёр суудлын хоёуланг баталгаатай авахын тулд нийт саналын 66,7 хувийг авсан байх хэрэгтэй.

Сонгуулийн бином (binomial) тогтолцооны үр дүнд бараг бүх дүүргээс Концертацони нэг төлөөлөгч, Чилийн Альянсаас нэг төлөөлөгч сонгогддог байна. Энэ тогтолцоонд нэг жагсаалтаас нэг суудлын төлөө өрсөлдөж байгаа хоёр нэр дэвшигчийн хооронд өрсөлдөөн явагдах боломжтой ч практик дээр аль аль эвсэлд байгаа элитүүдийн байр сууринаас болж энэ байдал ихээхэн хязгаарлагддаг.

Энэ тогтолцооны давтагдашгүй онцлог бол практик дээр хамгийн том олонхийг бус хамгийн том цөөнхийг дэмждэг явдал юм. Энэ бол мажоритар буюу олонхийн тогтолцоо биш. Харин нийт саналын 34 хувийг авсан сонгуулийн жагсаалт нийт суудлын тал хувийг авах боломж олгодог учраас хувь тэнцүүлэх механизм ашигладаг боловч пропорциональ бус үр дүн гаргадаг тогтолцоо юм. Яагаад ийм гажуудал гараад байгаагийн гол шалтгаан нь сонгуулийн өрсөлдөөнд тавьдаг хязгаарлалтуудтай холбоотой. Энэхүү сонгуулийн тогтолцоо нь хэд хэдэн үндэслэлээр шүүмжлэл өртөж ирсэн. Нэгдүгээрт, намууд нэг суудал авахын тулд маш өндөр босго давах ёстой болдог учраас сонгуульд заавал эвсэж орохыг хүчээр шаарддаг.

Хоёрдугаарт, ихэвчлэн эвсэл бүр нэг суудал авдаг учраас жинхэнэ өрсөлдөөн хоёр



Судалгааны эмхтгэл, Х боть

сөргөлдөгч эвсэл ба тэдний намуудын хооронд явагдахын оронд нэг эвслийн гишүүн намуудын хооронд явагддаг байна. Энэхүү маргаан нь эвслийн эв нэгдэл, тогтвортой байдалд эрсдэл учруулж байдаг. Дөрөвдүгээрт, энэ тогтолцоо нь намын удирдлагуудад асар их эрх мэдэл олгосноос тэд бараг жагсаалт хийж байх явцдаа л ялагчдыг сонгогчидог байна.

Олон тойрогт жинхэнэ өрсөлдөөн явагддаггүй учраас сонгогчид сонгуульд оролцох сонирхол муутай байгаад зогсохгүй өөрийнх нь дэмждэг намаас нэр дэвшигч байхгүй бол бүр ч сонирхолгүй болдог ажээ. Одоогийн сонгуулийн тогтолцоотой холбоотой өөр нэг асуудал бол сонгогчоор бүртгүүлэх эсэх нь сайн дурын боловч саналаа заавал өгөх шаардлага тавьдаг явдал юм.

Муниципалитетын сонгууль. Энэ сонгуулиар мэр ба муниципалитетын зөвлөхүүдийг сонгодог. Мэрийг сонгуульд оролцсон сонгогчдын ердийн олонхийн саналаар сонгодог. Тухайн муниципалитетын бүртгэгдсэн сонгогчдын тооноос хамаарч сонгогдох зөвлөхүүдийн тоо зургаагаас аравын хооронд байх бөгөөд суудлыг Хондтын аргаар хуваарилах сонгууль явуулдаг. 2004 оноос мэр ба зөвлөхүүдийн сонгуулийг тус тусад нь явуулдаг болжээ. Хуулиар муниципалитетын сонгууль 4 жил тутам аравдугаар сарын сүүлийн ням гаригт явагдах бөгөөд шинээр сонгогдсон хүмүүс тухайн оныхоо 12 дугаар сарын 6-нд ажилдаа ордог байна.

Регионы сонгууль. 2009 онд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр регионы зөвлөлийн гишүүдийг бүх нийтийн шууд сонгуулиар сонгодог болсон бөгөөд энэ сонгогдсон гишүүд Ерөнхийлөгчийн томилсон интенданттай хамт 4 жил регионы засгийн газрыг бүрдүүлнэ. Гишүүд дахин сонгогдох эрхтэй. Гишүүдийн тоо нь регионы хүн амын тоонд пропорционалиар тогтоогдоно. Одоогоор энэ журмаар сонгууль явагдаагүй болно.

Одоогийн байдлаар регион бүрийн муниципалитетын зөвлөхүүд тухайн регионы зөвлөлийн гишүүдийг сонгож байна. Өөрөөр хэлбэл, тухайн регионы провинцуудын сонгогчдын коллегийг муниципалитетын зөвлөхүүд бүрдүүлнэ. Провинц бүрээс регионы зөвлөлд сонгогдох гишүүдийн тоог дараах маягаар тогтооно. Провинц бүрээс 2 гишүүн байх ба ба үүн дээр 1 сая хүртэл хүн амтай бол 10, 1 саяас дээш хүн амтай бол 14 гишүүн байхаар тоог тогтооно.

3. Франц улс

Франц улс нь дараах засаг захиргааны нэгжид хуваагддаг байна:

- 22 мужид хуваагдах ба үүнээс гадна Корсика,
- мужууд нь 96 департаментад хуваагдана,
- департамент нь 342 дүүрэгт,
- дүүрэг нь 3,883 кантонд,
- кантон нь 36,686 коммунд,
- 3 коммун (Париж, Марсел, Леон) нь 45 нэгжүүдэд тус тус хуваагдана.

Эдгээр засаг захиргааны нэгжүүдээс муж нь мужийн зөвлөлийн, департамент болон кантон нь ерөнхий зөвлөлийн, коммун нь хотын зөвлөлийн сонгуулийг тус тус явуулдаг байна. Засаг захиргааны нэгж нь сонгуулийн тойрог болно. Сонгуулийн тухай хуульд зааснаар сонгуулийн тойрог бүр зохион байгуулах хороотой байх ба байнгын гурван гишүүний бүрэлдэхүүнтэй. Тэдгээр нь (1) тухайн нутаг дэвсгэрийн захирагч, эсвэл түүний орлогч, (2) муж ба департаментад префект (Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч), дүүрэгт дэд префект болон (3) Ерөнхий шүүгчийн томилсон этгээд зэрэг байна. Сонгуулийн үеэд ажиллах бүрэлдэхүүнийг сонгуулийн өдрөөс таван 7 хоногийн өмнө бүрдүүлнэ.

Францын улс төрийн намууд нь зохион байгуулалтын үндэсний хэмжээний буюу төв, орон нутгийн хэмжээний буюу салбаруудад хуваагдана. Намын салбар хорооны гишүүд тухайн орон нутгийн зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлнэ. Муж зөвлөл, департамент болон кантоны Ерөнхий зөвлөлийн сонгуульд нэр дэвшигчид тавигдах дараах шаардлагуудыг хуульд заасан байна:

- 18 ба түүнээс дээш настай,
- франц үндэстэн,
- мужийн сонгуулийн бүртгэлд бүртгэлтэй,
- хамгийн багадаа сүүлийн таван жил татвар төлсөн.

Эдгээрээс гадна сонгуульд нэр дэвшиж болохгүй тохиолдолыг Сонгуулийн тухай хуулинд тодорхой заасан байна. Тухайлбал, төрийн зарим албан тушаалтан, тухайлбал, мужид Засгийн газрыг төлөөлж ажиллаж байгаа албан тушаалтан сонгуульд нэрээ дэвшүүлэхийг хориглосон байна.

Францын орон нутгийн сонгууль нь холимог системээр хоёр шатлалтай явагдана. Эхний шатанд дийлэнхи олонхийн саналыг авсан нь нийт мандатын 1/4-ийг авна. Бусад мандатад нь хамгийн багадаа 5 хувийн санал авсан нэр дэвшигчид пропорциональ системийн дагуу сонгогдоно. Хэрэв дийлэнхи олонхийн саналыг ямар ч нэр дэвшигч аваагүй тохиолдолд дараагийн буюу 2 дахь шатны сонгуулийг явуулна.

Коммуны хувьд дараах онцлогтой:

- 3500 болон түүнээс бага хүн амтай коммунд мажоритар системээр 2 үе шаттайгаар,
- 3500 болон түүнээс олон хүн амтай коммунд пропорциональ системээр 2 үе шаттайгаар,
- Париж, Марсел, Леон зэрэг коммунд пропорциональ системээр 2 шаттайгаар тус тус явуулна.

Сонгуулийн тухай хуулийн дагуу сонгуулийн сурталчилгааны хуудсыг зөвхөн тухайн орон нутгийн захиргаанаас тогтоосон газруудад наах бөгөөд нэр дэвшигчдэд ижил тэнцүү хувааж өгнө. Бусад газар сурталчилгааны хуудсыг наахыг хориглоно. Сонгууль явагдахаас өмнөх өдрийн шөнө дундаас эхлэн ямар нэгэн сурталчилгаа явуулахыг хориглоно. Мужийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Сонгуулийн тухай хуулийн хавсралт №7-д тодорхой заасан. Мөн хуулийн 336-р зүйлд заасны дагуу Мужийн зөвлөлийн гишүүд 7 жилийн хугацаатай сонгогдохоор заасан. Харин Сайд нарын зөвлөлийн мужийн сонгуулийн мандатын хугацааг багасгах тухай саналын дагуу 2010 оны №2010-145 хуулиар 2010 оны 3-р сарын сонгуулиар сонгогдсон Мужийн зөвлөлийн мандат болон Корсикийн Ассамблейн мандатын хугацааг 2014 оны 3-р сард дуусахаар заажээ.

Франц улс бол улс төрд жендерийн тэгш байдлыг хангах талаар хуульчилсан анхны улс. Жендерийн тэгш байдлыг хангах харилцааг хангах үүднээс 2000 онд баталсан Жендерийн тэгш байдлын тухай хуульд дараах гол нөхцөлийг тусгасан байна. Энэ нь бүх сонгуулийг үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг заавал хангах тухай зарчим бөгөөд үүнийг тухайн сонгуулиас хамаарч янз бүрээр хэрэгжүүлнэ. Тухайлбал, 3500-аас дээш оршин суугчидтай коммуны ба мужийн зөвлөлийн сонгууль, Корсикагийн Ассамблейн сонгуульд нэр дэвшигчдийн тал хувь нь заавал эмэгтэй байх ёстой.

Франц улс нь улс төрийн санхүүжилтын асуудлыг чухалчилж үздэг учир 1990 онд Сонгуулийн кампанит ажлын болон улс төрийн санхүүжилтыг хянах үндэсний хороо (CNCCFP–Commission Nationale des Comptes de Campagne et des Financements

Судалгааны эмхтгэл, Х боть

Politiques²⁴)-г байгуулсан. Уг хороо нь хоёр үндсэн үүргийг хэрэгжүүлдэг байна:

1. Бүх нийтийн шууд явагдах сонгуулийн 9000-аас дээш оршин суугчидтай тойрогт нэр дэвшигчдийн кампанит ажлын дансыг шалгаж төрийн сангаас олгох нөхөн төлбөрийг тогтооно.
2. Улс төрийн намын санхүүжилтын журмыг биелүүлж байгааг шалгана.

4. Испани улс

Испанийн Үндсэн Хуулийн 13.2, 23, 140.1 болон 141 дүгээр зүйл; Сонгуулийн ерөнхий тогтолцоо органик хууль 5/1985; Улс төрийн намуудийн санхүүжилт Органик хууль 3/1987; Орон нутгийн бүтцийг зохицуулсан хууль 7/1985; Улс төрийн намуудын тухай Органик хууль 6/2002 зэрэг эдгээр хуулиудаар орон нутгийн сонгууль түүний процедурийг зохицуулдаг байна. Үндсэн хуулийн 13.2 болон 23 дугаар зүйлээр сонгох болон сонгогдох эрхийн үндсийг заасан.

Испани бол нутаг дэвсгэрийн зарчмын үндсэн дээр эрх мэдэл хуваарилан төвлөрлийг сааруулсан, бие даасан засаг захиргааны тогтолцоотой улс юм. 3 түвшний сонгуультай:

- Үндэсний түвшний сонгууль (Конгресс),
- Өөртөө засах орны сонгууль (17 өөртөө засах коммунийн хууль тогтоох байгууллагыг сонгох),
- Орон нутгийн түвшний сонгууль

Сонгууль, санал асуулгыг Сонгуулийн тухай хуулийн үндсэн дээр бүх түвшний сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий Сонгуулийн төв зөвлөлийн хяналтийн дор өөртөө засах орон, орон нутаг, бүсийн сонгуулийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулдаг. Испани улсын орон нутгийн сонгууль нь сонгуулийн хувь тэнцүүлсэн системн дагуу явагддаг. Сонгууль 4 жил тутамд болдог ба ойролцоогоор 66,000 орчим төлөөлөгчид орон нутагт сонгогддог байна. Улс төрийн намууд, Холбоо эвсэлүүд орон нутгийн сонгуульд оролцохоор бол Сонгуулийн Зөвлөлд сонгууль зарласанаас хойшхи 9 дэх өдрөөс өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, 15-20 хоногт нэр дэвшигчдийг танилцуулна. Улс төрийн нам нь дангаараа болон бусад улс төрийн намуудтай эвсэл байгуулан оролцож болно.

Тухайн улс төрийн нам, намуудын эвсэл болон холбоодоос ирүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалт дахь нэр дэвшигчдийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангасан байх ёстой (40 дүгээр зүйл-Сонгуулийн Ерөнхий тогтолцооны Органик хууль) бөгөөд энэ нь 3000-аас доош хүн амтай орон нутагт хамаардаггүй. Тус улсын иргэд, тухайн орон нутагт амьдарч буй Европын Холбооны иргэд болон олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн иргэд сонгууль өгөх эрхтэй. Тус улс дахь улс төрийн намууд төвийг сахих зарчим, мэргэжлийн ур чадварын өндөр стандартыг хангах зорилгоор Сонгуулийн менежментын байгууллагад өндөр нэр хүндтэй хүмүүсийг томилдог бөгөөд ийм тохиолдолд гишүүд намуудын төлөөлөгч маягаар ажилладаггүй.

Мөн түүнчлэн улс төрийн намуудтай харилцах харилцаагаа хялбаршуулахын тулд сонгуулийн эхний үеэс улс төрийн нам бүрээс Сонгуулийн төв зөвлөл, доод шатны сонгуулийн зөвлөлтэй харилцах ерөнхий төлөөлөгчийг томилуулж, улс төрийн намууд болон Сонгуулийн зөвлөлийн хооронд холбоо барих үүрэгтэйгээр ажиллуулдаг байна Хүн амын тооноос хамаарч дараахь байдлаар сонгогдоно.

- 100 хүртэл оршин суугчид-3

²⁴ Эх сурвалж: <http://www.legifrance.gouv.fr/>

- 101 - 250 хүртэл -5
- 251 - 1.00 хүрэл-7
- 1.001- 2.000 хүртэл-9
- 2.001 - 5.000 хүртэл-11
- 5.001 - 10.000 хүртэл-13
- 10.001 - 20.000 хүртэл-17
- 20.001 - 50.000 21 хүртэл -21
- 50.001 - 100.000 хүртэл-25

Хэрэв уг сонгогдсон төлөөлөгч нас барсан болон бүрэн эрхээ алдсан тохиолдолд жагсаалтад дараагийн өндөр санал авсан нэр дэвшигч төлөөлөгч болно. Сонгуулийн кампанит ажил сонгууль зарласны 38 дахь хоногт эхэлж 15 хоног үргэлжилнэ.

5. Словени улс

Бүгд Найрамдах Словени улсын нутгийн удирдлагын эрх зүйн үндэс нь:

- Үндсэн хууль
- Орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хууль
- Орон нутгийн сонгуулийн тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомжоор (Сонгуулийн хууль болон Улс төрийн намын тухай хууль гэх мэт 10 орчим) тогтоогдсон байна.

Үүнээс судалгааны захиалагчийн хүсэлтийн дагуу Словени улсын орон нутгийн сонгуулийн асуудлыг дэлгэрэнгүй авч үзье.

Орон нутгийн сонгуулийн тогтолцоо. Юуны өмнө Словени улсын хувьд орон нутгийн хамгийн том нэгжийг “Municipal Council” гэх бөгөөд энэ нь манайхаар аймаг, нийслэлтэй ижил статус бүхий нутаг дэвсгэрийн нэгж гэдэг нь холбогдох хууль тогтоомжоос харагдаж байна. Тиймээс “Municipal Council” гэдгийг үгчлэн орчуулбал “Орон нутгийн зөвлөл” гэж болох хэдий ч дээрх үндэслэлийг харгалзан үзэж захиалагчид илүү ойлгомжтой болгох үүднээс “Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал” гэж орчуулсаныг анхаарна уу.

Орон нутгийн сонгуулийг **Орон нутгийн сонгуулийн тухай хууль** болон **Орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулиар** зохицуулна. Орон нутгийн сонгуулийн тухай хуулиар “Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал”, засаг дарга, бүсийн зөвлөл болон хотын зөвлөлүүд, тосгон болон дүүргийн коммуныг сонгох сонгуулийн үйл явцыг зохицуулна. Ерөнхий орон нутгийн зөвлөлийн сонгууль нь 4 жил тутамд явагдах ба шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө зарлан явуулж болно. Орон нутгийн ердийн сонгуулийг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч, харин эрт (early) буюу хуулийн хугацаанаас өмнө явуулах дахин болон нөхөн сонгуулийг хотын захирагч зарлана.

Тухайн орон нутагт оршин суугч Словени улсын насанд хүрсэн бүх иргэн сонгуульд саналаа өгөх эрхтэй. Орон нутгийн сонгуулийн хуулийн дагуу 12-оос бага гишүүн бүхий “Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал”-ын (Төлөөлөгчдийн хурал гэх) мажоритар системээр, харин 12-оос олон гишүүн бүхий Төлөөлөгчдийн хуралд пропорциональ системээр сонгууль явагдана. Түүнчлэн, иргэд нь бие даан нэр дэвшигчдийг мажоритар системээр сонгох бөгөөд харин нэр дэвшигчдийн жагсаалтаас сонгох тохиолдолд пропорциональ системээр сонгуулийг явуулна.



Судалгааны эмхтгэл, Х боть

Төлөөлөгчдийн хурал нь орон нутгийн төлөөллийн байгууллага бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид ардчилсан сонгуулиар шууд сонгоно. Хотын захирагчдыг 4 жилийн хугацаатайгаар, энгийн мажоритар системээр шууд сонгогдоно. Хэрэв нэр дэвшигчдийн аль аль нь шаардлагатай олонхийн саналыг авч чадаагүй тохиолдолд хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчийг 2 дугаар шатанд өрсөлдүүлнэ. Нэр дэвшигчид болон нэр дэвшигчдийн жагсаалтад улс төрийн намууд, эсвэл сонгуулийн нэгж дэх сонгогчид гарын үсэг зурснаар тухайн нэр дэвшигч сонгуульд өрсөлдөх боломжтой болох бөгөөд үүнийг

Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтуудыг танилцуулсан хэсэгт авч үзэх болно. Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогчид нь санал асуулгаар болон сонгогчдын хурлаар нэр дэвшигчдийг нэрлэж болно. Сонгогчдын хурлаар нэрлэж байгаа тохиолдолд сонгогчид тухайн хүнийг нэр дэвшигчид өрсөлдүүлэхээр санал оруулж, хурлаар хэлэлцэн сонгогдсон тохиолдолд нэр дэвшинэ. Сонгогч тус бүр хамгийн дээд тал нь Төлөөлөгчдийн хурал дахь суудлын тоогоор нэр дэвшигч санал болгох эрхтэй. Бие даан нэр дэвшигч нь хамгийн багадаа 30 санал, хэрэв сонгуулийн нэгж нь 500-аас бага оршин суугчидтай бол хамгийн багадаа 50 (оршин суугчийн) санал авснаар нэр дэвшигчийн эрхтэй болно.

Нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуульд зааснаар Үндэсний Ассамблей нь дараахь тохиолдолд аймаг, нийслэлийн төлөөлөгчдийн хурлыг тараан сонгуулийг хугацаанаас нь өмнө зарлах эрхтэй. Үүнд:

- 6 сарын хугацаанд Төлөөлөгчдийн хурлыг зарлан хуралдуулахад 3 удаа хурлын хүчинтэйд тооцох ирц бүрдээгүй бол,
- Дараалан 2 жил төсвөө баталж чадаагүй бол

Тухайн хуулийн дагуу Үндэсний Ассамблей, Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан хууль баталсан, түүнчлэн хуулинд заасан үүргээ биелүүлээгүй, хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл хийсэн мөн уг үйлдлээ засч залруулаагүй тохиолдолд Засгийн газрын санал болгосноор хурлыг тараах эрхтэй.

Улс төрийн намуудын тухай хуулиар сонгуулийн кампанит ажлын санхүүжилт болон намуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга замуудыг тодорхойлсон. Харин бие даан нэр дэвшигчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар ямар нэгэн зохицуулалт хийгээгүй. Уг хуулийн дагуу улс төрийн намууд нь гишүүнчлэлийн хураамж, хувь хүн байгууллагуудаас хандивласан хандив, өөрийн өмчөөс олсон орлого, ашиг зэргээр санхүүжинэ. Үндэсний Ассамблейд суудал бүхий намууд нь төрөөс санхүүгийн дэмжлэг авах эрхтэй.

Орон нутгийн сонгуулийн зардлыг тухайн орон нутгууд гаргана. Сонгуулийн кампанит ажлын тухай хуулиар орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд, бусад холбоо харилцааны хэрэгслээр дамжуулан сонгуулийн кампанит ажил явуулах, сонгуулийн буухиа (сонгуулийн сурталчилгааны бүхий л үйл ажиллагаа) зохион байгуулах, кампанит ажлыг санхүүжүүлэх журмыг зохицуулсан. Орон нутгийн зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна. Хугацаанаасаа өмнө чөлөөлөгдөх, огцорч болох боловч энэ талаар хуулинд тусгайлан заагаагүй байна.

БНСловени улсын Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн зарим зохицуулалт.

Орон нутгийн сонгуулийн тухай хууль нь 5 бүлэг 122 зүйлээс бүрдэнэ.

1. Нийтлэг зохицуулалт
2. Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль
3. Засаг даргын сонгууль
4. Дүүрэг, тосгон, хотын коммуны сонгууль

5. Бусад гэсэн ерөнхий бүтэцтэй юм.

Тус хуулийн онцлог нь олонхийг төлөөлөх буюу мажоритар, хувь тэнцүүлэн хуваарилах буюу пропорциональ системийн аль алинийг хэрэглэн орон нутгийн сонгуулийг явуулдаг байна. Хуулийн дагуу орон нутгийн удирдлагыг шууд, чөлөөтэй, нууц санал хураалтын зарчмаар сонгоно.

Сонгуулийн систем.

Мажоритар системээр сонгууль явуулах тохиолдлууд: Аймгийн, нийслэлийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийн сонгууль нь мажоритар эсвэл хувь тэнцүүлсэн зарчмын дагуу явагдана. Түүнчлэн, хэрэв Төлөөлөгчдийн хурал нь 12-оос бага гишүүнтэй бол тухайн сонгуулийг мажоритар системээр явуулна. Мөн хуулийн 10-р зүйлд зааснаар Төлөөлөгчдийн хуралд Итали болон Унгар үндэстнийг төлөөлөх гишүүдийг мажоритар зарчмаар сонгоно, Аймгийн зөвлөлд Цыган үндэстнийг төлөөлөх гишүүдийг мажоритар зарчмаар сонгоно гэж тусгайлан заасан байна. Түүнчлэн, хуулийн 11-р зүйлд зааснаар “Бие даан нэр дэвшигчдийг мажоритар зарчмын дагуу сонгоно”. Сонгогчид нь хамгийн ихдээ Төлөөлөгчдийн хурал дахь тухайн сонгуулийн нэгжид оногдох суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчид санал өгөх эрхтэй. Хамгийн олон санал авсан нэр дэвшигч нь сонгогдоно.

Энэ хуулийн зохицуулалтын нэг онцлог нь Хэрэв сонгуулийн нэгж нь Төлөөлөгчдийн хуралд нэг гишүүн сонгох бол хоёр нэр дэвшигч тэнцүү санал авсан тохиолдолд сонгуулийн дүнг сугалаагаар эцэслэн шийдвэрлэнэ. Хэрэв сонгуулийн нэгж нь Төлөөлөгчдийн хуралд нэгээс олон гишүүн сонгох үед, хамгийн их санал авсан хоёр нэр дэвшигч тэнцүү санал авсан тохиолдолд сонгуулийн дүнг сугалаагаар эцэслэн шийдвэрлэнэ.

Пропорциональ системээр сонгууль явуулах тохиолдолууд: Тухайн сонгуулийн нэгжид (тойрогт) нэр дэвшигчдийн жагсаалтад санал өгөх бол пропорциональ зарчмаар сонгууль явагдана. Нэр дэвшигчдийн жагсаалтанд санал өгч байгаа тохиолдолд сонгогч нь зөвхөн нэг нэр дэвшигчид санал өгөх эрхтэй. Нэр дэвшигчдийн жагсаалтанд санал өгч байгаа сонгогч нь саналын хуудсан дээрээ аль нэр дэвшигчийг илүүтэйгээр дэмжиж байгаагаа тэмдэглэж болно. Ингэж тэмдэглэхдээ сонгогч нь зөвхөн нэг нэр дэвшигчийг тэмдэглэнэ.

Хэрэв сонгуулийн нэгжид (тойрогт) нэр дэвшигчдийн жагсаалтад санал хураалт явагдаж байгаа тохиолдолд бие даан нэр дэвшигчдэд олгогдох мандатын тоог жагсаалтаар сонгуульд орж буй бүх нэр дэвшигчдэд өгсөн саналын тоог тухайн аймгийн Төлөөлөгчдийн хуралд сонгогдсон гишүүдийн тоонд хувааж гарсан коэффициентээр тодорхойлно. Жагсаалт тус бүрт өгсөн саналын тоог энэхүү коэффициентээр хувааж гарсан тоотой тэнцэх тооны мандатыг тухайн жагсаалтад олгоно.

Сонгуулийн нэгж.

Юуны өмнө Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн 6 дугаар хэсэгт заасан сонгуулийн нэгж гэдэгт дараахь байгууллагуудыг ойлгоно. Үүнд:

- 1) Үндэсний Сонгуулийн Хорлоо -The National Electoral Commission
- 2) Орон нутгийн Сонгуулийн Хорлоо-The municipal electoral commission (аймаг нийслэлийн)
- 3) Сонгуулийн Хэсгийн Хороод-Electoral-unit electoral commissions (Сонгуулийн нэгж хороо)
- 4) Сонгуулийн Зөвлөл - Election boards гэсэн шатлалтай байна.



Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн 35-р зүйлд зааснаар Орон нутгийн Сонгуулийн Хороодууд болон Сонгуулийн Хэсгийн Хороод (сонгуулийн нэгж хороо) Ерөнхийлөгч, 3 гишүүд тэдгээрийн орлогчдоос бүрдэнэ. Сонгуулийн Хороодын бусад гишүүд болон тэдгээрийн орлогч нь улс төрийн намуудын болон бусад байгууллага, оршин суугчдын саналаар томилогдоно. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурлыг сонгох мажоритар системээр явагдах сонгуулийн нэгжийг аймгууд дээр байгуулна. Хэрэв аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурал нь 7-оос бага гишүүнтэй бол сонгуулийн нэг нэгж байгуулж сонгуулийг явуулна. Сонгуулийн нэгжийг байгуулахдаа Төлөөлөгчдийн хурлын гишүүн тус бүрийг ойролцоогоор тэнцүү тооны сонгогч сонгохоор байгуулна.

Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурлын мажоритар сонгуульд сонгуулийн нэгж тус бүр нэг гишүүнийг сонгоно. Тухайн сонгуулийн хорооны байгуулалттай нийцэж байгаа тохиолдолд нэг нэгжээс нэгээс илүү гишүүн сонгох боломжтой. Харин нэг сонгуулийн нэгжээс 3-аас илүү гишүүн гаргах боломжгүй. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурлын пропорциональ сонгуульд аймгуудад сонгуулийн нэгжүүдийг байгуулна. Пропорциональ сонгуулийн нэгжийг тус хуулийн 20-р зүйлд заасны дагуу, сонгуулийн нэгж тус бүрээс аймгийн зөвлөлд 5-с доошгүй гишүүн сонгохоор байгуулна.

Сонгуулийн хэсэг (Electoral bodies).

Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо зохион байгуулж явуулна. Үндэсний сонгуулийн хороо нь хуульд зааснаар орон нутгийн сонгуульд тодорхой үүргүүдийг гүйцэтгэнэ. Итали, Унгар, Цыган үндэстнүүдийн төлөөллүүдийг сонгох аймаг, нийслэлийн тусгай сонгуулийн хороо байгуулагдаж ажиллана.

Сонгох, санал өгөх газар, хэсгүүдийг сонгуулийн хэсэг зохион байгуулж явуулна. Санал хураах хэсэг болгонд хамгийн багадаа 1 сонгуулийн хэсэг ажиллана. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон сонгуулийн нэгж хороо нь дарга, 3 гишүүн болон эдгээрийн орлогчдоос бүрдэнэ. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурал нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, сонгуулийн нэгж хороог томилж, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сонгуулийн хэсгийг томилно.

Нэр дэвших.

Мажоритар системээр явагдах сонгуульд нэр дэвших. Мажоритар зарчмын дагуу Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшигчдийг аймаг, нийслэлд улс төрийн намууд, харин сонгуулийн нэгжид сонгогчид нэр дэвшүүлнэ. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурал дахь Итали, Унгар үндэстний төлөөллийг тухайн коммуны төлөөлөл болох 15-аас доошгүй хүний гарын үсэгтэйгээр санал болгосноор сонгогчид нэр дэвшүүлнэ. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурал дахь Цыган үндэстний төлөөллийг тухайн коммуны сонгогчид нэр дэвшүүлнэ.

Сонгуулийн нэгж тус бүр дээр улс төрийн намууд өөрийн нэр дэвшигчдийг Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлж болно. Улс төрийн намууд нэр дэвшигчийг сонгохдоо өөрсдийн тогтоосон дүрмийн дагуу сонгоно. Зөвхөн тухайн сонгуулийн нэгжид оршин суугч сонгуулийн эрх бүхий намын гишүүд нэр дэвшигчийг тодруулахад оролцоно. Нэр дэвшигчийг нууц санал хураалтаар сонгоно. Сонгогчид нэр дэвшигчийг гарын үсэг цуглуулж, эсвэл сонгогчдын хурлаар тодруулна.

Сонгуулийн нэгж тус бүр дээр Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвших хүмүүсийг тухайн нэгжид байнга оршин суух 15-аас доошгүй сонгогчийн гарын үсэгтэйгээр тодруулна. Пропорциональ системээр явагдах сонгуульд нэр дэвших. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвших хүмүүсийн нэрсийн жагсаалтыг аймаг, нийслэлд улс

төрийн нам, сонгуулийн нэгжид сонгогчид гаргана.

Жагсаалт тус бүр дэх нэр дэвшигчдийн тоо нь хамгийн ихдээ тухайн нэгжид оногдох Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурлын суудлын тоотой тэнцүү байна. Улс төрийн намууд сонгуулийн нэгж болгон дээр нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж болно. Сонгуулийн нэгж тус бүр дээр сонгогчид Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн 54-р зүйлд заасан тооны сонгогчийн гарын үсэгтэйгээр нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж болно. Нэг сонгогчийн групп нь зөвхөн нэг жагсаалт гаргах эрхтэй байна.

6. Шинэ Зеланд улс

Шинэ Зеланд Улс нь 1996 оноос эхлэн сонгуулийн холимог системээр парламентын сонгууль явуулж байгаа. Нэг мандаттай 63 тойрог, үндэсний уугуул маорийн (Шинэ Зеландын Полинези гаралтай уугуул иргэдийн цөөнх) нэг мандаттай 7 тойрог болон 50 гишүүнийг намын нэрийн жагсаалтаар сонгодог. Сонгогч бүр өөрийн харъяалах нутаг дэвсгэрийн сонгуулийн тойрогт нэр дэвшигчийн төлөө болон улс төрийн намуудын нэрийн жагсаалтаар хоёр санал гаргана. Нэг мандаттай тойрогт нэр дэвшигч нь ердийн олонхийн саналаар сонгогдоно. Харин улс төрийн намууд парламентад суудал авахын тулд нам бүр сонгогчдын 5-аас доошгүй хувийн санал авсан байна. Сонгуульд 18 нас хүрсэн, эх орондоо нэгээс доошгүй жил амьдарсан тус улсын иргэн санал өгөх эрхтэй. Парламентын гишүүнд нэр дэвшигч нь 18 нас хүрсэн, тус улсын иргэн байна.

Шинэ Зеландын холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд хоёр босго байдаг. Аливаа нам улсын хэмжээнд намд өгсөн саналынхаа тоогоор парламентад тодорхой хувь хэмжээний суудал авахын тулд нэг бол нийт намын саналын дор хаяж таван хувийг авсан байх, эсвэл нэг мандаттай тойргуудаас ганц ч болов суудал авсан байх ёстой. 2010 онд Шинэ Зеландын 49 дэх удаагийн сонгуулийн парламент улс төрийн 7 намын төлөөлөлтэй бүрэн эрхээ хэрэгжүүлж байна.

Засаг захиргааны хуваарь: Шинэ Зеландын Вант Улс нь төрийн удирдлагын хувьд хараат бус, гэхдээ Шинэ Зеландтай чөлөөт холбооны харилцаатай арлын улсууд болох Күүк, Ниуэ арал, түүнчлэн Токелау, Росса гэсэн нутаг дэвсгэрээс бүрддэг. Орон нутгийн өөрийн удирдлагын зарчимд суурилдаг. 1989 оноос Бүсийн зөвлөл, Нутаг дэвсгэрийн удирдлагын зөвлөл гэсэн тогтолцоог хэрэгжүүлж буй. Бүсийн 12 зөвлөл, нутаг дэвсгэрийн 74 зөвлөлтэй (16 хотын зөвлөл, орон нутгийн 57 зөвлөл, арлын 1 зөвлөл). Нийслэл нь Веллингтон (Wellington) хот.

Орон нутгийн сонгуулийн тухай хууль (Electoral Act 2001)

19 - Нутгийн захиргааны байгууллага, Бүсийн зөвлөл, community boards-ын төлөөлөгчдийн сонгуулийн суурь тогтолцоо

19А - Нутгийн захиргааны байгууллагын гишүүн

- Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь хотын даргыг оруулаад нутгийн захиргааны байгууллагын 6-аас доошгүй, 30-аас дээшгүй гишүүнээс бүрдэнэ.

19В - Нутгийн захиргааны байгууллагын даргын сонгуулийн суурь тогтолцоо

1. Нутгийн захиргааны байгууллагын дарга тойргийн бүх сонгогчдоос сонгогдоно.
2. Нутгийн захиргааны байгууллагын даргын сонгууль нутгийн захиргааны байгууллагын бусад гишүүдийг сонгох бүх нийтийн сонгуультай хамт явагдана.

19С - Нутгийн захиргааны байгууллагын гишүүдийн сонгуулийн суурь тогтолцоо



Судалгааны эмхтгэл, Х боть

1. Нутгийн захиргааны байгууллагын гишүүдийн сонгуулийн тойрог сонгуулийн хэсэгт (ward) хуваагдаж болно.
2. Сонгуулийн тойрог хэсэгт хуваагдах ба зарим нутгийн захиргааны байгууллагын гишүүд нийт тойргоос сонгогдож болох ба гэхдээ энэ тохиолдолд нутгийн захиргааны байгууллагын бусад гишүүд нь тойргийн хэсэг бүрээс сонгогдоно.
3. Хэсэг нь хамгийн багадаа нутгийн захиргааны байгууллагын нэг гишүүнийг сонгоно.
4. Хэрэв тойрог нь хэсэгт хуваагдахгүй бол нутгийн захиргааны байгууллагын гишүүн бүрийг нийт тойргийн сонгогчдоос сонгоно.
5. Хэрэв тойрог нь хэсэгт хуваагдвал нутгийн захиргааны байгууллагын гишүүн нь тухайн хэсгийн сонгогчдоор сонгогдоно.

19D - Бүсийн зөвлөлийн гишүүд

- Бүсийн зөвлөлийн удирдах байгууллага нь 6-аас доошгүй мөн 14-өөс дээшгүй гишүүнээс бүрдэнэ.

19E - Бүсийн зөвлөлийн гишүүдийн сонгуулийн суурь тогтолцоо

1. Бүс нутаг нь сонгуулийн зорилгоор сонгуулийн тойрогт хуваагдана.
2. Бүсийн зөвлөлийн гишүүд нь бүс нутгийн сонгуулийн тойргийн сонгогчдоос сонгогдоно.
3. Бүсийн зөвлөлийн гишүүдийн зарим хэсэг нь бүс нутгаас сонгогдохгүй байж болох ба мөн зарим хэсэг нь бүс нутгийн сонгуулийн тойргийн сонгогчдоос сонгогдож болно.
4. Сонгуулийн тойрог бүр хамгийн багадаа нэг Бүсийн зөвлөлийн гишүүнийг сонгоно.
5. Бүсийн зөвлөлийн гишүүд нь тухайн харьяалагдах сонгуулийн тойргийн сонгогчдоор сонгогдоно.

19F - (Community boards)-ын гишүүн

1. community boards) бүр
 - 4-өөс доошгүй 12-оос дээшгүй гишүүдээс бүрдэнэ.
 - Хамгийн багадаа 4 нь сонгогдсон гишүүн байх ба
 - Томилогдсон гишүүдээс бүрдэж болно.
 - Томилогдсон гишүүдийн тоо нийт гишүүдийн тооноос бага байна.

19G- /community board/-ын гишүүний сонгуулийн суурь тогтолцоо

1. Сонгуулийн тойргийн хэсэг нь сонгуулийн зорилгоор нийгэмлэг нь дахин хуваагдаж болно.
2. Хэсэг бүр хамгийн багадаа 1 (community board) гишүүнийг сонгоно.
3. Хэрэв нийгэмлэг нь 2 эсвэл түүнээс олон хэсгээс бүрдвэл, /community board/-ын сонгогдсон гишүүн бүр нь тухайн хэсэг бүрийн сонгогчдоор сонгогдоно.
4. Хэрэв нийгэмлэг нь сонгуулийн зорилгоор хэсэгт хуваагддаг эсвэл хэрэв community board-ын гишүүд 19G-3 т заасны дагуу сонгогдсон бол:
 - Хэсгүүдийг төлөөлж байгаа (community board)-ын гишүүн бүр тухайн хэсгүүдийн сонгогчдоор сонгогдсон байна.
 - Хэсгүүдийг төлөөлж байгаа (community board)-ын гишүүн бүр тухайн хэсгийн сонгогчдоор сонгогдсон байна.

Маорийн хэсгүүд ба Маорийн тойргууд (Māori wards and Māori constituencies)

19Z - Нутгийн захиргааны байгууллага эсвэл Бүсийн зөвлөл нь Маорийн хэсгүүд эсвэл Маорийн тойргийг байгуулж болно.

1. Аль ч нутгийн захиргааны байгууллага нь сонгуулийн зорилгоор, тойрог нь 1 эсвэл түүнээс олон Маорийн хэсэгт хуваагдаж болно.
2. Аль ч Бүсийн зөвлөл нь сонгуулийн зорилгоор, тойрог нь 1 эсвэл түүнээс олон Маорийн тойрогт хуваагдаж болно.
3. Хуваагдахдаа энэ хэсгийн дагуу-
 - Хэрэв энэ хуулийн 19Z-3(с)т заасны дагуу Нутгийн захиргааны байгууллага эсвэл Бүсийн зөвлөлийн гурван жилийн хугацаатай явагддаг олон нийтийн сонгууль нь дараагийн гурван жилийн хугацаатай явагддаг олон нийтийн сонгуулиас 2 жилийн өмнөх оны 11 сарын 23-ны дотор хуваагдвал хүчинтэй болно.

Сонгуулийн хууль (Electoral Act 1993)

62 - Улс төрийн намын бүртгэл

1. Улс төрийн нам энэ хуулийн дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлж болно
2. Сонгуулийн комисс улс төрийн намыг энэ хуулийн дагуу бүртгэх эсэхийг тогтоож, Улс төрийн намуудын регистрт бүртгэн авна

63 - Бүртгүүлэх өргөдөл

1. Сонгуулийн хороонд улс төрийн намууд сонгуульд оролцохоо илэрхийлсэн өргөдлөө өгнө.
 - Намын нарийн бичгийн даргаар эсвэл
 - Тухайн намын одоогийн санхүүгийн гишүүн (current financial member) болох парламентын гишүүнээр дамжуулан өргөдлөө өгнө.
2. Сонгогдох эрх бүхий улс төрийн намын бүртгэлийн өргөдөл нь:
 - Албан бичгээр
 - Өргөдөл гаргагчийн гарын үсэгтэй байх ба доорх мэдээллийг агуулсан байна:
 - Намын нэр
 - Намын нэрний товчлол
 - Өргөдөл гаргагчийн нэр хаяг
 - Хэрэв өргөдөл гаргагч нь намын нарийн бичгийн дарга биш бол намын нарийн бичгийн даргын нэр, хаягийг бичнэ.
 - Намын аудиторроор томилогдсоноо хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан этгээдийн нэр, хаяг
 - Сонгогчдийн нэрсийн жагсаалтанд бүртгэгдэх эрх бүхий 500-аас цөөнгүй санхүүгийн гишүүдтэй нам болохыг Сонгуулийн хорооноос баталсан маягтын дагуу баталгаажуулж хавсаргасан байна.
 - Нам нь хамгийн багадаа сонгогдох ба сонгогчийн нэрсийн жагсаалтанд бүртгүүлэх эрх бүхий 500-аас доошгүй санхүүгийн гишүүдтэй байх, Тангараг ба мэдүүлгийн акт (Oaths and Declarations Act 1957)–ын 9-д заасны дагуу намын нарийн бичгийн дарга гаргасан мэдэгдлийг хавсаргах ёстой.

- Тангараг ба мэдүүлгийн акт (Oaths and Declarations Act 1957)-ын 9-д заасны дагуу гаргасан намын мөрийн хөтөлбөрийг (party intends) тусгасан мэдэгдлийг хавсаргах ёстой. Олон нийтийн сонгуульд
 - Энэ хуулийн 127-д заасны дагуу нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг ирүүлэх, эсвэл
 - Нам эсвэл холбогдох улс төрийн нам нь 1 эсвэл түүнээс дээш тойргийн нэр дэвшигчтэй байх, эсвэл
 - Дээрх хоёулаа
 - Тангараг ба мэдүүлгийн акт (Oaths and Declarations Act 1957)-ын 9-т заасны дагуу намын нарийн бичгийн даргын гаргасан мэдүүлгэд доорхийг тусгасан байх:
 - Нам нь нэг юмуу эсвэл түүнээс олон намын бүрэлдэхүүн эсэхийг тусгах
 - Нам нь нэг юмуу эсвэл түүнээс олон намын бүрэлдэхүүн бол, бүрэлдэхүүн намуудын нэр тус бүрийг тусгах
- 1- Улс төрийн намын бүртгэлийн өргөдлийг хүлээн авснаар, сонгуулийн хороо нь энэ хуулийн дагуу өргөдлийг авч хянан үзээд, тухайн намыг бүртгэх эсэх талаар шийдвэр гаргана.

67А- Намын бүртгэл

1. Сонгуулийн хороо нь сонгуульд оролцох улс төрийн намыг бүртгэхээр шийдвэр гаргасан бол, сонгуулийн хороо нь
 - Сонгуульд оролцох намыг бүртгэхдээ
 - Намын нэр, мөн
 - Хэрэв намын нэрийн товчлол өргөдөлд бичсэн бол, нэрийн товчлол
 - Намыг бүрдүүлж байгаа бүх тус тусдаа улс төрийн намуудын нэрс
 - Сонгуулийн хороо нь намыг бүртгэснийг албан бичгээр тухайн өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
 - Намын бүртгэлийн мэдэгдлийг тухайн намд нэгдэн орсон бүх намын нарийвчилсан мэдээг оролцуулан засгийн газрын албан ёсны хэвлэлд хэвлэнэ.
- 2- Сонгуулийн хороо нь сонгуульд оролцох улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргасан бол Хороо нь энэ шийдвэр гарсан өдрөөс хойш 10 ажлын өдрийн дотор тухайн өргөдөл гаргагчид татгалзсан тухай албан бичгээр мэдэгдэх ба татгалзсан шалтгааныг бичнэ.
- 3- Энэ хуулийн дагуу сонгуульд оролцох намыг бүртгэсэн аливаа улс төрийн намын нарийн бичгийн даргын үүрэгт:
 - Сонгуулийн хороонд бүх харилцаа холбооны хаягийг өгнө.
 - Сонгуулийн хороонд бүх харилцаа холбооны хаяг өөрчлөгдвөл мэдэгдэнэ.
 - Сонгуулийн хороонд намын нарийн бичгийн дарга шинээр томилогдох бүрт мэдэгдэнэ.

63А- Намын логоны бүртгэлийн өргөдөл

1. Улс төрийн намын логоны бүртгэлийн өргөдлийг Сонгуулийн хороонд ирүүлнэ.

- Намын нарийн бичгийн даргаар, эсвэл
 - Тухайн намын одоогийн санхүүгийн гишүүн болох аль ч парламентын гишүүнээр дамжуулан өгнө.
2. Улс төрийн намын бүртгэлийн өргөдлийг хүлээн авснаар, сонгуулийн хороо нь энэ хэсгийн дагуу өргөдлийг авч хянан үзээд, тухайн намын логоог бүртгэх эсэх шийдвэр гаргана.

143 - Сонгуулийн тойрогт нэр дэвшүүлэх

1. Энэ хуульд заасан нэр дэвших эрх бүхий этгээдийг өөрийн нь зөвшөөрөлтэйгөөр аль нэг тойргийн 2-оос доошгүй бүртгүүлсэн сонгогч тухайн тойргийн сонгуульд нэр дэвшүүлж болох ба Сонгуулийн хорооноос баталсан маягтын дагуу нэр дэвшүүлэх баримтыг бүрдүүлнэ.
2. Энэ хуулийн 143-3-т заасны дагуу аливаа этгээд нэр дэвшихийг зөвшөөрснөө сонгуулийн хянан шалгагчид (Returning Officer) албан бичгээр эсвэл факсаар хүлээн авах боломж бүхий бол факсаар ирүүлж болно.
3. Тухайн цагт Шинэ Зеландаас гадна байрлаж байгаа аливаа хүн өөрийн нэр дэвших зөвшөөрлийг Сонгуулийн хорооноос зөвшөөрөгдсөн аль ч арга хэлбэрээр энэ хуулийн 143-2-т заасны дагуу сонгуулийн хянан шалгагчид (Returning Officer) илэрхийлж болно.

146 -Бүртгэлтэй улс төрийн намуудаас нэр дэвшигчдийн олонхын саналаар нэр дэвшүүлэлт (Bulk nomination of candidates by registered political parties)

146 В - Олонхын саналаар нэр дэвшүүлэлтийн төлөвлөгөөний мэдэгдэл

1. Олон нийтийн сонгуульд бүртгүүлсэн улс төрийн намууд сонгуулийн тойрогт сонгуульд нэр дэвшигчдийн олонхийн саналаар нэр дэвшүүлэх нэрийн жагсаалтыг (bulk nomination schedule) төлөвлөнө. Намын нарийн бичгийн дарга Сонгуулийн хороонд төлөвлөлтөө мэдэгдэнэ.
2. Мэдэгдэхдээ энэ хуулийн 146В-1т заасны дагуу-
 - Олон нийтийн сонгуулийн тогтоол гарсан өдрийн дараа нэг ажлын өдрийн дотор ирүүлнэ.
 - Сонгуулийн хорооноос баталсан маягтын дагуу
 - Биеэр, шуудангаар, эсвэл факсаар ирүүлнэ.
 - Намын нарийн бичгийн дарга нь олонхын саналаар нэр дэвшүүлэх нэрийн жагсаалтыг гаргахаас өмнө хэзээ ч Сонгуулийн хороонд хүчингүй болгуулахаар (буцаан авахаар мэдэгдэн энэ хуулийн 146В-1-т заасны дагуу мэдэгдлийг хүчингүй болгох) буцаан авж болно.
 - Хүчингүй болгох/ буцаан авах энэ хуулийн 146В-3-т заасны дагуу-
 - Сонгуулийн хорооноос баталсан маягтын дагуу
 - Биеэр, шуудангаар, эсвэл факсаар өгнө.

146D-Сонгуулийн тойргийн нэр дэвшигчдийг олонхийн саналаар нэр дэвшүүлэх

1. Аль ч олон нийтийн сонгуульд, энэ хуулийн Бүлэг 4-т заасны дагуу бүртгүүлсэн улс төрийн намын нарийн бичгийн дарга, энэ хэсгийн дагуу мөн хуулийн дагуу шаардлагад тохирсон ба нэр дэвшихийг зөвшөөрсөн хүмүүсийг сонгуульд сонгуулийн тойрогт нэр дэвшигчээр дэвшүүлнэ.
2. Намын нарийн бичгийн дарга нь Сонгуулийн хорооноос баталсан ганц олонхийн саналаар нэр дэвшүүлэх хавсралт (a single bulk nomination schedule) маягтын



дагуу нэр дэвшүүлж болно.

3. Олонхийн саналаар нэр дэвшүүлэлтийн хавсралт-
 - Гараар, шуудангаар, эсвэл факсаар ирүүлж болно. Мөн
 - Нэр дэвшүүлэх өдрөөс хоцрохгүйгээр Сонгуулийн хороонд явуулна.
 - Сонгуулийн хороо нь олонхийн саналаар нэр дэвшүүлэлтийн хавсралт бүрт бичгээр хүлээж авсан баримт өгнө.

146E-Олонхийн саналаар нэр дэвшүүлэлтийн нэрийн жагсаалт (bulk nomination schedule)

1. Олонхийн саналаар нэр дэвшүүлэлтийн нэрийн жагсаалтанд дараахь шаардлагууд тавигдана-
 - Нэрийн жагсаалтанд заавал нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн тойргийг тодорхойлно.
 - Нэрийн жагсаалт нь сонгуулийн тойрог бүрт доорхи мэдээллийг оруулна-
 - Тойргийн нэр дэвшигчийн бүтэн нэр, мөн
 - Хэрэв нэр дэвшигчийн бүтэн нэр нь саналын хуудсанд хэвлэгдэхгүй бол, саналын хуудсанд багтахар урт нэр байна.
- 2- Тангараг ба мэдүүлгийн акт (Oaths and Declarations Act 1957)-ын 9-т заасны дагуу намын нарийн бичгийн даргаас гаргасан олонхийн саналаар нэр дэвшүүлэх нэрийн жагсаалт бүр тойргийн нэр дэвшигч нь сонгогдох эрхтэйг баталсан мэдүүлэгтэй байна.
- 3- Улс төрийн намын нарийн бичгийн даргаас гаргасан тойргийн нэр дэвшигчийн олонхийн саналаар нэр дэвшүүлэх нэрийн жагсаалтанд-
 - Сонгуулийн хорооноос баталсан маягтын дагуу, тойргийн нэр дэвшигчээр гарын үсэг зуруулсан, мөн нэр дэвшигчийг нэр дэвшихийг зөвшөөрсөн баталгаа байна.
- 4- Хэрэв улс төрийн нам энэ хуулийн 67-д заасны дагуу бүртгүүлсэн намын логотой, гэвч улс төрийн нам нь энэ хуулийн 127-д заасны дагуу намын нэрийн жагсаалтыг ирүүлээгүй бол, улс төрийн намын нарийн бичгийн дарга нь олонхийн саналаар нэр дэвшүүлсэн нэрийн жагсаалт гаргахдаа, Сонгуулийн хороонд саналын хуудсанд оруулахаар логоны хуулбарыг ирүүлнэ.
- 5- Энэ хуулийн 146E-4-т заасны дагуу лого тус бүрийг-
 - Гараар, шуудангаар, эсвэл факсаар ирүүлж болно. Мөн
 - Нэр дэвшүүлэх өдрөөс хоцрохгүйгээр Сонгуулийн хороонд ирүүлнэ.

160-Сонгуулийн ажиглагч

1. Тойрогт нэр дэвшигч бүр сонгуулийн санал хураах байр тус бүрт 1 эсвэл түүнээс олон сонгуулийн ажиглагч томилон ажиллуулж болно.
2. Хэрэв сонгуулийн тойрогт нэр дэвшигч нь улс төрийн намаас нэр дэвшсэн бол намын нарийн бичгийн дарга нь сонгуулийн санал хураах байр бүрт 1 эсвэл түүнээс олон сонгуулийн ажиглагч томилж болно.
3. Томилогдсон сонгуулийн ажиглагч бүр-
 - Албан бичгээр, мөн
 - Тойргийн нэр дэвшигчээр гарын үсэг зуруулсан эсвэл шаардлагатай тохиолдолд намын нарийн бичгийн даргаар гарын үсэг зуруулсан байна.

4. Санал хураах газарт байх нэр дэвшигчийн эсвэл улс төрийн намын сонгуулийн ажиглагчийн тоо санал хураах газар томилогдон ажиллаж буй албан хаагчдын тооноос хэтэрч болохгүй.
5. Сонгуулийн ажиглагч нь томилогдсон санал хураах байранд санал хураах цагийн турш санал хураах байрнаас гарч орж болно.
6. Нэр дэвшигч нь сонгуулийн ажиглагч байж болохгүй.

7. БНСУ

Засаг захиргааны нэгжийн тухай.

Орон нутгийн өөрийн удирдлагын тогтолцоо БНСУ-ын үндсэн тогтолцоо мөн гэдгийг Үндсэн хуулиндаа зааж, түүний бие даасан байдал, бүтэц зохион байгуулалтыг “Орон нутгийн өөрийн удирдлагын хууль”-иараа тодорхойлсон байдаг. 1948 оны 11 сарын 17-нд “Орон нутгийн засаг захиргааны тухай түр хууль” батлагдан орон нутгийн засаг захиргааны нэгж, түүний харьяа байгууллагуудын тодорхойлсон бөгөөд энэхүү хуулийг 1949 оны 7 сарын 4-нд “Орон нутгийн өөрөө удирдах хууль” нэртэйгээр баталсан боловч тухайн цаг үеийн хямрал, солонгосын иргэний дайны улмаас уг хууль нь хэрэгжихгүй байсаар 1952 онд орон нутгийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн сонгуулийг явуулснаар анхны орон нутгийн өөрөө удирдах тогтолцоо бий болсон. Гэвч 1961 оны 5 сард бүх орон нутгийн иргэдийн хурлыг татан буулгасан байна.

1988 онд эрх баригч нам ба сөрөг намын зөвшилцлийн дүнд Засгийн газраас “Орон нутгийн өөрөө удирдах шинэчилсэн хууль”-ийг зарлан тунхаглаж, 1991 оны 3 сарын 26-нд орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн сонгууль явуулснаар 30 жил тасалдсан орон нутгийн өөрөө удирдах тогтолцоо дахин сэргэсэн байна.

Орон нутгийн засаг захиргааны бүтцийг “Орон нутгийн өөрөө удирдах хууль”-ийн 2.1-д дараахь байдлаар ангилсан байна.

1. Өөрөө удирдах өргөтгөсөн нэгж
 - Тусгай хот буюу нийслэл Сөүл хот
 - Өргөтгөсөн хот ба муж (Мужийн эрхтэй хот)- Бүсан, Дайгү, Инчон, Гванжү, Дайжон, Үлсэн
 - Өөрөө удирдах тусгай муж (Аймаг)-Гёнги, Гангвөн, Чүнгбүг, Чүнгнам, Жөнбүг, Жөннам, Гёнгбүг, Гёнгнам, Жэжү
2. Үндсэн нэгж
 - Хот
 - Гүн
 - Дүүрэг

Муж, өргөтгөсөн хотууд Засгийн газрын, нийслэл Сөүл хот ерөнхий сайдын шууд удирдлагад байдаг. Жижиг хотууд мужийн захиргаанд, гүн нь өргөтгөсөн хот болон мужийн захиргаанд харьяалагдана. Одоогоор нийслэл Сөүл хот нь тусгай хотод, Бүсан, Дайгү, Инчон, Гванжү, Дайжон, Үлсэн зэрэг 6 өргөтгөсөн хот, Гёнги, Гангвөн, Чүнгбүг, Чүнгнам, Жөнбүг, Жөннам, Гёнгбүг, Гёнгнам, Жэжү гэсэн 9 аймаг, 68 хоттой. БНСУ-ын орон нутгийн өөрөө удирдах тогтолцоонд дараах хоёр эрх барих дээд байгууллага байдаг.

- Орон нутгийн бүх шатны засаг дарга
- Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал

Судалгааны эмхтгэл, Х боть

Засаг дарга нь тухайн орон нутгийн өөрөө удирдах нэгжийг төлөөлөх, ажил хариуцах, гүйцэтгэх, удирдах, шийдвэрлэх үүрэг хүлээдэг. Харин Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь орон нутгийн шийдвэр гаргах хамгийн дээд байгууллага.

Орон нутгийн засаг дарга. Орон нутгийн өөрөө удирдах хуулийн 85, 86, 87-р зүйлд орон нутгийн өөрөө удирдах нэгж бүр засаг даргатай байна гэж заасан. Өргөтгөсөн хот, мужид 1 засаг дарга, 2 орлогч, хот, гүн, өөрөө удирдах дүүрэгт 1 засаг дарга, 1 орлогчтой байна. Бүх шатны захирагч, засаг даргыг энгийн, эрх тэгш, шууд, нууц санал хураалтаар сонгоно. Засаг даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд 3 удаа улиран сонгогдож болно. Орон нутгийн засаг дарга нь дараах эрх мэдлийг хэрэгжүүлнэ.

1. Төлөөлөн удирдах эрх
2. Төрийн хэрэг итгэмжлэн хариуцах
3. Ажил эрхлэн гүйцэтгэх эрх
4. Ажилтан томилох, огцруулах эрх

Иргэдийн төлөөлөгчдийн хурал. Орон нутгийн өөрөө удирдах хуулийн 26, 32-р зүйлд Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийг иргэдийн энгийн, эрх тэгш, шууд, нууц санал хураалтаар сонгоно. Гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил. Орон нутгийн иргэдийн хурлын тоог тогтооходоо бүс нутгийн онцлог байдалд зохицуулан шийдвэрлэхийн оронд хуулиар тодорхой тоо тогтоосны дараа, түүнийгээ бусад бүх иргэдийн хуралд нийцүүлэх зарчим баримталдаг. Орон нутгийн нэгжийн бүтцэд өөрчлөлт орсон тохиолдолд ИТХ-ын тоонд мөн зохицуулалт хийдэг.

Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хурлыг жилд 2 удаа хийнэ. Харин ээлжит бус хурлыг орон нутгийн засаг дарга болон нийт гишүүний 1/3 хувийн саналаар 15 хоногийн дотор хуралдуулж болно. ИТХ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1. Шийдвэрлэх эрх. ИТХ нь дараах асуудлыг шийдвэрлэхээр хуульчилсан.
 - Тогтоол журам боловсруулж батлах, хүчингүй болгох
 - Төсөв хэлэлцэж батлах
 - Тайлан тооцоог батлан зөвшөөрөх
 - Хуулинд зааснаас бусад хураамж, шимтгэл, ноогдол ашиг, орон нутгийн татвар, элсэлтийн хураамжийг тогтоон хураах
 - Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон өмч хөрөнгө бий болгох, зарцуулах
 - Нийтийн байгууламж байгуулж ажиллуулах
 - Санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэх
 - Гадаадын ижил түвшний нэгжтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх
 - Бусад хуулиар тогтоосон бүрэн эрх
2. Захиргааны ажлыг хянан шалгах эрх²⁵
3. Бие даасан эрх²⁶

²⁵ Энэ эрхийнхээ хүрээнд жилд нэг удаа тухайн орон нутгийн өөртөө засах нэгжийг шалгадаг. Өргөтгөсөн хот, мужийн захиргааны ажлыг 10 хоногт, хот, гүн, дүүргийн ажлыг 7 хоногийн дотор шалгана. Шалгалтын явцад шаарлагатай бичиг баримтын гаргуулан авах, газар дээр нь шалгах, албан хаагчийг дуудан мэдүүлэг авах эрхтэй байхын зэрэгцээ хариуцлага хүлээлгэх бүрэн эрхтэй.

²⁶ Дотоод зохион байгуулалт, гишүүнчлэл, хуралдаан болон гишүүдийн сахилгын шийтгэлийн талаархи журмыг ИТХ бие даан шийдвэрлэж болдог.

4. Санал гомдол барагдуулах бүрэн эрх²⁷**Орон нутгийн сонгууль****Орон нутгийн сонгуульд**

1. Өргөтгөсөн хот, мужийн захирагчийн сонгууль
2. Өргөтгөсөн хот, мужийн иргэдийн төлөөлөгчдийн сонгууль
3. Өөрөө удирдах дүүрэг, хот, гүний засаг даргын сонгууль
4. Өөрөө удирдах дүүрэг, хот, гүний ИТХ-ын сонгууль хамаарна.

Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь нам эвслээс, бие даан гэсэн хоёр хэлбэрээр нэр дэвшинэ. Өргөтгөсөн хот, мужийн захирагчид бие даан нэр дэвшигч нь 1000-2000 хүн, ИТХ-д нэр дэвшигч нь 100-200 хүний дэмжлэг буюу дэмжигчдийнхээ гарын үсгийг цуглуулсан байх ёстой. Өөрөө удирдах дүүрэг, хот, гүний засаг даргад нэр дэвшигч нь 300-500, ИТХ-д нэр дэвшигч байгаа бол 50-100 хүний дэмжлэгийг авна. Нэр дэвшигчдийг санал хураалт болохоос 15 хоногийн өмнө хоёр хоног, өглөө 9-17 цагийн хооронд бүртгэнэ. Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэхдээ дараах хэмжээний барьцааны мөнгийг авдаг.

| Сонгуулийн төрөл | Барьцааны мөнгө /вон/ |
|-------------------------------------|-----------------------|
| Өргөтгөсөн хот, мужийн захирагч | 50 сая |
| Өргөтгөсөн хот, мужийн ИТХ | 3 сая |
| Өөртөө засах дүүрэг, хот, гүний ЗД | 10 сая |
| Өөртөө засах дүүрэг, хот, гүний ИТХ | 2 сая |

Дээрхи барьцааны мөнгийг сонгуульд ялбал суутгалаа төлөөд буцааж авах, ялагдвал тодорхой хувийг буцааж авах нөхцөлтэй байдаг. Хэрэв нэр дэвшигч сонгогдох, нас нөгчих, хүчинтэй саналын хуудас 100-ны 15 хувиас дээш байвал үндсэн зардлыг нь хасаад эргүүлж өгнө. Харин хүчинтэй саналын хуудасны тоо 100-ны 10 хувиас дээш, 15 хувиас доош байвал барьцааны мөнгөний 50 хувийг буцааж олгоно.

Орон нутгийн сонгуульд албаны бүрэн эрхийн хугацаа 4 жил. Хуульд заасны дагуу шинэ захирагчийн бүрэн эрхийн хугацаа 7 сарын 1-ээс эхэлдэг. Сонгуулийн санал хураах өдрийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө, лхагва гарагт байхаар тохируулна. Сонгуулийн сурталчилгаа 14 хоног байна.

Сонгуульд ялагчийг дараах зарчмаар тодруулна.

1. Өргөтгөсөн хот, мужийн захирагч болон өөрөө удирдах дүүрэг, хот, гүний засаг даргын сонгуульд олонхийн санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон гэж үзнэ. Хэрэв 2 ба түүнээс дээш нэр дэвшигчийн саналын тоо тэнцвэл насны эрэмбээр шийдвэрлэнэ. Санал хураах цаг дуустал ганц нэр дэвшигч байвал нийт сонгогчдын 1/3 хувийн санал авч байж сонгогдсонд тооцогдоно.
2. Өөрөө удирдах дүүрэг, хот, гүний ИТХ-д нэр дэвшигчдээс олонхийн санал авсан эрэмбээр нийт ИТХ-ын тоонд нийцүүлэн сонгоно.
3. Орон нутгийн ИТХ-ын пропорциональ төлөөллийн сонгуульд 100-ны 5-аас дээш хувийн санал авсан нам суудал хуваарилуулж авах эрхтэй. Гэхдээ нийт суудлын 2/3-оос илүүг хуваарилахгүй.

²⁷ ИТХ нь орон нутгийн нэгжийн удирдлагыг хянан захирдаг.

Судалгааны эмхтгэл, Х боть

Сонгуулийн сурталчилгаа. Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчийг бүртгэж дууссан өдрөөс эхлэн санал хураах өдрийн урд өдөр хүртэл явуулна. Орон нутгийн иргэдийн хурал болон даргад нэр дэвшигч нь хот, гүн, дүүрэг бүрт нэг сонгуулийн байр байгуулж болно.

Сонгуулийн сурталчилгааг дараах төрлөөр явуулахаар Төрийн албаны сонгуулийн хуулиар хуульчилсан. Тухайлбал

- Зурагт хуудас
- Сонгуулийн мөрийн хөтөлбөр танилцуулах
- Сонингийн сурталчилгаа
- Телевизийн сурталчилгаа
- Телевизийн халз мэтгэлцээн
- Нэр дэвшигчийн дундах хэлэлцүүлэгт оролцох
- Мэдээлэл, холбооны сүлжээ ашиглах (интернэт, утас, мессэж)

Сурталчилгааны зурагт хуудсанд зураг, нэр, харьяа намын нэр (бие даагч), ажил байдлын товч намтар зэргийг оруулсан байна. Нэр дэвшигч нь бүртгэлийн хугацаа дууссан дараа 3 хоногийн дараа хот, дүүрэг, гүний сонгуулийн хороонд мөрийн хөтөлбөрөө хүргүүлнэ. Хэрэв дурдсан хугацаанд мөрийн хөтөлбөрөө ирүүлээгүй тохиолдолд мөрийн хөтөлбөргүй гэж үзнэ.

Ерөнхийлөгчийн болон орон нутгийн байгууллагын сонгуульд нэр дэвшигчид нь мөрийн хөтөлбөр боловсруулдаг. БНСУ-д сонгуульд нэр дэвшигчдийн тараах материалын тоог хуульчилж өгсөн байдаг онцлогтой. Энэ нь санхүүгийн багцаа гаргах, сонгуулийн дараа барьцааны мөнгийг буцаан олгоход чухал байдаг. Тухайлбал ерөнхийлөгчийн болон орон нутгийн байгууллагын удирдлагад нэр дэвшигчид нь дараах тооны тараах материалыг тараана. Хот, мужын сонгуульд 16 хүнд, тусгай муж, хот, гүний сонгуульд 12 хүн тутамд 1 сонгуулийн сурталчилгааны материал байхаар тооцно.

Телевизийн нэвтрүүлгийн хувьд сонгуулийн төрлөөс хамаарч зохицуулсан байдаг бөгөөд орон нутгийн сонгуульд нэр дэвшигчийн хувьд радио болон телевизийн 5 нэвтрүүлэг хийлгэх эрхтэй. Халз мэтгэлцээний хувьд нэг удаад 10 минутын нийт 5 радио болон телевизийн мэтгэлцээнд оролцох эрхтэй. Харин хэлэлцүүлгийн хувьд нэр дэвшигч нь хэлэлцүүлгийн талаархи саналаа 2 хоногийн өмнө харьяа сонгуулийн хороонд саналаа ирүүлнэ. Мэдээлэл, холбооны хэрэгсэл ашиглан сурталчилгаа хийхдээ өөрийн болон сонгуулийн хорооны цахим хуудсаар дамжуулан нийтэд сурталчилж болно. Утсаар үгэн болон дүрстэй мессэж явуулж болно.

Сонгуулийн менежмент (ерөнхий)-ийн хороо.

БНСУ-ын сонгуулийн менежментын хорооны гишүүнд улс төрийн намын гишүүн хүн гишүүнээр ордоггүй. БНСУ-ын сонгуулийн менежментын хороо нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. Үндэсний Ассамблей, Ерөнхийлөгч, Дээд шүүхийн даргаас тус бүр 3 хүнийг санал болгон гишүүнээр томилно. Тусгай болон өргөтгөсөн хот, мужийн сонгуулийн хороо 9, хот, дүүрэг, гүний сонгуулийн хороо 9, ыб, мёны сонгуулийн хороо нь 7 хүний бүрэлдэхүүнтэй.

Орон нутгийн сонгуулийн хорооны гишүүнээр Үндэсний Ассамблейд суудалтай улс төрийн намын гишүүн биш тухайн бүс нутагт оршин суудаг, хууль, боловсролын ажилтан болон мэргэжлийн салбартаа нэр хүндтэй хүмүүсээс сонгон орон нутгийн шүүхийн дарга сонгодог. Улс төрийн намаас санал болгосон буюу сонгуульд ажиглагчаар оролцож буй гишүүд нь сонгууль эхлэх өдрөөс эхлэн санал хураалтын албан ёсны хариу гарсан өдрийн дараагийн өдөр хүртэл ажиллана.

8. Унгар улс

Энэ 2010 онд БНУУ-ын Улсын хурал “Орон нутгийн хурлын төлөөлөгчид ба засаг даргыг сонгох тухай” 1990 оны LXIV (64 дүгээр) хуулиа Европын холбооноос гишүүн орнууддаа гаргасан зөвлөмжийг харгалзан шинэчлэн баталжээ. Ингэснээр 15 бүлэг, 63 зүйл, 5 хавсралт бүхий хуулиа 6 бүлэг, 25 зүйлтэй болгон өөрчилжээ. Орон нутгийн хурлын төлөөлөгчдийн тоог цөөрүүлж, сонгуулийн компанийн хугацааг багасгасан байна. Сонгуулийн кампанийн үргэлжлэх хугацааг 60 хоногоор тогтоожээ.

Нутгийн хурлын төлөөлөгчдийн тоо нь оршин суугчдын тооноос хамаарна. 10 мянга хүртэл оршин суугчидтай хот, тосгон хүн амаасаа хамаарч 2-8 төлөөлөгчийг шууд нэрсээр сонгох бол 10 мянгаас дээш хүн амтай хот, суурин газрууд хүн амынхаа тооноос хамааран тодорхой тооны төлөөлөгчдийг шууд нэрсээр сонгохоос гадна нэр дэвшээд сонгогдоогүй хүмүүсийн авсан саналын тоотой пропорционалиар саналын компенсацийн жагсаалтаар сонгоно. Гэхдээ энэ компенсацийн жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчдийн тоо нь шууд сонгогдсон төлөөлөгчдийн тооны 50 хувиас хэтрэхгүй. Тухайлбал:

А. Мужаас дооших нутаг дэвсгэрийн нэгж

1. 10000 ба түүнээс доош хүн амтай нутаг дэвсгэрийн нэгж сонгуулийн нэг тойрог болох ба уг тойргоос нэрсийн жагсаалтаар санал авч,
 - 100-гаас доош хүн амтай бол 2 төлөөлөгч
 - 1000-аас доош хүн амтай бол 4 төлөөлөгч
 - 5000-аас доош хүн амтай бол 6 төлөөлөгч
 - 10000-аас доош хүн амтай бол 8 төлөөлөгч тус тус сонгоно
2. 10000-аас дээш хүн амтай нутаг дэвсгэрийн нэгж, нийслэлийн дүүргүүдэд холимог системээр сонгууль явуулна. Шууд нэрсийн жагсаалтаар тодорхой тооны нэр дэвшигч сонгогдох ба тэдгээрийн авснаас цаана үлдсэн саналаар компенсацийн жагсаалт бүрдүүлнэ.
 - а. 25000 хүртэл оршин суугчтай бол 8 төлөөлөгч шууд нэрсийн жагсаалтаар, 3 төлөөлөгч компенсацийн жагсаалтаар сонгогдоно.
 - б. 50000 хүртэл оршин суугчтай бол тус тус 10 ба 4 төлөөлөгч
 - в. 75000 хүртэл оршин суугчтай бол тус тус 12 ба 5 төлөөлөгч
 - г. 100000 хүртэл оршин суугчтай бол тус тус 14 ба 6 төлөөлөгч сонгогдоно.
3. 100000-аас дээш оршин суугчтай бол дээш гарсан 10000 хүн тутамд 1 нэр дэвшигч нэрсийн жагсаалтаар, 25000 хүн тутамд 1 хүн компенсацийн жагсаалтаар сонгогдоно.

Б. Нийслэл. Нийслэл Будапешт хотын Ассамблейн гишүүдийг бүх хот нэг тойрог байхаар сонгууль явуулах бөгөөд 50000 оршин суугч тутмаас нэг төлөөлөгч сонгогдож байхаар гишүүдийн тоог тогтооно.

В. Муж. Мужийн хурлын төлөөлөгчдийг сонгохдоо муж нэг тойрог байхаар зохион байгуулна. Төлөөлөгчдийн тоог мужийн оршин суугчдын тоотой харьцуулан тогтооно.

- а. 400000 хүртэл оршин суугчтай бол 20000 оршин суугч бүрт 1 төлөөлөгч, гэхдээ нийтдээ 15-аас доошгүй байх
- б. 700000 хүртэл оршин суугчтай бол 20 төлөөлөгч байна. Гэхдээ 400000-аас дээш гарсан 30000 хүн тутамд 1 төлөөлөгч оногдож байхаар сонгууль явуулна.

Судалгааны эмхтгэл, Х боть

- в. 700000-аас илүү оршин суугчтай бол дээш давсан 40000 хүн тутамд 1 төлөөлөгч оногдож байхаар тооцно.

Нэрсийн ба компенсацийн жагсаалт

Мужаас дооших нутаг дэвсгэрийн нэгжид мажоритараар сонгууль явуулах үед гишүүн сонгох болон засаг дарга сонгох нэр дэвшигчдийн нэг нэг жагсаалт байх бөгөөд нэр дэвшигч зөвхөн аль нэгд нь нэрээ дэвшүүлнэ. Холимог системээр явагдах сонгуульд мужаас дооших нутаг дэвсгэрийн нэгж болон муж, мужийн эрхтэй хот, нийслэлд тус бүрт нь хурлын төлөөлөгчид нэр дэвшигчдийн 1 нэрсийн жагсаалт, 1 компенсацийн жагсаалт байна. Нэр дэвшигчид тухайн сонгуулийн тойрогтоо энэ 2 жагсаалтын аль алинд нь нэрээ дэвшүүлж болно. Хэрэв жагсаалтаар хоёулангаар нь сонгогдсон бол 30 хоногийн дотор сонголтоо хийж аль нэг жагсаалтаас нэрээ хасуулна.

Холимог системээр засаг даргыг сонгох үед нэр дэвшигч мөн хурлын төлөөлөгчийг сонгох нэрсийн ба компенсацийн жагсаалтад аль алинд нь нэрээ дэвшүүлж болно. Нийслэлийн засаг даргад нэр дэвшигч зөвхөн нийслэлийн жагсаалтанд нэрээ дэвшүүлнэ. Нийслэл болон мужид, муж болон мужийн эрхтэй хотод зэрэг нэр дэвшүүлж болохгүй.

Нэр дэвшигч ба нэр дэвшүүлж буй намд тавих шаардлага.

Мажоритараар сонгууль явуулж буй тойрогт нэр дэвшигч тухайн тойргийн сонгогчдын дор хаяж 1%-ийн дэмжлэг авч байж нэр дэвшинэ. Холимог системээр сонгууль явуулах тойрогт нэр дэвшүүлэх нам тухайн тойргийн сонгогчдын дор хаяж 1%-ийн дэмжлэг авсан байх ёстой.

Засаг даргад нэр дэвшигч:

- а. 10000 хүртлэх оршин суугчтай тойрогт сонгогчдын 3%-ийн дэмжлэг авсан,
- б. 10000-аас дээш 100000-аас доош оршин суугчтай тойрогт сонгогчдын 2%, гэхдээ 300-гаас доошгүй сонгогчдын дэмжлэг авсан
- в. 100000-аас дээш оршин суугчтай тойрогт сонгогчдын 1%, гэхдээ 2000-аас доошгүй сонгогчдын дэмжлэг авсан байж нэр дэвшинэ.
- г. Нийслэлийн засаг даргад нэр дэвшигч сонгогчдын 2%-иас доошгүйн дэмжлэг авч байж нэр дэвшинэ.

Нэр дэвшүүлэх намын хувьд:

- а. 10000-аас дээш оршин суугчтай тойрогт улс төрийн нам компенсацийн жагсаалт гаргахын тулд уг нутаг дэвсгэр дэхь мажоритараар сонгох тойргуудын дор хаяж талаас илүүд нь нэр дэвшигчтэй байх ёстой.
- б. Нийслэлийн дүүргүүдийн талаас илүүд нь компенсацийн жагсаалт гаргасан нам нийслэлийн хуралд нэр дэвшүүлэх эрхтэй.
- в. Аль нэг тойрогт нэр дэвшсэн байсан хүн нэрээ татснаар намынх нь нэр дэвшүүлэх эрх хүчингүй болохгүй.

Намууд хамтарсан жагсаалт гаргах

- а. Мажоритараар шууд сонгох тойргуудын талаас илүүд хамтран нэр дэвшүүлсэн намууд хамтарсан компенсацийн жагсаалт гаргаж болно.
- б. Нийслэлийн дүүргүүдийн талаас илүүд нь хамтарсан компенсацийн жагсаалт гаргасан намууд нийслэлийн шууд сонгох тойрогт хамтран нэр дэвшүүлж болно.
- в. Намууд мужийн сонгогчдийн 1% буюу дор хаяж 2000-аас доошгүй сонгогчийн

дэмжлэгийг хамтран авсан бол мужийн шууд сонгох тойрогт хамтран нэр дэвшүүлж болно.

Сонгуулийн систем ба дүн гаргах

1. Засаг дарга сонгох – Засаг даргыг сонгогчид шууд сонгоно. Хамгийн олон санал авсан нэр дэвшигч засаг дарга болно.

2. Шууд сонгох систем

- а. Хүчинтэй саналын хуудсаар хамгийн их санал авсан нэр дэвшигчид сонгогдоно. Саналын тоо тэнцвэл сугалаа явуулна.
- б. Сонгогч сонгуулийн хуудсанд мандатын тоогоор тэмдэглэгээ хийнэ.
- в. Төлөөлөгчөөр сонгогдсон хүн засаг даргаар сонгогдвол түүнийг жагсаалтаас хасч дараагийн хүн нь сонгогдоно.

3. Холимог систем

- а. Хүчинтэй саналын хуудсаар хамгийн их санал авсан нэр дэвшигчид шууд сонгогдоно.
- б. Тойрогт шууд сонгогдсон нэр дэвшигчдийн авсан саналаас гадна үлдсэн саналаас нам бүр өөрийн авсан саналтай пропорционалиар компенсацийн жагсаалтад мандат авна.
- в. Нам шууд санал хураалтаар 5%-иас доош санал авсан бол компенсацийн жагсаалтаар мандат авахгүй.

9. Казахстан улс

Казахстан улсад сонгууль явуулах журам, процедур, үндсэн зарчмуудыг “Бүгд Найрамдах Казахстан улсын сонгуулийн тухай” үндсэн хуулийн эрхтэй хуулиар тогтооно. Уг хуулиар Ерөнхийлөгч, Парламентын доод танхим Мажилисийн депутат, мужуудын хурал – маслихатын депутат, нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүдийг сонгох сонгуулийг бүгдийг нь зохицуулна.

Хуулийн нэгдүгээр бүлэгт сонгуулийн үндсэн зарчмуудыг тодорхойлсон бөгөөд дээр дурдсан бүх сонгууль бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн зарчим дээр нууц санал хураалтаар явагдана. Мөн бүлгийн есдүгээр зүйлд маслихатын депутатаар санал хураалтанд оролцсон сонгогчдоос хамгийн олон санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдоно гэж заасан байна.

Хуулийн хоёрдугаар бүлэгт Сонгуулийн байгууллагуудын талаар заасан. Таван жилийн хугацаатай байгуулагдах сонгуулийн комиссуудын нэгдсэн системийг:

- 1) Улсын сонгуулийн төв комисс
- 2) нутаг дэвсгэрийн сонгуулийн комисс
- 3) тойргийн сонгуулийн комисс
- 4) хэсгийн сонгуулийн комисс бүрдүүлнэ.

Нутаг дэвсгэр, тойрог, хэсгийн сонгуулийн комиссуудыг улс төрийн намуудын саналыг үндэслэн харгалзах маслихатууд сонгон байгуулна. Улс төрийн нам бүр харгалзах сонгуулийн комиссийн бүрэлдэхүүнд нэг нэг хүнийг нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг нэр дэвшигч нь тухайн намын гишүүн байх албагүй. Сонгуулийн комисс байгуулах тухай маслихатаас нэг сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэх бөгөөд энэ хугацаанд аль



Судалгааны эмхтгэл, X боть

нэг намаас санал ирээгүй бол бусад нам, олон нийтийн нэгдлүүдийн санал болон дээд шатны сонгуулийн комиссийн саналаар тухайн шатны сонгуулийн комиссийг байгуулна. Сонгуулийн комиссийн эхний хуралдаанаар комиссийн дарга, орлогч болон нарийн бичгийн даргыг сонгоно.

Хуулийн 20.6 заалтаар сонгуулийн кампанийн үеэр сонгуулийн комиссийн бүрэлдэхүүнд төлөөлөлгүй нам харгалзах комисст өөрийн зөвлөх эрхтэй төлөөлөгчөө ажиллуулж болно. Улс төрийн намын зөвлөх эрхтэй төлөөлөгч сонгуулийн комиссийн хуралдаан дээр үг хэлэх, комиссийн эрх мэдлийн хүрээний асуудлаар санал оруулах, комиссийн үйл ажиллагаа, эс үйлдлийн талаар дээд шатны сонгуулийн комисс, шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Хуулийн 20-1.2 заалтаар улс төрийн нам, бусад олон нийтийн байгууллагуудын сонгуулийн ажиглагчдын эрхийг заасан. Ажиглагчид сонгуулийн комиссийн хуралд байлцах; санал хураалтанд оролцож буй сонгогчдийн тооны талаар мэдээлэл авах; санал хураалтын болон санал тоолох үеэр санал хурааж байгаа байранд байх; зөвөрийн сонгуулийн хайрцагийг дагалдах, авч яваа тээврийн хэрэгсэлд нь сууж явах; санал хураалтын явц, саналын хуудсыг тоолох процедур, сонгуулийн хэсэг дээр саналын дүнг гаргах зэргийг ажиглах; сонгуулийн комиссийн гишүүд ашиглагдаагүй үлдсэн саналын хуудсыг тоолох, хүчингүй болгоход байлцах; санал хураалтанд саад бололгүйгээр фото, аудио, видео бичлэг хийх; санал хураалтын дүнгийн протоколыг дээд шатны сонгуулийн комисст дамжуулах процессийг ажиглах; санал хураалтын дараа сонгуулийн комиссийн санал хураалтын дүнгийн талаархи протоколтой танилцах, уг протоколын баталгаажуулсан хуулбарыг авах зэрэг эрхтэй байна.

Бүх шатны сонгуулийн сурталчилгаа, санхүүжилттэй холбоотой заалтууд адил байна. Сонгуулийн хуулийн 13 дугаар бүлэгт Маслихатын депутатуудыг сонгох талаар заасан. 101, 102 дугаар зүйлүүдэд маслихатын депутатын сонгуулийг зарлах, нэр дэвшигчдэд тавигдах шаардлагын талаар заажээ.

Зүйл 103. Маслихатын депутатад нар дэвшүүлэх

1. Тогтоогдсон журмын дагуу бүртгэгдсэн улсын болон орон нутгийн олон нийтийн нэгдлүүд болон тэдний бүтцийн салбарууд маслихатын депутатад нэр дэвшүүлнэ. Мөн иргэд бие даан нэр дэвшиж болно.
2. Улсын болон орон нутгийн олон нийтийн нэгдлүүд болон тэдний бүтцийн салбарууд маслихатын депутатад нэр дэвшүүлэх үйл ажиллагааг уг нэгдлийн дээд байгууллагаас нэр дэвшигч бүрийн дэвших сонгуулийн тойргийг заан мэдүүлж гүйцэтгэнэ. Олон нийтийн нэгдлүүд өөрийн гишүүн бус хүнийг депутатад нэр дэвшүүлэх эрхгүй. Олон нийтийн нэгдлүүд маслихатын сонгуулийн тойрог бүрт зөвхөн нэг нэр дэвшигчийн нэр дэвшүүлнэ. Маслихатын депутатад нэр дэвшүүлэх шийдвэрийг улсын болон орон нутгийн олон нийтийн нэгдлүүд, тэдний бүтцийн салбаруудын дээд байгууллагын нийт гишүүдийн олонхийн саналаар гаргаж, хуралдааны протоколоор баталгаажуулсан байна.
3. Олон нийтийн нэгдлийн дээд байгууллагын шийдвэрийг 1) нэр дэвшигчид танилцуулна, 2) нэр дэвшигчийн дэвших зөвшөөрөл бүхий өргөдлийн хамт харгалзах тойргийн сонгуулийн комисст хүргүүлнэ.
4. Маслихатын депутатад иргэн бие даан нэр дэвшихдээ харгалзах тойргийн сонгуулийн хороонд маслихатын депутатад нэр дэвших сонирхлоо илэрхийлсэн өргөдөл өгнө.
5. Хэн ч нэгээс илүү сонгуулийн тойрогт нэр дэвшиж болохгүй.
6. Хэрэв сонгууль зарлах үед өөрөөр заагаагүй бол депутатад нэр дэвшүүлэх ажил санал хураалтын өдрөөс хоёр сарын өмнө эхэлж, нэг сарын өмнө дуусна.

7. Хэрэв тухайн сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийг бүртгэж дуусах өдөр хоёроос доош тооны нэр дэвшигч бүртгэгдсэн байвал тойргийн сонгуулийн хорооны өргөн мэдүүлснээр нутаг дэвсгэрийн сонгуулийн хороо нэр дэвшүүлэх хугацааг хориос илүүгүй хоногоор сунгана.
8. Тойргийн сонгуулийн хороо гурав хоногийн хугацаанд нэр дэвшигч Үндсэн хууль болон үндсэн хуулийн эрхтэй энэхүү хуулийн шаардлагыг хангасан эсэхийг тогтооно.

Хуулийн энэ бүлгийн дараах зүйлүүдэд маслихатын сонгууль явуулахтай холбоотой бусад заалтууд орсон байна. Тухайлбал, нэр дэвшигчийг бүртгэх, нэр дэвшигч тойргийн сонгуулийн хорооны дансанд депозит болгон мөнгө байрлуулах, уг мөнгийг буцаах болон буцаахгүй байх нөхцөл, нэр дэвшигч болон эхнэр (нөхөр) хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах журам, олон нийтийн нэгдлээс нэр дэвшигчдийн бүртгүүлэхэд шаардагдах бичиг баримт, тойргийн крмиссоос тавах хяналт, бүртгэхээс татгалзах нөхцлүүд, нэр дэвшигчийг буцаан татах, нөхөн нэр дэвшүүлэх, саналын хуудас тоолох, дахин сонгууль явуулах, сонгуулийн үр дүнг гаргах, мэдээлэх зэргийг нарийвчлан заасан байна. Эдгээр заалтуудад улс төрийн намын үйл ажиллагаа, оролцооны талаар дурдагдаагүй болно.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Сайнбилэг.Д. БНСУ-ын улс төрийн тогтолцоо. УБ., 2008.
- БНСУ-ын төрийн албаны сонгуулийн тухай хууль (хамгийн сүүлийн 2010-11-18-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Орон нутгийн өөртөө засах хууль (хамгийн сүүлд 2011-01-01-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Сонгуулийн менежментын хорооны хууль (2010-11-18-нд нэмэлт өөрчлөлт орсон)
- Сонгуулийн менежментийн хувилбарууд: Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтын гарын авлага, IDEA.

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ:

- <http://www.legislation.govt.nz/>
- www.elections.ca/content
- <http://www.legifrance.gouv.fr/>
- <http://www.cnccfp.fr/>



ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ШУУД ЗАРЧИМ (Мэдээлэл лавлагаа)

Ц. Товуусүрэн, П. Амаржаргал, Ч. Базар, А. Пагма

Дэлхийн зарим улс орнуудын парламентын сонгуулийн зарчим

УИХ -ын Тамгын газрын нарийн бичгийн дарга С. Магнайсүрэнгийн захиалгаар “Дэлхийн зарим улс орны сонгуулийн зарчим” мэдээлэл, лавлагааг Судалгааны төвийн ахлах судлаач Ц. Товуусүрэн (Африк тивийн 10, Ази тивийн 6, Европ тивийн 10 улс), судлаач А.Пагма (Европ тивийн 7 улс), судлаач П. Амаржаргал (Ази тивийн 7 улс), шинжээч Ч. Базар (Америк тивийн 6 улс) нар гаргалаа.

Энэхүү судалгааг хийхэд судалгаанд хамрагдсан улс орнуудын Үндсэн хуульд байгаа заалтад ихэвчлэн суурилсан бөгөөд зарим нэг улс орны хувьд Парламентын тухай болон сонгуулийн тухай хуулиас холбогдох заалтыг авч үзсэн болно. Судалгаанд хамрагдсан 46 улсаас ихэнх нь нэг танхим бүхий парламенттай улс бөгөөд, Парламентын гишүүнийг шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэж Словак, Румын, Беларус, Болгар, Литва, Македони, Тунис, Руанда, Мавритани, Мадагаскар, Конго Бразвили, Камерун, Турк, Гайти зэрэг улсын Үндсэн хуульд заасан байхад, Судалгааны төвийн хийсэн “Сонгуулийн тогтолцооны онол арга зүйн үндэс, зохистой хувилбарыг сонгох зарчим” судалгаанаас харахад, тэдгээрийн дотроос Румын, Болгар, Литва, Руанда, Мавритани, Камерун улс сонгуулийн холимог тогтолцоотой байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудаас Финланд, Латви, Польш, Израйль зэрэг улс Үндсэн хууль (Израйль Кнессетийн тухай хууль)-даа Сонгуулийн зарчмаа **шууд** гэж заагаад, сонгуулийн хэлбэрээ **пропорциональ** гэдгийг ч давхар зааж өгсөн байна. Судалгаанд хамрагдсан 46 улсаас Итали, Латви, Израйль гэсэн гурван улс л парламентыг сонгох гэсэн хэллэгийг ашигласан байна. Ер нь аль ч улс оронд сонгуулийн зарчим нь бүх нийтийн, чөлөөтэй, тэгш, шууд, нууц гэсэн байх бөгөөд зарим улсад эдгээр зарчмын аль нэг нь байхгүй, эсвэл заавал санал өгөх зарчмыг нэмж тусгадаг байна. Сонгуулийн талаарх онолын үүднээс авч үзвэл, шууд сонгох эрх нь **сонгогч ямар нэг төлөөллөөр дамжуулахгүйгээр өөрөө саналаа өгөх** гэж ойлгодог байна.

I. Европ тив.

1. Дани

Section 31 [Elections]

- (1) The Members of the Parliament shall be elected by general and direct ballot.
 - Парламентын гишүүдийг бүх нийтийн, шууд санал хураалтаар сонгоно.

2. Финланд

Section 25 Parliamentary elections

- (1) The Representatives shall be elected by a direct, proportional and secret vote. Төлөөлөгчдийг шууд, пропорциональ, нууц санал хураалтаар сонгоно.

3. Грек

Article 51 [Deputies, Right to Vote]

- (3) The deputies shall be elected by direct, universal, and secret ballot and by citizens having the right to vote as the law provides.

Депутатуудыг шууд, бүх нийтийн нууц санал хураалтаар сонгох ба иргэд хуульд заасны дагуу саналаа өгөх эрхтэй

4. Исланд

Article 31

(1) The House of Representatives [Althingi] is composed of 63 members elected by the people by secret ballot on the basis of proportional representation for a term of four years.

Төлөөлөгчдийн танхим бүх ард түмнээс шууд, нууц санал хураалтаар, пропорциональ төлөөллийн үндсэн дээр, 4 жилийн хугацаагаар сонгогддог 63 гишүүнтэй.

5. Люксембург

Article 51 [Parliamentary Democracy, Election, Referendum]

(4) The election is direct.

(5) Deputies are elected by straightforward universal suffrage on the party-list system, in accordance with the rules of proportional representation...

4/ сонгууль шууд байна.

5/ Депутатуудыг бүх нийтийн санал хураалтаар, намын нэрсийн жагсаалтаар, пропорциональ төлөөллийн дагуу ... сонгоно

6. Словени

Article 80 (Composition and Election)

(2) Deputies are elected by universal, equal, direct and secret voting.

Депутатуудыг бүх нийтийн, тэгш, шууд, нууц санал хураалтаар сонгоно.

7. Словак

Article 74

(1) Deputies are elected by secret ballot in general, equal, and direct elections

Депутатуудыг бүх нийтийн, тэгш, шуудсонгох эрхийн үндсэн дээр, нууц санал хураалтаар сонгоно.

8. Швед

Парламентын тухай акт 7 дугаар бүлэг

Article 4

(1) Elections shall be held by secret ballot unless otherwise prescribed in Article 3 or in any other main provision of the Parliament Act...

Парламентын тухай хуулийн аль ч зүйл болон энэ хуулийн 3 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол сонгуулийг нууц санал хураалтаар явуулна...

9. Румын

Article 59 [Election, National Minorities]

(1) The Chamber of Deputies and the Senate are elected by universal, equal, direct, secret, and free suffrage, in accordance with the electoral law.

Депутатуудын танхим, Сенатыг сонгуулийн хуульд заасны дагуу бүх нийтийн, тэгш, шууд, чөлөөт сонгуулийн эрхийн үндсэн дээр сонгоно.

10. Герман



Article 38 [Elections]

(1) The deputies to the German House of Representatives [Bundestag] are elected in general, direct, free, equal, and secret elections.

Германы төлөөлөгчдийн танхим/Бундестаг/-ын депутатуудыг бүх нийтийн, шууд, чөлөөт, тэгш, болон нууц сонгуулиар сонгоно

11. Беларусь

Статья 91. Состав Палаты представителей - 110 депутатов. Избрание депутатов Палаты представителей осуществляется в соответствии с законом на основе всеобщего, свободного, равного, прямого избирательного права при тайном голосовании.

- 91 дүгээр зүйл. Төлөөлөгчдийн танхим 110 депутатаас бүрдэнэ. Төлөөлөгчдийн танхимын депутатуудыг сонгох сонгууль хуулийн дагуу бүх нийтийн, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар явагдана.

12. Болгар

Ст.10. Выборы, национальные и местные референдумы производятся на основе всеобщего, равного и прямого избирательного права при тайном голосовании.

- 10 дугаар зүйл. Сонгууль, үндсэний болон орон нутгийн бүх нийтийн санал асуулга нь бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар явагдана.

13. Итали

Статья 56 (10). Палата депутатов избирается всеобщим и прямым голосованием.

- 56 дугаар зүйл (10). Төлөөлөгчдийн танхим бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно.

14. Латви

6. Сейм избирается всеобщим, равным, прямым, тайным и пропорциональным голосованием.

- 6 дугаар зүйл. Сейм бүх нийтийн, чөлөөтэй, тэгш, шууд, нууц, пропорциональ саналын үндсэн дээр сонгогдоно.

15. Литва

Статья 55. Сейм состоит из представителей Народа - 141 члена Сейма, избираемых сроком на четыре года на основе всеобщего, равного, прямого избирательного права, путем тайного голосования.

- 55 дугаар зүйл. Сейм бүх нийтийн, чөлөөт, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгосон ард түмний 141 төлөөлөгчөөс бүрдэнэ.

16. Македони

Статья 62. Собрание состоит из 120 - 140 депутатов. Депутаты избираются на всеобщих, прямых и свободных выборах путем тайного голосования.

- 62 дугаар зүйл. Хурал 120-140 депутатаас бүрдэнэ. Депутатуудыг бүх нийтийн, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар сонгоно.

17. Польш

Ст.96.

1. Сейм состоит из 460 депутатов.
2. Выборы в Сейм являются всеобщими, равными, непосредственными и пропорциональными и проводятся тайным голосованием.
96 дугаар зүйл.
 1. Сейм 460 депутаттай байна.
 2. Сеймын сонгууль бүх нийтийн, тэгш, шууд, пропорциональ байх ба нууцаар саналаа өгөх замаар явагдана.

II. Африк тив

18. Намиби

Article 46 [Composition]

(1) The composition of the National Assembly shall be as follows:

a) seventy-two (72) members to be elected by the registered voters by general, direct and secret ballot.

- 1) Үндэсний ассамблей дараах бүрэлдэхүүнтэй байна:
a/ 72 гишүүнийг нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчид бүх нийтийн, шууд, нууц санал хураалтаар сонгоно.

19. Тунис

Article 19 [Election]

The members of the National Parliament are elected by universal, free, direct, and secret suffrage, according to the modalities and conditions determined by the Electoral Law.

- Үндэсний парламентын гишүүдийг бүх нийтийн, чөлөөт, шууд, нууц сонгох эрхийн үндсэн дээр сонгуулийн хуульд заасан нөхцөл, журмын дагуу сонгоно.

20. Замби

Article 63 [Composition of, and Election to, National Assembly]

(2) Subject to the provisions of this Constitution, the election of members of the National Assembly shall be direct, by universal adult suffrage and by secret ballot and shall be conducted in accordance with the provisions of this Constitution and as may be prescribed by or under an Act of Parliament.

- Үндсэн хуулийн заалт ёсоор Үндэсний ассамблейн гишүүдийн шууд сонгуулийг Үндсэн хууль, парламентаас баталсан хуулийн дагуу насанд хүрэгчдийн бүх нийтийн нууц санал хураалт явуулж сонгоно.

21. Руанда

Article 58 [Election]

(1) The National Assembly shall be composed of members designated as 'Deputies to the National Assembly.' Deputies shall be elected for a five year mandate by universal and direct suffrage.

- Үндэсний ассамблей, Үндэсний ассамблейн гишүүдээс бүрдэх бөгөөд депутатуудыг 5 жилийн мандатын эрхтэйгээр бүх нийтийн шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгоно.



22. Мавритани**Article 47 [Term, Eligibility]**

(1) The Deputies to the National Assembly are elected for five years by direct suffrage.

- Үндэсний ассамблейн пепутатуудыг 5 жилийн хугацаагаар шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгоно.

23. Мадагаскар**Article 66 [Title, Election, Term]**

(1) The members of the National Assembly shall have the title of Deputies of Madagascar.

(2) They shall be elected by direct universal suffrage for four-year terms.

- 1/ Үндэсний ассамблейн гишүүдийг Мадагаскарын депутат гэж нэрлэнэ.
- 2/ Тэдгээрийг бүх нийтийн шууд сонгох эрхийн үндсэн дээр 4 жилийн хугацаагаар сонгоно.

24. Этиопи**Article 54 Members of the House of Peoples' Representatives**

(1) Members of the House of Peoples' Representatives shall be elected by the People for a term of five years on the basis of universal suffrage and by direct, free and fair elections held by secret ballot.

- Ардын төлөөлөгчдийн танхимын гишүүдийг ард түмнээс 5 жилийн хугацаагаар, бүх нийтийн сонгуулийн эрхийн хүрээнд шууд, чөлөөт, шударга сонгуулийн санал хураалтаар сонгоно.

25. Эритрей**Article 31 Establishment and Duration of the National Assembly**

(2) The National Assembly shall be composed of representatives elected by the people.

(3) Members of the National Assembly shall be elected by direct and secret ballot by all citizens who are qualified to vote.

- 2/ Үндэсний ассамблей ард түмнээс сонгогдсон гишүүдээс бүрдэнэ
- 3/ Үндэсний ассамблейн гишүүдийг сонгуулийн эрх бүхий бүх иргэдээс шууд нууц санал хураалтаар сонгоно.

26. Конго Бразвилли**Article 93 [Houses, Election, Eligibility]**

(2) The Deputies of the National Assembly shall be elected by direct universal suffrage.

- Үндэсний ассамблейн гишүүдийг шууд, бүх нийтээр сонгох эрхийн үндсэн дээр сонгоно

27. Камерун

Article 12. The National Assembly shall have a term of five years. It shall be composed of one hundred and fifty members whose election shall be by direct universal suffrage and secret ballot.

- Зүйл 12. Үндэсний ассамблейн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. 150 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг шууд, бүх нийтээр сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгоно.

III. Ази тив.

28. Камбож

Article 76 [Election]

(1) The Assembly consists of at least 120 members.

(2) The deputies are elected by free, universal, equal, direct and secret ballot.

- 1/ Ассамблей 120 гишүүнээс бүрдэнэ.
- 2/ Депутатуудыг чөлөөт, бүх нийтийн тэгш, шууд, нууц санал хураалтаар сонгоно.

29. Иран

Article 62 [Election]

(1) The Islamic Consultative Assembly is constituted by the representatives of the people elected directly and by secret ballot.

- 1/ Исламын зөвлөх ассамблей ард түмнээс шууд, нууц санал хурааж сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.

30. Израйль

Кнессетийн тухай суурь хууль Section 4 Electoral system

The Knesset shall be elected by general, national, direct, equal, secret and proportional elections, in accordance with the Knesset Elections Law; this section shall not be varied save by a majority of the members of the Knesset.

- Кнессетийг үндэсний бүх нийтийн, шууд, тэгш, нууц, пропорциональ сонгуулиар энэ бүлэгт заасны дагуу Кнессетийн олонхийн саналаар баталсан Кнессетийн сонгуулийн тухай хуулийн дагуу сонгоно.

31. Кувейт

Article 80 [Election, Ministerial Members]

(1) The National Assembly is composed of fifty members elected directly by universal suffrage and secret ballot in accordance with the provisions prescribed by the electoral law.


- Үндэсний ассамблей, сонгуулийн хуульд заасны дагуу бүх нийтийн шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгогдсон 50 гишүүнтэй байна.

32. Катар

Article 77

Al-Shoura Council shall consist of forty-five Members thirty of whom shall be elected by direct, general secret ballot; and the Emir shall appoint the remaining fifteen Members from amongst the Ministers or any other persons.

- Аль-Шура зөвлөл 45 гишүүнээс бүрдэх бөгөөд 30 нь бүх нийтийн, шууд, нууц санал хураалтаар сонгогдах ба 15-ыг нь Эмир сайдууд болон бусад хүмүүсээс томилно.



33. Турк**Article 75 Composition**

The Turkish Grand National Assembly shall be composed of five hundred and fifty deputies elected by universal suffrage.

- Туркийн Үндэсний Их Хурал бүх нийтийн сонгуулийн эрхийн үндсэн дээр сонгогддог 550 депутатаас бүрдэнэ.

34. Лаос

Article 54.

(New) The term of office of each National Assembly legislature is five years. Members of the National Assembly are elected by the Lao citizens in accordance with the laws.

- 54 дүгээр зүйл. Үндэсний Хурлын бүрэн эрхийн хугацаа таван жил байна. Үндэсний хурлын гишүүд хуульд заасны дагуу Лаосын иргэдээс сонгогдоно.

Эх сурвалж: <http://www.lexadin.nl/wlg/legis/nofr/oeur/lxwelao.htm>

35. БНСУ**Article 41 [Election]**

(1) The National Assembly shall be composed of members elected by universal, equal, direct, and secret ballot by the citizens.

- 41 дүгээр зүйл. Үндэсний хурлын гишүүдээс бүрдэх бөгөөд бүх нийтийн, тэгш, шууд, нууц санал хураалтаар иргэд сонгоно.

Эх сурвалж: <http://www.lexadin.nl/wlg/legis/nofr/oeur/lxwekor.htm>

36. Бирм /Мьянмар/

Article 42. The Pyithu Hluttaw shall be formed with People's representatives elected directly by secret ballot by citizens who have the right to vote under this Constitution and other electoral laws.

- 42 дугаар зүйл. Парламент нь (The Pyithu Hluttaw) ард түмний төлөөлөлөөс бүрдэх бөгөөд шууд, нууц санал хураалтаар Үндсэн хууль болон сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн эрх бүхий иргэд сонгоно.

Эх сурвалж: <http://www.thailawforum.com/database1/constmyanmar.html>

37. Казахстан

Article 50. The Parliament shall consist of two Chambers acting on a permanent basis: the Senate and the Majilis.

3. The Majilis shall consist of hundred seven deputies elected in an order, established by the constitutional law.

- 50 дугаар зүйл. Парламент нь Сенат ба Мажилис гэж нэрлэх хоёр танхимаас бүрдэнэ.
- 3. Төлөөлөгчдийн танхим /The Majilis/ зуун далан төлөөлөгчөөс бүрдэх бөгөөд тэдгээр нь Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан дүрмийн дагуу сонгогдоно.

Эх сурвалж: <http://www.constcouncil.kz/eng/norpb/constnk/>

38. Непал /Балбын Вант Улс.

Article 44. Constitution of Legislature. There shall be a Legislature, to be called Parliament, which shall consist of His Majesty and two Houses, namely the House of Repre-

sentatives and the National Assembly.

- 44 дүгээр зүйл. ...Парламент нь хоёр танхимаас бүрдэх бөгөөд Төлөөлөгчдийн танхим болон Үндэсний Хурал байна.

45.(5) Subject to the provisions of this Constitution, election to membership in the House of Representatives shall be held on the basis of one man-one vote through secret ballots in accordance with the provisions of law

- 45 дугаар зүйл. Төлөөлөгчдийн танхимын гишүүний сонгуулийг нэг хүн, нэг саналын эрхтэйгээр хуульд заасны дагуу нууц санал хураалтаар явуулна.

Эх сурвалж: <http://www.asianlii.org/np/legis/const/1990/index.html>

39. Туркменистан

Article 60: the Parliament consists of 125 deputies, elected from geographical constituencies with approximately equal number of voters, for five years.

- 60 дугаар зүйл. Парламент нь 125 төлөөлөгчөөс бүрдэх бөгөөд, тэдгээрийг газар зүйн байрлалаар тогтоосон тойргоос тэгш тоотой (сонгуулийн тэгш зарчим) сонгогчоос таван жилийн хугацаатай сонгоно.

Эх сурвалж:

<http://www.legislationline.org/documents/section/constitutions/country/51>

40. Япон

Article 42. The Diet shall consist of two Houses, namely the House of Representatives and the House of Councillors.

Article 47. Electoral districts, method of voting and other matters pertaining to the method of election of members of both Houses shall be fixed by law.

- 42 дугаар зүйл. Парламент нь хоёр танхимаас бүрдэх бөгөөд Төлөөлөгчдийн танхим болон Зөвлөхүүдийн танхим гэж нэрлэнэ.
- 47 дугаар зүйл. Сонгуулийн тойрог, санал хураах аргачлал, хоёр танхимын гишүүдийн сонгуульд холбогдох бусад асуудлыг хуулиар тогтооно.

Эх сурвалж: <http://www.sangiin.go.jp/eng/law/tcoj/index.htm>

IV. Америк тив.

41. Гайти.

ARTICLE 89:

The House of Deputies is a body composed of members elected by direct suffrage by the citizens and is responsible for exercising, on their behalf and in concert with the Senate, the functions of the legislative branch.

- Зүйл 89: Төлөөлөгчдийн Танхимын гишүүд нь санал өгөх эрх бүхий иргэдээс **шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогддог** ба тэд иргэдийн нэрийн өмнөөс хариуцлага хүлээдэг, Сенаттай зөвшилцөн ажиллах, хууль тогтоох эрх бүхий этгээд юм.

42. Гренада

Article 32.-(1) Each of the constituencies into which Grenada is divided in accordance with the provisions of section 56 of this Constitution shall return one member to the House of Representatives who shall be directly elected in such manner as may, subject to the provisions of this Constitution, be prescribed by or under any law.



- Зүйл 32. Үндсэн хуулийн 56-р зүйлд заасны дагуу Гренада нь сонгуулийн тойргуудад хуваагдах бөгөөд нэг тойргоос нэг Төлөөлөгчдийн танхимын гишүүнийг тухайн тойргийн иргэд **шууд сонгох** бөгөөд түүний бүрэн эрхийг Үндсэн хууль болон бусад хуульд заасны дагуу ёсчлоно.

43. Коста-Рика

Article 93. Suffrage is a primary and compulsory civic function and is exercised before Election Boards through direct and secret vote by the citizens registered in the Civil Registry.

- Зүйл 93: Санал өгөх нь иргэн бүрийн үндсэн чухал, заавал биелүүлэх үүрэг бөгөөд Иргэний бүртгэлд бүртгэгдсэн иргэд нь шууд, нууцаар саналаа өгөх эрхтэй.

44. Сент Луис

33.- Elections

(1) Each of the constituencies established in accordance with the provision of section 58 of this Constitution shall return one member to the House who shall be directly elected in such manner as may, subject to the provisions of this Constitution, be prescribed by or under any law.

- Зүйл 33.1. Үндсэн хуулийн 58-р зүйлд заасны дагуу сонгуулийн тойргууд байгуулагдах бөгөөд нэг тойргоос нэг Төлөөлөгчдийн танхимын гишүүнийг тухайн тойргийн иргэд **шууд сонгох** бөгөөд түүний бүрэн эрхийг Үндсэн хууль болон бусад хуульд заасны дагуу ёсчлоно.

45. Урагвай

Chapter II ,Article 77.

Suffrage shall be exercised in the manner determined by law, but on the following bases:

2)Secret and compulsory vote.

Chapter III

Article 94.

The Chamber of Senators shall be composed of thirty members, elected directly by the people, in a single electoral district, pursuant to the guaranties and rules concerning suffrage contained in Section III and as stated in subsequent articles.

- Бүлэг 2, Зүйл 77: Санал өгөх эрх нь хуульд заасны дагуу доорхи зүйлд үндэслэнэ.
- 2/ Нууцаар, заавал (сайн дурын үндсэн дээр бус) саналаа өгнө.
- Бүлэг 3, Зүйл 94: Сенатын танхим нь 30 гишүүнтэй байх бөгөөд хуулийн 3-р хэсэгт заасан сонгуулийн эрх бүхий хүмүүс сонгуулийн нэг дүүргээс (тойргоос) нэг гишүүнийг шууд сонгоно.

46. Чили

Article 43: The Chamber of Deputies is composed of 120 members elected by direct ballot of the electoral districts established by the respective constitutional organic law.

- Зүйл 33: Төлөөлөгчдийн Танхим нь 120 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг Үндсэн хуулийн чанартай органик хуулиар байгуулсан сонгуулийн тойргоос (дүүргээс) шууд, нууц санал хурааж сонгоно.

Ашигласан эх сурвалж:

1. Дэлхийн улс орнуудын парламент (Судлаачдын баг)
2. www.servat.unibe.
3. www.lexadin.nl
4. Зарим улс орны Парламентын сайт



ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОЁР ТАНХИМТАЙ ПАРЛАМЕНТЫН ТАЛААРХИ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Ц. Товуусүрэн, Р. Хатанбаатар, Б. Буяндэлгэр, П. Амаржаргал,
Б. Ариунжаргал, Ц. Болормаа, Г. Билгээ, Г. Гэрэл,
О. Нарантуяа, А. Пагма*

УДИРТГАЛ

Сүүлийн үед парламентын шинэчлэлийн асуудлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд, МАН-ын дарга Сү.Батболд 2 танхимтай парламентын асуудлыг хөндөн ярьж, улс төрчид болон олон нийтийн дунд тодорхой мэтгэлцээн, санал шүүмжлэл өрнөж байна. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв энэ асуудалд анхаарал хандуулан өөрийн чиг үүрэгт заасны дагуу дэлхийн 56 улсын 2 танхимтай парламент, тэдгээрийг бүрдүүлж байгаа хэлбэр, танхим тус бүрийн бүрэн эрх, харилцан хамаарал, хууль хэлэлцэн баталж буй процедур зэргийг харьцуулан судалж “Гадаадын зарим орны хоёр танхимтай парламентын талаархи судалгаа” сэдэвт судалгааны тайланг хүргүүлж байна.

2010 онд тус Төв нь дэлхийн 193 орны төрийн байгуулал, парламентын тогтолцооны талаар дэлгэрэнгүй судалгаа хийж “Дэлхийн улс орнуудын парламент” номыг хэвлүүлэн гаргасан.

Энэхүү судалгааны ажил нь бусад орнуудын төрийн байгууллын тогтолцоог харьцуулсан байдлаар харуулсан мэдээлэл лавлагааны шинжтэй бөгөөд судалгааны тайлангийн нэгдсэн хүснэгтүүдээс парламентын Дээд танхим байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцооны талаархи мэдээллийг авч, дүгнэлт гаргах боломжтой.

Судалгааны зорилго:

Хоёр танхим бүхий парламенттай орнуудын парламентын эрх зүйн зохицуулалт, дээд болон доод танхим байгуулагдах хэлбэр, танхим хоорондын харилцаа, сонгогдох болон томилогдох хэлбэр, хууль тогтоох үйл ажиллагааны процедур, тухайн орны засаглалын болон парламентын тогтолцооны онцлог зэргийг харьцуулан судалж нэгдсэн мэдээлэл бэлтгэх, дүгнэлт гаргах боломж олгоход оршино.

Судалгааны зорилтууд:

- Гадаадын зарим орны парламент байгуулагдах хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Хоёр танхим бүхий парламенттай улс орнуудын парламентын дээд танхимуудын бүрэн эрх, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Дээрх орнуудын парламентын хууль тогтоох журам, түүний онцлогийг харьцуулан судлах

Судалгааны аргачлал:

- Судалгаанд хамрагдсан гадаадын зарим орнуудын Үндсэн хуулийн холбогдох бүлэг заалт,
- Гадаадын зарим орны парламентын тухай хууль, эрх зүйн зохицуулалтыг харьцуулах
- Судалгааны материалыг харьцуулан нэгтгэн дүгнэх

Хамрах хүрээ:

Судалгаанд дээр дурдсан нийт 5 тивийн 56 орон хамрагдсан.

1. Австрали, зарим далайн орнуудын парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт, нийт 3 улс,
2. Ази тивийн нийт 16 улсын парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт,
3. Африк тивийн нийт 12 орны парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт,
4. Америк тивийн нийт 10 орны парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт,
5. Европ тивийн нийт 15 улсын парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт,

Судалгааны үе шат:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийх
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийх
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичих

Судалгааны ажлыг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн ахлах референт Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар нар ахалж, Р.Хатанбаатар Парламентын бүтэц, зохион байгуулалтын зарим асуудал, Австрали, далайн орнууд; Ц.Товуусүрэн Африк тивийн долоон орон, дэлхийн зарим улс орнуудын парламентын дээд танхим байгуулагдах хэлбэр, холбогдох хүснэгтүүд; ахлах референт Б.Буяндэлгэр Беларус, Польш, ОХУ, Словени, Чех; судлаачид А.Пагма Франц, Швейцари, ИБУИНВУ, Итали, Ирланд; Г.Билгээ Австри, Бельги, Герман, Румын, Испани; Г.Гэрэл Афганистан, Бахрейн, Казахстан, Пакистан; П.Амаржаргал Япон, Тайланд, Камбож, Филлипин; Б.Хатантуул АНУ, Аргентин, Боливи, Бразил, Канад, Д.Мягмарцэрэн Парагвай, Урагвай, Чили, Мексик, Колумби, Б.Ариунжаргал Йордан, Йемен, Оман, Узбекистан; О.Нарантуяа Бутан, Малайз, Энэтхэг, Тажикстан; Ц.Болормаа Нигерия, ӨАБНУ, Сенегал, Тунис, Этиопи улсын парламентын талаархи хэсгийг тус тус гүйцэтгэв.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ:

- Парламентын дээд танхимыг шууд, шууд бус сонгууль болон томилгоо хосолсон хэлбэрээр судалгаанд хамрагдсан Ази тивийн 16 улсаас 8 нь, Африк тивийн 12 улсаас 7 нь, Европ тивийн 15 улсаас 3 нь, бүгд 18 улс байгуулдаг бол Америк тивийн 10 улсаас энэ хэлбэрийг хэрэглэдэг улс алга байна.
- Парламентын дээд танхимыг зөвхөн томилгоогоор байгуулдаг улс судалгаанд хамрагдсан 56 улсаас 10 улс байгаагийн дотор олонхи нь хаант засагтай улс байгаа бөгөөд Эзэн хаан нь энэ томилгоог хийдэг байна. Парламентын дээд танхимын гишүүдийг муж улсуудын Засгийн газар нь томилдог Герман, Ерөнхийлөгч нь томилдог Йемен Улс байна.
- Харин Америк тивийн судалгаанд хамрагдсан 10 орноос Канадаас бусад нь парламентын дээд танхимаа шууд сонгуулиар байгуулдаг байна. Шууд сонгуулиар парламентын дээд танхимыг байгуулдаг хэлбэрийг Азиас Япон, Филиппин, далайн орнуудаас Австрали, Палау, Африк тивээс Нигерия, Европоос Итали, Польш, Румын, Чех Швейцарит хэрэглэж байна Судалгаанд хамрагдсан 56 улсаас 18 нь энэ хэлбэрийг хэрэглэдэг байна.
- Парламентын дээд танхимыг судалгаанд хамрагдсан Африк тивийн 12 орноос 4 нь, Европ тивийн 15 орноос 3 нь зөвхөн шууд бус сонгуулиар байгуулдаг байна.

Үүнээс гадна Америк тивд олонх улс орнуудад парламентын дээд танхимыг шууд сонгуулиар байгуулсан байхад Европ тивийн улс орнууд дээр дурдсан хэлбэрүүдийн аль, алинаар нь

Судалгааны эмхтгэл, Х боть

парламентынхаа дээд танхимыг байгуулж байгаа дүр зураг харагдаж байна. Энэ хоёр тив бол парламентат ёсны хөгжлийн олон жилийн түүхтэй тивүүд юм. Ази, Африк тивд шинэ тутам парламентат ёс төлөвшиж эхлэхдээ шууд бус сонгууль, томилгооны хосолсон хэлбэрээр парламентын дээд танхимаа байгуулах хандлага давамгайлж байна.

Судалгаанаас үзэхэд, 2 танхимтай парламентын тогтолцоог сонгон авахад тухайн орны төрийн эрх мэдлийг зохицуулж ирсэн уламжлал, холбооны болон нэгдмэл улсын тогтолцооны онцлог, эдийн засгийн хөгжлийн түвшин, хүн амын тоо, бүс нутгийн болон орон нутгийн удирдлагын тогтолцоо, үндэстэн ястан, шашин омгууд, бүс нутаг, нийгмийн анги давхаргуудын төлөөлөл, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал хоорондын эрх мэдлийн хуваарилалт, хяналтын тогтолцоо зэрэг олон хүчин зүйлүүдийг харгалзан үзэх шаардлагатай нь харагдаж байна.

Дээд танхимыг бүрдүүлсэн хэлбэрээс үзэхэд, Хаант засаглалтай болон язгууртны “уламжлалт” хэв шинжийг хадгалж бүрдүүлсэн, улс төрийн намуудаас бүрдүүлсэн, ардчиллын зарчмаар нийгмийн бүлэг, давхаргуудын төлөөллийг оролцуулж бүрдүүлсэн, хууль тогтоох байгууллагын дархлааг бий болгох үүднээс сонгон шалгаруулалтын зарчмаар туршлагатай улс төрчид, эрдэмтдээс бүрдүүлсэн гэх мэтийн дүр зураг харагдаж байна.

Дээд танхимын бүрэн эрхийн тухайд, зарим орнуудад Дээд танхим нь хууль тогтоох ажиллагаанд Доод танхимтай зэрэгцээ байдлаар оролцдог, зарим оронд зөвхөн тодорхой асуудлуудыг хянан хэлэлцдэг заагтай, зарим оронд доод танхимдаа зөвлөх үүрэгтэй гэх мэтийн хэлбэрүүд байна.

Дээд танхимд сонгогдох, томилогдох хэлбэрийн тухайд, Дээд танхимыг шууд сонгуулиар сонгох, шууд бус сонгуулиар тодорхой субьектээс сонгох, Үндсэн хуулинд заасны дагуу Эзэн хаан эсвэл Ерөнхийлөгчөөс, эсвэл муж улсын эрх бүхий байгууллагаас томилох зэрэг хэлбэрүүд байна. Үүнээс үзэхэд Дээд танхимыг шууд болон шууд бус сонгууль, томилгооны хэлбэрээр болон тэдгээрийн хосолсон хэлбэрээр бүрдүүлдэг байна. Тухайлбал, Сенатын нийт гишүүдийн тодорхой хэсгийг томилгоогоор, тодорхой хэсгийг шууд болон шууд бус сонгуулиар бүрдүүлдэг гэсэн үг. Доод танхимд ихэвчлэн бүс нутгийн хүн амын тоонд пропорционалиар тогтоосон тодорхой тооны гишүүдийг бүх нийтийн шууд сонгуулиар сонгодог байна.

Судалгаанаас үзэхэд, Холбооны улсууд ихэвчлэн 2 танхимтай парламенттай байх ба хууль тогтоох, засаглалын үйл ажиллагаанд оролцох оролцоо, эрх мэдэл нь хүчтэй, сулавтар, сул байдаг байна. 2 танхимын эрх мэдэл, үүргийн хуваарилалт нь улс орон бүрт харилцан адилгүй.

Нэгдмэл улсуудын хувьд ихэвчлэн 1 танхимтай парламенттай байх боловч 2 танхимтай парламенттай орнууд цөөнгүй байна. Тэдгээрийн хувьд Дээд танхимдаа нийгмийн янз бүрийн бүлэглэлүүдийн төлөөллийг оролцуулах, Доод танхимынхаа хууль тогтоох үйл ажиллагааг хянах, зөвлөх эрхтэй байдаг байна. Дээд танхимдаа Мужийн сонгогдсон зөвлөл, эмэгтэйчүүд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг сонгох болон томилох хэлбэрээр оруулдаг улсууд ч байна. 1 танхимтай парламент нь гол төлөв төвлөрсөн буюу унитар тогтолцоотой, үндэстний цөөнх багатай, хүн ам цөөтэй орнуудад байдаг.

2 танхимтай парламентын:

Давуу тал нь

- Хүн амын этникийн онцлог, бүс нутаг, нийгмийн давхарга, овог аймгийн ялгарал ихтэй улс орнуудад тохиромжтой байж болох юм. Нөгөө талаас парламентад чадварлаг парламентчид, нийгмийн анги бүлгүүдийн

төлөөллийг оруулах, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих механизмыг сайжруулах талтай.

Сул тал нь

- Хууль тогтоомжийг шуурхай батлан гаргах процесс удаашралтай, олон шат дамжлагатай, хэлэлцүүлгийн хугацаа сунжрах, нэгдсэн шийдэлд хүрэхэд төвөгтэй
- Хууль тогтоох үйл ажиллагааны эцсийн хариуцлага хүлээх субъект тодорхой биш
- Парламент болон Ажлын аппаратын зардал их

Парламентын тогтолцооны хэлбэр, танхимын тооны асуудал нь Үндсэн хууль, төрийн байгуулалын хэлбэрт хамаарах асуудал учраас Монгол улсын парламентын төлөвшил, эрх зүйн систем, эдийн засаг, нийгмийн үр дагаварыг сайтар судлах шаардлагатай. Бусад орнуудын туршлагаас үзэхэд харьцангуй олон янзын тогтолцоо, эрх зүйн систем үйлчилж байна. Шууд хуулбарлах буюу тэр нь зөв, энэ нь сайн гэх тодорхой зүй тогтол, хувилбарыг одоогоор хэлэх боломжгүй байна. Судалгааны төвийн судлаач, шинжээчид 1 танхимтай Парламентын асуудлаар судалгаа хийхээр төлөвлөж байна.

Жич: Судалгаанд хамрагдсан 56 улсаас зөвхөн Тайланд л парламентын дээд танхимаа Шууд ба шууд бус сонгуулийн аль алиныг хослуулан хэрэглэж байгуулдаг юм байна.

Парламентын бүтэц, зохион байгуулалтын зарим асуудал

Үндсэн хуулийн эрх зүйд парламент хэдэн танхимтай (chambers) байх вэ гэдэг нь маргаантай асуудал юм. Хууль тогтоох хоёр танхимтай (two legislative chambers) байх нь анх Их Британи ба Европын орнуудын хаант засаглалын системд аристократууд болон жирийн иргэдийн төлөөллийг, АНУ-д штатуудын төлөөллийг тус тус хууль тогтоох үйл ажиллагаанд оролцуулах шаардлагаас үүссэн байдаг. Нэгдмэл танхимын систем (unicameral system) буюу хууль тогтоох нэг танхимтай (one legislative chamber) байх нь авторитар орнуудад голлон байдаг гэсэн үзэл байсаар ирсэн. Орчин үед ингэж үзэх нь буруу боловч шинэ ардчилсан улсууд, ялангуяа том улсуудын хувьд ерөнхийдөө хоёр танхимын системд шилжих хандлагатай болж байна. Гэхдээ түүх, соёл, улс төрийн нөхцөл байдлаасаа шалтгаалан тухайн улс хэдэн танхимтай парламенттай байхаа шийдэх нь зүйн хэрэг.

Хоёр танхимтай парламент

Хоёр танхимтай хууль тогтоох байгууллага (a bicameral legislature) нь гол төлөв дээд ба доод танхим гэж нэрлэгдэх хоёр танхимаас бүрдэнэ. Доод танхим нь ихэвчлэн бүс нутаг бүрийн хүн амын тоонд пропорционалиар тогтоогдсон тооны гишүүдээс бүрдэнэ. Дээд танхимыг бүрдүүлэхдээ үе залгамжлах, янз бүрийн байгууллага, эрх мэдэл бүхий хүмүүсийн зүгээс томилох, шууд ба шууд бус сонгуулиар сонгох гэх мэт бүрдүүлэх олон арга хэлбэр ашиглана.

Дээд танхим нь улс төрийн намуудын төлөөлөл хэлбэрээр бас байгуулагдаж болно, тухайлбал, АНУ-ын Сенат, ХБНГУ-ын Бундесрат, Энэтхэгийн Раджа Сабхаг ийм зарчмаар байгуулдаг. Засаглалын хоёр түвшний байгууллагаас шалтгаалан холбооны улсуудад хоёр танхимын (Bicameral system) систем тохиромжтой байдаг. Мөн дээд танхимд нийгмийн чухал нэгжүүдийн төлөөлөл, тухайлбал Энэтхэг, Этиопи зэрэг улсуудтай адил үндэстэн ястан, шашин, омогийн бүлэглэлүүдийн төлөөллийг оруулдаг жишиг бий.

Холбооны улс буюу федерализм нь харьцангуй ховор улс төрийн систем бөгөөд нэг



газар нутаг ба иргэдэд засаглалын хоёр түвшин үйлчилж байдаг. Хууль батлах, төсөв хуваарилах зэрэг нь төрийн төв байгууллага ба штат, провинц, нутаг дэвсгэрийн төрийн байгууллага хооронд хуваагдана. Дэлхийн ихэнх улс унитар байх бөгөөд орон нутгийн төрийн байгууллагын эрх мэдэл нь төвөөсөө тодорхойлогдоно. Хүчтэй федерал системд штат, орон нутгийн засаг өөртөө орлого төвлөрүүлэх эрхтэй байдаг.

- Федерал систем голдуу хоёр танхимтай парламенттай байх бөгөөд үндэсний хууль тогтоох байгууллагад штат, регионы эрх ашгийг төлөөлсөн дээд танхим байна.
- Федерал системд тодорхой хэмжээнд хууль тогтоох эрх бүхий хоёр дахь шатны хууль тогтоох байгууллага (subnational legislature) байдаг. Зарим эрх мэдэл хууль тогтоох хоёр шатны байгууллага хооронд хуваагдана.
- Хүчтэй федерал системд үндэсний хэмжээний хууль тогтоох ба гүйцэтгэх эрх мэдлийг сулруулсан байна.

Засаглалын хоёр түвшинд эрх мэдлийн баланс улс бүрт адилгүй. АНУ, ХБНГУ, Канад хүчтэй федерал системтэй, Нигерд сул, Мексикт дунд зэргийн хүчтэй федерал систем байна. Энэтхэгийн холбооны улсын үндсэн хуулиар төрийн төв байгууллага нь батлан хамгаалах, гадаад харилцаа, төмөр зам, тээвэр, холбоо, валют, банк, гааль, онцгой албан татварын асуудлаар хүчтэй холбоо байдаг. Энэтхэгийн парламент хууль тогтоох зарим тодорхой эрх мэдлийг 14 штат, 5 бүс нутгийн хоёрдахь шатны хууль тогтоох байгууллагатай хуваалцдаг. Үүнд, эдийн засаг ба нийгмийн төлөвлөлт, нийгмийн халамж, хөдөлмөрийн асуудал зэрэг орно. Хоёр шатны эрх мэдэл зөрчилдсөн тохиолдолд үндэсний парламент ба холбооны засгийн газрын хууль шийдвэрүүд давуу эрхтэй.

Хоёр танхимын системд парламентын хоёр танхимын эрх мэдэл улс бүрт өөр өөр байдаг. Сул хоёр танхимын системтэй зарим оронд дээд танхим нь зөвхөн зөвлөх эрхтэй байдаг. Жишээлбэл, Их Британид бүх ард түмнээс сонгогдсон Нийтийн танхим нь хууль тогтоох давуу эрх мэдэлтэй бөгөөд шийдвэрүүд нь дээд танхим–Лордуудын танхимнаас давуу байна. АНУ-д бол хоёр танхим нь адил болон харилцан нөхөх эрх мэдэлтэй бөгөөд гарч буй хууль тогтоомж хоёр танхимаар хоёулангаар нь дэмжигдсэн байх шаардлагатай. Канадад Нийтийн танхим нь илүү эрх мэдэлтэй боловч Сенат нь доод танхимын баталсан хуульд нь нэмэлт оруулах болон бодлогын асуудлаар хяналт хийх эрхтэй. Федерал системтэй Германд муж улсуудын сонирхол парламентын дээд танхим Бундесратад тусгагдах бөгөөд гишүүд нь муж улсуудын засгийн газруудаас томилогдоно. Бундесратын хууль тогтоох эрх мэдэл нь хүчтэй биш боловч муж улсууд болон холбооны засгийн газрын хоорондын маргааныг эцэслэн шийдвэрлэх эрхтэй.

Хоёр танхимтай унитар улсуудад дээд танхимыг нийгмийн янз бүрийн бүлэглэлүүдийн төлөөллийг оруулах болон доод танхимын хууль тогтоох эрх мэдлийг хянах зорилгоор байгуулдаг. Жишээ нь, Ботсванийн Удирдагчдын танхим нь сонгогдсон болон уламжлалт овог аймгуудаас томилогдсон гишүүдээс бүрдэнэ. Удирдагчдын танхим нь хязгаарлагдмал үүрэг гүйцэтгэх боловч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах болон овог аймгуудын асуудлаар энэ танхимтай заавал зөвлөлдөх ёстой. Буркино Фасод дээд танхим нь цэвэр зөвлөлдөх байгууллага бөгөөд янз бүрийн регион, нийгмийн бүлгүүдийн дуу хоолойг хүргэх зорилготой байгуулагдана. Энэ танхим мужийн сонгогдсон зөвлөлүүдийн төлөөлөл, эмэгтэйчүүдийн байгууллага, уламжлалт удирдагчид, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл зэргийг оролцуулсан томилогдсон болон шууд бус сонгуулиар сонгогдсон нийт 178 гишүүнтэй.

Дээд танхим нь ерөнхийдөө дараахь аргуудын нэгээр байгуулагдана:

- Шууд сонгууль–сонгогчид саналаа шууд тодорхой нэр дэвшигчид юмуу намд өгнө (АНУ)

- Шууд бус сонгууль—сонгогчид орон нутгийн эрх барих байгууллагыг сонгоод, дараа нь уг байгууллагаас дээд танхимын гишүүдийг сонгоно. (Аргентин, Австри, Герман, Энэтхэг)
- Доод танхимаас дээд танхимын гишүүдийг сонгох шууд бус сонгууль (Канад, Йордан, Тайланд)
- Үе залгамжлах (Их Британид Лордуудын танхимын гишүүдийн ихэнх нь үе залгамжилсан пэрүүд байдаг)
- Үндсэн хуулиар эрх олгогдсон байгууллага, хүмүүсийн зүгээс томилох.

Хоёр танхимын системийн зарим давуу талуудаас дурдвал:

- Бүс нутаг, нийгмийн анги давхрага, овог аймаг зэргээр нийгмийн олон янзын төлөөллийг парламентад оруулна
- Дутагдал, өө сэвтэй хууль батлагдан гарахаас сэргийлнэ (нэг танхим нь нөгөөгийнхөө баталсан хуулийг дахин хэлэлцдэг)
- Хоёр танхимтай байснаар гүйцэтгэх засаглалд тавих хяналт сайжирна.

Нэг танхимтай парламент

Нэг танхимтай парламент нь (One-chamber or unicameral legislatures) гол төлөв төвлөрсөн юмуу унитар тогтолцоотой, хүн амын бүрэлдэхүүн нэгэн төрөл, цөөн хүн амтай орнуудад байдаг. Ийм улсуудын тоонд Коста-Рика, Португали, Унгар, Исланд, Швед, Словени, Уганда, Шинэ Зеланд зэрэг улсууд бий. Олон орнуудад үндсэн хуулийн бүтэц нь өөрчлөгдсөн, сүүлийн хориод жилд олон орон ардчилсан тогтолцоонд шилжсэн гэх мэт өөрчлөлт их гарч байгаа боловч хүн ам цөөнтэй орнууд ихэвчлэн нэг танхимтай парламентын систем сонгодог тенденци хадгалагдсаар байна. Тухайлбал, Украинаас бусад Зүүн Европын бүх орнууд нэг танхимтай парламентын системийг сонгосон байна.

Зарим тохиолдолд сонгуулийн системийн онцлогоор нэг танхимтай парламентад ч нийгмийн олон янзын сонирхлын төлөөллийг оруулж болдог. Жишээлбэл, Словенийн үндсэн хуулиар нэг танхимтай парламент-Үндэсний хуралдаа үндэсний цөөнхүүдийн нэг нэг төлөөллийг оруулдаг. Угандын нэг танхимтай парламентад улсын 39 район бүрээс орох эмэгтэйчүүдэд зориулсан суудлууд байх ба нийгмийн бэрхшээлтэй иргэд, хөлсний ажилчдад оногдох суудал ч бий.

Нэг танхимтай парламентын давуу талууд нь:

- Шаардлага тулгарсан үед хууль тогтоомжийг шуурхай батлан гаргах боломжтой. Хоёр танхимаар дамжин хугацаа алдахгүй гэсэн үг.
- Зөвхөн нэг танхим гарсан хуулийн төлөө хариуцлага хүлээх учир хариуцлага хүлээлгэх боломж их
- Мэдээж, нэг танхимтай, цөөн гишүүнтэй байхад зардал бага байна.

Хоёр танхимын үүрэг, эрх мэдлийг зохицуулах аргууд

Хууль тогтоох процесст хоёр танхим оролцож байгаа үед танхим хооронд ялгаатай саналаар зөвшилцөх болон зөвшилцөл явуулах процессийн талаархи аргуудыг тодорхойлсон байх ёстой. Танхим тус бүр нь ялгаатай учир дээрхи аргуудыг тодорхойлох хууль тогтоомжууд нь ялгаатай байна. Ихэнх хоёр танхимтай парламентад хуулийн төслийг авч үзэх, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр танхимууд эцсийн зөвшилцөлд хүртэл нэг танхимаас нөгөөрүүгээ төслийг дамжуулан хэлэлцдэг систем (a shuttle system) үйлчилдэг. Энэ системээр нэг танхим нь хуулийн төслийн өөрийн хувилбарыг нөгөө танхимдаа танилцуулах бөгөөд тэр танхим нь төслийг батлах, буцаах болон нэмэлт, засвар оруулах зэргээр хэлэлцэнэ.



Судалгааны эмхтгэл, X боть

Энэ процесс хоёр танхим хуулийн нэг төсөл дээр бүрэн зөвшилцөх хүртэл үргэлжлэнэ. Зөвшилцөлд хүрэхгүй тохиолдолд аль нэг танхимын төслөөр батлах, хуулийн төслийг бүрмөсөн буцаах эсвэл парламент тарах гэх мэт олон янзын шийдэл байдаг.

Олон тохиолдолд хуулийн төслийг эцэслэн батлахад аль нэг танхим (голдуу доод танхим) нь шийдвэрлэх эрхтэй байна.

- Словенид дээд танхим-Үндэсний зөвлөл нь доод танхим-Үндэсний хурлаас баталсан хуульд долоо хоногийн дотор хориг тавих эрхтэй. Гэхдээ Үндэсний хурал ердийн олонхийн саналаар хоригийг хүлээн авахгүй байх эрхтэй.
- Орост дээд танхим Холбооны зөвлөл нь доод танхим Төрийн думын баталсан хуулийг буцаах эрхтэй боловч доод танхим нь дийлэнх олонхийн саналаар хоригийг хүлээн авахгүй байж болно.

Зарим оронд хоёр танхимын эрх мэдэл нь хэлэлцэж буй хуулиас шалтгаалан өөрчлөгдөх тохиолдол бий.

- ӨАБНУ-д хуулийн төсөл провинцуудад шууд хамаарахааргүй (үндэсний хэмжээний батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүйн гэх мэт асуудлууд) бол доод танхим Үндэсний Ассамблей ердийн олонхийн саналаар батлах ба дээд танхим Провинцуудын үндэсний зөвлөл батлах буюу буцааж болно, эсвэл өөрчлөлт оруулж болно. Харин провинцуудад нөлөөлөхөөр хуулийн төсөл дээр хоёр танхим санал зөрөлдвөл уг төслийг хоёр танхимын гишүүдээс бүрдсэн дундын хороонд шилжүүлнэ. Хэрэв уг хороо санал зөрөлдөөнийг зохицуулж чадахгүй бол хуулийн төслөөр доод танхим Үндэсний Ассамблейд дахин санал хураалт явуулах бөгөөд энэ удаад хууль гишүүдийн гуравны хоёроос дээш олонхийн саналаар батлагдах ёстой.

Зарим тохиолдолд хоёр танхим зөвшилцөлд хүрч чадахгүй бол хуулийн төслийг бүрмөсөн буцаана. Маш цөөн тохиолдолд парламент тарах болдог.

- Казахстанд доод танхим Мажилис баталсан хуулиа дээд танхим Сенатаар дэмжүүлэхээр өргөн барина. Сенат хуулийг дэмжилгүй Мажилист буцааж болдог. Энэ тохиолдолд Мажилис хуулийг дахин хэлэлцэж, гуравны хоёроос доошгүйн саналаар баталаад Сенатад дахиад хүргүүлж болно. Хэрэв Сенат төслийг дахин дэмжихгүй бол уг төслийг бүрмөсөн буцаах бөгөөд парламентын энэ чуулганы хугацаанд дахин хэлэлцэхгүй.
- Австралид доод танхим - Төлөөлөгчдийн танхим баталсан хуулийн төслөө дээд танхим Сенатад өргөн барина. Хэрэв Сенат уг төслийг батлахаас татгалзах юмуу нэмэлт өөрчлөлттэйгээр баталсан бөгөөд үүнтэй нь доод танхим санал нийлэхгүй байвал доод танхим уг хуулийн төслийг дахин гурван сарын дараа авч хэлэлцэн баталж болно. Хэрэв Сенат төслийг дахин батлахаас татгалзах юмуу доод танхимынхаас ялгаатайгаар баталвал Генерал-губернатор хоёр танхимыг хоёуланг нь зэрэг тарааж болно.

Австрали, далайн орнууд

АВСТРАЛИЙН ХАМТЫН НӨХӨРЛӨЛ (Commonwealth of Australia)

Хоёр танхимт парламенттай. Доод танхим нь Төлөөлөгчдийн танхим (House of Representatives), 150 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 3 жил. Дээд танхим нь Сенат (Senate), 76 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 6 жил. Их Британийн Хатан хааны өргөмжилсөн Амбан захирагч парламентын гишүүн байна.

Сонгууль

Доод танхимын гишүүнийг бүх нийтийн, шууд санал хураалтаар нэг мандаттай тойргоос сонгуулийн мажоритари системээр 3 жилийн хугацаагаар сонгодог. Амбан захирагчийн шийдвэрээр хугацаанаас өмнө тарааж болно. Сенатын гишүүнийг бүх нийтийн, шууд санал хураалтаар олон мандат бүхий сонгуулийн пропорциональ системээр 6 жилийн хугацаагаар, харин Холбооны нутаг дэвсгэрийг төлөөлдөг 4 гишүүнийг 3 жил хүртэл хугацаагаар сонгодог. Нийт гишүүдийн 50 хувийг 3 жил тутам шинэчлэн сонгоно. Доод танхимд муж бүр 5-аас доошгүй тооны гишүүний төлөөлөлтэй байна. Сенатад 6 муж тус бүрийг 12 сенатор, Холбооны 2 нутаг дэвсгэр тус бүрийг хоёр сенатор төлөөлнө

Төрийн байгуулал

Үндсэн хуульт хаант засагтай холбооны улс. Төрийн тэргүүний үүргийг Английн Хатан хаан хоёрдугаар Елизабет ёс төдий хэлбэрээр гүйцэтгэдэг бөгөөд бүрэн эрхийг нь түүний өргөмжилсөн Амбан захирагч хэрэгжүүлдэг. Амбан захирагч нь Холбооны парламентаас баталсан хуулийг ёсчлох ба парламентын ээлжит чуулганы товыг зарлах, завсарлуулах болон парламентын доод танхимыг тараах эрх эдэлнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилно. Дээд шатны шүүхийн шүүгчдийг томилох, зэвсэгт хүчнийг командлах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.


Парламентын бүрэн эрх

Үндсэн хуулиар парламент нь Австралийн холбооны сайн сайхны төлөө энх тайван, эмх журамтай байх, Холбоог удирдахтай холбоотой бүх хуулийг батлан гаргах бүрэн эрхтэй. Мөн засгийн газрын байрлах газрыг тогтоох, засгийн газрын харьяа төрийн байгууллагуудтай холбоотой асуудал зэргээр онцгой бүрэн эрхтэй. Сенат орлого, мөнгөний бодлого, татвар тогтоохтой холбоотой асуудлаар хуулийн төсөл санаачлах болон нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй. Харин энэ төрлийнхөөс бусад хуулийн төслийг дахин авч үзэж, сайжруулахыг шаардан Төлөөлөгчдийн танхимд буцаах эрхтэй. Бусад бүх асуудлаар Сенат ба Төлөөлөгчдийн танхим адил эрхтэй. Төсөв, мөнгөний бодлоготой холбоотой хуулийн төслийг парламентаас Амбан захирагчид хүргүүлж, зөвхөн тухайн чуулганы хугацаанд Амбан захирагчийн зүгээс тодорхой төсөв, санхүүжилтийг дэмжсэн мэдэгдлээ парламентад танилцуулсан тохиолдолд уг хуулиар санал хураалт явуулж, шийдвэр гаргана.

Хууль тогтоох журам

Англи-саксоны эрх зүйн тогтолцооны уламжлалд суурилсан эрх зүйн тогтолцоотой. Хууль хэлэлцэн батлах журмын тухайд хоёр танхим адил боловч Сенат нь санхүүгийн талаархи хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүй. Танхим бүрт хуулийн төслийг хэд хэдэн үе шаттай хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлгээр парламентын гишүүд төслийн эх бичвэр, агуулга, зорилттой танилцаж, хоёр дахь хэлэлцүүлгээр төслийг хэлэлцэж холбогдох Байнгын комисст засч сайжруулахаар шилжүүлнэ. Гурав дахь хэлэлцүүлгээр уг төсөл парламентын хоёр танхимаар дэмжигдсэн байна. Хэрэв аль нэг танхим төсөлд өөрчлөлт оруулбал нөгөө танхим уг өөрчлөлтийг мөн адил зөвшөөрч батална.

Танхимууд төслийг батлах талаар санал нийлэхгүй тохиолдолд танхим тус бүр өөрсдийн төлөөлөгчөө томилж, тэдгээр нь нэгдсэн шийдвэр гаргахад нийцүүлэн төслийг засч сайжруулна. Хоёр танхимаар дэмжигдсэн төслийг Амбан захирагчаар батлуулахаар өргөн мэдүүлнэ. Хэрэв Сенат тодорхой хугацааны дотор хуулийн төслийг 2 удаа дэмжээгүй, эсхүл Засгийн газар хугацаанаас өмнө сонгууль явуулахыг зөвшөөрч байгаа тохиолдолд парламентын хоёр танхим зэрэг тарж, танхимуудыг бүрэн бүрэлдэхүүнээр нь дахин сонгоно. Хэрэв маргаантай хуулийн төслийг шинээр сонгогдсон танхимууд хэлэлцэн



Судалгааны эмхтгэл, Х боть

баталж чадахгүй бол хоёр танхимын нэгдсэн хуралдааныг зарлан хуралдуулна. Холбооны болон мужуудын парламентын хууль тогтоох эрх мэдэл тодорхой заагтай. Дээд, доод танхимын гишүүн хууль санаачлах эрх эдэлнэ.

ПАЛАУ - Бүгд Найрамдах Палау Улс (Republic of Palau)

Хууль тогтоох дээд байгууллага нь Үндэсний хурал (Olbiil Era Kelulau). Хоёр танхимтай. Доод танхим нь Төлөөлөгчдийн танхим (House of Delegates), дээд танхим нь Сенат (Senate).

Төлөөлөгчдийн танхим 16 гишүүнтэй, муж бүрээс нэг төлөөлөгчийг бүх нийтийн, шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгодог. Сенат 13 гишүүнтэй. Гишүүдийг бүх нийтийн, шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгодог.

Төрийн байгуулал:

Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Улс. Ерөнхийлөгчийг бүх нийтийн, шууд санал хураалтаар 4 жилийн хугацаагаар сонгоно. Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. Гүйцэтгэх засгийг Ерөнхийлөгч тэргүүлэх ба дэд Ерөнхийлөгч Засгийн газрын гишүүн байна. Засгийн газрын танхимын бусад гишүүнийг парламентын дээд танхимтай зөвшилцсөнөөр Ерөнхийлөгч томилно. Ерөнхийлөгчийн томилгоо парламентын дээд танхимын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжсэн саналаар баталгаажна. Засгийн газрын гишүүн парламентын гишүүн байж болохгүй. Засгийн газар ажлаа парламентын өмнө хариуцна.

Хууль тогтоох журам:

Парламентын хоёр танхим тус бүр хууль батлан гаргана. Парламентын танхим тус бүрийн баталсан хуулийг Ерөнхийлөгч баталснаар хүчин төгөлдөр болно. Үндсэн хуулийн 9 дэх хэсгийн 15 дугаар зүйлд зааснаар хэрэв Ерөнхийлөгч хуулийн төсөлд хориг тавьсан бол хуанлийн 15 хоногийн дотор парламентын хоёр танхимд буцаана. Танхимууд хоригийг хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногт багтаан хэлэлцэж гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батлан Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Ерөнхийлөгч хоёр дахь удаагаа хуулийн төслийг парламентад буцаахгүй. Засгийн газар хууль санаачлах эрх эдэлдэггүй

Сонгууль:

Парламентын доод танхимын гишүүнийг нэг мандаттай 16 тойргоос сонгуулийн мажоритар системээр, бүх нийтээр, олонхийн саналаар, шууд сонгоно. Сонгуульд 18 нас хүрсэн, Палаугийн иргэн, тус улсад амьдардаг, сонгуулийн эрх бүхий иргэн санал өгөх эрхтэй. Нэр дэвшигч нь 25 нас хүрсэн, өмнөх сонгуулиас хойш 5-аас доошгүй жил эх орондоо амьдарсан, Палаугийн иргэн, тухайн тойргийн нутаг дэвсгэрт нэгээс доошгүй жил амьдарч буй иргэн байна.

Сенатын гишүүнийг нийт үндэсний хэмжээний нэг тойргоос 13 суудалд сонгоно. Сонгогч бүр саналын хуудсанд нэр орсон нэр дэвшигчдээс 13-г сонгох ба хамгийн олон санал авсан 13 нэр дэвшигч сонгогдсонд тооцогдоно. Сенатын танхимын даргыг 4 жилийн хугацаагаар сонгоно. Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгчийн эзгүйд тэдгээрийг орлоно.

Бүрэн эрх

Парламент нь хууль тогтоох, банк, мөнгөний бодлогыг тодорхойлох, гадаад худалдааг зохицуулах бүрэн эрхтэй. Мөн засгийн газрыг тэргүүлдэг ерөнхийлөгчийн хийх

томилолтуудыг Сенатын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батлана. Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч болон Дээд шүүхийн шүүгчдийг огцруулах болон импичментийн асуудлыг хоёр танхим тус бүрдээ гишүүдийн гуравны хоёроос багагүйн саналаар шийднэ.

ФИЖИ - Фижи Арлуудын Бүгд Найрамдах Улс (Republic of the Fiji Islands)

Парламент нь Ерөнхийлөгч, Сенат, Төлөөлөгчдийн танхимаас бүрдэх бөгөөд Төлөөлөгчдийн танхим нь 71 гишүүнтэй, Сенат нь 32 гишүүнтэй. Гэвч тус улсад гарсан 2006 оны төрийн эргэлтийн дүнд парламентын үйл ажиллагаа түр зогссон байгаа.

Бүтэц, зохион байгуулалт:

Хоёр танхимтай. Дээд танхим Сенат. 32 гишүүнтэй. 14 гишүүнийг Удирдагчдын дээд зөвлөлийн дэвшүүлснээр, 9 гишүүнийг Ерөнхий сайдын санал болгосноор, 8 гишүүнийг сөрөг хүчний удирдлагын санал болгосноор, 1 гишүүнийг Ротумын тусгаар нутаг дэвсгэрийн зөвлөлийн дэвшүүлснээр Ерөнхийлөгч тус тус томилдог. Доод танхим нь Төлөөлөгчдийн танхим. 71 гишүүнтэй. 23 суудлыг Фижи үндэстний төлөөлөл, 19 суудлыг энэтхэг үндэстний төлөөлөл, 3 суудлыг бусад үндэстний төлөөлөл, 1 суудлыг Ротума тойргийн Зөвлөлөөс бүрдүүлж, 25 суудлыг бүх нийтийн сонгуулиар сонгодог. Бүрэн эрхийн хугацаа 5 жил.

Төрийн байгуулал:

1970 оны Үндсэн хуулиар төрийн удирдлагын Вестминстерийн парламентын загвар бүхий Вант улсын тогтолцоог баталж, Их Британийн Хатан хаан буюу түүний өргөмжилсөн Амбан захирагч төрийн тэргүүний үүргийг гүйцэтгэж байсан. 1987 онд төрийн эргэлт гарч тус улсад цэргийн удирдлага тогтоосон. 1990 онд хоёр дахь Үндсэн хуулиа баталж Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах улс болжээ. 1997 онд шинэ Үндсэн хууль баталж төрийн удирдлагын ардчилсан зарчмуудыг баталгаажуулсан боловч 2006 онд төрийн эргэлт гарч тус улсад онц байдал тогтоосон. 1997 оны Үндсэн хуулиар төрийн тэргүүн Ерөнхийлөгч байхаар заасан. Ерөнхийлөгчийг Удирдагчдын дээд зөвлөлөөс (Great Council of Chiefs) 5 жилийн хугацаагаар сонгодог. Нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч парламентын гишүүнээс томилдог.

Бүрэн эрх

Хууль тогтоох эрх мэдэл Төлөөлөгчдийн танхим ба Сенат, мөн Ерөнхийлөгчөөс бүрдэх парламентад байна. Парламентын хоёр танхим аль аль нь хууль тогтоох үндсэн чиг үүрэгтэй боловч хууль батлах талаар Сенатын танхим арай бага эрх мэдэлтэй бөгөөд гол төлөв Төлөөлөгчдийн танхимын баталсан хуулийг хэлэлцэж засвар оруулах, буцаах чиглэлээр ажилладаг.

Хуулийн төсөл парламентын хоёр танхимаар дэмжигдээд Ерөнхийлөгч гарын үсэг зурснаар хүчинтэй болдог. Ерөнхийлөгчид урьдчилан танилцуулж, зөвшөөрлийг нь авсны дараа батлагдсан хуульд Ерөнхийлөгч гарын үсэг зурахгүй байж болохгүй.

Хууль тогтоох журам

Бүх хуулийн төслүүдийг Төлөөлөгчдийн танхим эхлэн хэлэлцээд дараа Сенатад өгнө. Сенат төслийг засваргүй юмуу засвартайгаар батлах, эсвэл буцааж болно. Хэрэв хууль сенатаар засвартайгаар батлагдвал Төлөөлөгчдийн танхим энэ хэлбэрээр нь хүлээж авах юмуу авахгүй байж болно. Төлөөлөгчдийн танхим ийнхүү хүлээж аваагүй бол уг хуулийн төслийг анх батлагдсан хэлбэрээр нь дахин Сенатад явуулна. Хэрэв а) хуулийн төсөл Төлөөлөгчдийн танхимаар хоёр чуулган дараалан орж батлагдсан, б) хоёр



Судалгааны эмхтгэл, Х боть

хэлэлцүүлэгийн хооронд зургаан сараас доошгүй хугацаа байсан, в) хоёр дахин өргөн барихад Сенат хоёуланд нь хүлээн зөвшөөрөөгүй юмуу засвартайгаар баталсан, үүнтэй нь Төлөөлөгчдийн танхим санал нийлэхгүй байвал хуулийн төсөлд гарын үсэг зуруулахаар шууд ерөнхийлөгчид өргөн барьж болно. Мөн яаралтай хуулийн төслийн хувьд

- а) ерөнхий сайдын зүгээс Төлөөлөгчдийн танхимын баталсан хууль нь хойшлуулашгүй чухал хууль гэдгийг Сенатын даргад бичгийн хэлбэрээр нотолсон,
- б) хуулийн төслийг чуулган дуусахаас ажлын долоогоос доошгүй хоногийн өмнө Сенатад хүргүүлсэн,
- в) Сенат төслийг хүлээн авснаас хойш ажлын долоо хоногийн дотор хэлэлцэн хариу өгөөгүй юмуу

Төлөөлөгчдийн танхим хүлээн авахааргүй хариу өгсөн бол төслийг ерөнхийлөгчид гарын үсэг зуруулахаар өргөн барьж болно. Төсөв мөнгөний бодлоготой холбоотой асуудал дээр Сенатын эрхийг тодорхой хэмжээнд хязгаарласан байна.

АЗИЙН ОРНУУД

АФГАНИСТАН

Исламын Бүгд Найрамдах Афганистан Улс (Islamic Republic of Afghanistan)

Хууль тогтоох байгууллага Үндэсний Ассамблей нь Доод танхим буюу Төлөөлөгчийн танхим, Дээд танхим буюу Сенат гэсэн 2 танхимтай.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Төлөөлөгчдийн танхимын гишүүдийг нийтийн, нууц, чөлөөт, шууд сонгуулиар 5 жилийн хугацаатайгаар сонгодог. Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн тоо нь бүх бүс нутгийн хүн амыг хувь тэнцүүлэн оруулсан байх бөгөөд хамгийн ихдээ 250 байна. Төлөөлөгчдийн танхимын нийт гишүүдийн арав нь Афганы нүүдэлчин омгийн (Kuchis) төлөөлөл байх ба үүнээс хамгийн багадаа 3 нь эмэгтэй гишүүн байна. Түүнчлэн 65 суудал эмэгтэй гишүүнд зориулсан байх бөгөөд Төлөөлөгчдийн танхимын 68 гишүүн нь эмэгтэй байна. Төлөөлөгчдийн танхимын сонгууль нь олон мандаттай /нэг тойрог 2 - 33 мандаттай/, олон /34/ тойргоос хувь тэнцүүлэх аргаар сонгодог. Сонгох эрх 18 нас хүрсэн байх бол сонгогдох эрх нь 25 нас хүрсэн байх шаардлага тавьдаг.

Сенатын танхим нь 102 гишүүнтэй бөгөөд 68 -ийг нь шууд бусаар сонгож, 34 -ийг нь Ерөнхийлөгч 5 жилийн хугацаатайгаар томилох бөгөөд Ерөнхийлөгчийн томилох гишүүдийн 50 хувь нь эмэгтэй гишүүн байна. Сенатын танхимын гишүүд сонгогдсон, томилогдсон байдлаасаа хамааран 3-5 жилийн хугацаатайгаар бүрэн эрхээ хэрэгжүүлдэг. Бүх мужын зөвлөл нэг төлөөлөгчийг 4 жилийн хугацаатайгаар сонгодог. Мужийн дүүргүүдийн зөвлөлүүдээс 3 жилийн хугацаатайгаар Сенатын нэг гишүүнийг сонгодог. Сенатын танхимын гишүүний сонгуулийг энгийн олонхийн аргаар хоёр үе шаттайгаар явуулдаг. Сенатын танхимын гишүүнээр сонгогдохын тул 35 нас хүрсэн байх шаардлагыг тавьдаг. Хэн нэг этгээд нэгэн зэрэг хоёр танхимын гишүүн байж болохгүй.

Бүрэн эрх

Үндэсний Ассамблей нь буюу хоёр танхим хамтран дараахь бүрэн эрхтэй. Хууль тогтоомж батлах, хүчингүй болгох, өөрчлөх, нийгэм, эдийн засаг, соёл, технологийн хөгжлийн хөтөлбөрийг батлах, улсын нэгдсэн төсвийг батлах, түүнийг зарцуулах зөвшөөрөл олгох, зээл олгох, захиргааны нэгжийг байгуулах, өөрчлөх, олон улсын гэрээ, конвенцийг батлах, олон улсын байгууллагын гишүүнээс гарах зэрэг Үндсэн хуульд заасан чиг үүргийг

хэрэгжүүлдэг байна. Үндэсний Ассамблей нь танхимууд өөрсдийн дотоод дэгийн дагуу холбогдох асуудлаар чиглэлийн хороодтой үйл ажиллагаагаа явуулна. Хоёр танхим зарим асуудлаар хамтарсан хороо байгуулан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авдаг.

Доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим нь дараахь бүрэн эрхтэй. Үндсэн хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу сайд нарт асуулга тавин шийдвэр гаргах, улсын төсвийн талаархи хоёр танхимын маргаантай асуудлаар эцсийн шийдвэр гаргах, Үндсэн хуульд заасан томилгоог батлах зэрэг бүрэн эрхтэй. Түүнчлэн Төлөөлөгчдийн танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг мөрдөн шалгах зорилгоор тусгай түр хороо байгуулан ажиллуулж болно. Уг хорооны үйл ажиллагаа, процедурыг танхимын дотоод дэгээр зохицуулна.

Төрийн дээд эрхийг барих субъект

Исламын Бүгд Найрамдах Афганистан улс нь бие даасан, нэгдмэл, хуваагдашгүй улс мөн гэж Үндсэн хуулийнхаа 1 дүгээр зүйлд заасан. Афганистан нь хүчтэй Ерөнхийлөгчийн засагтай, бүгд найрамдах, шашины улс юм.

Хууль тогтоох журам

Үндэсний Ассамблейн баталсан хуулийг Ерөнхийлөгч соёрхон батлах бөгөөд Ерөнхийлөгч хуульд үндэслэлтэй хориг тавих эрхтэй. Ерөнхийлөгчийн хориг тавьсан хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим гуравны хоёрын саналаар баталвал хууль хүчин төгөлдөр болно. Засгийн газрын санаачилсан хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимд хүргүүлдэг бөгөөд уг танхим хуулийн төслийг 1 сараас хэтрэхгүй хугацаанд хэлэлцээд баталвал Сенатын танхимд хүргэдэг. Сенатын танхим 15 хоногийн дотор шийдвэр гаргах шаардлагатай байдаг.

БАХРЕЙН - Бахрейны Вант Улс (Kingdom of Bahrain)

Хууль тогтоох дээд байгууллага Үндэсний Ассамблей (The National Assembly) нь Дээд танхим буюу Зөвлөх зөвлөл /The Consultative Council/ болон Доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим /The Chamber of Deputies/ гэсэн хоёр танхимтай.

Сонгууль

Төлөөлөгчдийн танхимын 40 гишүүнийг бүх нийтийн, шууд сонгуулиар нууц санал хураалтаар сонгодог. Нэг мандаттай 40 тойрогт сонгогчдын дийлэнх олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогддог. Хэрэв дийлэнх олонхийн санал аваагүй бол 2 дахь шатны сонгуулиар ердийн олонхийн санал авсан нь сонгогддог. Бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна. 20 нас хүрсэн иргэн сонгуулийн эрх эдлэх ба нэр дэвшигч мөн 20 нас хүрсэн байна. Дээд танхим буюу Зөвлөх зөвлөлийн 40 гишүүнийг хаан томилно. Бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

Бүрэн эрх

Үндэсний Ассамблей нь буюу хоёр танхим хамтран дараахь бүрэн эрхтэй: Хоёр танхимын аль ч гишүүн хууль санаачлах эрхтэй. Харин Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хоёр танхимын 15-аас доошгүй гишүүн санаачилах ёстой. Хуулийн төслийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, татгалзах эрхтэй. Мөн улсын төсөв батлах, Засгийн газрын программыг батлан зөвшөөрөх, батлан хамгаалах дайн зарлах ба шийдвэр гаргах, улсын үндэсний аюулгүй байдал эсвэл цэрэг дайны хуулийг зарлан тунхаглах, зөвшөөрөгдсөн хууль тогтоомжын дагуу олон улсын гэрээ хэлэлцээрт оролцох эрхтэй. Мөн аль ч танхимын гишүүн сайдад асуулт тавьж хариулт авах эрхтэй.



Доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим нь дараахь бүрэн эрхтэй:

Төлөөлөгчдийн танхимын дарга ба хоёр дэд даргаа сонгох, үйл ажиллагаагаа явуулах болон бүрэн эрхээ хэрэгжүүлэх хороодыг байгуулах, Сайд нар Төлөөлөгчдийн танхимын өмнө хариуцлага хүлээх ба сайдад итгэл хүлээлгэх асуудлыг Төлөөлөгчдийн танхимын 10-аас доошгүй гишүүний санаачилгаар авч хэлэлцдэг. Харин Төлөөлөгчдийн танхимын гуравны хоёроос илүү гишүүн итгэл хүлээлгэхгүй байхаар санал өгвөл сайдыг тэр дор нь чөлөөлөх ёстой. Парламентын хяналтын үйл ажиллагааны өөр нэг хэлбэр нь Засгийн газарт бичгэн асуулт, асуулга тавих хэлбэр байдаг. Засгийн газар тухайн асуудлаар хуралдан Төлөөлөгчдийн танхимд заавал бичгээр хариу өгөх ёстой.

Төрийн дээд эрхийг барих субъект

Хаан нь төрийн тэргүүн. Ерөнхий сайдыг Хааны зарлигаар томилж, чөлөөлдөг. Ерөнхий сайдын саналаар бусад сайдыг Хаан томилж, чөлөөлнө. Хааны Зөвлөх Зөвлөлийн гишүүдийг мөн томилдог. Хаан зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба цэргийн албан тушаалтан, дипломат төлөөлөгчдийг томилох, Үндэсний Ассамблейн хуралдааныг зарлах, Дээд шүүхийн зөвлөлийг даргалах, даргыг томилох, уучлал үзүүлэх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Хаан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль санаачлах эрхтэй бөгөөд хууль тогтоомжийг соёрхон баталдаг.

Хууль тогтоох журам

Хуулийн төслийг Зөвлөх зөвлөл, Төлөөлөгчдийн танхимаар, эсхүл Үндэсний Ассамблейгаар хэлэлцэн баталж Хаанд өргөн мэдүүлнэ. Хаан соёрхон баталсаны дараа нийтэд зарлан тунхаглана.

Ерөнхий сайд хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимд хүргүүлдэг. Төлөөлөгчдийн танхимын танилцсан хуулийн төслийг Зөвлөх зөвлөлд мөн хүргүүлдэг. Парламентын доод танхимын баталсан хуулийн төслийг дээд танхим батлаагүй бол доод танхимд дахин хэлэлцүүлэхээр буцаадаг. Хэрэв хуулийн төслийг доод танхим баталвал тус төслийг дээд танхимын дарга Ерөнхий сайдад хүргүүлдэг ба Ерөнхий сайд Хаанд өргөн мэдүүлнэ. Хэрэв хоёр танхим хоёр удаа санал зөрвөл Зөвлөх зөвлөлийн даргын удирдлага доор хамтарсан чуулган явуулах ба үүнд Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх ба хэрэв шийдвэрт хүрч чадахгүй бол уг хуулийн төслийг тэр Үндэсний Ассамблейн хугацаанд дахин хэлэлцэхгүй.

БУТАН

Бутаны Вант Улс

Парламентын танхимуудын нэр: Парламент нь дээд танхим буюу Үндэсний зөвлөл (gyelyong tshogde national council)-25 гишүүнтэй, Доод танхим буюу Үндэсний Ассамблей (Tshogdu-National Assembly)-55 гишүүнээс илүүгүй.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Үндэсний зөвлөл: Нийт суудлын 24 хувь буюу 6 эмэгтэй гишүүнтэй байна. 20 гишүүнийг бүх нийтийн санал хураалтаар нэг мандаттай 20 тойргоос сонгогчдын олонхийн саналаар сонгох ба 5 гишүүнийг Хаан томилдог.

Үндэсний Ассамблей: Нийт 47 суудалтай, үүнээс 8,5 хувь буюу 4 эмэгтэй гишүүн байна. Нэг мандаттай 47 тойргоос олонхийн саналаар сонгодог.

Бүрэн эрх:

Дээд танхим:

- Мөнгө болон санхүүгийн хуулийн саналын зөрүүг бэлтгэх, хүлээн авах
- Үйлчилж буй хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах болон хянах
- Энэ хуульд нийцүүлэн Үндэсний Ассамблейн баталсан бүх төрлийн хуулийн төслийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, татгалзах, авч үзэх
- Засгийн газрын хөтөлбөр болон төлөвлөгөөнд хяналт тавих, тайлбар авах
- Засгийн газрын гүйцэтгэлийг хянах
- Хууль болон тогтоолын хэрэгжилтийг хянах
- Улсын бусад чухал асуудлуудыг хянах

Доод танхим:

- Үндсэн хуульд заасны дагуу Үндэсний Ассамблейд хууль тогтоох эрх мэдэл хадгалагдах бөгөөд Төрийн тэргүүний дэмжлэгтэйгээр хууль батлан гаргах бүрэн эрхтэй.
- Үндэсний Ассамблей нь үйл ажиллагаандаа олон ургалч үзлийг баримтлах ба асуудлыг чөлөөт хэлэлцүүлэг болон хамтын зөвшилцөл дээр суурилан шийдвэрлэнэ.

Төрийн дээд эрхийг барих субъект: Төрийн тэргүүн нь Бутаны Ван байна.

Хууль тогтоох журам: Аль нэг танхим хуулийн төслийг хэлэлцээд баталсан тохиолдолд 30 хоногийн дотор нөгөө танхимдаа хүргүүлдэг. Хэрэв нөгөө танхим нь уг төслийг батлахгүй бол хуулийн төслийн баталсан танхимд буцаан хүргүүлдэг. Танхим хуулийн төслийг дахин хэлэлцээд баталвал Хаанд соёрхон батлуулахаар хүргүүлдэг. Хуулийг Хаан батламжилснаар хүчин төгөлдөр болно.

<http://www.nationalcouncil.bt/>

ЙЕМЕН УЛС

Бүгд Найрамдах Йемен улс нь ардчилсан сонгууль болон олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн парламентын тогтолцоотой улс.

- Зөвлөх зөвлөл (111 гишүүнтэй)
- Төлөөлөгчдийн танхим. (301 гишүүнтэй) гэсэн 2 парламентын танхимтай.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Дээд танхим: Йемен Улс нь арабын ертөнцөд хийсэн нэгэн томоохон шинэлэг зүйл нь эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Йеменд олон намын тогтолцоог хадгалах үүднээс намуудын тэнцвэртэй байдлыг бий болгох талаар төрөөс улс төрийн нэлээд чармайлт үзүүлдэг байна. Зөвлөх зөвлөлийг 1997 оны 5 сард Ерөнхийлөгч шууд өөрөө томилж байхаар байгуулсан. Анх байгуулахдаа 59 гишүүн томилсон байна. 40 нас хүрсэн, тухайн улсын иргэн, мөн төлөөлөгчдийн танхим болон орон нутгийн хүмүүсээс оролцуулдаггүй ерөнхийлөгчөөс шууд томилдог байна.

Доод танхим: Төлөөлөгчдийн танхимын 301 гишүүдийг нэг мандаттай олон тойргоос мажоритари саналаар шууд ард түмнээс сонгогдог. Парламентын бүрэн эрхийн хугацаа 6 жил. Ерөнхийлөгч нь Зөвлөх зөвлөлийн гишүүнийг томилдог. Ерөнхийлөгч төлөөлөгчдийн танхимын сонгууль болсноос хойш эхний хуралдааныг 60 хоногийн дотор хуралдуулна.



Судалгааны эмхтгэл, X боть

Хамгийн ахмад настай гишүүн нь анхны хуралдааныг удирдан дарга, 3 дэд даргаа сонгодог байна. Жилд 2 удаа хуралддаг.

Бүрэн эрх

Дээд танхимын бүрэн эрх

Зөвлөх зөвлөлийн гишүүнийг ерөнхийлөгчөөс шууд томилдог. Зөвлөх зөвлөлийг Йемений хөгжил, ирээдүйд хувь нэмэр оруулахуйц мэдлэг, туршлагатай Йемены салбар бүрийн хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсээр бүрдүүлдэг байна.

- Ерөнхийлөгчид аливаа асуудлаар саналаа өгөх
- Засгийн газрын агентлагт санал, зөвлөмж өгөх
- Орон нутаг болон үндэсний хэмжээний стратеги, улс төр, нийгэм, цэрэг арми, аюулгүй байдлын чиглэлээр санал, зөвлөмж өгөх
- Төрийн байгууллагыг нэгтгэх тал дээр зөвлөгөө өгөх
- Эдийн засаг, санхүү, төсөв, жилийн тайланд зөвлөгөө өгөх эрхтэй байна.
- Аудитын хяналтаас өгсөн цаг үеийн тайланг Ерөнхийлөгчид өгдөг.

Доод танхимын бүрэн эрх

Төлөөлөгчдийн танхим нь хууль батлах, улс төрийн бодлогыг тодорхойлох, нийгэм-эдийн засгийн төлөвлөгөөг батлах, Засгийн газрын төсөв, нэгдсэн тайланг баталдаг. Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаанд шууд хяналт шинжилгээ хийдэг. Төлөөлөгчдийн танхимын гишүүн болон Засгийн газар нь хуулийн төслийн санал гаргах эрхтэй бөгөөд санхүүгийн хууль тогтоомж, татвар нэмэх, бууруулах, улсын сан хөмрөгтэй холбоотой хуулийн төслийг Засгийн газар болон гишүүдийн 20 хувиас багагүйн саналаар Төлөөлөгчдийн танхимд өргөн барьдаг.

Төлөөлөгчдийн танхим нь ерөнхий асуудлаар Засгийн газарт зааварчилгаа, зөвлөмж өгөх бүрэн эрхтэй. Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн 20 хувийн шаардлагаар олон нийтийн хамрах асуудлаар хэлэлцүүлэг хийх, Засгийн газрын бодлогын талаар тайлбар шаардах, холбогдох асуудлаар санал бодол солилцох арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Доод тал нь 10 гишүүний шаардлагаар нийтийн эрх ашгийн төлөө Сайд, Засгийн газрын агентлаг, хороо, төрийн болон холимог өмчийн аж ахуйн нэгж, орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааг мөрдөн шалгах зорилгоор тусгай хороо байгуулж болох бөгөөд тусгай хороо нь холбогдох асуудлаар нотлох баримт цуглуулахын тулд гэрчийн мэдүүлэг авах, холбогдох баримт бичиг, мэдээллийг гүйцэтгэх болон тусгай эрх бүхий бүх байгууллагаас гаргуулж авах эрхтэй.

Төрийн дээд эрхийг барих субъект

Йеменийг төрийн удирдлагын хэлбэрийн хувьд холимог. Ерөнхийлөгч нь нэлээд өргөн эрх мэдэлтэй бөгөөд Йеменд гүйцэтгэх эрх мэдэл ерөнхийлөгч болон Сайд нарын зөвлөлд хадгалагддаг. Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба 7 жилийн хугацаатай ард түмнээс шууд сонгодог.

Хууль тогтоох журам

Төлөөлөгчдийн танхимын гишүүн болон Засгийн газар нь хуулийн төслийн санал гаргах эрхтэй бөгөөд санхүүгийн хууль тогтоомж, татвар нэмэх, бууруулах, улсын сан хөмрөгтэй холбоотой хуулийн төслийг Засгийн газар болон гишүүдийн 20 хувиас багагүйн

саналаар Төлөөлөгчдийн танхимд өргөн барьдаг. Зарим тохиолдолд л хуулийн төслийг дээд танхимаар хэлэлцдэг байна. Ерөнхийлөгч санал болгосноор Зөвлөх зөвлөл болон Төлөөлөгчдийн танхим 2 хамтран хуралддаг байна. Зөвлөх зөвлөл нь төлөөлөгчдийн танхимтай хамтран хуралдаан хийхдээ нийгэм, эдийн засгийн хэтийн төлөвийг хэлэлцдэг. Мөн батлан хамгаалах, харилцаа холбоо, энхтайвны асуудлаар гэрээ хэлэлцээ хийдэг байна.

ЙОРДАН УЛС

Йорданын хууль тогтоох байгууллага Үндэсний Ассамблей (The National Assembly, Majlis Al-Umma) нь Сенатын танхим (55 гишүүнтэй), Төлөөлөгчдийн танхим (110 гишүүнтэй) гэсэн 2 танхимтай.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Сенатын танхим нь 55 гишүүнтэй бөгөөд 4 жилийн хугацаагаар хаан нь томилдог байна. Сенатын гишүүнээр томилогдохын тул 40 нас хүрсэн, хааны удмын холбоогүй хүн сонгогдоно. Сенатын гишүүн сонгогддоггүй зөвхөн томилогддог байна. Төлөөлөгчдийн танхим нь 110 гишүүнээс бүрддэг бөгөөд тэдгээр гишүүдийг олон мандаттай олон тойргоос мажоритар аргаар 4 жилийн хугацаатай сонгодог байна. 12 суудал Христосын шашинтнууд болон Черкезүүдэд харин 6 суудал эмэгтэйчүүдэд хуваарилахаар тогтоосон байна.

Бүрэн эрх

а/ Дээд танхимын бүрэн эрх

Сенатын танхимыг зөвхөн хаан томилдог байна. Сенатын танхим нь 7 Байнгын хороотой үйл ажиллагаагаа явуулдаг байна. Йорданы парламент нь бие даасан төсөвтэй байдаг.

б/ Доод танхимын бүрэн эрх

Төлөөлөгчдийн танхим нь хууль батлах чиг үүрэгтэй бөгөөд Ерөнхий сайд хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимын даргад хүргүүлдэг байна.

Төлөөлөгчдийн танхим нь гүйцэтгэх салбарыг хянан шалгах чиг үүрэгтэй байдаг. Энэ чиг үүргээ асуулт асуух, байцаах, мэтгэлцэх, итгэл үзүүлэх зэрэг аргаар хэрэгжүүлдэг байна. Төлөөлөгчдийн танхимын гишүүн нь ард түмнийг төлөөлөх чиг үүрэгтэй. Төлөөлөгчдийн танхим нь олон нийт болон Засгийн эрх мэдэл хоёрыг холбогч суваг гэж үздэг байна.

Төрийн дээд эрхийг барих субъект

Йордан нь үе залгамжилсан хаан бүхий парламентын тогтолцоотой, Үндсэн хуульт хаант улс болохоо тогтоосон. 1952 оноос хойш Үндсэн хуульдаа хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Йорданы ард түмэн бол Араб үндэстний нэг хэсэг бөгөөд төрийн эрх мэдлийн үндэс нь ард түмэн бөгөөд Үндсэн хуулийн дагуу уг эрх мэдлийг ард түмэн эдэлнэ.

Төрийн тэргүүн нь Хаан бөгөөд ямар нэг хариуцлага, үүрэг хүлээхгүй бөгөөд хаан хуулийг соёрхон баталж, нийтэлдэг. Хаан зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба дайн зарлах, энх тайваны гэрээ батлах, Төлөөлөгчдийн танхим болон Сенатыг тараах эрхтэй. Хаан Ерөнхий сайдыг томилж бөгөөд Ерөнхий сайд бусад сайдыг хаантай зөвшилцөн томилдог.

Хаан Сенатын гишүүдийг мөн томилдог. Хаан өршөөл үзүүлэх, уучлах эрхтэй. Хууль тогтоох эрх мэдэл нь Үндэсний Ассамблей болон Хаанд олгогдсон. Гүйцэтгэх эрх мэдэл



Судалгааны эмхтгэл, Х боть

Хаан болон Үндсэн хуулийн дагуу хааны томилсон сайд нарт, шүүх эрх мэдэл хуулиар байгуулсан өөр өөр төрөл, шатны шүүхүүдтэй байна. Шүүхийн шийдвэр хааны нэрийн өмнөөс гаргадаг.

Хууль тогтоох журам

Хуулийн төслийг холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлээд дүгнэлт гаргадаг. Ерөнхий сайд Төлөөлөгчдийн танхимын даргад хүргүүлдэг байна. Хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим баталсны дараагаар Үндсэн хуульд заасан процедурын дагуу Сенатад хүргүүлдэг. Сенат хуулийг баталсны дараагаар Хаанд хүргүүлэн хаан соёрхон баталж албан ёсны сонинд нийтэлснээр хууль хүчин төгөлдөр болдог. Сенатаас хуулийн төсөл буцсан тохиолдолд Төлөөлөгчдийн танхим хуулийн төслийг эргэн хэлэлцдэг байна. Хаан хуулийн төсөлд хориг тавьсан тохиолдолд 2 танхим хоёулаа 2/3-оос доошгүй саналаар хуулийг баталж болдог байна.

КАЗАХСТАН

Бүгд Найрамдах Казахстан Улс (Republic of Kazakhstan)

Парламентын танхимуудын нэр: Казахстаны парламент нь Дээд танхим буюу Сенат, Доод танхим буюу Мажилис гэсэн байнгын үйл ажиллагаатай 2 танхимтай.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Сенатын гишүүнээр муж, нийслэл болон улсын чанартай хотуудын төлөөллийн байгууллагуудын хамтарсан хурлаас дээрхи субъект тус бүрээс 2 хүнийг сонгодог. 15 депутатыг Ерөнхийлөгч томилно. Сенатын депутатын бүрэн эрхийн хугацаа 6 жил бөгөөд 3 жил тутам депутатуудын тал хувийг шинээр сонгож, томилдог. Сенатын танхимын даргад төрийн албан ёсны хэлийг бүрэн эзэмшсэн хүнийг улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлнэ. Сенатын танхимын даргыг нууц санал хураалтаар танхимын нийт депутатын олонхийн саналаар сонгоно.

Мажилис нь 107 депутатаас бүрднэ. 98 депутатыг бүх ард түмний сонгуулиар, намын нэрсийн жагсаалтаар хувь тэнцүүлэх зарчмаар сонгох бөгөөд 9 депутатыг “Казахстаны ард түмний Ассамблей”-гаас сонгоно. Мажилисийн депутатын бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Мажилисын ээлжит сонгуулийг тухайн Мажилисын бүрэн эрхийн хугацаа дуусахаас хоёроос доошгүй сарын өмнө явуулна. Мажилисын дарга нь төрийн албан ёсны хэлийг чөлөөтэй эзэмшсэн, Мажилисын депутат хүн байх бөгөөд түүнийг танхимын депутатууд нэр дэвшүүлж нууц санал хураалтаар нийт депутатын олонхийн саналаар сонгоно. Парламентын депутатаар сүүлийн 10 жилийн турш Казахстан улсад байнга оршин сууж байгаа тус улсын иргэнийг сонгоно. Сенатын депутат нь дээд боловсролтой, 5-аас доошгүй жил ажилласан, төлөөлж буй хот, муждаа 3-аас доошгүй жил байнга оршин сууж байгаа 30 нас хүрсэн иргэн байна. Харин Мажилисийн депутатаар 25 нас хүрсэн иргэнийг сонгоно.

Бүрэн эрх

Хоёр танхим хамтран дараахь бүрэн эрхтэй: Танхимууд хамтарч болон тус тусдаа хуралдах бөгөөд хамтарсан хуралдаанаар Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, Засгийн газрын болон Тооцооны хорооны тайланг хэлэлцэх, Ерөнхийлөгчид зарим эрх мэдэл олгох, Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах, парламентын хоёр танхимын хамтарсан комиссыг байгуулах, тэдгээрийн илтгэл тайланг сонсож дарга нарыг нь сонгож, чөлөөлөх болон дайн энхийн асуудлыг хэлэлцдэг.

Хоёр танхим тус тусдаа хуралдахдаа Хууль батлах, төсвийн асуудлыг хэлэлцэх, татвар



хураамж тогтоох, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг батлах, өөрчлөх, ард нийтийн санал асуулга явуулах, өршөөл үзүүлэх, гэрээ хэлэлцээр соёрхон батлах, төрийн шагнал, цэргийн болон бусад цол бий болгох, улсын төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, улсын зээл, эдийн засгийн тусламж ба бусад тусламж дэмжлэгийн асуудлыг хэлэлцэх зэрэг асуудлыг Мажилис хэлэлцсэний дараа Сенатаар хэлэлцүүлнэ.

Түүнчлэн Парламент нь олон нийтийн харилцааг зохицуулахад ба үндсэн зарчмуудыг тогтооход хамгийн чухал хуулиудыг гаргах эрхтэй. Үүнд: хувь хүн ба хуулийн этгээдийн хуулийн эрхт байдал ба түүний үүрэг хариуцлага, иргэний эрх, эрх чөлөө, өмч өмчлөх нөхцлүүд ба бусад өмчлөх эрхүүд, улсын ба орон нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын, улсын ба цэргийн албаны тогтолцоо, зохион байгуулалт ба үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, татвар, татвар ногдуулах ба бусад албан журмын төлбөрүүдийг тогтоох, улсын нэгдсэн төсөв, шүүхийн тогтолцооны асуудлууд, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн байдал, аж үйлдвэрийн болон тэдний өмч хувьчлал, хүрээлэн буй орчны хамгаалалт, улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц, түүнчлэн улсын батлан хамгаалах ба аюулгүй байдлыг хангах зэрэгтэй хамааралтай хуулиуд орно.

Дээд танхим буюу Сенат нь дараахь онцгой эрхтэй: Дээд шүүхийн дарга, гишүүдийг Ерөнхийлөгчийн санал болгосноор сонгох, чөлөөлөх, Үндэсний банкны дарга, Ерөнхий прокурор, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн даргыг томилсон Ерөнхийлөгчийн томилгоог зөвшөөрөх, Ерөнхий прокурор, Дээд шүүхийн дарга гишүүдийн халдашгүй байдлыг цуцлах зэрэг асуудлууд хамрагддаг. Мөн Мажилисын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд дараагийн Мажилис бүрдэх хүртэл хууль батлах үүргийг дангаараа гүйцэтгэх эрхтэй.

Доод танхим буюу Мажилис нь дараахь онцгой эрхтэй: Хуулийн төслийг хүлээн авч хэлэлцэх, Ерөнхий сайдыг томилсон Ерөнхийлөгчийн томилгоог зөвшөөрөх, Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зарлах зэрэг асуудлууд хамаарна.

Төрийн дээд эрхийг барих субъект

Холимог засаглалтай (Ерөнхийлөгчийн болон парламентын) бүгд найрамдах улс. Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл. Казахстаныг Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс хэмээн тунхаглаж, засаглал хуваах зарчмыг тодорхойлон, парламентыг хоёр танхимтай байхаар тогтоож “парламент нь хууль тогтоох эрх мэдэл бүхий төлөөллийн дээд байгууллага мөн” гэж заажээ.

Хууль тогтоох журам

Мажилисын хүлээн авч хэлэлцээд олонхиороо дэмжсэн хуулийн төслийг Сенат 60 хоногийн дотор хэлэлцэх бөгөөд Сенатын гишүүдийн олонхийн дэмжлэг авбал хуулийг батлагдсанд тооцон 10 хоногийн дотор Ерөнхийлөгчид гарын үсэг зуруулахаар танилцуулна. Сенатын нийт гишүүдийн олонхийн дэмжлэг аваагүй хуулийн төслийг Мажилист буцаах бөгөөд Мажилисийн нийт гишүүдийн гуравны хоёр нь уг хуулийн төслийг дахин дэмжвэл Сенатаар хэлэлцүүлж санал хураалгахаар шилжүүлнэ. Хэрэв Сенат дахин буцаавал тухайн чуулганы хугацаанд уг хуулийн төслийг хэлэлцэхгүй.

Сенатын нийт гишүүдийн олонхи хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулбал уг төслийг Мажилист шилжүүлэх бөгөөд танхимын нийт гишүүдийн олонхи нь нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрснөөр хуулийг батлагдсанд тооцно. Хэрэв танхимын олонхи дээрх нэмэлт, өөрчлөлтийг хүлээж авахгүй бол асуудлыг зөвшилцөн шийдвэрлэнэ. Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа танхим тус бүрийн нийт депутатын гуравны хоёрын дэмжлэгээр шийдвэрлэнэ. Хуулинд Ерөнхийлөгч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог.



КАМБОЖИЙН ВАНТ УЛС

Камбож нь либераль ардчилал, олон ургальч үзлийг Үндсэн хуулийнхаа зарчим болгосон Үндсэн хуульт хаан засагтай, парламентын улс. 1993 он хүртэл Камбожийн парламентын бүтэц хэд хэдэн удаа өөрчлөгдсөн. 1947-1970 онд хаант засагтай байх үед болон 1970-1975 онд бүгд найрамдах засагтай болоход парламент нь хоёр танхимтай байсан. Харин 1975-1979 онд Улаан Кхмерүүд төр барьж байхад болон 1979-1993 онд нэг танхимтай болсон байна. 1993 онд Үндэсний Ассамблейг байгуулсан. 1999 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан Сенатын танхимыг байгуулж хууль тогтоох байгууллагыг хоёр танхимтай болгожээ.

Парламентын дээд танхим нь Сенат (Senate), Доод танхим нь Үндсэний Ассамблей (National Assembly). Үндэсний Ассамблей нь 123 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 5 жил. Байнгын хороодын зохион байгуулалттай. Парламентын дотоод дэгийн дагуу шаардлагатай асуудлаар комисс байгуулан ажиллуулдаг.

1993 оны 9 дүгээр сарын 21-ны өдөр батлагдсан Үндсэн хуулийн долоодугаар бүлгийн 90 дүгээр зүйлд заасны дагуу Үндэсний хурал нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх бөгөөд Үндсэн хууль, бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Энэхүү бүрэн эрхийг ямар ч байгууллага хувь хүнд шилжүүлж үл болох.
- Үндэсний хурал нь үндэсний төсөв, төрийн төлөвлөгөө зээл, санхүүгий гэрээ, татвар бий болгох, өөрчлөх, хүчингүй болгох.
- Үндэсний хурал нь захиргааны тайланг батлах.
- Үндэсний хурал ерөнхий өршөөлийн хуулийг батлах.
- Үндэсний хурал нь олон улсын гэрээг цуцлаж мөн байгуулах.
- Үндэсний хурал нь дайн зарлах тухай хуулийг батлах.

Дээр дурьдсан асуудлаар шийдвэр гаргахдаа Үндэсний хурлын гишүүдийн туйлын олонхи шийдвэрлэнэ. Үндэсний хурал нь Засгийн газарт итгэл үзүүлэх асуудлыг бүх гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ.

Сенатын танхим нь 6 жилийн хугацаатай сонгогддог 61 гишүүнтэй. Үндэсний Ассамблейн үндсэн чиг үүрэг нь хууль, парламентын бусад шийдвэр батлан гаргах, парламентын дотоод дэгийн хүрээнд гадаадын орны парламент хоорондын харилцааны асуудлыг хамаардаг. үндэсний төсөв, төрийн төлөвлөгөө, зээл зэрэг асуудлыг баталдаг байна.

Үндэсний Ассамблей хугацаанаасаа өмнө тарах ёсгүй ч 12 сарын дотор Засгийн газар хоёр удаа огцорсон тохиолдолд Ерөнхий сайдын саналаар Үндэсний Ассамблейн даргын зөвшөөрснөөр Хаан Үндэсний Ассамблейг тараах эрхтэй. Үндэсний Ассамблейн гишүүд болон Ерөнхий сайд хууль санаачлах эрхтэй. Үндэсний Ассамблейн баталсан хуулийг Хаан соёрхон баталж төрийн сонинд нийтэлснээр хүчин төгөлдөр болдог.

Үндэсний Ассамблейн гишүүдийг олон мандаттай 21 тойргоос намын жагсаалтаар, сонгогчдын өгсөн саналыг пропорционал сонгуулийн системээр явуулдаг. Сенатын танхимын 61 гишүүний 2 гишүүнийг Хаан томилдог. 2 гишүүнийг Үндэсний Ассамблейгаас сонгодог. 57 гишүүнийг засаг захиргааны нэгж болох хороо, багийн зөвлөлийн (Commune/Sangkat Councillors) гишүүдээс шууд бусаар сонгодог.

Ашигласан материал:

Цахим хуудас: <http://www.national-assembly.org.kh/>

<http://www.senate.gov.kh/>

МАЛАЙЗ

Малайзын Холбооны Улс

Парламентын танхимуудын нэр: Доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим (Dewan Rakyat 8 House of Representatives), Дээд танхим буюу Сенатын танхим (Dewan Negara).

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Төлөөлөгчдийн танхимын 222 гишүүнийг шууд сонгох ба сонгуулийг нэг мандаттай 222 тойргоос энгийн олонхийн саналаар 5 жилийн хугацаатай сонгодог. Сенатын танхим нийт 70 сенатортай. Сенаторуудын 28,13 хувь буюу 18 нь эмэгтэй сенатор байна. 26 сенаторыг шууд бус буюу муж улсын хууль тогтоох хурлаас сонгоно. Эдгээр 26 сенаторыг олон мандаттай 13 тойргоос, 44 сенаторыг улсын тэргүүн буюу хаан томилдог.

Бүрэн эрх:

- Нутаг дэвсгэр дээр хүчин төгөлдөр үйлчлэх хууль тогтоомж батлах
- Засгийн газрын санхүүгийн үйл ажиллагааг хянах
- Нийт үндэстний ач холбогдол бүхий асуудлаар олон нийтийн санал бодлыг илэрхийлэх
- Зарим эрх бүхий албан тушаалтныг томилох

Төрийн дээд эрхийг барих субъект: Төрийн тэргүүн нь Малайзын Хаан

Хууль тогтоох журам: Хууль парламентын 2 танхимаар орж батлагдах ба Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Хаан соёрхон баталснаар хүчин төгөлдөр болно. Хууль батлахдаа 2 танхим тус бүр дараах 4 үе шатаар хэлэлцэнэ.

- Анхны хэлэлцүүлэг
- 2 дугаар хэлэлцүүлэг
- Хорооны үе шат
- 3 дугаар хэлэлцүүлэг

Дээрхи үе шатаар дамжин хэлэлцүүлэгдэж 2 танхимаас батлагдсан хуулийг Хаан соёрхон баталж хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр болно. Хаан 30 хоногийн дотор соёрхон батална.

<http://www.parliamen.gov.my/index.php?lang=en>


ОМАН УЛС

Оманы Султант улсын хууль тогтоох эрх мэдлийг Султан болон хоёр танхим бүхий парламент хэрэгжүүлдэг. Оман Улсын парламентыг Оманы зөвлөл (Majlis Oman) гэж нэрлэдэг байна.

- Төрийн зөвлөл (72 гишүүнтэй) Majlis Addawla
- Зөвлөх зөвлөл (84 гишүүнтэй) Majlis Shura

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Дээд танхим: Султаны зарлигаар 4 жилийн хугацаагаар томилдог 72 гишүүнтэй. Нөгөө танхимын гишүүдийн тооноос илүү гарч болохгүй гэсэн байна. Дээд танхим нь сайд, элчин сайд байсан хүмүүсээс бүрддэг байна. Энэ танхимд 40 нас хүрсэн, ямар нэгэн ял шийтгэл



Судалгааны эмхтгэл, Х боть

эдэлж байгаагүй, тухайн улсын иргэн сонгогдох эрхтэй байдаг байна. Сонгуулийн дараах чуулганы анхдугаар хуралдааныг Султан удирдаж, дээд, доод танхимын дарга, дэд дарга нар, Ерөнхий нарийн бичгийн даргыг томилно. Доод танхимын Даргын товчоо дарга, дэд дарга, 6 гишүүнээс бүрдэнэ.

Доод танхим: Бүх ард түмнээс 4 жилийн хугацаагаар шууд сонгогддог 84 гишүүнтэй. 30 000 болон түүнээс дээш хүн амтай тойргоос 2 гишүүн, 30 000-аас доош хүн амтай тойргоос 1 гишүүн сонгодог байна. Оман улсын иргэн, хуулиар заасны дагуу нэр дэвших болзлыг хангасан 30 насанд хүрсэн, ял шийтгэлгүй, зохих ёсны боловсрол эзэмшсэн, дадлага туршлага бүхий иргэнийг нэр дэвшүүлнэ. Бүрэн эрхийн хугацаа 4 жил (улиран сонгогдох эрхтэй) Consultative Council-ийн гишүүн болон төрийн албанд байж болохгүй гэж заасан байна.

Бүрэн эрх

Дээд танхимын бүрэн эрх. Парламентын дээд танхим хууль тогтоохгүй, зөвхөн Султаанд зөвлөх чиг үүрэгтэй байна. Оман Улсын парламентын хууль тогтоох эрх мэдэл, хяналтын чиг үүрэг нь нэлээд бэлгэдлийн шинжтэй байна. Санхүү, захиргааны хувьд бие даасан хараат бус байдаг. Үндэсний хөгжил дэвшил, Засгийн газар болон ард түмний харилцааг зохицуулах үүрэгтэй. Төрийн зөвлөл нь улс орны ерөнхий бодлогыг тодорхойлдог. Султаны санал болгосноор хуралддаг байна.

Доод танхимын бүрэн эрх. Парламентын доод танхим өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хууль тогтоох, Засгийн газраас хэрэгжүүлэх тодорхой асуудлын талаар мэдээлэл авах, эдийн засаг нийтийн үйлчилгээг боловсронгуй болгох чиглэлээр өөрийн байр сууриа илэрхийлэх, Сайдуудад зориулсан шийдвэрлэвэл зохих асуудлаар багц зөвлөмж боловсруулж, Султанд танилцуулах, Сайдуудын жил бүрийн илтгэл, хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай гэж үзвэл хэлэлцүүлэг, санал бодлоо солилцох зэргээр төрийн бодлогыг боловсруулах, шийдвэрлэхэд оролцдог байна. Хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд хууль, тогтоомжийн актуудыг батлан гаргах, эдийн засаг, нийгмийн харилцааг шинэчлэх, боловсронгуй болгоход чиглэгдсэн зохицуулалтын талаархи саналаа Султанд танилцуулж шийдвэрлүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Төрийн дээд эрхийг барих субъект

Султан төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Султан Ерөнхий сайд, сайдууд, энэ хууль болон хууль тогтоомжид заасан иргэний болон цэргийн өндөр албан тушаалтныг томилж, чиг үүргийг нь тодорхойлно. Султан хууль, олон улсын гэрээ соёрхон батлах, хуулийн хүчинтэй зарлиг гаргах, уучлал үзүүлэх, шагнах, Сайд нарын Зөвлөл болон бусад зөвлөлийн хуралдааныг даргалах эрх эдэлнэ.

Хууль тогтоох журам

Хуулийн төсөлд холбогдох Байнгын хороо нь тухайн асуудал дээр (яаралтай тохиолдолд заасан хугацаанд) бусад тохиолдолд 3 сар тухайн төсөл дээр ажилладаг. Шаардлагатай гэж үзвэл хуулийн төслийг боловсруулсан ажлыг хэсгийг хуралдуулдаг байна. Хамгийн сүүлд Тухайн хуулийн төсөлтэй холбогдох Байнгын хороо нь Хууль эрх зүйн байнгын хороотой хамтран эцсийн байдлаар хуулийн төслийг боловсруулна. 2 байнгын хороодын хуулийг хамтран боловсруулах хугацаа нь 14 хоногоос ихгүй байна.

Хуулийн төслийг доод танхим буюу Majlis Shura хэлэлцэн өөрсдийн саналыг оруулдаг. Нийтийн эрх ашгийг хөндсөн хуулийг батлах эрх нь Султанд байдаг байна. Дээд танхим буюу Majlis Addawla нь Султаны батлах хуулинд зөвлөх үүрэгтэй. Султаны батлах хууль нь хүний хөгжлийг дэмжих асуудал дээр тулгуурладаг байна. Засгийн газраас өргөн барьсан

хуулийн төслийг баталдаг байна. Засгийн газрын тэргүүн нь Султан байдаг байна.

ПАКИСТАН

Лалын Бүгд Найрамдах Пакистан улс (The Islamic Republic of Pakistan)

Парламентын танхимуудын нэр

Пакистаны хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч парламент нь Ерөнхийлөгч болон дээд, доод гэсэн 2 танхимаас бүрддэг. Пакистаны Ерөнхийлөгч нь Парламентынхаа бүтэц ордог. Парламентын дээд танхим нь Сенат (Senate), доод танхим нь Үндэсний Ассамблей (National Assembly) юм.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Үндэсний Ассамблей нь 342 гишүүнтэй бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь 5 жил. Үндэсний Ассамблейн гишүүнийг 2002 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн баталсан сонгуулийн хуулийн дагуу сонгодог ба гишүүдийг шууд, нэг суудалтай олон /272/ тойргоос энгийн олонхийн аргаар сонгодог. Үндэсний Ассамблейн 342 суудлын 60-ыг эмэгтэй гишүүнд, 10-ыг Мусульман бус цөөнхид хуваарилсан. Сонгох нас 21, сонгогдох нас 25. Санал өгөх эрх сайн дурынх байна.

Сенат нь 100 гишүүнтэй бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь 6 жил боловч хагас нь 3 жил тутамд өөрчлөгддөг. Сенатын танхимын 100 гишүүнийг шууд бусаар сонгодог. Сенатын танхимын гишүүдийг 4 мужаас муж болгоны Ассамблейгаас 22 гишүүнийг сонгох ба тэдгээрийн 4 нь Үндсэн хуульд зааснаар эмэгтэй, 4 нь технократ байна. 8 гишүүнийг Холбооны удирдлага дахь Омог (The Federally Administered Tribal Areas)-ийг төлөөлүүлэн сонгодог. 4 гишүүнийг Холбооны нийслэл Исламабадаас сонгох ба 1 нь эмэгтэй байх, 1 нь технократ байна. Сенатын гишүүнийг сонгох сонгууль нь нэг шилжих саналтай, төлөөлөн хувь тэнцүүлэх аргаар явагддаг. Сонгогдох нас 30-аас эхэлдэг.

Бүрэн эрх

Хоёр танхим хамтран дараахь бүрэн эрхтэй: Парламент нь хуулийн төсөл хэлэлцэх, үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Мөн Үндсэн хуульд заасны дагуу бусад олон чухал чиг үүрэгтэй. Тухайлбал, Ерөнхийлөгчийг сонгох, Ерөнхийлөгчийн импичмент эсхүл чөлөөлөх асуудал, Үндэсний Ассамблей нь Кабинетэд итгэл хүлээлгэх асуудлыг хариуцдаг. Доод танхим буюу Үндэсний Ассамблей нь дараахь онцгой эрхтэй:

Төсөв, санхүүгийн хуулийн төслийг гаргах ба Сенат руу явуулан 7 хоногийн дотор Сенатаас зөвлөмж хүлээн авах ба Үндэсний Ассамблей тэр зөвлөмжийг нь хэлэлцэн (Сенатын зөвлөмжийг заавал хэлэлцэх шаардлагагүй) хуулийн төслийг батлан Ерөнхийлөгчөөр батлуулахаар танилцуулах онцгой эрхтэй. Төсөв, санхүүгийн хуулийн төсөлд татвар, татвар ногдуулалт, Холбооны Засгийн газрын зээл, Холбооны Нэгдсэн Нөөцийн (Federal Consolidated Fund) хадгаламж, Холбооны Засгийн газар эсвэл Мужын Засгийн газрын санхүүгийн аудит зэргийн асуудалтай холбоотой хуулийн төслүүд орно.

Төрийн дээд эрхийг барих субъект

Пакистан нь Холбооны Бүгд Найрамдах Улс бөгөөд Исламын Бүгд Найрамдах Улс гэнэ. Исламын шашинтай ардчилсан парламентын холбооны бүгд найрамдах улс. Пакистаныг хагас ерөнхийлөгчийн засагтай парламентын улс гэдэг. Учир нь Пакистаны Ерөнхийлөгч нь нэлээд өргөн эрх мэдэлтэй байдаг. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд бүгд найрамдах улсын нэгдмэл байдлын бэлгэдэл мөн.

Хууль тогтоох журам

Хуулийн төслийг аль нэг танхим хэлэлцэн олонхиор батлавал, түүнийг нөгөө танхимдаа хүргүүлдэг. Нөгөө танхим ямар нэг өөрчлөлтгүй хуулийг баталвал хуулийг Ерөнхийлөгчид соёрхон батлуулахаар хүргүүлдэг. Хэрэв аль нэг танхимын баталсан хуулийн төсөл нөгөө танхимдаа ирээд 90 өдрийн дотор батлагдаагүй эсхүл татгалзсан, эсхүл нэмэлт, өөрчлөлт орсон бол анх хуулийн төслийг баталсан танхимын шаардлагаар Ерөнхийлөгч хоёр танхимын хамтарсан хуралдааныг зарлан уг хуулийн төслийг хэлэлцүүлнэ. Хамтарсан хуралдаанаар бүх гишүүний олонхийн саналаар хуулийн төсөл нэмэлт, өөрчлөлтгүй эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулан баталвал Ерөнхийлөгчид соёрхон батлуулахаар хүргүүлдэг. Хуулийг парламентаар баталсаны дараа Ерөнхийлөгч 30 хоногийн дотор соёрхон батална.

ТАЖИКИСТАН**Бүгд Найрамдах Тажикистан Улс**

Парламентын танхимуудын нэр: Парламент нь 2 танхим бүхий Мажилис Оли. Доод танхим буюу Мажилиси намояндагон, Дээд танхим буюу Мажилиси милли.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Парламентын доод танхим нь байнгын ажиллагаатай бөгөөд 63 депутатай. Энэ танхимын депутатууд холимог тогтолцоогоор, тойргоор сонгогддог. Харин дээд танхимын гишүүдийн дөрөвний гурав нь тухайн бүс нутгийн төлөөллийн бүх байгууллагын хурлаас сонгогдож, харин дөрөвний нэгийг Ерөнхийлөгч томилдог. Мажилиси милли нь 34 гишүүнтэй. Доод танхим нь ард түмнийг төлөөлдөг бол дээд танхим нь бүс нутгуудыг төлөөлдөг. Мажилис Олигийн депутатууд 5 жилээр сонгогддог.

Бүрэн эрх:

- Хууль, тогтоол батлах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох
- Үндсэн хууль болон хууль тайлбарлах
- Засгийн газрын үндсэн чиглэлийг тодорхойлох
- Сонгуулийн төв хороог байгуулах
- Парламентын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн товийг зарлах
- Хуулийн төсөл болон Засгийн газар, орон нутгийн чухал асуудлаар олон нийтийн санал асуулга зарлах
- Дээд болон орон нутгийн төлөөлөгчдийн байгууллагын сонгуулийн товийг тогтоох
- Ерөнхий сайд болон Засгийн газрын бусад гишүүдийг хүлээн авах, ажлаас чөлөөлөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батлах
- Үндэсний банкны дарга болон түүний төлөөлөгчийг томилох, ажлаас чөлөөлөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батлах
- Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, эдийн засгийн шүүхийн дарга, шүүгчдийг сонгох, эгүүлэн татах тухай Ерөнхийлөгчийн хүсэлт
- Ерөнхий Прокурор болон түүний орлогчийг томилох, ажлаас чөлөөлөх зөвшилцөх
- Улсын төсөв, мөнгөний бодлого болон бусад бодлогын баримт бичиг батлах
- Төрийн бэлэг тэмдгийн батлах
- Өршөөл үзүүлэх

Доод танхим:

- Ерөнхийлөгчийн саналаар Сонгуулийн төв хороог байгуулах, дарга, төлөөлөгч, гишүүнийг өөрчлөх
- Улсын өр зээлийг хүлээн авах, эргүүлэн төлөх асуудал
- Олон улсын гэрээ, хэлэлцээрийг зөвшөөрөх, батлах, хүчингүй болгох
- Бүх нийтийн санал асуулга явуулах
- Шүүх байгуулах
- Төрийн шагнал урамшууллыг батлах
- Үндэсний банкны дарга, түүний төлөөлөгчийг чөлөөлөх болон томилох Ерөнхийлөгчийн зарлигийг батлах
- Цэргийн, дипломат цол болон онцгой цолны талаар зөвлөх
- Үндсэн хууль болон хуулиар олгосон бусад бүрэн эрх

Төрийн дээд эрхийг барих субъект:

Төрийн тэргүүн нь Тажикстаны Ерөнхийлөгч байна.

Хууль тогтоох журам

Доод танхим Үндсэн хуулинд өөрөөр заагаагүй бол хуулийг нийт депутатын олонрийн саналаар хуулийг батлана. Доод танхимаас баталсан Улсын төсөв ба өршөөлийн хуулиас бусад бүх хуулийг Дээд танхимд хүргүүлнэ. Хэрэв дээд танхим нийт гишүүдийнхээ олонхиор дэмжвэл хуулийг дээд танхим дэмжлээ гэж үзнэ. Хэрэв дээд танхим хуулийг дэмжээгүй бол доод танхим дахин хэлэлцэнэ.

оод танхим дээд танхимын шийдвэртэй санал нийлээгүй бөгөөд уг төслийг дахин 2/3-аас доошгүйн саналаар баталвал уг хуулийг батлагдсан гэж үзнэ. Үүний дараа хуулийг ёсчлуулахаар ерөнхийлөгчид хүргэнэ. Хэрэв ерөнхийлөгч хууль буюу түүний аль нэг хэсэгтэй санал нийлэхгүй байвал 15 хоногийн дотор доод танхимд буцаана. Энэ тохиолдолд дээд, доод танхимууд дахин хуулийн төслийг хэлэлцэж аль аль нь нийт гишүүдийн 2/3-аас доошгүйн саналаар баталвал ерөнхийлөгч 10 хоногийн дотор хуульд гарын үсэг зурна. Улсын төсвийн хууль болон өршөөлийн хуулийг зөвхөн доод танхим хэлэлцэж батлана.

www.parlament.tj

<http://www.majlisimilli.tj/ru/>

ТАЙЛАНДЫН ВАНТ УЛС

Тайланд улс нь Үндсэн хууль хаант засагтай парламентын улс. Үндсэн хуулиараа хаан нь төрийн тэргүүн байх ба засгийн эрх мэдлийг ардчилсан дэглэмтэй байхыг заасан. 2007 оны 11 дүгээр сард батлагдсан Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлгийн 88 дугаар хэсэгт заасны дагуу Үндэсний хурал нь Төлөөлөгчдийн танхим ба Сенатаас бүрдэнэ.

Тайландын парламент нь Төлөөлөгчдийн танхим (Доод танхим-House of Representatives, Saphaphuthan Ratsadon), Сенатын танхим (Дээд танхим-Senate, Wuthisapha) гэсэн хоёр хууль тогтоох танхимтай. Үндэсний Ассамблейн дарга нь Төлөөлөгчдийн танхимын дарга, Сенатын танхимын дарга Үндэсний Ассамблейн дэд дарга байна гэж Үндсэн хуульдаа заасан. Нэг хүн зэрэг Төлөөлөгчдийн болон Сенатын танхимын гишүүн байж болохгүй. Үндсэн хуулийн дагуу Үндэсний Ассамблей нь Төлөөлөгчдийн болон Сенатын хамтарсан болон салангид хуралдаанаар чуулах бөгөөд хамтарсан хуралдааны үйл ажиллагааг журмаар зохицуулахаар заасан байна.

Үндсэн хуулийн 136 дугаар зүйлд заасны дагуу дараахь тохиолдолд Төлөөлөгчдийн танхим болон Сенатын танхим хамтарсан хурал хийнэ. Үүнд:



Судалгааны эмхтгэл, X боть

- Эзэн хааны томилгоог батлах
- Эзэн хааны алба, үндэсний хуралд мэдүүлэг өгөх
- Ордны өв залгамжлалын хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлах
- Хаан ширээ залгамжилсныг батлах

Уг Үндсэн хуулийн 90 дугаар хэсэгт заасны дагуу Хууль болон хуулийн төсөл Үндэсний хурлаар батлагдах бөгөөд эзэн хаан гарын үсэг зурснаар, төрийн хэвлэлд нийтлэгдэж хууль хүчин төгөлдөр болно.

Төлөөлөгчдийн танхим 480 гишүүнээс бүрддэг бол Сенатын танхим нь 150 гишүүнтэй. Хууль тогтоох гол чиг үүрэгтэй. Хуулийн төслийг эхлээд Төлөөлөгчдийн танхим нэмэлт, өөрчлөлт оруулан эсхүл шууд хэлэлцээд Сенатын танхимд хүргүүлдэг байна. Сенатын танхим уг төслийг 60 хоногийн дотор хэрэв мөнгөтэй холбоотой төсөл бол 30 хоногийн дотор хэлэлцэх ба дахин хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл Төлөөлөгчдийн танхимд буцаадаг байна.

Төлөөлөгчдийн танхим сонгууль олон мандаттай олон тойргоос гишүүдийг 4 жилийн хугацаатай сонгодог. Гэхдээ 400 гишүүнийг олонхийн аргаар, 80 гишүүнийг хувь тэнцүүлэх аргаар сонгодог байна. Төлөөлөгчдийн танхимын 2007 оны 12 дугаар сарын 23-ны өдөр болсон сонгуулиар 56 эмэгтэй гишүүн сонгогдсон. Тайландын Үндсэн хууль нь Төлөөлөгчдийн танхимын сонгуулийн талаар нэлээд нарийн зохицуулалтыг тусгасан байдаг байна.

Сенатын танхим нь 150 гишүүнтэй бөгөөд 76 гишүүнийг шууд олонхийн аргаар сонгодог бол 74 гишүүнийг нь шууд бусаар Сенатын гишүүнийг сонгох хороо сонгодог байна. Сенатын гишүүнийг сонгох хороо нь Үндсэн хуулийн шүүхийн дарга, Сонгуулийн хорооны дарга, Омбудсмануудын ерөнхийлөгч, Үндэсний авилгатай тэмцэх комиссын дарга, Төрийн аудитын комиссын дарга, Дээд шүүхийн шүүгч нараас бүрддэг байна. Сенатын танхимын гишүүдийг 6 жилийн хугацаатай сонгодог.

Цахим хуудас:

<http://www.parliament.go.th>

<http://www.senate.go.th/>

УЗБЕКИСТАН

Узбекистаны төрийн эрх барих дээд байгууллага нь 5 жилээр сонгогддог хоёр танхимтай парламент-Олий Мажлис юм.

- Сенат
- Хууль тогтоох танхим

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Бүс нутгийг төлөөлж буй Сенатын гишүүнээр Каракалпакын Бүгд найрамдах улс, мужууд болон Ташкент хотын төлөөллийн байгууллагуудын хурлаас тус бүр 6 хүнийг сонгоно. Мөн шинжлэх ухаан, урлаг, утга зохиол, аж үйлдвэр, төр, нийгмийн салбарт онцгой гавьяа байгуулсан, нэр хүнд, туршлага бүхий иргэдээс 16 хүнийг Ерөнхийлөгч томилно. Бүрэн эрхийнхээ хугацааг дуусгаж чөлөөлөгдсөн Ерөнхийлөгч бүх насаараа Сенатын гишүүн байна.

Олий мажлисын доод танхим буюу Хууль тогтоох танхим нь Узбекистаны ард түмнийг төлөөлж олон намын үндсэн дээр сонгуулийн нутаг дэвсгэрийн тойргуудаас мажоритар тогтолцоогоор сонгогдсон 120 депутатаас бүрдэнэ. Доод танхимын депутатаар 25 насанд хүрсэн, сүүлийн 5 жил тус улсад амьдарсан Узбекистаны иргэнийг сонгоно.

Бүрэн эрх

Үндсэн хууль, бусад хуулиудыг батлах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, гадаад, дотоод бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлох, төрийн стратегийн хөтөлбөрийг батлах, Ерөнхий сайд болон Сайд нарын танхимын гишүүдийг томилох тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батламжлах, Узбекистан улсын Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх болон Аж ахуйн Дээд шүүхийг сонгох, Ерөнхий прокурор болон түүний орлогч нарыг томилох буюу огцруулах тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн Төв банкны даргыг томилох буюу албан тушаалаас нь чөлөөлөх, онц байдал зарлах, бүрэн буюу хэсэгчилсэн цэрэг татлага явуулах тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, Сайд нарын танхимын зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах зэрэг бүрэн эрхүүд багтана.

Төрийн дээд эрхийг барих субъект

Хууль тогтоох танхим болон Сенатын хооронд тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг тогтворгүй болгох шийдвэрлэшгүй санал зөрөлдөөн үүссэн үед болон хоёр танхим Үндсэн хуульд харшилсан шийдвэрийг нэг бус удаа гаргасан бол Хууль тогтоох танхим болон Сенатыг тус улсын Үндсэн хуулийн шүүхтэй зөвшилцсөний үндсэн дээр Ерөнхийлөгч тарааж болно.

Хууль тогтоох журам

Хууль санаачлах эрх ерөнхийлөгч, Сенатад байдаг байна. Хууль тогтоох танхимаар хэлэлцэн батлагдаад Сенат дэмжиж, Ерөнхийлөгч гарын үсэг зурж, албан ёсны хэвлэлд нийтэлснээр хууль хүчин төгөлдөр болдог байна. Хууль тогтоох танхимд батлагдсан хуулийг 10 хоногийн дотор Сенат батлаад мөн 10 хоногийн дотор Ерөнхийлөгч гарын үсэг зурж баталдаг байна.

Сенатын танхим дэмжихгүй бол Хууль тогтоох танхимд хуулийн төсөл эргэн хүргэгдэнэ. 2 дахь удаа буцаж ирсэн тохиолдолд Хууль тогтоох танхимын нийт гишүүдийн 2/3-ын саналаар Ерөнхийлөгчид илгээнэ. Ерөнхийлөгч хуулийн төслийг дэмжиж болно. Татгалзаж буцаасан тохиолдолд татгалзлын бичигтэй буцаадаг байна. Буцаж ирсэн хуулийг аль аль танхим 2/3-оос доошгүй саналаар ирсэн хуулийг 14 хоногийн дотор Ерөнхийлөгч заавал баталдаг байна.

БҮГД НАЙРАМДАХ ФИЛИППИН УЛС

Филиппин Улс нь нэгдмэл бөгөөд төрийн удирдлагын хэлбэрийн хувьд ерөнхийлөгчийн засагтай Бүгд Найрамдах улс юм. Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1-д зааснаар хууль тогтоох эрх мэдэл Филиппиний Конгресст хадгалагддаг. 1900-1907 онд Филиппин нь Америкийн колони байхад Филиппиний хууль тогтоох байгууллага нь Филиппиний комисс гэж байсан бөгөөд түүний гишүүдийг АНУ-ын Ерөнхийлөгч томилдог байсан. 1987 онд шинэ Үндсэн хууль баталснаар өнөөгийн тогтолцоонд шилжин орсон байна. Филиппин нь улс төрийн түүхийн хувьд 5 дахь Филиппиний Бүгд найрамдах улс гэж үздэг бөгөөд 15 дахь конгресс нь үйл ажиллагаагаа явуулж байна.

Филиппиний Конгресс нь Төлөөлөгчдийн танхим (доод танхим), Сенатын танхим (дээд танхим) гэсэн 2 танхимаас бүрддэг. Сенатын танхим нь 24 гишүүнээс бүрддэг бөгөөд Сенатын танхимын бүрэн эрхийн хугацаа нь 6 жил. Үндсэн хуульдаа Төлөөлөгчдийн танхим нь 250-аас ихгүй гишүүнтэй байхаар заасан бөгөөд харин хуулиар 250-аас олон гишүүнтэй байхаар зохицуулж болно. Уг танхимын бүрэн эрхийн хугацаа 3 жил.

1987 онд батлагдсан Үндсэн хуулийн дөрөвдүгээр зүйлийн 23 дугаар хэсэгт зааснаар



Конгресс нь хоёр танхимын гуравны хоёроос илүүгүй саналтай хамтарсан хуралдаанаар тус тусдаа санал хурааж дайны байдал зарлана. Мөн уг хуулийн 24 дүгээр хэсэгт зааснаар Төрийн мэдэлд өмч хөрөнгө авах, татвар, төлбөрийн хэмжээ тогтоох, орон нутгийн хууль тогтоомж, засгийн газрын өрийг нэмэгдүүлэх, болон тусгай хуулиудыг зөвхөн Төлөөлөгчдийн танхим гаргах бөгөөд Сенат нь түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал оруулж болно.

Хууль тогтоох чиг үүргээс гадна Үндсэн хуулиар олгогдсон нилээд олон бүрэн эрхийг танхимууд хэрэгжүүлдэг. Бүх хуулийн төсөл конгрессоор дамжин хууль болох бөгөөд түүний дараа Ерөнхийлөгчид хүргэгддэг. Конгресс нь гүйцэтгэх эрх мэдлийн зарим албан тушаалтныг томилох, чөлөөлөх, Засгийн газрын үйл ажиллагаанд сангуудыг хуваарилах, улсын төсөв батлах, татвар тогтоох гэх мэт нилээд чиг үүрэгтэй. Харин олон улсын гэрээг батлах нь Сенатын бүрэн эрхэд хамаардаг.

Төлөөлөгчдийн танхим нь 287 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 20 хувийг намын жагсаалтаар, 80 хувийг нэг мандаттай 219 тойргоос олонхийн саналаар сонгодог. Харин үлдсэн 20 хувийг намын жагсаалтаар 2 хувийн босготойгоор улсыг нэг тойрог болгон хувь тэнцүүлэх аргаар сонгодог байна. 2010 оны 5 дугаар сарын сонгуулиар 229 гишүүн сонгогдсон байгаа бөгөөд тэдгээрийн 49 нь эмэгтэй гишүүн байна. Төлөөлөгчдийн танхимын гишүүнд нэр дэвшигч 25 нас хүрсэн, Сенатын танхимын гишүүнд нэр дэвшигч 35 нас хүрсэн байх шаардлага тавьдаг. Сенатын танхимын 24 гишүүнийг улсыг нэг тойрог болгон шууд олонхийн саналаар 6 жилийн хугацаатайгаар сонгодог.

Цахим хуудас:

<http://www.congress.gov/ph/>

<http://www.senate.gov/ph/>

ЭНЭТХЭГ

Бүгд Найрамдах Энэтхэг Улс

Парламентын танхимуудын нэр: Доод танхим буюу Ардын танхим (Lok Sabha), Дээд танхим буюу Муж улсуудын зөвлөл (Rajya Sabha).

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо: Парламентын доод танхим бүх ард түмнээс шууд сонгогддог 543, Энэтхэгийн Англичуудын нийгэмлэгээс Ерөнхийлөгч томилдог 2, нийт 545 гишүүнтэй. Доод танхимын даргыг (шаардлагатай гэж үзвэл дэд даргыг) сонгуулийн дараа Ерөнхийлөгчийн зарлан хуралдуулсан анхдугаар чуулганы эхний хуралдаанаар гишүүдээс 5 жилийн хугацаагаар сонгодог.

Дээд танхимын нийт 245 гишүүний гуравны нэг хувь нь 2 жил тутамд шинэчлэгдэн сонгогддог. Дээд танхимын даргаар улсын дэд ерөнхийлөгч албан тушаалынхаа хувьд сонгогдон ажилладаг.

Дээд танхимын гишүүдийг 1-31 мандат бүхий тойргоос муж улсуудын болон холбооны нутаг дэвсгэрийн хурлаас саналын хувь тэнцүүлэн хуваарилах системийн нэг шилжих саналын аргаар сонгодог байна.

Доод танхимын гишүүдийн сонгуулийг Сонгуулийн хуулийн дагуу нэг мандат бүхий 543 тойргоос сонгуулийн мажоритар системээр сонгодог. Үлдсэн 2 гишүүнийг Энэтхэгийн англичуудын нийгэмлэгээс дэвшүүлж Ерөнхийлөгч томилдог.

Бүрэн эрх:

- Хууль тогтоох
- Гүйцэтгэх засаглалыг хянах
- Улсын төсөв батлах

- Ерөнхийлөгчийн огцруулах
- Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг томилох, чөлөөлөх
- Сонгуулийн ерөнхий комиссарыг томилох, чөлөөлөх
- Улсын аудиторыг томилох, огцруулах

Төрийн дээд эрхийг барих субъект: Төрийн дээд эрхийг парламент хэрэгжүүлдэг.

Хууль тогтоох журам:

Хуулийн төслийг 2 танхим дараалан хэлэлцэх журамтай. Жил бүрийн ээлжит чуулганы хуралдаан болон 2 танхимын хамтарсан хуралдаанаар төслийг танхим тус бүрийн нийт гишүүдийн 1/10–ийн ирцтэйгээр хэлэлцэх бөгөөд Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол гишүүдийн олонхийн саналаар төслийг баталдаг. Хуулийн төслийг хэлэлцэх явцад парламентын 2 танхимын хооронд саналын зөрүү гарвал танхимуудын хамтарсан хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар төслийг батлагдсанд тооцдог.

Санхүү, мөнгөний холбогдолтой хуулийн төслийг Дээд танхим хэлэлцэхгүй, харин төслийн талаархи саналаа Доод танхимд хүрүүлнэ. Доод танхим уг төсөлд Дээд танхимаас ирүүлсэн саналыг авч үзэх бөгөөд тэдгээрийг тусгасан, эс тусгаснаас үл хамааран төслийг Доод танхим баталснаар хүчин төгөлдөр болно. Батлагдсан хуулийг Ерөнхийлөгч ёсчилно. Хууль тогтоох болон санхүүгийн асуудлаар парламентын гаргасан шийдвэр эцсийнх байдаг.

<http://www.parliamentofindia.nic.in/>
<http://www.mongolindia.com/>

ЯПОН УЛС

1946 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Япон Улсын Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлгийн 41 дүгээр зүйлд заасны дагуу "Парламент бол төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү хадгална". Энэхүү заалт нь тус улсын төрийн удирдлага нь Парламентын засаглалтай улс гэж тодорхойлсон байна.

Дэлхийн II дайнаас өмнө Японы Эзэнт Улсын 1889 оны Үндсэн хуулийн дагуу парламент нь Дээдсийн танхим (The House of Peers), Төлөөлөгчдийн танхим (The House of Representatives) гэсэн хоёр танхимаас бүрддэг байсан. Төлөөлөгчдийн танхимын гишүүдийг ард түмнээс сонгодог байсан бол Дээдсийн танхимын бүрэлдэхүүнд эзэн хааны гэр бүл, ноёд болон эзэн хааны томилсон гишүүд ордог байжээ.

Одоогийн мөрдөгдөж байгаа Үндсэн хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Парламент (Коккай) нь хоёр танхимаас бүрдэх бөгөөд Төлөөлөгчдийн танхим (Shugiin буюу House of Representative) болон Зөвлөхүүдийн танхим (Sangiin буюу House of Councillors) байна. Хууль тогтоох, улсын төсөв хэлэлцэх, Ерөнхий сайдыг томилох зэрэг асуудлаар Төлөөлөгчдийн танхим нь Зөвлөхүүдийн танхимаас давуу эрхтэй байдгаараа онцлогтой. Парламентын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг Парламентын тухай хууль болон Зөвлөхүүдийн танхимын дүрмээр тус тус зохицуулдаг. Засгийн газар, парламентын гишүүн хууль санаачлах эрхтэй. Мөн Үндсэн хуулийн 43 дугаар зүйлд зааснаар хоёр танхимын гишүүд сонгогдох бөгөөд бүх ард түмнийг төлөөлж танхим бүрийн гишүүдийн тоог хуулиар тогтооно.

Парламентын үндсэн чиг үүрэг нь хууль тогтоох явдал. Хуулийн төслийг хоёр танхим батална. Төлөөлөгчдийн танхимаар баталсан хуулийн төслийг Зөвлөхүүдийн танхим хүлээн зөвшөөрөхгүй бол уг төслийг Төлөөлөгчдийн танхим дахин хэлэлцээд гишүүдийн



Судалгааны эмхтгэл, Х боть

гуравны хоёрын дэмжсэн саналаар хууль батлагдсанд тооцдог. Хэлэлцэж буй хуулийн төслөөр 2 танхим хамтарсан хороо байгуулж болно. Төлөөлөгчдийн танхимаас ирүүлсэн хуулийн төслийг Зөвлөхүүдийн танхим хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор ямар нэг шийдвэр гаргахгүй бол Зөвлөхүүдийн танхим уг төслийг батлаагүйд тооцдог.

Ерөнхий сайдын томилгоо, улсын төсөв батлах асууудлаар 2 танхимын санал зөрөлдсөн тохиолдолд, эсхүл Төлөөлөгчдийн танхимаас гаргасан саналын талаар тодорхой хугацаанд Зөвлөхүүдийн танхим нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол Төлөөлөгчдийн танхимын саналын дагуу уг хуулийг батлан гаргана. Парламент нь гүйцэтгэх эрх мэдлийг хянах үүрэгтэй. Аль ч танхим Засгийн газраас үйл ажиллагааны талаар тайлбар хийхийг шаардах эрхтэй.

Үндсэн хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөгчдийн танхимын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Бүрэн эрхийн хугацаа нь Төлөөлөгчдийн танхим тарсанаар хугацаанаасаа өмнө дуусаж болно. Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн суудал 480 байдаг. Төлөөлөгчдийн танхимын гишүүдийг сонгуулийн холимог системээр сонгох ба 300 гишүүнийг нэг мандаттай 300 тойргоос олонхийн саналаар сонгодог. Үлдсэн гишүүдийг 6-29 олон мандат бүхий 11 тойргоос хувь тэнцүүлэх аргаар сонгодог. 20 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэн санал хураалтад оролцох эрхтэй

Үндсэн хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу Зөвлөхүүдийн танхимын бүрэн эрхийн хугацаа 6 жил. Зөвлөхүүдийн танхим 242 суудалтай. 121 суудлыг 3 жил тутам шинэчлэн сонгодог. Зөвлөхүүдийн танхимын гишүүдийг мөн холимог системээр сонгох бөгөөд 2-10 мандат бүхий 47 тойргоос 146 гишүүнийг, үлдсэн 96 мандатыг улсыг нэг тойрог болгон сонгодог байна. Харин 121 суудлыг шинэчлэн сонгохдоо нэг мандаттай 29 тойргоос 29 гишүүнийг, 2-5 мандаттай 18 тойргоос 44 гишүүнийг, үлдсэн 48 гишүүнийг улсыг нэг тойрог болгон тус тус сонгодог байна. 20 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэн санал хураалтад оролцох эрхтэй.

Цахим хуудас:

- <http://www.shugiin.go.jp>,
- <http://www.sangiin.go.jp>.
- <http://www.sangiin.go.jp/eng/law/tcoj/index.htm>

АМЕРИК ТИВИЙН ОРНУУД

АНУ

Америкийн Нэгдсэн Улс (United States of America)

Америкийн Нэгдсэн Улсын хууль тогтоох байгууллага буюу парламентыг Конгресс (Congress) гэнэ. Дээд танхим Сенат (Senate) 100 гишүүнтэй, Доод танхим болох Төлөөлөгчдийн танхимд (House of Representative) сонгогдох гишүүдийн тоо тухайн муж улсын хүн амын тооноос хамаардаг агаад 435 гишүүнтэй бөгөөд Нэгдсэн улсын Конгресс нь Үндсэн хуульд баталгаажуулсан хууль тогтоох бүрэн эрхийг эдэлнэ. Сенат нь сайд нар болон Дээд шүүхийн шүүгчдийг томилоход оролцдог бөгөөд импичментийн асуудалтай холбогдсон хэргийг хянан хэлэлцэх онцгой эрхтэй. Төлөөлөгчдийн танхим нь танхимын дарга болон бусад ажилтныг сонгох бөгөөд гагцхүү энэ танхим Импичментын эрх эдэлнэ.

АНУ-н конгрессын бүрэн эрх нь хууль батлах явдал юм. Дараахь 4 төрлийн аль нэг хэлбэрээр нь санал болгож танилцуулдаг байна.

1. Хуулийн төсөл (байнгын эсвэл түр хугацааны; ерөнхий эсвэл тусгай; нийтийн

- эсвэл хувийн)
2. Хамтарсан тогтоол (2 танхимын)
 3. Тусдаа гаргасан тогтоол
 4. Ердийн тогтоол

Төлөөлөгчдийн танхим нь улсын болон татварын орлогын тухай бүх хуулийн төслийг хэлэлцэнэ. Харин Сенат бусад хуулийн төсөл, тэдгээрт нэмэлт оруулах санал гаргаж, хуулийн хэлэцүүлэгт оролцож болно. Төлөөлөгчдийн танхим ба Сенатын танхим тус бүрээр дэмжигдсэн хуулийн төслийг Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчид илгээнэ. Ерөнхийлөгч уг хуулийн төслийг дэмжвэл гарын үсэг зурж хүчин төгөлдөр хэрэгжих ба хэрэв татгалзвал уг хуулийн төслийг эсэргүүцлийн хамт буцаадаг.

Уг хуулийн төслийг дахин авч хэлэлцээд 2/3 саналаар хэвээр нь баталбал Ерөнхийлөгчийн эсэргүүцлийн хамт нөгөө танхимдаа шилжүүлнэ. Тус танхим дахин авч хэлэлцээд 2/3 саналаар баталбал уг хуулийн төсөл хүчин төгөлдөр болсон гэсэн үг. Хэрэв Ерөнхийлөгч ямар нэгэн хуулийн төслийг танилцуулахаар илгээснээс хойш 10 хоногийн дотор (ням гарагийг тооцохгүй) буцаагаагүй бол дэмжсэн гэж үзнэ. Мөн түүнчлэн Сенат болон Төлөөлөгчдийн танхимын бүх тогтоолыг Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчид танилцуулах ба дэмжсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Хэрэв татгалзвал Сенат болон Төлөөгчдийн танхимаас 2/3-ийн саналаар дахин баталж болно.

Сонгууль: Дээд танхим Сенат (Senate)-д Муж улс бүрээс 6 жилийн хугацаатай сонгогдсон 2 Сенатч орно. 30 нас хүрсэн, 9 жилийн турш Нэгдсэн улсын иргэн байсан болон сонгуулийн үед тухайн Муж улсад оршин сууж байгаа хүнийг Сенатчаар сонгоно. Нэгдсэн улсын Дэд ерөнхийлөгч Сенатын дарга байх боловч гагцхүү санал тэнцүү хуваагдахаас бусад тохиолдолд санал хураалтад оролцохгүй.

Доод танхим болох Төлөөлөгчдийн танхим (House of Representative) нь тусгаар Муж улс бүрийн хүн амаас 2 жил тутам сонгогдох гишүүдээс бүрдэнэ. Хамгийн олон гишүүнтэй мужийн хууль тогтоох хурлын сонгогчдод тогтоосон шаардлага муж улс бүрийн сонгуульд оролцогчдод нэгэн адил тавигдах бөгөөд 25 нас хүрсэн, 7 жил Нэгдсэн улсын иргэн байсан, түүнчлэн сонгогдох гэж байгаа Муж улсад тухайн сонгуулийн үед амьдарч буй хүнийг төлөөлөгчөөр сонгоно. Сонгуулийн тогтолцоог сонгуулийн хуулиар зохицуулах бөгөөд Төлөөлөгчдийн танхимын гишүүдийг мажоритори системээр сонгодог.

Конгресс дараахь эрх эдэлнэ. Үүнд:

- -Нэгдсэн улсын бүх нийтийн чинээлэг аж байдал, хамтын батлан хамгаалах хүчийг зузаатгах, өр зарлагаа төлөх зорилгоор албан татвар, хураамж, гаалийн болон онцгой татвар тогтоон татах,
- -Нэгдсэн Улсын нэрийн өмнөөс зээл авах,
- -Гадаад худалдаа,
- -Гадаадын хүмүүсийг иргэн болгох нэгдсэн журам тогтоох,
- -Зоос, мөнгөн тэмдэгт хэвлэх, дотоод, гадаад мөнгөн тэмтэгтийн ханшийг зохицуулах, жин хэмжүүрийн нэгж тогтоох,
- -Дээд шүүхээс харьяа доод шатны шүүхүүдийг байгуулах,
- -Дайн зарлах,
- -Усан цэргийн хүчнийг бий болгох,
- -Усан ба хуурай замын цэргийн хүчнийг удирдах болон зохион байгуулах журам зэрэг Нэгдсэн Улсын Үндсэн хуулиар олгосон эрхийг хэрэгжүүлдэг байна.

АРГЕНТИН

Бүгд Найрамдах Аргентин Улс (Republic of Argentina)

Холбооны Бүгд Найрамдах Ерөнхийлөгчийн засаглалтай Аргентин улсын парламент нь Үндэсний Конгресс (National Congress). Үндэсний Конгресс хоёр танхимтай. Депутатуудын танхим (Chamber of Deputies) буюу доод танхим нь 257 гишүүнтэй. Сенат (Senate) буюу дээд танхим нь 72 гишүүнтэй.

Депутатуудын танхимын гишүүнийг 1983 оны 8 дугаар сарын 18-нд (1995 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) баталсан сонгуулийн хуулийн дагуу хүн амын сүүлийн тооллогон дээр үндэслэж муж бүрээс төлөөлөлтэй байхаар хувь тэнцүүлсэн зарчмаар тухайн нэр дэвшиж буй тойрогтой сүүлийн 2 жил оршин сууж буй 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг 4 жилийн хугацаатай сонгоно. Нийт гишүүдийн 1/2 нь 2 жил тутамд шинээр сонгогддог.

Сенатын танхим нь муж бүрээс 3 төлөөлөлтэй байхаар гишүүдээ бүрдүүлдэг. Жилийн орлого нь 2000 хатуу песо эсвэл түүнтэй тэнцэх хэмжээний орлоготой, тухайн нэр дэвшиж буй тойрогтоо сүүлийн 2 жил оршин сууж буй Аргентин улсын 30 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг 6 жилийн хугацаагаар сонгоно.

Депутатын танхимд хадгалагддаг онцгой эрх нь дээд албан тушаалтныг ноцтойгоор хууль зөрчсөн гэж буруутган Сенатын танхимд танилцуулдаг. Мөн Сенатын танхим нь уг дээд албан тушаалтны буруутай эсэхийг шүүдэг онцгой эрхтэй мөн гадны халдлагын үед Холбооны улсыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн бүсчлэн хаах зөвшөөрлийг гаргах эрхтэй. Конгрессын аль ч гишүүн Засгийн газрын Зөвлөл болон төрийн бусад албан тушаалд томилогдож болохгүй.

Жил бүрийн 3 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 30-ний хооронд 2 танхимын ээлжит чуулган хуралддаг ба Үндэсний Ерөнхийлөгч ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах эсвэл ээлжит чуулганыг сунган хуралдуулж болно. Конгрессын гишүүн, Ерөнхийлөгч хууль санаачлах эрхтэй байдаг. Уг санаачилсан хуулийн төслийг танхим тус бүрээр хэлэлцэж 2 танхим хоёул дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид танилцуулна. Ерөнхийлөгч дэмжвэл уг хуулийн төсөл хууль болон хэрэгжинэ. Улсын орлого санхүү, цэрэг татлагатай холбоотой бүх хуулийн төслийг зөвхөн Депутатуудын танхим санаачилна.

Үндэсний Конгресс нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- -Хууль тогтоох,
- -Улсын нэрийн өмнөөс зээл авах,
- -Үндэсний газар нутгаас ашиглах болон захиран зарцуулах талаар шийдэх,
- -Холбооны Банк, Улсын мөнгө тэмдэгт хэвлэх, гадаад мөнгөн тэмдэгтийн ханшийг зохицуулах, жин хэмжүүрийн нэгж тогтоох,
- -Гадаад худалдаа,
- -Хүний хөгжил, нийгэм, эдийн засгийн асуудал,
- -Ерөнхийлөгчид дайны байдал зарлах болон энх тайванг тогтоох эрх олгох,
- -Үндэсний аюулгүй байдал зэрэг Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

БОЛИВИ

Бүгд Найрамдах Боливи Улс (Republic of Bolivia)

Ерөнхийлөгчийн засаглалтай нэгдсэн, Бүгд Найрамдах улсын хууль тогтоох байгууллага



нь хоёр танхим бүхий Хууль тогтоох Ассамблей (Legislative Assembly) юм. Хууль тогтоох Ассамблей (Legislative Assembly) хоёр танхимтай. Депутатуудын танхим (Chamber of Deputies) буюу Доод танхим 130 гишүүнтэй. Сенатуудын танхим (Chamber of Senators) буюу Дээд танхим 36 гишүүнтэй. Хууль тогтоох Ассамблейг тус улсын дэд Ерөнхийлөгч удирдана. Жил бүрийн 8 дугаар сарын 6-нд чуулган эхэлж, жилд 2 удаа 15 хоногоор завсарлана. Чуулган завсарласан хугацаанд яаралтай асуудлаар Ассамблейн Зөвлөл үүрэг гүйцэтгэнэ.

Үндэсний Ассамблей бүтцийн хувьд Байнгын болон зарим тодорхой асуудлаар Түр хороодыг байгуулж болно. Хууль тогтоох Ассамблей хууль батална. Үндсэн хуульд заасан хэм хэмжээг тогтооно. Ассамблейн дээд, доод 2 танхимын гишүүд, Ерөнхийлөгч, өөрийн эрхэлсэн асуудлийн хүрээнд Дээд шүүх болон иргэн хүн хууль санаачлах эрхтэй. Уг хуулийн төслийг 2 танхимаар хэлэлцэж гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид соёрхон батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгчийн соёрхон баталсан хуулийг төрийн хэвлэлд нийтлэснээр хүчин төгөлдөр үйлчилнэ.

Сенатуудын танхимд 2002 оны 4 дүгээр сарын 30-нд баталсан сонгуулийн хуулийн дагуу Боливи улсын 35 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг мажоритари системээр бүх ард түмнээс, шууд, тэгш, нууцаар 5 жилийн хугацаагаар сонгодог. Депутатуудын танхимд сонгуулийн хуулийн дагуу тус улсын 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг холимог системээр буюу 68 суудлыг энгийн мажоритари системээр, 62 суудлыг хувь тэнцүүлэх зарчмаар 5 жилийн хугацаатай сонгодог. Сенатын танхим нь Ерөнхийлөгчийн санал болгож буй Элчин сайдыг зөвшөөрөх, эс зөвшөөрөх эрхтэй байдаг байна.

Хууль тогтоох Ассамблей нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Хууль батлах,
- Мөнгөний бодлогын асуудал,
- Засаг захиргааны хуваарьт өөрчлөлт оруулах,
- Сонгуулийн Хорооны гишүүдийг томилох,
- Ерөнхий прокурорыг томилох,
- Засгийн газраас өргөн барьсан улсын төсвийг батлах,
- Үндэсний аюулгүй байдлын асуудал зэрэг Үндсэн хуулиар олгосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

БРАЗИЛ

Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс(Federative Republic of Brazil)

Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын хууль тогтоох байгууллага нь хоёр танхим бүхий Үндэсний Конгресс (National Congress) юм. Доод танхим-Депутатуудын танхим (Chamber of Deputies) 513 гишүүнтэй. Дээд танхим-Холбооны Сенат (Federal Senate) 81 гишүүнтэй. Танхим тус бүр байнгын хороо болон түр хороодыг байгуулан ажиллуулахаас гадна хамтарч эрх зүй, төр, нийгэм, эдийн засгийн салбар чиглэлээр олон чиг үүрэг бүхий Байнгын хороо, тодорхой асуудлаар Түр хороодыг байгуулан ажиллаж болно.

Ерөнхийлөгч, 2 танхимын гишүүд, Дээд шүүх болон Ерөнхий прокурор хууль санаачлах эрхтэй байдаг. Зэвсэгт хүчин, төрийн алба, Захиргааны байгууллага, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн талаар хууль санаачлах эрх нь зөвхөн Ерөнхийлөгчид хадгалагдана.

Хуулийн төслийг 2 танхимаар хэлэлцүүлж, Үндэсний Конгрессын гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. 1965 оны 7 дугаар сарын 15-нд (1995 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) баталсан сонгуулийн хуулийн дагуу



Судалгааны эмхтгэл, Х боть

хувь тэнцүүлэх зарчмаар Бразил улсын сонгуулийн эрх бүхий иргэд Депутатуудын танхимд 21 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг 4 жилийн хугацаатай сонгоно.

Холбооны Сенатын гишүүнийг 8 жилийн хугацаагаар сонгуулийн мажоритар системээр сонгодог. Холбооны Сенатын гишүүнээр Бразил улсын 35 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно. Муж тус бүр болон Холбооны тойрог бүр 3 сенатчийн төлөөлөлтэй байна. Мужаас сонгогдсон нийт сенатчийн 1/3 болон Холбооны тойргоос сонгогдсон нийт сенатчийн 2/3 нь дөрвөн жил тутамд шинээр сонгогддог. Бразилийн сенатын сонгуулийн нэг онцлог нь сенатчтай хамт түүний 2 орлогчийг сонгодог оршино. Орлогч нь Холбооны Сенатын бүрэлдэхүүнд багтдаггүй боловч сенатчийн ажилд тусалж түүнийг орлож, сонгогчидтой уулздаг бөгөөд сенатч нас барсан, эсхүл огцорсон тохиолдолд нөхөн сонгууль явуулахгүйгээр сенатчийн албан тушаалд шууд томилдог байна.

Хорих ял эдэлж байгаа хүмүүс, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүс сонгох, сонгогдох эрхгүй мөн тус улсад цэргийн доод тушаалын албан хаагчид сонгууль өгөх эрхгүй байдаг байна. Үндэсний Конгресс нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Хууль батлах,
- ✓ Мөнгөний бодлого,
- ✓ Зэвсэгт хүчний цэргийн нөөцийн асуудал,
- ✓ Үндэсний болон орон нутгийн хөгжлийн асуудал,
- ✓ Үндэсний газар нутаг, агаар, далай тэнгисийн хил хязгаарын асуудал,
- ✓ Өршөөл үзүүлэх зэрэг Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

КАНАД

Канад Улс (Canada)

Парламентын засагтай ардчилсан Үндсэн хууль, хаант Канад Улс нь парламентын 2 танхимтай: Дээд танхим-**Сенат** (Senate) 105 гишүүнтэй, Доод танхим-**Нийтийн танхим** (House of Commons) 308 гишүүнтэй. Парламентын чуулган жил бүрийн 9 дүгээр сард эхлэж, дундаа завсарлагатайгаар 6 дугаар сар хүртэл үргэлжилдэг. Парламентын гишүүд нь олон үүрэг гүйцэтгэх ёстой. Үүнд жишээ нь:

- сонгогчдыг төлөөлөх,
- хэлэлцүүлэг хийх,
- хууль батлах,
- хянан шалгах гэх мэт бөгөөд парламентын танхимуудын зүгээс дурдсан үүргүүдэд өгөх ач холбогдол нь харилцан адилгүй байдаг ба үндсэн хууль, түүхэн замнал, уламжлагдан ирсэн заншлын дагуу эдгээр үүргийг өөр өөрийн гэсэн арга замаар хэрэгжүүлдэг. Сенатын танхимын хувьд ялгарах онцлог нь орон нутаг болон цөөнхийн эрх ашгийг төлөөлөх ба ямарч хуулийн төсөл Сенатын танхимаар хэлэлцэхгүйгээр хууль болж батлагдахгүй.

Хуулийг Сенат болон Нийтийн танхим аль аль санаачилж болох бөгөөд харин Засгийн газар хуулийн төслийг Нийтийн танхимд өргөн барьдаг. Харин “мөнгө санхүүтэй холбогдсон хуулийн төслийг” Сенатад хэлэлцдэггүй. Хуулийн төслийн хувьд бол нийтлэг (public) болон хувийн (private) гэсэн 2 хэлбэр байдаг ба нийтлэг хуулийн төслийг Засгийн газрын Сайд нар өргөн барих ба ийм хууль нь улсын хэмжээний бодлогын, тухайлбал орлогын татвар, эрүүгийн хэрэгтэй холбогдол бүхий хууль, цагаачлалын зэрэг асуудлыг хамардаг. Үүний зэрэгцээ хувийн хуулийн төслийг Парламентын гишүүн өргөн барьж болох ба тухайн хуулийн санаачлагч нь байна. Ийм хуулийн төсөл нь хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байдаг.

Нийтийн танхим болон Сенатад хуулийн төслийг 3 удаагийн хэлэлцүүлэгээр эцэслэн баталсаны дараа тухайн хуулийг хуульчлан зарлан тунхаглах хүсэлтийг Хатан хаанд хүргүүлдэг. Хааны зөвшөөрлийг авсаны дараа тухайн хуулийн төсөл нь хуульчилагдан батлагдсанд тооцогддог ба ихэвчлэн “Парламентын баталсан хууль” гэж нэрлэдэг.

Хууль тогтоох үйл явц:

❖ НИЙТИЙН ТАНХИМД

- Төсөл өргөн барих тухай мэдэгдэл өгөх
- Хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах
- Анхны хэлэлцүүлэг, хэвлэн тараахыг зөвшөөрөх
- Хоёрдахь хэлэлцүүлэг
- Хорооны үе шат
- Илтгэх үе шат
- Гуравдахь хэлэлцүүлэг

❖ СЕНАТЫН ҮЕ ШАТ

- Хороодын түвшинд урьдчилан танилцах
- Анхны хэлэлцүүлэг
- Хоёрдахь хэлэлцүүлэг
- Хорооны үе шат
- Илтгэх үе шат
- Гуравдахь хэлэлцүүлэг
- Сенатын нэмэлт, өөрчлөлтийг Нийтийн танхимд хэлэлцэх

❖ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- Хаан батламжлах

Сонгууль: Сенат нь 1985 оны 1 дүгээр сарын 1-нд баталсан сонгуулийн хуулиар бүс нутаг, мужуудыг төлөөлсөн Канад улсын эсвэл Их Британийн хамтын нөхөрлөлийн орны 30 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг Ерөнхий сайдын зөвлөмжөөр Амбан захирагч томилдог. Тэд 75 нас хүртлээ Сенатын гишүүн байх эрхтэй. Нийтийн танхим нь 2000 оны 9 дүгээр сарын 1-нд баталсан сонгуулийн хуулийн дагуу Канад улсын 18 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуулийн мажоритар системээр 5 жилийн хугацаагаар сонгоно. Нийтийн танхимын Спикерийг тус танхимын гишүүд дотроосоо нууцаар санал хурааж сонгодог.

КОЛУМБИ

Бүгд Найрамдах Колумби Улс (Republic of Colombia)

Парламентын танхимуудын нэр: Бүгд Найрамдах Колумби Улсын хууль тогтоох байгууллага болох Конгресс нь 2 танхимтай. Тус улс нь 1979 онд Олон улсын Парламентын Холбоонд элссэн. Колумби Улсын Парламент-Конгресс хоёр танхимтай: Доод танхим-Төлөөлөгчдийн танхим (House of Representative) 166 гишүүнтэй, Дээд танхим-Сенат (Senate) 102 гишүүнтэй. Конгресс нь бүтцийн хувьд 12 Байнгын болон зарим тодорхой асуудлаар 6 Түр хороодыг байгуулан ажиллаж байна.

Бүрэн эрх

Дээд танхимын бүрэн эрх:

Судалгааны эмхтгэл, Х боть

1. Ерөнхийлөгчийн зарлиг тушаалыг батламжлах
2. Цэргийн дээд тушаалын офицеруудыг батламжлах
3. Дайны талаарх Ерөнхийлөгчийн зарлиг тушаалыг зөвшөөрөх
4. Гадаадын улс орнуудын цэргийг газар нутгаараа дамжин өнгөрөхийг зөвшөөрөх

Доод танхимын бүрэн эрх:

1. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх
2. Төсөв болон эрдэнэсийн сангийн ерөнхий гүйлгээг хянах
3. Татвартай холбоотой хууль зүйн журмуудыг зөвшөөрөх
4. Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг шийдэх

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Сенат нь 1900 оны 1 дүгээр сарын 1-нд (1990 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) баталсан сонгуулийн хуулийн дагуу Колумби улсын 30 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуулийн пропорционал системээр 4 жилийн хугацаагаар сонгоно. Сүүлийн сонгууль 2010 оны 3 дугаар сарын 14-нд болсон. Төлөөлөгчдийн танхимд сонгуулийн хуулийн дагуу тус улсын 21 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуулийн пропорциональ системээр 4 жилийн хугацаагаар сонгоно. Сүүлийн сонгууль 2010 оны 3 дугаар сарын 14-нд болсон.

Төрийн эрх барих субъект: Колумби нь 1991 оны Үндсэн хуулиараа Ерөнхийлөгчийн засаглалтай Ардчилсан улсыг байгуулсан. Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн байдаг. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуулийг 1991 онд (1993-2005 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан) баталсан. Анхны Үндсэн хууль 1886 онд батлагдаж байсан Үндсэн хуулиараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангасан. Олон намын тогтолцоотой.

Колумби нь үндсэн хуульд засгийн газрын урт удаан уламжлалтай бөгөөд 1848, 1849 онд тус тус байгуулагдсан Колумбийн Либерал Нам, Колумбийн Консерватив Намууд нь Өмнөд Америк дахь одоо байгаа хамгийн эртний улс төрийн намууд болно. Тус улсын эрх зүй Ром-Германы эрх зүйн системд тулгуурласан.

Хууль тогтоох журам: Конгрессын гишүүд, Ерөнхийлөгч, мөн түүнчлэн эрхэлсэн асуудлынхаа хүрээнд Үндсэн хуулийн Шүүх, Дээд Шүүхийн Зөвлөл, Төрийн Зөвлөл, Үндэсний Сонгуулийн Зөвлөл, Үндэсний Ерөнхий Прокурор болон Бүгд Найрамдах Улсын Ерөнхий Аудитор хууль санаачлах эрхтэй. Хуулийн төслийг танхим тус бүрээр 2 удаа хэлэлцүүлж, төслийг хоёр танхим дэмжсэн үед Ерөнхийлөгчид соёрхон батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгчийн соёрхон баталсан хуулийн төсөл албаны хэвлэлд нийтлэгдсэнээр хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хэрэв санаачилсан буюу хүлээн авсан танхимаас ирүүлсэн төслийг нөгөө танхим нь дэмжээгүй тохиолдолд хоёр танхимын гишүүдээс тэнцүү тоотойгоор оролцуулсан төсөл хэлэлцэх холимог хороог байгуулна. Энэ хороо нь төсөл дэх санал зөрөлдөөнтэй зүйл заалтад холбогдох засвар өөрчлөлтийг оруулсны дараа төслийг батлуулахаар Ерөнхийлөгчид өргөн барьдаг.

Ерөнхийлөгч хориг тавих эсэхээ шийдэх хугацаа нь зүйл заалтын тооноос хамаарсан шатлалтай.

- 20-иос дээшгүй зүйл заалттай хуулийн төсөл бол 6 хоногийн дотор
- 21-ээс 50 хүртэл зүйл заалттай хуулийн төсөл бол 10 хоногийн дотор
- 51-ээс дээш зүйл заалттай хуулийн төсөл бол 20 хоногийн дотор хориг тавих

эсэхээ шийднэ.

Үндэсний Конгресс Ерөнхийлөгчийн хоригийг Үндсэн Хууль зөрчсөн гэж үзсэн тохиолдолд Үндсэн Хуулийн Шүүхэд хянуулахаар хүсэлт гаргана. Үндсэн Хуулийн Шүүх энэ талаар 6 хоногийн дотор хэлэлцээд хариу өгнө. Хэрэв Ерөнхийлөгчийн хориг Үндсэн Хууль зөрчсөн гэж шийдвэл хуулийг батлана. Зөрчөөгүй гэж үзвэл төслийг хэлэлцүүлэхээр буцаана. Харин Ерөнхийлөгч хуулийг батлахаас татгалзах буюу эсвэл хориг тавих хугацаа өнгөрсөн ч ямар нэг тодорхой шийдвэр гаргаагүй бол Үндэсний Конгрессын тэргүүн хуулийг батлана.

МЕКСИК

Мексикийн Нэгдсэн Улс (United States of Mexico)

Парламентын танхимуудын нэр: Мексикийн Нэгдсэн Улсын хууль тогтоох байгууллага буюу парламент нь 2 танхим бүхий Холбооны Конгресс (Congress of the Union) юм. Тус улс нь 1925-1928 онд Олон улсын Парламентын Холбооны гишүүн байсан ба 1973 оноос тус холбооны гишүүнчлэлээ сэргээсэн.

Мексикийн Нэгдсэн Улсын хууль тогтоох дээд байгууллага болох Холбооны Конгресс нь (Congress of the Union) хоёр танхимтай. Бүх ард түмний ашиг сонирхлыг төлөөлдөг Доод танхим-Депутатуудын танхим (Chamber of Deputies) нь 500 гишүүнтэй, мужуудын ашиг сонирхлыг төлөөлдөг Дээд танхим-Сенат (Senate) нь 128 гишүүнтэй. Конгресс нь жилд 2 удаа 9 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 15-ийг хүртэл мөн 2 дугаар сарын 1-ээс 4 сарын 30 хүртэл чуулдаг бөгөөд Чуулганы явцад хуулийн төслийг хэлэлцэх болон Үндсэн хуульд заасан үүрэгт ажлуудыг гүйцэтгэдэг.

Холбооны Конгресс нь бүтцийн хувьд нутгийн уугуул иргэдийн асуудал, Загасны аж ахуй, Далайн асуудал эрхэлсэн гэх мэт 44 Байнгын Хороо, 39 Түр хороотой.

Дээд танхимын бүрэн эрх:

1. Ерөнхийлөгчийн албан тушаалыг батлах
2. Гадаад бодлого тодорхойлох
3. Улс орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулах, татгалзах
4. Дипломат албан тушаалтныг томилох

Доод танхимын бүрэн эрх:

1. Дайн зарлах
2. Нийгмийн халамж болон Засгийн гарын зардалд зарцуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг батлах
3. Сенатын гишүүн болон Дээд шүүхийн шүүгчдэд итгэл үзүүлэх эсэхийг шийдвэрлэх
4. Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх явцад Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо: Депутатуудын танхим нь 1900 онд баталсан сонгуулийн хуулийн дагуу Мексик Улсын 21 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий 500 иргэнийг 3 жилийн хугацаагаар сонгуулийн холимог системээр буюу 300 гишүүнийг сонгуулийн мажоритари, 200 гишүүнийг сонгуулийн пропорционал системээр сонгодог. Мексикийн Конгрессын нэг онцлог нь депутат болон сенатчийн хамт тэдгээрийн орлогчид сонгогддог оршино. Эдгээр орлогчид нь танхимын бүрэлдэхүүнд ордоггүй бөгөөд депутат буюу сенатчийнхаа ажилд тусалдаг бөгөөд харин тэд нас барсан, эсхүл тэтгэвэрт гарсан тохиолдолд нөхөн сонгууль явуулахгүйгээр шууд депутат эсхүл сенатч болдог байна.

Судалгааны эмхтгэл, Х боть

Сенатын танхим нь 1917 онд баталсан сонгуулийн хуулийн дагуу Мексик Улсын 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий 128 иргэнийг 6 жилийн хугацаагаар сонгуулийн холимог системээр буюу 96 суудлыг сонгуулийн мажоритари системээр, 32 суудлыг сонгуулийн пропорционал системээр сонгодог.

Төрийн эрх барих субъект: Мексик нь Ерөнхийлөгчийн засаглалтай Холбооны Бүгд Найрамдах Улс. Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн байдаг. Анхны Үндсэн хууль нь 1824 онд батлагдсан. Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хууль нь 1917 оны 2 дугаар сарын 5-нд батлагдаж, 1993, 1999, 2000, 2008 болон 2009 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Үндсэн хуулиараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангаж өгсөн юм. 1917 оны Үндсэн хууль батлагдахаас өмнө түүхэндээ Гүйцэтгэх эрх мэдэл нь давамгайлан ноёрхож байсан.

Мексикт гүйцэтгэх засаглалыг Мексикийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгч тэргүүлдэг. Ерөнхийлөгч нь 6 жилийн хугацаагаар сонгогддог. Ерөнхийлөгчийн онцгой бүрэн эрхэд Засгийн газрын гишүүн сайд нарыг биечлэн албан тушаалд томилох ба огцруулах, халах зэрэг орно. Засгийн газар нь Ерөнхийлөгчийн өмнө хариуцлага хүлээнэ.

Дээд шүүх нь шүүхийн дээд байгууллага бөгөөд түүний 11 шүүгчийг Сенаттай зөвшилцсөнөөр Ерөнхийлөгч томилдог. Мөн Холбооны Шүүхийн Зөвлөл нь 5 жилийн хугацаатай томилогддог 7 гишүүнтэй. Тус улс нь Ром-Германы эрх зүйн системд суурилсан хууль, эрх зүйн тогтолцоотой улс юм. Мексик Улс нь нэг зонхилгоч намтай, олон намын тогтолцоотой.

Хууль тогтоох журам: Ерөнхийлөгч болон Холбооны Конгрессийн гишүүд хууль санаачлах эрхтэй. Уг хуулийн төслийг 2 танхимаар хэлэлцүүлж, Холбооны Конгрессийн гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Хэрэв анх санаачилсан буюу хүлээн авсан танхимаас ирүүлсэн төслийг нөгөө танхим нь дэмжээгүй тохиолдолд засвар өөрчлөлт оруулах шаардлагатай зүйл заалт болон хэрхэн өөрчлөх тухай саналаа оруулж төслийг буцаана. Энэ саналыг хүлээн зөвшөөрч төсөлдөө тусган шинэчлэн боловсруулсан бол нөгөө танхимдаа дахин хэлэлцүүлэлгүйгээр шууд батлуулахаар Ерөнхийлөгчид өргөн барьдаг.

Харин төслийг анх санаачилсан буюу хүлээн авсан танхим нь нөгөө танхимаас ирүүлсэн төсөлд оруулах засвар өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол энэ тухай үндэслэл, тайлбараа багтаан төслийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлнэ. Нөгөө танхим энэ тайлбар үндэслэлийг хүлээн зөвшөөрөхгүй, төслийг заавал засч өөрчлөх ёстой байсан гэж үзвэл төслийг хэлэлцэхгүй. Энэ тохиолдолд уг хууль батлагдахгүй. Гэхдээ энэ танхимд төслийг хэлэлцэхдээ зөвхөн хяналтын чиг үүрэгтэй байдаг. Тиймээс хуулийн төсөлд засвар өөрчлөлт оруулах шаардлага гарвал анх санаачилсан буюу хүлээн авсан танхимд нь буцаадаг. Ерөнхийлөгч 10 хоногийн дотор хориг тавих эсэхээ шийдэх ёстой. Ерөнхийлөгчийн хоригийг Холбооны Конгресс хүлээн авсан бол уг төслийг дахин хэлэлцэхгүй. Хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол хуулийн төслийг анхны процедураар дахин хэлэлцэнэ.

ПАРАГВАЙ

Бүгд Найрамдах Парагвай Улс (Republic of Paraguay)

Парламентын танхимуудын нэр: Бүгд Найрамдах Парагвай Улсын хууль тогтоох байгууллага буюу парламент нь 2 танхимтай Конгресс юм. Анхны парламент нь 1813 онд байгуулагдаж байсан. Парагвай улс Олон Улсын Парламентын Холбоонд 1958-2003 оны хооронд гишүүнчлэлтэй байсан бөгөөд 2006 онд гишүүнчлэлээ сэргээсэн.

Парагвай улсын Парламент (Congress) хоёр танхимтай. Депутатуудын танхим (Chamber of Deputies) буюу доод танхим 80 гишүүнтэй, Сенат (Senate) буюу дээд танхим 45 гишүүнтэй.

Конгресс бүтцийн хувьд 26 Байнгын, 7 Түр хороотой.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо: Сенатын танхим нь 1900 оны 1дүгээр сарын 1-нд баталсан сонгуулийн хуулийн дагуу Парагвай улсын 40 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг пропорционал системээр 5 жилийн хугацаагаар сонгоно. Депутатуудын танхим нь сонгуулийн хуулийн дагуу Парагвай улсын 25 нас хүрсэн иргэнийг сонгуулийн пропорционал системээр 5 жилийн хугацаагаар сонгоно.

Дээд танхимын бүрэн эрх:

1. Хуулийг батлах, өөрчлөх, хүчингүй болгох
2. Орон нутгийн засаг захиргааны нэгж бий болгох
3. Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох
4. Төсөв батлах
5. ОУ-ын гэрээнд нэгдэн орох эсэхийг шийдвэрлэх
6. Өршөөл уучлал үзүүлэх
7. Сонгуулын системийг боловсруулах

Доод танхимын бүрэн эрх:

1. Батлан хамгаалах болон бусад ОУ-ын гэрээ хэлэлцээрийг боловсруулах
2. Засаг захиргааны нэгжийн талаар санал боловсруулах
3. Хууль, тогтоолуудын батлах, өөрчлөх, татгалзах

Төрийн эрх барих субъект:

Парагвай нь Ерөнхийлөгчийн засаглалтай улс. Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн байдаг. 1992 оны 6 дугаар сарын 20-нд батлагдсан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үндсэн хууль нь 1811 онд тусгаар улс болсноос нь хойшхи 6 дахь Үндсэн хууль юм. Анхны Үндсэн хууль нь 1813 онд батлагдаж байжээ. Тус улсын эрх зүй нь Ромын эрх зүйн системд суурилсан. Үндсэн хуулиараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангасан. Олон намын тогтолцоотой.

Хууль тогтоох журам:

Конгрессын гишүүн, Ерөнхийлөгч мөн түүнчлэн өөрийн эрхэлсэн хүрээний асуудлаар Дээд Шүүх хууль санаачлах эрхтэй. Уг хуулийн төслийг Үндэсний Конгрессын гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгч 10 хоногийн дотор хориг тавих эсэхээ шийдэх ёстой. Ерөнхийлөгчийн хоригийг Үндэсний Конгресс хүлээн авсан бол уг төслийг дахин хэлэлцэхгүй.

Хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол хуулийн төслийг анхны процедураар, санаачилсан буюу анх хүлээн авсан танхим нь 60 хоногийн дотор дахин хэлэлцээд нөгөө танхимдаа шилжүүлнэ. Үндэсний Конгрессын гишүүдийн олонхи буюу 2/3 нь хоригийг хүлээн зөвшөөрөхгүйгээр шийдвэл уг хууль батлагдана. Хэрэв хоригийг яаралтай хэлэлцэх шаардлагатай бол дээрх процедураар 30 хоногийн дотор төслийг хэлэлцэнэ.

УРУГВАЙ

Дорнын Бүгд Найрамдах Уругвай Улс (Oriental Republic of the Uruguay)

Парламентын танхимуудын нэр: Дорнын Бүгд Найрамдах Уругвай Улсын хууль тогтоох байгууллага буюу парламент нь Үндэсний Ассамблей. Үндэсний Ассамблей (National Assembly) хоёр танхимтай. Төлөөлөгчдийн танхим (House of Representative) буюу доод

Судалгааны эмхтгэл, Х боть

танхим 99 гишүүнтэй, Сенат (Senate) буюу дээд танхим 31 гишүүнтэй. Үндэсний Ассамблей бүтцийн хувьд Байнгын болон зарим тодорхой асуудлаар Түр хороодыг байгуулж болно.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Төлөөлөгчдийн танхим нь 1925 оны 10 дугаар сарын 1-нд (1999 оны 6 дугаар сарын 9-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан) баталсан сонгуулийн хуулийн дагуу Уругвай улсын 25 нас хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэнийг пропорционал системээр 5 жилийн хугацаатай сонгоно. Сенатын танхимд Уругвай улсын 30 нас хүрсэн, эрх зүйн чиглэлээр эсвэл албан үүрэг 7 жил гүйцэтгэсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуулийн хуулийн дагуу пропорционал системээр 5 жилийн хугацаатай сонгоно.

Төлөөлөгчдийн танхим нь сонгуулийн хувь тэнцүүлэх зарчмын дагуу ард түмнээс шууд сонгогддог 99 гишүүнтэй.

- -Муж тус бүрээс доод тал нь 2 төлөөлөлтэй байна
- -2 танхимын нийт гишүүдийн 2/3 саналаар төлөөлөлийн тоог хуулиар өөрчилж болно.

Дараахь тохиолдолд Төлөөлөгчдийн танхимын гишүүнээр сонгогдохгүй. Үүнд:

- 1) Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Шүүх эрх мэдлийн гишүүд, орон нутгийн хороодын тэргүүлэгч нар, Төвлөрөлийг сааруулах үйлчилгээний удирдлага
- 2) Нэгээс дээш жил Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийн алба хашиж байсан иргэн, мөн ажил үүргээ гүйцэтгэж байгаа шүүгч, прокурор болон сонгууль болохоос 3 сарын өмнө ажил үүргээ гүйцэтгэж байсан Цагдаагийн байгууллагын ажилтан, цэргийн албан хаагч нар Төлөөлөгчдийн танхимд нэр дэвшихгүй.

Сенатын танхим нь сонгуулийн хувь тэнцүүлэх зарчмын дагуу ард түмнээс шууд сонгогддог 30 гишүүнтэй.

Бүрэн эрх

Ерөнхий Ассамблей дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Хууль баталж түүнийг хэвлэн нийтлэх,
- 2) Шүүхийг томилох,
- 3) Бүгд Найрамдах Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, түүний бүрэн бүтэн байдал; хүний эрх, эрх чөлөө; хөдөө аж ахуй, гадаад дотоод худалдаатай холбоотой хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах,
- 4) Шаардлагатай татварыг тогтоож улсын төсвийг бүрдүүлэх,
- 5) Засгийн газрийн танилцуулж буй зардалыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зөвшөөрөх эсвэл зөвшөөрөхгүй байх
- 6) Засгийн газрыг байгуулах
- 7) Хоёр танхимын нийт гишүүдийн үнэмлэхүй олонхийн саналаар дайныг зарлана.
- 8) Жил бүр шаардлагатай зэвсэгт хүчнийг томилно
- 9) Хоёр танхимын нийт гишүүдийн 2/3 саналаар шинэ хэлтэс, албадыг байгуулж болно. Тус шинэ хэлтэс, албад нь чиг үүрэгийнхээ дагуу харьяалсан яамандаа харьяална.
- 10) Бүгд Найрамдах Улсын газар нутагт гадны цэргийг орж ирэхийг зөвшөөрөх болон хориглох

- 11) Үндэсний зэвсэгт хүчнийг Бүгд Найрамдах Улсаас явахыг зөвшөөрөх болон татгалзах, явах тохиолдолд буцаж ирэх хугацааг тогтоож өгнө
- 12) Ажлын байрыг нэмэгдүүлэх болон шинээр бий болгох; Засгийн газрын төсвийг батлах, зөвшөөрөхгүй байх болон төсвийг багасгах; Засгийн газартай тэтгэвэр тэтгэмж болон бусад нийгмийн халамжийг хэлэлцэх
- 13) Хоёр танхимын нийт гишүүдийн 2/3 саналаар уучлал үзүүлэхийг зөвшөөрөх; зарим онцгой тохиолдолд өршөөл үзүүлэхийг тохирохдоо хоёр танхимын нийт гишүүдийн үнэмлэхүй олонхийн саналаар шийдвэрлэнэ
- 14) Цагдан сэргийлэх газрын эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох
- 15) Хоёр танхимын хурлаар Дээд шүүхийн, Сонгуулийн Шүүхийн, Захиргааны хэргийн шүүхийн болон Санхүүгийн шүүхийн гишүүдийг сонгоно.
- 16) Яамдуудын үйл ажиллагааг үнэлэх
- 17) Үндсэн хуулийг тайлбарлах
- 18) Хоёр танхимын нийт гишүүдийн үнэмлэхүй олонхийн саналаар төсвийг батална

Доод танхимын бүрэн эрх: Төлөөлөгчдийн танхим нь Сенатын танхимын өмнө 2 танхимын гишүүд, Бүгд Найрамдах Улсын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, Төрийн яамдын сайдууд, Дээд шүүхийн гишүүд, Захиргааны Шүүхийн гишүүд, Санхүүгийн шүүхийн гишүүд, Сонгуулийн Шүүхийн гишүүд Үндсэн хуулийг зөрчсөн болон хүнд гэмт хэрэг үйлдсэн нь илэрсэн гомдол өргөдлийн дагуу буруутгах онцгой эрхтэй.

Төрийн эрх барих субъект:

Уругвай нь Ерөнхийлөгчийн засаглалтай улс. Ерөнхийлөгч нь Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн байдаг. 1967 онд батлагдсан (1989, 1994, 1996, 2004 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан) одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хууль нь 1828 онд тусгаар улс болсноос нь хойшхи 5 дахь Үндсэн хууль. Анхны Үндсэн хууль нь 1830 онд батлагдаж байжээ. Тус улсын эрх зүй нь Ром-германы эрх зүйн тогтолцоонд суурилсан. Үндсэн хуулиараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангасан. Олон намын тогтолцоотой.

Хууль тогтоох журам

Парламентын гишүүн, Ерөнхийлөгч хууль санаачлах эрхтэй байдаг. Уг хуулийн төслийг Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгч 10 хоногийн дотор хориг тавих эсэхээ шийдэх ёстой. Ерөнхийлөгч хориг тавих тохиолдолд хоригийг Үндэсний Ассамблей хүлээн авсан бол уг төслийг дахин хэлэлцэхгүй. Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхи буюу 3/5 нь хоригийг хүлээн зөвшөөрөхгүйгээр шийдвэл уг хууль батлагдана.

ЧИЛИ

Бүгд Найрамдах Чили Улс (Republic of Chile)

Парламентын танхимуудын нэр:

Бүгд Найрамдах Чили Улсын хууль тогтоох байгууллага буюу парламент нь Үндэсний Конгресс юм. Үндэсний Конгресс (National Congress) нь 1811 оны 7 дугаар сарын 4-нд байгуулагдсан. Чили улс 1990 онд Олон Улсын Парламентын Холбоонд элсжээ. Үндэсний Конгресс нь 2 танхимтай. Сенат (Senate) 38 гишүүнтэй, Депутатуудын Танхим (Chamber of Deputies) 120 гишүүнтэй.

Дээд танхимын бүрэн эрх: Сенатын танхим нь дараахь онцгой эрхийг эдэлнэ. Үүнд:

1. Депутатуудын танхимын гэм буруутай гэж үзсэн хэрэгтэй танилцах бөгөөд



- Сенатын танхим нь шүүгч адил буруутан гэм буруутай эсэхийг тогтооно.
2. Бүгд найрамдах Улсын Ерөнхийлөгчийн гэм буруутайг тогтоох үед нийт сенаторын 2/3 саналаар шийдвэрлэнэ. Бусад хэрэгт олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Доод танхимын бүрэн эрх: Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. Депутатын танхимын гишүүдийн олонхийн саналаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг батлах эсвэл нэмэлт санал болгох

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Депутатуудын танхимд сүүлийн 2 жил харьяалсан сонгуулийн тойрогтоо амьдарсан, бүрэн дунд боловсролтой эсвэл түүнтэй ижил боловсрол эзэмшсэн, 21 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий Чили улсын иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгуулийн мажоритари системээр сонгоно. Чилийн иргэд сонгуульд заавал оролцож саналаа өгөх үүрэгтэй. Сонгуульд оролцохоос зайлсхийсэн иргэдэд торгох хүртэл захиргааны арга хэмжээ авдаг.

Чили улсын муж тус бүрээс шууд санал хураалтаар сонгогдох (хамгийн багадаа муж тус бүрээс нэг төлөөлөл байна) сенаторуудаас Сенатын танхим бүрдэнэ. Сонгуулийн мажоритари системээр сонгоно. Сенатын танхимын гишүүдийн бүрэлдэхүүн, тэдгээрийн сонгогдох сонгуулийн зарчмыг хуулиар тогтооно. Түүний бүрэн эрхийн хугацаа 8 жил. Нийт гишүүдийн 1/2 нь 4 жил тутамд шинээр сонгогдоно. Шинэчлэн сонгох журмыг хуулиар тогтооно. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн, сонгуулийн эрх бүхий Чили Улсын 35 насанд хүрсэн иргэнийг Сенатын танхимд нэр дэвшүүлж сонгож болно. Депутатын танхимын болон Сенатын танхимын сонгууль нэг дор болно.

Төрийн эрх барих субъект:

Чили нь Ерөнхийлөгчийн засаглалтай Бүгд Найрамдах улс юм. 1980 оны 9 дүгээр сарын 11-нд өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хууль нь батлагдсан. Чили бол олон намын системтэй улс. Төрийн тэргүүн ерөнхийлөгч нь Төр, Засгийн эрхийг давхар барьдаг, хууль тогтоох дээд байгууллага нь хоёр танхимт парламент ажээ. Ром-Германы эрх зүйн системд суурилсан эрх зүйн тогтолцоотой.

Хууль тогтоох журам

Ерөнхийлөгч болон Конгрессын гишүүд хууль санаачлах эрхтэй. Хуулийн төслийг танхим тус бүрээр хэлэлцүүлж, нийт гишүүдийн олонхийн дэмжлэг авсан тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Хэрэв санаачилсан буюу хүлээн авсан танхимаас ирүүлсэн төслийг нөгөө танхим нь дэмжээгүй тохиолдолд хоёр танхимын гишүүдээс тэнцүү тоотойгоор оролцуулсан төсөл хэлэлцэх холимог хороог байгуулна. Энэ хороо нь төсөл дэх санал зөрөлдөөнтэй зүйл заалтад холбогдох засвар өөрчлөлтийг оруулсны дараа төслийг анх санаачилсан буюу хүлээн авсан танхимд нь хэлэлцүүлэхээр оруулна.

Хэрэв холимог хороо нэгдсэн саналд хүрэхгүй буюу холимог хорооны ирүүлсэн засвар өөрчлөлтийг төслийг анх санаачилсан буюу хүлээн авсан танхим хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд Ерөнхийлөгч төслийг анх санаачилсан буюу хүлээн авсан танхимын гишүүдийн 2/3-ын саналаар батлагдсан төслийг нөгөө танхим нь шууд хүлээн авч хэлэлцэхийг шаардах эрхтэй. Энэ шаардлагаар хүлээн авсан төслийг гишүүдийн 3/5 нь дэмжсэн тохиолдолд хууль батлагдана. Хэрэв дэмжээгүй тохиолдолд дахин хоёр танхимын гишүүдээс бүрдсэн шинэ холимог хороо байгуулж хэлэлцэх процессыг санал нэгдэх хүртлээ явуулна.

Эцэст нь санал нэгдэж чадвал Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгч 30 хоногийн дотор хориг тавих эсэхээ шийдэх ёстой. Ерөнхийлөгчийн хоригийг Үндэсний

Конгресс хүлээн авсан бол уг төслийг дахин хэлэлцэхгүй. Хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол хуулийн төслийг анхны процедураар хоёр танхим дахин хэлэлцээд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Үндэсний Конгрессын гишүүдийн олонхи буюу 3/2 нь хоригийг хүлээн зөвшөөрөхгүйгээр шийдвэл уг хууль батлагдана. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч хуулийг батлах үүрэгтэй. Хэрэв хоригийг яаралтай хэлэлцэх шаардлагатай бол дээрх процедураар 30 хоногийн дотор төслийг хэлэлцэнэ.

АФРИК ТИВИЙН УЛСУУД

АЛЖИР УЛС

Алжир Улс Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьдаг нэгдмэл улс. Парламентын а/ доод танхим нь Үндэсний ардын ассамблей (Аль-Маджлис аш-Шааби аль-Ватани), б/ дээд танхим нь Үндэстний зөвлөл (Меджлис аль-Оумма) Парламентын доод танхим 389 гишүүнтэй, танхимын гишүүдийг 5 жил тутам бүх ард түмнээс шууд сонгоно. 8 суудлыг гадаадад амьдарч байгаа алжирчуудын сонгуульд зориулдаг.

Сонгуулийг 1997 оны 3 дугаар сарын 2-нд батлагдсан сонгуулийн хуулийн дагуу хувь тэнцүүлэн хуваарилах системээр явуулах журамтай. Парламентийн дээд танхим нь 144 гишүүнтэй. Гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил, 3 жил тутамд 50 хувь нь шинэчлэгдэн сонгогддог.

Дээд танхимын гишүүдийн 96 нь шууд бус сонгуулиар, 48 нь томилогддог байна. 1997 оны III сарын 7-нд баталсан сонгуулийн хуулийн дагуу 96 гишүүнийг орон нутгийн иргэдийн нийтийн хурлаас сонгон шалгаруулсан сонгогчид мужуудын Үндэсний хурлын гишүүдээс сонгодог. Нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын 40 нас хүрсэн нэртэй зүтгэлтнүүдээс 48 гишүүнийг Ерөнхийлөгч томилдог.

Парламентын доод танхим дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг

- Хууль тогтоох;
- Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг батлах;
- Засгийн газрын жил бүрийн бодлогын асуудлыг батлах;
- Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Засгийн газарт итгэл хүлээлгэх эсэх асуудлаар шийдвэр гаргах;
- Гадаад бодлогын асуудлаар хэлэлцүүлэг явуулах;
- Төсвийн зарцуулалтад хяналт тавих;

Парламентын дээд танхим дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг

- Хууль тогтоох;
- Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг зөвшөөрөх;
- Засгийн газрын жил бүрийн бодлогын асуудлыг зөвшөөрөх;
- Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Гадаад бодлогын асуудлаар хэлэлцүүлэг явуулах;
- Төсвийн зарцуулалтад хяналт тавих;

Үндсэн хуульд заасны дагуу хууль, тогтоомжийн төслийг эхлээд парламентын доод танхим хэлэлцэж, баталсны дараа дээд танхим хэлэлцэж 3/4-ийн саналаар баталснаар Ерөнхийлөгчид ёсчлуулахаар өргөн барина. Доод танхим нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ ердийн хуулийн төслийг олонхиор, органик хуулийн төслийг 2/3-оос дээшхийн саналаар батална. Үндсэн хуулийн зөвлөл батлагдсан төсөл Үндсэн хуульд

Судалгааны эмхтгэл, X боть

нийцсэн эсэхийг хянана. Харин Ерөнхийлөгч 30 хоногийн дотор төслийг дахин хэлэлцүүлэх санал тавих эрхтэй. Энэхүү саналыг доод танхим хүлээн авч хэлэлцээд 2/3-ийн саналаар баталбал хууль батлагдсанд тооцно.

Парламентын доод танхимын хэлэлцэж олонхиороо баталсан хуулийн төслийг дээд танхим хэлэлцэх журамтай. Дээд танхим төслийг 3/4-ын саналаар баталсан тохиолдолд уг хууль Ерөнхийлөгчид ёсчлуулахаар өргөн баригдана. Доод танхимын баталсан төслийг дээд танхим 3/4-ын саналаар зөвшөөрөөгүй бол 2 танхимаас тэнцүү тооны гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилж холбогдох асуудлаар Засгийн газрын байр суурь, үндэслэлийг сонсож, Засгийн газрын саналтай нийлэхгүй байвал уг заалтыг батлагдаагүйд тооцно.

БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН КОНГО УЛС.

БНАКонго Улс Ерөнхийлөгч нь Төрийн дээд эрхийг барьдаг нэгдмэл улс. БНАКУ-ын парламент буюу конгресс нь доод танхим буюу Үндэсний ассамблей (Assemblée nationale), дээд танхим буюу Сенат (Senate) гэсэн 2 танхимтай. Энэхүү 2 танхим хоёулаа байнгын ажиллагаатай. Парламентын доод танхим бүх ард түмнээс шууд, нууц санал хураалтын үндсэн дээр сонгогддог, 5 жилийн бүрэн эрх бүхий 500 гишүүнтэй.

Парламентын доод танхимын сонгууль 2006 оны III сарын 9-нд баталсан сонгуулийн тухай хуулийн дагуу явагдана. Нэг мандаттай 60 тойрогт нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдоно. 109 тойрог (2-оос дээш мандаттай)-т 440 нэр дэвшигчийг пропорциональ системийн нээлттэй жагсаалтаар санал хурааж, хуульд заасан журмын дагуу суудлын хуваарилалтыг тооцож гаргана.

Сенатын сонгууль 2006 оны III сарын 9-нд баталсан сонгуулийн тухай хуулийн дагуу явагдана. Энэ хуулиар 108 гишүүнийг мужуудын ассамблейгаас шууд бусаар 5 жилийн хугацаагаар сонгох журамтай. Харин Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүн бүх насаараа Сенатын гишүүн байхаар тогтоожээ. Сенатын гишүүн 50 нас хүрсэн байх ёстой.

Парламентын доод, дээд танхим хууль батлах, Засгийн газар болон төрийн үйлдвэр байгуулагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, Үндсэн хуулийн шүүхийн 3 гишүүний асуудлыг хамтран зөвшилцөх, дайн зарлах зөвшөөрлийг Ерөнхийлөгчид олгох, Ерөнхийлөгчийн зарласан бүслэлтийн байдал, онцгой байдлын дэглэмийг цуцлах, зөвшөөрөл олгох, хууль сахиулах байгууллагаас нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай асуудлаар шийдвэр гаргах зөвшөөрлийг Засгийн газарт олгох, улсын төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх, мужуудын ассамблейд хамааралтай асуудлаар зарлиг гаргах чиглэл өгөх, Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудлаар баталгаа гаргах, дотоод зохион байгуулалтын асуудал (гишүүдийн мандатыг шалгах, дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах, удирдах ажилтнуудыг томилох, улс төрийн болон мужуудын бүлэгт нэр дэвшигчдийг батлах, байнгын хороо байгуулах график батлах, чуулганы хуралдааны тов зарлах, байнгын хороодын болон парламентын төлөөлөгчдийн илтгэлийг батлах)-ыг хэлэлцэж шийдвэрлэх эрхтэй.

Хуулийн төслүүдийг доод, дээд танхим дараалан чуулганы хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн 2/3 нь оролцсон тохиолдолд хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батлах журамтай. Танхим дундын нэгдсэн байнгын болон тусгай хорооны хурлаар шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцдэг. 2 танхимын хооронд хэлэлцэж буй асуудлаар саналын зөрүү гарвал доод танхимын гишүүдийн туйлын олонхийн саналаар баталсан шийдвэр давуу эрхтэй байдаг. Засгийн газар болон бусад байгууллагуудад хяналт тавихдаа төсөв батлах, аудитын хяналт шалгалт оруулах хэлбэрээр хэрэгжүүлдэг байна.

ЗИМБАБВЕ УЛС.

Зимбабве Улс Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьдаг нэгдмэл улс. Зимбабве улсын парламент нь Хурлын танхим (House of Assembly) буюу доод танхим, Сенатын танхим буюу дээд танхимаас бүрдэнэ. Парламентын доод танхим 5 жилийн бүрэн эрх бүхий 214 гишүүнтэй. Парламентын доод танхимын сонгууль 2004 оны XII сарын 15-нд батлагдсан сонгуулийн хуулийн дагуу явагдана. Танхимын 210 гишүүн нь 1 мандат бүхий тойргоос мажоритар системээр бүх ард түмнээс шууд сонгогдоно. 4 гишүүнийг албан тушаалыг нь харгалзан томилдог.

Дээд танхим 100 гишүүнтэй.

Парламентын дээд танхим-Сенат 1981 онд ОУПХ-нд бүртгүүлсэн байна. Парламентын дээд танхим 100 гишүүнтэй, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Сенатын гишүүдийн 60 нь шууд сонгуулиар мажоритар системээр 10 мужаас тус бүр 6 сенатор сонгогдох бөгөөд 5-ыг нь Ерөнхийлөгч томилох, 35 нь бусад албан тушаал заасан (10 бүс нутгийн захирагч, 16 удирдах тушаалтан, худалдаа, үйлчилгээний салбарын 7, захирлуудын зөвлөлийн дарга, орлогчид) хүмүүс орох журамтай.

Зимбабве Улсын парламентын доод танхимд Үндсэн хуулийн дагуу байгуулагддаг Хууль зүйн байнгын хороо нь Үндсэн хуулиар тогтоосон бүрэн эрхтэй байдаг. Хууль зүйн байнгын хороог Байнгын дүрэм журмын хороо гэх бөгөөд парламентын гишүүн, Засгийн газрын гишүүн, мужуудын захирагч тус бүрээс 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулах бөгөөд гишүүд нь Үндсэн хуульд заасан эрх зүйн салбарын мэргэжил, боловсрол, онол практикийн шалгуурыг хангасан байх ёстой.

Хууль зүйн байнгын хороо парламентад өргөн барьсан хуулийн төслийг эцэслэн батлахын өмнө уг төсөл хүний эрхийн хэм хэмжээ, Үндсэн хуулийн заалтад нийцсэн эсэх талаар дүгнэлт гаргаж парламентын дээд, доод танхимын хуралдаанд илтгэх бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Парламентын дээд, доод танхим дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;
- Хууль батлах
- Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Иргэнийг харъяат болгох;
- Иргэнийг харъяатаас хасах;
- Зимбабве Улсын иргэн болгохоос татгалзах;
- Зимбабве Улсын иргэнээс хасах

Хууль тогтоох журам

Парламентын доод танхим хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Парламентын хуулийн хороогоор хэлэлцэж, дүгнэлт гаргасан хууль, тогтоомжийн төслийг хэлэлцэж, олонхийн саналаар батлан Сенатад шилжүүлэхийн хамт Хурлын танхимын дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй. Доод танхим батлагдсан хуулийг Ерөнхийлөгчид батламжлуулахаар шилжүүлнэ.

Ерөнхийлөгч буцаасан хуулийн төслийг 6 сарын дотор дахин хэлэлцэж батлан Ерөнхийлөгчид батламжлуулахаар дахин хүргүүлнэ. Парламент баталж, Ерөнхийлөгч батламжилсан хуулийг бүх нийтээр мөрдүүлэхээр нийтлүүлнэ. Парламентын дээд танхим доод танхимаар хэлэлцэж шилжүүлсэн хуулийн төсөл болон Үндсэн хуулиар шууд хэлэлцэхээр заасан хуулийн төслийг хэлэлцэж батлах, Сенатын дотоод зохион



Судалгааны эмхтгэл, X боть

байгуулалттай холбоо бүхий асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ олонхийн саналыг баримтална.

Парламентын доод танхимаас Засгийн газарт хяналт тавих, хариуцлага хүлээлгэх, сонгогчдыг илүү үр дүнтэй төлөөлөх, олон нийттэй харилцах эрх үүргийг нийгмийн зүгээс шаардаж буй хэмжээнд хүргэх зорилгоор 1996 онд Парламентын чиглэлийн хороодыг байгуулан ажиллуулсан байна.

КОНГО УЛС.

Конго Улс Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьдаг нэгдмэл улс. Үндсэн хуулиар Конго улсын парламент доод танхим буюу Үндэсний ассамблей (Assemblée Nationale), дээд танхим буюу Сенат (Senate) гэсэн 2 танхим бүхий парламент хууль тогтоох бүрэн эрхийг Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгчтэй хамтран хэрэгжүүлдэг байна.

Парламентын доод танхим нь бүх ард түмнээс 5 жилийн хугацаатайгаар шууд сонгогддог 137 гишүүнтэй, Үндсэн хуулиар тогтоосон хүрээний асуудлаар хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Парламентын доод танхимын гишүүдийн сонгуулийг 2001 оны XII сарын 22-нд баталсан сонгуулийн тухай хуулийн дагуу явуулдаг. Парламентын доод танхимын гишүүнд нэр дэвшигчдийг нэг мандат бүхий 137 тойргоос мажоритар системээр олонхийн санал авсан тохиолдолд сонгогдсонд тооцдог.

Конго улсын Сенат болох парламентын дээд танхим нь 1992 онд анх байгуулагдаж байсан. Сенат нь шууд бус сонгуулиар 45 нас хүрсэн муж, дүүрэг, орон нутгийн коммуны зөвлөлөөс 6 жилийн хугацаагаар сонгогдох 72 гишүүнтэй. 50 хувь нь 3 жил тутамд шинэчлэгдэн сонгогдох журамтай. Сенатын сонгууль 2002 оны I сарын 20-нд баталсан сонгуулийн тухай хуулийн дагуу 42 мандатад 7 муж тус бүрээс 6 гишүүн сонгогддог.

Парламентын бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор хууль тогтоох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, дотоод дэгийг батлах, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Сенатын удирдах бүрэлдэхүүнийг Сенатын гишүүд шинэчлэгдэн сонгогдсон тухай бүр шинэчлэх журамтай. Сенат нь Үндсэн хуулиар тогтоосон хүрээнд хууль тогтоох үйл ажиллагаанд оролцохоос гадна Ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг томилоход саналаа өгөх, орон нутгийн удирдах байгууллага, нийгэм соёлын үүсгэл санаачлагын байгууллагын ашиг сонирхлыг төлөөлж хамгаалах үүрэгтэй. Сенатын гишүүд орон нутгийн удирдах байгууллагыг төлөөлж, үндэстний шинэчлэгч, зөвлөхийн үүргийг гүйцэтгэнэ.

Хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ парламентад хэлэлцүүлэхээр оруулсан хуулийн төслийг 2 танхим дараалан хэлэлцэж батлах журамтай. Парламент жилд 3 удаа ээлжит чуулганыг тус бүр 2 сарын хугацаагаар хийж, Ерөнхийлөгч болон гишүүдийн санаачилсан хуулийн төслийг 20 хоногийн дотор танхимуудын холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлсний дараа нэгдсэн хуралдаанд оруулж, олонхийн саналаар батлах журамтай. Хуулийн төслөөр парламентын танхимуудын хооронд саналын зөрүү гарвал Засгийн газраас танхимуудын хамтарсан комисс байгуулж нэгдсэн саналд хүрэх талаар хүсэлт тавина. Үүний дагуу комисс нэгдсэн саналд хүрээгүй бол доод танхим эцэслэн шийдвэрлэх журамтай. Ерөнхийлөгч тодорхой асуудлаар зарлиг гаргаж эрх зүйн хэм хэмжээ тогтоох тухай парламентад хүсэлт гаргасан тохиолдолд гишүүдийн олонхи зөвшөөрөл олгоно. Ерөнхийлөгчийн шийдвэрээр гарсан эрх зүйн хэм хэмжээний акт тогтоосон хугацаанд парламентаар батламжлагдахгүй бол хүчин төгөлдөр бус болно.

Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхдээ асуулт, асуулга тавих, хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулан гүнзгийрүүлэн шалгах, Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах, Ерөнхийлөгчийн зарласан бүслэлт, онц байдал, дайн бүхий байдлын эрх зүйн үндэслэлийг хэлэлцэх, Сенаттай санал зөрсөн хуулийн төслөөр хамтарсан комисс байгуулж уг төслийг шийдвэрлэх зэрэг хэлбэрээр ажиллана. Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь зайлуулах эрхийг парламент эдэлнэ. Парламентын 2 танхимын хамтарсан хурлыг шаардлагатай үед ерөнхийлөгч, 2 танхимын даргын санаачлагаар хуралдуулах бөгөөд доод танхимын дарга уг хуралдааныг даргална.

ЛЕСОТО УЛС.

Лесото Улс нь Парламент бүхий Үндсэн хуульт Эзэн хаант, нэгдмэл улс. Эзэн хаан парламентыг тараах эрхтэй. Ерөнхий сайд намын дарга байхыг хуулиар хориглодог. 1993 оны Үндсэн хуулийн дагуу Лесото улсын парламент доод танхим буюу Үндэсний ассамблей (National assamblee), дээд танхим буюу Сенат (Senate) гэсэн 2 танхимтайгаар хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Парламентын доод танхим нь бүх ард түмнээс 5 жилийн хугацаатайгаар шууд сонгогддог 120 гишүүнтэй.

Парламентын доод танхимын гишүүдийн сонгуулийг 2002 оны I сарын 9-нд баталсан сонгуулийн тухай хуулийн дагуу явуулна. Сонгуулийг нэг мандат бүхий 80 тойргоос мажоритар системээр олонхийн санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцох ба улсын хэмжээний нэг тойргоос пропорциональ системээр намын нэрийн жагсаалтаар санал хурааж, 40 суудлыг хуваарилдаг байна.

Парламентын дээд танхим-Сенат Английн колони байх үеэс Басутолендийн зүгээс гарч байсан эсэргүүцлийг зөөллөх зорилгоор 1900 оноос зөвлөлдөх зөвлөл болох Үндэсний зөвлөлийг байгуулж ирсний үе уламжилсан хэлбэр нь өнөөгийн парламентын дээд танхим Сенат болсон байна.

Сенат 33 гишүүнтэй, 1900 онд батлагдсан хуулийн дагуу 22 гишүүн нь дээд албан тушаалтан байх бөгөөд тэднийг хэлбэрийн төдий нууцаар санал хурааж сонгоно. 11-ийг нь хаан томилдог байна.

Парламент дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хоёр танхим хамтарч хууль тогтоох;
2. Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихдаа
 - а/ Засгийн газрын тайланг сонсох
 - б/ Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх
 - в/ Төрийн зардлын санхүүжилтийн тайланг хэлэлцэх
 - г/ төрийн гадаад бодлогыг тодорхойлж, явцад нь хяналт тавих
 - д/ Үндсэн хуулийн биелэлтийг омбудсманы хяналтаар дамжуулан хянах
 - е/ Онц байдал, дайн бүхий байдлын эрх зүйн үндэслэлийг хэлэлцэх
 - ж/ Иргэнийг харъяат болгох;
 - з/ Иргэнийг харъяатаас хасах;
 - и/ Лесотто Улсын иргэн болгохоос татгалзах;
 - к/ Лесотто Улсын иргэнээс хасах

Доод танхим хууль тогтоох дээд эрх мэдлийг Сенаттай хамтарч гүйцэтгэнэ. Хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийж олонхийн саналаар батлан Сенатад шилжүүлнэ. Сенатад

өөрчилсөн зүйл заалтыг Доод танхим зөвшөөрсөн ч эс зөвшөөрсөн ч тэр парламентын эцсийн шийдвэр байна. Засгийн газраас явуулж байгаа төрийн бодлогын асуудалд дүн шинжилгээ хийх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын тайлан, төсвийн гүйцэтгэл, төрийн зардлын санхүүжилтийн тайланг хэлэлцэх, гадаад бодлогын асуудал, онц байдал тогтоох эрх зүйн үндэс, хуулийг хэрэгжүүлэх явц дахь Үндсэн хуулийн зарчмын биелэлтэд омбудсманы хяналт тавих замаар хэрэгжүүлнэ. Парламентын дээд танхим Сенат доод танхимын баталсан хуулийг тоймлон хэлэлцэж батлах бөгөөд хууль санаачлах эрх эдлэхгүй. Парламентыг тараасан ч Сенатын гишүүн дээд тушаалтнууд хэвээр үлдэнэ.

МАРОККО УЛС.

Марокко Улс бол Үндсэн хуульт, Эзэн хаант, нэгдмэл улс. Марокко Улс бол Арабын эзэн хаант улсуудаас хамгийн орчин үеийн либерал улсуудын нэг юм. Марокко Улсын Ван Засгийн газраа огцруулах, цэрэг хөдөлгөх, парламентыг тараах эрхтэй, гэхдээ шинээр байгуулагдсан танхимыг 1 жилийн дотор тараахгүй.

1972 он (1992 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-д батлагдсан Үндсэн хуулийн дагуу Марокко Улсын парламент доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим (Majliss-annouwab), дээд танхим буюу Зөвлөхүүдийн танхим (Majliss al-Mustacharin) гэсэн 2 танхимтайгаар хууль тогтоох бүрэн эрхийг Үндсэн хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлдэг. Парламентын доод танхим нь бүх ард түмнээс 5 жилийн хугацаатайгаар шууд сонгогддог 325 гишүүнтэй. Парламентын доод танхимын сонгууль 1997 оны 3 дугаар сарын 27-нд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн дагуу явагдах бөгөөд гишүүдийн 295 нь 95 тойргоос, эмэгтэйчүүдэд зориулсан үндэсний хэмжээний 1 тойргоос 30 нь хувь тэнцүүлэн хуваарилах системээр их дунджийн аргаар суудлыг хуваарилдаг байна.

Парламентын дээд танхим 1996 онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны дараа 1997 онд анх удаа байгуулагдсан. Дээд танхимд Үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоод, орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын төлөөлөгчид ордог. Дээд танхим нь шууд бус сонгуулиар бүс нутгийг төлөөлөх, 9 жилийн бүрэн эрх бүхий 270 гишүүнтэй. Гишүүдийн 1/3 нь 3 жил тутамд шинэчлэгдэн сонгогдох бөгөөд эхний сонгуулийн эхний ээлжийн шинэчлэх сонгууль сугалаагаар шийдвэрлэгдэнэ.

Дээд танхимын гишүүд нь дүүрэг, орон нутгийн зөвлөлийн гишүүд, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлдвэрчний байгууллагын төлөөлөгчдөөс шууд бусаар сонгогддог. Шууд биш сонгуулийн сонгогчид болох орон нутаг, бүс нутгийн зөвлөлийн гишүүд нэг талаас 162 гишүүнийг сонгох ба аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлдвэрчний эвлэлүүд зэрэг 6 төлөөллөөс 108 гишүүнийг сонгох журамтай.

Парламент дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а/ Хууль тогтоох;
- б/ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг батлах;
- в/ Улсын төсвийн тухай хууль, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ;
- в/ Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, мөрдөн шалгах түр комисс байгуулан ажиллуулах;
- г/ Засгийн газарт парламентын доод танхимын гишүүдийн s-ийн саналаар итгэл үзүүлэхгүй гэж үзсэн тохиолдолд Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох;
- д/ Засгийн газраас оруулсан Засгийн газарт итгэл хүлээлгэх эсэх асуудлыг доод танхимын гишүүдийн j-ийн саналаар хэлэлцэх;

Хууль тогтоох журам

Парламент хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ жилд 2 удаа хуралддаг ээлжит чуулган, Вангийн зарлиг болон гишүүдийн олонхийн саналаар хуралдах ээлжит бус чуулганы хуралдаанаар өргөн мэдүүлсэн хуулийн төслийг 2 танхим хоёулаа хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэр гаргана. Ерөнхий сайд, парламентын гишүүдийн санаачилж, Засгийн газрын танхимын хурлаар дэмжигдсэн хуулийн төсөл болон чуулганы завсарлагааны үед Засгийн газар баталсан хууль тогтоомжийн актуудыг хэлэлцэнэ. Парламентын доод танхим хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэсэн төслийг Парламентын дээд танхимд шилжүүлнэ.

Парламентын 2 танхим хуулийн төслийг тус бүр 2 удаа хэлэлцсэн ч саналын зөрүүтэй асуудал гарсан бол уг асуудлаар адил тооны гишүүд оролцсон хамтарсан комисс байгуулж, Засгийн газартай хамтран үндэслэлийг нь сонсож, эцсийн шийдвэр гаргана. Органик хуулийн төслийг 2 танхим заавал хэлэлцэнэ.

НАМИБИ УЛС.

Намиби Улсын Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьдаг, нэгдмэл улс юм. Ерөнхийлөгч парламентыг тараах эрх эдлэх бөгөөд парламентын 2 танхим 2/3-ын саналаар Ерөнхийлөгчийг албан тушаалаас зайлуулах эрх эдэлнэ.

Намиби Улсын парламент доод танхим буюу Үндэсний ассамблей (National assembly), дээд танхим буюу Үндэстний зөвлөл (National council) гэсэн 2 танхимтай, хууль тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Парламентын доод танхим бүх ард түмнээс 5 жилийн хугацаатайгаар шууд сонгогдох 72 гишүүн, танхимын дарга, ажлын туршлага, мэргэжил, чадварыг нь харгалзаж томилсон таслах эрхгүй 6-аас дээшгүй гишүүнээс бүрдэнэ.

Парламентын доод танхимын сонгуулийг 1992 оны VIII сарын 28-нд баталж, 1998, 1999 онд нэмэлт өөрчлөлт оруулсан сонгуулийн хуулийн дагуу явуулах журамтай. Сонгуулийг үндэсний хэмжээний 1 тойрог, 107 хэсэгт намуудын нэрсийн жагсаалтаар пропорциональ системээр явуулж, суудлыг их үлдэгдлийн зарчмаар хуваарилах журамтай. Бүрэн эрхийн хугацаа дуусаагүй байхад гишүүний суудал чөлөөлөгдвөл тухайн намд нь эрхийг нь өгөх боловч сонгуульд нэрсийн жагсаалтад хамрагдсан нэр дэвшигч байхыг илүүтэйд үздэг.

Парламентын дээд танхим нь орон нутгийн зөвлөлөөс шууд бус сонгуулиар 6 жилийн хугацаатайгаар сонгогддог 26 гишүүнтэй. Парламентын дээд танхимын сонгуулийг 1992 оны VIII сарын 28-нд баталсан сонгуулийн тухай хуулийн дагуу явуулах журамтай. Дээд танхимд 13 бүс нутгаас тус бүр 2 гишүүнийг 107 хэсэгт санал хураахдаа бүс нутгийн зөвлөлөөс шууд санал хураах зарчим баримтална.

Парламентын доод танхим-Үндэсний Ассамблей дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1/ Хууль тогтоох;
- 2/ Төсөв батлах;
- 3/ Татвар ногдуулах;
- 4/ Олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг хэлэлцэу дүгнэлт гаргах;
- 5/ Олон улсын гэрээ хэлэлцээрийг соёрхон батлахад санал өгөх;
- 6/ Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын тайланг хүлээн авч, холбогдох эрх мэдэлтнээс тайлбар авах;
- 7/ Ард нийтийн санал асуулгыг санаачилж, үндэсний ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар шийдвэр гаргах;

Судалгааны эмхтгэл, X боть

- 8/ Үндсэн хуулийн холбогдолтой асуудлаар Ерөнхийлөгчтэй зөвлөлдөх;
- 9/ Тусгаар тогтносон, эрх чөлөөт Намибийн төлөө, ядуурал, өлсгөлөн, салан тусгаарлах үйл явцын хохирогч болсон ядуу хүмүүст дэмжлэг үзүүлэх;
- 10/ Үндсэн хууль, хуулиар тогтоосон бусад бүрэн эрх;

Парламентын дээд танхим-Үндэсний зөвлөл дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Үүнд:

1. Үндэсний Ассамблейгаар хэлэлцэж шилжүүлсэн хуулийг төслийг хэлэлцэх;
2. Хууль тогтоомжийн дэд актын тайланг шалгаж, Үндэсний Ассамблейд энэ талаар илтгэл тавьж хэлэлцүүлэх;
3. Бүс нутгийн асуудлаар хууль тогтоомжийн төслийг Үндэсний Ассамблейд оруулж хэлэлцүүлэх;
4. дотоод зохион байгуулалтын асуудал, дэг журмыг тогтоох;

Парламентын доод танхим хууль тогтоохоос гадна улсын төсвийг батлах, олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, ард нийтийн санал асуулгыг санаачлах, хууль батлах, Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж, 2/3-оос дээшхийн саналаар шийдвэрлэх эрхийг эдэлнэ. Доод танхим аливаа асуудлыг хэлэлцэхэд 37, түүнээс дээш гишүүн оролцох бөгөөд Үндсэн хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Доод танхим хэлэлцэж баталсан хуулийн төслийг дээд танхимын даргад шилжүүлнэ. Дээд танхимаар хэлэлцэж, хуулийн төслийг зөвшөөрсөн бол дээд танхимын дарга батлагдсан хуулийг Ерөнхийлөгчид хэвлэн нийтлүүлэх зөвшөөрөл авахаар хүргүүлнэ.

Дээд танхимаар хэлэлцсэн төслөөр саналын зөрүү гарвал танхимын дарга энэ тухай илтгэлдээ дурдаж, доод танхимд дахин хэлэлцүүлэхээр буцаана. Дээд танхимаас ирүүлсэн саналыг доод танхимаар хэлэлцэж, баталсан төслийн хувилбарыг дахин дээд танхимд хүргүүлэх шаардлагагүй бөгөөд хууль батлагдсанд тооцож Ерөнхийлөгчид хэвлэн нийтлүүлэх зөвшөөрөл авахаар хүргүүлнэ. Хэрэв Дээд танхимын бүх гишүүдийн 2/3-ын саналаар оруулсан өөрчлөлтийг доод танхимаар хэлэлцүүлэхээр буцаасан бол доод танхим хэлэлцэж гишүүдийн 2/3-ын саналаар баталсан төсөл хүчин төгөлдөр болох ба 2/3-оос доош санал авсан бол энэ төслийг үргэлжлүүлэн хэлэлцэхгүйгээр хууль санаачлагчид буцаана.

Парламентын дээд танхим доод танхимаар хэлэлцэн баталж шилжүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхээс гадна бүс нутгийн асуудлаархи хуулийн төслийг доод танхимд санал болгох, Парламентын доод танхимтай санал нийлээгүй асуудлыг 2/3-оос дээшхийн саналаар баталж, энэ тухай илтгэлдээ оруулна. Доод танхим энэ асуудлыг дахин хэлэлцэж, 2/3-оос дээшхийн саналаар зөвшөөрвөл уг асуудал дээд танхимын саналаар шийдвэрлэгдсэнд тооцно. Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын хөтөлбөрийг хэлэлцэж батлах, улсын төсвийг батлахын өмнө шалгалтын комисс оруулах, Засгийн газарт асуулт, асуулга тавьж, хариуг сонсох, омбудсманы хяналт зэрэг хэлбэрийг ашигладаг байна.

НИГЕРИ

Холбооны Бүгд Найрамдах Нигери Улс

Парламентын танхимуудын нэр:

- а) Дээд танхим: Сенат (Senate)

b) Доод танхим: Төлөөлөгчдийн танхим (House of Representatives)²⁸

Бүрэн эрх

2007 оны парламентын сонгуулиар өнгөрсөн 37 жилийн хугацаанд 7 дахь парламент нь байгуулагдсан байна. Парламентын доод танхим бүх нийтийн шууд сонгуулиар 4 жилийн хугацаатайгаар сонгогддог 360 гишүүнтэй, дээд танхим муж улс тус бүрээс 3, нийслэлээс 1 бүгд 109 гишүүнтэй байна. Парламентын дээд танхимын гишүүн 35 нас, доод танхимын гишүүн нэр дэвшихдээ 30 насанд хүрсэн байх ёстой. Парламентын доод, дээд танхимын дарга, дэд даргыг гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, танхим тус бүрээсээ сонгоно.

Тус улсын Үндсэн хуулийн 5 дугаар бүлэгт хууль тогтоох эрх мэдлийг хуульчилсан бөгөөд Үндэсний Ассамблейн танхимуудын бүрэн эрхийг нэгтгэн зохицуулсан байна. Үндсэн хуулиар танхимуудын бүрэн эрхийг дараахь байдлаар зохицуулсан байна:

57.1 Парламент нь хоёр танхим бүрээр хууль хэлэлцэн батлах замаар хууль тогтоох эрхээ эдлэнэ.

57.2 Санхүүгийн хуулиас бусад хуулийг Парламентийн аль ч танхим санаачлан хэлэлцэж болно. Санхүүгийн хуулийг зөвхөн Төлөөлөгчдийн танхим санаачлан хэлэлцэнэ.

57.3 Хуулийн төсөл нь анх санаачлан хэлэлцсэн танхимаас батлагдвал нөгөө танхимд шилжинэ.

Түүнчлэн, Үндсэн хуулийн 58 дугаар зүйлд зааснаар **Сенат нь**:

1. Тухайн хууль тогтоомж нь Төлөөлөгчдийн танхимаас өргөн баригдаагүй тохиолдолд дараах зорилгоор тухайн хуулийг хэлэлцэхгүй:
 - (i) Татвар ногдуулах, хүчингүй болгох, өөрчлөх
 - (ii) Холбооны нэгдсэн орлогын сан болон Холбооны бусад сангуудад төлбөр хураамж тогтоох
 - (iii) Нэгдсэн орлогын сангаас болон Холбооны бусад сангуудаас төлсөн төлбөр, эдгээрт орсон орлого, зарлагын ямар ч дүнд аливаа төлбөр ноогдуулах
 - (iv) Холбооны татварын бүрэлдэхүүн болон хөнгөлөлт үзүүлэх зорилгоор тус хуулийн төслийг хэлэлцэхгүй.

Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар **Төлөөлөгчийн танхим нь**: Ерөнхийлөн захирагчийн санал болгосноор, Холбооны Засгийн газрын сайдын мэдэгдснээс бусад тохиолдолд Төлөөлөгчдийн танхим нь дараах зорилгоор аливаа хууль тогтоомж болон хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцэхгүй:

- (i) Татвар ногдуулах, хүчингүй болгох, хөнгөлөхөөс бусдаар өөрчлөх
- (ii) Холбооны нэгдсэн орлогын сан болон Холбооны бусад сангуудад аливаа төлбөр хураамж тогтоох, хөнгөлөхөөс бусдаар өөрчлөх
- (iii) Нэгдсэн орлогын сангаас болон Холбооны бусад сангуудаас төлсөн төлбөр, эдгээрт орсон орлого, зарлагын ямар ч дүнд аливаа төлбөр ноогдуулах, хэрэв тийм төлбөр байгаа бол үүнийг ихэсгэх
- (iv) Холбооны татварын бүрэлдэхүүн болон хөнгөлөлт зорилгоор тус хуулийн төслийг хэлэлцэхгүй.

²⁸ ХБННУ-ын Үндсэн хууль, 5 дугаар бүлэг, 1 дүгээр хэсэг, 47-р зүйл.

Нигери улсын нэг онцлог нь Үндсэн хуулиар Сенатын хууль тогтоох эрх мэдэлд тодорхой хязгаарлалт²⁹ тавьсан явдал юм.

Сенатын эрх мэдлийн хязгаарлалт

- Санхүүгийн хуулийн төсөл нь Төлөөлөгчдийн танхимаас батлагдан чуулган тарахаас хамгийн багадаа 1 сарын өмнө Сенатад хүргэгдсэн тохиолдолд 1 сарын дотор Сенатаас ямар нэгэн өөрчлөлтгүйгээр батлагдаагүй байвал хэрэв Төлөөлөгчдийн танхим өөрөөр шийдвэрлээгүй бол Ерөнхийлөн захирагчид өргөн барина.
- Хэрэв:
 - (а) Санхүүгийн хуулиас бусад хуулийн төсөл нь Төлөөлөгчдийн танхимаар батлагдан, чуулган тарахаас өмнө хамгийн багадаа 1 сарын өмнө Сенатад шилжиж, чуулган тарахаас өмнө Сенатаас батлагдаагүй, эсвэл ямар нэгэн өөрчлөлтгүйгээр батлагдан, тухайн өөрчлөлтийг Төлөөлөгчдийн танхим чуулган тарахаас өмнө хэлэлцэн зөвшөөрөөгүй тохиолдолд;
 - (b) Дараагийн чуулган хуралдахад (өмнөх парламент эсвэл шинэ парламент болохтой үл хамааран) тухайн хуулийн төсөл нь Төлөөлөгчдийн танхимаас дахин батлагдаж, чуулган тарахаас хамгийн багадаа 1 сарын өмнө Сенатад шилжин, чуулган тарахаас өмнө Сенатаас батлагдаагүй эсвэл ямар нэгэн өөрчлөлтгүйгээр батлагдан, тухайн өөрчлөлтийг төлөөлөгчдийн танхим чуулган тарахаас өмнө хэлэлцэн зөвшөөрөөгүй тохиолдолд;
 - Төлөөлөгчдийн танхим өөрөөр шийдвэрлээгүй бол Ерөнхийлөн захирагчид өргөн барина. Хэрэв хоёр танхимаар хоёулангаар нь хэлэлцэгдэн батлагдсан нэмэлт өөрчлөлт байвал эдгээрийг мөн Ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлд өргөн барина.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Парламентын доод танхимын сонгуулийг 1982 оны VIII сарын 5-нд баталсан сонгуулийн хуулийн дагуу сонгуулийн мөжаритар системээр явуулах журамтай. Нэг мандат бүхий 360 тойргоос улс төрийн намуудаас нэр дэвшигчдийг сонгогч шууд сонгох бөгөөд олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогддог. Доод танхимын гишүүн 30 нас хүрсэн байх бөгөөд төрийн тэргүүн, бусад танхимын гишүүн, төрийн сайд, төрийн өндөр албан тушаалтан, шүүгчид, төрийн албан хаагчид, сонгуулийн комиссын гишүүд, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийхний үүргийг бүрэн эрхийн хугацаанд хавсарч болохгүй. Нэр дэвшигчид намаас дэвших ба 20000 найра-г барьцаа болгож өгөх журамтай.

2007 оны IV сарын 27-нд явагсан Парламентын доод танхимын сонгуулиар Ардын ардчилсан нам (PDP) олонхи болж, тус танхимын даргаар хатагтай Патриция Олубунми Этте (анхны эмэгтэй дарга) сонгогджээ. Харин 3 сарын дараа энэ хатагтай мөнгө, хөрөнгө шамшигдуулсан асуудлаар огцорсон байна. Энэ сонгуулийн дүнгээр 25 эмэгтэй нэр дэвшигч гишүүнээр сонгогдсон байна.

Сенатын сонгуулийг 1982 оны VIII сарын 5-нд баталсан сонгуулийн тухай хуулийн дагуу сонгуулийн мөжаритар системээр явуулах журамтай. Нийслэлийн 1 мандат бүхий 1 тойрог, 3 мандат бүхий 36 тойргоос улс төрийн намуудаас нэр дэвшигчдийг сонгогч шууд сонгох бөгөөд олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогддог. Сенатын гишүүн 35 нас хүрсэн байх бөгөөд төрийн тэргүүн, бусад танхимын гишүүн, төрийн сайд, төрийн өндөр албан тушаалтан, шүүгчид, төрийн албан хаагчид, сонгуулийн комиссын гишүүд,

²⁹ ХБННУ-ын Үндсэн хууль, 5 дугаар бүлэг, 59 дүгээр зүйл.

зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийхний үүргийг бүрэн эрхийн хугацаанд хавсарч болохгүй. Нэр дэвшигчид намаас дэвших ба 30000 найра-г барьцаа болгож өгөх журамтай.

Төрийн дээд эрхийг барих субъект: Нигери Улс АНУ-ын загвартай Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьдаг, Холбооны улс юм.

ӨМНӨД АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС

Парламентын танхимуудын нэр:

- a) Дээд танхим: Үндэсний Ассамблей (the National Assembly)
- b) Доод танхим: Мужийн Үндэсний Зөвлөл (the National Council of Provinces)

Парламент, түүний бүрэн эрх

Өмнөд Африкийн анхны парламент-Үндэсний Конгресс 1912 онд байгуулагджээ. 1948-1980 онд 2 танхимтай парламент ажиллаж байгаад 1980-1984 онд 1 танхимтай, 1984-1994 онд 3 танхимтай парламенттай байжээ. 1994 оноос 2 танхимтай парламентыг сэргээсэн байна. 1960-1990 он хүртэл 30 жилийн турш улс төрийн нам нууц байдалд ажилласан байна. 1990 онд Нелсон Мандела зэрэг улс төрийн хоригдлууд суллагдсаны дараа улс төрийн намуудын үйл ажиллагаа ил болсон байна. 1996 оны Үндсэн хуулиар үндэсний хэмжээний хууль тогтоох эрх мэдлийг Парламент хэрэгжүүлэхээр тогтоосон байна.

ӨАБНУ-ын Үндсэн хуулийн 43, 44 дүгээр зүйлүүдэд хууль тогтоох байгууллагын бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд мөн хуулийн 55 дугаар зүйлд Үндэсний Ассамблейн бүрэн эрхийг, 68 дугаар зүйлд Мужийн Үндэсний Зөвлөлийн бүрэн эрхийг тус тус хуульчилсан байна.

43 дугаар зүйлд заасны дагуу Парламентын дээд танхим нь хууль тогтоох дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- Үндсэн хуулийн 4 болон 5 дугаар Хавсралтад холбогдох асуудлаар хууль батлах
- Төрийн албан хаагчдыг томилно.

Түүнчлэн, Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд зааснаар Үндэсний Ассамблей нь:

1. Үндэсний Ассамблей нь хууль тогтоох дараахь эрх мэдлийг хэрэгжүүлнэ:
 - Аливаа хууль тогтоомжийг хэлэлцэх, батлах, нэмэлт өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох
 - Мөнгөний хуулийн төслөөс бусад хууль тогтоомжийг санаачлах,
2. Үндэсний Ассамблей нь дараахь механизмийг бүрдүүлнэ:
 - Гүйцэтгэх засаглалын бүх байгууллагууд нь Үндэсний Засгийн газарт үйл ажиллагаагаа тайлагнах нөхцлийг бүрдүүлэх
 - Дараахь хяналтыг хэрэгжүүлнэ:
 - Үндэсний гүйцэтгэх эрх мэдлийн биелэлт, хуулийн хэрэгжилт
 - Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавина.

Доод танхим нь хууль тогтоох, мужийг парламентад төлөөлөх, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна өөрийн бүтцийг байгуулах дотоод дэг журмаа тогтоох эрх эдэлнэ.

Парламентын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

- ❖ Улс төрийн системийн
- ❖ Тайлангийн
- ❖ Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны
- ❖ Төсөв
- ❖ Улсын төсвийн зардал
- ❖ Төсвийн гүйцэтгэл
- ❖ Гадаад бодлого
- ❖ Батлан хамгаалах салбарын үндэсний бодлогын
- ❖ Онц байдлын
- ❖ Хуулийг Үндсэн хуульд нийцүүлэн хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавина.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Үндсэн хуулийн 46 болон 47 дугаар зүйлээр дээд танхим буюу Үндэсний Ассамблейн сонгуулийн ерөнхий зохицуулалтыг журамласан. ӨАБНУ-ын Парламентын доод танхим бүх ард түмнээс 5 жилийн хугацаатайгаар шууд сонгогддог 400 гишүүнтэй, Парламентын дээд танхим нь мужийн хууль тогтоох байгууллагаас 5 жилийн хугацаатайгаар сонгогддог 90 гишүүнтэй, 54 нь сонгогдох бөгөөд байнгын гишүүн, 36 нь солигдож томилогдож байдаг байна. Тэдгээрийн дотор мужийн Ерөнхий сайд, түүний сонгосон 3 тусгай, 6 байнгын гишүүн ордог. Парламентын 2 танхим танхимын дарга, дэд даргыг гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, танхим тус бүрээсээ сонгоно. Парламентын 2 танхимын даргын дэргэд танхимын товчоо, Дарга нарын бага хурлыг байгуулан ажиллуулдаг.

Парламентын доод танхимын сонгуулийг 1993 оны XII сарын 1-нд баталсан Сонгуулийн тухай хуулийн дагуу явуулах журамтай. Сонгуулийн тухай хуулийн дагуу доод танхимын гишүүдийн сонгуулийг 9 мужид байгуулагдсан 4-43 мандаттай тойргоос пропорциональ системээр явуулж, намын хаалттай жагсаалтаар санал хурааж суудлыг хуваарилна. Ингэхдээ 200 суудлыг Үндэсний хэмжээний намуудын жагсаалтаас, 200 суудлыг бүс нутгийн намуудын жагсаалтаас сонгох журамтай.

Төрийн дээд эрхийг барих субъект

ӨАБНУ-ын парламент нь төрийн дээд эрхийг барьдаг, Холбооны улсын зарим шинж бүхий Нэгдмэл улс юм. Ийм эрх мэдлийн хуваарьтай улс дэлхийд өөр байхгүй ба Ерөнхийлөгч нь Парламентаас 5 жилийн хугацаатай сонгогдох бөгөөд Засгийн газрын тэргүүн байна.

Хууль тогтоох журам

Аливаа төслийг Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Парламентын 2 танхим дараалан хэлэлцэж, олонхийн саналаар баталсны дараа Ерөнхийлөгчид батламжлуулахаар шилжүүлдэг. Хуулийн төслийг 2 танхимын алинд ч өргөн барьж болно. Санхүүгийн холбогдол бүхий хуулийн төслийг зөвхөн доод танхимд өргөн барина. Парламентын доод танхим нь хууль тогтоох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна өөрийн бүтцийг байгуулах дотоод дэг журмаа тогтоох эрх эдэлнэ. Тус улсын Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэгт “Үндэсний хууль тогтоох процесс” гэсэн бие даасан зохицуулалт байх ба 73-83 дугаар зүйл бүхий нилээд өргөн хүрээний зохицуулалт багтсан байна. Үүнээс 75 дугаар зүйлд хуулийн төслийг батлахад 2 танхим санал зөрсөн тохиолдолд хэрхэн шийдвэрлэхийг дараахь байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Үндэсний Ассамблей энэ хуулийн 74 болон 76 дугаар зүйлд зааснаас бусад

хуулийг баталсан тохиолдолд тухайн хууль нь Мужийн Үндэсний Зөвлөлд шилжинэ.

- (а) Үндэсний Зөвлөл дараах байдлаар шийдвэрлэж болно.
 - (i) Хуулийг тэр чигээр нь батлах;
 - (ii) Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналтайгаар батлах;
 - (iii) Хуулийг буцаах.
- (b) Хэрэв хуулийг нэмэлт өөрчлөлт оруулах саналтайгаар баталвал уг хуулийг Ерөнхийлөгчийн зөвшөөрөлд өргөн барина.
- (c) Хэрэв хуулийг буцаах буюу нэмэлт өөрчлөлт оруулах саналтайгаар баталвал Үндэсний Ассамблей тухайн хуулийг дахин авч хэлэлцэх буюу Мужийн Үндэсний Зөвлөлөөс оруулсан нэмэлт өөрчлөлт оруулах саналыг авч хэлэлцэн дараахь шийдвэр гаргана:
 - (i) Хуулийг нэмэлт өөрчлөлтэйгээр болон хэвээр нь дахин батлах; буюу
 - (ii) Хуулийг дахин авч хэлэлцэхгүй байхаар шийдвэрлэж болно.
 - (d) Хэрэв энэ хуулийн С хэсэгт заасан хууль батлагдвал Ерөнхийлөгчийн зөвшөөрөлд өргөн барина. гэж заасан байна.

СЕНЕГАЛ

Бүгд Найрамдах Сенегал Улс

Парламентын танхимуудын нэр:

- a) Дээд танхим: Үндэсний ассамблей (Assemblée nationale)
- b) Доод танхим: Сенат (Senate)

Парламент, түүний бүрэн эрх

Сенегал Улсын анхны хууль тогтоох байгууллага 1960 онд байгуулагдаж байв. 1973 оны сонгуулийг оруулаад 4 сонгуулиар зөвхөн нэг намын оролцоотой парламент байгуулагдаж байжээ. 1993 оноос хойш олон намын оролцоотой парламентын сонгуулийг явуулах болсон байна.

Парламентын доод танхимын гишүүн төрийн сонгуульт бус чиг үүрэг биелүүлдэг этгээдийн, эдийн засаг, нийгмийн зөвлөлийн гишүүний, гадаадын улс, олон улсын байгууллагад ажил эрхлэгчийн, гүйцэтгэх засаглалын болон төрийн оролцоотой компани, хадгаламж, зээлийн байгууллага, компанийн удирдлагын, Засгийн газрын сайдын, зэвсэгт хүчин, цагдаа, цэргийн жинхэнэ албан хаагчийн үүргийг хавсран гүйцэтгэж болохгүй.

Түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихдаа Засгийн газрын хөтөлбөрийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, Засгийн газарт итгэл үзүүлэх, эсэх, буруушаах, төсөв, татварын бодлогын асуудлаар хэлэлцүүлэг явуулах, тодорхой асуудлаар хяналтын түр хороо байгуулан ажиллуулах, Үндэсний болон олон улсын чанартай асуудлаар асуулга, асуулт тавьж хариуг сард 1 удаа сонсох, төрийн байгууллагуудын ажилтай танилцах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Сенегал улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд танхимуудын бүрэн эрхийг дараахь байдлаар хуульчилсан байна:

- a) Үндэсний Ассамблей нь хууль тогтоох эрхийг эдэлнэ.
- b) Үндэсний Ассамблей нь дараахь асуудлаар хууль батлана:
 - Иргэний эрх, нийтлэг эрх чөлөөгөө эдлэхэд нь иргэдэд олгосон үндсэн

- баталгаа
- Үндэсний батлан хамгаалах хүчний хувь хүн болон иргэдийн өмчид үзүүлэх хязгаарлалтууд
- Иргэншил, хувь хүний статус, иргэний гэрлэлт, өв залгамжлуулалт болон бэлэглэл
- Гэмт үйлдлүүд болон авах арга хэмжээ, шийтгэлийг тогтоох, өршөөл, шүүхийн шинэ журмыг тогтоох, шүүгч нарын статус
- Бүх төрлийн татварын хувь хэмжээ, татвар хураах нөхцөл, мөнгөн тэмдэгт хэвлэн, тараах тухай дүрэм журам
- Үндэсний ассамблей болон орон нутгийн ассамблейн сонгуулийн систем
- Төрийн байгууллагыг байгуулах
- Иргэний болон улсын цэргийн үндсэн баталгаа
- Аж ахуйн нэгжүүдийг улсын мэдэлд авах, төрийн өмчит аж ахуйн нэгжийг хувийн өмчид шилжүүлэх
- Үндэсний Ассамблей нь дараахь асуудлуудын үндсэн зарчмыг хуулиар тогтооно:
- Үндэсний батлал хамгаалахын ерөнхий бүтэц, зохион байгуулалт
- Орон нутгийн удирдлагын ур чадвар болон нөөц
- Боловсрол
- Өмчийн дэглэм, бодит эрх, иргэний үүрэг, худалдаа
- Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
- Төрийн албан хаагчдын цалин урамшууллын багц

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Парламентын доод танхимын сонгуулийг 1991 оны Ү сарын 20-нд баталсан сонгуулийн хуулийн дагуу можаритар, пропорциональ холимог системээр явуулах журамтай. Үндэсний ассамблейн 90 суудалд нэр дэвшигчдийг олон мандат бүхий 35 тойргоос можаритар системээр ердийн олонхийн санал авсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцох ба 60 суудалд намуудаас нэр дэвшигчдийг пропорциональ системийн их үлдэгдлийн аргаар суудал хуваарилах зарчмаар сонгох журамтай.

Сенатын 35 гишүүнийг нэг мандаттай 35 тойрогт нам, намын эвслүүдээс нэр дэвшүүлж, 45 бүс нутгийг төлөөлсөн бүс нутгийн, орон нутгийн зөвлөлийн гишүүдээс бүрдсэн сонгогчид сонгох журамтай.

Төрийн дээд эрхийг барих субъект

Сенегал улс нь Ерөнхийлөгчийн засаглалтай улс бөгөөд бүх ард түмний сонгуулиар 5 (2001 оноос) жилийн хугацаагаар сонгогддог, Нэгдмэл улс юм.

Хууль тогтоох журам

Парламентын доод танхим хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ Ерөнхийлөгч, Засгийн газар, Парламентын танхимуудын гишүүдээс санаачилсан хуулийн төслийг хэлэлцэж, ердийн хуулийг олонхийн саналаар, органик хуулийн төслийг гишүүдийн 3/5-ийн саналаар баталж Сенатад шилжүүлэх журамтай. Хууль батлагдсаны дараа хуанлийн 6 хоногт багтаж Ерөнхийлөгч болон гишүүдийн 1/10 нь шаардлагатай гэж үзсэн бол Үндсэн хуулийн зөвлөл түүнийг Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар хянан үзнэ.

Сенат Парламентын доод танхим баталсан хуулийн төслийг хэлэлцэж батлан Ерөнхийлөгчид өргөн барихаас гадна Сенатуудын санаачилсан хуулийн төслийг хэлэлцэж, доод танхимд шилжүүлнэ. Түүнчлэн Засгийн газрын мөрийн хөтөлбөр, төсвийн хуулийг хэлэлцэж батлахдаа бүс нутаг, үндэстний асуудалд илүү анхаарч ажиллана.

ТУНИС

Бүгд Найрамдах Тунис Улс

Парламентын танхимуудын нэр:

- a) Дээд танхим: Депутатуудын танхим (Majlis al-Nuwab) Chamber of Deputies
- b) Доод танхим: Зөвлөхүүдийн танхим (Majlis al-Mustasharin) Chamber of Advisors³⁰

Парламент, түүний бүрэн эрх

Тунис Улс тусгаар улс болсны дараа 1956 оны III сарын 25-ны бүх нийтийн сонгуулиар анхны парламент Үндсэн хуулийн хурал нэртэй байгуулагдаж байжээ. 1959 онд Үндсэн хууль баталсаны дараа Ерөнхийлөгчийн болон парламентын сонгууль явагдсан ба 2009 оны парламентын сонгуулийг оруулаад 13 дахь удаагийн парламент нь байгуулагдан ажиллаж байна 1979, 1987 онд Ерөнхийлөгч парламентыг тарааж байсныг эс тооцвол Африк тивдээ парламентын сонгууль тогтвортой явагддаг орны тоонд багтаж байна.

Тус улсын Үндсэн хуулийн онцлог нь танхимуудын бүрэн эрхийг тус тусад нь хуульчилаагүй бөгөөд 2 дугаар бүлэгт хууль тогтоох эрх мэдлийг нэгтгэн хуульчилсан байна. Тус хуулинд зааснаар Тунисын Парламент хууль тогтоох дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) Депутатуудын танхим болон Зөвлөхүүдийн танхим нь олонхийн саналаар органик болон ердийн хуулийг батлах эрхтэй. Дээр дурдсан олонхийн санал нь тухайн танхимын гишүүдийн гуравны нэгээс доошгүй байна.
- b) Депутатуудын танхим болон Зөвлөхүүдийн танхим нь санхүүгийн хуулийн төсөл болон төсвийн органик хуулийн дагуу төсвийн зохицуулалтын хуулийг батлана.
- c) Хуульд заасан дараахь асуудлаар:
 - Органик хуульд зааснаас бусад Үндсэн хуулийг сахиулах ерөнхий нөхцлүүд
 - Төрийн байгууллага болон төрийн оролцоотой аж ахуйн нэгжийн ангилалыг бий болгох
 - Иргэншил, хувь хүний статус болон үүрэг хариуцлага.
 - Гэмт хэргийн тодорхойлолт, авч болох ял шийтгэл, хорих ял хүртээх гэмт үйлдлийн тодорхойлолт
 - Өршөөл үзүүлэх
 - Санхүү болон татварын хуульд ерөнхийлөгчид тодорхой эрх өгснөөс бусад тохиолдолд татварын хувь, хэмжээ, татвар хураах ажил, үйл явцыг тодорхойлох
 - Мөнгөн тэмдэгтийг хэвлэх, тараах систем
 - Засгийн газрын өр зээл, санхүүгийн үүрэг амлалтууд
 - Энгийн иргэн болон цэргийн албан хаагчдад зохицуулан гаргасан үндсэн баталгаанууд зэрэг асуудлаар шийдвэр гаргана.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Парламентын доод танхим нь 5 жилийн хугацаатайгаар бүх ард түмнээс шууд сонгогддог

³⁰ ӨАБНУ-ын Үндсэн хууль, 4 дүгээр бүлэг, 42 дугаар зүйл. 1996 №108

Судалгааны эмхтгэл, X боть

214 гишүүнтэй, дээд танхим нь 126 гишүүнтэй, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 6 жил байдаг. Дээд танхимын гишүүдийн 50 хувь нь 3 жил тутамд шинэчлэн сонгогддог. Парламентын дээд, доод танхимын дарга, 2 дэд даргыг ээлжит чуулган бүрийн эхэнд гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, олонхийн саналаар 1 жилийн хугацаагаар сонгоно. Парламентын доод танхимын зөвлөл, дээд танхимын товчооны бүрэлдэхүүнд танхимын дарга, 2 дэд дарга, 7 байнгын хорооны дарга, Байнгын хороо тус бүрээс итгэмжлэгдсэн төлөөлөл 7 гишүүн ордог.

Парламентын доод танхимын гишүүдийн сонгуулийг 1969 оны IV сарын 8 (2009 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-нд баталсан сонгуулийн хуулийн дагуу можаритар болон хувь тэнцүүлэн сонгох холимог системээр явуулдаг. Улсын хэмжээнд олон мандаттай 26 тойргоос 161 гишүүнийг сонгодог, 53-ыг нь улсын хэмжээний 1 тойргоос намын нэрийн жагсаалтаар санал авч хувь тэнцүүлэх аргаар суудлыг хуваарилахаар сонгуулийн хуульд заасан.

Парламентын дээд танхимын анхны сонгууль 2005 оны VI сарын 3-нд болжээ. Парламентын дээд танхимын 126 гишүүнээс 85 нь шууд бусаар сонгогдож, 41-ийг Ерөнхийлөгч томилдог байна. Шууд бус сонгуулиар орон нутгийн доод шатны зөвлөлөөс тодруулсан сонгогчид нь нийт ард түмнийг төлөөлж, нэр дэвшигчдээс гишүүдийг сонгодог журамтай

Төрийн дээд эрхийг барих субъект

Тунис Улс Үндсэн хуулийн дагуу 5 жилээр бүх ард түмнээс шууд сонгогддог Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьдаг, Нэгдмэл улс юм. Тунис Улс тусгаар тогтносны дараахан 1956 оны III сарын 25-нд үндэсний хэмжээний сонгуулиар Үндэсний Үндсэн хуулийн хурлыг байгуулж, Хаант улсын Үндсэн хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Зохион байгуулах хороог байгуулан ажиллуулсан байна.

Хууль тогтоох журам

Үндсэн хуулиар Парламентын баталж мөрдүүлэх хууль, эрх зүйн орчны хүрээг хязгаарлаж тогтоосон байдаг. Хууль тогтоох үйл ажиллагаанд Ерөнхийлөгч тодорхой бүрэн эрхийг давхар эдэлдэг байна. Парламент хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ жил бүр тогтмол хийдэг ээлжит чуулганаар болон ээлжит бус, тусгай чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэж, ердийн олонхийн саналаар батлах бөгөөд түүнд Ерөнхийлөгч 15 хоногийн дотор хориг тавьж болно. Хориг тавьсан төслийг Парламент 2/3-оос дээшхийн саналаар хүлээн авсанд тооцдог бөгөөд хууль шууд хүчин төгөлдөр болно.

Доод танхим өргөн баригдсан хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийж, олонхийн саналаар баталсан тохиолдолд дээд танхимд хэлэлцүүлэхээр шилжүүлнэ. Дээд танхим хугацаандаа хэлэлцээгүй болон 2 танхим санал зөрсөн асуудлаар нэгдмэл байр сууринд хүрч чадаагүй төслийг доод танхим Ерөнхийлөгчид шууд ёсчлуулахаар өргөн барих эрхтэй. Санхүүгийн холбогдолтой хуулийн төслийг зөвхөн доод танхим дангаараа хэлэлцэж батлан Ерөнхийлөгчид ёсчлуулахаар өргөн барина. Органик хуулийн төслийг нийт гишүүдийн олонхийн саналаар, ердийн хуулийн төслийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гэхдээ нийт гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар батална.

Парламентын дээд танхим Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоох ажиллагаанд оролцоно. Парламентын дээд танхим, доод танхимаас хэлэлцэж шилжүүлсэн хуулийн төслийг 15 хоногийн хугацаанд хэлэлцэж батлах журамтай. Хэрэв Парламентын доод танхимаас шилжүүлсэн төсөлд дээд танхим өөрчлөлт оруулан баталсан бол Ерөнхийлөгчид ёсчлуулахаар өргөн барих бөгөөд энэ тухай доод танхимд мэдэгдэнэ. Парламентын дээд танхим органик хуулийн төслийг нийт гишүүдийн олонхийн саналаар, ердийн хуулийн төслийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гэхдээ нийт

гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар батална.

ЭТИОП

Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улс.

Парламентын танхимуудын нэр:

- a) Дээд танхим: Холбооны Танхим (House of the Federation)
- b) Доод танхим: Ардын Төлөөлөгчдийн Танхим (Yehizb Tewokayoch Mekir Bete) (House of Peoples' Representatives)³¹

Парламент, түүний бүрэн эрх

Шинэ үеийн парламент нь 1994 онд баталсан Үндсэн хуулийн дагуу 2 танхим бүхий Холбооны Ассамблей бөгөөд 1995 оны сонгуулиар шинэ үеийн анхны парламентын 2 танхимыг байгуулсан байна. **Доод танхим** болох Ардын Төлөөлөгчдийн Танхим нь нийт ард түмнээс 5 жилийн хугацаатай шууд сонгогдох бөгөөд 550 гишүүнтэй байна.

Доод танхим нь тус улсын **Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд** заасан дараахь бүрэн эрхийг эдлэнэ. Үүнд:

1. Төлөөлөгчдийн Танхим нь Үндсэн хууль болон хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд хуульд заасан бүх асуудлаар хууль гаргах эрхтэй.
2. Нэгдүгээр зүйлд заасны дагуу Төлөөлөгчдийн Танхим нь дараах асуудлуудаар хууль гаргах бүрэн эрхийг эдэлнэ.
 - (a) Газар болон бусад байгалийн баялгийн ашиглалт, улсын хил дамнасан, хоёр ба түүнээс дээш тооны мужуудыг холбон байрлах гол мөрөн, нуурын ашиглалт
 - (b) Муж хоорондын худалдаа, гадаад худалдаа
 - (c) Агаарын, төмөр замын, усан замын болон далайн тээвэр, хоёр болон хоёроос дээш мужийг холбосон гол замууд, шуудан, цахилгаан холбооны үйлчилгээ
 - (d) Үндсэн хуулиар олгогдсон улс төрийн эрхийн хэрэгжилтийг сахиулах, сонгуулийн тухай хуулиуд болон сонгууль явуулах журам
 - (e) Иргэншил, цагаачлал, паспорт, тус улсад нэвтрэх болон тус улсаас гарах, дүрвэгсдийн эрх болон орогнох эрх
 - (f) Хэмжилтийн болон хуанлийн нэгдсэн стандарт
 - (g) Патент, зохиогчийн эрх
 - (h) Зэвсэг эзэмших, зөөвөрлөх
3. Хөдөлмөрийн хуулийг батална.
4. Худалдааны хуулийг батална.
5. Эрүүгийн хуулийг батална. Холбооны эрүүгийн хуульд тусгайлан заагаагүй зарим асуудлаар мужууд тус тусын эрүүгийн хуулийг батлан мөрдөх эрхтэй.
6. Нэгдсэн нэг эдийн засгийн тогтолцоог хангах үүднээс Холбооны Танхимаас шаардлагатай гэж үзсэн иргэний хуулиудыг батлах.
7. Үндэсний батлан хамгаалалт, олон нийтийн аюулгүй байдал болон Үндэсний цагдаагийн хүчний бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох. Хэрэв дээрх хүчнүүдийн үйл ажиллагаа нь хүний эрх болон үндэсний аюулгүй байдалд заналхийлэхэд хүрвэл

³¹ БНАЭУ-ын Үндсэн хууль, 6 дугаар бүлэг, 53 дугаар зүйл.

Төлөөлөгчдийн Танхим нь шалган байцаах үйл ажиллагааг явуулж, шаардлагатай арга хэмжээг авна.

8. Үндсэн хуулийн 93 дугаар зүйлд нийцүүлэн онцгой байдал зарлана. Засгийн газрын зарласан онцгой байдлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргана.

9. Сайд нарын зөвлөлөөс өргөн барьсан хуулийн төслийн дагуу дайны байдал зарлана.

10. Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, санхүү, мөнгөний ерөнхий бодлого, стратегийг батлана. Орон нутгийн мөнгөн тэмдэгт, Үндэсний банкны, гадаад валютын удирдлагын хуулийг батлана.

11. Холбооны Засгийн газарт хамаарах орлогын эх үүсвэрүүдээс татвар хураах, Холбооны төсвийг батлана.

12. Засгийн газрын байгуулсан олон улсын гэрээг баталгаажуулна.

13. Холбооны шүүгчид, Сайд нарын Зөвлөлийн гишүүд, Комиссын гишүүд, Ерөнхий Аудит болон хуулиар томилогддог бусад албан тушаалтнуудын томилгоог батлана.

14. Хүний эрхийн комиссыг байгуулж, эрх үүргийг нь хуулиар тогтооно.

15. Омбудсмений байгууллагыг байгуулж, гишүүдийг нь томилно. Тус байгууллагын эрх үүргийг хуулиар тогтооно.

16. Эрх бүхий байгууллага болон албан тушаалтан нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хүний эрхийг зөрчиж буй үйлдлүүдийг хорих арга хэмжээ авч чадахгүйд хүрвэл өөрийн санаачлагаар Холбооны Танхим болон Төлөөлөгчдийн Танхимын нэгдсэн хуралдааныг хуралдуулах хүсэлт гаргана. Нэгдсэн хуралдаанаар гарсан нэгдсэн шийдвэрийн дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтанд удирдамж, захирамж өгнө.

17. Ерөнхий сайд болон бусад холбооны албан тушаалтнуудыг шаардлагатай гэж үзвэл дуудан асуулга тавих, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаатай танилцаж, үүргээ хэрхэн гүйцэтгэж буйг шалгах.

18. Төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүй хувийн саналаар гүйцэтгэх засаглалын эрх мэдэлтэй холбогдох аливаа асуудлыг хэлэлцэх, шаардлагатай гэж үзвэл энэ талаар шийдвэр гаргах.

19. Танхимын дарга болон орлогч даргыг сонгох, шаардлагатай гэж үзвэл байнгын болон түр хороодыг байгуулах эрхтэй.

Дээд танхим:

Үндсэн хуульд зааснаар Парламентын дээд танхим болох Холбооны Танхим нь нийт үндэстэн ястны төлөөллийг оролцуулах бөгөөд Төрийн Зөвлөлөөс 5 жилийн хугацаатай сонгогдоно. Ийнхүү сонгохдоо үндэстэн ястан бүрээс наад зах нь нэг гишүүн байх ба хүн амын нэг сая тутамд нэмэлт нэг гишүүн байхаар төлөөлүүлнэ. **Үндсэн хуулийн 62-р зүйлд** дээд Танхимын чиг үүрэг болон бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд энэ нь дараахь байдалтай байна. Үүнд:

1. Үндсэн хуулийг тайлбарлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2. Үндсэн хуулийн цэцийг эмхлэн байгуулна.

3. Үндэстнүүдийн эрх, үндэстэн болон ард түмний бие даах болон салан тусгаарлахтай холбоотой асуудлуудыг Үндсэн хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.

4. Үндсэн хуульд заасан Этиопын ард түмний эрх тэгш байдлыг хангаж, харилцан зөвшилцлийн үндсэн дээр ард түмний нэгдмэл байдлыг бэхжүүлнэ

5. Өөрт болон Төлөөлөгчдийн танхимд олгогдсон бүрэн эрхийг эдэлнэ.

6. Мужууд хооронд үүссэн үл ойлголцол, маргааныг шийдвэрлэнэ.

7. Холбооны болон мужийн нэгдсэн татварын орлогыг хуваарилж, Холбооны Засгийн

газраас мужуудад олгох татаасыг тодорхойлно.

8. Төлөөлөгчдийн танхимаас хууль гарган зохицуулах иргэний эрх зүйн асуудлуудыг тодорхойлно.

9. Аливаа муж энэхүү Үндсэн хуулийг зөрчин, Үндсэн хуулийн дэглэмд аюул учруулсан тохиолдолд Холбооны Засгийн газарт тус мужийн засгийн эрхийг гартаа авахыг тушаана.

10. Байнгын болон түр хороодыг байгуулна.

11. Танхимын дарга болон орлогч даргыг сонгох, дотоод удирдлагын дүрэм, журмыг батлан мөрдүүлэх зэрэг бүрэн эрхийг эдэлдэг.

Түүнчлэн, Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд Үндсэн хуулийн нэрийн өмнөөс засах үүрэг өгөх, дотоод зохион байгуулалт, дэг, дүрмийн асуудлаа шийдвэрлэх чиглэлээр хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Парламент байгуулагдах хэлбэр буюу сонгуулийн тогтолцоо

Парламентын доод танхимын гишүүдийн сонгуулийг 1993 оны VIII сарын 23-нд баталсан Сонгуулийн хуулийн дагуу явуулна. Доод танхимын сонгуулийг сонгуулийн хуулийн дагуу нэг мандат бүхий тойргуудад мөжаритар системээр намуудаас нэр дэвшигчдийн талаар санал хурааж, олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдоно. Доод танхимын сүүлчийн сонгууль 2005 оны V сарын 15, VIII сарын 23-нд явагдсан байна. Сонгуульд Этиопийн Ард Түмний Хувьсгалт Ардчилсан Фронт Нам 296 суудал авч ялалт байгуулсан бол 116 эмэгтэй гишүүнээр сонгогдож 21.21 хувийг эзэлж байна.

Парламентын дээд танхим үндэстэн, ястан бүрээс наад зах нь нэг гишүүн байх ба 1 сая хүн тутмаас 1 нэмэлт төлөөлөлтэй байхаар Үндсэн хуульд заажээ. Холбооны Танхимын гишүүнийг муж улсын зөвлөлөөс шууд бусаар сонгох, эсвэл муж улсын зөвлөл Холбооны зөвлөлд суух өөрийн төлөөлөгчийг нийт ард түмнээсээ шууд сонгохоор зохион байгуулж болохоор байна.

Төрийн дээд эрхийг барих субъект

Үндсэн хуулинд зааснаар Этиоп улс нь Парламентын засаглалтай Холбооны улс юм. Этиоп Улс холбооны төрийн дээд байгууллагууд, холбооны улсуудаас бүрдэнэ. Холбооны төрийн дээд байгууллагууд, холбооны муж улсуудын хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагууд тус тусын эрх мэдлээ хэрэгжүүлнэ. Тус улсын парламент (Ардын төлөөлөгчдийн танхим) холбооны төрийн эрхийг барих дээд байгууллага мөн бөгөөд ард түмний өмнө хариуцлага хүлээнэ.

Хууль тогтоох журам

Доод танхим: Үндсэн хуулийн 57 дугаар зүйлд Ардын Төлөөлөгчдийн танхим буюу доод танхимын хууль батлах /adoption of laws/ тухай заалт орсон байна. Тус зүйлд зааснаар Парламентын доод танхим нь хуулийг батлахдаа:

Танхимаас хэлэлцэн баталсан хуулийг гарын үсэг зуруулахаар Үндсэний Ерөнхийлөгчид өргөн барина. Ерөнхийлөгч өргөн барьсан хуульд 15 хоногт гарын үсэг зурна. Хэрэв, Ерөнхийлөгч 15 хоногийн дотор гарын үсэг зураагүй бол түүний гарын үсэггүйгээр тухайн хууль хүчин төгөлдөр болно.

Дээд танхим: Хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ жил бүр хуралддаг 2 удаагийн ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар дээр дурдсан асуудлаар өргөн барьсан төслийг хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд хуралдаанд гишүүдийн 2/3-оос дээшхи нь оролцож, олонхийн саналаар шийдвэрлэнэ.



ЕВРОП ТИВИЙН ОРНУУД

АВСТРИ УЛС

Бүгд Найрамдах Австри Улс

Парламентын танхимуудын нэр:

Австрийн парламент болох Холбооны ассамблей (Bundesversammlung) нь хоёр танхимтай:

- a. Дээд танхим – Холбооны зөвлөл (Bundesrat)
- b. Доод танхим – Үндэсний зөвлөл (Nationalrat)

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Парламентын 2 танхим дотоод асуудлаа шийдвэрлэх, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоох чиг үүрэг бүхий Дарга нарын бага хурал байгуулах бөгөөд бүрэлдэхүүнд нь дарга, дэд дарга нар, парламентын бүлгүүдийн дарга нар албан тушаалаараа ордог байна.

Парламентын 2 танхим төр, эрх зүй, нийгэм эдийн засаг, Европын холбоотой харилцах чиглэлээр Хууль зүйн, Эдийн засгийн, санхүүгийн, Европын болон гадаад харилцааны асуудлын, Хөдөө аж ахуй, орон нутгийн хөгжлийн, Эрүүл мэндийн зэрэг байнгын хороодыг байгуулан ажиллуулдаг.

Холбооны зөвлөл: Парламентын дээд танхимын гишүүдийг шууд бус, Холбооны Бүгд найрамдах улсын 9 мужийн парламент (Landtag)-аас сонгодог. Мужууд өөрсдийн хүн амын тооноос хамаарч Холбооны зөвлөлд төлөөлдөг. Хамгийн олон хүн амтай муж 12 мандаттай бөгөөд бусад мужууд хамгийн багадаа 3 мандаттай байна. Тийм ч учраас нийт гишүүдийн тоо янз бүр байх ба одоогийн Холбооны зөвлөл 64 гишүүдтэй. Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь мөн мужийн парламентын бүрэн эрхийн хугацаанаас хамаарч 4-6 жил байдаг.

Холбооны зөвлөлийн даргыг муж улсуудын парламент (landtag)-аас сонгох бөгөөд муж тус бүр 6 сарын хугацаагаар ээлжилж энэ албан тушаалд суудаг байна. Холбооны зөвлөлийн сонгуулийг 1900 оны 1-р сарын 1-нд баталсан Сонгуулийн хууль (1990 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан)-ийн дагуу явуулдаг.

Үндэсний зөвлөл:

Парламентын доод танхимын 183 гишүүдийг пропорциональ системээр Холбооны бүх ард түмнээс шууд сонгуулиар сонгоно. Бүрэн эрхийн хугацаа 5 жил. Сонгогдох гишүүдийн тоо нь Холбооны сонгуулийн тойргийн хүн амын тооноос хамаарна. Сонгуулийг 7-36 мандат бүхий сонгуулийн 9 тойргоос намуудын хаалттай жагсаалтаар санал хурааж, муж дүүргийн түвшинд Харегийн аргаар, холбооны түвшинд D'Hondt-ын аргаар суудлыг хуваарилах бөгөөд намуудад 4 хувийн саналын босго тогтоосон байна.

Шинээр сонгогдсон Үндэсний зөвлөлийг сонгууль явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Холбооны ерөнхийлөгч товлон зарлана. Холбооны ерөнхийлөгч нь Үндэсний зөвлөлийг тараах бүрэн эрхтэй. Үндэсний зөвлөлийн дарга болон хоёр дэд даргыг гишүүдийн дотроос сонгуулийн дараах анхны хуралдаанаар 5 жилийн хугацаагаар сонгоно. Үндэсний зөвлөлийн сонгуулийг 1992 онд баталсан Сонгуулийн хууль (2007 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан)-ийн дагуу явуулна. Үндэсний зөвлөлийн сүүлчийн сонгууль 2008 оны 9-р сарын 28-ны өдөр явагдаж, Ардын нам, Социал демократ нам эвсэж Засгийн газраа байгуулсан бөгөөд парламентын гишүүнээр 50 эмэгтэй сонгогдсон байна.

Бүрэн эрх

Парламент нь хууль тогтоох, Засгийн газар болон танхимын гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Хууль тогтоох чиг үргээ хэрэгжүүлэхдээ жил бүр холбооны Ерөнхийлөгчийн зарласнаар хуралддаг ээлжит чуулган, хуульд заасны дагуу хуралддаг ээлжит бус, онцгой чуулганы хуралдаанаар хууль эрхийн актуудын төслийг 2 танхим дараалан хэлэлцэнэ. Холбооны зөвлөл төслийн талаар үндэслэл бүхий татгалзлаа илэрхийлсэн тохиолдолд Үндэсний зөвлөл гишүүдийн олонхи нь оролцсон хуралдаанаар хэлэлцэж, олонхийн саналаар эцэслэн шийдвэрлэнэ. Үндсэн хуульд тусгайлан заагаагүй бол Парламентын танхимуудын ердийн хуралдааны ирц 1/3-ээс дээш байж, харин төслийг нийт гишүүдийн олонхийн саналаар батлах журамтай.

Холбооны парламентын 2 танхимын гишүүд Засгийн газрын гишүүдэд асуулт тавьж хариуг сонсох, тодорхой асуудлаар түр комисс томилон ажиллуулж, дүнг хэлэлцэх зэргээр хяналтын чиг үүргээ хэрэгжүүлнэ.

Төрийн дээд эрхийг барих субъект. Парламентын засаглалтай холбооны улс.

Хууль тогтоох журам

Хуулийн төслийг хамгийн түрүүнд Үндэсний зөвлөлд өргөн барих бөгөөд Зөвлөл нь өөрийн Байнгын хороо руу шилжүүлнэ. Ийнхүү анхны хэлэлцүүлэг Байнгын хороо дээр өрнөх бөгөөд энэ үеэр гишүүд тухайн асуудлаар мэргэшсэн шинжээчдийг байлцуулан асуудал бүрээр дэлгэрэнгүй хэлэлцүүлэг хийнэ. Энэ үеэр сөрөг хүчин өөрсдийн саналыг илэрхийлнэ. Шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлаар дэд хороог байгуулна. Хуулийн төслийг хэлэлцэж дууссаны дараа санал хураалт явагдаж, олонхийн саналын шийдвэрээр дараагийн хэлэлцүүлэгт шилжүүлнэ. Анхны хэлэлцүүлэгийн онцлог нь хаалттай явагдах бөгөөд хэлэлцүүлэг бүрийн товч мэдээллийг олон нийтэд мэдээллэнэ.

Хоёр дахь хэлэлцүүлэг нь Үндэсний зөвлөлийн нэгдсэн хуралдаан дээр явагдах бөгөөд Холбооны улсын засгийн газрын гишүүдийг байлцуулна. Гурав дахь хэлэлцүүлэгийн үеэр хуулийн төслийн маргаантай байгаа найруулга, хэвлэлийн алдаан дээр анхаарна. Үүний дараа хуулийн төслийг Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн 1/3-ийн ирцтэйгээр батлах бөгөөд дараа нь Холбооны зөвлөлд өргөн баригдана. Үндэсний зөвлөл нь гагцхүү Холбооны улсын төсвийг бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэй.

Холбооны зөвлөлийн хуулийн төсөл хэлэлцэх процедур нь Үндэсний зөвлөлийнхтэй адил журам баримтлана. Холбооны зөвлөл нь Үндэсний зөвлөлийн баталсан хуулийн саналыг өөрчилж чадахгүй, гэхдээ Үндэсний зөвлөлийг дахин хэлэлцэхийг итгүүлэхийн тулд 8 долоо хоног хүртэл хүлээж авахгүй байх боломжтой.

Энэ тохиолдолд Үндэсний зөвлөл нь гаргасан шийдвэрээ эргэх харах ёстой. Магадгүй үүний дараа анх гаргасан шийдвэрээ өөрчлөөгүй байж болох боловч гол нь Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн тал хувийн ирцтэй байж шийдвэр хүчинтэй байх журамтай. Энэхүү тогтвортой шийдвэрийн дараа Холбооны зөвлөл дахин эсэргүүцэх боломжгүй.

Хэрэв Үндэсний зөвлөл нь шийдвэрээ өөрчлөвөл Холбооны зөвлөл нь уг шийдвэрийг шалгаж үзнэ. Холбооны зөвлөл нь дахин эсэргүүцвэл, энэ удаагийн “вето” нь нийт гишүүдийнх нь тал хувийн ирцтэй, түүнчлэн ирсэн гишүүдийн 2/3 хувийн саналыг авсан байх журамтай. Энэ бүхний дараа Холбооны зөвлөл нь хүлээн авсан, эсвэл Үндэсний зөвлөл нь Холбооны зөвлөлийн саналыг хүлээн авахгүй бол хууль хүчин төгөлдөр болно. Үүний дараа Холбооны улсын Ерөнхийлөгч хуулийг ёсчлох бөгөөд энэ нь тухайн хуулийг батлах процедур нь Үндсэн хуулийн дагуу явагдаж өнгөрснийг баталж байгаа хэрэг. Холбооны улсын Канцлер ч мөн үүнийг хүлээн зөвшөөрч гарын үсгээ зурна. Хамгийн



Судалгааны эмхтгэл, X боть

сүүлд нь батлагдсан хуулийг Холбооны улсын хууль тогтоомжийн сонинд нийтлүүлнэ.

Цахим хуудас: <http://www.parliament.gy.at>

БЕЛАРУС

Ерөнхийлөгчийн засаглалтай Бүгд Найрамдах Улс. Хууль тогтоох дээд байгууллага нь Үндэсний хурал бөгөөд Төлөөлөгчдийн танхим (Палата представителей), Төрийн зөвлөл (Совет Республики) гэсэн хоёр танхимтай.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Төлөөлөгчдийн танхим нь нэг мандаттай тойргоос сонгогддог 110 депутатаас бүрддэг. Төрийн зөвлөлийн бүрэлдэхүүнд муж, нийслэл Минск хот тус бүрээс 8 депутат сонгогдож ордог бөгөөд Ерөнхийлөгч мөн 8 депутатыг шууд томилдог. Эдгээр сенатчдын зургааг тухайн мужийн зөвлөл сонгодог бол гурвыг муж тус бүрээс Ерөнхийлөгч шууд томилдог.

Төлөөлөгчдийн танхимын депутат нь сонгуулийн эрх бүхий 21 нас хүрсэн Беларус иргэн, харин Төрийн зөвлөлийн депутат 30 нас хүрсэн бөгөөд тухайн мужийн нутаг дэвсгэр дээр 5-аас доошгүй жил байнга амьдарсан иргэн байх шаардлагатай.

Бүрэн эрх

Дээд танхим буюу Төрийн зөвлөл нь Төлөөлөгчдийн танхимын батласан хуулийг сайшаах буюу буцаах, Үндсэн хуулийн шүүхийн дарга, Дээд шүүхийн дарга, шүүгчид Сонгуулийн төв комиссын дарга, улсын Ерөнхий прокурор, Үндэсний банкны даргыг томилсон Ерөнхийлөгчийн томилгоог зөвшөөрөх, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, Сонгуулийн төв комиссын гишүүдийг томилох, нутгийн удирдлагын байгууллагыг (Совет депутатов) тараах, түүний хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох, тодорхой үндэслэл байвал Ерөнхийлөгчийг нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар огцруулах, дайны болон онц байдал зарлах тухай, цэрэг татлагын тухай Ерөнхийлөгчийн зарлигийг хэлэлцэх зэрэг бүрэн эрхтэй.

Доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим нь Ерөнхийлөгч болон сонгуулийн эрх бүхий 150 мянгаас доошгүй иргэний санаачлагаар Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийг тайлбарлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Мөн хууль хэлэлцэх, хуулийг тайлбарлах, улсын дотоод гадаад бодлогын чиглэл, цэргийн номлолыг батлах, олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, улсын төсөв, төсвийн тайланг хэлэлцэх, татвар хураамжийн хэмжээг тогтоох, засаг захиргаа - нутаг дэвсгэрийн тогтолцоог өөрчлөх журмыг тогтоох, өршөөл үзүүлэх, төрийн дээд шагналыг бий болгох, дайн энхийн асуудлыг шийдвэрлэх, дайны болон онц байдал тогтоох, Ерөнхийлөгчийн сонгууль зарлах, Ерөнхий сайдыг томилсон Ерөнхийлөгчийн томилгоог зөвшөөрөх, Засгийн газрын хөтөлбөр, Засгийн газарт итгэл үзүүлэх эсэхийг хэлэлцэх, Ерөнхийлөгчийг хүнд гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд шийдвэр гаргах, Ерөнхийлөгчийг огцруулах зэрэг асуудлыг хэлэлцэх бүрэн эрхтэй.

Ерөнхийлөгч, Төлөөлөгчийн танхимын гишүүд, Төрийн Зөвлөл, Засгийн газар болон сонгуулийн эрх бүхий 50 мянгаас доошгүй иргэн нэгдэж хууль санаачлах эрх эдлэнэ. Парламентын бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд зөвхөн дайны үед энэ хугацааг сунгаж болохоор хуулинд заажээ. Төрийн зөвлөлийн гишүүн нь Засгийн газрын гишүүнээр давхар ажиллахыг хориглодог. Мөн хоёр танхимын гишүүнээр зэрэг ажиллаж болохгүй. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахад 6 сар хүрэхгүй хугацаа үлдсэн, Ерөнхийлөгчийг огцруулах, чөлөөлөх асуудлыг хэлэлцэж байхад, дайны болон онц

байдал зарласан үед, мөн анхдугаар хуралдаанаас хойш нэг жилийн дотор парламентыг тараахыг хориглодог.

Хууль батлах журам

Хуулийн төслийг эхлээд Төлөөлөгчийн танхим, дараа нь Төрийн зөвлөл хэлэлцэх бөгөөд нийт гишүүдийн олонхийн саналаар батлана. Ерөнхийлөгч, Төлөөлөгчийн танхимын гишүүд, Төрийн Зөвлөл, Засгийн газар болон сонгуулийн эрх бүхий 50 мянгаас доошгүй иргэн нэгдэж хууль санаачлах эрх эдлэнэ. Төлөөлөгчдийн танхим хууль, тогтоол гаргадаг бол Төрийн зөвлөл зөвхөн тогтоол гаргана. Хуулийн төслийг эхлээд Төлөөлөгчийн танхим, дараа нь Төрийн зөвлөл хэлэлцнэ.

Төлөөлөгчдийн танхимын нийт гишүүдийн олонхийн саналаар батлаж, Төрийн зөвлөлийн олонхи сайшааснаар хууль хүчин төгөлдөр болно. Төрийн зөвлөл хуулийг буцаавал танхимуудын төлөөллөөс бүрдсэн зөвшилцөх комисс хуулийн төслийг дахин боловсруулж хоёр танхимд хүргүүлнэ. Уг төслийг Төлөөлөгчдийн танхимын нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжвэл хууль батлагдсанд тооцно. Ингэж батласан болон ердийн журмаар буюу Төлөөлөгчдийн танхимын батлаж, Төрийн зөвлөлийн сайшаасан хуулийг 10 хоногийн дотор Ерөнхийлөгчид гарын үсэг зуруулахаар хүргүүлнэ.

БЕЛЬГИ

Бельгийн Вант Улс

Парламентын танхимуудын нэр:

- a. Дээд танхим–Сенат
- b. Доод танхим–Төлөөлөгчдийн танхим

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Сонгуулийн тойргоос сонгогдох гишүүдийн тоог тухайн сонгуулийн хорооны хүн амтай харьцуулан Хаан 10 жил тутам гардаг хүн амын нэгдсэн тоо бүртгэл дээр үндэслэн эсхүл хуульд заасан бусад арга хэрэгслээр тодорхойлж 6 сарын дотор нийтэд мэдээлнэ. Сенат болон Төлөөлөгчдийн танхимын гишүүнд 25 нас хүрсэн, иргэний болон улс төрийн эрхтэй, Бельги улсад оршин суудаг, Бельги улсын иргэн нэр дэвших эрхтэй. Хоёр танхимын сонгуулийг хамт зохион байгуулна.

Сенат: Дээд танхим нь 71 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 40-ийг нь шууд сонгуулиар сонгоно, 21-ийг нь коммунитигийн парламентуудаас томилно, 10-ыг нь төлөөллөөр сонгоно. Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд хамгийн сүүлийн сонгууль 2010 оны 6-р сарын 13-нд болсон. Шууд сонгогдох 40 гишүүдийн 25-ыг нь Голландын сонгуулийн коллегиос, 15-ыг нь Францын сонгуулийн коллегиос сонгоно.

Коммунитигийн парламентуудаас томилогдох 21 гишүүдийн 10-ыг нь Фламандын коммунитигийн парламентын гишүүдээс, 10-ыг нь Францын коммунитигийн парламентын гишүүдээс, 1-ийг Герман коммунитигийн парламентын гишүүдээс тус тус томилно. Сенатад төлөөллөөр сонгогдох 10 гишүүдийг язгууртнууд өөрсдийн бүлгээс шууд сонгуулиар сонгодог байна. Голланд хэлний бүлэг 6 гишүүн, Франц хэлний бүлэг 4 гишүүнийг тус тус сонгоно. 1893 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Сенатын гишүүдийн шинэ ангилал бий болсон байна.

Гишүүдийг хоёр хэлний бүлэгт хуваагддаг бөгөөд 41 төлөөлөгч Голланд хэлний бүлэгт (зөвхөн Голланд хэлний бүлэг хамаарна), бусад гишүүд Франц хэлний бүлэгт (Франц болон Герман хэлний бүлгүүд хамаарна) тус тус харьяаллагддаг байна. Сенатын гишүүн



Судалгааны эмхтгэл, X боть

цалингүй байх боловч жилд 4000 франкын нөхөн төлбөр авах эрхтэй. Тэд Бельгийн нутаг дэвсгэрт нийтийн тээврээр үнэгүй зорчих эрхтэй. Хааны хүүхдүүд, хэрэв хүүхэд байхгүй бол хааны угсааны 18 нас хүрсэн үе залгамжлагч нар Сенатын гишүүний адил эрх мэдэлтэй байна. **Төлөөлөгчдийн танхим:** Төлөөлөгчдийн танхимын 150 гишүүдийг 4 жилийн хугацаагаар бүх ард түмнээс шууд сонгоно. Сонгуулийг хуульд заасны дагуу пропорциональ тогтолцоогоор явуулна.

Гишүүд Сенатын нэгэн адил хоёр хэлний бүлэгт хуваагддаг бөгөөд одоогийн байдлаар 88 төлөөлөгч Голланд хэлний бүлэгт, 62 төлөөлөгчид Франц хэлний бүлэгт тус тус харьяалагддаг байна. Төлөөлөгчдийн танхимын гишүүд Сенатын гишүүний адил Бельгийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих эрхтэй. Төлөөлөгчдийн танхимын даргын мөнгөн тэтгэмжийн хэмжээг түүний хуралд зарцуулсан цагаас шалтгаалан өөрчилж болно.

Танхим бүр дарга, дэд дарга болон хороогоо томилох бөгөөд танхимын хуралдаан нээлттэй байна. Хоёр танхимын гишүүнээр нэг хүн нэгэн зэрэг ажиллаж болохгүй. Төлөөлөгчдийн танхимын хурал хуралдаагүй үед Сенатын хуралдааныг зохион байгуулна.

Бүрэн эрх

Бельгийн вант улсын парламент тус улсын хууль тогтоох дээд эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Парламентын танхимууд адил эрх мэдэлтэй байна хэмээн Үндсэн хуульдаа заасан. Хоёр танхимын гишүүд бүх ард түмнийг төлөөлнө. Танхимуудад ирсэн өргөдөл, гомдлыг сайд нарт илгээж, тэднээс тайлбар авах эрхтэй. Танхимын гишүүдийг түүний албан үүргээ гүйцэтгэж байхдаа өгсөн санал, илэрхийлсэн үзэл бодолтой нь холбогдуулан мөрдөн шалгаж болохгүй.

Төрийн дээд эрхийг барих субъект: Үндсэн хуульт хаант засаглалтай, парламентын ардчилсан улс.

Хууль тогтоох журам

Бельгийн хууль тогтоох эрх мэдлийг Хаан, болон Төлөөлөгчдийн танхим дараах тохиолдлуудад хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

- Иргэний харьяалал олгох,
- Эзэн хаан сайд нарын иргэний болон эрүүгийн хариуцлагатай холбоотой хууль батлах,
- Улсын санхүү, төсөв батлах,
- Зэвсэгт хүчин байрлуулах.

Мөн Хаан, Төлөөлөгчдийн танхим, Сенат нь тус бүрдээ хууль тогтоох эрх мэдэлтэй. Ингэхдээ хуулийн төслөөс хамаарч дараах дараалаар хэлэлцэнэ:

- хааны санаачилсан хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим хэлэлцээд Сенат руу шилжүүлнэ.
- хааны санаачилсан хуулийн төсөл нь олон улсын гэрээтэй холбоотой бол Сенат хэлэлцээд Төлөөлөгчдийн танхим руу шилжүүлнэ.

Танхимууд хуулийн төслийн зүйлүүдийг задлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд тухайн хуулийн төслийн зүйл зүйлээр нь санал авсаны дараа батална. Үндсэн хуулийн заалтыг хянах, танхимуудаас зохицуулагдах асуудал, танхимуудын олонхийн саналаар батлагдах хууль, олон улсын гэрээг батлах, төрийн Зөвлөлтэй холбогдох хууль, шүүхийн байгууллагууд, төр, коммунити болон бүс хоорондын хамтын ажиллагааны гэрээг

батлахад Сенат, Төлөөлөгчдийн танхим хоёр адил тэгш эрхтэй байна.

Бусад тохиолдолд хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим хэлэлцэж батлаад Сенат руу дараах журмаар шилжүүлнэ:

- 1) Хуулийн төслийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор 15-аас доошгүй Сенатын гишүүний шаардсанаар хуулийн төслийг шалгана. Сенат 60 хоногийн дотор шалгаад хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахгүй тухай, эсхүл хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулсаны дараа батлах тухай гэсэн хоёр шийдвэрийн аль нэгийг гаргана. Хэрэв Сенат заасан хугацаанд уг хуулийн төсөлд саналаа илэрхийлээгүй, эсхүл Төлөөлөгчдийн танхимын гаргасан шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулахгүй тухай шийдвэр гаргасан бол уг хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим Хаанд өргөн барина.
- 2) Хэрэв Сенат уг хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийн зарим хэсгийг болон бүхэлд нь эсэргүүцэх тухай, эсхүл батлах тухай аль нэг шийдвэрийг гаргуулахаар Төлөөлөгчдийн танхим руу буцаана. Сенатаас нэмэлт өөрчлөлт орж буцаагдсан хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим дахин хэлэлцэж, нэмэлт өөрчлөлт оруулаад эргүүлээд Сенат руу шилжүүлнэ. Сенат үүнийг хүлээж аваад 50 хоногийн дотор Төлөөлөгчдийн танхимын оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай, эсхүл дахин нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн төслийг батлах тухай шийдвэрийн аль нэгийг гаргана. Хэрэв Сенат заасан хугацаанд уг хуулийн төслийн талаархи саналаа илэрхийлээгүй, эсхүл Төлөөлөгчдийн танхимын оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн бол Төлөөлөгчдийн танхим уг хуулийн төслийг Хаанд өргөн барина.
- 3) Хэрэв Сенат уг хуулийн төсөлд цаашид нэмэлт өөрчлөлт оруулна гэж үзсэн бол Төлөөлөгчдийн танхим руу буцаах бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, эсхүл уг хуулийн төслийг батлах тухай шийдвэрийн аль нэгийг гаргана.

Хааны санаачилсан хуулийн төсөл болон Сенат, Төлөөлөгчдийн танхим хоёрын адил тэгш эрхтэй байхаас бусад асуудлаар гарч буй хуулийн төслийг хэлэлцэж байхад Холбооны Засгийн газар Сенатаас шийдвэр гаргах хугацааны хязгаарыг нэн даруй тогтоохыг Парламентын Зөвлөлгөөний Хорооноос шаардана.

Цахим хуудас:

<http://www.fed-par.be/>

<http://www.decamer.be/>

<http://www.lachambre.be/>

<http://www.senate.be/>

ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛС**Парламентын танхимуудын нэр**

а/ Дээд танхим - Лордуудын танхим

б/ Доод танхим - Нийтийн танхим

Парламент байгуулагдах хэлбэр

Нийтийн танхим нь бүх ард түмнээс дээд тал нь 5 жилээр шууд сонгогддог 650 гишүүнтэй. Парламентын нийтийн танхимын сонгуулийг 1983 оны II сарын 8 (1997 онд хамгийн сүүлд нэмэлт, өөрчлөлт оруулсан)-нд баталсан Сонгуулийн хуулийн дагуу явуулах журамтай.



Судалгааны эмхтгэл, Х боть

Нийтийн танхимын 650 суудлаас 4 нь гаднах арлын улсуудад ногдох бөгөөд 646 гишүүнийг нэг мандат бүхий 646 тойргоос олонхийг төлөөлөх тогтолцооны дагуу санал хурааж сонгодог. Сонгуулийн тойргуудаас 529 нь Англид, 59 нь Шотландад, 40 нь Уэльсэд, 18 нь Умард Ирландад ногддог байна.

Нийтийн танхимын сүүлчийн сонгууль 2010 оны Ү сарын 6-нд явагдаж, аль ч нам олонхийн суудал аваагүй учраас Консерватив нам, Либерал ардчилсан нам нэгдэж, Засгийн газрыг байгуулж, Хатан хааны зарлигаар ноён Кэмероныг Ерөнхий сайдаар томилжээ. Лордуудын танхим нь Английн сүм хийдийн хамба нар, угсаа залгамжлагчид, язгууртнуудаас 1900 оны I сарын 1-ний хуулийн дагуу Хаан томилдог 733 гишүүнтэй.

Парламентын бүрэн эрх

Дээд танхим-Лордуудын танхим нь Английн давж заалдах дээд шатны нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй мөн нийтийн танхимаас баталсан хуулиудыг хэлэлцэн нэмэлт өөрчлөлт оруулах, нийтийн танхимын баталсан хуулиудад богино хугацааны хориг тавих эрхтэй.

Доод танхим-Парламентын нийтийн танхимыг уламжлал ёсоор доод танхим гэж нэрлэх боловч төрийн хууль тогтоох эрх мэдлийг бүхэлд нь тогтоох чиг үүрэгтэй ажилладаг. Парламентын гол чиг үүрэг нь хууль тогтоох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх явдал юм. Мөн санхүүгийн онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлдэг, тухайлбал, татвар ногдуулах, төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлах, төсвийн зарцуулалтад хяналт тавих гэх мэт. Ямар ч шинэ хууль, нэмэлт, өөрчлөлт, хориг, татвар ногдуулалт Нийтийн танхимын шийдвэргүйгээр гардаггүй. Түүнчлэн улс орныхоо гадаад бодлогыг тодорхойлох, батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлын зорилтууд, эдийн засгийн үндсэн асуудлуудыг тодорхойлох бүрэн эрхтэй.

Төрийн дээд эрхийг барих субъект: Парламент

Хууль тогтоох журам

Хуулийн төслийг парламентын аль ч танхимд өргөн барьж болох боловч практик дээр хуулийн төслийг эхлээд Нийтийн танхимд 3 удаа хэлэлцсэний эцэст баталсан тохиолдолд Лордуудын танхимд хэлэлцүүлэхээр шилжүүлдэг. Аливаа хуулийн төсөл нь парламентын хоёр танхимаар хоёулангаар нь батлагдах ёстой ба хаан буюу хатан хаан зөвшөөрсний дараа хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Парламентын гишүүд ба Төрийн тэргүүн буюу хаан эсхүл хатан хаан хууль санаачлах эрхтэй бөгөөд түүний нэрийн өмнөөс сайдууд хуулийн төслийг өргөн барьдаг. Ихэнхи хуулийн төслүүд (95% хүртэл) засгийн газрын санаачлагаар өргөн баригддаг ба хуулийн төслийн хэлэлцүүлгийг хийхэд танхимын 40-өөс доошгүй гишүүн оролцох ёстой, харин хуулийн төслийг танхимын гишүүдийн олонхийн саналаар баталдаг.

Хуулийн төсөл батлагдсаны дараа түүнийг Лордуудын танхимд шилжүүлдэг ба тэнд мөн л ийм журмаар хуулийн төслийг хэлэлцэж батална. Гэхдээ Лордуудын танхимын хууль тогтоох эрх мэдэл нь Нийтийн танхимаас нэлээд хязгаарлагдмал ба энэхүү хязгаарлалтыг 1911 оны Парламентын тухай хуулиар тогтоожээ. Зарим төрлийн билль нь Лордуудын танхимын зөвшөөрөлгүйгээр шууд хааны зөвшөөрлийг авахаар өргөн баригдаж болно.

Лордуудын танхим нь мөнгөний тухай биллийг нэг сараас дээш хугацаагаар батлахгүйгээр байлгах эрхгүй ба бусад хуулийг парламентын хоёр чуулганы хугацаанаас илүү хугацаагаар батлахгүй хүлээлгэх ёсгүй. Мөн Лордуудын танхим нь санхүүгийн биллүүдийг хэлэлцэхээс түдгэлздэг уламжлалтай ба татварын харилцаатай холбоотой хуулинд

өөрчлөлт оруулдаггүй. Түүнчлэн Лордуудын танхим нь сонгуульд ялалт байгуулсан намын хууль санаачлах эрхийг хязгаарлах, сөрөх боломжгүй юм.

ГЕРМАН

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Парламентын танхимуудын нэр:

- a. Дээд танхим – Холбооны зөвлөл (Бундесрат)
- b. Доод танхим – Холбооны хурал (Бундестаг)

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Парламентын 2 танхим дотоод асуудлаа шийдвэрлэх, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоох чиг үүрэг бүхий Дарга нарын бага хурал байгуулах бөгөөд бүрэлдэхүүнд нь дарга, дэд дарга нар, парламентын бүлгүүдийн дарга нар албан тушаалаараа ордог байна. Бундесрат: Бундесратын 69 гишүүнийг 16 муж улсуудын Засгийн газраас гишүүдээс томилох бөгөөд тогтсон хугацаагүй. Муж улс бүр гурваас доошгүй саналын эрхтэй бөгөөд хэрэв 2 саяас дээш хүн амтай муж улс бол 4; 6 саяас дээш хүн амтай муж улс бол 5; 7 саяас дээш хүн амтай муж улс бол 6 саналын эрхтэй байна. Муж улс бүр энэ саналын эрхийн тоотойгоо тэнцүү гишүүдийг томилж болно.

Бундесратын даргыг 1 жилийн хугацаагаар Бундесратаас сонгоно. Түүнийг Холбооны Засгийн газрын шаардсанаар, эсхүл хоёроос доошгүй муж улсын шаардсанаар Бундесратийг хуралдуулах үүрэгтэй. Бундесратын шийдвэр олонхийн саналаар гарах бөгөөд хуралдаан нь олон нийтэд нээлттэй байна. Муж улсын Засгийн газраас Бундесратын гишүүдийг хэдийд ч томилох, солих эрхтэй байдаг.

Бундестаг: Одоогийн 17 дахь Германы Бундестаг нь 621 гишүүн байгаа нь өмнөх сонгуулийн хугацаанаас 11 гишүүнээр олон байна. Гишүүдийг ард түмнээс 4 жилийн хугацаатай шууд сонгодог. Сонгуулиас хойш 30 хоногийн дотор Бундестаг хуралдах ёстой. Цаашдаа хуралдаанаа хэдийд завсарлах, үргэлжлүүлэх эсэхээ Бундестаг өөрөө тодорхойлно.

299 сонгуулийн тойрогтой бөгөөд 299 гишүүнийг нь мажоритар сонгуулийн системээр, үлдсэн гишүүдийг сонгуулийн пропорциональ системээр сонгоно. Сонгогч бүр нэг сонгуулийн хорооны нэг нэр дэвшигчид өгөх нэг санал болон намд өгөх нэг санал гэсэн 2 санал өгөх эрхтэй байдаг. Сонгуулийн мажоритар системийн дагуу сонгуулийн тойрог бүрт анхны санал хураалтаас хамгийн их санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон гэж үзнэ. Парламентын суудлыг пропорциональ төлөөллөөр хуваарилна.

Үндэсний хэмжээнд хоёр дахь санал хураалтаас 5 хувиас доошгүй санал авсан эсхүл мажоритар тогтолцооны дагуу гурваас доошгүй парламентын суудал авсан намууд пропорциональ төлөөллийн тогтолцооны дагуу парламентын суудал авах эрхтэй. Хэрэв мажоритар системээр их суудал авсан нам 2 дахь санал хураалтаар пропорциональ төлөөллийн тогтолцооны үр дүнгээр суудал авах эрхтэй байвал үүнийг нэмэлт суудал “overhang seats” гэж хадгална. Улс төрийн намаас шалтгаалан парламентын хоосон суудал гарвал дараа нь байгаа тухайн намын нэр дэвшигчээс нөхнө. Гишүүд нь чөлөөлөгдсөн суудал бүрийг пропорциональ тогтолцоогоор сонгоно. Суларсан суудал “overhang seats”-г нөхөхгүй. Парламентын суларсан суудлыг сонгуулийн тойрог бүрт тусгай сонгууль зохион байгуулж нөхнө.

Холбооны улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн ажлын албаны гишүүд, Холбооны улсын Ерөнхий сайд, Холбооны улсын Аудитын газрын гишүүд, шүүгч нар, Бундесратын гишүүд

Судалгааны эмхтгэл, X боть

болон civil servant нар буюу төрийн албан хаагчид Бундестагын гишүүнд нэр дэвшиж болохгүй.

Бундестаг дарга, дэд дарга, нарийн бичгийн даргыг сонгох журмаа өөрөө баталж, сонгоно. Бундестагийн 622 гишүүдийг 4 жилийн хугацаагаар шууд сонгоно. Бундестагийн даргыг анхны хуралдаан дээрээ дотроосоо сонгон 4 жилийн хугацаагаар томилно. Тэргүүн, дэд тэргүүн болон нарийн бичгийн даргаа дотроосоо сонгодог. Бундестагийн

Бүрэн эрх

Бундесрат: Хууль тогтоох эрх мэдлийг парламент хэрэгжүүлнэ. Бундесрат нь хуулийг эцэслэн батлах эрхтэй. Бундесрат нь аливаа дээд танхимийн адил муж улсын сонирхлыг илэрхийлнэ. Гэхдээ энэ танхимийн үүрэг нь олон улсад түгсэн Сенат хэмээх уламжлалт институцээс ялгаатай. Сенат нь муж улсаас сонгогдон, хуулийн төслийг батлах зэрэг эрх хэмжээтэй байдаг. Гэтэл Бундесратийн гишүүд сонгогддоггүй томилогддог, хуулийн төслийг шууд батлах эрх эдлэхгүй, харин Бундесрат нь хууль санаачлан, Бундестагийн шийдвэрт хориг тавих эрх эдэлнэ

Бундестаг: Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Засгийн газарт хяналт тавина. Мөн Бундестагийн гишүүдийн гол эрх үүрэг нь Холбооны улсын төсөв болон Холбооны зэвсэгт хүчнийг Герман улсаас гадна байрлуулах тухай хэлэлцэж батлана.

Өөр нэг чухал бүрэн эрх үүрэг нь Холбооны Герман улсын Канцлерийг сонгоно. Ингэхдээ ихэвчлэн Холбооны Ерөнхийлөгчийн оролцоотойгоор Бундестагт хамгийн олон суудалтай намын тэргүүнийг Канцлераар сонгодог. Үндсэн хуулийн 67 дугаар зүйлийн дагуу Канцлерт итгэл үзүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэхийн өмнө заавал Канцлер огцорсон үед шууд батлагдах залгамжлагчийг тодруулан санал хурааж, олонхийн санал авсан хүний нэрийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсний дараа уг асуудлыг хэлэлцэж эхлэх журамтай. Хэрэв Канцлерт итгэл үзүүлэхгүй бол Ерөнхийлөгч өргөн мэдүүлсэн хүний нэрийг шууд батламжилна. Шинэ Канцлер сонгох буюу итгэл үзүүлэх асуудлыг шийдэж чадалгүй хугацаа алдах нь Ерөнхийлөгч Бундестагийг тараах эрх зүйн үндэслэл болно. Иймээс Гүйцэтгэх дээд байгууллагын бүрэлдэхүүнийг сонгох, солих бүх асуудал Бундестагт эрсдэл бий болгодог.

Төрийн дээд эрхийг барих субъект

Парламентын засаглалтай холбооны улс.

Хууль тогтоох журам

Бундестаг нь тус улсын хууль тогтоох засаглалын хамгийн чухал бүрэлдэхүүн бөгөөд Холбооны улсын бүхий л хууль тогтоомжийг хэлэлцэж батална. Холбооны Засгийн газар, Бундесрат, эсвэл зарим тохиолдолд Бундестаг хуулийн төсөл санаачилах эрхтэй. Хэрэв Бундестаг өөрөө хууль санаачилах бол тус танхимын нийт гишүүдийн 5 хувийн саналыг авах, эсвэл парламентын бүлгийн дэмжлэх авах ёстой.

Бундесрат нь Засгийн газраар дамжуулж хуулийн төслөө Бундестагт өргөн барьдаг. Засгийн газар нь тухайн хуулийн төсөлд 6 долоон хоногийн дотор, эсвэл зарим тодорхой тохиолдолд 3-9 долоо хоногийн дотор саналаа оруулж Бундестагт өргөн мэдүүлнэ.

Засгийн газар хуулийн төсөл өргөн мэдүүлсэн тохиолдолд Бундесрат нь тухайн хуулийн төсөлд дээрхи хугацааны дотор саналаа оруулж Бундестагийн өмнө танилцуулна. Бундестаг нь хуулийн төслийг нэгдсэн хураалдаанаараа 3 удаа хэлэлцүүлнэ. Сүүлийн хэлэлцүүлэгээр хуулийн төслийг баталсны дараа Бундесратад шилжүүлнэ. Бундесрат

хянан үзээд Бундестагийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн, эс хүлээн зөвшөөрсөн, эсвэл Зуучлалын хороо (Mediation Committee)-г хуралдуудах зэрэг шийдвэрийн аль нэгийг гаргана. Гэхдээ Бундесрат нь эс хүлээн зөвшөөрсөн тухай шийдвэр гаргахаасаа өмнө Зуучлалын хороог хуралдуудах эсэхээ шийдэж, Хорооны шийдвэр гарсны дараа Бундесрат эс зөвшөөрөх тухайгаа шийдвэрлэнэ.

Зуучлалын хороо нь хоёр танхимын санал зөрөлдөөд байгааг зөвшилцөлд хүргэх зорилготой бөгөөд хуульд ямар нэгэн засвар хийх эрхгүй. Зуучлалын хорооны гаргасан саналыг Бундестаг ба Бундесрат хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Хэрэв Бундесрат нь хуулийг эс зөвшөөрөх бол энэ шийдвэрээ 2 долоо хоногийн дотор гарна. Бундесратын татгасан шийдвэрийг Бундестаг хяцаалт хийнэ. Бундесрат хуулийн төслийг хүлээн зөвшөөрч парламент дахь ажиллагаа дуусна. Гэхдээ тухайн хуулийн төсөлтэй холбоотой салбарын сайд болон Холбооны Канцлер, Холбооны Ерөнхийлөгч ч нар хүлээн зөвшөөрч баталсан тохиолдолд хууль батлах ажиллагаа амжилттай болж өндөрлөсөн гэж үзнэ.

Цахим хуудас:

<http://www.bundestag.de>

<http://www.bundesrat.de>

БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛС

Парламентын танхимуудын нэр

а/ Дээд танхим- Сенат

б/ Доод танхим- Төлөөлөгчдийн танхим

Парламент байгуулагдах хэлбэр

Төлөөлөгчдийн танхим нь 630 гишүүнтэй. Холбооны сенат нь 315 гишүүнээс бүрддэг. Аль аль танхим нь сонгогчдын олонхийн саналаар сонгогддог. Итали улсын 18 насанд хүрсэн бүх иргэд сонгуульд санал өгөх эрхтэй байдаг ч Сенатийн гишүүнийг 25 буюу түүнээс дээш насны хүмүүсийн саналаар сонгодог.

Төлөөлөгчдийн танхимын депутатуудыг сонгох сонгуулийн тухай хууль (1957 он), Сенатын депутатуудын сонгуулийн хуулиуд нь (1948 ба 1958 он) хоёр танхимыг бүрдүүлэх өөр хоорондоо нэлээд ялгаатай тогтолцоог хуульчилсан. Төлөөлөгчдийн танхимын депутатуудыг сонгоход олон мандаттай тойрогт сонгуулийн хувь тэнцүүлэх, харин Сенатын депутатуудыг сонгуулийн хувь тэнцүүлэх хувилбарын зарим нэг шинжийг агуулсан нэг мандат бүхий олонхийн төлөөллийн тогтолцоог хэрэглэдэг.

Сенатад зориулсан сонгуулийн тогтолцоо нь шашны төлөөлөлд үндэслэдэг. Хоёр танхимд хамгийн ихдээ 5 жилийн хугацаатайгаар сонгогдох эрхтэй. Италийн парламентад тогтсон журмын дагуу италийн хилийн чанадад байнга оршин суудаг 2,7 сая Итали Улсын иргэд санал өгөх эрхтэй. Бүс нутгийн бус сенаторийн тоо хамгийн ихдээ 7-оос илүүгүй байна. Тухайлбал Молис 2, Вале Даоста 1 сенаттай байна.

Нэг төлөөлөгч нь нэг сонгуулийн тойргоос сонгогдох бөгөөд сонгуулийн тойрогт байнгын оршин суугч хамаарагдана. Итали улсын 40 насанд хүрсэн иргэн нь Сенатын гишүүнээр сонгогдох эрхтэй. Бүс нутгийн парламентын суудлын тоог тухайн бүс нутгийн хүн амын хамгийн сүүлийн тоог үндэслэж үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн дагуу тогтооно. Төлөөлөгчдийн танхим болон Сенат нь таван жилийн хугацаатай сонгогддог.

Парламентын бүрэн эрх

Парламент хууль тогтоох, хяналт тавих, шүүх, төрийн бодлогыг тодорхойлох,



Судалгааны эмхтгэл, X боть

Ерөнхийлөгчийг сонгох бүрэн эрхийг Үндсэн хуульд заасан нөхцөл, журмын дагуу хэрэгжүүлнэ. Шүүх бүрэн эрхийн тухайд Үндсэн хуулийн 91 дүгээр зүйлийн дагуу улсын Ерөнхийлөгчийг хууль зөрчсөн тохиолдолд тусгай шүүхэд шилжүүлэх, 96 дугаар зүйлийн дагуу засгийн газрын гишүүдийг шүүхээр мөрдөн байцаах зөвшөөрөл олгох эрхээр хэрэгждэг.

Төрийн дээд эрхийг барих субъект

Парламент. Италийн Үндсэн хуулийн дагуу Ерөнхийлөгч нь хоёр танхимын даргын саналыг сонссоны дараа хоёр танхимыг, эсвэл аль нэг танхимыг тараах эрхтэй.

Хууль тогтоох журам

Хуулийн төслийг Засгийн газар, Парламентын гишүүн буюу үндсэн хуулийн нэмэлтээр эрх олгогдсон этгээд, байгууллага санаачлана. Хууль нь батлагдсанаас хойш сарын дотор Ерөнхийлөгч ёсчилоны дараа хуулийг зарлана. Хэрвээ хоёр танхимын гишүүдийн туйлийн олонхи нь хуулийг яаралтай тунхаглах ёстой гэж үзвэл хуульд тунхаглагдах эцсийн хугацааг зааж өгнө. Хуулийн хүчин төгөлдөр болсны дараа нэн даруй нийтлэх ёстой бөгөөд хэрвээ хуульд өөрт нь хүчин төгөлдөр болох хугацааг зааж өгөөгүй бол тус хууль нийтлэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

Засгийн газар нь зөвхөн хязгаартай хугацаанд буюу тусгай зорилгоор хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тусгай асуудлаар аль нэг танхим хуралдаж байх үед нөгөө танхим нь тухайн асуудлыг авч хэлэлцэнэ. Тусгай асуудлаар хуралдахдаа Ерөнхийлөгч, парламентын дарга болон парламентын гишүүний санаачлагаар хуралдана.

БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛС

Парламентын танхимуудын нэр

а/ Дээд танхим- Сенат

б/ Доод танхим- Төлөөлөгчдийн танхим

Парламент байгуулагдах хэлбэр

Төлөөлөгчдийн танхим бүх ард түмнээс 5 жилийн хугацаагаар шууд сонгогдох 160-170 гишүүнтэй, Сенат шууд бус сонгуулиар 5 жилийн хугацаагаар сонгогддог 49, томилогддог 11, бүгд 60 гишүүнтэй.

Парламентын дээд, доод танхимын сонгуулийг 1992 оны XI сарын 5-нд батлагдсан Сонгуулийн хуулийн дагуу явуулна. Парламентын доод танхимын 166 гишүүнийг 3-5 мандат бүхий 42 тойргоос нэг шилжих санал бүхий хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны дагуу санал хурааж, нийт саналын хуудасны тоог тухайн тойргийн мандатын тоон дээр 1-ийг нэмж хуваан тойргийн босгыг тогтооно. Энэхүү босгыг давсан нэр дэвшигч шууд сонгогдсонд тооцогдох ба босгоос давсан саналын тоо нь намынхаа дараагийн нэр дэвшигчид шилжиж тооцогдох байна. Парламентын доод танхимын бүрэн эрхийн хугацаа 5 жил байдаг. Сонгуульд оролцох нас 18, парламентын доод танхимын сонгуульд нэр дэвших нас 21 байна.

Парламентын дээд танхимын 49 гишүүний 6-г Үндэсний болон Дублины Их сургуулиас, 43-ыг төрөл бүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас сонгох бөгөөд 11 гишүүнийг Ерөнхий сайд томилогдсоныхоо дараа саналаа оруулж томилуулах журамтай. 49 гишүүнийг сонгох тогтолцоо нь нэг шилжих санал бүхий хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо юм. Сенатын танхим 5 жилийн хугацаатайгаар бүрэн эрхээ хэрэгжүүлдэг.

Парламентын бүрэн эрх

Парламент хууль тогтоох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, цэрэг, зэвсэгт хүчнийг байгуулах, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Парламент Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ Засгийн газрын байгууллагын илтгэл мэдээллийг байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар сонсох, Засгийн газрын байгууллагуудад мөрдөн шалгах комисс ажиллуулах, Засгийн газрын Ерөнхий сайд, сайдуудад асуулт, асуулга тавьж, хариуг нэгдсэн хуралдаан дээр сонсох, омбудсман, аудитын хяналтын мөрөөр ажиллах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлдэг. Түүнчлэн дээр дурьдсан бүрэн эрхүүдийн зэрэгцээ танхимууд зарим салбарт нэмэлт бүрэн эрх эдэлдэг. Тухайлбал, Дээд шүүхийн Дарга болон шүүгчид, Ерөнхий аудиторыг албан тушаалаас нь чөлөөлөх, онц байдал зарлах, цуцлах зэрэг болно.

Дээд танхим буюу Сенат дараах хоёр төрлийн онцгой бүрэн эрхтэй. Үүнд:

- Хуульд Ерөнхийлөгч гарын үсэг зурж хүчин төгөлдөр болсныг зарлах хугацааг багасгах,
- Ард нийтийн санал асуулгаар шийдвэр гаргахаас өмнө Ерөнхийлөгчийг хуульд гарын үсэг зурахаас татгалзах хүсэлт гаргах зэрэг болно.

Төрийн дээд эрхийг барих субъект: Парламент

Хууль тогтоох журам

Хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийн өргөн баригдсан төслийг хүлээн авсан танхим нь нэгдсэн хуралдаанаар эхлэн хэлэлцэж, нөгөө танхимдаа шилжүүлж, 2 танхим дараалан хэлэлцэх журамтай. Төслийг хэлэлцсэн сүүлчийн танхим төсөлд ямар нэг өөрчлөлт оруулбал, түүнийг доод танхим эцэслэн батлана. Парламентын 2 танхим дараалан хэлэлцэж баталсан хуулийг Ерөнхийлөгчид үзэглэж, тунхаглан зарлуулахаар шилжүүлнэ.

ИСПАНИ - Испанийн Вант Улс

Парламентын танхимуудын нэр:

- а. Дээд танхим – Сенат
- б. Доод танхим – Төлөөлөгчдийн Конгресс

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Сенат: Одоогийн Сенат нь нийт 264 гишүүнтэй бөгөөд бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Сүүлийн сонгууль 2009 оны 5-р сарын 12-нд болсон. Нийт гишүүдийн ихэнхи нь буюу 208 гишүүн нь орон нутгаас сонгогдсон байна. Орон нутаг бүрээс 4 сенатор бүх нийтийн, тэгш, чөлөөтэй, шууд, нууцаар санал хураах зарчмын үндсэн дээр сонгогддог. Харин 51 гишүүнийг шашны хууль тогтоогчдоос томилогддог. Сонгуулийн тойрогт ногдох мандатын тоог муж бөгөөд тухайн тойргийн хүн амын тоог харгалзан тодорхойлно. Гэсэн хэдий ч Сеута болон Мелила хотууд нь тус бүр нэг гишүүнтэй байна.

Парламентын дээд танхим болох Сенат нь нутаг дэвсгэрийн төлөөллийн танхим бөгөөд Хууль тогтоомжийн байнгын хороо, хууль тогтоомжийн түр хороо, Хамтарсан хороо, Судалгааны, Тусгай, Холимог, Доод танхимтай нэгдсэн зэрэг хороо байгуулан ажилладаг.

Төлөөлөгчдийн конгресс: Сонгуулийн тухай хууль нь 1985 оны 6 дугаар сарын 16-нд батлагдсан. Сонгуулийн тогтолцооны хувьд холимог. Төлөөлөгчдийн конгресс нь 350 гишүүнтэй, 4 жил тутамд пропорциональ төлөөллийн системийн дагуу бүх нийтийн



Судалгааны эмхтгэл, X боть

сонгуулиар сонгогддог. Тус улсын 50 мужийн хувьд пропорциональ төлөөллийн системээр санал хурааж, суудлыг D`Hondt-ын аргаар хуваарилдаг. Харин 2 сонгуулийн тойргийн хувьд тус бүр нэг төлөөлөгч сонгодог.

Төлөөлөгчдийн конгресс нь дарга, дэд дарга нар, нарийн бичгийн дарга нараас бүрддэг. Дэд дарга, нарийн бичгийн дарга нарын тоо парламентад байгаа бүлгийн тоотой адил байдаг. Товчоо парламентын доод танхимын дотоод зохион байгуулалт, төсөв зардлын асуудлыг зохицуулах чиг үүрэгтэй байна.

Парламентын доод танхим төр, эрх зүй, нийгэм, эдийн засгийн салбар чиглэлээр Үндсэн хуулийн, Шүүхийн хэргийн, Гадаад хэргийн, Дотоод хэргийн, Батлан хамгаалахын, Эдийн засаг, санхүүгийн, Төсвийн, Хөгжлийн, Боловсрол, спортын, Цагаачлалын асуудлын, Аж үйлдвэр, худалдаа, аялал жуулчлалын зэрэг хууль тогтоомжийн 19 Байнгын хороо, Дэгийн, Гишүүний эрх зүйн байдлын, уучлалын, Тахир дутуу болохын эсрэг бодлогын, Нэр дэвшүүлэлтийн, Зардлын аудитын зэрэг хууль тогтоомжийн бус 6 Байнгын хороо, Тооцооны танхимтай холбогдох хамтарсан хороо, Европын холбооны асуудлын хамтарсан хороо, Омбудсмантай хамтран ажиллах нэгдсэн хороо, Мансууруулах бодисын асуудлын хамтарсан хороо гэсэн 2 танхим хамтран байгуулдаг хороо ажиллаж байна. Тодорхой асуудлаар байгуулагдсан 7 дэд хороо ажиллаж байна.

Бүх испаничууд өөрийн улс төрийн эрхээ хэрэгжүүлж сонгуульд оролцох эрхтэй. Үүний дагуу испани улсын нутаг дэвсгэрээс гадна оршин сууж байгаа бүх испани иргэний сонгох эрхийг төрөөс баталгаажуулдаг. Сонгууль явагдсанаас хойш 30-60 хоногийн дотор өмнөх парламентын бүрэн эрх дуусгавар болох бөгөөд сонгогдсон парламент 25 өдрийн дотор анхдугаар хуралдаанаа хуралдуулах ёстой. Парламентын 2 танхимын дарга, дэд дарга нарыг сонгуулийн дараах анхны чуулганы хуралдаанаар гишүүдийн дотроос сонгодог. Бүрэн эрх

Парламентын дээд танхим болох Сенат нь мужуудыг төлөөлөх бөгөөд хууль тогтоох, гадаад бодлогын удирдлагыг хэрэгжүүлэх, улс төрийн үйл явцыг хянах чиг үүрэгтэй ажиллана. Парламентын доод танхим болох Төлөөлөгчдийн конгресс нь сонгогч, иргэдийг төлөөлөх бөгөөд бие даасан мандатын эрх эдлэхгүй, нийт ард түмний эрх ашгийн төлөө ажиллана.

Парламентын 2 танхим хууль тогтоох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Парламентын 2 танхим Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Засгийн газарт илгээлт, айлтгал явуулж, хариуг сонсох, омбудсманы хяналтыг ашиглах, мөрдөн шалгах комисс ажиллуулах зэрэг хэлбэрийг ашигладаг байна.

Төрийн дээд эрхийг барих субъект: Үндсэн хуульт хаант засаглалтай улс.

Хууль тогтоох журам

Хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ өргөн баригдсан төслийг Төлөөлөгчдийн конгресс гишүүдийн олонхи нь оролцсон хурлаар Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол олонхийн саналаар баталж, Сенатад шилжүүлнэ. Сенат энэхүү төслийг хэлэлцэж олонхийн саналаар батлах, эсхүл хориг тавина. Төлөөлөгчдийн танхим баталсан хуулийг Эзэн хаанд батламжлуулахаар шилжүүлнэ.

Хуулийн төслийн талаар 2 танхим саналын зөрүүтэй асуудлаар нэгдсэн хороо байгуулан ажиллаж, нэгдсэн саналд хүрэхийг эрмэлзэх бөгөөд хориг тавьсан хуулийн төслийг сарын дотор дахин хэлэлцэж, хоригийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хүлээн авах эсхүл хоригийг нийт гишүүдийн олонхийн саналаар хүлээн авахгүй байх шийдвэр

гаргана. Хууль санаачлах эрхийг Парламентын 2 танхимын гишүүд, өөртөө засах эрх бүхий мужийн парламент, Засгийн газар, 500 мянгаас доошгүй иргэд нэгдэж санаачлах эрх эдэлнэ.

Цахим хаяг: <http://www.congreso.es>

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс. Холбооны Хурал нь Оросын Холбооны Улсын парламент бөгөөд Холбооны зөвлөл болон Төрийн Дум гэсэн хоёр танхимаас тогтоно.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Холбооны зөвлөлд ОХУ-ын субъект нэг бүрээс хоёр төлөөлөгч, төрийн захиргааны төлөөллийн болон гүйцэтгэх байгууллагаас тус бүр нэг төлөөлөгч орно. Төрийн Дум 450 депутаттай. Төрийн Думын депутатууд намын нэрсийн жагсаалтаар пропорциональ тогтолцоогоор сонгогддог бөгөөд намуудад суудлыг Неге-ын аргаар хуваарилдаг. 7 хувийн босготой. Депутатын суларсан суудалд намын сонгуулийн нэрсийн жагсаалтад бичигдсэн дараагийн хүн нөхөж суудаг. Төрийн Думын депутатаар 21 нас хүрсэн бөгөөд сонгуульд оролцох эрх бүхий ОХУ-ын иргэн сонгогдож болно. Төрийн Думын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

Нэг хүн нэгэн зэрэг Холбооны Хурлын гишүүн болон Төрийн Думын депутат байж болохгүй. Төрийн Думын депутат төрийн захиргааны төлөөллийн бусад байгууллагууд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын депутат байж болохгүй. Төрийн Думын депутатууд мэргэжлийн байнгын үндсэн дээр ажиллана. Төрийн Думын депутатууд төрийн алба хааж, багшлах, шинжлэх ухааны болон бусад бүтээлч үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулж болохгүй. Холбооны Хурал болон Төрийн Дум тус тусдаа хуралдана.

Бүрэн эрх

Холбооны Хурлын мэдэлд:

- -ОХУ-ын субъектүүд хоорондын хилийг батлах, өөрчлөх
- -Дайны байдал болон онц байдал тогтоох тухай Ерөнхийлөгчийн зарлигийг батлах
- -Зэвсэгт хүчнийг ОХУ-ын нутаг дэвсгэрийн гадна ашиглах боломжийн тухай асуудлыг шийдвэрлэх
- -Ерөнхийлөгчийн сонгуулийг товлох
- -Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах
- -Үндсэн хуулийн шүүхийн, Дээд шүүхийн, Арбитрын Дээд Шүүхийн шүүгчдийг томилох
- -Ерөнхий прокурорыг албан тушаалд томилох болон албан тушаалаас чөлөөлөх
- -Тооцооны танхимын орлогч дарга болон түүний аудитуудын бүрэлдэхүүний хагасыг албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх асуудлууд багтана.
- Төрийн Думын мэдэлд:
 - -Засгийн газрын тэргүүнийг томилох тухай Ерөнхийлөгчийн саналыг хэрхэх тухай шийдвэрлэх
 - -Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэх
 - -Төв банкны даргыг албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх
 - -Тооцооны танхимын дарга, түүний аудитуудын бүрэлдэхүүний хагасыг албан

Судалгааны эмхтгэл, X боть

тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх

- -Холбооны үндсэн хуулийн дагуу үйп ажиллагаагаа явуулж байгаа хүний эрхийн талаархи бүрэн эрхт тушаалтныг албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх
- -Өршөөл зарлах
- -Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулахаар түүний эсрэг хэрэг үүсгэх зэрэг асуудлууд багтана.

Хууль батлах журам

Холбооны хуулиудыг Төрийн Дум батлаж Холбооны Хурлаар хэлэлцүүлэхээр тав хоногийн хугацаанд шилжүүлнэ. Хэрэв Холбооны Хурлын танхимын нийт гишүүдийн талаас илүү нь дэмжсэн буюу 14 хоногийн дотор Холбооны Хурлаар хэлэлцэгдээгүй бол холбооны хууль Холбооны Хурлаар зөвшөөрөгдсөнд тооцогдоно. Харин холбооны хуулийг Холбооны Хурлын танхим буцаасан тохиолдолд үүссэн санал зөрөлдөөнийг арилгахын тулд зохицуулах комиссыг байгуулж ажиллуулсны дараа холбооны хуулийг Төрийн Думаар дахин хэлэлцүүлж болно. Холбооны Хурлын шийдвэртэй Төрийн Дум санал нийлээгүй бол дахин санал хураалтын үед Төрийн Думын нийт депутатуудын гуравны хоёроос цөөнгүй нь холбооны хуулийг дэмжсэн бол түүнийг батлагдсанд тооцно.

Батлагдсан холбооны хуулийг тав хоногийн хугацаанд Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Ерөнхийлөгч холбооны хуулийг зөвшөөрсөн тохиолдолд 14 хоногийн дотор баталж, ёсчлох бөгөөд харин буцаавал Төрийн Дум болон Холбооны Хурал уг хуулийг дахин авч хэлэлцэж нийт гишүүдийнхээ гуравны хоёроос доошгүйн саналаар анхны редакцаар батлагдвал долоо хоногийн хугацаанд Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч түүнийг ёсчлох үүрэгтэй.

Ерөнхийлөгч Үндсэн хуульд заасан тохиолдолд Төрийн Думыг тарааж болно. Харин Төрийн Думыг сонгогдсоноос хойш жилийн хугацаанд, ОХУ-ын нийт нутаг дэвсгэр дээр дайны буюу онц байдал тогтоогдсон үед, мөн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахад зургаан сар хүрэхгүй хугацаа үлдсэн бол, түүнчлэн Ерөнхийлөгчийн эсрэг хэрэг үүсгэсэн мөчөөс Холбооны Хурал зохих шийдвэр гаргах хүртэл тарааж болохгүй. Хэрэв Засгийн газрын даргад нэр дэвшсэн хүнийг Төрийн Дум гурван удаа буцаавал Ерөнхийлөгч Засгийн газрыг томилж, Төрийн Думыг тарааж, шинээр сонгууль явуулна.

ПОЛЬШ

Парламентын засаглалтай бүгд найрамдах улс. Парламент нь Сейм, Сенат гэсэн 2 танхимтай. Польш улсын парламентыг зарим тохиолдолд тухайлбал Үндсэн хууль батлах тохиолдолд Ардын Хурал гэж нэрлэх нь байдаг боловч албан ёсоор түүний танхимуудын нэрээр буюу Сейм (Доод танхим) болон Сенат (Дээд танхим) гэж нэрлэдэг.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Сейм болон Сенат нь 4 жилийн хугацаагаар сонгогддог. Сонгууль нь нэгэн зэрэг явагдана. Сейм болон Сенатын бүрэн эрхийн хугацаа нь харилцан хамааралтай байдаг бөгөөд хэрэв Сеймийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон тохиолдолд Сенатын бүрэн эрхийн хугацаа нэгэн адил дуусгавар болдог.

Польшийн Сейм нь сонгуулийн пропорциональ тогтолцоогоор сонгогддог 460 депутатаас бүрддэг бөгөөд тэдгээрээс 69 нь бүх Польшийн сонгуулийн тойргоос сонгогддог бол 391 нь намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаар орон нутгийн олон мандатай тойрогт (3-аас 17 мандат бүхий) сонгогддог. Намууд гишүүдээ парламентад сонгуулахын тулд 5

хувийн босго давах ёстойн дээр орон нутгийн тойрогт намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгүүлэхийн тулд 5000-аас доошгүй сонгогчдын гарын үсэг цуглуулах учиртай.

Сенат нь олон мандаттай сонгуулийн мажоритар системээр сонгогддог 100 гишүүнтэй. Сейм нь нийт ард түмний ашиг сонирхлыг төлөөлдөг бол Сенат нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төлөөллийн байгууллага юм. 49 воеводство тус бүр 2 сенатч илгээдэг бол хүн ам ихтэй Варшав болон Катовице тус бүр 3 сенатч сонгодог. 21 нас хүрсэн сонгуулийн эрхтэй Польшийн иргэн Сеймийн депутат, 30 нас хүрсэн мөн ийм иргэн Сенатын гишүүн байж болно.

Бүрэн эрх

Сенат нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхээс гадна бүх нийтийн санал асуулга явуулах тухай Ерөнхийлөгчийн саналыг зөвшөөрөх, Хянан шалгах хорооны дарга, Хүний эрхийн төлөөлөгч, Хүүхдийн эрхийн асуудлаархи бүрэн эрхт төлөөлөгчийг томилоход оролцох, Радио, телевизийн үндэсний зөвлөлийн нэг гишүүн, Хууль зүйн үндэсний зөвлөлийн 2 гишүүн, Мөнгөний бодлогын зөвлөлийн 3 гишүүнийг томилох эрхтэй.

Сенат нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих эрхгүй бөгөөд энэхүү үүргийг Сейм хэрэгжүүлдэг. Сейм нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхээс гадна тодорхой хэргийг мөрдөн шалгах комисс байгуулж ажиллуулах, дайн энхийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг бүрэн эрхтэй. Ерөнхийлөгч, Сеймийн гишүүд, Сенат, Засгийн газар болон сонгуулийн эрх бүхий нэг зуун мянгаас доошгүй иргэн нэгдэж хууль санаачлах эрх эдлэнэ.

Хууль хэлэлцэж батлах журам

Сейм хуулийн төслийг гурван удаагийн хэлэлцүүлгээр хэлэлцэж батална. Сенат Сеймийн батласан хуулийг хүлээн авсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор, яаралтай бол 14 хонгийн дотор хэлэлцнэ. Сенат тухайн хуулийг шууд батлах эсвэл засвар оруулах, буцаах эрхтэй. Хуульд засвар оруулах, буцаах тухай тогтоол нь Сенатын нийт гишүүдийн талаас илүү нь хуралдаанд оролцож, тэдний дөрөвний гурав нь дэмжсэнээр хүчин төгөлдөр болно. Харин улсын төсвийн тухай хуулийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор хэлэлцэж батална. Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 60 хоногийн хугацаанд хэлэлцэнэ. Сеймийн Маршал батлагдсан хуулийг гарын үсэг зуруулахаар Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

РУМЫН

Бүгд Найрамдах Румын Улс

Парламентын танхимуудын нэр:

- a. Дээд танхим – Сенат
- b. Доод танхим – Төлөөлөгчдийн танхим

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо:

Хоёр танхимын бүрэн эрхийн хугацаа 4 жил. Сонгуулийн холимог тогтолцоотой. Сенат болон Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн тоог сонгуулийн хуулиар тогтоодог. Мөн парламент дахь үндэсний цөөнхийн төлөөллийн тоог мөн хуулиар тогтооно. Нэг этгээд нэгэн зэрэг 2 танхимын гишүүн байж болохгүй. Парламентын гишүүн нь Засгийн газрын гишүүн байж болно. Шинээр сонгогдсон парламентын анхдугаар чуулганыг Ерөнхийлөгч сонгууль явагдсанаас хойш 12 хоногийн дотор зарлан хуралдуулна. Хоёр танхимын ээлжит



чуулган жилд хоёр удаа 2-6 дугаар сард, 9-12 дугаар сард тус тус хуралдана. Ээлжит бус чуулганыг Ерөнхийлөгчийн хүсэлтээр, эсвэл танхим тус бүрийн байнгын хороодын болон нийт депутат, сенатчдын гуравны нэгийн шаардсанаар зарлан хуралдуулна.

Сенат: Одоогийн Сенат 129 гишүүнтэй бөгөөд сүүлийн сонгууль 2008 оны 11-р сард явагдсан байна. Сенат 16 байнгын хороотой. Төлөөлөгчдийн танхим: Төлөөлөгчдийн танхимын 296 гишүүдийг нийт ард түмний шууд сонгуулиар сонгоно. Төлөөлөгчдийн танхим нь 17 байнгын хороотой.

Бүрэн эрх

Хоёр танхим тусдаа хуралдаж хууль, бусад шийдвэрийг хэлэлцэж батлах бөгөөд танхим тус бүрийн хэлэлцэх асуудлыг Үндсэн хуулиар тодорхойлсон байдаг. Хоёр танхим дараах асуудлаар хамтран хуралдаж шийдвэр гаргана. Үүнд:

- 1) Ерөнхийлөгчийн илгээлтийг хүлээн авах;
- 2) улсын төсвийг хэлэлцэж батлах;
- 3) бүх нийтийн болон хэсэгчилсэн цэрэг татлага, дайчилгаа зарлах;
- 4) дайны байдал зарлах;
- 5) дайны ажиллагааг түр буюу бүрэн зогсоох;
- 6) батлан хамгаалах стратегийг батлах;
- 7) Үндэсний батлан хамгаалах Дээд зөвлөлийн тайланг хэлэлцэх;
- 8) Ерөнхийлөгчийн санал болгосноор тусгай албадын удирдлагыг томилох;
- 9) Засгийн газарт итгэл хүлээлгэх, эсэх;
- 10) Үндсэн хуульд заасан бусад асуудлууд.

Төрийн дээд эрхийг барих субъект

Парламентын ардчилсан үндсэн хуульт хаант засаглалтай нэгдмэл улс.

Хууль тогтоох журам

Парламентын хоёр танхимын гишүүд, Засгийн газар болон 100 000-аас доошгүй сонгуулийн эрх бүхий иргэн нэгдэж хууль санаачлах эрхтэй. Иргэд олон улсын харилцаа, татвар, уучлал, өршөөлийн асуудлаар хууль санаачилж болохгүй. Батлагдсан хуулийн төслийг батламжлуулахаар Ерөнхийлөгчид хүргүүлэх бөгөөд Ерөнхийлөгч 20 хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв батламжлахаас татгалзвал парламентаар дахин хэлэлцүүлэхээр нэг удаа буцааж болно. Ерөнхийлөгч тухайн хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн шүүхэд хандвал тус шүүх хуулийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор дүгнэлт гаргана. Хууль нь хэвлэгдсэнээс хойш 3 хоногийн дараа хүчин төгөлдөр болно

Цахим хуудас:

<http://www.cdep.ro>

<http://www.senat.ro>

СЛОВЕНИ

Парламентын засаглалтай Бүгд найрамдах улс. Словенийн парламент нь Үндэсний Хурал, Үндэсний Зөвлөл гэсэн хоёр танхимтай.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Доод танхим болох Үндэсний Хурлын 90 гишүүний 88-ыг пропорциональ (4 хувийн

босготой) тогтолцоогоор сонгодог бол 2-ыг нь итали, унгар үндэстний цөөнхөөс мажоритар тогтолцоогоор сонгодог. Бүрэн эрхийн хугацаа нь 4 жил. Үндэсний Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явагдсан өдрөөс хойш 20 хоногийн дотор Ерөнхийлөгч зарлан хуралдуулдаг. Хэрэв Үндэсний Хурал хугацаанаасаа өмнө тарвал 2 сарын дотор сонгууль явагдна.

Дээд танхим буюу Үндэсний Зөвлөл нь 40 гишүүнээс бүрддэг. Бүрэн эрхийн хугацаа нь 5 жил. Гишүүдийг нийгэм, эдийн засаг, үндэстний болон мэргэжлийн бүлэг, давхрагын төлөөлөл, орон нутгийн эрх ашгийг харгалзан сонгодог. Тухайлбал, ажил олгогч эзэд, жижиг үйлдвэрлэл эрхлэгчид 4, ажил мэргэжлийн төлөөлөл 4, төрийн албаны төлөөлөл 4, төрийн бус байгууллагын төлөөлөл 6, орон нутгийн төлөөлөл 22 байна.

Бүрэн эрх

Үндэсний Зөвлөл нь :

- хууль санаачлах
- Үндэсний Хурлын баталсан хуулийг хэлэлцэж батлах
- бүрэн эрхэд нь хамаарах ямар ч асуудлаар Үндэсний Хуралд саналаа хүргүүлэх
- хууль батлагдахаас өмнө тухайн хуулийг дахин хэлэлцэхийг Үндэсний Хурлаас шаардах
- ард нийтийн санал асуулга явуулахыг Үндэсний Хуралд санал болгох
- нийгмийн амьдралын чухал асуудлаар асуулга тавих
- Үндэсний Хурлын депутатуудыг батламжлах зэрэг бүрэн эрхтэй.
- Үндэсний Хурал нь :
- Үндсэн хууль болон бусад шийдвэрийг хэлэлцэж, батлах
- олон улсын гэрээг соёрхон батлах
- дайны болон онц байдал зарлах
- батлан хамгаалах хүчнийг хөдөлгөх
- ард нийтийн санал асуулга зарлаж товлох зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Хууль хэлэлцэж батлах журам

Үндэсний Хурлын гишүүн, Үндэсний Зөвлөл, Засгийн газар, 5000-аас доошгүй сонгогчид нэгдэж хууль санаачлах эрх эдлэнэ. Үндэсний Хурлын чуулганы хуралдаан нийт гишүүдийн талаас илүү нь оролцооноор хүчин төгөлдөр болох бөгөөд хууль болон бусад шийдвэрийг хуралдаанд оролцогсдын олонхиор батладаг.

Сонгуулийн тухай хууль болон ард нийтийн санал асуулга явуулах тухай шийдвэрийг нийт депутатын гуравны хоёроор батладаг. Үндэсний Зөвлөл Үндэсний Хурлын баталсан хуулийг дахин хэлэлцүүлэхээр 7 хоногийн дотор буцааж болно. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний Хурлын нийт депутатын олонхи нь дэмжсэн тохиолдолд уг хуулийг батлагдсанд тооцно. Батлагдсан хуулийг 8 хоногийн дотор Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС

Парламентын танхимуудын нэр

а/ Дээд танхим-Сенат

б/ Доод танхим-Үндэсний ассамблей

Парламент байгуулагдах хэлбэр

Парламентын доод танхим бүх ард түмнээс 5 жилээр сонгогддог 577 депутаттай Сенатын танхим нь шууд бус сонгуулиар мужууд (департамент)-аас 9 жилээр сонгогддог 350 сенатчтай.

Парламентын дээд, доод танхимын сонгуулийг 1964 оны X сарын 27-нд баталж, 2000 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн дагуу явуулах журамтай. Парламентын доод танхимын 577 гишүүнийг улсын хэмжээнд байгуулагдсан 1 мандат бүхий 577 тойргоос олонхийг төлөөлөх системээр, шаардлагатай бол 2 шаттайгаар санал хурааж сонгох журам мөрдөгддөг байна. Нэр дэвшигчид 2 дахь шатны санал хураалтад орохын тулд тойрогт бүртгэгдсэн нийт сонгогчдын 12.5 хувийн босгыг давсан байхыг шаарддаг. Харин тухайн тойрогт эхний санал хураалтаар энэ босгыг зөвхөн 1 нэр дэвшигч давсан тохиолдолд 2 дахь нэр дэвшигч 12.5 хувиас бага саналтай байсан ч 2 дахь шатны санал хураалтад оролцох эрхтэй байдаг нь онцлог байж болох юм.

Сенатын гишүүдийн 1/3 нь 3 жил тутамд шинэчлэгдэн сонгогдох журамтай. Сонгуулийн хуулийн ёсоор 331 сенатчийг шууд бус сонгуулиар сонгох бөгөөд нэр дэвшигчдийн дотор хүйсийн тэнцвэрийг хангах журамтай. Сенатын сонгуулийг сонгуулийн холимог системээр явуулдаг. 128 тойргоос мажоритар системээр 128 сенатчийг 2 шатны санал хураалтаар сонгодог бол үлдсэн 203 суудлыг пропорциональ системээр намын хаалттай жагсаалтаар санал хурааж, суудлыг хамгийн их дундажийн аргаар хуваарилдаг байна. Нэг мужаас дунджаар 3-5 сенатч сонгогддог.

Сенатчдыг сонгохын тулд мужид 1000 хүнтэй сонгогчдын зөвлөлийг тусгайлан бүрдүүлдэг бөгөөд түүний бүрэлдэхүүнд тухайн мужаас үндэсний хуралд сонгогдсон бүх депутатат /2-7 депутат/ мужийн төлөөллийн байгууллагын депутатууд /30-40 депутат/, доод шатны орон нутгийн нэгж коммун бүрээс 10-15 төлөлөгч/ тус тус ордог. Коммуны төлөөлөгчид сонгогчдын коллегид тоогоороо давамгайлдаг нь Францын сенатчдыг үндсэндээ коммунны төлөөлөгчдөөс сонгодог гэж үзэхэд хүргэдэг. Доод танхимын гишүүнд нэр дэвшигч 23 нас, сенатчид нэр дэвшигч 35 насанд хүрсэн байх шаардлагатай.

Парламентын бүрэн эрх

Парламент хууль тогтоох, хяналт тавих, шүүх, эдийн засаг, гадаад бодлоготой холбоотой бүрэн эрхийг Үндсэн хуульд заасан нөхцөл, журмын дагуу хэрэгжүүлнэ. Тухайлбал, эдийн засгийн бүрэн эрхээ (жишээ нь, төсөв, эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөөг батлах) хэрэгжүүлэхдээ тодорхой хууль батлах замаар хэрэгжүүлнэ. Парламентын шүүхийн бүрэн эрх гэдэг нь төрийн дээд албан тушаалтнуудын хэргийг хэлэлцэх тусгай шүүх байгуулах эрхтэй байдаг оршино. Олон улсын гэрээг соёрхон батлах замаар гадаад бодлогын бүрэн эрхээ хэрэгжүүлдэг.

Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтын шийтгэлтэй холбоотой асуудлыг зөвхөн доод танхимаар хэлэлцдэг ба доод танхим нь засгийн газарт итгэл үл үзүүлэх байдлаар засгийн газрыг огцруулж болно. Парламент хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ энгийн, органик, Үндсэн хуульд өөрчлөлт оруулахтай холбоотой хуулиудыг баталдаг ба 1958 оны Үндсэн хуулийн дагуу Францын парламент нь ялангуяа энгийн хуулийг батлах асуудлаар хязгаарлагдмал эрхтэй юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд парламент хууль батлах замаар зохицуулж болох асуудлуудыг тодорхойлсон байна. Зарим асуудлаар (тухайлбал, боловсрол, хөдөлмөр, батлан хамгаалах зэрэг) парламент зөвхөн ерөнхий зарчмуудыг тодорхойлж, харин нарийвчилсан зохицуулалтыг гүйцэтгэх засаглал хэрэгжүүлдэг.

Парламентын хууль хэвлэн нийтлэх эрх нь зарим тохиолдолд Ерөнхийлөгчийн хуулийн

төслийг парламентыг алгасан ард нийтийн санал асуулга явуулах бүрэн эрхээр хязгаарлагддаг.

Төрийн дээд эрхийг барих субъект

Франц улс нь Ерөнхийлөгч, Парламентын эрх хэмжээ харьцангуй тэнцвэржсэн, нэгдмэл улс. Үндсэн хуульд зааснаар хууль тогтоох дээд эрхийг парламент хэрэгжүүлдэг. Францын Ерөнхийлөгчийн институт төрийн байгууллын тогтолцоонд гол байр суурийг эзэлж, Үндсэн хуулиар түүнд өргөн бүрэн эрхийг олгожээ. Тухайлбал, Ерөнхийлөгч парламентын доод танхим болох Үндэсний Ассамблейг өөрийн үзэмжээр татан буулгах эрхтэй байдаг. Францын улс төр судлаач М.Дюверже Францыг 1962 оноос хойш хагас ерөнхийлөгчийн засаглалтай улс гэж тодорхойлжээ.

Хууль тогтоох журам

Засгийн газар хуулийн төслийг парламентын аль ч танхимд өргөн барьж болдог бол харин депутатууд зөвхөн өөрийн харьяалагддаг танхимын товчоонд хуулийн төслийг өргөн барьдаг. Парламентын депутатын өргөн барьсан хуулийн төсөлд төрийн зарлагыг нэмэгдүүлж, орлогыг багасгахаар заалт тусгагдсан тохиолдолд түүнийг хүлээн авдаггүй байна.

Танхимын товчооноос хуулийн төслийг байнгын болон тусгай комисст шилжүүлсэний дараа ерөнхий хэлэлцүүлэг, зүйл тус бүрээр хэлэлцэх, санал хураах гэсэн 3 үе шатыг дамжин батлагдана. Хэрэв парламентын аль нэг танхим хуулийн төслийг батлахгүй буцаавал дөрөв, тав дахь хэлэлцүүлгийг хийж болно.

Өргөн барьсан төслийн талаар 2 танхимын хооронд саналын зөрүү гарвал Ерөнхий сайдын хүсэлтээр хамтарсан адил тооны гишүүдээс бүрдсэн комисс байгуулж хэлэлцэх бөгөөд нэгдсэн саналд хүрсэн төслийг 2 танхим дахин хэлэлцэж шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд саналын зөрүү гарвал Ерөнхий сайд Парламентын доод танхимд батлах хүсэлт тавьж тэрээр эцэслэн шийдвэрлэнэ. Ийнхүү хууль тогтоох үйл ажиллагаанд засгийн газар нэлээд үүрэгтэй байдаг. Гэхдээ засгийн газарын хуулийн төслийг батлуулах шаардлага нь ихэнхидээ өөрийнх нь өргөн барьсан хуулийн төсөлтэй холбоотой болно.

Хууль батлагдсаны дараа түүнийг Ерөнхийлөгч ёсчилдог ба тэрээр 15 хоногийн дотор уг хуулийг дахин хэлэлцэхийг шаардах эрхтэй байна. Үүний тулд Ерөнхийлөгч тунхаг гарган, Хуулийн аль хэсгийг, аль танхимаар хэлэлцэхийг заана.


ЧЕХ

Бүгд Найрамдах Чех Улс

Парламентын засаглалтай бүгд найрамдах улс. Чехийн парламент нь Депутатуудын танхим ба Сенат гэсэн хоёр танхимтай.

Парламент байгуулагдах хэлбэр, сонгуулийн тогтолцоо

Депутатуудын танхим нь намын жагсаалтаар сонгогддог 200 депутаттай. 21 нас хүрсэн сонгуулийн эрхтэй Чехийн иргэн депутатаар сонгогдож болно. Сенат нь мажоритар системээр сонгогдсон 81 сенатчаас бүрддэг. Сенатчийн бүрэн эрхийн хугацаа нь 6 жил байх ба хоёр жил тутам сенатчдын гуравны нэг нь сэлгээний журмаар шинэчлэгдэн сонгогддог. Сонгуулийн эрхтэй 40 нас хүрсэн Чехийн иргэн сенатч байж болно. Депутатуудын танхим нь Засгийн газарт итгэл хүлээлгэх, эсэх тухай асуудлыг 50-аас доошгүй депутатын саналаар тавих эрхтэй. Энэ танхимын Сенатаас ялгагдах нэг онцлог нь Ерөнхийлөгчийн шийдвэрээр хугацаанаасаа өмнө тарах асуудал юм.



Бүрэн эрх

Танхимууд хамтарч болон тус тусдаа хуралдах бөгөөд хамтарсан хуралдаанаар улсын Ерөнхийлөгчийг сонгох, Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, Засгийн газрын тайланг хэлэлцэх, Зэвсэгт хүчнийг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах болон дайн энхийн асуудлыг хэлэлцдэг.

Хууль батлах, төсвийн асуудлыг хэлэлцэх, татвар хураамж тогтоох, ард нийтийн санал асуулга явуулах, өршөөл үзүүлэх, олон улсын гэрээ хэлэлцээр соёрхон батлах, төрийн шагнал, цэргийн болон бусад цол бий болгох зэрэг асуудлыг Депутатуудын танхим хэлэлцсэний дараа Сенатаар хэлэлцүүлнэ. Мөн Депутатуудын танхимын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд дараагийн Депутатуудын танхим бүрдэх хүртэл хууль батлах үүргийг дангаараа гүйцэтгэх эрхтэй. Гэвч Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, улсын төсөв, түүний гүйцэтгэл. Сонгуулийн хууль, олон улсын гэрээ хэлэлцээрийн талаархи хуулийг хэлэлцэх эрхгүй.

Хууль хэлэлцэж батлах журам

Хууль тогтоох ажиллагааны эхний шат нь хууль санаачлах эрхийг хэрэгжүүлэх явдал байдаг. Депутатууд, депутатуудын бүлгүүд, Сенат, Засгийн газар, орон нутгийн өөрөө удирдах дээд нэгжийн төлөөлөгчид хууль санаачлах эрхтэй. Хуулийн төслийг Депутатуудын танхимд өргөн барьдаг.

Хоёрдахь шат нь хуулийн төслийг хэлэлцэн батлахад оршино. Хуулийг батлахын тулд түүнийг хоёр танхим хоёулаа хүлээн зөвшөөрөх учиртай. Эхлээд Депутатуудын танхим дараа нь Сенат төслийг хэлэлцэж нийтлэг журмын дагуу хууль батлахын тулд нийт депутат болон сенатчаас гуравны нэгээс доошгүй нь байлцаж депутат болон сенатчдын олонхиор батлах шаардлагатай. Харин Чехийн нутаг дэвсгэр дээр гадаадын цэргийг байрлуулах, эсхүл дайн зарлах тухай шийдвэрийг батлахын тулд нийт депутат болон сенатчдын талаас илүү санал, Үндсэн хууль батлахад нийт депутатууд болон сенатчдын тавны гурваас доошгүйн санал шаардлагатай.

Хуулийг Депутатуудын танхим батласны дараа түүнийг батлуулахаар Сенатад хүргүүлнэ. Сенат нь депутатуудын танхимаар батлагдсан хуулийг 30 хоногийн хугацаанд судлан үзэж шийдвэрээ гаргах ёстой. Хэрэв Сенат хуулийг дэмжвэл түүнийг Ерөнхийлөгчид ёсчлуулахаар хүргүүлнэ. Мөн дээрх хугацаанд Сенат хуулийн талаар ямар нэг шийдвэр гаргаагүй бол түүнийг Сенатаар батлагдсанд тооцно.

Сенат нь Депутатуудын танхимын батласан хуулийг дэмжихээс татгалзвал Депутатуудын танхим Сенатын хоригийг нийт депутатуудын олонхийн саналаар давж болдог. Сенатаас гадна тус улсын Ерөнхийлөгч парламентын баталсан хуульд 15 хоногийн дотор хориг тавьж болно. Энэ тохиолдолд Ерөнхийлөгчийн хоригийг давах журам нь Сенатын хоригийг давах журамтай адил байдаг.

ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛС**Парламентын танхимуудын нэр**

- а/ Доод танхим-Үндэсний Зөвлөл
- б/ Дээд танхим- Кантонуудын Зөвлөл

Парламент байгуулагдах хэлбэр

Үндэсний Зөвлөл 200 төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд ард түмнээс 4 жилийн хугацаагаар

шууд сонгогдоно. Кантонуудын Зөвлөл нь Кантоны 46 төлөөлөгчөөс бүрдэнэ. Үндэсний Зөвлөлийн төлөөлөгчдийг сонгох сонгууль 4-н жилд нэг удаа пропорциональ системээр явагдах бөгөөд кантон бүр сонгуулийн тойргоо бүрдүүлнэ. Кантонуудаас сонгогдох төлөөлөгчийн суудлыг кантон бүрийн хүн амын тоог харгалзан тогтоох бөгөөд кантон бүр нэгээс доошгүй суудалтай байна. Нэр бүхий 6 кантон (Obwald, Nidwald, Basel City, Basel Land, Appenzell Outer Rhodes болон Appenzell Inner Rhodes)-оос тус бүр 1 сенатор, бусад кантоноос тус бүр 2 сенатор бүгд 46 сенаторыг шууд бусаар сонгоно. Кантонуудын Зөвлөлийн сонгуулийн журмыг кантон бүр өөрсдөө тогтооно.

Бүрэн эрх

Парламентын хоёр танхимтай бөгөөд эдгээр нь адил эрх мэдэлтэй байна. Холбооны улсын парламент нь хууль тогтоомж гаргах үндсэн үүргээсээ гадна дараахь эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Швейцарь улсын төвийг сахисан байдал, бие даасан байдал, дотоодын аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авах,
- Цэргийн албыг удирдаж зарим хэсгийг нь эсхүл бүхэлд нь дайчлах,
- Холбооны улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах,
- Ард нийтийн санаачилсан хүчин төгөлдөр шаардлагыг хэрэгжүүлэх,
- Уучлал хүссэн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх.

Холбооны улсын парламент гадаад бодлогоо тодорхойлоход оролцож гадаад харилцаандаа хяналт тавих бөгөөд Холбооны Засгийн газрын эрх мэдэлд хамаарахгүй олон улсын олон талт гэрээг баталдаг. Мөн Холбооны улсын төсвийг батална. Холбооны улсын Засгийн газрын гишүүд, канцлер, улсын дээд шүүхийн шүүгчид болон ерөнхий шүүгчийг гагцхүү парламентаас сонгоно. Холбооны улсын парламент Холбооны улсын Засгийн газар, засаг захиргааны байгууллага, шүүх болон бусад холбооны улсын асуудлыг хариуцсан байгууллагуудад хяналт тавина.

Төрийн дээд эрхийг барих субъект: Парламент

Хууль тогтоох журам

Холбооны улсын парламент Холбооны улсын хууль \statute\, захирамж \ordinance\ хэлбэрээр эрх зүйн актаа баталдаг. Бусад актууд нь тогтоол хэлбэрээр гардаг бөгөөд тогтоол нь ард нийтийн санал асуулгаар хэлэлцэгдэхгүй. Хууль тогтоох үйл явцад хоёр танхим адил эрх мэдэлтэй ба хуулийн төслийг тус тусдаа хэлэлцэн баталсан тохиолдолд хүчин төгөлдөр болно. Өргөн барьсан төслийн талаар 2 танхимын хооронд саналын зөрүү гарвал, түүнийг хэлэлцэж эхэлсэн танхимд нь буцааж, дахин хэлэлцэхдээ нөгөө танхимын саналыг харгалздаг. Үүний дараа дахин саналын зөрүүтэй тохиолдолд зөвшилцөх бага хурал зохион байгуулж, түүний үр дүнд шийдвэр гаргана. Энэ зөвшилцлийн бага хурлаар нэгдсэн шийдэлд хүрэх боломжгүй бол уг асуудлыг хэлэлцэх асуудлын жагсаалтаас хасна.

Үндэсний хурлын хууль тогтоох журам нь бусад улсын хоёр танхимтай парламентын жишигтэй ижил төстэй боловч зарим хуулийг бүх нийтийн санал асуулгаар дэмжсэн тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилдэг онцлогтой.

* * *



Дэлхийн зарим улс орнуудын парламентын дээд танхим байгуулагдах хэлбэр**I. Ази тив**

1. Афганистан–Сенат, 68-ыг шууд бус сонгуулиар, 34-ийг Ерөнхийлөгч томилдог
2. Бахрейн–Зөвлөх зөвлөл, 40 гишүүнийг бүгдийг Эзэн хаан томилдог.
3. Бутан–Үндэсний зөвлөл, 20 гишүүнийг шууд сонгуулиар, 5 гишүүнийг Эзэн хаан томилдог.
4. Йемен–Зөвлөх зөвлөл, 111 гишүүнийг бүгдийг Ерөнхийлөгч томилдог.
5. Йордан–Сенат, 55 гишүүнийг бүгдийг Эзэн хаан томилдог.
6. Казахстан–Сенат, 47 гишүүнээс Муж, нийслэл, улсын чанартай хотуудын төлөөллийн байгууллагуудын хамтарсан хурлаас тус бүр 2 депутат буюу бүгд 32-ыг сонгох ба 15 депутатыг Ерөнхийлөгч томилдог
7. Камбож–Сенат, 59 гишүүн шууд бус сонгуулиар сонгогддог. 2 гишүүнийг Эзэн хаан томилдог.
8. Малайз–Сенат, 70 сенатораас 26-г нь шууд бус сонгуулиар сонгодог, 44-ийг нь Эзэн хаан томилдог.
9. Оман–Төрийн зөвлөл, 72 гишүүнийг бүгдийг Султан томилдог.
10. Пакистан–Сенат, шууд бус сонгуулиар байгуулагддаг. 88 нь 4 мужийг, 4 нь нийслэлийг, 8 нь омгуудыг төлөөлдөг.
11. Тажикстан–Мажилис милли, 34 гишүүний 3/4-ыг бүс нутгийн төлөөллийн байгууллагуудын хурлаас шууд бусаар сонгох ба 1-ийг Ерөнхийлөгч томилдог.
12. Тайланд–Сенат, 76 гишүүнийг шууд сонгуулиар, 74 гишүүнийг шууд бус сонгуулиар сонгодог.
13. Узбекистан–Сенат, 100 гишүүнээс 84-ийг шууд бус сонгуулиар, 16-г Ерөнхийлөгч томилдог.
14. Филиппин–Сенат, 24 гишүүнийг бүгдийг шууд сонгуулиар сонгодог.
15. Энэтхэг–Муж улсуудын зөвлөл/Rajya Sabha/, 545 гишүүнээс 543-ыг шууд бус сонгуулиар, 2-ыг англичуудын нийгэмлэгээс нэр дэвшүүлж Ерөнхийлөгч томилдог.
16. Япон–Зөвлөхүүдийн танхим, 242 гишүүнийг шууд сонгуулиар, холимог системээр сонгодог.

II. Австрали, далайн орнууд

1. Австали–Сенат, 76 гишүүнийг бүгдийг шууд сонгуулиар сонгодог
2. Палау–Сенат, 13 гишүүнийг бүгдийг бүх нийтийн шууд сонгуулиар сонгодог.
3. Фижи–Сенат, 32 гишүүнээс 14-ийг удирдагчдын дээд зөвлөл, 9-ийг Ерөнхий сайд, 8-ыг цөөнхийн удирдлага, 1-ийг Ротумын зөвлөлөөс нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилдог

III. Америк тив

1. АНУ–Сенат, 100 сенаторыг бүгдийг шууд сонгуулиар сонгодог.
2. Аргентин–Сенат 72 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
3. Боливи–Сенат, 36 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
4. Бразил–Холбооны сенат, 81 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог
5. Канад–Сенат, 105 гишүүнийг ерөнхий сайдын санал болгосноор амбан захирагч

томилно.

6. Колумби–Сенат, 102 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
7. Мексик–Сенат, 128 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
8. Парагвай–Сенат, 80 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
9. Уругвай–Сенат, 31 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
10. Чили–Сенат, 38 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.

IV. Африк тив

1. Алжир–Үндэстний зөвлөл /Меджлис аль-Умма/, 154 гишүүнээс 96 гишүүнийг орон нутгийн иргэдийн нийтийн хурлаас сонгон шалгаруулсан сонгогчид мужуудын Үндэсний хурлын гишүүдээс шууд бус сонгуулиар сонгодог. Нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын 40 нас хүрсэн нэртэй зүтгэлтнүүдээс 48 гишүүнийг Ерөнхийлөгч томилдог.
2. БНАКонго–Сенат, 108 гишүүнийг мужуудын ассамблейгаас шууд бусаар 5 жилийн хугацаагаар сонгох журамтай. Харин Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүн бүх насаараа Сенатын гишүүн байхаар тогтоожээ.
3. Зимбабве–Сенатын гишүүдийн 60 нь шууд сонгуулиар мажоритар системээр 10 мужаас тус бүр 6 сенатор сонгогдох бөгөөд 5-ыг нь Ерөнхийлөгч томилох, 35 нь бусад албан тушаал заасан /10 бүс нутгийн захирагч, 16 удирдах тушаалтан, худалдаа, үйлчилгээний салбарын 7, захирлуудын зөвлөлийн дарга, орлогчид/ хүмүүс орох журамтай.
4. Конго–Сенат, муж, дүүрэг, орон нутгийн коммуны зөвлөлөөс шууд бусаар 6 жилийн хугацаагаар сонгогдох 72 гишүүнтэй.
5. Лесотто–Сенат 33 гишүүнтэй, 22 гишүүн нь дээд албан тушаалтан байх бөгөөд тэднийг хэлбэрийн төдий нууцаар санал хурааж сонгоно. 11-ийг нь хаан томилдог байна.
6. Марокко–Зөвлөхүүдийн танхим, 270 гишүүнийг дүүрэг, орон нутгийн зөвлөлийн гишүүд, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлдвэрчний байгууллагын төлөөлөгчдөөс шууд бусаар сонгогддог.
7. Намиби–Үндэсний зөвлөл, орон нутгийн зөвлөлөөс шууд бус сонгуулиар 6 жилийн хугацаатайгаар сонгогддог 26 гишүүнтэй.
8. Нигерия–Сенат, 109 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
9. ӨАБНУлс–Мужуудын үндэсний зөвлөл, 90 гишүүнээс 54 нь шууд бус сонгуулиар сонгогдох ба 36 нь солигдож томилогддог.
10. Сенегал–Сенат, 100 гишүүнээс 65-ыг нь Ерөнхийлөгч томилдог, 35 нь шууд бус сонгуулиар сонгогддог.
11. Тунис–Зөвлөхүүдийн танхим, 126 гишүүнээс 85 нь шууд бус сонгуулиар сонгогдож 41-ийг Ерөнхийлөгч томилдог.
12. Этиопи–Холбооны танхим, 112 гишүүнийг муж улсын зөвлөлөөс шууд бусаар сонгодог.

V. Европ тив

1. Австри–Холбооны зөвлөл, 64 гишүүнийг шууд бусаар сонгодог.
2. Бельги–Сенат, 71 гишүүнийг шууд бус сонгуулиар сонгодог.
3. Словени–Үндэсний Зөвлөл, 40 гишүүнийг нийгэм, эдийн засаг, үндэстний болон мэргэжлийн бүлэг, давхрагын төлөөлөл, орон нутгийн төлөөллийг харгалзан шууд бусаар сонгоно.

Судалгааны эмхтгэл, Х боть

4. Герман–Бундесрат, 69 гишүүнийг муж улсуудын Засгийн газраас томилдог.
5. Ирланд–Сенат, 60 гишүүнээс 49 нь шууд бус сонгуулиар сонгогдох ба 11-ийг нь Ерөнхий сайд томилдог.
6. Испани–Сенат, 259 гишүүний 208 нь шууд сонгуулиар, 51 нь шашны төлөөллөөс томилогддог.
7. Итали–Холбооны сенат, 315 гишүүн шууд сонгуулиар сонгогддог.
8. ИБУИНВУ–Лордын танхим, Хатан хаан томилдог.
9. ОХУ–Холбооны зөвлөл, 178 гишүүнийг Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч томилдог.
10. Польш–Сенат, 100 гишүүн шууд сонгуулиар сонгогддог.
11. Румын–Сенат, 129 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
12. Беларус–Төрийн зөвлөл 64 гишүүний 56-г шууд бус сонгуулиар сонгож, 8-ийг ерөнхийлөгч томилдог
13. Франц–Сенат, 350 гишүүнийг шууд бус сонгуулиар сонгодог.
14. Чех–Сенат, 81 гишүүнийг шууд сонгуулиар сонгодог.
15. Швейцари–Сенат, 46 сенаторыг шууд сонгуулиар сонгодог.

Бүгд 56 улсын парламентын дээд танхимыг хамруулав. Хүснэгт №1

Парламентын дээд танхимыг шууд ба шууд бус сонгууль, томилгоо хосолсон хэлбэрээр байгуулдаг улс орнууд

| № | Улсын нэр | Парламентын танхимын нэр | Нийт гишүүдийн тоо | Шууд бус сонгуулиар | | Томилгоо | |
|---|------------|--------------------------|---|--|---------------|------------------|---------------|
| | | | | Сонгох субъект | Гишүүдийн тоо | Томилдог субъект | Гишүүдийн тоо |
| 1 | Афганистан | Сенат | 102 | Муж, дүүргийн зөвлөл | 68 | Ерөнхийлөгч | 34 |
| 2 | Бутан | Үндэсний зөвлөл | 25 | шууд | 20 | Эзэн хаан | 5 |
| 3 | Казахстан | Сенат | 47 | Муж, нийслэл, улсын чанартай хотуудын төлөөллийн байгууллагуудын хамтарсан хурал | 32 | Ерөнхийлөгч | 15 |
| 4 | Камбож | Сенат | 61 | -Хороо, анхан шатны нэгжийн хурлаас -Үндэсний ассамблей | 57 2 | Ван | 2 |
| 5 | Малайз | Сенат | 70 | Муж улсын хууль тогтоох хурал | 26 | Эзэн хаан | 44 |
| 6 | Тажикстан | Мажилис Милли | 34 Сонгуулийн хугацаа дуусгавар болсон сүүлчийн Ерөнхийлөгч орно | Ардын депутатуудын нэгдсэн хурал | 25 | | 8 |

| | | | | | | | |
|----|------------|---------------------------------|---------|--|---------|--|---------|
| 7 | Узбекистан | Сенат | 100 | Каракалпак болон Ташкент хот, мужуудын төлөөллийн байгууллагын хурал | 84 | Ерөнхийлөгч | 16 |
| 8 | Энэтхэг | Муж улсуудын зөвлөл/Rajya Sabha | 545 | Муж улсуудын парламент | 543 | Ерөнхийлөгч /англичуудын нийгэмлэгээс/ | 2 |
| 9 | Алжир | Үндэстний зөвлөл | 154 | Орон нутгийн иргэдийн ний-тийн хурлаас сонгон шалга-руулсан сонгог-чид | 96 | Ерөнхийлөгч | 48 |
| 10 | БНАКонго | Сенат | 108+... | Мужуудын ассамблей | 108 | Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүс | |
| 11 | Зимбабве | Сенат | 100 | Шууд сонгуулиар | 60 | Ерөнхийлөгч Албан тушаал зааж шууд ордог | 5 35 |
| 12 | Лесото | Сенат | 33 | Хуулиар тогтоосон гол удирдагчид, хэлбэрийн төдий санал хураалт | 22 | Төрийн зөвлөлийн санал болгосноор Эзэн хаан | 11 |
| 13 | ӨАБНУ | Мужуудын үндэсний зөвлөл | 90 | Мужуудын хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй нам | 54 | Мужуудын хууль тогтоох байгууллагын төлөөлөл | 36 |
| 14 | Сенегал | Сенат | 100 | Муж, хот. Орон нутгийн хурлын гишүүдээс бүрдсэн сонгогчид | 35 | Ерөнхийлөгч | 65 |
| 15 | Тунис | Зөвлөхүүдийн танхим | 126 | Орон нутгийн төлөөллийн байгууллагын төлөөлөл | 80 | Ерөнхийлөгч | 46 |
| 16 | Ирланд | Сенат | 60 | -Үндэсний болон Дублиний их сургууль -Төрөл бүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага | 6 43 | Ерөнхий сайд | 11 |
| 17 | Испани | Сенат | 259 | Шууд сонгуулиар | 208 | Шашны байгууллагууд | 51 |
| 18 | Беларус | Төрийн зөвлөл | 64 | Шууд бус сонгуулиар | 56 | Ерөнхийлөгч | 8 |

* * *

Хүснэгт № 2

Парламентын дээд танхимыг зөвхөн томилгооны хэлбэрээр байгуулдаг улс орнууд

| № | Улсын нэр | Танхимын нэр | Гишүүдийн тоо | Томилдог субъект |
|---|-----------|-----------------|---------------|------------------|
| 1 | Бахрейн | Зөвлөх зөвлөл | 40 | Эзэн хаан |
| 2 | Йемен | Үндэсний зөвлөл | 111 | Ерөнхийлөгч |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | | |
|---|---------|----------------|-----|--|
| 3 | Иордан | Сенат | 55 | Эзэн хаан |
| 4 | Оман | Төрийн зөвлөл | 72 | Султан |
| 5 | Фижи | Сенат | 32 | Ерөнхийлөгч |
| 6 | Канад | Сенат | 105 | Амбан захирагч |
| 7 | Герман | Бундесрат | 69 | Муж улсуудын Засгийн газар |
| 8 | ИБУИНВУ | Лордын танхим | 733 | Хатан хаан |
| 9 | ОХУ | Холбооны хурал | 178 | Муж улсуудын хууль тогтоох байгууллага |

* * *

Хүснэгт № 3

Парламентын дээд танхимыг шууд сонгуулиар байгуулдаг улс орнууд

| № | Улсын нэр | Танхимын нэр | Гишүүдийн тоо | Сонгуулийн тогтолцоо |
|----|-----------|---------------------|---------------|--|
| 1 | Филлипин | Сенат | 24 | Улсын хэмжээний 1 тойргоос мажоритар тогтолцоо |
| 2 | Япон | Зөвлөхүүдийн танхим | 242 | Сонгуулийн холимог тогтолцоо 146/96 |
| 3 | Австрали | Сенат | 76 | Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо |
| 4 | Палау | Сенат | 13 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |
| 5 | АНУ | Сенат | 100 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |
| 6 | Аргентин | Сенат | 72 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |
| 7 | Боливи | Сенат | 36 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |
| 8 | Бразил | Холбооны сенат | 81 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |
| 9 | Колумби | Сенат | 102 | Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо |
| 10 | Мексик | Сенат | 128 | Сонгуулийн холимог тогтолцоо 96/32 |
| 11 | Парагвай | Сенат | 80 | Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо |
| 12 | Уругвай | Сенат | 31 | Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо |
| 13 | Чили | Сенат | 38 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |

| | | | | |
|----|----------|----------------|-----|---|
| 14 | Нигерия | Сенат | 109 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |
| 15 | Итали | Холбооны сенат | 315 | Сонгуулийн холимог тогтолцоо 12/302 |
| 16 | Польш | Сенат | 100 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |
| 17 | Румын | Сенат | 129 | Сонгуулийн 1 мандаттай тойрог бүхий холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо 50%-ийн босготой, 50%-иас доош авсан саналыг үндэсний хэмжээнд нэгтгэж намуудад хуваарилсаны дараа суудлыг хуваарилах |
| 18 | Чех | Сенат | 81 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |
| 19 | Швейцари | Сенат | 46 | Сонгуулийн мажоритар тогтолцоо |

* * *

Хүснэгт № 4

Парламентын дээд танхимыг шууд бус сонгуулиар байгуулдаг улс орнууд

| № | Улсын нэр | Танхимын нэр | Гишүүдийн тоо | Сонгуулийн тогтолцоо | Сонгох субъект |
|---|-----------|---------------------|---------------|--|--|
| 1 | Пакистан | Сенат | 100 | 1 шилжих саналын эрх бүхий хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо | Мужуудын ассамблейгаас 88, Холбооны омгуудын хурлаас 8, Нийлэлийн ассамблейгаас 4 |
| 2 | Конго | Сенат | 72 | Сонгуулийн мажоритар тогтолцоо | Муж, дүүрэг, орон нутгийн коммуны зөвлөл |
| 3 | Намиби | Үндэсний зөвлөл | 26 | Сонгуулийн мажоритар тогтолцоо | Орон нутгийн зөвлөлийн гишүүдээс бүрдсэн сонгогчдын коллеги |
| 4 | Марокко | Зөвлөхүүдийн танхим | 270 | Сонгуулийн мажоритар тогтолцоо | Орон нутгийн зөвлөлийн гишүүд, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлдвэрчний байгууллагын төлөөлөгчид |
| 5 | Этиопи | Холбооны танхим | 112 | Сонгуулийн мажоритар тогтолцоо | Муж улсын зөвлөл эсвэл муж улсын зөвлөл шууд сонгууль явуулах |
| 6 | Австри | Холбооны зөвлөл | 64 | Сонгуулийн хувь тэнцүүлсэн тогтолцоо | Мужуудын ассамблей |

Судалгааны эмхтгэл, Х боть

| | | | | | |
|---|---------|-----------------|-----|--------------------------------------|---|
| 7 | Бельги | Сенат | 71 | Сонгуулийн хувь тэнцүүлсэн тогтолцоо | Дани, францын сонгуулийн коллегт, Флемиш, Франц Данийн коммуни |
| 8 | Франц | Сенат | 350 | Сонгуулийн холимог тогтолцоо 128/203 | Муж тус бүрт 1000 хүнээс бүрдсэн сонгогчдын коллегийн бүрэлдэхүүнд муж бүрээс сонгогдсон Үндэсний Ассамблейн гишүүд /2-7 гишүүн/, Мужийн төлөөллийн байгууллагын депутатууд /30-40 депутат/, коммун тус бүрээс 10-15 төлөөлөгч орсон сонгогчдын коллеги |
| 9 | Словени | Үндэсний зөвлөл | 40 | Харьцангуй мажоритари тогтолцоо | Үндэсний Зөвлөл, 40 гишүүнийг нийгэм, эдийн засаг, үндэстний болон мэргэжлийн бүлэг, давхрагын төлөөлөл, орон нутгийн төлөөлөл |



ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

Бодлогын судалгаа, шинжилгээ”
эмхэтгэл (Х боть) -ийн хавсралт

УИХ -ын 2011 оны хаврын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа

(IX ботид орсон бусад судалгааны жагсаалт)

| № | Судалгаа, мэдээлэл, лавлагаа | Гүйцэтгэсэн судлаачид |
|--|---|--|
| УДИРТГАЛ ХЭСЭГ | | |
| 1 | Бодлогын судалгаа ба бодлогын шинжилгээ (Арга зүйн зөвлөмж) | Ц. Норовдондог (Ph.D), Ц. Болормаа, О. Нарантуяа |
| Нэг. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ | | |
| 2 | • Төсвийн дүн шинжилгээ, хяналтын чиг үүрэг бүхий парламент дахь бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үйл ажиллагааны талаархи харьцуулсан судалгаа | Ц. Норовдондог (Ph.D), Г. Билгээ, Г. Гэрэл, О. Нарантуяа, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа |
| 3 | • Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлага, экспортыг дэмжих бодлогын судалгаа | Г. Алтан - Оч (Ph.D), Б. Буяндэлгэр, С. Дорждагва, Б. Ариунжаргал |
| 4 | • Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль ба архи, согтууруулах ундааны худалдаа, архидан согтуурахтай тэмцэх асуудлаархи судалгаа, бусад орны туршлага | Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батдорж, Ц. Батбаяр, Г. Билгээ, Г. Гэрэл, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа |
| 5 | • Монгол Улсад импортоор орж ирж буй гол нэрийн бараа, бүтээгдэхүүний талаархи лавлагаа мэдээлэл (2005 - 2011) | Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа |
| 6 | • Монгол Улсын макро эдийн засгийн 2011 оны эхний хагас жилийн тойм | Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батдорж, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа |
| 7 | • Монгол Улсын хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хамаарлын судалгаа, дүн шинжилгээ | Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа |
| Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ | | |
| 8 | • Үйлдвэрлэл, үйлчилгээний буюу мэргэшлийн холбоодын эрхзүйн зохицуулалтын талаархи ХБНГУ -ын туршлага, харьцуулсан судалгаа | Г. Алтан - Оч (Ph.D) |
| 9 | • Цэргийн тэтгэвэр болон нэг удаагийн тэтгэмж авсан цэргийн албан хаагчдын талаархи судалгаа (Лавлагаа мэдээлэл) | Б. Мөнхцэцэг, А. Пагма |
| 10 | • “Алслагдсан бүс” нутгийн шалгуур үзүүлэлт, тэдэнд олгодог хөнгөлөлт, нэмэгдлийн талаархи судалгаа | Г. Алтан - Оч (Ph.D) |

| | | |
|----|---|--|
| 11 | <ul style="list-style-type: none"> • Ялтны хөдөлмөр эрхлэлтийн талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт | <i>Р. Хатанбаатар, Б. Буяндэлгэр, Г. Алтан - Оч (Ph.D) Т. Мягмаржав, О. Нарантуяа, Н. Түвшинтөгс</i> |
| 12 | <ul style="list-style-type: none"> • Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох тогтолцоо, стандарт, төсөв санхүүжилт, багшлах боловсон хүчний талаар төрөөс баримталж буй бодлого (Лавлагаа-Мэдээлэл) | <i>Ц. Төвүүсүрэн, Р. Хатанбаатар, А. Пагма, Ч. Базар, Б. Дуламсүрэн, Б. Мөнхцэцэг</i> |
| 13 | <ul style="list-style-type: none"> • Тэтгэвэрийн нэрийн дансыг өвлүүлдэг талаархи гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт (Судалгаа - мэдээлэл) | <i>Б. Ариунжаргал, Т. Мягмаржав</i> |
| 14 | <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулинд энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгасан байдал (Лавлагаа, мэдээлэл) | <i>Б. Төвүүсүрэн, П. Амаржаргал, Б. Мөнхцэцэг, А. Пагма, Б. Хатантуул</i> |



ISBN 978-999-9--56-70-8

УИХ -ын Тамгын газар ©
«БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ»
(Судалгааны эмхтгэл, Х боть)

«Мөнхийн үсэг» хэвлэх үйлдвэр
Хэвлэлтэд шилжүүлсэн 2011.9.09
Тираж 400, Хэвлэлийн хуудас 20
Цаасны хэмжээ 176 * 250 ¹/₁₀
(Анхны хэвлэл)

УБ, 2011